Сургалтын хөтөлбөрийн дараагийн өөрчлөлт нь 2006 онд ерөнхий боловсрол 11 жилийн боловсролын тогтолцоонд шилжсэнтэй холбоотойгоор хийгдсэн бөгөөд Боловсролын хүрээлэнгийн захирлын 15 дугаар тушаалаар 11 жилийн сургуульд судлах хичээлүүд болон тэдгээрийн агуулгын хүрээг боловсролын стандартын айн хүрээнд үлгэрчилсэн байдлаар боловсруулж хэрэгжүүлжээ. Эдгээр сургалтын хөтөлбөрийг боловсруулахад 2004 онд батлагдсан боловсролын стандарт чиг баримжаа болсон бөгөөд уг стандартад цогц чадамжийг "*Хүний эзэмшсэн мэдлэг, чадвар, туршлага, төлөвшсөн хандлага, зан үйлийн илэрхийлэл, хүний хөгжлийн чадамж"*, харин танин мэдэхүйн түвшний шалгуурыг *"Агуулгын ай бүрээр суралцагчдын эзэмших цогц чадамжийг үнэлэх тодорхой мэдлэг, чадварыг танин мэдэхүйн түвшин бүрт харгалзуулан тодорхойлсон жишиг"* гэж тодорхойлжээ.

Гурав дахь өөрчлөлт нь 2006 оноос эхэлсэн байх бөгөөд энэ нь ерөнхий боловсролын 12 жилийн сургалтад шилжих шийдвэр гарсантай холбоотой. 2008 онд 12 жилийн бүрэн дунд боловсролын тогтолцоонд шилжиж, сургалтын агуулгыг хүрэх үр дүнгээр тодорхойлж, арга зүй, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан өмнөх сургалтын хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх уялдаатай байдал, залгамж холбоог хангасан үндэсний 12 жилийн сургалтын хөтөлбөрийг боловсруулж, практикт нэвтрүүлсэн байна.

Харин Боловсролын хүрээлэнгээс хийж буй энэхүү судалгааны хүрээнд хэрэгжилтийн байдлыг нь тодорхойлохыг зорьж буй сургалтын хөтөлбөрийг боловсруулах, турших ажил [1] 2012 оноос эхэлж, 2013 онд БШУ-ны Сайдын А/155 тоот тушаалаар Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлал, сургалтын хөтөлбөр боловсруулах багийг судлагдахуун бүрээр баталжээ. Эдгээр баг нь 2012-2017 онд танин мэдэхүй, нийгэмшил болон зан үйл, хандлагыг өв тэгш хөгжүүлэх, амьдрах чадвартай монгол хүүхэд төлөвшүүлэх, үндэснийхээ боловсролын агуулга, арга зүй, тогтолцоог олон улсын боловсролын жишигт хүргэх, бие даан сурах арга барил эзэмшүүлэх зорилгоор сургалтын цөм хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамжуудыг боловсролын түвшин, судлагдахуун бүрээр боловсруулан үндэсний хэмжээнд дараах үе шатаар хэрэгжүүлж байна. Үүнд:

1. 2014 оноос бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг үндэсний хэмжээнд бүх нийтээр хэрэгжүүлсэн.

[1] 2012 оны БШУ-ны Сайдын А/180-р тушаалаар

2. 2015 оноос суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг үндэсний хэмжээнд бүх нийтээр хэрэгжүүлсэн.
3. 2016 оноос бүрэн дунд боловсролын 10-р ангийн сургалтын цөм хөтөлбөрийг үндэсний хэмжээнд бүх нийтээр хэрэгжүүлсэн.
4. 2017 оноос бүрэн дунд боловсролын 11-р ангийн сургалтын цөм хөтөлбөрийг үндэсний хэмжээнд бүх нийтээр хэрэгжүүлсэн.
5. 2018 оноос бүрэн дунд боловсролын 12-р ангийн сургалтын цөм хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэ эхэлсэн байна.

Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг заавал судлах хичээлийн, заавал сонгон судлах хичээлийн гэсэн 2 хэлбэртэй боловсруулсан байна.

Сургалтын цөм хөтөлбөр бүрт сургалт, үйл ажиллагааны зорилго, зорилт, зохион байгуулалт, арга зүй, үнэлгээ, сургалтын орчин, багш, эцэг эхийн оролцоо зэрэг нийтлэг зүйлс тусгагдсан. Цөм хөтөлбөр нь багш суралцагчийн хамтын үйл ажиллагаанаас гадна сургуулийн бодлого, менежмент, эцэг, эх, асран хамгаалагч, олон нийтийн байгууллага, хамтын оролцооны үр дүнд хэрэгжих бөгөөд сургалтын болон сургалтыг дэмжих үйл ажиллагааны зохион байгуулалт, арга зүйгээр дамжуулан сурагчдад цогц чадамж төлөвшихөд нь боломж, дэмжлэгийг бий болгоход чиглэнэ. Сургалтын цаг гэдэгт хичээл/судлагдахуунаар хэрэгжих үйл ажиллагаа, сургалтыг дэмжих үйл ажиллагаа гэдэгт байгаль, нийгэм, соёлын хүрээний иргэний боловсрол, амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа, хичээлээс гадуурх үйл ажиллагааг хамааруулан авч үзэж байна.

Цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын орчин гэдэгт танхим, танхимаас гадуурх байгаль, нийгэм, соёлын орчинг авч үзэхээс гадна, суралцагч өөрөө бие даан суралцах үйлийн орчин, цахим техник хэрэгсэл зэргийг зааж өгчээ. Сургалтын хэрэглэгдэхүүнийг орон нутгаг, сургуулийн онцлогийг харгалзан олдоцтой хямд төсөр, гарын доорх материал ашиглан бэлтгэж болох талаар дурджээ.

Боловсролын хүрээлэн нь энэхүү судалгаагаар сургалтын цөм хөтөлбөрийн тохироц хийгээд хэрэгжилтийг орон нутаг, сургууль, багш нарын хөтөлбөрийн менежментийн арга зүйтэй уялдуулан авч үзэж, хэрэгжилтийн нөхцөл байдлыг иргүүлэхийг зорьж, а) ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн чиглэлээр хийгдсэн судалгааны үр дүнд дүн шинжилгээ хийх; б) ерөнхий боловсролын сурах бичиг нь сургалтын хөтөлбөрийн уялдааг авч үзэх; в) сургууль, багш нарын хичээлийн жил болон, нэгж, ээлжит хичээлийн төлөвлөлт болон сургалтын хөтөлбөрийн уялдаа холбоог авч үзэх тохирцын шинжилгээ; г) ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрөөр суралцагчийн эзэмшвэл зохих мэдлэг, чадварыг 4, 8, 11 дүгээр ангийн бүх хичээлээр авч үзэх, д( сургалтын материаллаг орчин, хэрэглэгдэхүүний нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх; е( сургалтын цөм хөтөлбөрийн хэрэгжилтэд нөлөөлж буй хүчин зүйлийг тогтоох; ё( судалгааны тайлан боловсруулж, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх санал зөвлөмж боловсруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэв.

### *Хичээлийн төлөвлөлт*

Судалгаанд хамрагдсан багш нарын заадаг хичээлийг авч үзвэл 24.5 хувь нь физик, хими, биологи, газарзүй зэрэг байгалийн ухааны хичээл заадаг багш нар байна. Нийгмийн ухааны, бага ангийн болон хавсарсан буюу 1-ээс олон судлагдахуун заадаг

багш нарын эзлэх хувь бага байна. Багшилсан жилийн хувьд 55.7 хувь нь 10-аас дээш жил ажилласан туршлагатай багш нар байна.

**Багш нар хичээлээ төлөвлөхдөө** тухайн судлагдахууныхаа сурах бичгийг байнга ашигладаг ба харин сургалтын цөм хөтөлбөр болон суралцахуйн удирдамжийг тэдний 50.0 хувь нь ашиглаж байна. Мөн багш нар хичээлдээ биет үзүүлэн болон зураг, дүрслэл бүхий үзүүлэнг түлхүү ашиглаж байна.

***Хичээл төлөвлөлт, боловсролын түвшнээр***




Сургууль, багш нар хичээлийн төлөвлөгөөг боловсруулахдаа аймаг, дүүргийн түвшинд хамран ажиллах нь нийтлэг болсон. Жилийн болон улирал, нэгж, ээлжит хичээлийн төлөвлөгөө харилцан уялдаатай боловсруулдаг ч ээлжит хичээлийн төлөвлөгөөг боловсруулалгүй хичээл заах тохиолдол цөөнгүй. Багш нарын боловсруулсан төлөвлөгөөнд зорилго, зорилт, агуулгын залгамж холбоо, хэрэглэгдэхүүн, үнэлгээг тодорхой тусгахгүй байдал нийтлэг байна.

Хичээлийн төлөвлөлтийг цөм хөтөлбөртэй нийцэж буй эсэхийг авч үзэхэд, бага боловсролын түвшинд 3.2-57.7 хувь, суурь боловсролын түвшинд 57.5 хувь, бүрэн дунд боловсролын түвшинд 20.6-31.0 хувь нь тохироц сайн байна гэж дүгнэв. Багш нарын хичээл төлөвлөлтийн бүтцийг авч үзэхэд агуулгын хуваарилалтийг аль ч түвшинд хангалттай сайн хийж байгаа боловч, зорилго, зорилт, үнэлгээ, агуулгын залгамж холбоо, жил, нэгж, ээлжит хичээлийн хоорондын уялдаа холбоог хангалтгүй төлөвлөж байна.

*Ээлжит хичээл төлөвлөхөд тулгардаг бэрхшээлүүд, хувиар*

| *Бэрхшээлүүд* | *хэцүү* |
|---|---|
| хичээлийн зорилгыг цөм хөтөлбөртэй уялдуулах | 26.0 |
| сурагчдын өмнөх мэдлэг, чадвар, хандлагыг харгалзах | 36.3 |
| сурагчдын ялгаатай байдалд тохируулах | 55.9 |
| нэгж хичээлийн үнэлгээний даалгавар боловсруулах | 24.9 |
| явцын үнэлгээний арга, хэрэгслийг тусгах | 23.7 |
| дадлага, туршилтыг тусгах | 26.4 |
| асуултыг танин мэдэхүйн түвшнийг харгалзан боловсруулах | 31.3 |
| явцын үнэлгээнд тулгуурлан төлөвлөлтийг сайжруулах | 21.0 |
| гэрийн даалгаврын гүйцэтгэлд тулгуурлах | 22.7 |
| цаг бага, төлөвлөөгүй ажил гарах | 68.7 |
| сургалтын хэрэглэгдэхүүнд зардал гарах | 81.2 |

Хичээл төлөвлөлтийн яюцад багш нарт дараах бэрхшээл нийтлэг учирдаг байна. Үүнд:

- сурагчдын ялгаатай байдлыг тусгах
- ажлын төлөвлөгөөнд тусаагүй цаг үеийн ажил их байх
- сургалтын хэрэглэгдэхүүний зардал байхгүй зэрэг байна.

Багш нар явцын үнэлгээнд тулгуурлан төлөвлөлтөө сайжруулахыг чухалчилдаг нь харагдав.

Сургалтын менежерүүдийн 50.9 хувь нь хичээлийн зорилгоо сургалтын хөтөлбөрийн зорилготой уялдуулах, тодорхойлох, сурагчдын өмнөх мэдлэг чадварыг харгалзаж хичээлээ төлөвлөхөд нь ерөнхий зөвлөгөө өгөх байдлаар хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлдэг бол сурагчдын ялгаатай байдалд тохируулан үйл ажиллагаа, дасгал даалгаврыг боловсруулахад нь тэр бүр тусалж чаддаггүйг багш нар хэлжээ.

*Сургалтын менежерүүдийн багш нарт арга зүйн дэмжлэг үзүүлж буй байдал*




Хичээлийн арга зүйн талаар тодорхой арга, аргачлал зөвлөдөг гэх сургалтын менежерүүдийн эзлэх хувь нь ерөнхий зөвлөгөө өгдөг сургалтын менежерүүдийн эзлэх хувиас доогуур үзүүлэлттэй байна.

Хичээлийн багш төвтэй байгаа бөгөөд анги ахихад багаар болон хосоор зохион байгуулах ээлжит хичээлийн эзлэх хувь нэмэгдэж байна. Хосоор багаар болон хосоор зохион байгуулж байгаа хичээлүүдэд сурагчдын идэвхтэй оролцоог хангах, мэдлэгээ ашиглах, шинжлэх ухаан ч арга барил эзэмшилтийг дэмжсэн аргуудыг ашиглах нь цөөнгүй ажиглагдав.

### *Үнэлж дүгнэх үйл ажиллагаа*

Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад сурагчдын сурлагын амжилтын үнэлгээнд даалгавар боловсруулахтай холбоотой өөрчлөлт орсон гэж багш нарын 61.2 хувь нь, явцын үнэлгээнд үндэслэн сурагчдыг чиглүүлэх, зөвлөн туслах, сурагч өөрийгөө болон бусдыг үнэлэхэд өөрчлөлт орсон гэж багш нарын 50 орчим хувь нь үзжээ. Үнэлгээний зорилгоо томьёолох, шалгуур боловсруулах хийгээд ашиглах, үнэлгээний арга хэрэгслийг ашиглах аргачлалын талаар багш нарт дэмжлэг үзүүлэх, нөгөөтэйгүүр сургалтын менежерүүдийг багш нарт зөвлөгөө өгөх хэмжээнд сургаж, дадлагажуулах хэрэгтэй нь харагдав. Мөн сурагчийн үнэлгээний шинэчилсэн журмыг хэрэгжүүлэхтэй холбоотой цогц дэмжлэг шаардлагатай.

### *Хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээн дэх хамтын ажиллагаа, эцэг эх, олон нийтийн оролцоо*

Хичээл, сургалтын явцад эцэг эх, асран хамгаалагчдтай хамтран ажилладаг чиглэл, давтамжийн талаар багш нар, төрөл бүрийн чиглэл, хэлбэрээр хамтран ажилладаг дүр зурагтай байна. Эцэг эх, асран хамгаалагчид, олон нийтийн хамтын ажиллагаа бага болон ахлах ангийн түвшинд дунд ангитай харьцуулахад идэвхжсэн байна. Бага ангийн түвшинд эцэг эхийн зүгээс хүүхдэдээ тавьдаг анхаарал сайн байдаг нь нийтлэг харин ахлах ангийн хувьд ЭЕШ-тай холбоотой хамтын ажиллагаа идэвхжиж байна.

Багш нарын хувьд эцэг эх, асран хамгаалагчид болон боловсролын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагууд (ТББ)-ын тусламж, дэмжлэг, хамтын ажиллагаанд сэтгэл дундуур байгаа дүр зурагтай байна. Аймаг, нийслэлийн боловсролын газар зэрэг шат шатны холбогдох байгууллагуудын зүгээс үзүүлж буй дэмжлэг, хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатайг багш нар онцлож байна.

### *Сурах бичгийн хангалт, хүртээмж*

Судалгаанд түүврээр сонгогдсон 4, 8, 11 дүгээр ангийн анги удирдсан багшийн журнал дээрх сурах бичгийн бүртгэлээс сурах бичгийн хангалт, хүртээмжийн талаарх мэдээллээс харахад дараах дүр зураг харагдав.

*Сурах бичгийн хангалт, түвшинээр*




Бага ангид сурах бичгийн хангалт 93.7 хувь, дунд ахлах ангийн сурах бичгийн хангалт дунджаар 46.4 хувь байгаа ч ээлжит хичээлийн ажиглалтаар сурах бичигтэй сурагчдын тоо цөөн байв.

*Зураг. Сурах бичгийн хангалт, байршлаар*




Сурах бичгийн хангалтыг нийслэлийн сургуулийн ойролцоогоор 3 сурагч тутмын нэг, аймгийн сургуулийн 2 сурагч тутмын нэг, сумын сургуулийн 4 сурагч тутмын нэг нь сурах бичиггүй байна гэж тооцоолж болохоор байна.

Судалгаанд хамрагдсан нийт сурагчдын 57.8 хувь нь сурах бичгээ номын сангаас, 42.1 хувь нь худалдаж авсан байна.

Сурах бичгийн хангалтыг байршлаар авч үзвэл, худалдаж авсан хүүхдийн эзлэх хувь суманд нийслэл болон аймгийн хувиас бага байгаа нь манай улсад сурах бичгийн худалдаа борлуулалтын нэгдсэн сүлжээ, зохицуулалт байхгүйтэй шууд холбоотой. Сурах бичгийн хангалтыг нэмэгдүүлэх талаар эцэг эх, асран хамгаалагчийн 87.6 хувь нь төрөөс үнэгүй өгөх хэрэгтэй гэж үзсэн нь анхаарал татав.

Харин багш нарт багшийн номыг ашиглах хэрэгцээ их байгаа хэдий ч хүртээмж маш муу байна. Тухайлбал, дунд ангид хичээл заадаг багш нарын хүрээнд 14 багшид нэг л багшийн ном ашигладаг сургууль байна.

Сурах бичгийг ээлжит хичээлийн явцад шинэ мэдээлэл авах, даалгавар гүйцэтгэх, зураг дээр ажиллах зэргээр ашиглахаас гадна багш хичээл төлөвлөхөд, сурагчид гэрийн даалгавар хийхэд тус тус ашиглаж байгаа хэдий ч ээлжит хичээлийн ажиглалтаас харахад бага ангийн сурагчдын 60 орчим хувь, дунд ангийн сурагчдын 50 орчим хувь, ахлах ангийн сурагчдын 40 орчим хувь нь л сурах бичигтэй нь харагдав. Энэ нь ээлжит хичээлийн явцад сурагчдын сурах бичиг ашиглалт бүх сурагчдын хувьд хүртээмжтэй бус байгааг харуулна.

### *Сургалтын орчин*

Нийт сургуулийн 76.2 хувь нь гаднаа цэцэрлэгжүүлэлтийн талбайтай, 71.4 хувь нь гэрэлтүүлэгтэй, 64.2 хувь нь цардмал зам болон явган хүний замтай, 81.0 хувь нь сууж амрах зориулалтын сандалтай, 66.7 хувь нь сүүдрэвчтэй байна.

*Гадаад орчны тохижилт*




Сургуулийн гадаад орчин, эдэлбэр газрын тохижилтод аймгийн сургуулиуд цэцэрлэгжүүлэлтээрээ, нийслэлийн сургуулиуд цардмал зам болон явган хүний замаараа, сумын сургуулиуд сууж амрах сандал, сүүдрэвч зэрэг нь нийслэл, аймгийн сургуулиас илүү байна.

*Нэг багшид ногдох хүүхдийн тоо, байршлаар*

Нийслэлийн сургуулийн нэг багшид ногдох хүүхдийн тоог тухайн сургуулийн нийт багш, сурагчийн тоотой харьцуулахад бага ангид 5-13, дунд, ахлах ангид 2-4 хүүхдээр илүү байна. Харин бүлэг дүүргэлтийн хувьд судалгаанд хамрагдсан нийслэлийн төрийн өмчийн сургуулийн 4 дүгээр ангийн нэг бүлэгт дунджаар 40.5 сурагч байгаа бол төрийн бус өмчийн сургуулийнх 22 байна.

“Сургалт-хүмүүжлийн байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм[2]”-ийн 4.3-д нэг анги дахь хүүхдийн тооны дээд хэмжээг 30-35 байхаар заасан. Гэтэл нийслэлийн төрийн өмчийн нийт сургуулийн 87.5 хувийнх нь дөрөвдүгээр ангийн хүүхдийн тоо дурьдсан хэмжээнээс илүү байна. Энэ нь нийслэлийн төрийн өмчийн сургуулийн бага ангийн багш аймаг, сумын сургуулийн бага ангийн багшаас илүү ачаалалтай байгааг харуулж байгаа юм.

Сургууль төвтэй мэргэжил дээшлүүлэх тогтолцоо бүрдүүлэх, багш ажлын байрандаа мэргэжил боловсролоо дээшлүүлэх, ээлжит хичээлээ хамтран бэлтгэх орчин нөхцөл бүрдүүлэх үүднээс БСШУ-ны сайдын 2008 оны 114 тоот тушаалаар "Багшийн хөгжлийн танхим" ажиллуулах зөвлөмж, шаардлагыг баталсан. Энэхүү зөвлөмж, шаардлагыг

[2] МХЕГ-ын даргын 2017 оны А/179 дүгээр тушаалын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан

хэрэгжүүлэх хүрээнд нийт сургуулийн 70 орчим хувьд дээрх зориулалт бүхий багш хөгжлийн өрөөг тохижуулж, үйл ажиллагаа явуулж байгааг нь тогтоогдов.

### *Номын сан, дотуур байр*

Судалгаанд хамрагдсан сургуулийн номын сангийн уншлагын танхимын суудлын тоо дунджаар 26 байна. Ажиглалтаар уншлагын танхимаар үйлжлүүлж буй сурагчдын тоо суудлын тооноос дунджаар 10 дахин цөөн байлаа. Нийт сургуулийн 60.0 хувь нь ажиглалт хийх үед уншлагын танхим хоосон буюу сурагчидгүй, 40.0 хувьд нь дунджаар 6-7 сурагч номын сангаар үйлчлүүлж байсан байна.

Дотуур байрны хүртээмжийг авч үзэхдээ хүүхдийн тоо ба орны тоонд тулгуурласан болно. Судалгаанд хамрагдсан дотуур байрнуудын нэг өрөөнд дунджаар 5-6 хүүхэд амьдарч байна. Хамгийн олондоо 8-уулаа, цөөндөө 3 хүүхэд нэг өрөөнд амьдардаг бөгөөд өрөөнүүдийн 68.7 хувьд нь хүүхдийн тоотой тэнцүү тоогоор ортой, 25.0 хувь нь хүүхдийнхээ тооноос цөөн тооны ортой байна.

### *Хичээлүүдийн сорилын гүйцэтгэл*

Судалгаанд хамрагдсан ангиудын бүх хичээлийн сорилыг боловсруулахдаа бага ангийн даалгаврын 50 хувь нь мэдлэг ойлголт, 50 хувь нь мэдлэг хэрэглэх байдлыг илрүүлэхийг зорьсон бол энэ харьцааг дунд ангийн хувьд 40 хувь нь мэдлэг ойлголтыг, 30 хувь нь мэдлэг хэрэглэх чадварыг, 30 хувь нь шинжлэх ухааны арга барилыг илрүүлэх, ахлах ангийн хувьд мэдлэг ойлголтыг 50 хувь нь, мэдээлэл боловсруулах асуудал шийдвэр чадварыг 30 хувь нь, туршилт гүйцэтгэх чадварыг 20 хувь нь илрүүлэх даалгавар байхаар тооцоолов.

**4 дүгээр анги**




**8 дугаар анги**




**11 дүгээр анги**




Сорилын гүйцэтгэлийн ерөнхий дундаж бага ангид 46.7; дунд ангид 38.3; ахлах ангид 34.3 байна. Анги ахих тутам хөтөлбөр эзэмшилт буурсан ба аль ч ангид мэдлэг, ойлголтыг авч үзсэн даалгаврын гүйцэтгэл мэдлэг хэрэглэх болон асуудал шийдвэрлэх, шинжлэх ухаанч арга барилын эзэмшилтийг авч үзсэн даалгаврын гүйцэтгэлээс илүү байна.

*Даалгаварын хүнд, хөнгөний байдал*




Анги ахих тусам сорилын даалгаврууд хүндэдсэн байна. Суурь боловсролын түвшний даалгаврын 36.0 хувь нь хэт хүндэдсэн бол бүрэн дунд боловсролын түвшинд 40 гаруй хувь нь хүндэдсэн нь харьцангуй өндөр үзүүлэлт байна.

Сорилын гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг авч үзэхэд, хувийн өмчийн сургуулийн сурагчдын хөгжмийн судлагдахууны мэдлэг, ойлголт нь төрийн өмчийн сургуулийн сурагчдаас илүү байсан. Хувийн өмчийн сургуулийн сурагчдын хөгжим, англи хэлний судлагдахууны мэдлэг ойлголтын үнэлгээний үзүүлэлт нь төрийн өмчийн сургуулийн сурагчдын гүйцэтгэлтэй харьцуулахад илүү үзүүлэлттэй байна.

Сурагчдын хот, хөдөөгийн сургуулийн сурагчдын англи хэлний мэдлэг ялгаатай нь харагдлаа ($p<0.01$). Улаанбаатар хотын сурагчдын даалгаврын гүйцэтгэлийн хувь аймаг, сумын сургуулийн сурагчидтай харьцуулахад илүү байна.

Эцэг эх, асрах хамгаалагчдын ажил эрхлэлт болон өрхийн сарын дундаж орлогын хэмжээ сурагчдын сорилын гүйцэтгэлтэй хамааралтай байна.

Сурагчдын орой унтдаг цаг, бага ангийн сурагчдын хичээлд бүрэн суусан эсэх, хичээлд ашигладаг нэмэлт материалууд мөн багшийн ажилласан жил сорилын гүйцэтгэлтэй хамааралтай нь нотлогдов.

# ОРШИЛ

Ерөнхий боловсролын сургалтын шинэчилсэн хөтөлбөр хэрэгжиж эхлээд 5 жил болж байгаа бөгөөд хөтөлбөрийн хөгжлийн бодлогыг хөтөлбөрийн менежментийн циклийн арга зүйд тулгуурлах шийдвэрийг БСШУСЯ-аас гаргав. Иймээс ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг судлах, хэрэгжилтэд нөлөөлж буй хүчин зүйлсийг тогтоох, багш нарын хөтөлбөр хэрэгжүүлэх арга зүйг дэмжихийг Боловсролын хүрээлэн чухалчилж байгаа юм.

### *Зорилго, зорилт*

Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг илрүүлэх, багш нарт арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгод хүрэхийн тулд дараах зорилтод ажлуудыг гүйцэтгэв. Үүнд:

*Зорилт:*

1. Ерөнхий боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн чиглэлээр хийсэн судалгааны үр дүнд дүн шинжилгээ хийх;
2. Ерөнхий боловсролын сургалтын цөм хөтөлбөр, сурах бичгийн уялдааг шинжлэх;
3. Ерөнхий боловсролын сургалтын цөм хөтөлбөрөөр суралцагчийн эзэмшвэл зохих мэдлэг, чадварыг 4, 8, 11 дүгээр ангийн бүх хичээлээр авч үзэх,
4. Ерөнхий боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн нөхцөл байдлын судалгааны арга, хэрэгсэл боловсруулах;
5. Сургалтын материаллаг орчин, хэрэглэгдэхүүний нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх;
6. Ерөнхий боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн хэрэгжилтэд нөлөөлж буй хүчин зүйлсийг тогтоох;
7. Судалгааны тайлан боловсруулж, сургалтын цөм хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх санал, зөвлөмж боловсруулах зэрэг болно.

### *Судалгааны арга, аргачлал*

Судалгааны мэдээллийг дараах хэрэглэгдэхүүнийг ашиглан цуглуулав. Үүнд:

1. ЕБС-ийн сургалтын менежер, багш, сурагч, эцэг эхээс *асуулга*;
2. БСГУ-ын мэргэжилтэн, багш, сурагч, сургалтын менежер, дотуур байрны сурагчаас *фокус бүлгийн ярилцлага*;
3. Бага, дунд, ахлах ангийн сурагчдын хөтөлбөрийн эзэмшилтийг тогтоох хичээлүүдийн *сорил*;
4. Сорилд хамрагдсан сургууль, ангийн ээлжит хичээлийн явцын, дотуур байрны материаллаг гадаад дотоод орчны *ажиглалт*.

Судалгааны мэдээлэлд тоон болон чанарын шинжилгээг хийж, MS Excel, Testan 6.5, SPSS 22 программ ашиглан статистик үзүүлэлтийг тооцов. Түүврийг зориудын түүврийн аргаар хийж, тэмдэглэл хөтлөх, ажиглалт, ярилцлага, асуулга, хичээлийн сорилууд ашиглан мэдээлэл цуглуулж, чанарын ба тоон шинжилгээ хийв. Түүвэрт бүс нутаг төлөөлүүлэн ерөнхий боловсролын 21 сургуулийг хамруулав.

### *Судалгаанд хамрагдагчид, тоогоор*

| БСУГ мэргэжилтэн | Сургуулийн удирдлага | Багш | Эцэг эх | суралцагчид | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | бага | дунд | ахлах |
| 36 | 90 | 1370 | 2440 | 804 | 635 | 595 |

Энэхүү судалгааг үндсэн 3 үе шат, үе шат бүрт нийт мөн 4 шатат үйл ажиллагаагаар хэрэгжүүлэв.

### *Судалгааны агуулгын хүрээ*






Судалгаагаар сургуулийн өмнөх боловсролын түвшингээс их, дээд сургуулийн түвшинд боловсролын бүхий л түвшний байгууллагын сургалтын үйл ажиллагаа, сургалтын орчин, байгууллагын менежмент, суралцагчдын хөтөлбөр эзэмшилтийн байдал зэргийг агуулгын хувьд хэрхэн уялдуулан авч үзсэн ба энэхүү тайланд ахлах, дунд, бага ангийн түвшинд хөтөлбөрийн хэрэгжилтийг тусгасан юм.

## Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр: эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт

### Эрх зүйн зохицуулалт

Монгол улсын иргэн бүрийн Үндсэн хуулиар хамгаалагдсан сурч боловсрох эрх, түүний дотор ерөнхий боловсрол эзэмших эрхийг хэрэгжүүлэхэд боловсролын агуулга, түүнийг хэрэгжүүлэх сургалтын хөтөлбөр чухал үүрэгтэй. Монгол улсын Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын 4.8-д "Сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын стандарт, цөм хөтөлбөрийг төрөөс тогтоож, чанар, үр дүнг үнэлнэ." гэж, Монгол улсын Боловсролын тухай хуулийн 3.11.8-д ""сургалтын цөм хөтөлбөр" гэж тухайн шатанд суралцагчийн эзэмших мэдлэг, ур чадвар, төлөвшлийн түвшин, түүнд хүрэх цогц үйл ажиллагааны ерөнхий зохион байгуулалтыг илэрхийлсэн баримт бичгийг;" ойлгоно гэж тус тус заасан байна. Сургалтын хөтөлбөр нь боловсролын агуулыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд шат, шатны боловсролын зорилго, агуулыг холбогдох хууль, бодлогын баримт бичигт тусгасан байна.

Боловсролын тухай хуулийн хоёр дугаар бүлэг бүхэлдээ боловсролын хөтөлбөр, агуулга, стандарттай холбоотой байна. Хуулийн энэ бүлэгт боловсролын агуулгыг "Боловсролын агуулга нь суралцагчийн нас, бие, сэтгэхүйн онцлог, авьяас, сонирхол, хувийн болон нийгмийн хэрэгцээ, үндэсний өв, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн хандлагад нийцүүлэн боловсролын зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэнэ" гэж заагаад, энэхүү боловсролын агуулгыг хөтөлбөрөөр зохион байгуулна гэжээ. Мөн уг хөтөлбөрийг боловсруулах, баталгаажуулахад хэн, ямар үүрэг гүйцэтгэхийг тогтоож өгсөн байна. Тухайлбал, СӨБ болон бага, суурь, бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрийг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага боловсруулж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянан батлахаар Боловсролын хуулийн 11.5-д, Бага, дунд боловсролын тухай хуулийн 7.3-т "Ерөнхий боловсролын сургуульд мөрдөх сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага боловсруулж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянаж, батална." гэж тус тус заасан байна. Харин төрөлжсөн болон гүнзгийрүүлсэн сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтоох бөгөөд тухайн сургалтын байгууллага шаардлагыг хангасан хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлдэг бол олон улсын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталдаг байна.

Мөн Боловсролын хуулийн 11.5-д сургалтын хөтөлбөрийг өмчийн бүх хэлбэрийн боловсролын сургалтын байгууллага дагаж мөрдөнө гэжээ.

Боловсролын тухай хуулиар боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үүргийг боловсролын хөтөлбөр, норм, нормативыг хэрхэн хэрэгжүүлж

байгааг тогтоох зорилгоор боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийн чанарт үнэлгээ хийх, дүгнэлт гаргах, хүүхдийн хөгжлийн ахиц дэвшлийг дэмжих, баталгаажуулах чиглэлээр мэргэжлийн удирдлагаар хангах;[3] гэжээ.

Дээрх хуулийн зохицуулалтын дагуу БСШУСЯ, түүний харьяа боловсролын мэргэжлийн байгууллагууд ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийг боловсруулах, түүний хэрэгжилтийг үнэлэх, судлах ажил дээр тодорхой чиг үүрэг хүлээн ажилладаг байна.

Боловсролын тухай багц хууль 2002 онд гарснаас хойш ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр хэд хэдэн удаа өөрчлөгдсөн байх бөгөөд эдгээр нь дээр танилцуулсан хуулийн дагуу, уг хуулиар боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад олгосон эрх хэмжээний хүрээнд гарсан тушаал шийдвэрээр хийгдсэн байна.

Дурьдсан хугацаанаас хойшхи эхний өөрчлөлтийг нь 2004-2006 хийсэн байна. Мөн 2002 онд БСШУ-ны сайдын А/202 дугаар тушаалаар "Бага, дунд боловсролын киррикюлим болон стандартыг шинэчлэн хөгжүүлэх үзэл баримтлал"-ыг баталсан нь сургалтын хөтөлбөрийг дахин боловсронгуй болгох үндэслэл болжээ. Энэхүү үзэл баримтлалын дагуу Боловсролын Хүрээлэнгээс "ЕБС-ийн агуулгын үлгэрчилсэн хүрээ"-г 2004-2006 онд боловсруулсан байна. Үүнд:

1. Ерөнхий боловсролын сургалтын төлөвлөгөө. Хичээлүүдийн агуулгын үлгэрчилсэн хүрээ, БСШУЯ, БХ, 2004;
2. Ерөнхий боловсролын шилжилтийн агуулгын хүрээ (2005-2006 оны хичээлийн жилд мөрдөнө), БСШУЯ, БХ, БХХ-3, 2005;
3. Ерөнхий боловсролын 11 жилийн сургуульд 2006-2007, 2007-2008 оны хичээлийн жилд мөрдөх сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зөвлөмж, хичээлүүдийн агуулгын үлгэрчилсэн хүрээ (Бага анги), БХ, 2006;
4. Ерөнхий боловсролын 11 жилийн сургуульд 2006-2007, 2007-2008 оны хичээлийн жилд мөрдөх сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зөвлөмж, хичээлүүдийн агуулгын үлгэрчилсэн хүрээ (Дунд, ахлах анги), БХ, 2006 зэрэг болно.

Сургалтын хөтөлбөрийн дараагийн өөрчлөлт нь 2006 онд ерөнхий боловсрол 11 жилийн боловсролын тогтолцоонд шилжсэнтэй холбоотойгоор хийгдсэн бөгөөд Боловсролын хүрээлэнгийн захирлын 15 дугаар тушаалаар 11 жилийн сургуульд судлах хичээлүүд болон тэдгээрийн агуулгын хүрээг боловсролын стандартын айн хүрээнд үлгэрчилсэн байдлаар боловсруулж хэрэгжүүлжээ. Эдгээр сургалтын хөтөлбөрийг боловсруулахад 2004 онд батлагдсан боловсролын стандарт чиг баримжаа болсон бөгөөд уг стандартад цогц чадамжийг *"Хүний эзэмшсэн мэдлэг, чадвар, туршлага, төлөвшсөн хандлага, зан үйлийн илэрхийлэл, хүний хөгжлийн чадамж"*, харин танин мэдэхүйн түвшний шалгуурыг *"Агуулгын ай бүрээр суралцагчдын эзэмших цогц чадамжийг үнэлэх тодорхой мэдлэг, чадварыг танин мэдэхүйн түвшин бүрт харгалзуулан тодорхойлсон жишиг"* гэж тодорхойлжээ.

Гурав дахь өөрчлөлт нь 2006 оноос эхэлсэн байх бөгөөд энэ нь ерөнхий боловсролын 12 жилийн сургалтад шилжих шийдвэр гарсантай холбоотой. 2008 онд 12 жилийн бүрэн дунд боловсролын тогтолцоонд шилжиж, сургалтын агуулгыг хүрэх үр дүнгээр тодорхойлж, арга зүй, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан өмнөх

[3] Боловсролын тухай хууль (2002), 28.1.8.

сургалтын хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх уялдаатай байдал, залгамж холбоог хангасан үндэсний 12 жилийн сургалтын хөтөлбөрийг боловсруулж, практикт нэвтрүүлсэн байна.

Харин Боловсролын хүрээлэнгээс хийж буй энэхүү судалгааны хүрээнд хэрэгжилтийн байдлыг нь тодорхойлохыг зорьж буй сургалтын хөтөлбөрийг боловсруулах, турших ажил4 2012 оноос эхэлж, 2013 онд БШУ-ны Сайдын А/155 тоот тушаалаар Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлал, сургалтын хөтөлбөр боловсруулах багийг судлагдахуун тус бүрээр баталжээ. Эдгээр баг нь 2012-2017 онд танин мэдэхүй, нийгэмшил болон зан үйл, хандлагыг өв тэгш хөгжүүлэх, амьдрах чадвартай монгол хүүхэд төлөвшүүлэх, үндэснийхээ боловсролын агуулга, арга зүй, тогтолцоог олон улсын боловсролын жишигт хүргэх, бие даан сурах арга барил эзэмшүүлэх зорилгоор сургалтын цөм хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамжуудыг боловсролын түвшин, судлагдахуун бүрээр боловсруулан үндэсний хэмжээнд дараах үе шатаар хэрэгжүүлж байна. Үүнд:

1. 2014 оноос бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг үндэсний хэмжээнд бүх нийтээр хэрэгжүүлсэн
2. 2015 оноос суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг үндэсний хэмжээнд бүх нийтээр хэрэгжүүлсэн
3. 2016 оноос бүрэн дунд боловсролын 10-р ангийн сургалтын цөм хөтөлбөрийг үндэсний хэмжээнд бүх нийтээр хэрэгжүүлсэн
4. 2017 оноос бүрэн дунд боловсролын 11-р ангийн сургалтын цөм хөтөлбөрийг үндэсний хэмжээнд бүх нийтээр хэрэгжүүлсэн
5. 2018 оноос бүрэн дунд боловсролын 12-р ангийн сургалтын цөм хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэ эхэлсэн байна.

Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг заавал судлах хичээлийн, заавал сонгон судлах хичээлийн гэсэн 2 хэлбэртэй боловсруулсан байна.

Сургалтын цөм хөтөлбөр бүрт сургалт, үйл ажиллагааны зорилго, зорилт, зохион байгуулалт, арга зүй, үнэлгээ, сургалтын орчин, багш, эцэг эхийн оролцоо зэрэг нийтлэг зүйлс тусгагдсан. Цөм хөтөлбөр нь багш суралцагчийн хамтын үйл ажиллагаанаас гадна сургуулийн бодлого, менежмент, эцэг, эх, асран хамгаалагч, олон нийтийн байгууллага, хамтын оролцооны үр дүнд хэрэгжих бөгөөд сургалтын болон сургалтыг дэмжих үйл ажиллагааны зохион байгуулалт, арга зүйгээр дамжуулан сурагчдад цогц чадамж төлөвшихөд нь боломж, дэмжлэгийг бий болгоход чиглэнэ. Сургалтын цаг гэдэгт хичээл/судлагдахуунаар хэрэгжих үйл ажиллагаа, сургалтыг дэмжих үйл ажиллагаа гэдэгт байгаль, нийгэм, соёлын хүрээний иргэний боловсрол, амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа, хичээлээс гадуурх үйл ажиллагааг хамааруулан авч үзэж байна.

Цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын орчин гэдэгт танхим, танхимаас гадуурх байгаль, нийгэм, соёлын орчинг авч үзэхээс гадна, суралцагч өөрөө бие даан суралцах үйлийн орчин, цахим техник хэрэгсэл зэргийг зааж өгчээ. Сургалтын хэрэглэгдэхүүнийг орон нутгаг, сургуулийн онцлогийг харгалзан олдоцтой хямд төсөр, гарын доорх материал ашиглан бэлтгэж болох талаар дурджээ.

[4] 2012 оны БШУ-ны Сайдын А/180-р тушаалаар

*Сургалтын цөм хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, чадвар, хандлага*

*Бага боловсролын цөм хөтөлбөрт* суралцагчийн танин мэдэхүйн, хэл-нийгмийн, амьдрах ухааны чадамжийг хөгжүүлж, түүнд харгалзах ерөнхий чадвар, сурах арга барил эзэмшихэд хувь нэмэр үзүүлнэ гэж тусгажээ.

*Танин мэдэхүйн чадамж:* сэтгэн бодох, асуудал шийдвэрлэх, *хэл-нийгмийн чадамж нь* харилцах, хамтран суралцах *, амьдрах ухааны чадамж* нь бие даан суралцах, мэдээлэл, технологитой ажиллах, эрүүл ахуйн зөв дадал хэвшилтэй болох, байгаль орчинтой зөв харилцах ерөнхий чадваруудаас бүрдэх аж.

*Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн* зорилго нь сурагч бүрт сурах арга барил, амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар, бие даан бүтээлчээр суралцах чадвар эзэмших, үндэсний хэл, түүх, соёлоо дээдлэн хөгжүүлэх, ардчилсан, хүмүүнлэг үзэлтэй иргэн болон төлөвшихөд боломж олгох зорилготой.

Хөтөлбөрийн агуулга, арга зүй нь сурагчдын бүтээлч үйл ажиллагаа, асуудал шийдвэрлэх, хамтран ажиллах, үр дүнгээ бусдадаа танилцуулах үйл дээр суурилахаар тусгагдсан. Сургалтыг зориулалтын анги танхим, лаборатори, музей, номын сан ашиглаж явуулна.

Суурь боловсролын цөм хөтөлбөр нь зорилгоо хэрэгжүүлэхдээ суралцагчдын суралцах чадварын хөгжил, шинжлэх ухааны мэдлэг, ойлголтын эзэмшилт, юмс үзэгдлийг судлах сонирхол, идэвх зүтгэл эрмэлзлэлийг бий болгоход чиглэнэ.

*Суралцах чадварын хөгжил нь:* таамаглал дэвшүүлэн шинжлэн судлах, мэдээлэлтэй ажиллах зэрэг үйл ажиллагааг төлөвлөн, үе шаттайгаар хэрэгжүүлэх, баримт нотолгоонд тулгуурлан үр дүнг тооцож, задлан шинжлэх, учир шалтгаанд нь сэтгэн, нэгтгэн дүгнэх, түүнийгээ, илэрхийлэх, засан сайжруулах чадварыг агуулна.

*Шинжлэх ухааны мэдлэг, ойлголтын эзэмшилт нь:* тодорхой шинжлэх ухааны мэдлэг ойлголт, онол, зүй тогтлыг эзэмших, үүнийгээ ашиглан бусадтай харилцаж, илэрхийлэх, өдөр тутмын амьдрал үйл ажиллагаандаа хэрэглэх чадвараар илэрнэ.

*Юмс үзэгдлийг судлах сонирхол, идэвх зүтгэл, эрмэлзлэл нь:* юмс үзэгдлийн зүй тогтол, хувирал өөрчлөлтийг судлах сонирхол хэрэгцээ, судлагдахуун бүрийн үйл ажиллагаанд идэвх санаачилга, хүсэл эрмэлзлэлтэй оролцох байдал, үр бүтээлтэй ажиллах, хариуцлагатай, хамтран ажиллах чадвар, түүх, соёл, уламжлалаа хайрлах, бүтээх сонирхол эрмэлзлэлийг агуулна.

*Бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрөөр* суралцагчдын эзэмшвэл зохих чадварыг шинжлэх ухааны үндэс,түүний гүнзгийрэл судалгааны арга, бие даан бүтээлчээр, насан туршдаа суралцах хандлага, чадвар, ажил мэргэжлийн чиг баримжаатай болох, авъяас, давуу талаа таньж хөгжүүлэх, хувь хүний хөгжил, нийгмийн үнэт зүйлийг эзэмших, иргэн болж төлөвшихөд шаардлагатай ур чадвар гэж Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сургалтын талаар баримтлах бодлогод тусгасан байна (2016).

*Сургалтын хөтөлбөр ба сурах бичиг*

Сургалтын хөтөлбөрийн өөрчлөлт нь сурах бичгүүдийг дахин боловсруулах хэрэгцээг бий болгож иржээ. Бага, дунд боловсролын тухай хуулийн Хоёрдугаар бүлгийн 8.1, 8.2-т бага, дунд боловсролын сурах бичиг нь боловсролын стандарт, эрүүл ахуйн шаардлагад

нийцсэн байх, ийм сурах бичиг зохиох, хэвлүүлэх, түгээх ажлыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмын дагуу зохион байгуулахаар, Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын талаар баримтлах бодлогод “Стандартад суурилсан боловсролын шинэчлэл, сургалтын нээлттэй хөтөлбөрийн бодлого, бага, суурь, бүрэн дунд боловсролын стандарт, түүний үзэл санааны хүрээнд сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний агуулга, арга зүйг нээлттэй, хувилбартай, сонголттой болгох зарчмыг баримтлан шинэчлэн хөгжүүлэхээр” тус тус заажээ. Хуулийн дагуу боловсролын асуудал эрхэл төрийн захиргааны төв байгууллагаас “Сурах бичиг зохиох, хэвлэх, түгээх журам”-ыг 2006 он (108 дугаар тушаал(, 2007 он )хоёр удаа, 102, 278 дугаар тушаал(, 2008 онуудад боловсруулан мөрдсөн байна.

Өнөөгийн байдлаар 2008 оны журмын дагуу, сургалтын цөм хөтөлбөрийн дараах сурах бичгүүдийн сургалтад ашиглаж байна. Үүнд:

- Бага боловсролын түвшинд 6-8 судлагдахууны 33 нэрийн сурах бичиг;
- Суурь боловсролын түвшинд 6-9 дүгээр ангийн 11-17 судлагдахууны 54 нэрийн сурах бичиг;
- Бүрэн дунд боловсролын түвшинд 10-12 дугаар ангийн 14-15 судлагдахууны 38 нэрийн сурах бичиг;

Монгол улсын Засгийн газрын шийдвэрийн[5] дагуу 2009 оноос бага ангийн сурагчдын сурах бичгийг 80-100 хүртэл хувийг, дунд ахлах ангийн зорилтот бүлгийн сурагчдад зориулан 40 хүртэл хувийг төрөөс үнэгүй хангаж, сургуулийн номын сангаар дамжуулан олгож байна.

### *Сургалтын хөтөлбөр ба үнэлгээ*

Сургалтын хөтөлбөрийн өөрчлаөлтийг дагаж сурагчийн болон сурлагын амжилтын үнэлгээний журам мөн л өөрчлөгдөж ирсэн байна.

БСШУ-ны Сайдын 2013 оны А/309 тоот тушаалаар ерөнхий боловсролын суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварыг ахиц амжилтыг үнэлж, сайжруулах зорилгоор “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон чанарын үнэлгээний журам”-ыг баталсан. Энэхүү журмаар суралцагч дүнгийнхээ 10 хувийг ирц, 60 хувийг явцын үнэлгээ, 30 хувийг үр дүнгийн үнэлгээнээс авахаар зохицуулжээ. Явцын үнэлгээний мөн чанар нь дүн тавихад чиглээгүй бөгөөд багш суралцагчийн суралцах үйлтэй холбоотой мэдээлэл цуглуулах, түүнд суурилж заах арга зүйгээ өөрчлөх, тохируулах зорилготой тул энэхүү журам нь явцын үнэлгээний мэдээллийг сурлагын дүнтэй хамааруулахгүй байх олон улсад баримталдаг нийтлэг зарчимтай зөрчилдөж байв. Мөн сургалтын цөм хөтөлбөрт суралцагч мэдлэг, чадвар, хандлага эзэмшинэ гэж заасан ч энэхүү журамд мэдлэг, чадварын ахицыг үнэлнэ гэж заасан нь сургалтын хөтөлбөртэй энэ тал дээр сайн уялдаагүй харагдаж байгаа юм. Эдгээрээс үндэслэн БСШУС-ын Сайдын 2018 оны А/425 тоот тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарыг үнэлэх журам”-ыг баталсан юм. Энэхүү журмаар өмнөх журмын дээр дурдсан зарим дутагдалтай зүйлсийг засаж, сайжруулсан ба суралцагчийн сурлагын амжилтыг үр дүнгийн үнэлгээгээр дүгнэх, суралцагчийн хандлага, төлөвшлийг үнэлэх талаар тусгасан.

[5] Монгол улсын Засгийн газрын 2009 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны 28 дугаар тэмдэглэлийн 7.1

2013 оны “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон боловсролын чанарын үнэлгээний журам”-аар боловсролын чанарыг тасралтгүй хянаж, үнэлэх боломжтой болсон байна.

Монгол улсад хэрэгжсэн сургалтын хөтөлбөрүүдэд хийсэн шинжилгээний үр дүнгээс үзэхэд сургалтын хөтөлбөр нь олон улсын чиг хандлага, үндэсний үнэт зүйл, өсвөр үеийнхний нийтлэг сайн сайхан байдал, хүүхэд бүрийн хөгжлийг хангахад чиглэсэн төрийн бодлогын үндсийг шинээр дэвшүүлсэн давуу талтай ч, богино хугацааны өөрчлөлт нь сургалтын хөтөлбөрийн уялдаа холбоо алдагдах, үр дүнг дараагийн шинэчлэл, өөрчлөлтөд тусган хэрэгжүүлэх үндэсний болон сургуулийн түвшний тогтолцоо бүрдэж амжихгүй байдалд хүргэж байна. Түүнчлэн үндэсний хэмжээнд сургалтын хөтөлбөрийг үнэлэх, сайжруулах, менежмент төлөвшөөгүйгээс сургалтын хөтөлбөрийн урт, дунд хугацааны хэрэгжилтийн үр дүнд дүгнэлт хийх боломж бүрдэхгүй байгаа юм. Иймд сургалтын хөтөлбөрийг төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах цогц үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлдэг улс орны туршлагад үндэслэн Монгол улсын онцлогт тохирсон “Хөтөлбөрийн менежментийн цикл”-ийг нэвтрүүлж, нотолгоонд суурилсан тогтвортой бодлого, төлөвлөлтийг бий болгох зорилгоор БСШУС-ын сайдын 2018 оны А/549 тоот тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох аргачлал”-ыг баталж, үндэсний хэмжээнд мөрдөхөөр болжээ.

## Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн удирдлага, зохион байгуулалт

Судалгааны явцад аймгуудын БСУГ-ын мэргэжилтнүүд болон сургалтын менежерүүдээс сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр хийж буй ажлын талаар мэдээлэл авав.

### *Хэрэгжилтийг хангах чиглэлээр хийж, зохион байгуулж буй ажил*

Аймаг, орон нутгийн түвшинд боловсролын хөтөлбөр батлан хэрэгжүүлж байгаа нь сургалтын цөм хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд хийж буй нэг ажил гэж тэд үзэж байна. Тухайлбал, “Чадварлаг багш”, “Эрдэм хөтөлбөр 2020” зэрэг хөтөлбөр, мөн багш нарт заах арга, аргачлалыг тодорхой болгосон хөтөлбөр батлан хэрэгжүүлж буй сайн туршлага байна.

Аймгуудын БСУГ болон мэргэжилтнүүд тухайн хичээлийн жилд 1-2 удаа сумын сургуулиар явж зөвлөн туслах ажил хийдэг гэж байгаа боловч зарим аймаг энэ хичээлийн жилд нэг ч яваагүй тохиолдол байлаа. Тэдний зөвлөн туслах ажил зөвхөн хичээлд ажиглалт хийж, зөвлөгөө өгөхөөр хязгаарлагддаг байдал ажиглагдав.

Мэргэжилтнүүдийн олонх нь сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр дараах ажлыг хийдэг гэв. Үүнд: багш нартайгаа хамт агуулгын шинжилгээ хийсний үр дүнд агуулга давхцахгүй, агуулга орхигдохгүй байх боломж бүрджээ. Орон нутгийн зөвлөгөөн, сайн хичээл, үйл ажиллагаа зохион байгуулж, харилцан туршлага солилцох, бие биеэсээ суралцах боломжоор хангадаг. Судлагдахуун бүрээр granddesign гаргадаг, багш нартай хамтран даалгавар боловсруулдаг гэх мэт ажлуудыг онцлон дурдаж байв.

> Сургуулиудад зөвлөмжилдөг. Сүүлийн жилүүдэд сумдын багш солилцоог хэрэгжүүлж байна. Тухайлбал, ...суманд очиж 7 хоног математик монгол хэлний шилдэг багш нар хичээл заах ажил хийсэн.
>
> *Аймгийн БСУГ-ын мэргэжилтэн*

Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой санал, хүсэлтийг сургууль, багш нараас ирүүлдэг эсэх талаар БСУГ-ын мэргэжилтнүүдээс тодруулахад багш нараас ирдэг саналын олонх нь агуулгын багтаамж, сургалтын хэрэглэгдэхүүнтэй холбоотой бэрхшээлүүд байдаг. Тухайлбал, зарим мэргэжилтний тооцоогоор багш нар сар бүр 50,000-78,000 төгрөгийн зардал (цалингийн 10 орчим хувийг тогтмол) гаргадаг байна. Мөн цэцэрлэгийн багш нарт зориулж сурах бичиг гаргаж болох эсэх, тэднийг оролцуулаад сурах бичиг зохиох, өдөрт 10-11 цаг ажиллаж байхад улирлын амралт өгөх тухай санал ирсэн байна.

*Сургалтын хөтөлбөрийн хэрэгжүүлэх чиглэлээр хийж буй хамтын ажиллагаа, оролцоо*

Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, хичээлийн төлөвлөлтийн хэрэгжилтийг дэмжихэд сургалтад оролцогчдын хамтын үйл ажиллагааг дэмжих менежментийг чухалчилах нь хөтөлбөрийн үзэл баримтлалд нийцнэ.

Орон нутгийн боловсролын газраас сургууль болон багш нарын хамтын үйл ажиллагаа, бие биеэсээ суралцах боломжийг дэмжсэн дараах үйл ажиллагааг зохион байгуулжээ. Үүнд: аймаг бүр сургуулийн хамтын ажиллагааны 2-6 бүс болгон зохион байгуулдаг; орон нутагт багш солилцооны хөтөлбөр хэрэгжүүлсэн; багш нар ажлын 5 хоногоор солигдож хичээл заасан; багшийн хөрөг нэвтрүүлэг хийсэн, хичээлийн судалгааг аян хэлбэрээр байнга зохион байгуулж байгаа; олимпиад зохион байгуулж байна; эцэг эх, орон нутгийн байгууллагатай түншлэлийн гэрээ байгуулж хичээлд суух зэргээр ажилладаг; англи хэлний багш нарын бага хурал зохион байгуулсан зэрэг болно.

Сургалтын хөтөлбөрийн чиглэлээрх хамтын үйл ажиллагааны талаар сургалтын менежерүүдийн хувьд голлон хамтран ажилладаг хүмүүс нь *багш нар, эцэг эх* бөгөөд эцэг, эхийн оролцоог “сайн” гэж үзсэн байна. Олонх сургууль эцэг, эхээс сэтгэл ханамжийн болон сургуулийн үйл ажиллагааны талаар асуулга судалгаагаар мэдээлэл цуглуулдаг бөгөөд эцэг, эхтэй хамтран ажиллах үйл ажиллагааг сургуулийн төлөвлөгөөнд тусгайлан тусгаж, сурагчдын хичээл сонголт хийх, тайлан хэлэлцүүлэх зэрэг үйл ажиллагаанд хамруулах; эцэг, эхийн зохион байгуулах гэх мэт уламжлалт үйл ажиллагаанаас гадна:

- 12-р ангид эцэг эхийн хяналтын баг ажиллуулах,
- шатар, даам зэрэг дугуйланг эцэг эх зохион байгуулах,
- нутгийн дуу, үлгэр, тууль заах,
- эцэг эхийн бүлэг байгуулах гэх мэт ажлуудыг хэрэгжүүлдэг байна.

Хамтын үйл ажиллагаа сургууль бүрт харилцан адилгүй байх бөгөөд нэг сургууль энэ талаар ямар ч оролцоо байхгүй гэжээ. Тухайлбал, нэгэн “сумын сургуулийн хувьд эцэг эхийн дэмжлэг бараг байхгүйтэй адил, 1-р ангид нь жаахан анхаардаг. Ангийн хурал зарлахад эцэг эх, асран хамгаалагчдын 50 хувь л ирдэг” гэсэн байх юм.

Мөн тодорхой аж ахуйн нэгж байгууллага, ОУБ, төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажилладаг талаар сургалтын менежерүүд дурджээ.

Сургуулиудын хувьд сургалт, арга зүйн чиглэлээр туршлага солилцох, арга зүйн дэмжлэг, сургалт авах зэргээр хамтран ажилладаг бол аж ахуйн нэгж байгууллага болон ОУБ, төсөл хөтөлбөр нь санхүүгийн дэмжлэг үзүүлэхээс гадна үйл ажиллагаа үйл ажиллагаа зохион байгуулахад тусалдаг байна. Тухайлбал, судалгаанд хамрагдсан нэгэн аймгийн хувьд Дэлхийн зөн ОУБ-ын дэмжлэгтэй төсөл хэрэгжүүлэн сургуулийн тоглоомын талбайг тохижуулсны зэрэгцээ зорилготой амьдрах сургалт зохион байгуулж, технологийн танхим, орон нутгийн сангаас хөгжмийн танхим байгуулж өгсөн байна. Мөн Цагдаагийн газар зэрэг зарим төрийн байгууллагатай хамтран ажиллаж замын хөдөлгөөний дүрмийн хичээлийг аймгийн сургуулиудын хэмжээнд ордог жишээ байна.

### *Сургалтын хөтөлбөрийн хэрэгжүүлэх багшийн хөгжил*

Сургалтын менежерүүд өөр өөрийн сургуулийг багшийг хөгжүүлэх, хүний нөөцийн чиглэлийн тусгайлсан бодлоготой, тодорхой үйл ажиллагаа хэрэгжүүлдэг гэдгээ мэдэгдсэн.

Сургалтын менежерүүдийн хувьд, цаашид багшийн хөгжлийг дэмжих чиглэлээр хийх ажлын нэг нь сургалт гэж үзсэн нь багш нарын саналтай ижил байгаа бөгөөд тухайлан, залуу багш нарт зориулсан, шинэ гарч буй бодлого, журмын хэрэгжилтийг дэмжсэн сургалт хэрэгтэй гэсэн байна. Учир нь залуу багш нарыг ажлын байран дээр сургахад менежерүүдээс ихээхэн хүч хөдөлмөр цаг хугацаа зарцуулж байгаагийн зэрэгцээ шинээр гарсан тухайлбал, журнал хөтлөх, үнэлгээний журмыг хэрэгжүүлэх зэрэгт бэрхшээл үүссэн байна. Мөн ёс зүйн, сэтгэл зүйн, харилцааны ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр сургалт хэрэгтэй гэж менежерүүд үзэж байна. Багш нарын аливаа сургалтыг сурагчдын амралтын үеэр зохион байгуулдаг байх, БСШУСЯ, БМДИ-ээс явуулж байгаа сургалтын чанарт анхаарах хэрэгтэй гэжээ. Түүнчлэн:

- багшийн хөгжилтэй холбоотой гарын авлага, материал шаардлагатай байна,
- сайн туршлага, цахим хичээлүүдийг нээлттэй тавих, хуваалцах,
- арга зүйн зөвлөмжөөр хангах,
- үнэлгээ тодорхой стандарттай байх.
- компьютерийн сургалтад хамруулах,
- сургалтын орчин буюу хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангах, өндөр хурдны интернэтэд холбох гэх мэт зүйлс эн тэргүүнд шаардлагатай байгааг ярилцлагад хамрагдсан багш нар дурджээ.

> Сургалтууд багшийг хөгжүүлэхэд чиглэсэн биш, цаг үеийн мэдээлэл түгээхэд чиглэж байдаг. Сургалтын чанар, үр өгөөж сул.
>
> *Ерөнхий боловсролын сургуулийн багш*

Багш мэргэжлийн хувьд тасралтгүй хөгжих чиглэлийн үйл ажиллагаанд багш нарын ихэнх нь сэтгэл дундуур байна. Тэд одоогийн зохион байгуулагдаж байгаа сургалтууд нь багш нарын хэрэгцээ, шаардлагыг хангаж чадахгүй, цаг нөхцөөсөн төдий байгаа гэх мэтээр шүүмжлэлтэй хандсан байна.

> Багш нарт арга зүйн зөвлөгөө өгдөгөөс, мэдлэгийг нь сайжруулах сургалт бага. Сургалтуудыг явуулахаас өмнө багш нараас санал, чиглэл авч баймаар байна.
>
> *Ерөнхий боловсролын сургуулийн багш*

Судалгааны хүрээнд анхаарал хандуулсан нэг асуудал нь сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулж, багш нарт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлдэг БСУГ-ын мэргэжилтнүүд болон сургалтын менежерт шаардлагатай байгаа мэргэжлийн хөгжлийн дэмжлэг туслалцааг тандах явдал байлаа.

Цугларсан мэдээллээс үзэхэд мэргэжилтнүүдийн олонх нь "Өөрийгөө хангалттай гэж хэлж чадахгүй", "Миний хувьд дундаж түвшинд", "Хангалттай гэж хэлэхгүй" гэх мэтээр өөрсдийн мэргэжлийн мэдлэг, чадварт шүүмжлэлтэй хандаж байна. Тэдний үзэж буйгаар сургалтын хөтөлбөрт шинээр орж ирсэн, тодорхой чадвар шаардсан зүйлсийг хийхэд бэлэн биш байна гэж үзэж байна. Мөн багш нарынхаа ард орох явдал байгааг ч тэмдэглэсэн байна. Тэдний хувьд мэргэжлийн чиглэлээр сургалтанд хамрагдаж, хэлний мэдлэгээ дээшлүүлэх. Шинэ шинэ программмуудыг сурах, өөрийгөө хөгжүүлэх хүсэл сонирхол байна.

Мэргэжилтнүүд мэргэжлийн хувьд хөгжих, багш нартаа мэргэжлийн зөвөлгөө, дэмжлэгийг хангалттай өгч чадахгүй байгаад дараах нөхцөл байдал нөлөөлдөг гэжээ. Үүнд:

- Захиргааны ажил их хийдэг. Тухайлбал, хэлний зөвлөлийн тайлан бичих, ёс зүйн зөвлөлд ажиллах, төрийн байгууллага болон энэ тэндээс хийж буй эсээ зохион бичлэгийн уралдаануудыг зохион байгуулах гэх мэт. Намын ажлууд хүртэл маш олон зохиогдож ажил дээр ажил нэмдэг.
- Давхар давхар ажил, мөн судлагдахуунуудыг хариуцдаг. Тухайлбал, тухайн 2-3 судлагдахуунаас гадна эмч, дотуур байр, ..... зэргийг давхар хариуцан ажиллана.
- Цалин бага, багш нараас бага цалин авдаг.
- Ажлын цагийн ачаалал их.

БСУГ-ын мэргэжилтэн мэргэжил дээшлүүлэхэд Боловсролын хүрээлэн илүү үүрэг гүйцэтгэх хэрэгтэй гэж зарим оролцогч үзсэн байна. Мөн тэд орон нутагт боловсролын бодлогыг хэрэгжүүлэхэд бодлогын тогтворгүй байдал, дээд түвшний байгууллагуудаас өгч буй мэдээлэл зөрүүтэй байдаг нь бэрхшээлтэй байдаг хэмээн тэмдэглэжээ.

Цаашид анхаарах асуудал, санал:

- Арга зүйчийг үе шаттай сургалтаар бэлтгэх. Тэднийг бэлтгэх бодлого, тогтолцоо хэрэгтэй.
- Тэдэнд зориулан хийж буй сургалтын чанарт анхаарах. Агуулгын болон сургагч багш нарын талаас. Тухайлбал, мэргэшүүлэх сургалтын гадна удирдахуйн сургалт, хэлний сургалт шаардлагатай.

Зарим сургалтын менежерүүд өөрсдийн мэргэжил, мэдлэг чадварын тухайд зарим менежер "мэргэжил арга зүйн хувьд бол багш нартаа зөвлөх туслах бол аль ч менежерт тэр тал дээрээ сайн ажилладаг" гэсэн боловч судалгаанд оролцсон бүх сургалтын менежерүүдийн хувьд өөрсдийн мэргэжлийн мэдлэг, хөгжлийн хувьд "чамлангүй" явдаг байна. Тэд олон төрлийн хичээл зааж буй мэргэжлийн багш нар зөвлөгөө өгөхөд

өөрсдийн мэдлэг хангалтгүй гэж үзэхийн зэрэгцээ зөвхөн арга зүйн талын зөвөлгөө өгдгөө хэлж байв. Тухайлбал, "Би л гэхэд чинь Биеийн тамир, Түүх нийгэм, Гадаад хэлний багш нар хариуцаж ажилладаг. Гадаад хэл, Биеийн тамирын багш нарт дэмжлэг үзүүлэхэд дутмаг байна. Гадаад хэлний хичээлд сууж зөвлөгөө өгөхөд нэлээд асуудалтай байна. Би өөрөө монгол хэлний багш." гэжээ. Мөн олон жил менежер хийсэн хүн багшийн мэргэжлээсээ хөндийрөх бэрхшээл үүсдэг байна.

Дээрх нөхцөл сургалтын менежер бүрт үүсдэг байх бөгөөд тэд хичээлд суухдаа секцийн ахлагч нарыг дагуулан суугаад мэргэжлийн талаар нь зөвлөгөө өгүүлдэг байна. Мөн нэг сургалтын менежерийн хэлснээр "... Өмнө нь сургалтын менежерүүдэд сургалтын хөтөлбөрийн талаар сургалтууд өгөгдөөд байсан. Энэ жилийн тухайд яг бидэнд чиглэсэн сургалт өгөөгүй. Жишээлбэл, энэ жил мэргэжил мэргэжлийн багш нарт нь чиглэсэн сургалт хийгээд бидэнд сургалт өгөөгүй бас бичиг нь ирээгүй учраас багш нар нь нэг өөр ойлголттой байсан учир зөрүүтэй зүйл бий болсон. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой сургалтын менежерүүдэд нэлээн сайн зөвлөгөө заавар өгч баймаар л санагддаг" гэсэн байна. Тэдний үзэж байгаагаар удирдлагуудад зориулсан сургалт, хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа шаардлагатай байна. Юуны өмнө судалгаа арга зүй, багшид мэргэжлийн дэмжлэг үзүүлэх мэдлэг ур чадвараа хөгжүүлэх хэрэгцээ тэдэнд байна. Үүний тулд сургалтын менежерүүдийг чадавхжуулах сургалтыг тогтмол календарчласан төлөвлөгөөтэй бай шаардлагатай.

# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

## Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн удирдлага, зохион байгуулалт

### *Хэрэгжилтийг хангах чиглэлээр хийж, зохион байгуулж буй ажил*

Судалгааны явцад аймгуудын БСУГ-ын мэргэжилтнүүдээс сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж буй ажлын талаар мэдээлэл авав.

Аймаг, орон нутгийн түвшинд боловсролын хөтөлбөр батлан хэрэгжүүлж байгаа нь сургалтын цөм хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд хийж буй нэг ажил гэж тэд үзэж байна. Тухайлбал, “Чадварлаг багш”, “Эрдэм хөтөлбөр 2020” зэрэг хөтөлбөр, мөн багш нарт заах арга, аргачлалыг тодорхой болгосон хөтөлбөр батлан хэрэгжүүлж буй сайн туршлага байна.

Аймгуудын БСУГ болон мэргэжилтнүүд тухайн хичээлийн жилд 1-2 удаа сумын сургуулиар явж зөвлөн туслах ажил хийдэг гэж байгаа боловч зарим аймаг энэ хичээлийн жилд нэг ч яваагүй тохиолдол байлаа. Тэдний зөвлөн туслах ажил зөвхөн хичээлд ажиглалт хийж, зөвлөгөө өгөхөөр хязгаарлагддаг байдал ажиглагдав.

Мэргэжилтнүүдийн олонх нь сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр дараах ажлыг хийдэг гэв. Үүнд: багш нартайгаа хамт агуулгын шинжилгээ хийсний үр дүнд агуулга давхцахгүй, агуулга орхигдохгүй байх боломж бүрджээ. Орон нутгийн зөвлөгөөн, сайн хичээл, үйл ажиллагаа зохион байгуулж, харилцан туршлага солилцох, бие биеэсээ суралцах боломжоор хангадаг. Судлагдахуун бүрээр granddesign гаргадаг, багш нартай хамтран даалгавар боловсруулдаг гэх мэт ажлуудыг онцлон дурдаж байв.

> Сургуулиудад зөвлөмжилдөг. Сүүлийн жилүүдэд сумдын багш солилцоог хэрэгжүүлж байна. Тухайлбал, ...суманд очиж 7 хоног математик монгол хэлний шилдэг багш нар хичээл заах ажил хийсэн.
>
> *Аймгийн БСУГ-ын мэргэжилтэн*

Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой санал, хүсэлтийг сургууль, багш нараас ирүүлдэг эсэх талаар БСУГ-ын мэргэжилтнүүдээс тодруулахад багш нараас ирдэг саналын олонх нь агуулгын багтаамж, сургалтын хэрэглэгдэхүүнтэй холбоотой бэрхшээлүүд байдаг. Тухайлбал, зарим мэргэжилтний тооцоогоор багш нар сар бүр 50,000-78,000 төгрөгийн зардал (цалингийн 10 орчим хувийг тогтмол) гаргадаг байна. Мөн цэцэрлэгийн багш нарт зориулж сурах бичиг гаргаж болох эсэх, тэднийг оролцуулаад сурах бичиг зохиох, өдөрт 10-11 цаг ажиллаж байхад улирлын амралт өгөх тухайд санал ирсэн байна.

### *Сургалтын хөтөлбөрийн хэрэгжүүлэх чиглэлээр хийж буй хамтын ажиллагаа, оролцоо*

Орон нутгийн боловсролын газраас сургууль болон багш нарын хамтын үйл ажиллагаа, бие биеэсээ суралцах боломжийг дэмжсэн дараах үйл ажиллагааг зохион байгуулжээ. Үүнд: аймаг бүр сургуулийн хамтын ажиллагааны 2-6 бүс болгон зохион байгуулдаг; орон нутагт багш солилцооны хөтөлбөр хэрэгжүүлсэн; багш нар ажлын 5 хоногоор солигдож хичээл заасан; багшийн хөрөг нэвтрүүлэг хийсэн, хичээлийн судалгаа аян хэлбэрээр байнга зохион байгуулж байгаа; олимпиад зохион байгуулж байна; эцэг эх, орон нутгийн

байгууллагатай түншлэлийн гэрээ байгуулж хичээлд суух зэргээр ажилладаг; англи хэлний багш нарын бага хурал зохион байгуулсан зэрэг болно.

Сургалтын хөтөлбөрийн чиглэлээрх хамтын үйл ажиллагааны талаар сургалтын менежерүүдийн хувьд голлон хамтран ажилладаг хүмүүс нь *багш нар, эцэг эх* бөгөөд эцэг, эхийн оролцоог "сайн" гэж үзсэн байна. Олонх сургууль эцэг, эхээс сэтгэл ханамжийн болон сургуулийн үйл ажиллагааны талаар асуулга судалгаагаар мэдээлэл цуглуулдаг бөгөөд эцэг, эхтэй хамтран ажиллах үйл ажиллагааг сургуулийн төлөвлөгөөнд тусгайлан тусгаж, сурагчдын хичээл сонголт хийх, тайлан хэлэлцүүлэх зэрэг үйл ажиллагаанд хамруулах; эцэг, эхийн зохион байгуулах гэх мэт уламжлалт үйл ажиллагаанаас гадна:

- 12-р ангид эцэг эхийн хяналтын баг ажиллуулах,
- шатар, даам зэрэг дугуйланг эцэг эх зохион байгуулах,
- нутгийн дуу, үлгэр, тууль заах,
- эцэг эхийн бүлэг байгуулах гэх мэт ажлуудыг хэрэгжүүлдэг байна.

Хамтын үйл ажиллагаа сургууль бүрт харилцан адилгүй байх бөгөөд нэг сургууль энэ талаар ямар ч оролцоо байхгүй гэжээ. Тухайлбал, нэгэн "сумын сургуулийн хувьд эцэг эхийн дэмжлэг бараг байхгүйтэй адил, 1-р ангид нь жаахан анхаардаг. Ангийн хурал зарлахад эцэг эх, асран хамгаалагчдын 50 хувь л ирдэг" гэсэн байх юм.

Мөн тодорхой аж ахуйн нэгж байгууллага, ОУБ, төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажилладаг талаар сургалтын менежерүүд дурджээ.

Сургуулиудын хувьд сургалт, арга зүйн чиглэлээр туршлага солилцох, арга зүйн дэмжлэг, сургалт авах зэргээр хамтран ажилладаг бол аж ахуйн нэгж байгууллага болон ОУБ, төсөл хөтөлбөр нь санхүүгийн дэмжлэг үзүүлэхээс гадна үйл ажиллагаа үйл ажиллагаа зохион байгуулахад тусалдаг байна. Тухайлбал, судалгаанд хамрагдсан нэгэн аймгийн хувьд Дэлхийн зөн ОУБ-ын дэмжлэгтэй төсөл хэрэгжүүлэн сургуулийн тоглоомын талбайг тохижуулсны зэрэгцээ зорилготой амьдрах сургалт зохион байгуулж, технологийн танхим, орон нутгийн сангаас хөгжмийн танхим байгуулж өгсөн байна. Мөн Цагдаагийн газар зэрэг зарим төрийн байгууллагатай хамтран ажиллаж замын хөдөлгөөний дүрмийн хичээлийг аймгийн сургуулиудын хэмжээнд ордог жишээ байна.

## Судалгаанд хамрагдсан бага ангийн сурагчдын ерөнхий мэдээлэл

Бага боловсролын хөтөлбөрийн хэрэгжилтийг судлахад 21 сургуулийн 652 сурагчаас мэдээлэл авснаас судалгааны боловсруулалтад 598 сурагчийн мэдээлэл боловсруулагдав. Тэдний 31.2 хувь нь хотын, 49.4 хувь нь аймгийн, 19.2 хувь нь сумын сургуулийн сурагчид байна. Сургуулийн өмчийн хэлбэрээр авч үзвэл 88.8 хувь нь төрийн өмчийн 11.0 хувь нь хувийн өмчийн сургуулийн сурагчид байна.

Хүйсийн хувьд 51.6 хувь эрэгтэй, 48.2 хувь нь эмэгтэй сурагчид. Судалгаанд хамрагдсан бага ангийн сурагчдын сургуульд хамрагдсан эсэхийг авч үзэхэд 92.8 хувь нь цэцэрлэгт явж байсан, 7.0 хувь нь цэцэрлэгт явж байгаагүй гэжээ.

Судалгаанд хамрагдсан сурагчдын 84.0 хувь нь гэртээ, 8.7 хувь нь өвөө эмээгийндээ амьдагдар ба 30 хүүхэд буюу 8.3 хувь нь таньдаг айл, дотуур байранд амьдардаг ажээ.

4 дүгээр ангийн сурагчдын унтдаг цагийг авч үзэхэд, 40.2 хувь нь 20-21 цагт, 23.0 хувь нь 22-23 цагт унтдаг гэсэн ба 23 цагаас хойш 14.8 хувь нь унтдаг гэсэн байна.

Бид сурагчдын өглөөний цайгаа уудаг эсэх талаар мэдээлэл авсан ба судалгаанд хамрагдсан сурагчдын 62.6 хувь нь үргэлж цайлдаг, 32.6 хувь нь заримдаа, 2.7 хувь нь өглөө цай уудаггүй гэсэн байна.

*Хүснэгт 1. Бага ангийн сурагчдын өглөөний цай уудаг эсэх ба орой унтдаг цаг*

| *Өглөөний цай уудаг эсэх* | *Орой унтдаг цаг* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | *19-20 цагт* | *20-21 цагт* | *21-22 цагт* | *22-23 цагт* | *23-24 цагт* | *24 цагаас хойш* |
| тогтмол | 18.4% | 44.0% | 8.5% | 20.8% | 5.6% | .8% |
| заримдаа | 14.4% | 33.8% | 10.8% | 28.7% | 10.3% | .5% |
| үгүй | 0.0% | 43.8% | 12.5% | 18.8% | 25.0% | 0.0% |

Хүснэгтээс харахад өглөө тогтмол цайлдаг сурагчид заримдаа цайлдаг сурагчдаас эрт унтдаг бөгөөд 22 цагаас хойш унтдаг сурагчдын дунд заримдаа цайлдаг эсвэл огт цайлдаггүй гэсэн сурагчдын эзлэх хувь илүү байна.

Сурагчдын гэрийн даалгавраа хийхдээ зарцуулдаг цагийг авч үзэхэд, 63.6 хувь нь 1-2 цаг, 19.5 хувь нь 3 цаг, харин 15.2 хувь нь 4-өөс дээш цаг зарцуулдаг байна. Тэд гэрийн даалгавараа хийхдээ 65.3 хувь нь сурах бичиг ашигладаг, 23.2 хувь нь багшийн өгсөн нэмэлт материал, 6.0 хувь нь бусад нэмэлт материал гарын авлага ашигладаг гэсэн ба 3 сурагч л цахим сүлжээг ашиглаж байна.

*Зураг 1. Бага ангийн сурагчдын хичээлд идэвхтэй оролцдог байдал, судлагдахуунаар*




Сурагчдын 59-ээс дээш хувь нь хичээлүүддээ байнга идэвхтэй оролцдог гэсэн ба математик, биеийн тамир, дүрслэх урлаг, технологийн хичээлд оролцох нь бусад хичээлтэй харьцуулахад илүү дүр зураг харагдаж байна.

Судалгаанд хамрагдсан сурагчдаас 2018-2019 оны хичээлийн жилд судалгааны мэдээлэл цуглуулах өдөр хүртэл хэд хоногоор хичээл завсардсаныг авч үзэв. Суралцагчдын сурлагын амжилтад хичээл завсардалт нөлөөлөх нэг хүчин зүйл гэж олон улсын чанарын судалгаануудад авч үздэг нь уг мэдээллийг авах үндэслэл болов.

*Зураг 2. Хичээлийн бус цагаар оролцсон үйл ажиллагаа (бага ангийн сурагчдын хариулт)*




Судалгаанд хамрагдсан бага ангийн сурагчдын 37.4 хувь нь спортын үйл ажиллагаанд, 35.1 хувь нь хичээлтэй холбоотой ямар нэг дугуйланд, 34.6 хувь нь урлаг, соёлын үйл ажиллагаанд оролцож, хамрагддаг бол 10 орчим хувь нь огт хамрагддаггүй гэжээ. Сурагчдын ихэнх хувь нь хичээлийн бус цагаар сургууль дээрээ ямар нэг үйл ажиллагаанд хамрагдсан дүр зурагтай байна.

*Зураг 3. Сурагчдын хичээл завсардалт (бага ангийн сурагчдын хариулт)*




Зургаас харахад сурагчдын олонх нь хичээл завсардаагүй боловч 31.0 хувь нь 1-3 өдөр завсардсан, 6.0 хувь нь 4-7 өдөр завсардсан байна. 13 хүүхэд буюу 2.1 хувь нь удаан хугацаанд хичээл завсардсан байна.

*Хүснэгт 2. Бага ангийн сурагчдын сургуульд сэтгэл ханамж ба багш нарын харилцааг үнэлсэн байдал*

| | | *Багш нар чамд шударга ханддаг уу?* | |
|---|---|---|---|
| | | *Тийм* | *Үгүй* |
| Сургуульдаа сэтгэл хангалуун байдаг уу? | тийм | 95.5% | 3.8% |
| | үгүй | 81.3% | 18.8% |

Зургаас харахад сургуульдаа сэтгэл хангалуун бус байдаг сурагчид багш нар шударга харилцдаг гэдэгт эргэлздэг байна.

## *Судалгаанд хамрагдсан сурагчдын эцэг эх, асран хамгаалагчид*

Судалгаанд хамрагдсан сурагчдын эцэг эх, асран хамгаалагчдын насны байдлыг харахад 25-30 хүртэлх насных 42.9 хувь, 36-45 насных 36.2 хувь, 46-аас дээш насных 20.7 хувь байна. Эцэг эх, асран хамгалаалагчдыг хүйсээр авч үзэхэд, 24.2 хувь нь эрэгтэй, 75.6 хувь нь эмэгтэй байна.

Эцгийн боловсролын түвшинг авч үзэхэд 48.6 хувь нь бүрэн дунд боловсролтой, 29.2 хувь нь дээд боловсролтой байна. Харин эхийн 40.9 хувь нь бүрэн дунд, 45.7 хувь нь дээд боловсролтой байна. Тэдний ажил эрхлэлтийг авч үзэхэд:

*Зураг 4. Эцэг эх, асран хамгаалагчдын ажил эрхлэлтийн байдал, бага анги*




Судалгаанд хамрагдсан хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчдын олонх нь ажил эрхэлдэг ба 10 гаруй хувь нь тодорхой ажилгүй байна.

Өрхийн сарын дундаж орлогыг авч үзэхэд сарын 100,000 хүртэлх төгрөгийн орлоготой өрх 6.3 хувь, 101,000-300,000 орлоготой 18.7 хувь, 301,000-500,000 орлоготой өрх 15.1 хувь, 501,000-800,000 орлоготой 15.1 хувь, 801,000-1 сая орлоготой нь 14.2 хувь, 1 саяас дээш орлоготой өрх 20.9 хувь, 2 саяас дээш орлоготой өрх 7.2 хувь байна. Харин эцэг эх, асран хамгаалагчдын 4.2 хувь нь энэ асуултад хариулаас татгалзжээ.

Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийнхээ сурах үйл ажиллагаанд үзүүлдэг дэмжлэгийг судалсан бөгөөд 53.4 хувь нь хүүхдийнхээ гэрийн даалгаврыг хийхэд “хааяа” тусалдаг бол 33.2 хувь нь “үргэлж” тусалдаг байна.

*Хүснэгт 3. Хүүхдийнхээ гэрийн даалгавар хийхэд үзүүлдэг дэмжлэг ба багштай хамтран ажилладаг байдал*

| | | *Хүүхдийнхээ сурлагын ахиц, өөрчлөлтийн талаар багштай ярилцдаг байдал* | | |
|---|---|---|---|---|
| | | *байнга* | *хааяа* | *үгүй* |
| Хүүхдийнхээ хичээл, гэрийн даалгавраа хийхэд нь үзүүлдэг дэмжлэг | байнга тусалдаг | 64.8% | 35.2% | 0.0% |
| | хааяа тусалдаг | 39.4% | 58.1% | 1.9% |
| | Завгүй тул тусалж чаддаггүй | 20.6% | 73.5% | 5.9% |
| | хичээлийг нь мэдэхгүй тул тусалж чаддаггүй | 19.4% | 72.2% | 2.8% |

Хүүхдийнхээ гэрийн даалгавар хийхэд байнга дэмжлэг үзүүлдэг эцэг эх, асран хамгаалагчид сурлагын ахиц, өөрчлөлтийн талаар багштай нь байнга ярилцдаг байна. Харин хичээлийг нь мэдэхгүй тул тусалж чаддаггүй эцэг эх, асран хамгаалагчид хүүхдүүдийнхээ сурлагын ахиц өөрчлөлтийн талаар байнга яррилцдаг гэсэн хариултын хамгийн цөөн хувьтай өгчээ.

Эцэг эх, асран хамгаалагчдын 76.1 хувь нь хүүхдийнхээ багштай байнга уулздаг ажээ.

*Зураг 5. Эцэг эх, асран хамгаалагчдын багштай хамтран ажиллах байдал (бага анги)*




Эцэг эх, асран хамгаалагчид сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэхэд багшид дэмжлэг үзүүлэх нь бусад хамтын ажиллагаатай харьцуулахад илүү байна. Харин хүүхдийнхээ сургалт, хүмүүжлийн талаар аливаа сургалт, зөвлөн туслах үйл ажиллагаанд тэр бүр хамрагдаж чадахгүй байгаа ажээ. Хүүхдийнхээ сурлагын ахиц өөрчлөлт, хүмүүжил төлөвшлийн талаар багштай тодорхой давтамжтайгаар ярилцаж, хэрэгцээтэй мэдээллээ авч чадаж байгаа ажээ.

*Хүснэгт 4. Эцэг эх, асран хамгаалагчид багш нарын хичээл сонирхолтой заах чадвар болон мэргэжлийн ур чадварыг үнэлсэн байдал (бага анги)*

| | | *Багш нарын мэргэжлийн ур чадвар сайн уу?* | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | *үргэлж* | *ихэвчлэн* | *ховор* | *үгүй* | *мэдэхгүй* |
| Багш нар хичээлээ сонирхолтой заадаг уу? | тийм | 91.2% | 8.5% | .3% | 0.0% | 0.0% |
| | ихэвчлэн | 52.1% | 46.5% | 1.4% | 0.0% | 0.0% |
| | ховор | 11.1% | 48.1% | 25.9% | 14.8% | 0.0% |
| | үгүй | 0.0% | 33.3% | 0.0% | 66.7% | 0.0% |
| | мэдэхгүй | 12.5% | 0.0% | 12.5% | 0.0% | 75.0% |

Багш нарыг хичээлээ сонирхолтой заадаг гэж үзсэн эцэг эх, асран хамгаалагчид тэдний мэргэжлийн ур чадварт сэтгэл хангалуун байна. Харин хичээлээ сонирхолтой заадаг эсэхийг мэдэхгүй байгаа эцэг эх, асран хамгаалагчид багш нарын мэргэжлийн ур чадварын талаар тодорхой хэлж мэдэхгүй байна.

*Хүснэгт 5. Эцэг эх, асран хамгаалагчид багш нарын хичээл сонирхолтой заах чадвар болон хүүхдийнхээ ахицыг үнэлсэн байдал*

| | | *Танай хүүхдийн мэдлэг, ур чадвар ахиж байна уу?* | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | *үргэлж* | *ихэвчлэн* | *ховор* | *үгүй* | *мэдэхгүй* |
| Багш нар хичээлээ сонирхолтой заадаг уу? | тийм | 82.7% | 8.5% | .3% | 0.0% | 0.0% |
| | заримдаа | 63.2% | 93.7% | 27.3% | 14.8% | 0.0% |
| | үгүй | 0.0% | 33.3% | 0.0% | 66.7% | 0.0% |
| | мэдэхгүй | 12.5% | 0.0% | 12.5% | 0.0% | 75.0% |

Багш нар хичээлээ сонирхолтой заадаг гэсэн эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийнхээ мэдлэг, ур чадварыг ахиж байгаа гэж үзэж байна.

Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийнхээ ямар хүүхдүүдтэй найзлаж, нөхөрлөж байгаад анхаарал тавьдаг эсэхийг авч үзэхэд 71.5 хувь нь анхаардаг, 26.2 хувь нь мэдэхгүй

байна. Бага насны хүүхдүүдтэйгээ судалгаанд хамрагдсан эцэг эх, асран хамгаалагчдын 74.0 хувь нь хамт тоглож, цагийг хамт өнгөрөөдөг ажээ.

*Хүснэгт 6. Хүүхдэдээ чөлөөт цаг гаргадаг байдал (байршлаар)*

| | | Та хүүхэдтэйгээ хамт тоглож, аяллаар явдаг уу? | | |
|---|---|---|---|---|
| | | *Тийм* | *Үгүй* | *Бөглөөгүй* |
| Байршил | нийслэл | 87.2% | 10.7% | 2.1% |
| | аймаг | 69.6% | 26.0% | 4.1% |
| | сум | 64.3% | 35.7% | 0.0% |

Тэд хүүхдээ ойлгохыг хичээж, сонсож чаддаг гэсэн байна. Харин 34.9 хувь нь хүүхдийнхээ сонирхолын талаар мэдэхгүй байна. Эцэг эх, асран хамгаалагчдын 27.2 хувь нь багш нар хүүхдийг нь ойлгодог эсэхэд, 12.2 хувь нь хүүхдээ сургуульд явах дуртай эсэхэд эргэлзэж байна. Тэд хүүхдээ ангийхантайгаа эерэг дотно харилцаатай байдаг гэжээ.

# Судалгаанд хамрагдсан дунд ангийн сурагчдын ерөнхий мэдээлэл

Бүрэн дунд боловсролын хөтөлбөрийн хэрэгжилтийг судлахад 21 сургуулийн 563 сурагчаас мэдээлэл авснаас 471 сурагчийн мэдээллийг боловсруулав. Тэдний 32.9 хувь нь хотын, 45.0 хувь нь аймгийн, 22.1 хувь нь сумын сургуулийн сурагчид байна. Сургуулийг өмчийн хэлбэрээр авч үзвэл 89.0 хувь нь төрийн өмчийн 11.0 хувь нь хувийн өмчийн сургуулийн сурагчид байна.

Судалгаанд хамрагдсан сурагчдын 47.3 хувь нь эрэгтэй, 52.7 хувь нь эмэгтэй байна. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байсан эсэхийг авч үзэхэд 88.3 хувь нь цэцэрлэгт явж байсан бол 11.7 хувь нь “үгүй” гэжээ.

Судалгаанд хамрагдсан сурагчдын 83.7 хувь нь гэртээ, 7.6 хувь нь өвөө эмээгийндээ амьдардаг бол 3.6 хувь нь таньдаг айл, дотуур байранд, 4.0 хувь нь хамаатан садныдаа амьдардаг байна.

Дунд ангийн сурагчид орой унтдаг цагийг авч үзэхэд 15.3 хувь нь 20-21 цагт, 45.3 хувь нь 22-23 цагт унтдаг бол 21.7 хувь нь 23 цагаас хойш унтдаг гэсэн байна.

Бид сурагчдын өглөөний цайгаа уудаг эсэх талаар мэдээлэл авсан ба судалгаанд хамрагдсан сурагчдын 49.5 хувь нь үргэлж, 45.8 хувь нь заримдаа цайлдаг бол 4.7 хувь нь өглөө цай уудаггүй гэсэн байна.

Сурагчдын гэрийн даалгавраа хийхдээ зарцуулдаг цагийг авч үзэхэд 38.2 хувь нь 1-2 цаг, 40.0 хувь нь 2-3 цаг, харин 21.7 хувь нь 4-өөс дээш цаг зарцуулдаг байна.

Тэд гэрийн даалгавраа хийхдээ 81.4 хувь нь сурах бичиг ашигладаг, 6.0 хувь нь багшийн өгсөн нэмэлт материал, 5.5 хувь нь бусад нэмэлт материал гарын авлага ашигладаг гэсэн бол 31 сурагч буюу 6.6 хувь нь интернэт, цахим сүлжээг ашигладаг гэж хариулжээ.

*Зураг 6. Дунд ангийн сурагчдын хичээлд идэвхтэй оролцдог байдал (судлагдахуунаар)*




Дунд ангийн сурагчдын 50-иас дээш хувь нь хичээлдээ идэвхтэй оролцдог гэсэн ба математик, монгол хэл, уран зохиол, мэдээллийн технологи, биологи, дизайн технологи, биеийн тамирын хичээлийн оролцоо нь бусад хичээлтэй харьцуулахад илүү дүр зураг харагдаж байна.

*Зураг 7. Хичээлийн бус цагаар оролцсон үйл ажиллагаа (дунд ангийн сурагчдын хариулт)*




Судалгаанд хамрагдсан дунд ангийн сурагчдын 46.9 хувь нь спортын үйл ажиллагаанд, 42.5 хувь нь хичээлтэй холбоотой ямар нэг дугуйланд, 34.6 хувь нь урлаг, соёлын үйл ажиллагаанд оролцжээ. Сурагчдын 23.1 хувь нь ямар нэг үйл ажиллагаанд хамрагдаагүй байна. Сурагчдын ихэнх хувь нь хичээлийн бус цагаар сургууль дээрээ ямар нэг үйл ажиллагаанд хамрагдсан дүр зурагтай байна.

Судалгаанд хамрагдсан сурагчдаас 2018-2019 оны хичээлийн жилд судалгааны мэдээлэл цуглуулах өдөр хүртэл хэд хоногоор хичээл завсардсаныг авч үзэв. Суралцагчдын сурлагын амжилтад хичээл завсардалт нөлөөлөх нэг хүчин зүйл гэж олон улсын чанарын судалгаануудад авч үздэг нь уг мэдээллийг авах үндэслэл болов.

*Зураг 8. Сурагчдын хичээл завсардалт (дунд ангийн сурагчдын хариулт)*




Зургаас харахад сурагчдын 60.6 нь хичээл завсардаагүй гэсэн боловч 30.4 хувь нь 1-3 өдөр завсардсан, 5.4 хувь нь 4-7 өдөр завсардсан байна. Харин 1 сараас дээш хугацаанд хичээл завсардсан сурагчдын хувь 0.8 байна.

Судалгаанд хамрагдсан сурагчдын 92.1 хувь нь сурч байгаа сургуульдаа сэтгэл хангалуун байдаг гэсэн хариулт өгсөн бөгөөд сургуулийн юу нь таалагддаг талаар тодруулж ярилцахад “сургуулийн орчин” гэж хариулжээ.

*Судалгаанд хамрагдсан сурагчдын эцэг эх, асран хамгаалагчид*

Судалгаанд хамрагдсан сурагчдын эцэг эх, асран хамгаалагчдын насны байдлыг харахад 25-30 хүртэлх насных 10.8 хувь, 31-35 насных 19.5 хувь, 36-45 насных 41.6 хувь, 46-аас дээш насных 28.0 хувь байна. Эцэг эх, асран хамгаалагчдын 26.8 хувь нь эрэгтэй, 73.2 хувь нь эмэгтэй байна.

Эцгийн боловсролын түвшинг авч үзэхэд 73.7 хувь нь суурь боловсролтой нь гэж хариулсан бол 25.7 хувь нь хариулахаас татгалзжээ. Эхийн 48.1 хувь бүрэн дунд, 20.6 хувь нь дээд боловсролтой байна. Тэдний ажил эрхлэлтийг авч үзэхэд:

*Зураг 9. Эцэг эхийн ажил эрхлэлтийн байдал (дунд анги)*




Судалгаанд хамрагдсан хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчдын олонх нь ажил эрхэлдэг ба 10.3 хувь нь тодорхой ажилгүй, 18.8 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг байна.

Өрхийн сарын дундаж орлогыг авч үзэхэд:

| | |
|---|---|
| 100,000 хүртэл | 7.0% |

| | |
|---|---|
| 101,000-300,000 | 17.0% |
| 301,000-500,000 | 19.7% |
| 501,000-800,000 | 20.6% |
| 801,000-1,000,000 | 8.3% |
| 1,000,000 – 2,000,000 | 15.7% |
| 2,000,000-с дээш | 5.3% |

Харин эцэг эх, асран хамгаалагчдын 6.4 хувь нь энэ асуултад хариулахаас татгалзжээ.

Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийнхээ сурах үйл ажиллагаанд үзүүлдэг дэмжлэгийг бид судалсан бөгөөд тэдний 55.8 хувь нь хүүхдийнхээ гэрийн даалгаврыг хийхэд "хааяа"тусалдаг бол 14.7 хувь нь л "байнга" тусалдаг байна. "Завгүй" эсвэл "хичээлийг нь мэдэхгүй тул тусалж чадахгүй" гэсэн хариулт 29.6 хувийг эзэлж байна.

*Хүснэгт 7. Хүүхдийнхээ гэрийн даалгавар хийхэд үзүүлдэг дэмжлэг ба багштай хамтран ажилладаг байдал (дунд анги)*

| *Гэрийн даалгавар хийхэд тусалдаг байдал* | *Хүүхдийнхээ сурлагын ахиц, өөрчлөлтийн талаар багштай ярилцдаг* | | |
|---|---|---|---|
| | байнга | хааяа | үгүй |
| байнга тусалдаг | 73.1% | 26.9% | 0.0% |
| тусалдаг | 22.2% | 74.2% | 3.6% |
| завгүй тул тусалж чаддаггүй | 26.8% | 58.9% | 14.3% |
| хичээлийг нь мэдэхгүй тул тусалж чаддаггүй | 27.3% | 67.5% | 5.2% |

Хүүхдийнхээ гэрийн даалгавар хийхэд байнга тусалж дэмждэг эцэг эх, асран хамгаалагчид сурлагын ахиц өөрчлөлтийн талаар багштай нь байнга ярилцдаг байна. Харин завгүй эсвэл хичээлийг нь мэдэхгүй тул тусалж чаддаггүй эцэг эх хүүхдүүдийнхээ сурлагын ахиц өөрчлөлтийн талаар байнга ярьдаг нь цөөн хувь хувьтай буюу хааяа ярилцдаг гэжээ. Эцэг эх, асран хамгаалагчдын 62.2 хувь нь хүүхдийнхээ багштай байнга уулздаг ажээ.

*Зураг 10. Эцэг эх, асран хамгаалагчид багштай хамтран ажиллах байдал (дунд анги)*




Эцэг эх, асран хамгаалагчид сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэхэд багшид дэмжлэг үзүүлэх нь бусад хамтын ажиллагаатай харьцуулахад илүү байна. Харин хүүхдийнхээ сургалт, хүмүүжлийн талаар аливаа сургалт, зөвлөн туслах үйл ажиллагаанд тэр бүр хамрагдаж чадахгүй байгаа ажээ. Хүүхдийнхээ сурлагын ахиц өөрчлөлт, хүмүүжил

төлөвшлийн талаар тодорхой давтамжтайгаар багштай ярилцаж хэрэгцээтэй мэдээллээ авч чадахын зэрэгцээ хүүхдэдээ тохиолдсон бэрхшээлийг багштай хамтран шийдвэрлэхэд идэвхтэй оролцдог байна.

Эцэг эх, асран хамгаалагчид нь хүүхдийнхээ ямар хүүхдүүдтэй найзлаж, нөхөрлөж байгаад анхаарал тавьдаг эсэхийг авч үзэхэд, 79.4 хувь анхаардаг байна. Судалгаанд хамрагдсан эцэг эх, асран хамгаалагчдын 70.2 хувь нь хүүхдүүдтэйгээ аялах, тоглох зэргээр цагийг хамт өнгөрөөдөг ажээ.

*Хүснэгт 8. Хүүхдэдээ чөлөөт цаг гаргадаг байдал (байршлаар)*

| | *тийм* | *үгүй* |
|---|---|---|
| нийслэл | 81.6% | 18.4% |
| аймаг | 77.2% | 22.8% |
| сум | 80.8% | 19.2% |

Эцэг эх, асран хамгаалагчдын 30.5 хувь нь хүүхдийнхээ сонирхлын талаар мэдэхгүй байна. Тэдний 81.9 хувь нь багш нар хүүхдийг нь ойлгодог гэдэгт итгэлтэй байгаа ч 30.0 хувь нь хүүхдээ сургуульд явах дуртай эсэхэд эргэлзжээ.

## Судалгаанд хамрагдсан ахлах ангийн сурагчдын ерөнхий мэдээлэл

Бүрэн дунд боловсролын хөтөлбөрийн хэрэгжилтийг судлахад 21 сургуулийн 599 сурагчаас мэдээлэл авснаас 433 сурагчийн мэдээллийг боловсруулав. Тэдний 31.9 хувь нь хотын, 46.2 хувь нь аймгийн, 21.9 хувь нь сумын сургуулийн сурагчид байна. Сургуулийн өмчийн хэлбэрээр авч үзвэл 87.3 хувь нь төрийн өмчийн 12.7 хувь нь хувийн өмчийн сургуулийн сурагчид байна.

Хүйсийн хувьд 42.5 хувь эрэгтэй, 57.5 хувь нь эмэгтэй сурагчид байна. Судалгаанд хамрагдсан ахлах ангийн сурагчдаас сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байсан эсэхийг авч үзэхэд 87.5 хувь нь цэцэрлэгт явж байсан бол 12.5 хувь нь “үгүй” гэжээ.

Судалгаанд хамрагдсан сурагчдын 79.2 хувь нь гэртээ, 7.6 хувь нь өвөө эмээгийндээ амьдардаг бол 19 сурагч буюу 3.9 хувь нь таньдаг айл, дотуур байранд, 8.1 хувь нь хамаатан садныдаа амьдардаг байна.

Ахлах ангийн сурагчдын орой унтдаг цагийг авч үзэхэд, 7.9 хувь нь 20-21 цагт, 43.6 хувь нь 22-23 цагт унтдаг гэсэн ба 39.2 хувь нь 23 цагаас хойш унтдаг гэсэн байна.

Бид сурагчдын өглөөний цайгаа уудаг эсэх талаар мэдээлэл авсан ба судалгаанд хамрагдсан сурагчдын 21.2 хувь нь үргэлж, 60.5 хувь нь заримдаа цайлдаг бол 18.0 хувь нь өглөө цай уудаггүй гэсэн байна.

Сурагчдын гэрийн даалгавраа хийхдээ зарцуулдаг цагийг авч үзэхэд, 33.5 хувь нь 1-2 цаг, 39.5 хувь нь 3 цаг, харин 26.6 хувь нь 4-өөс дээш цаг зарцуулдаг байна. Хичээл хийхэд зарцуулдаг хугацааны талаар лавлахад 1-2 цаг, 2-3 цаг, 3-4 цаг гэсэн хариултын хувилбаруудыг хэлсэн. Хичээл хийхэд зарцуулдаг цаг ихсэх тусам энэ хариултыг хэлсэн суралцагчдын тоо буурсан үзүүлэлт харагдаж байлаа.

Тэд гэрийн даалгавраа хийхдээ 57.7 хувь нь сурах бичиг ашигладаг, 18.7 хувь нь багшийн өгсөн нэмэлт материал болон дасгал ажлын ном, 6.7 хувь нь бусад нэмэлт материал

гарын авлага ашигладаг гэсэн бол 71 сурагч буюу 16.4 хувь нь интернэт буюу цахим сүлжээг ашигладаг гэж хариулжээ.

*Зураг 11. Ахлах ангийн сурагчдын хичээлд идэвхтэй оролцдог байдал (судлагдахуунаар)*




Ахлах ангийн сурагчдын 40-өөс дээш хувь нь хичээлдээ идэвхтэй оролцдог гэсэн ба математик, монгол хэл, нийгэм судлал, биеийн тамирын хичээлийн оролцоо нь бусад хичээлтэй харьцуулахад илүү дүр зураг харагдаж байна.

Судалгаанд хамрагдсан сурагчдаас 2018-2019 оны хичээлийн жилд судалгааны мэдээлэл цуглуулах өдөр хүртэл хэд хоногоор хичээл завсардсаныг авч үзэв. Суралцагчдын сурлагын амжилтад хичээл завсардалт нөлөөлөх нэг хүчин зүйл гэж олон улсын чанарын судалгаануудад авч үздэг нь уг мэдээллийг авах үндэслэл болов.

*Зураг 12. Сурагчдын хичээл завсардалт (ахлах ангийн сурагчдын хариулт)*




Зургаас харахад сурагчдын 47.6 нь хичээл завсардаагүй гэсэн боловч 39.6 хувь нь 1-3 өдөр завсардсан, 8.6 хувь нь 4-7 өдөр завсардсан байна. 18 хүүхэд буюу 4.2 хувь нь удаан хугацаанд хичээл завсарджээ.

Судалгаанд хамрагдсан ангийн сурагчдын 87.5 хувь нь сурч байгаа сургуульдаа сэтгэл хангалуун байдаг гэсэн хариулт өгсөн бөгөөд сургуулийн юу нь таалагддаг талаар тодруулж ярилцахад “найзууд” гэж хариулжээ. Ахлах ангийн сурагчдын 78.3 хувь нь “багш шударга ханддаг” гэсэн бөгөөд сургуулиа ямар байгаасай гэж хүсдэг талаар дэлгэрүүлж асуухад тохилог орчинтой, цэвэрхэн, багшийн харилцаа сайн байгаасай гэж хүсдэг гэсэн бол удирдах ажилтан соёлтой байгаасай гэж зарим сурагч хэлсэн байна.

> Багш нар биднийг ойлгож, удирдах ажилтан найрсаг харилцаатай байгаасай гэж хүсдэг
>
> *Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагч*

Чөлөөт цагаараа юу хийдэг, зурагтын нэвтрүүлгээс ямар нэвтрүүлэг үздэг талаар тодруулахад олонх нь сагс тоглодог, зурагт үзэж өнгөрүүлдэг, телевизээр спортын тойм голчлон үздэг гэсэн хариултыг өгсөн.

### *Судалгаанд хамрагдсан сурагчдын эцэг эх, асран хамгаалагчид*

Судалгаанд хамрагдсан сурагчдын эцэг эх, асран хамгаалагчдын насны байдлыг харахад 25-30 хүртэлх насных 43.1 хувь, 36-45 насных 38.1 хувь, 46-аас дээш насных 18.7 хувь байна. Эцэг эх, асран хамгалаалагчдын 26.8 хувь нь эрэгтэй, 73.2 хувь нь эмэгтэй байна.

Аавуудын боловсролын түвшинг авч үзэхэд, бүрэн дунд боловсролтой нь 45.9 хувь, 36.1 хувь нь дээд боловсролтой байна. Харин ээжүүдийн 35.7 хувь бүрэн дунд, 52.2 хувь нь дээд боловсролтой байна. Тэдний ажил эрхлэлтийг авч үзэхэд:

*Зураг 13. Эцэг эх, асран хамгаалагчдын ажил эрхлэлтийн байдал (ахлах анги)*




Судалгаанд хамрагдсан хүүхдийн эцэг эхийн олонх нь ажил эрхэлдэг ба 15 орчим хувь нь тодорхой ажил эрхлээгүй байна.

Өрхийн сарын дундаж орлогыг авч үзэхэд 100,000 хүртэлх төгрөгийн орлоготой өрх 4.1 хувь, 101,000-300,000 орлоготой 13.5 хувь, 301,000-500,000 орлоготой өрх 14.4 хувь, 501,000-800,000 орлоготой 14.7 хувь, 801,000-1 сая төгрөгийн орлоготой нь 17.0 хувь, 1 саяас дээш орлоготой өрх 27.4 хувь, 2 саяас дээш төгрөгийн орлоготой өрх 8.9 хувийг тус тус эзэлж байна. Харин энэ асуултад хариулаас татгалзсан хувь 3.5 байна.

Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийнхээ сурах үйл ажиллагаанд үзүүлдэг дэмжлэгийг бид судалсан бөгөөд тэдний 55.1 хувь нь хүүхдийнхээ гэрийн даалгаврыг хийхэд “хааяа”тусалдаг бол 32.5 хувь нь “байнга” тусалдаг байна.

*Хүснэгт 9. Хүүхдийнхээ гэрийн даалгавар хийхэд туслах байдал ба багштай хамтран ажиллах байдал (ахлах анги)*

| *Гэрийн даалгавар хийхэд тусалдаг байдал* | *Хүүхдийнхээ сурлагын ахиц, өөрчлөлтийн талаар багштай ярилцдаг* | | |
|---|---|---|---|
| | *байнга* | *хааяа* | *үгүй* |

| | | | |
|---|---|---|---|
| байнга тусалдаг | 66.2% | 33.8% | 0.0% |
| хааяа тусалдаг | 39.6% | 58.3% | 2.1% |
| завгүй тул тусалж чаддаггүй | 14.8% | 77.8% | 7.4% |
| хичээлийг нь мэдэхгүй тул тусалж чаддаггүй | 25.0% | 70.8% | 4.2% |

Хүүхдийнхээ гэрийн даалгавар хийхэд байнга тусалж дэмждэг эцэг эх сурлагын ахиц өөрчлөлтийн талаар багштай нь байнга ярилцдаг юм байна. Харин завгүй эсвэл хичээлийг нь мэдэхгүй тул тусалж чаддаггүй эцэг эх хүүхдүүдийнхээ сурлагын ахиц өөрчлөлтийн талаар байнга ярьдаг нь цөөн хувь хувьтай буюу хааяа ярилцдаг гэжээ. Эцэг эх, асран хамгаалагчдын 78.4 хувь нь хүүхдийнхээ багштай байнга уулздаг ажээ.

*Зураг 14. Эцэг эх, асран хамгаалагчид багштай хамтран ажиллах байдал (ахлах анги)*




Эцэг эх, асран хамгаалагчид сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэхэд багшид дэмжлэг үзүүлэх нь бусад хамтын ажиллагаатай харьцуулахад илүү байна. Харин хүүхдийнхээ сургалт, хүмүүжлийн талаар аливаа сургалт, зөвлөн туслах үйл ажиллагаанд тэр бүр хамрагдаж чадахгүй байгаа ажээ. Хүүхдийнхээ сурлагын ахиц өөрчлөлт, хүмүүжил төлөвшлийн талаар тодорхой давтамжтайгаар багштай ярилцаж хэрэгцээтэй мэдээллээ авч чадаж байна.

Эцэг эх, асран хамгаалагчид нь хүүхдийнхээ ямар хүүхдүүдтэй найзлаж, нөхөрлөж байгаад анхаарал тавьдаг эсэхийг авч үзэхэд, 71.8 хувь анхаардаг, 26.8 хувь нь мэдэхгүй байна. Судалгаанд хамрагдсан эцэг эх, асран хамгаалагчдын 79.0 хувь нь хүүхдүүдтэйгээ аялах, тоглох зэргээр цагийг хамт өнгөрөөдөг ажээ.

*Хүснэгт 10. Хүүхдэдээ чөлөөт цаг гаргадаг байдал (байршлаар)*

| | *тийм* | *үгүй* | *хариулаагүй* |
|---|---|---|---|
| нийслэл | 86.6% | 13.4% | 2.9% |
| аймаг | 74.7% | 25.3% | 3.0% |
| сум | 77.2% | 22.8% | 3.2% |

Судалгаанд хамрагдсан эцэг эх, асран хамгаалагчид хүүхдээ ойлгохыг хичээж, сонсож чаддаг бөгөөд хүүхдэдээ тулгарсан асуудлыг хамтдаа шийдвэрлэдэг гэж хариулсан.

Ямар нэг хэцүү зүйл тулгарвал хэнд ханддаг талаар сурагчдаас лавлахад “асуудал тулгардаггүй” гэж цөөнх хариулсан бол эцэг, эхдээ ханддаг гэсэн хариултыг дийлэнх нь өгсөн. Харин найз нөхдөдөө болон багшдаа хэлдэг гэсэн хариултын хувь ижил байлаа.

Ямар нэг хэцүү зүйл гарвал би эхлээд аав ээждээ хэлнэ.

*Нийслэлийн сургуулийн ахлах ангийн сурагч*

Эцэг эх, асран хамгаалагчдын 32.7 хувь нь хүүхдийнхээ сонирхолын талаар мэдэхгүй байна. Тэдний 22.6 хувь нь багш нар хүүхдийг нь ойлгодог гэдэгт, 12.5 хувь нь хүүхдээ сургуульд явах дуртай эсэхэд мөн эргэлзсэнээс гадна 68.3 хувь нь хүүхдээ ангийхантайгаа ээрэг дотно харилцаатай байдаг гэж үзжээ.

Судалгаанд оролцсон эцэг эх, асран хамгаалагчдын олонх нь хүүхдийнхээ цахим хаяг, түүний сонирхлын талаар мэдээлэлтэй байдаг гэж хариулсан бол судалгаанд хамрагдсан сурагчдаас цахим орчноос ямар мэдээллийг хайдаг, хэдэн цагийг өнгөрөөдөг, цахим орчинд байхдаа дарамтлуулах доромжлуулах тохиолдол гарч байсан уу гэж асуухад тэд цахим орчинд ихэвчлэн 2-4 цагийг өнгөрүүлдэг ба ямар нэгэн дарамтлуулах, сөрөг зүйлд өртөж байгаагүй гэж дийлэнх нь хариулсан.

Өдөрт 3 цаг зарцуулдаг. Хааяа хэрүүл маргаан фэйсээр явдаг. Би голдуу сонирхолтой зүйл цахимаар үздэг.

*Орон нутгийн сургуулийн ахлах ангийн сурагч*

# ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАГА БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛ

## Бага боловсролын сургалтын арга зүй

Бид бага боловсролын сургалтын арга зүйг хичээлийн арга зүйн хүрээнд судалсан бөгөөд хичээлийн төлөвлөлт, түүний хэрэгжилт үр дүнд анхаарлаа хандуулсан болно. Хичээлийн төлөвлөлтийг жилийн, нэгж хичээл, ээлжит хичээлийн хүрээнд баримт бичигт дүн шинжилгээ хийн авч үзэв. Харин хичээлийн төлөвлөлтийн хэрэгжилтийг, хичээлийн зохион байгуулалт, багшлах үйл ажиллагаа, сургалтын явцад суралцагчдын оролцоо, гүйцэтгэж буй үйл, хичээлд сурах бичиг сургалтын хэрэглэгдэхүүний ашиглалт, суралцагчдыг урамшуулах дэмжих үйл ажиллагаа зэргээр авч үзэхдээ ажиглалт, асуулга, ярилцлагыг аргуудыг ашиглан мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийв.

Судалгааны явцад БСУГ-ын газрын мэргэжилтнүүдээс сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар мэдээлэл авахад бага боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг харьцангуй олон мэргэжилтэн “гайгүй”, “боломжийн” хэрэгжиж байгаа гэж үзсэн байх бөгөөд энэ нь бага боловсролын хөтөлбөрийг туршиж, туршилтын хугацаанд болон дараа нь зөвлөн туслах, дэмжлэг үзүүлэх ажлыг аймаг, нийслэл, сум, сургуулийн түвшинд хийсэнтэй холбоотой гэж үзэж байна. Тухайлбал, нэг аймгийн 20 сургууль бага боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжсэн тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаж дэмжлэг авснаар математик, байгалийн ухааны хэрэглэгдэхүүнтэй болжээ.

### <u>Хичээлийн төлөвлөлт</u>

Судалгааны хүрээнд сонгогдсон 4 дүгээр ангийн хувьд хичээл (судлагдахуун)-ийн жилийн, нэгж, ээлжит хичээлийн төлөвлөлтийг сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамжтай харьцуулж, тохирцыг илрүүлэхийн тулд:

- Судалгаанд хамрагдсан ерөнхий боловсролын сургуулиудаас сонгосон 4 дүгээр анги, бүлгийн сонгосон хичээл (судлагдахуун)-ийн жилийн, нэгж, ээлжит хичээлийн төлөвлөлтийг авсан.
- Судлагдахуун бүрээр багшийн боловсруулсан төлөвлөлтийг сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамжтай харьцуулж, тодорхой шалгуурын дагуу тохирцыг илрүүлнэ.
- Судлагдахуун бүрээр хийсэн шинжилгээний дүнг нэгтгэн дүгнэв.

Судалгаанд хамрагдсан ерөнхий боловсролын сургуулиудын 4 дүгээр ангид судалдаг хичээлүүдээс хичээл ажиглалтад сонгосон 7 хичээл (судлагдахуун)-ийн жилийн, нэгж, ээлжит хичээлийн тус бүр 42 төлөвлөлтөд шинжилгээ хийхээр төлөвлөснөөс 29 багшийн өгсөн жилийн болон улирлын 31 (73.8 хувь), нэгж хичээлийн 20 (47.6 хувь), ээлжит хичээлийн 24 (57.1 хувь) төлөвлөлтөд баримт бичгийн шинжилгээг хийн, сургалтын хөтөлбөртэй тохирох байдлыг судлав.

*4 дүгээр ангийн хичээлийн төлөвлөлтөд хийсэн шинжилгээний үр дүн*

Судалгаанд хамрагдсан ерөнхий боловсролын сургуулийн 4 дүгээр ангид хичээл заадаг багш нарын төлөвлөлтөөс зарим сургууль, багш нар жилийн төлөвлөлтөө бүтэн жилээр бус, улирлаар гаргадаг болох нь жилийн төлөвлөлтийн оронд өгсөн улирлын

төлөвлөлтийн эзлэх хувиас (25.8) харагдаж байна (Хавсралт 4.1). Төлөвлөлтөө өгсөн 18 бага ангийн багшийн 11.1 хувь заасан хоёр хичээлээр жилийн, нэгж, ээлжит хичээлийн төлөвлөлттэй, 44.4 хувьд аль нэг хичээлээр эдгээр нь бүрэн, 50.0 хувьд ажиглалт хийгдсэн хичээлээр эдгээр төлөвлөлтийн зарим нь байхгүй байна. Харин судалгаанд хамрагдсан ангид хичээл заадаг, төлөвлөлтөө өгсөн 6 хөгжмийн багшийн 16.7 хувь жил, нэгж, ээлжит хичээлийн төлөвлөлттэй байгаа бол 83.3 хувьд төлөвлөлтөд тусгавал зохих бүрдэл хэсгийн зарим нь байхгүй байна. Судалгаанд хамрагдсан 4 дүгээр ангид хичээл заадаг, төлөвлөлтөө өгсөн биеийн тамирын 5 багшийн жилийн, нэгж, ээлжит хичээлийн төлөвлөлт бүрэн бус, харин 60.0 хувь нь жилийн төлөвлөлттэй байна.

*4 дүгээр ангийн хичээл судлагдахууны жилийн төлөвлөлтөд хийсэн шинжилгээний үр дүн*

Баримт бичгийн судалгаанд хамрагдсан багш нарын боловсруулсан хичээл (судлагдахуун)-ийн жилийн 23 төлөвлөлт, нэг буюу хоёр улирлаар боловсруулсан 8 төлөвлөлтийг сургалтын хөтөлбөртэй нийцэх байдлыг өгсөн шалгуурын дагуу шинжлэв. Төлөвлөлтүүдэд ихэвчлэн агуулга, үүн дотор бүлэг сэдэв буюу нэгж хичээлийн сэдэв, цагийн хуваарилалтыг голчлон тусгаж (96.8 хувь), харин зорилго, зорилтыг бага (16.2-19.3 хувь) тусган, үнэлгээг бараг тусгаагүй (96.8 хувь) байна.

Бид хичээлийн төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийхдээ төлөвлөгөөнд тусвал зохих бүрдэл хэсгүүд байгаа эсэх, жилийн, нэгж болон ээлжит хичээлийн төлөвлөлтүүдтэй хэр уялдсан байдлыг шинжлэн маш сайн, сайн дунд, хангалтгүй тусгаагүй хэмээн чанарын үнэлгээг ашиглан хэмжээсжүүлэв.

*Зураг 15. 4 дүгээр ангийн хичээл (судлагдахуун)-ийн жилийн төлөвлөлтийн шинжилгээний дүн*




| | Зорилго | Зорилт | Агуулга | Үнэлгээ |
|---|---|---|---|---|
| Маш сайн | 16.1 | 6.5 | 16.1 | 0.0 |
| Сайн | 3.2 | 0.0 | 22.6 | 0.0 |
| Дунд | 0.0 | 9.7 | 35.5 | 0.0 |
| Хангалтгүй | 0.0 | 0.0 | 22.6 | 3.2 |
| Тусгаагүй | 80.6 | 87.1 | 3.2 | 96.8 |

Төлөвлөлтүүдийн 19.3 хувьд тусгасан зорилго, зорилт нь сургалтын хөтөлбөртэй тодорхой хэмжээгээр уялдаж байна.

Үзүүлэлт бүрийн үр дүнг нэгтгээд багш нарын жилийн төлөвлөлтийн сургалтын хөтөлбөртэй тохирох байдлыг авч үзвэл төлөвлөлтүүдийн 3.2 хувь сайн, 45.2 хувь дунд, 48.4 хувь хангалтгүй байна.

*4 дүгээр ангийн нэгж хичээлийн төлөвлөлтөд хийсэн шинжилгээний үр дүн*

Судалгаанд хамрагдсан ерөнхий боловсролын сургуулийн сонгогдсон анги, багш нарын боловсруулсан 20 нэгж хичээлийн төлөвлөлт нь сургалтын хөтөлбөр, жилийн төлөвлөлттэй уялдах байдлыг өгсөн шалгуурын дагуу шинжлэв. Эдгээр нэгж хичээлийн төлөвлөлтөд зорилго, зорилт, агуулгын залгамж холбоо, тухайн нэгжийн агуулга, орчин хэрэглэгдэхүүн, үнэлгээг жилийнхтэй харьцуулахад тодорхой хэмжээгээр тусгаж байгаа нь дараах зургаас харагдаж байна.

*Зураг 16. 4 дүгээр ангийн нэгж хичээлийн төлөвлөлтийн шинжилгээний дүн*




| | Зорилго | Зорилт | Залгамж холбоо | Агуулга | Орчин, хэрэглэгдэхүүн | Үнэлгээ | Жилийн төлөвлөлттэй нийцэх байдал |
|---|---|---|---|---|---|---|---|
| Маш сайн | 38.1 | 25.8 | 12.9 | 25.8 | 25.8 | 3.2 | 16.1 |
| Сайн | 0.0 | 0.0 | 6.5 | 25.8 | 0.0 | 3.2 | 9.7 |
| Дунд | 16.1 | 12.9 | 6.5 | 9.7 | 6.5 | 6.5 | 3.2 |
| Хангалтгүй | 6.5 | 6.5 | 6.5 | 0.0 | 0.0 | 29.0 | 3.2 |
| Тусгаагүй | 16.1 | 19.4 | 32.3 | 12.9 | 32.3 | 22.6 | |

Төлөвлөлтүүд дэх зорилго, зорилтын 25.8-38.1 хувь, агуулгын 51.6 хувь, хэрэглэгдэхүүний 25.8 хувь сургалтын хөтөлбөрийн зорилго, агуулга, арга зүйтэй сайн нийцэж байна. Нэгж хичээлийн төлөвлөлтөд жилийн төлөвлөлтөөс илүү үнэлгээг тусгасан ч төлөвлөлтүүдийн 3.2 хувьд үнэлгээг маш сайн, 3.2 хувьд сайн, 6.5 хувьд дунд, 29.0 хувьд хангалтгүй байгаа нь бусад бүрэлдэхүүн хэсгүүдтэй харьцуулахад бага хувийг эзэлж байна.

Багш нарын нэгж хичээлийн төлөвлөлтийн 25.8 хувь жилийн төлөвлөлттэй маш сайн болон сайн нийцсэн, үлдэх хувь нь жилийн төлөвлөлттэй тэр бүр уялдаагүй байна. Ерөнхийд нь дүгнэвэл, шинжилгээнд хамруулсан нэгж хичээлийн төлөвлөлтийн 10.0 хувь сургалтын хөтөлбөртэй маш сайн, 35.0 хувь сайн, 25.0 хувь дунд зэрэг нийцсэн, 30.0 хувийнх нь хангалтгүй байна.

*4 дүгээр ангийн ээлжит хичээлийн төлөвлөлтөд хийсэн шинжилгээний үр дүн*

Судалгаанд хамрагдсан багш нарын 24 ээлжит хичээлийн төлөвлөлтийг сургалтын хөтөлбөр, нэгж хичээлийн төлөвлөлттэй тохирох байдлыг шинжиллээ.

Ээлжит хичээлийн төлөвлөлтийн 58.0 хувьд агуулгыг, 48.4 хувьд зорилгыг, 42.0 хувьд арга зүй, хэрэглэгдэхүүнийг сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж, сурах бичигтэй уялдуулан сайн, маш сайн тусгаж байна. Харин зорилгод хүрэх зорилтыг болон зорилгод хүрч буй байдлыг илрүүлэхэд чиглэсэн явцын үнэлгээний арга, хэрэгслийг тусгах байдал бусад бүрэлдэхүүн хэсэгтэй харьцуулахад бага (19.4-22.6 хувь) байна. Түүнчлэн ээлжит

хичээлийн явцад хэрэглэх арга стратегийг ерөнхийд нь томьёолж бичсэн ч аль үе шатанд хэрхэн хэрэглэх нь одорхой харагдахгүй байв.

*Зураг 17. 4 дүгээр ангийн ээлжит хичээлийн төлөвлөлтийн шинжилгээний дүн*




| | Зорилго | Зорилт | Агуулга | Арга зүй | Орчин, хэрэглэгд эхүүн | Явцын үнэлгээ | Нэгж хичээлийн төлөвлөлт тэй нийцэх байдал |
|---|---|---|---|---|---|---|---|
| Маш сайн | 41.9 | 16.1 | 29.0 | 9.7 | 35.5 | 6.5 | 22.6 |
| Сайн | 6.5 | 6.5 | 29.0 | 32.3 | 6.5 | 12.9 | 16.1 |
| Дунд | 12.9 | 12.9 | 3.2 | 16.1 | 0.0 | 3.2 | 12.9 |
| Хангалтгүй | 6.5 | 6.5 | 16.1 | 0.0 | 6.5 | 9.7 | 3.2 |
| Тусгаагүй | 16.1 | 41.9 | 3.2 | 25.8 | 35.5 | 51.6 | |

Багш нарын ээлжит хичээлийн төлөвлөлтүүдийн 38.7 хувь нь нэгж хичээлийн төлөвлөлттэй маш сайн болон сайн нийцсэн, үлдэх хувь нь сайн уялдаагүй байна. Ерөнхий байдлаар ээлжит хичээлийн төлөвлөлтийн 7.7 хувь сургалтын хөтөлбөртэй маш сайн, 50 хувь сайн, 26.9 хувь дунд зэрэг нийцсэн, 15.4 хувийн тохирох байдал хангалтгүй байна.

Багш нар хичээлийн зорилго, зорилтыг бага боловсролын сурагчдад ойлгомжтой танилцуулах, эргэцүүлэн бодох олон янзын санаа гаргахад сурагчдыг чиглүүлэх үйл ажиллагааг ээлжит хичээлийн төлөвлөгөөнд тусгаж байна.

Баримт бичгийн түвшинд хийсэн шинжилгээнээс харахад дараах дүр зураг харагдаж байна. Үүнд:

- Баримт бичгийн шинжилгээнд хамруулбал зохих хичээлийн төлөвлөлт жилийн, нэгжийн, ээлжитийнхээс хамаарч 47.6-73.8 хувьтай нь байгаа нь ерөнхий боловсролын сургууль, багш нар төлөвлөлтийг тодорхой хэмжээгээр боловсруулан, ажиллаж байгааг илэрхийлнэ.
- Нэгж болон ээлжит хичээлийн төлөвлөлттэй харьцуулахад жилийн, улирлын төлөвлөлтийг (73.8 хувь) шинжилгээнд хамрагдсан нь нь ерөнхий боловсролын сургууль, багш нар урт хугацааны төлөвлөлт гаргахад анхаарал хандуулдгийг тодорхой хэмжээгээр илтгэж байна.
- Бага ангийн багш нарын 44.4 хувь хичээлийн төлөвлөлтөө жил, нэгж, ээлжит хичээлээр боловсруулсан бол ээлжит хичээлийн төлөвлөлтөө боловсруулаагүй байх тохиолдол цөөн биш байна. Түүнчлэн ажиглалт хийсэн хичээлийн 42.9 хувьд төлөвлөлтгүй байсан нь төлөвлөлтгүйгээр хичээлээ заах явдал байгааг илэрхийлж байна.

- Аль ч түвшний төлөвлөлтөд багш нар агуулгын хуваарилалт, цагийн төлөвлөлтийг сургалтын төлөвлөгөө, сургалтын хөтөлбөр, сурах бичигт баримжаалан төлөвлөж чадаж байна. Төлөвлөлтийн хамрах хугацаа нэмэгдэх буюу нэгж, жилийнх болох тусам агуулгаас бусад бүрэлдэхүүн хэсгийг (зорилго, зорилт, арга зүй, хэрэглэгдэхүүн, үнэлгээ) тусгах байдал суларч байна. Ялангуяа үнэлгээг хангалтгүй тусгасан байна.
- Төлөвлөлтийг хэдий чинээ дэлгэрэнгүй боловсруулна төдий чинээ сургалтын хөтөлбөртэй нийцсэн байна.
- Төлөвлөлтүүдийн 40 хүрэхгүй хувьд өмнөх болон дараагийн түвшний төлөвлөлттэй тохирох байдал сайн, 60 гаруй хувийнх тэр бүр нийцэхгүй байна. Нийцэхгүй байгаа зүйлс нь агуулгын хуваарилалт, цагийн төлөвлөлт хоорондоо зөрөх, зарим агуулга орхигдох зэрэг болно.

*Санал, зөвлөмж*

- Жилийн, нэгжийн, ээлжит хичээлийн төлөвлөлтөд тусгах бүрэлдэхүүн хэсэг, тэдгээрийг ямар хэмжээнд боловсруулах талаар ерөнхий боловсролын сургууль, багш төдийгүй бусад оролцогчид нэгдсэн ойлголттой болох, үүнд нийгмийн хөгжил, сурагчдын хэрэгцээ, сургалтын чанар, багш нарын ачааллыг давхар тооцох.
- Жилийн, нэгж, ээлжит хичээлийн төлөвлөлтийг сургалтын хөтөлбөртэй илүү нийцүүлэхийн зэрэгцээ хоорондын уялдаа холбоог сайжруулах.
- Жилийн, нэгж, ээлжит хичээлийн төлөвлөлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийг, ялангуяа зорилго, зорилт, арга зүй, үнэлгээг сургалтын цөм хөтөлбөрийн зорилго, зорилттой илүү уялдуулах.
- Ээлжит хичээлийн үе шат бүрт сурагч, багшийн хийх үйлийн дараалал, хэрэглэх сургалтын арга, хэрэглэгдэхүүнийг зорилго, агуулгатай уялдуулан тусгахын зэрэгцээ юуг, хэдийд, хэрхэн хэрэглэх, хийх зэргийг тодорхой байхаар төлөвлөх.
- Аль ч түвшний төлөвлөлтөд үнэлгээг тусгах, ээлжит хичээлийн төлөвлөлтөд хэрэглэх явцын үнэлгээний арга, хэлбэр, үнэлгээний хуудас, даалгавар, үнэлэх шалгуур, аргачлал зэргийг тодорхой тусгах.

## Хичээлийн төлөвлөлтийг хэрэгжүүлж буй байдал

Багш нар хичээлийг төлөвлөж, төлөвлөлтийн дагуу сургалтыг зохион байгуулах, үр дүнг тооцох нь хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үндсэн үйл ажиллагаа юм.

Бага ангийн багш нарын хувьд 39.7 хувь мэргэжлийн зэрэггүй, 45.2 хувь заах аргач, 15.1 хувь нь тэргүүлэх зэрэгтэй байгаа бөгөөд ихэнх хувь нь бага ангийн анги удирдсан багш, бусад нь мэргэжлийн багш нар байна.

Багш нарын олонх нь (76.4 хувь) хичээлийг төлөвлөхдөө заадаг хичээлийнхээ сурах бичгийг байнга ашигладаг юм байна. Түүнээс гадна сургалтын цөм хөтөлбөр болон суралцахуйн удирдамжийг багш нарын 60.0-63.0 хувь нь байнга ашигладаж байна. Сургалтын хэрэглэгдэхүүний хувьд биет үзүүлэн, зураг дүрслэл бүхий үзүүлэн, тест, даалгаврын сан зэрэг төрөл бүрийн хэрэглэгдэхүүнийг ихэвчлэн ашиглаж байна.

*Хүснэгт 11. Хичээл төлөвлөхөд тулгардаг бэрхшээл (бага ангийн багш)*

| *бэрхшээлүүд* | хэцүү | хэцүү биш |
|---|---|---|
| хичээлийн зорилгыг цөм хөтөлбөртэй уялдуулах | 24.7 | 75.3 |
| сурагчдын өмнөх мэдлэг, чадвар, хандлагыг харгалзах | 27.4 | 72.6 |
| сурагчдын ялгаатай байдалд тохируулах | 41.1 | 58.9 |
| нэгж хичээлийн үнэлгээний даалгавар боловсруулах | 20.5 | 79.5 |
| явцын үнэлгээний арга, хэрэгслийг тусгах | 23.3 | 76.7 |
| дадлага, туршилтыг тусгах | 19.2 | 80.8 |
| асуултыг танин мэдэхүйн түвшнийг харгалзан боловсруулах | 21.9 | 78.1 |
| явцын үнэлгээнд тулгуурлан төлөвлөлтийг сайжруулах | 23.3 | 76.7 |
| гэрийн даалгаврын гүйцэтгэлд тулгуурлах | 17.8 | 82.2 |
| цаг бага, төлөвлөөгүй ажил гарах | 71.2 | 28.8 |
| сургалтын хэрэглэгдэхүүнд зардал гарах | 78.1 | 21.9 |

Дээрхээс харахад олонх нь хичээл төлөвлөхөд зарцуулах цаг бага, төлөвлөөгүй цаг үеийн ажил гардаг, сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэхэд мөнгө, зардал гаргах зэрэг нь бэрхшээлтэй гэж үзсэн. Цөөнгүй багш нарт сурагчдын ялгаатай байдалд тохируулан хичээл төлөвлөх нь бэрхшээлтэй байгаа ажээ.

### *Ээлжит хичээлийн бүтцэд хийсэн шинжилгээ*

Энэхүү судалгаанд хичээлийн бүтэцтэй холбоотой хийгддэг үйлүүдийг түүнд зарцуулсан хугацаатай уялдуулан шинжиллээ. Ажиглалт хийсэн хичээлүүдээс харахад, хичээлийн нийт хугацааны 53.8 хувь нь шинэ мэдлэг бүтээхэд, гэрийн даалгавар шалгахад 19.2 хувийг зарцуулж байна.

Багш ээлжит хичээлээр гэрийн даалгавар шалгахад хугацаа их зарцуулах тусам сурагчдаар мэдлэг бүтээх үйлд зарцуулах хугацаа багасаж байна (r=-0.53).

*Зураг 18. Ээлжит хичээлийг зохион байгуулах бүтэц, зарцуулсан дундаж хугацаа (минут, 4 дүгээр анги)*




Ээлжит хичээлд зарцуулбал зохих 40 минут бүрэн ашиглагдаж буй нь дээрх зургаас харагдаж байгаа юм.

Ажиглалт хийсэн хичээлүүдээс харахад учир шалтгааныг олох, эрэл хайгуул хийх үйлд сурагчдыг чиглүүлэх үйлийг цөөн хийж харин зорилгод чиглэсэн эргэцүүлэн бодох асуултаар сурах сэдэл төрүүлэх үйлийг багагүй хийж байгаа ажээ. Бага боловсролын түвшинд хичээлийн зорилготой уялдуулан туршин шийдвэрлэх үйлийг багагүй хийж байна.

Ээлжит хичээлийн явцын үнэлгээг сурагчдын дасгал даалгаврын гүйцэтгэлд тулгуурладаг ба үнэлгээнд зарим нэг нэмэлт хэрэглэгдэхүүн ашиглах байдал ажиглагдав. Хичээлийг дүгнэхдээ, сурагчдын нас сэтгэхүйн онцлогт тохироогүй үг хэллэг

ашигладаг, тухайн үйлд сурагчдын оролцоонд тулгуурлан өөрийн үнэлгээ, дүгнэлт гаргуулахдаа дутмаг байна.

*Ээлжит хичээлийн зохион байгуулалтын хэлбэр*

Багш нар хичээлийг анги нийтээр зохион байгуулах хэлбэрийг түлхүү ашиглаж байна. Анги нийтээр хичээлийг зохион байгуулахдаа сурагчдад тэгш, шударга, ялгаваргүй хандах; тэдэнд хариулах боломж олгох; суралцах чадварын ялгааг харгалзах; тухайн хичээлтэй холбоотой даалгавар өгөх гэх мэт үйлүүд нэлээд давтамжтайгаа хийгдэж байна.

Ажиглалт хийсэн хичээлүүдийн хувьд хичээлийн зохион байгуулалт нь анги нийтээр байх нь олонх байсан юм. Харин багаа болон хосоор нь зохион байгуулах нь 30 орчим хувь байв. Анги нийтээр хичээл зохион байгуулж буй тохиолдолд сурагчдын бие биеэ сонсох, багаараа идэвхтэй, хамтран ажиллах үйл буурч, дэвтэртээ замбараагүй бичиглэлтэй сурагчийн тоо нэмэгдэх байдал ажиглагдав.

Ээлжит хичээлийг багаар, хосоор зохион байгуулахад сурагчдын идэвхтэй үйл ажиллагаа илүү ажиглагдав. Сурагч хичээл дээр өөрийн санаа бодлоо шүүн тунгааж эргэцүүлснээ ярих, бичиж илэрхийлэх тусам багш хичээлийн агуулгыг нэгтгэн дүгнэх үйл нь багасаж, сурагчид өөрсдөө нэгтгэн дүгнэх нь нэмэгдсэн байна. Гэхдээ энэ үйл нь харьцангуй бага ажиглагдсан нь дээрх зургаас харагдаж байна.

Бага ангийн сурагчид багшийн болон хамт суралцагчдынхаа үнэлгээг хүлээн зөвшөөрөхгүй байдал цөөнгүй ажиглагдаж байгаа нь хичээлийн эерэг үзүүлэлтийн нэг байж болох талтай юм.

Хичээлийн идэвх оролцооны талаар бага ангийн сурагчдаас тодруулахад тэдний олонх нь монгол хэл, математикийн хичээлдээ сонирхолтой гэж хариулсан бөгөөд шалтгааныг нь тодруулахад ач холбогдол, оролцоо, мэргэжилтэй холбоотой хариултууд олон байсан нь анхаарал татаж байлаа. Харин дургүй хичээл байгаа эсэх талаар асуухад ихэнх нь хариулт өгөөгүй бөгөөд өгсөн хариултуудыг нэгтгэж үзвэл биеийн тамир, математик, монгол хэл гэж хариулжээ. Тодруулж асуухад сонирхолгүй гэсэн хариултыг дийлэнх нь, “гар чилээд байдаг, байнга бичээд байдаг, байнга зураад байдаг” гэсэн хариултыг цөөн сурагч өгсөн.

> Математик бол шинжлэх ухааны хаан гэж ярьдаг. Тийм ч учраас би математикт дуртай. Мөн оюун ухаан хөгжүүлдэг сонирхолтой хичээл.
>
> *Орон нутгийн сургуулийн бага ангийн сурагч*

*Зураг 19. Хичээлийн зохион байгуулалтын талаарх сурагчдын хариулт (судлагдахуунаар)*




Зургаас харахад бага боловсролын түвшинд хичээлийг ихэвчлэн анги нийтээр зохион байгуулдаг ба багш нар багаар болон хосоор ажиллуулах хэлбэрийг бага сонгож байна. Гэхдээ хичээлүүдээр бага зэрэг ялгаатай дүр зураг харагдав. Тухайлбал, гоо зүйн чиглэлийн хичээлд багаар сургалт зохион байгуулах нь бусад хичээлүүдтэй харьцуулахад илүү, харин хүн ба нийгэм, хүн ба байгаль хичээлд хосоор ажиллуулах аргыг бусад хичээлүүдтэй харьцуулахад илүү ашиглаж байна.

Судалгаанд хамрагдсан сурагчдаас судлагдахууны чиглэлээр хичээлийн зохион байгуулалтын хэлбэр талаар мэдээлэл цуглуулахад дараах дүр зураг харагдаж байна.

Багш нар хичээлээ ихэвчлэн ямар зохион байгуулалттай явуулдаг талаар тодруулахад анги нийтээр заадаг гэж сурагчдын олонх хариулсан бол хичээлийн зохион байгуулалтын ямар хэлбэр таалагддаг гэсэн асуултад багаар гэж тэдний дийлэнх нь хариулсан.

Багш ихэвчлэн ангиар зааадаг бас хосоор заадаг. Хосоор заахад бид нар гурвуулаа суудаг байсан. Баг багаар сууж заах нь сардаа нэг л байдаг. Ингэж сууж хичээл орохоор гаднаас багш нар ирж суудаг.

*Нийслэлийн сургуулийн бага ангийн сурагч*

Хичээлийн явцад хариултыг мэдэж байсан ч бусдаас түрүүлж хариулах, дуугарах нь хэцүү байдаг уу гэхэд сурагчид хэцүү биш гэж 64.0 хувь нь, хэцүү байдаг гэж 34.0 хувь хариулжээ. Сурагчдаас хичээлтэй үедээ багшаасаа хэр их асуулт асуудгыг мөн асуултынхаа хариултыг авч чаддаг эсэхийг тодруулахад, ихэнх нь асууж чаддаг, цөөн тооны суралцагчид хааяа асуудаг, асуудаггүй гэжээ. Тэд асуултынхаа хариултыг авч чаддаг гэв. Харин тухайн хичээлийг ойлгох, багшийн ямар арга техник таалагддаг талаар асуухад жишээ гарган тайлбарлабал, зургаар дүрсэлбэл сурагчид таатай байдаг ажээ. Харин цөөн сурагч хөгжилтэй аргаар хичээлийг заах, мөн багш загнавал илүү ойлгодог гэсэн нь судлаачдын анхаарлыг татаж байлаа.

### *Ээлжит хичээл бүрээр туршилт, шийдвэрлэх асуудлыг оновчтой тодорхойлох үйл*

Ээлжит хичээлийн аль ч үед, ямар ч шийдвэрлэх асуудал үүсч болох бөгөөд багшийн зүгээс тухайн хичээлээр шийдвэрлэх асуудлыг тодорхойлохдоо юуны өмнө хичээлийн зорилготой уялдуулах ёстой.

> “Дүрс биетийг ялгах” гэсэн хичээлийн зорилготой хийж байгаа үйл ажиллагаа зохиоцоогүй гэж үзлээ. Сурагчдад тарааж өгсөн дэлгээсийн дагуу биет хийж, орой, ирмэг, талыг тоолуулах үйл ажиллагаа хийв. Хичээлийн зорилгод сурагчдыг чиглүүлсэн гэхээсээ илүү хичээл дээр хийж байгаа үйл ажиллагаанд тэдний анхаарал төвлөрч байсан.
>
> *4-р ангийн математикийн хичээлийн ажиглалтын тэмдэглэлээс*

Ээлжит хичээлээр туршилт, шийдвэрлэх асуудлыг тодорхойлоход хийгдсэн багшийн үйлийг харахад, багш нар шинэ мэдлэг бүтээх үйлийг хүүхдийн өмнө нь эзэмшсэн мэдэг, чадвар, дадалд тулгуурлан зохион байгуулдаг нийтлэг хандлага ажиглагдлаа. Сурагчид багаар ажиллаж байгаа хэдий ч баг доторх хамтын үйл ажиллагаа сул байна. Асуудлыг хамтран хэлэлцэж, нэгдсэн шийдвэрт хүрэх үйл нь зарим багш нарын хичээлийн зохион байгуулалтад тусаагүй байна. Сурагчдын ойролцоогоор 50 хувь нь л дэвтэртээ эмх цэгц дэс дараалалтай бичиглэл тэмдэглэлийг хийсэн байна.

*Сурагчдын нас, хөгжлийн онцлогт тохируулан сэдэлжүүлэх үйл*

Ээлжит хичээлийн турш сурагчдын сурах сэдлийг төрүүлэх нь багшлах арга зүйг тодорхойлох нэн чухал хүчин зүйл юм. Энэ үйл ажиллагаа нь танил үг хэллэг хэрэглэн сурагчдаас зорилгод чиглэсэн эргэцүүлэн бодох асуултыг асуух, зорилгод чиглэсэн үйл гүйцэтгүүлэхдээ тэдний нас сэтгэхүйн онцлогт тохирсон сургалтын хэрэглэгдэхүүн ашиглах, явцын үнэлгээгээр урамшуулах үйлүүдтэй шууд хамааралтай юм.

Танил үг хэллэг хэрэглэн сурагчдаас эргэцүүлэн бодох асуулт асуух нь ээлжит хичээлийн турш хийгддэг багшийн бусад үйлтэй хэрхэн холбогдсоныг авч үзье.

Багш, сурагчдаар бүтээлч дасгал даалгавар ашиглан учир шалтгааныг олох эрэл хайгуул хийлгэхэд тэдний багаар ажиллах чадвар нэмэгдэх хандлага ажиглагдсан байна.

Сурагчдаар бие даан дүгнэлт гаргаж, мэдлэг бүтээх боломж олгохын тулд эргэцүүлэн бодох асуултаар сэдэлжүүлэх, гарын доорх материал хэрэглэгдэхүүн ашиглах, сурагчдад зөвлөн туслах, урамшуулах үйлүүдийг судалгаанд хамрагдсан багш нарын 60 гаруй хувь, учир шалтгааныг олох эрэл хайгуул хийлгэх, самбараас мэдээлэл авах хугацаа хангалттай олгож, дасгал даалгавар ашиглан явцын үнэлгээ хийх үйлийг 40 орчим хувь нь хийжээ. Багшийн үйл ихсэх тутам сурагчдад самбараас мэдээлэл авах хангалттай хугацаа хомсоддог нь ажиглагдав. Сурагчдын хувьд өөрийн санаа бодол, эргэцүүлснээ бичгээр илэрхийлэх, нэгтгэн дүгнэх үйлийг нийт хичээлийн 50 хувьд ажиглагджээ. Эндээс дүгнэж үзвэл, багш сурагчдыг бодвол олон төрлийн идэвхтэй үйлүүдийг хийсэн боловч сурагчдын хариу үйлдэл дэндүү цөөн байгаа нь ээлжит хичээл дээр багшийн үйл давамгайлсан, “багш” төвтэй байгааг бас харж болохоор байна.

Сурагчдын асуулт, хариултыг багш анхааралтай сонсож, дэмжсэн багш зорилгод чиглэсэн үйл ажиллагаанд сурагчдын анхаарлыг хичээлийн турш хандуулж чадаж байгаа нь (65 хувь) багш сурагчийн үйл идэвхтэй, үр дүнтэй болохыг харуулна.

*Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн*

Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн дагуу 1-4 дүгээр ангийн 6-8 судлагдахууны 33 нэрийн сурах бичгийг сургалтад хэрэглэж байна. Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн сурагчдын сурах бичгийг бага ангид 80-100 хүртэл хувийг төрөөс үнэгүй хангах тухай гарсан шийдвэрийн дагуу 2009 оноос өнөөг хүртэл сургуулийн номын сангаар дамжуулан олгож байна. Зурагт судалгаанд хамрагдсан дөрөвдүгээр ангийн сурагчдын сурах бичгийн хүртээмжийг судлагдахуун бүрээр харуулав.

*Зураг 20. Сурах бичгийн хүртээмж (судлагдахуунаар)*




Зургаас харахад бага ангийн сурах бичгийн хүртээмжийн дундаж хувь 93.7 байна. Судлагдахуунаар нь авч үзвэл бусад сурах бичигтэй харьцуулахад иргэний боловсролын сурах бичгийн хүртээмж бага байгаа нь харагдаж байна.

Сурах бичгийн хүртээмжийг нийслэл, аймаг, сумаар нь дараах зурагт харуулав.

*Зураг 21. Сурах бичгийн хүртээмж (байршлаар)*




Сурах бичгийн хүртээмжийг байршлаар авч үзэхэд нийслэлд дундаж хувь 92.7, аймаг суманд 94.0 байна.

Сурагчдаас сурах бичиггүйн шалтгааныг тодруулахад 62.5 хувь нь гээсэн, 20 орчим хувь нь сургуулиас өгдөггүй, гээчихээд дахин худалдаж авах гэхээр олддоггүй гэжээ.

Сурагчид сурах бичгийг хэрхэн хэрэглэдэг талаар тодруулахад, сурах бичгийг хуулж бичдэг, эхийг нь уншдаг, зургийг нь хардаг, дасгал даалгаврыг нь хийдэг, сорил туршилт хийхдээ ашигладаг гэсэн нийтлэг хариулт өгсөн байна. Бага ангийн сурагчдын дунджаар 48 хувь нь сурах бичгийг хуулж бичдэг, 45 хувь нь эхийг нь уншдаг, 42 хувь нь зургийг нь хардаг, 66 хувь нь дасгал даалгаврыг нь хийдэг, 31 хувь нь сорил туршилт хийхдээ ашигладаг гэжээ. Дараах зурагт хамгийн их санал авсан үйлийг судлагдахуун бүрээр харуулав.

*Зураг 22. Бага ангийн сурах бичгийн хэрэглээ (судлагдахуунаар)*




Сурах бичгээс дасгал даалгавар хийдэг гэсэн нийтлэг хариулт багагүй хувийг эзэлж байгаа бөгөөд судлагдахууны онцлогоос хамаарч монгол хэлний сурах бичгийн эхийг уншдаг, математикийн сурах бичгийн дасгал даалгаврыг хийдэг, хүн ба нийгмийн сурах бичгийг хуулж бичдэг гэсэн хариулт цөөнгүй байна. Харин "Хүн ба байгаль" сурах бичгийн хувьд сорил туршилт хийдэг гэсэн хариултын эзлэх хувь хуулж бичдэг гэсэн хувиас бага байгаа нь байгалийн ухааны хичээлд сорил, туршилтыг бага хийж байна гэж үзэх талтай.

Сурах бичиг, сургалтын хөтөлбөрийн уялдаа холбоо хэр байгаа талаар багш нараас тодруулж асуухад ерөнхийдөө холбоотой, уялдаатай байдаг гэсэн хариултыг нийслэлийн болон хөдөө, орон нутгийн сургуулиудын багш нар өгсөн байна.

Зарим судлагдахууны багш нарын хариултаас үзэхэд, ялангуяа бага ангийн монгол хэлний хувьд унших бичигтэй нэгтгэсэн нь оновчтой биш талаар дурджээ.

Монгол хэл, унших 2-ыг нийлүүлсэн нь сурагчдын ойлгож унших чадвар нь сулраад байна.

*Нийслэлийн сургуулийн бага ангийн багш*

### *Сурах бичгийн агуулга, арга зүй*

Сурах бичгийн агуулга, арга зүйн талаар бага ангийн багш нар:

- бие даалт бага,
- ойлгомжгүй асуудал ихтэй,
- бие даах даалгаврууд дутуу,
- нэмэлт даалгавар их өгдөг
- хүүхэд уншаад ойлгохгүй үг байдаг,
- бага ангийн сурах бичгийн хувьд ихэвчлэн нэмэлт сургалтын материал ашигладаг.
- хөгжмийн хичээлийн хувьд 1-5-р анги боломжийн байна гэсэн хариултыг нийслэлийн сургуулийн багш өгсөн байна.

*Зураг 23. Бага боловсролын сурах бичигтэй ирсэн сурагчдын хувь (ажиглалтын давтамжаар)*




Зургаас харахад судалгаа авах үед сурах бичиггүй хичээллэсэн тохиолдол байхгүй ба харин ангийн нийт сурагчийн 50 хүртэл хувь нь сурах бичигтэй байсан 10 хичээл, 50-90 хүртэл хувь нь сурах бичигтэй 15 хичээл байна. Бага боловсролын сурах бичгийг сурагчдад 100 хувь хангадаг тул дээрх үзүүлэлт нь судалгаа авах үед хичээлийн хуваарь өөрчлөгдсөнтэй холбоотой байж болох юм.

Сурагчдад гэрийн даалгавар өгөхдөө хичээлийн агуулгатай холбоотой даалгаврыг сурах бичгээс өгдөг нь нийтлэг ажиглагдаж байна. Харин дараагийн үзэх хичээлийн агуулгатай холбоотой даалгаврыг сурах бичгээс өгсөн тохиолдол цөөн хувьтай ажиглагджээ. Ээлжит хичээлээр гарын авлага ба бусад хэрэглэгдэхүүн ашиглах нь нэмэгдэх тутам сурагч өөрийн гүйцэтгэх үйлд чиглэсэн асуулт асууж, сурагч сурагчаа үнэлэх нь ихсэж байна.

Сургалтад сурах бичиг ашиглалт нийтлэг сайн байгаа бөгөөд сургалтын хэрэглэгдэхүүн ашиглалтыг авч үзэхдээ ээлжит хичээлд самбарыг хэр ашиглаж байгаа нь сурагчдад мэдээллийг хүртээмжтэй хүргэхэд ач холбогдолтой юм.

Ажиглалтаар багш, самбарт гаргацтай, харагдахуйц бичиглэл хийдэг, самбараас мэдээлэл авах хангалттай хугацааг сурагчдад олгодог, самбарт бичсэн мэдээллийг ашиглан хичээлээ дүгнэдэг зэрэг үйлүүдийг хийж байна.

*Зураг 24. Самбар ашиглалт (4 дүгээр анги)*



*Зураг 25. Бага боловсролын түвшинд хичээлд ашигласан үзүүлэн (4 дүгээр анги)*




Зургаас харахад судалгаанд хамрагдсан бага боловсролын багш ээлжит хичээлд лабораторийн үзүүлэн, амьд үзүүлэн хэрэглэсэн нь ажиглагдаагүй ба хэвлэмэл үзүүлэн ихэвчлэн ашиглаж байна.

*Үнэлгээ, дүгнэлт*

Судалгаагаар сурагчдыг үнэлэхэд гардаг өөрчлөлтийн талаар багш нараас тодруулахад ерөнхийдөө өөрчлөлт орсон гэж багш нарын олонх нь үзжээ. Тэр дундаа явцын үнэлгээнд үндэслэн сурагчдыг чиглүүлэх, зөвлөн туслахад өөрчлөлт орсон гэж багш нарын 41.1 хувь нь үзсэн бол тэдний 50-иас дээш хувь нь сурагчдыг үнэлэхэд бага зэргийн өөрчлөлт орсон, 3.0-11.0 хувь нь үнэлгээнд өөрчлөлт гараагүй гэсэн байна.

Судалгаанд хамрагдсан багш нарын 65.8 хувь нь сурагчдаар бие биенийг нь үнэлүүлэх, 64.4 хувь сурагчийн өөрийн үнэлгээний аргыг зарим хичээлд хамгийн их ашигладаг гэсэн байна. Үнэлгээний аргуудыг бүх хичээлд тодорхой хэмжээгээр ашигладаг гэсний дунд хичээлийн явцад ажиглах, асуулт тавих, тэмдэглэл хөтлөх аргуудыг нэлээд дурдсан байна. Үнэлгээний арга, хэлбэрүүдийг хичээлдээ ашигладаггүй гэж хариулсан багш нарын хувь бага байгаагаас үзэхэд багш нар үнэлгээний төрөл бүрийн арга, хэлбэрийг хичээлдээ ямар нэг байдлаар хэрэглэдэг байна.

Багш нар явцын болон үр дүнгийн үнэлгээг дараах зорилгоор сургалт, үйл ажиллагаандаа хэрэглэж байгаа гэжээ. Үүнд:

- Сурагчдын ахицыг үнэлэх;
- Сурагчдыг идэвхжүүлэх, сонирхлыг сайжруулах;
- Сурагчдыг оношлох;
- Өөрийн боловсруулсан хөтөлбөр, төлөвлөгөөнд анализ хийх гм.

Бага ангийн үнэлгээ дунд ангийн үнэлгээтэй зөрүүтэй байгаа талаар сургалтын менежерүүд хөндөж байна. Энэ нь ялангуяа 4, 5 дугаар ангийн сурагчдын хувьд илүү ажиглагддаг тухай дурдаад “бага ангид үнэлгээний хувьд “массаараа тайван явдаг”, гэтэл дунд ангид ороод анхны гарааны үнэлгээгээр стандарт хангахгүй гардаг” гэсэн нь анхаарал татав.

Ярилцлагад хамрагдсан сурагчдаас үнэлгээнд хэр сэтгэл ханамжтай байдаг талаар тодруулахад сэтгэл ханамжтай, шударга үнэлдэг гэсэн хариултыг бүх сурагчид өгсөн байна.

> Бид нар том болсон болохоор одоо бол багш смайл тавихаа болиод зөвлөж тавьдаг болсон.
>
> *Орон нутгийн сургуулийн бага ангийн сурагч*

Хичээлийн явцад бие биенийгээ болон өөрийгөө үнэлдэг" болон "үнэлдэггүй" гэсэн хариултын хувилбар тооны хувьд ойролцоо байна. Цаашид юун дээр анхаарахаа үнэлгээнээс мэдэж авч чаддаг уу гэсэн асуултад бүгд тийм гэсэн хариултыг өгсөн байна.

Ямар нэг хэцүү зүйл тулгарвал хэнд ханддаг талаар лавлахад судалгаанд хамрагдсан сурагчдын 10 орчим хувьд асуудал тулгардаггүй гэсэн хариулт өгсөн бөгөөд харин сурагчдын 50.0 хувь нь эцэг, эх гэр бүлийнхэндээ, 33.0 хувь нь багшдаа 17.0 хувь нь найз нөхдөдөө ханддаг гэсэн хариултыг өгчээ.

Ээлжит хичээлийн үнэлгээ, дүгнэлт хийх нь дараагийн хичээлийн төлөвлөлт, зохион байгуулалтын урьтач нөхцөл болно. Үнэлгээ, дүгнэлт хийхдээ ээлжит хичээлийн явц ба төгсгөлд даалгаврын гүйцэтгэл, хэрэглэгдэхүүн ашиглах, эсвэл аман үнэлгээгээр урамшуулах үйлүүдтэй хамт хийгдсэн байна.

Явцын үнэлгээг даалгавраар хийхэд хүүхдийн асуулт, хариултыг анхааралтай сонсож, дэмжсэн, сурагчдад зөвлөн тусалсан, бие даан дүгнэлт гаргаж, мэдлэг бүтээх боломж олгосон, төлөвлөсөн зорилтоо бүрэн хэрэгжүүлсэн байх юм. Сурагчид өөрийн санаа бодол, шүүн тунгааж эргэцүүлснээ бичгээр, яриагаар илэрхийлсэн, бие биеэ анхааралтай сонссон байна.

*Зураг 26. Явцын үнэлгээ (4 дүгээр анги, судлагдахуунаар)*




Судалгаанд хамрагдсан эцэг эх, асран хамгаалагчид хүүхдэд нь хичээл заадаг багш нарын чадварыг дараах байдлаар дүгнэж байна.

*Зураг 27. Бага ангийн багш нарын ур чадварыг үнэлсэн байдал (эцэг эх, асран хамгаалагчид)*




Эцэг эх, асран хамгаалагчид багш нарыг хүүхдээ бодитой үнэлэх чадварт шүүмжлэлтэй хандсан байна. Мөн хичээлийг сонирхолтой заах чадварыг сайжруулах шаардлагатай гэж үзжээ.

### *Сургалтыг дэмжих үйл ажиллагаа*

Сургалтыг дэмжих үйл ажиллагаа хэрхэн хэрэгжиж байгаа болон цаашид яаж зохион байгуулах нь үр дүнтэй байж болох талаар судалгаанд хамрагдсан сургуулиудын сургалтын менежерүүд, багш нартай ярилцахад харилцан адилгүй хариултыг өгсөн байна.

> СДҮА нь анги хамт олон төлөвшилд багаар ажиллах, хүүхдэд хүүхдийн сэтгэл зүйд хандсан ажил байвал сургалтыг дэмжих цаг дээр ядаж нэг асуудал шийдэж байна.
>
> *Нийслэлийн сургуулийн бага ангийн багш*

Амьдрах чадварт суралцах үйл ажиллагааг эрүүл мэндийн хичээлээр сольсоныг сургалтын менежерүүд онцлон тэмдэглэсэн бөгөөд бага ангид СДҮА-аар STEM (Шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик) хөтөлбөрийг хэрэгжүүлж байна гэжээ.

Хувийн сургуулиудын хувьд сургалтыг дэмжих үйл ажиллагааг мөн адил зохион байгуулдаг бөгөөд анги даасан багш нарын мэдэлд байхын зэрэгцээ төрөл бүрийн үйл ажиллагааг зохион явуулдаг талаар хэлсэн байна. Тухайлбал, ерөнхий боловсролын түвшин бүрээр сургалтыг дэмжих үйл ажиллагааг тогтвортой зохион байгуулдаг туршлага хуримтлуулсан байна. Жишээлбэл, 1-3 дугаар ангид “Би том болж байна” хөтөлбөр, 4-5 ангид 5 дахь жилдээ хэрэгжиж “Боролдой хөтөлбөр” зэргийг сургалтын менежерүүд болон багш нар дурдсан байна.

Хичээлээс гадуурх үйл ажиллагааны оролцооны талаар судалгаанд хамрагдсан сургуулиудын сурагчидтай бүлгийн ярилцлага хийхэд ихэвчлэн урлагийн үзлэг зохион байгуулагддаг бөгөөд үүнд анги нийтээрээ оролцдог гэсэн хариултыг өгсөн. Гар бөмбөг, бөх, хөлбөмбөг, даам зэрэг секц, дугуйланд хамрагддаг гэсэн хариултыг олонх сурагч өгсөн бол сэтгэл ханамжийн талаар тодруулахад бүгд эерэг хариулт өгсөн. Харин цаашид хичээллүүлэх дугуйлан секцийн талаар лавлахад бөх, бокс, хөгжмийн дугуйлан гэж дийлэнх нь, усанд, сэлэлт, илтгэл, теннис, зураг, таэквондо, волейбол, сагсан бөмбөг, шатар, уран нугаралт гэсэн хариултыг зарим сурагчид хэлсэн.

*Хамтын ажиллагаа, оролцоо*

Хичээл, сургалтын явцад эцэг эх, асран хамгаалагчдтай хамтран ажилладаг чиглэл, давтамжийн талаар багш нараас тодруулахад олон чиглэл, хэлбэрээр тодорхой давтамжтайгаар хамтран ажилладаг дүр зурагтай байна. Тухайлбал, багш нарын 50.7 хувь нь хүүхдэд тулгарсан асуудал, бэрхшээлийн талаар 14 хоногт нэг удаа эцэг эх, асран хамгаалагчидтай ярилцдаг, шийдвэрлэдэг; сургуулийн зорилго, хөгжлийн талаар улиралд нэг удаа мэдээлдэг гэж 54.8 хувь нь хариулсан байна. Цаг үеийн мэдээлэл, үйл явцын талаар 14 хоногт нэг удаа мэдээлдэг гэж багш нарын 30.1 хувь нь, сурагчийн сурлагын ахиц, амжилт, өөрчлөлтийн талаар сард нэг удаа эцэг эхтэй хамтран ажилладаг гэж багш нарын 35.6 хувь хариулсан.

Багш нарын зүгээс улирал, сар эсвэл 14 хоног тутам сурагчийн зан төлөв, хүмүүжил төлөвшлийн талаар эцэг эх, асран хамгаалагчдад мэдээлэл өгөх, ярилцах зэргээр хамтран ажилладаг гэж багш нарын 23-37 хувь хариулжээ.

Сурагчдын сурлагын амжилтыг ахиулахад эцэг эх, асран хамгаалагчдын оролцоог багш нараар үнэлүүлэхэд эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийнхээ сурлагын ахиц, өөрчлөлт болон хүмүүжил, төлөвшлийн талаар багшаас хааяа мэдээлэл авч, асууж ярилцдаг гэж багш нарын олонх нь хариулсан. Харин сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, хангахад огт тусалдаггүй гэж багш нарын 31.5 хувь нь хариулсан байна.

**Цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд үзүүлж буй дэмжлэг, хамтын ажиллагааг багшаар үнэлүүлэхэд ерөнхийдөө сайн гэж үнэлжээ**. Ялангуяа, заах аргын нэгдлүүд (ЗАН) болон сургалтын захирлыг дэмжлэг сайн үзүүлдэг гэж судалгаанд оролцсон багш нарын 50 гаруй хувь нь хариулсны зэрэгцээ сургалтын менежерийн дэмжлэг сайн гэж тал нь үзжээ.

Багш нарын хувьд аймаг, нийслэлийн боловсролын газар зэрэг шат шатны холбогдох байгууллагууд, эцэг эх, асран хамгаалагчид тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлж, хамтран ажилладаг гэсэн бөгөөд боловсролын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагууд (ТББ)-ын тусламж, дэмжлэг, хамтын ажиллагаанд сэтгэл дундуур байгаа дүр зурагтай байна.

*Хичээлийн төлөвлөлтийг хэрэгжүүлэх байдлыг ээлжит хичээлийн түвшинд судалсан бөгөөд багш нар жилийн болон улирал, нэгж хичээлийн төлөвлөлтийг ээлжит хичээлийнхээс илүүтэй боловсруулдаг. Ээлжит хичээлийг төлөвлөлгүйгээр бусад төлөвлөгөөндөө тулгуурлан хичээлийг зохион байгуулах байдал цөөнгүй ажиглагдсан болно. Хичээлийн төлөвлөлтийн дагуу ажиллахад цаг үеийн төлөвлөгдөөгүй ажлууд гарч ирдэг мөн хичээлд ашиглах нэмэлт хэрэглэгдэхүүний зардал олдохгүй байх, хүүхдийн онцлогийг харгалзан ажиллахад мэдлэг, туршлага дутагдах байдал нь бэрхшээл үүсгэж байна.*

*Бага боловсролын түвшинд хичээл багш төвтэй байна. Бага боловсролын түвшинд хичээлийн зорилгыг сурагчдад танилцуулахдаа багш нар сул анхаарч байгаа ба ихэвчлэн анги нийтээр хичээлийг зохион байгуулж байна. Гэтэл сурагчид багаар болон хосоор зохион байгуулахад сонирхолтой байна. Багаар болон хосоор хичээлийг зохион байгуулахад сурагчдын идэвхтэй үйл анги нийтээр зохион байгуулсан хичээлтэй харьцуулахад илүү ажиглагдав. Анги нийтээр зохион байгуулж байгаа үед багш нар сурагчдын оролцоог хангах, тэдний ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах,*

*асуултад хариулах боломжийг тэгш олгох талаар анхаарч байлаа. Эцэг эхчүүдийн 70.0 хувь нь багш нарын мэргэжлийн чадварыг сайн гэж үзсэн ч 55.0 хувь нь тэд хичээлээ хүүхдэд нь сонирхолтойгоор явуулж чадаж байна гэжээ.*

*Бага боловсролын түвшинд сурах бичгийн хүртээмжийг авч үзэхэд, багшийн журналын тэмдэглэгээний хүрээнд 90 гаруй хувьтай байна. Сурах бичгийн ашиглалтын хувьд хичээл дээр дасгал ажиллах, хуулж бичих мөн гэрийн даалгавар хийхэд сурагчид ашиглаж байна. Багшийн хувьд багшийн номыг ашигладаг, сургалтад ихээхэн хэрэгцээтэй ч хүртээмж муу байна.*

*Багш нар сурагчдын үнэж дүгнэх үйл ажиллагааг ээлжит хичээлийн түвшинд авч үзэхэд ажиглалт хийсэн хичээлийн 50 хувьд үнэлгээг тодорхой хэмжээгээр хийж байна. Ингэхдээ дасгал, даалгаврын гүйцэтгэлд тулгуурлах хийх нь нийтлэг байна. Эцэг эхчүүдийн 65.0 хувь нь багш нар хүүхдүүдийг нь бодитой үнэлдэгт гэж үзжээ.*

*Бага боловсролын түвшинд багш эцэг эхчүүдийн хамтын ажиллагаа спортын уралдаан тэмцээн зохион байгуулах, багшийн зүгээс холбогдох мэдээлэл хүргэх, хүүхдийн сурлагын амжилтын талаар мэдээлэл өгөх зэргээр ихэвчлэн хамтардаг ч энэ төрлийн үйл ажиллагаанд тогтмол оролцдог нь 40 орчим хувьтай байна.*

*Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд аймаг, нийслэлийн боловсролын газар тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлдэг ч тухайн хичээлийн арга зүйтэй холбоотой илүү тодорхой дэмжлэг хэрэгтэй байгааг багш нар онцолжээ. Тэдний 50 хувь нь сургалтын менежерийн дэмжлэгэд сэтгэл хангалуун байна. Харин бусад хамтрагч байгууллагууд, иргэд нь хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжиж чадахгүй байгаа нь харагдав.*

## Сорилын гүйцэтгэлийн шинжилгээ

*Зорилго:* 2014 оноос үндэсний хэмжээнд хэрэгжиж эхэлсэн бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрөөр 4, 8, 11 дүгээр ангийн сурагчдын эзэмшсэн мэдлэг, чадварыг тандахад оршино.

Судалгаанд хамрагдсан ерөнхий боловсролын сургуулиудаас авсан сорилын материалуудыг засаж, оноожуулж, шивж, гарсан үр дүнг нэгтгээд, MS Excel, Testan 6.5, SPSS 22 зэрэг статистикийн программ ашиглан шинжилгээг хийсэн. Шинжилгээний үр дүнд тулгуурлан даалгаврын хүнд, хөнгөний зэрэг, ялгах чадварыг дараах байдлаар авч үзсэн болно. Үүнд:

- Хүнд, хөнгөний зэргийг сурагчдын даалгаврын гүйцэтгэлийн хувь:
    - **80-аас багагүй бол “хэт хөнгөн”,**
    - **70-аас багагүй 80-аас бага байвал “хөнгөн”,**
    - **30-аас багагүй 70-аас бага байвал “тохиромжтой”,**
    - **20-оос багагүй 30-аас бага байвал “хүнд”,**
    - **20-оос бага бол “хэт хүнд” гэж тооцов.**
- Ялгах чадварыг 0.4-өөс багагүй бол “маш сайн”, 0.3-аас багагүй 0.4-өөс бага байвал “сайн”, 0.2-оос багагүй 0.3-аас бага байвал “дундаж”, 0.1-ээс багагүй 0.2-оос бага байвал “муу”, 0.1-ээс бага бол “маш сул” гэж тооцсон.

# Математикийн сорилын гүйцэтгэлийн шинжилгээ

Бага боловсролын 4 дүгээр ангийн математикийн сорилд сургалтын хөтөлбөрийн тоо тоолол, хэмжигдэхүүн, геометр, өгөгдөлтэй ажиллах агуулгыг хамруулан сурагчдын мэдлэг, мэдлэгээ хэрэглэх чадварыг тандахад чиглэсэн сонгох хариулттай 5, бодолт хийж гүйцэтгэх задгай хэлбэрийн 5, нийт 10 даалгаврыг оруулав.

*Хүснэгт 12. Сорилын бүтэц (Математик, 4 дүгээр анги)*

| Даалгаврын түвшин | Даалгаврын эзлэх хувь | Онооны хуваарилалт |
|---|---|---|
| Мэдлэг, ойлголт | 50.0 | 7 |
| Мэдлэгээ хэрэглэх чадвар | 50.0 | 9 |
| Нийт | 100.0 | 16 |

### *4 дүгээр ангийн сурагчдын математикийн сорилын гүйцэтгэлийн ерөнхий үр дүн*

*Зураг 28. Сорилын нийт гүйцэтгэл )Математик, 4 дүгээр анги(*




4 дүгээр ангийн математикийн сорилоор сурагчдын авсан онооны тархалт нормал тархалт уруу дөхсөн, найдварт байдлын коэффициент 0.729 байна.

Сорилын даалгавар бүрээр арифметик дундаж, авбал зохих оноо, хамаарал, сурагчдын гүйцэтгэлийн хувийг хүснэгтээр харууллаа.

*Хүснэгт 13. Сорилын нийт даалгаврын хамаарал, гүйцэтгэл (Математик, 4 дүгээр анги)*

| Даал-гаврын дугаар | Даалгаврын зорилго | Ариф-метик дундаж (Mean) | Оноо (Maximum) | Корре-ляцын коэффи-циент ($r_{pb}$) | Гүйцэтгэ-лийн хувь (Percent) |
|---|---|---|---|---|---|
| Д:1 | Сая хүртэлх натурал тоог тоймлох | 0.699 | 1.0 | 0.381 | 69.5 |
| Д:2 | Нийлбэр нь 1 байх хоёр энгийн бутархайг олох | 0.446 | 1.0 | 0.541 | 44.3 |
| Д:3 | Ижил хуваарьтай энгийн бутархайг нэмж, хасан асуудал шийдвэрлэх | 0.358 | 1.0 | 0.571 | 35.6 |
| Д:4 | Боломжийг тооцоолох | 0.599 | 1.0 | 0.521 | 57.9 |
| Д:5 | Тоон шулуун хэрэглэн сөрөг тоог жиших | 0.617 | 1.0 | 0.485 | 61.1 |
| ЗД:6 | Дүрсийн талбайн хэмжээ, периметрийг олох | 0.480 | 2.0 | 0.557 | 24.0 |
| ЗД:7 | Өгсөн дүрстэй тэгш хэмтэй дүрсийг зурах | 0.754 | 2.0 | 0.396 | 37.7 |
| ЗД:8а | Мөр, баганыг нь тоо, үсгээр тэмдэглэсэн хүснэгтийн аль нэг нүдэнд байгаа юмсын байршлыг олох | 0.788 | 1.0 | 0.530 | 78.8 |
| ЗД:8б | Юмсыг заасан нүдэнд шилжүүлэн зурах | 0.565 | 1.0 | 0.534 | 56.5 |
| ЗД:9а | Худалдааны хялбар тооцоо хийх | 0.818 | 1.0 | 0.51 | 81.8 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| ЗД:9б | Үйлдлийн гишүүдийн хамаарлыг хэрэглэн дүгнэлт гаргах | 0.162 | 1.0 | 0.486 | 16.2 |
| ЗД:10а | Баганан диаграмм дахь утгыг хэрэглэн тооцоолол хийх | 0.562 | 1.0 | 0.641 | 56.2 |
| ЗД:10б | Баганан диаграммыг гүйцээн зурах | 0.687 | 1.0 | 0.578 | 68.7 |
| ЗД:10в | Баганан диаграммд өгсөн утгуудын хамгийн багыг олох | 0.788 | 1.0 | 0.513 | 78.8 |
| Нийт | | | 16 | 1.0 | |

Хүнд, хөнгөний зэргээр даалгавар 9б хэт хүнд, 6 хүнд, даалгавар **1-5, 7, 8б, 10а, 10б тохиромжтой**, 8а, 9а, 10в хөнгөн байна. Цэгэн бисериал корреляцын коэффициентийн үзүүлэлтээс харахад ихэнх даалгаврын гүйцэтгэлийн оноо сорилоор авсан оноотой эерэг хамааралтай ($r_{pb}$>0.25) байна.

*Хүснэгт 14. Сорилын даалгавруудын хамаарал (Математик 4 дүгээр анги)*

| Даал-гавар | Д:1 | Д:2 | Д:3 | Д:4 | Д:5 | ЗД:6 | ЗД:7 | ЗД:8а | ЗД:8б | ЗД:9а | ЗД:9б | ЗД:10а | ЗД:10б | ЗД:10в |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Д:1 | 1 | .105** | .186** | .251** | .181** | .137** | .057 | .087* | .123** | .106** | .121** | .185** | .179** | .087* |
| Д:2 | .105** | 1 | .417** | .248** | .161** | .210** | .154** | .220** | .163** | .189** | .262** | .305** | .243** | .236** |
| Д:3 | .186** | .417** | 1 | .255** | .165** | .277** | .089* | .234** | .225** | .235** | .315** | .336** | .225** | .226** |
| Д:4 | .251** | .248** | .255** | 1 | .232** | .193** | .129** | .217** | .190** | .267** | .175** | .226** | .206** | .200** |
| Д:5 | .181** | .161** | .165** | .232** | 1 | .237** | .093* | .230** | .260** | .172** | .197** | .213** | .211** | .171** |
| ЗД:6 | .137** | .210** | .277** | .193** | .237** | 1 | .084* | .184** | .297** | .232** | .295** | .313** | .207** | .190** |
| ЗД:7 | .057 | .154** | .089* | .129** | .093* | .084* | 1 | .153** | .113** | .070 | .144** | .120** | .157** | .123** |
| ЗД:8а | .087* | .220** | .234** | .217** | .230** | .184** | .153** | 1 | .328** | .295** | .140** | .291** | .329** | .270** |
| ЗД:8б | .123** | .163** | .225** | .190** | .260** | .297** | .113** | .328** | 1 | .232** | .276** | .252** | .231** | .188** |
| ЗД:9а | .106** | .189** | .235** | .267** | .172** | .232** | .070 | .295** | .232** | 1 | .184** | .378** | .233** | .316** |
| ЗД:9б | .121** | .262** | .315** | .175** | .197** | .295** | .144** | .140** | .276** | .184** | 1 | .233** | .150** | .173** |
| ЗД:10а | .185** | .305** | .336** | .226** | .213** | .313** | .120** | .291** | .252** | .378** | .233** | 1 | .509** | .333** |
| ЗД:10б | .179** | .243** | .225** | .206** | .211** | .207** | .157** | .329** | .231** | .233** | .150** | .509** | 1 | .373** |
| ЗД:10в | .087* | .236** | .226** | .200** | .171** | .190** | .123** | .270** | .188** | .316** | .173** | .333** | .373** | 1 |

**. Correlation is significant at the 0.01 level )2-tailed(. *. Correlation is significant at the 0.05 level )2-tailed(.

Даалгавар 1 ба 7, 7 ба 9а-аас бусад даалгаврууд хамааралтай (Pearson correlation) байгаа нь хүснэгтээс харагдаж байна.

4 дүгээр ангийн математикийн сонгох хариулттай даалгаврыг гүйцэтгэхдээ сурагчдын сонгосон хариултын хувилбар, ялгах чадварыг Testan программ хэрэглэн гаргав.

*Хүснэгт 15. Сонгох хариулттай даалгаврын гүйцэтгэл (Математик, 4 дүгээр анги)*

| *Даалгаврын дугаар* | *Сонгосон хариултын хувь* | | | | | | *Ялгах чадвар (Discrimination)* |
|---|---|---|---|---|---|---|---|
| | *А* | *Б* | *В* | *Г* | *Хүчингүй* | *Хоосон* | |
| Д:1 | 12.1 | 9.7 | 4.5 | 69.5 | 0.6 | 3.5 | 0.533 |
| Д:2 | 19.8 | 44.3 | 12.1 | 18.7 | 0.3 | 4.8 | 0.698 |
| Д:3 | 19.5 | 34.9 | 35.6 | 4.0 | 1.1 | 4.9 | 0.669 |
| Д:4 | 6.7 | 57.9 | 14.8 | 11.6 | 0.3 | 8.6 | 0.686 |
| Д:5 | 3.5 | 14.8 | 61.1 | 16.4 | 1.6 | 2.6 | 0.675 |

Бүх даалгаврын ялгах чадвар маш сайн, даалгавруудын хариултын хувилбар бүрээс сурагчид тодорхой хэмжээгээр сонгосон байна.

*Мэдлэг, ойлголтыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

4 дүгээр ангийн математикийн сорилд сурагчдын мэдлэг, ойлголтыг илрүүлэхэд чиглэсэн 5 даалгавар (1, 2, 5, 7, 8) тусгасны 3 нь сонгох хариулттай, 2 нь задгай хэлбэрийн даалгавар байв. Статистик үзүүлэлтүүдээс харахад нэг даалгавар хөнгөн, бусад нь тохиромжтой, сорилын бусад даалгавартай хамааралтай байна.

Даалгавар 1-ийг зөв гүйцэтгэсэн сурагчдын эзлэх хувь (69.5) даалгавар тэдэнд хөнгөдөх талтай байсныг илэрхийлэх ч сурагчдын 30.5 хувь буруу хариултыг сонгон, бодолтдоо тоог тоймлох орныг андуурах, 0-ийг тооцохгүй байх зэрэг алдаа гаргаж байсан нь тэд тоог тоймлохын утга санааг бүрэн ойлгоогүйг илэрхийлж байна.

Даалгавар 2 нь цээжээр тооцоолох боломжтой энгийн бутархайн үйлдэлд тулгуурлан тоо, хэмжээн дээр тооцоолол хийхэд чиглэсэн байв. Сонгосон буруу хариулт, бичиглэлээс сурагчдын 55.7 хувь энгийн бутархайн нэмэх, хасах аргын талаар ташаа ойлголттой байгаа нь харагдаж байна. Тухайлбал: сурагчид хүртвэр дээр хүртвэрийг, хуваарь дээр хуваарийг нэмэх, үүний адилаар сэтгэн хасаж алдсан байна. Нөгөө талаас, энэ нь ерөнхий боловсролын сургуулиудын I, II улиралд судлахаар төлөвлөсөн агуулга харилцан адилгүй, сурагчид III ангиас эхэлж судалсан энэхүү сэдвийг судалгаа авахаас өмнөх хугацаанд 4 дүгээр ангидаа үргэлжлүүлэн судалж, бататгаж амжаагүй байж болох талтай.

Даалгавар 5 сурагчдад харьцангуй хөнгөн байсан ч сурагчдын 38.9 хувь буруу хариулт сонгосон буюу хариулаагүй орхисон байдлаас эерэг тоотой андуурч жиших, 0-ийг хамгийн бага гэж тооцох, их хэмжээг олох тал ажиглагдав.

2 онооны даалгавар 7-г зөв гүйцэтгэсэн сурагчдын дундаж хувь 37.7 байна. Сурагчдын 46.3 хувь даалгаварт өгсөн нөхцөлийн дагуу тэгш хэмтэй дүрсийг зөв зурж 2 оноо авсан бол 14.5 хувь өгсөн зааврын дагуу биш ч тэгш хэмтэй дүрсийн талаар мэдлэг, ойлголтоо илэрхийлсэн зураглал хийн 1 оноо авсан байна.

2 алхамтай 8 дугаар даалгаврын эхний алхмыг сурагчдын 78.8 хувь, хоёрдугаар алхмыг 56.5 хувь зөв гүйцэтгэсэн байна. Уг даалгаврыг гүйцэтгэхдээ хүснэгтийн мөр, баганы тэмдэглэгээг зөрүүлэн бичих, баруун, зүүнээ ялгахгүй буруу чиглэлд шилжүүлэх байдал зарим сурагчдын хувьд ажиглагдлаа.

*Мэдлэгээ хэрэглэх чадварыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

4 дүгээр ангийн математикийн сорилд сурагчдын мэдлэгээ хэрэглэх чадварыг илрүүлэхэд чиглэсэн 5 даалгавар (3, 4, 6, 9, 10) тусгасны 2 нь сонгох хариулттай, 3 нь задгай хэлбэрийн даалгавар байна. 9, 10 дугаар даалгаврыг хийх алхмаар нь задлан шинжилсэн статистик үзүүлэлтүүдээс харахад 9а, 10в хөнгөн, 6, 9б хүнд, бусад нь тохиромжтой, сорилын бусад даалгавартай хамааралтай байна.

Даалгавар 3-ыг сурагчдын 35.6 хувь гүйцэтгэсэн байна. Уг даалгаврыг хоёр үйлдлээр зөв бодсон сурагчдын зэрэгцээ бодлогын өгсөн нөхцөл дэх энгийн бутархайг нэмэх буюу хасах, өмнө дурдсанчлан энгийн бутархайн нэмэх, хасах үйлдлийг буруу гүйцэтгэх байдал ажиглагдав.

Даалгавар 4-ийг сурагчдын 57.9 хувь зөв гүйцэтгэсэн байна. Эдгээр сурагчид тоонуудаа тоочин бичих, модны загвар хэрэглэх, үржүүлэн тооцоолох аргаар бодсон байлаа. Харин бусад сурагчид зарим тоог бичиж боломжийг дутуу тооцоолох, өгсөн нөхцөлд тохирохгүй тоо бичих зэргээр алджээ.

Даалгавар 6 нь өгсөн дүрсийн талуудын уртыг хэмжээд, талбайн хэмжээ, периметрийг тооцоолоход чиглэсэн. Сурагчдын 6.9 хувь уг даалгаврыг бүрэн зөв, 34.3 хувь талбайн хэмжээ, периметрийн аль нэгийг олсон буюу зөв аргаар тооцоолох оролдлого хийсэн байна. Сурагчдын үлдэх хувь тэгш өнцөгтөөс ялгаатай дүрсийн талбайн хэмжээ, периметрийг тэгш өнцөгтийн хувьд хэрэглэдэг томьёогоор бодох гэж оролдох, дүрсийг хэсгүүдэд хуваан илүү, дутуу, эсвэл буруу тооцоолол хийх зэргээр алдсан байна.

Даалгавар 9-ийн зорилго худалдааны тооцоололд хэрэглэдэг юмсын нэгжийн үнэ, тоо хэмжээ, нийт үнийн дүнгийн хамаарлын талаар дүгнэлт гаргахад оршиж байв. Сурагчид дүгнэлт гаргахад нь дэмжлэг болгоход чиглэсэн: юмсын худалдан авахад төлөх нийт үнийн дүнг 9а-д хялбархан тооцоолсон (81.8 хувь) ч түүндээ тулгуурлан дүгнэлтээ сайн гаргаж чадахгүй байгаа нь 9б-д хариулсан сурагчдын эзлэх хувь 16.2 байгаагаас харагдаж байна.

Даалгавар 10-ын гүйцэтгэлээс сурагчид баганан диаграммыг унших, өгсөн мэдээллийг хэрэглэн асуултад хариулах, тооцоолол хийх чадвартай нь харагдаж байна. Харин өгсөн бодлогын заавар, асуултыг дутуу харж орхигдуулан буруу ойлгох, тооцооллыг буруу хийх зэргээр сурагчдын 21.2 - 43.8 хувь алдсан байна.

Бага боловсролын математикийн сорилын гүйцэтгэлийн үр дүнгээс харахад:

- 4 дүгээр ангийн математикийн сорилын 10 даалгаврын заримыг алхмаар задлан 14 болгож, тэдгээрт сурагчдын гүйцэтгэлийг шинжлэхэд 3 нь хөнгөн, 2 нь хүнд, 9 нь тохиромжтой, даалгавруудын ялгах чадвар сайн, хоорондоо хамааралтай байна. Түүнчлэн сурагчдын гүйцэтгэлийн тархалтын муруй нормал тархалтад дөхсөн байна.
- Мэдлэг, ойлголтыг илрүүлэхэд чиглэсэн 5 даалгаврын 3 нь дунджаар 60-аас дээш, 2 нь 30-аас дээш хувийн гүйцэтгэлтэй байна. Бага хувийн гүйцэтгэлтэй даалгавруудад холбогдох агуулгыг III ангиас судалж байсан ч 4 дүгээр ангидаа бататган сэргээж амжаагүй, тэгш хэмийн тэнхлэгээ хаана авахаа сайн мэдэхгүй, энгийн бутархайг нэмэх, хасах аргын талаар буруу ойлголттой байгаа зэрэг нь сурагчдыг алдахад хүргэсэн байх талтай.
- Мэдлэгээ хэрэглэх чадварыг илрүүлэхэд чиглэсэн даалгавруудаас сурагчид өгөгдөлтэй ажиллах, худалдааны тооцоо хийх, боломжийг тоочих зэргийг сайн хийсэн байна. Гэхдээ шинэ нөхцөлд хэрэглэх аргаа сонгон асуудал шийдвэрлэх, дүгнэлт гаргах чадварыг хөгжүүлэх, түүнчлэн асуулт, даалгаврын зааврыг бүрэн гүйцэд уншиж сайн ойлгосны дараа гүйцэтгэх зэрэгт анхаарахаар байна.
- 2014 оноос үндэсний хэмжээнд хэрэгжиж эхэлсэн математикийн сургалтын хөтөлбөрт орсон шинэ агуулгатай холбогдох сөрөг тоог таних, жиших, тэгш хэмтэй дүрсийг таних, юмсын байршил хөдөлгөөний тодорхойлох даалгаврыг боломжийн гүйцэтгэж байна. Харин энгийн бутархайн үйлдлийг болон дүрсийн тэгш хэмийн тухайд түвшнийг ахиулан өгсөн даалгаврыг хангалттай сайн хийгээгүй байна.
- 2014 оноос өмнөх болон одоогийн сургалтын хөтөлбөрүүдэд тусгагдаж байсан агуулгуудаас тоог тоймлох, худалдааны хялбар тооцоо хийх, баганан диаграммтай ажиллах нь сурагчдын хувьд боломжийн түвшинд, харин тэгш өнцөгтүүдээс тогтсон нийлмэл дүрсийн талбайн хэмжээ, периметрийг олох, үйлдлийн гишүүдийн хамаарлыг ойлгон хэрэглэх, модны загвар хэрэглэн боломжийг тооцоолох чадварыг хөгжүүлэхэд анхаарал хандуулахаар харагдаж байна.

- Сурагчдын даалгаврын гүйцэтгэл, сонгосон буруу хариулт, хийсэн бодолт, бичиглэл, зураглал зэргээс математикийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг нэмэгдүүлэхийн тулд заах арга зүй, үнэлгээг сайжруулах хэрэгтэй нь харагдаж байна. Тухайлбал, тогтолцооны шинжилгээний үүднээс хандан агуулгыг нягтруулах, олон талаас нь авч үзэн асуудлыг бүрэн ойлгох, ахуй амьдралын асуудалтай уялдуулан ойлгоход дөхөм арга, хэрэгслийг сонгон заах, даалгаврын төрлийг баяжуулан тавилыг сурагчдад танил болгох, бага гэлтгүй сурагчдын гаргаж байгаа алдаа, ойлголтын зөрүүнд анхаарал хандуулах, сурагчдыг заавраа тогтож унших, ойлгох, тоо, хэмжээ, тэмдэглэгээ гэх мэтийг бичихдээ хайнга хандалгүй зөв бичиж тооцооллыг хийхэд чиглүүлэх гэх мэт.

## Монгол хэлний сорилын гүйцэтгэлийн шинжилгээ

Бага боловсролын 4 дүгээр ангийн монгол хэлний сорил нь тухайн ангийн нэгдүгээр улиралд судалсан агуулгын хүрээнд унших, бичих чадвар, хэл зүй, үгийн санг эзэмшсэн байдлыг илрүүлэх зорилготой бөгөөд мэдлэг, ойлголт буюу А хэсэг, мэдлэгээ хэрэглэх буюу Б хэсгийн нийт 13 онооны 10 задгай даалгавартай.

*Хүснэгт 16. Сорилын бүтэц (Монгол хэл, 4 дүгээр анги)*

| *Агуулга* | *Даалгаврын эзлэх хувь* | *Онооны эзлэх хувь* |
|---|---|---|
| Мэдлэг, ойлголт | 50 | 63.3 |
| Мэдлэгээ хэрэглэх чадвар | 50 | 36.7 |

*Хүснэгт 17. Сурагчдын даалгаврын гүйцэтгэл (Монгол хэл, 4 дүгээр анги)*

| *Үнэлгээний зорилт* | *Гүйцэтгэлийн хувь* | | | | | | | | | | *Дундаж хувь* |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | *ЗД:1* | *ЗД:2* | *ЗД:3* | *ЗД:4* | *ЗД:5* | *ЗД:6* | *ЗД:7* | *ЗД:8* | *ЗД:9* | *ЗД:10* | |
| Мэдлэг ойлголтыг илрүүлэх | 57.6 | | 52.4 | 47.9 | 48.9 | | | 49.9 | | | 51.3 |
| Мэдлэгээ хэрэглэх | | 52.9 | | | | 51.5 | 40.5 | | 63.4 | 65.6 | 54.8 |

Монгол хэлний 4 дүгээр ангийн сорилын 1, 2, 3, 6, 8 дугаар даалгавар унших чадварыг, 5, 9, 10 дугаар даалгавар бичих чадварыг, 4, 7 дугаар даалгавар хэл зүйн чадварыг илрүүлэхэд чиглэсэн. Нийт сурагчийн унших чадвар сайн, бичих болон хэл зүй, үгийн сангийн даалгаврын гүйцэтгэл дундаж байна.

*Хүснэгт 18. Унших, бичих, хэл зүй үгийн сангийн даалгаврын гүйцэтгэл (Монгол хэл, 4 дүгээр анги)*

| *Үнэлгээний зорилт* | *Гүйцэтгэлийн хувь* | | | | | | | | | | *Дундаж хувь* |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | *ЗД:1* | *ЗД:2* | *ЗД:3* | *ЗД:4* | *ЗД:5* | *ЗД:6* | *ЗД:7* | *ЗД:8* | *ЗД:9* | *ЗД:10* | |
| Унших | 57.6 | 52.9 | 52.4 | | | 51.5 | | 49.9 | | | 52.9 |
| Бичих | | | | | 48.9 | | | | 63.4 | 65.6 | 59.3 |
| Хэл зүй, Үгийн сан | | | | 47.9 | | | 40.5 | | | | 44.2 |

Монгол хэлний унших болон бичих даалгаврыг сурагчид сайн гүйцэтгэсэн боловч хэл зүй, үгийн сангийн даалгаврын гүйцэтгэлийг харахад үгийн тоондоо хүрээгүй, буруу бичсэн үг их байгаагаас гадна, найруулан бичих чадвар маш муу эзэмшсэн нь сорил гүйцэтгэсэн шинжилгээний явцад ажиглагдлаа.

Энэ нь (4 дүгээр анги) бага боловсролын цөм хөтөлбөрт тусгагдсан, бичсэнээ хянах, сайжруулах-найруулгын алдааг хянаж засах чадварыг сурагчид хагалтгүй эзэмшсэн харагдаж байна.

Сурагчдын монгол хэлний сорилын нийт гүйцэтгэлийн арифметик дундаж 58.0 хувь, медиан 61.5 хувь, моод 69.2 хувь, максимум 100 хувь, минимум 0 байна.

*Зураг 29. Сорилын нийт даалгаврын гүйцэтгэл (Монгол хэл, 4 дүгээр анги)*




*Зураг 30. А хэсгийн задгай даалгаврын гүйцэтгэл (Монгол хэл, 4 дүгээр анги)*




Задгай даалгаврын гүйцэтгэлийн арифметик дундаж 60.6 хувь, медиан 62.5 хувь, моод 75.0 хувь, максимум 100 хувь, минимум 0 байна.

*Бичих чадварыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

*Зураг 31. Б хэсгийн задгай даалгаврын гүйцэтгэл (Монгол хэл, 4 дүгээр анги)*




Монгол хэлний сорилын бичих чадварын гүйцэтгэлийн арифметик дундаж 53.8 хувь, медиан 60.0 хувь, моод 40.0 хувь, максимум 100 хувь, минимум 0 байна.

*Хүснэгт 19. Задгай даалгаврын гүйцэтгэлийн хувь (Монгол хэл, 4 дүгээр анги)*

| Даалгавар | ЗД:9а | ЗД:9б | ЗД:10 |
|---|---|---|---|
| Гүйцэтгэлийн хувь | 59.4 | 67.3 | 65.6 |

Бичих чадварыг илрүүлэх “Б” хэсгийн задгай даалгаврын гүйцэтгэлийн хувь 64.1 байна.

*Хүснэгт 20. Бичих чадварыг илрүүлэх даалгаврын шалгуур, гүйцэтгэл “Б хэсэг” (Монгол хэл, 4 дүгээр анги)*

| *Шалгуур* | *Оноо* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|
| Эхийг үргэлжлүүлэн зөв оновчтой таамаглан, зохиож бичсэн эсэх | 2 | 59.4 |
| Зөв бичгийн дүрэм | 1 | 67.3 |
| Үргэлжлүүлэн бичсэн эхээ бүрэн гүйцэд дуусгаж чадсан эсэх /үг нэмэх, хасах/ | 1 | 65.6 |
| Зөв бичгийн дүрэм | 1 | |
| Дундаж хувь | | 64.1 |

Бага боловсролын монгол хэлний даалгаврын хамаарлыг хүснэгтээр харуулав.

*Хүснэгт 21. Сорилын даалгаврын хамаарал (Монгол хэл, 4 дүгээр анги)*

| | *ЗД:1* | *ЗД:2* | *ЗД:3* | *ЗД:4* | *ЗД:5* | *ЗД:6* | *ЗД:7* | *ЗД:8* | *ЗД:9а* | *ЗД:9б* | *ЗД:10* |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| ЗД:1 | 1 | .258** | .303** | .234** | .304** | .231** | .109** | .222** | .401** | .109** | .252** |
| ЗД:2 | .258** | 1 | .228** | .229** | .191** | .260** | .177** | .193** | .266** | 0.002 | .281** |
| ЗД:3 | .303** | .228** | 1 | .212** | .269** | .259** | .121** | .178** | .260** | 0.069 | .236** |
| ЗД:4 | .234** | .229** | .212** | 1 | .225** | .206** | 0.068 | .223** | .228** | 0.074 | .190** |
| ЗД:5 | .304** | .191** | .269** | .225** | 1 | .214** | .116** | .236** | .303** | 0.067 | .171** |
| ЗД:6 | .231** | .260** | .259** | .206** | .214** | 1 | .182** | .218** | .315** | 0.041 | .152** |
| ЗД:7 | .109** | .177** | .121** | 0.068 | .116** | .182** | 1 | .154** | .240** | 0.016 | .188** |
| ЗД:8 | .222** | .193** | .178** | .223** | .236** | .218** | .154** | 1 | .274** | 0.048 | .216** |
| ЗД:9а | .401** | .266** | .260** | .228** | .303** | .315** | .240** | .274** | 1 | .094* | .491** |
| ЗД:9б | .109** | 0.002 | 0.069 | 0.074 | 0.067 | 0.041 | 0.016 | 0.048 | .094* | 1 | 0.053 |
| ЗД:10 | .252** | .281** | .236** | .190** | .171** | .152** | .188** | .216** | .491** | 0.053 | 1 |

Бага боловсролын монгол хэлний 4 дүгээр ангийн сорилын даалгавар 9б, 4 ба 7-оос бусад даалгавар хоорондоо ач холбогдол бүхий эерэг хамааралтай байна. Бага боловсролын монгол хэлний сорилын гүйцэтгэлийн үр дүнгээс харахад:

- Бага боловсролын 4 дүгээр ангийн сурагчдын мэдлэг, ойлголт 51.3 хувь, мэдлэгээ хэрэглэх чадвар 54.8 хувь байна.
- Сурагчид А хэсгийн задгай даалгаварт хэт анхаарлаа төвлөрүүлсэн Б хэсгийн мэдлэгээ хэрэглэх даалгавруудыг орхигдуулсан байж болзошгүй байдал байна.

## “Хүн ба байгаль”-ийн сорилын гүйцэтгэлийн шинжилгээ

Бага боловсролын 4 дүгээр ангийн хүн ба байгалийн сорил нь мэдлэг, ойлголт, мэдлэгээ хэрэглэх чадварыг илрүүлэх 5 даалгавартай. Сорилд мэдлэгээ хэрэглэх чадвар эзэмшилтийг илрүүлэх даалгаврын эзлэх хувь өндөр байх зорилго тавьсан.

*Хүснэгт 22. Сорилын даалгаврын жин, гүйцэтгэл (Хүн ба байгаль, 4 дүгээр анги)*

| *Агуулга* | *Даалгаврын эзлэх хувь* | *Онооны эзлэх хувь* | *Гүйцэтгэлийн дундаж хувь* |
|---|---|---|---|
| Мэдлэг, ойлголт | 20.0 | 25.0 | 85.0 |
| Мэдлэгээ хэрэглэх чадвар | 30.0 | 75.0 | 27.0 |

*Мэдлэг, ойлголтыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Даалгавар 1.

*Зорилго*: Тулгуур хөдөлгөөний эрхтнийг мэдэж ойлгосон эсэхийг илрүүлэхэд оршино.

4 дүгээр ангийн сургалтын цөм хөтөлбөрт хүний биеийн араг яс, булчинг загвар болон зурагтай харьцуулан заан нэрлэх, араг яс, булчинг хамтад нь тулгуур, хөдөлгөөний эрхтэн хэмээн нэрлэдэг болохыг мэдэх агуулга туссан. Үүнтэй холбоотой энэхүү даалгаврын хүндрэлийн зэрэг маш хүнд, ялгах чадвар маш бага байгааг Testan программм хэрэглэн даалгаварт хийсэн шинжилгээний үр дүн харуулж байна.

Сурагчдын 71.8 хувь Г буюу зөв хариултыг сонгосон байна. Харин нийт сурагчийн 28.2 хувь буруу хариултыг сонгосон байгаа нь тулгуур хөдөлгөөний эрхтэн тогтолцооны эрхтнүүдийн талаар ойлголт дутмаг байгааг харуулж байна. Тулгуур хөдөлгөөний эрхтэн тогтолцоонд хамаарахгүйг сонгоно уу гэсэн нь сурагчдын даалгаврын гүйцэтгэлд нөлөөлсөн байх талтай.

Даалгавар 2.

*Зорилго:* 4 дүгээр ангид үзэж судалсан агуулгатай залгамж холбоо бүхий өмнө үзсэн агуулга эзэмшилтийг илрүүлэхэд оршино.

Сурагчид 2 дугаар ангид гэрэл гаргадаг биеүүдийг нэрлэх, гэрэл үүсгэгчтэй холбоотой болохыг мэдэх, туршлагаар нотлох агуулга үзэж судалсан. Үүнтэй залгамж холбоо бүхий агуулгатай уг даалгаврын хүндрэлийн зэрэг нь хэт хөнгөн, ялгах чадвар маш бага байгааг даалгаварт хийсэн шинжилгээний үр дүн харуулж байна.

Сурагчдын 98.2 хувь В буюу зөв хариултыг сонгосон байгаагаас даалгаврын тавил хэт хөнгөн болсон харагдаж байна.

Судалгаанд хамрагдсан сурагчдын мэдлэг, ойлголтыг илрүүлэх даалгаврын гүйцэтгэл 85 хувь байгаа нь эдгээр агуулгын суурь мэдлэг ойлголт хангалттай сайн байгааг харуулж байна.

*Мэдлэгээ хэрэглэх чадварыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Мэдлэгээ хэрэглэх чадварыг илрүүлэх даалгаврыг богино хариулттай байхаар боловсруулсан.

Даалгавар 3.

*Зорилго*: Сурах бичигт тусгасан даалгаврыг сурагчид хэрхэн гүйцэтгэж байгааг болон шинжлэх ухааны өгөгдөл бүхий зураг унших, үр дүнг тайлбарлан бичих чадварыг илрүүлэхэд оршино.

Сургалтын цөм хөтөлбөрт хүний араг яс үетэй хэсгээрээ хөдөлдөг болохыг хуруу болон биеийн бусад хэсгүүд дээр турших, зураг дээр үетэй хэсгүүдийг тэмдэглэн хөдөлгөөнтэй холбон тайлбарлах, бугалганы хос булчинг барьж тэмтрэх, зураг дээр заан нэрлэх, бугалганы булчингийн ажиллах зарчмыг турших, зураг, загвараар тайлбарлах, хос булчингийн агшилт, сулралтаар араг яс хөдөлгөөнд ордог болохыг туршин батлах агуулга туссан.

Дээрхтэй холбоотой чадварыг илрүүлэхэд чиглэсэн энэ даалгаврыг сурагчдын 12.9 хувь зөв, 87.1 хувь буруу гүйцэтгэсэн байна. Сурагчид зургийн өгөгдлийг хараад зөв тайлбар хийж чадаагүй байна. Сурах бичигт тусгасан зургийн өгөгдлийг хэрэглэн боловсруулсан энэ даалгаврын гүйцэтгэлээс сурагчид сурах бичгийг сургалтад хэрэглээгүй байх магадлалтай нь харагдаж байна.

Даалгавар 4.

*Зорилго*: Туршилтын үр дүнгээс сүүдрийн хэмжээ биеийн байрлалаас хамаарч байгааг илрүүлэх, үр дүнг тооцоолон бичих чадварыг илрүүлэхэд оршино.

Сургалтын цөм хөтөлбөрт тунгалаг биш биет гэрэл нэвтрүүлэхгүй, тунгалаг биет ихэнх гэрлийг нэвтрүүлдэгийг болон сүүдрийн хэмжээ биеийн байрлалаас хэрхэн хамаарахыг судлах агуулга туссан.

Даалгавар 4а-г сурагчдын 31.6 хувь зөв, 68.4 хувь буруу, даалгавар 4б-г сурагчдын 20.4 хувь зөв, 79.6 хувь буруу гүйцэтгэсэн байна. Сурагчдын даалгаврын гүйцэтгэлээс харахад туршилтын үр дүнд тулгуурлан дүгнэлт хийсэн сурагчдын эзлэх хувь бага байна. Энэ нь бага боловсролд туршилтын хичээлийг төлөвлөх, хэрэгжүүлэх байдалтай холбоотой байх магадлалтай тул багшийн хичээл төлөвлөлтөд шинжилгээ хийж үзэх хэрэгцээ байгааг харуулж байна.

Даалгавар 5.

*Зорилго*: Шинжлэх ухааны өгөгдөл бүхий зургийг ажиглаад араг ясны гүйцэтгэх үүргийг тайлбарлан бичих чадварыг илрүүлэхэд оршино.

Сургалтын цөм хөтөлбөрт араг яс нь биеийн тулгуурын, хамгаалах үүрэгтэй болохыг туршилтаар батлах агуулга туссан. Сурагчдын даалгаврын гүйцэтгэлээс харахад зургийн өгөгдлөөс биеийн эрхтнүүдийг хамгаалах үүрэгтэй 2 араг ясны нэрийг хоёуланг зөв нэрлэсэн сурагчид 62.5 хувь, нэгийг нэрлэсэн сурагчид 17.9 хувь, харин үүргийг тайлбарлаж бичсэн сурагчид нийт сурагчийн 15 хувийг эзэлж байна.

*Хүснэгт 23. Сорилын 5 дугаар даалгаврын гүйцэтгэл (Хүн ба байгаль, 4 дүгээр анги)*

| *Даалгавар* | *Оноо* | *Хариултын мэдээлэл /гүйцэтгэлийн хувиар/* | | | |
|---|---|---|---|---|---|
| | | *1 оноо* | *2 оноо* | *Буруу хариулсан* | *Огт хариулаагүй* |
| ЗД:5а | 2 | 17.9 | 62.5 | 19.6 | 0 |
| ЗД:5б | 1 | 15.0 | 0 | 85.0 | 0 |

Энэ даалгаврын гүйцэтгэлийг агуулга, танин мэдэхүйн түвшний хувьд ижил 3 дугаар даалгаврын гүйцэтгэлтэй харьцуулахад адилхан хангалтгүй байна. Энэ нь сурагчдын тулгуур хөдөлгөөний эрхтэн тогтолцооны талаарх ойлголт дутмаг байгааг харуулж байна.

*Хүснэгт 24. Мэдлэгээ хэрэглэх чадварыг илрүүлэх даалгаврын статистик үзүүлэлт (Хүн ба байгаль, 4 дүгээр анги)*

| | *Минимум оноо* | *Максимум оноо* | *Арифметик дундаж* | *Стандарт хазайлт* |
|---|---|---|---|---|
| ЗД:3 | .0 | 1.0 | .129 | .3357 |
| ЗД:4а | .0 | 1.0 | .316 | .4652 |
| ЗД:4б | .0 | 1.0 | .204 | .4034 |
| ЗД:5а | .0 | 2.0 | 1.429 | .7990 |
| ЗД:5б | .0 | 1.0 | .150 | .3573 |

Хүн ба байгаль хичээлийн агуулга эзэмшилтийг дараах байдлаар ангилан судалж, үр дүнг хүснэгтэд харуулав.

*Хүснэгт 25. Агуулгын шинжилгээний дүн (Хүн ба байгаль, 4 дүгээр анги)*

| *Агуулга* | *Даалгаврын дугаар* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|
| Сургалтын цөм хөтөлбөрт шинээр тусгасан агуулга | 4 | 26.0 |
| Өмнөх ангид судалсан агуулгатай залгамж холбоо бүхий гүнзгийрсэн агуулга | 2 | 98.2 |
| Сурах бичигт тусгасан даалгаврыг хөгжүүлсэн агуулга | 3 | 12.9 |
| Тухайн ангид судалсан агуулга | 1 | 71.8 |
| | 5 | 43.2 |

Бага боловсролын хүн ба байгаль хичээлийн сорилын сурагчдын гүйцэтгэл хэвийн тархалттай байна.

*Зураг 32. Сорилын нийт гүйцэтгэл (Хүн ба байгаль, 4 дүгээр анги)*




Бага боловсролын хүн ба байгалийн сорилын гүйцэтгэлийн үр дүнгээс харахад:

- Сорилын гүйцэтгэлийн дундаж 56.0 хувь, мэдлэг ойлголтын эзэмшилт 85.0 хувь байгаа нь суурь, бүрэн дунд боловсролын гүйцэтгэлээс илүү байна.
- Мэдлэгээ хэрэглэх чадварын гүйцэтгэлийн дундаж 27.0 хувь байгаа нь багш нарын мэдлэг ур чадвар, хандлага, сургалтын орчин бүрдүүлэхээс хамааралтай байж болох юм.
- Сургалтын цөм хөтөлбөрт шинээр тусгасан агуулгын эзэмшилт 26.0 хувь байгаа нь бага ангийн багшийн байгалийн ухааны хичээл заах арга зүйд дэмжлэг үзүүлэх шаардлага байгааг харуулж байна.
- Сурах бичигт тусгасан даалгаврыг хөгжүүлсэн сорилын гүйцэтгэл 12.9 хувь байгаа нь бага ангийн багш нар сурах бичгийг сургалтад хэрэглэхгүй, шинжлэх ухааны өгөгдөл бүхий зураг, хүснэгт бүхий дасгал даалгавар ажиллуулахгүй байгаатай холбоотой байж болно.

## “Хүн ба нийгэм”-ийн сорилын гүйцэтгэлийн шинжилгээ

Бага боловсролын 4 дүгээр ангийн хүн ба нийгэм хичээлийн сорил нь сургалтын цөм хөтөлбөрт заасан мэдлэг, ойлголтыг илрүүлэх 5 даалгавраас бүрдэнэ.

*Хүснэгт 26. Сорилын даалгаврын жин, гүйцэтгэл (Хүн ба байгаль, 4 дүгээр анги)*

| Агуулга | Даалгаврын эзлэх хувь | Онооны эзлэх хувь | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|
| Мэдлэг, ойлголт | 100 | 100 | 74.8 |

Даалгавар 1.

*Даалгаврын зорилго*: Уугийн бичгийг эхлэн хөтлөхөд заавал мэдвэл зохих ээжийн талын төрөл саданг ялган таних, зөв нэрлэх.

Хүндрэлийн зэрэг хөнгөн, ялгах чадвар маш сайн байгааг даалгаварт хийсэн шинжилгээний үр дүн харуулж байна.

Нийт сурагчийн 73.8 хувь зөв хариултыг, 26.2 хувь буруу хариултыг сонгожээ. Г зөв хариултыг сурагчдын 73.8 хувь сонгосон нь тэдний энэ чиглэлийн мэдлэг боломжийн байгааг илрүүлж байна. Сорилд хамрагдагчдын 10 хувь А буруу хариултыг сонгосон нь эцгийн талын төрөл садант авга, эхийн талын төрөл садант нагац гэдэгтэй андуурсантай холбоотой. Б буруу хариултыг 9.1 хувь сонгосон нь ахмад хүнээ хүндэтгэхэд хэрэглэгдэх нэршил гэж үзсэнтэй холбогдоно. В буруу хариултыг 5.3 хувь сонгосон нь төрөл саднаа нэрлэх нэршлээр ерөнхий нэршил гэж үзсэнтэй холбоотой.

Даалгавар 2.

*Даалгаврын зорилго*: Харилцааны олон хэлбэрээс сургуулийн орчин дахь харилцааны хэлбэрийг зөв сонгох.

Хүндрэлийн зэрэг тохиромжтой, ялгах чадвар дундаж байгааг даалгаварт хийсэн шинжилгээний үр дүн харуулж байна.

Сурагчдын 64.6 хувь зөв хариултыг, 35.4 хувь буруу хариултыг сонгожээ. Үүнээс 64.6 хувь А зөв хариултыг сонгосон нь харьцангуй боломжийн байна. Б буруу хариултыг 3.3 хувь сонгосон нь харилцааг зөвхөн өөртэйгээ харилцах хэлбэр гэж үзсэнтэй холбоотой. В буруу хариултыг 5.7 хувь сонгосон нь байгалийг харилцааны бас нэг орчин гэж ойлгосон гэж үзэхээр байна. Г буруу хариултыг 24.1 хувь сонгосон нь сургуулийн орчин дахь харилцааг нийгэмтэй харилцах өргөн хүрээний харилцаанаас ялгаж ойлгоогүйтэй холбоотой.

Даалгавар 3.

*Даалгаврын зорилго*: Сурагч бичил нийгэм болох гэр бүлдээ хэрхэн, яаж туслах хэлбэрүүдийг ойлгосон байх.

Хүндрэлийн зэрэг маш хүнд, ялгах чадвар дундаж байгааг даалгаварт хийсэн шинжилгээний үр дүн харуулж байна.

Сурагчдын 86.1 хувь зөв хариултыг (Б), 13.9 хувь буруу хариултыг сонгожээ. Б зөв хариултыг сонгосон сурагчид 86.1 хувь сонгосон нь эдгээр сурагчдын энэ чиглэлийн мэдлэг боломжийн буйг илтгэнэ. Сурагчдын 4.6 хувь А буруу хариултыг сонгосон нь сургуулийн орчин болон гэр бүлийн орчны ялгаа, тэдгээр орчинд яаж туслах хэлбэрүүдийг мэдээгүйтэй холбоотой. В буруу хариултыг 6.4 хувь сонгосон нь мөн л сургуулийн орчин ба гэр бүлийн орчныг ялгаж ойлгоогүйтэй холбогдоно. Г буруу хариултыг сурагчдын 6 хувь сонгожээ.

Даалгавар 4, 5.

Найдварын зэрэг 0.65 байгааг даалгаварт хийсэн шинжилгээний үр дүн харуулж байна.

*Хүснэгт 27. Сорилын даалгавар 4, 5-ын гүйцэтгэл (Хүн ба байгаль, 4 дүгээр анги)*

| *Даалгаврын дугаар* | *Хариулт/оноо* | *Гүйцэтгэлийн хувь* | *Гүйцэтгэлийн дундаж хувь* |
|---|---|---|---|
| 4 | 1 | 68.1 | 46.9 |
| | 2 | 25.8 | |
| 5 | 1 | 66.2 | 47 |
| | 2 | 27.9 | |

*Хүснэгт 28. Даалгаврын хамаарал (Хүн ба байгаль, 4 дүгээр анги)*

| Даалгавар | 4 | 5 |
|---|---|---|

| | | |
|---|---|---|
| 4 sig.(2 tailed) | | 0.000 |
| 5 sig.(2 tailed | 0.000 | |

4 дүгээр даалгаврын гүйцэтгэлийн дүнгээс үзэхэд сурагчийн 25.8 хувь даалгаврыг зөв гүйцэтгэж, 68.1 хувь дутуу гүйцэтгэж, 6.1 хувь буруу гүйцэтгэсэн байна. Дутуу болон буруу гүйцэтгэлтэй сурагчид аливаа дүрмийн хэрэгжилт, ач холбогдол, санал бодлоо илэрхийлэх арга барилыг дутмаг эзэмшсэнтэй холбоотой байна. 5 дугаар даалгаврын гүйцэтгэлийн дүнгээс үзэхэд сурагчийн 27.9 хувь даалгаврыг зөв гүйцэтгэж, 66.2 хувь дутуу гүйцэтгэж, 6 хувь буруу гүйцэтгэсэн байна. Дутуу болон буруу гүйцэтгэлтэй сурагчид аливаа дүрмээс сурагчийн эрх, үүрэг болон сургуулийн дүрмийг ялгах арга барилыг дутмаг эзэмшсэнтэй холбоотой байна. Даалгаврын хамаарлын шинжилгээний дүнгээс үзэхэд 4 болон 5 дугаар даалгаврууд хоорондоо хамааралтай байна.

*Зураг 33. Сорилын нийт гүйцэтгэл (Хүн ба байгаль, 4 дүгээр анги)*




Бага боловсролын хүн ба нийгэм хичээлийн сорилын даалгаврын гүйцэтгэлийн үр дүнг зургаар харуулав.

Бага боловсролын хүн ба нийгмийн сорилын гүйцэтгэлийн үр дүнгээс харахад:

- Хүн ба нийгэм сорилд хамрагдсан сурагчдын 73.8-64.6 хувь зөв хариултыг (сорилын 1, 2 дугаар даалгаврын хувьд) сонгосон нь дундаж, дунджаас дээгүүр үзүүлэлт юм.
- Сурагчдын 86.1 хувь (сорилын 3 дугаар даалгаврын хувьд) зөв гүйцэтгэсэн нь тэдний төрөл садангаа ялангуяа, эхийн талын төрөл саданг ялгах, нэрлэх мэдлэг харьцангуй хангалттай байгааг харуулж байна.
- Сурагчдын сонгох сорилын даалгавруудын гүйцэтгэлийн шинжилгээ нь тэд сургуулийн орчин дахь харилцааны хэлбэрийг зөв сонгох, сургуулийн орчны харилцааг нийгэмтэй харилцах өргөн хүрээний харилцаанаас ялгах, бас санал бодлоо илэрхийлэх арга барилын эзэмшилт сул байгааг харуулав.
- Сурагчдын задгай даалгаврын гүйцэтгэл нь сурагчийн эрх, үүрэг болон сургуулийн дүрмийн заалтыг ялгах, тодорхойлох арга барилыг сул эзэмшсэнийг илрүүлж байна.
- “Хүн ба нийгэм”-ийн даалгаврын хамаарлын шинжилгээний дүн нь 4 ба 5 дугаар даалгавар (задгай даалгавар) хоорондоо хамааралтайг харуулж байна.

## Хөгжмийн сорилын гүйцэтгэлийн шинжилгээ

Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлснээр сурагчдын сурлагын амжилтад гарч буй өөрчлөлтийг судалж, хөтөлбөрийг илүү боловсронгуй болгоход санал гаргах зорилгоор хэрэгжсэн судалгааны нэг хэсэг нь сурагчдын сурах арга барилыг илрүүлэх даалгаврын сорил юм.

Бага боловсролын 4 дүгээр ангийн хөгжмийн сорилын даалгавар нь мэдлэг, мэдлэг, ойлголтоо хэрэглэх чадварыг илрүүлэх 3 даалгавартай. Сорилд мэдлэг ойлголт, мэдлэгээ хэрэглэх чадвар эзэмшилтийг илрүүлэх даалгавар нь тэнцүү байх зорилго тавьсан бөгөөд тухайн агуулгад онооны эзлэх хувийг дараах хүснэгтээс харж болно.

*Хүснэгт 29. Сорилын даалгаврын жин, гүйцэтгэл (Хөгжим, 4 дүгээр анги)*

| *Агуулга* | *Даалгаврын эзлэх хувь* | *Онооны эзлэх хувь* | *Гүйцэтгэлийн дундаж хувь* |
|---|---|---|---|
| Мэдлэг, ойлголт | 50.0 | 40.0 | 21.8 |
| Мэдлэгээ хэрэглэх чадвар | 50.0 | 60.0 | 39.2 |

Сурагчдын гүйцэтгэлийг даалгавар тус бүрээр авч үзэхэд даалгавар 1б буюу эгшгийн уртыг тэмдэглэх, даалгавар 4 буюу ноот бичлэгийг ажиглаад бишгүүр болон пианика хөгжмөөр хөгжимдөх чадвар бусад даалгаврын гүйцэтгэлээс доогуур байна. Харин эгшгийг нэрлэх, аялгууны шинж төрхийг тодорхойлох даалгаврын гүйцэтгэл дундаж түвшинд байгаа бол Д.Кабалевский “Гурван охин” зохиолыг сонсоод аялгууны хурдыг тодорхойлох чадвар сайн байна.

*Зураг 34. Даалгавар тус бүрийн гүйцэтгэл (Хөгжим, 4 дүгээр анги)*




Сурагчдын буруу хариултыг шинжилж үзэхэд аялгууны шинж төрх, хурдыг хооронд нь зөрүүлж ойлгох тохиолдол нэлээдгүй байна.

*Мэдлэг үнэлэх даалгаврын шинжилгээ*

Даалгавар 1.

*Даалгаврын зорилго:* Ноот бичлэгт ажиглалт хийж аялгууны чиглэл, хөдөлгөөн /өгсөх, уруудах/-ийг мэдэрч, эгшгийг нэрлэх, уртыг тэмдэглэх

*Зураг 35. Мэдлэг үнэлэх даалгаврын харьцуулалт (Хөгжим, 4 дүгээр анги)*




Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн агуулгад ноотоор унших, энгийн хэмнэлийн багцлалуудыг сонсож бичих, хөгжмийн дүр дүрслэлийг аялгууны хэмнэл, эгшгийн чиглэл хөдөлгөөн, өнгө аяс, хурд хүчний нийлэмжээр ойлгуулахаар тусган оруулсан байдаг.

Судалгаанд хамрагдсан сурагчдын нэгдүгээр даалгаврын гүйцэтгэлийг харахад эгшгийг нэрлэж бичих чадварын хувьд хангалттай хэдий ч эгшгийн уртыг тэмдэглэж, нэрлэх чадвар хангалтгүй байна. Сурагчдын буруу хариултыг шинжилж үзэхэд дэвсгэр 5 шугам дээр ноотны байрлалыг мэдэхгүй байх, зөрүүлж бичих тохиодол их байгаа бол эгшгийн уртыг тэмдэглэхдээ математикийн хичээлийн зүй тогтолоор ихэнх нь бичсэн байна.

*Сонсох чадварыг үнэлэх даалгаврын шинжилгээ*

Даалгавар 2.

*Даалгаврын зорилго:* Хөгжмийн зохиолч Д.Кабалевский “Гурван охин” бүтээлийг сонсоод аялгууны хурд, шинж төрхийг тодорхойлох

*Хүснэгт 30. Сонсох даалгаврын гүйцэтгэл (Хөгжим, 4 дүгээр анги)*

| *Оноо* | | *Хувь* | *Хүчинтэй хувь* | *Хуримтлагдсан хувь* |
|---|---|---|---|---|
| ЗД:2 | 0 | 70.8 | 70.8 | 70.8 |
| | 1 | 29.2 | 29.2 | 100 |
| ЗД:3 | 0 | 23.3 | 23.3 | 23.3 |
| | 1 | 76.7 | 76.7 | 100 |

Сургалтын цөм хөтөлбөрийн агуулгад хөгжим сонсох үйл ажиллагаагаар дамжуулан хөгжмийн зохиолчдын бүтээлээс сонсож аялгууны шинж төрх, өнгө аяс, хурд, хүчийг тодорхойлох, эдгээр хэрэглүүрийн тусламжтайгаар хөгжмийн зохиолын утга санаа, хөгжмийн энгийн хэлбэрүүдийг ойлгож, хэрэглээ болгох зорилтыг дэвшүүлсэн байдаг.

Судалгааны даалгавар энэхүү зорилтын хэрэгжилт рүү чиглэсэн бөгөөд сурагчдын гүйцэтгэлийг харахад Д.Кабалевский “Гурван охин” зохиолын хөгжмийг сонсоод хурдыг тодорхойлох чадвар харьцангуй сайн байна. Харин дүрслэлийг илэрхийлсэн зураг, ноот бичвэрийг уншаад аялгууны шинж төрхийг тодорхойлох чадвар доогуур 29.2 хувийг эзэлж байна.

Сурагчдын буруу хариултыг шинжлэхэд зураг, график дүрслэл, өгөгдөл, ноот бичвэрийг харьцуулан унших чадвар сул, хурдыг тодорхойлох үг хэллэгтэй андуурч бичих байдал нэлээдгүй байна.

*Хөгжимдөх чадварыг үнэлэх даалгаврын шинжилгээ*

Даалгавар 3.

*Даалгаврын зорилго:* Ноот бичлэгийг ажиглаад бишгүүр хөгжмөөр янз бүрийн дасгалыг ноотоор хөгжимдөх чадварыг илрүүлэх.

Сурагчдын хөгжимдөх чадварыг судалгаанд хамрагдсан сургуулиудын 4 дүгээр ангиас түүврийн аргаар 10 сурагчийг сонгон авч үзсэн болно. Тухайн сургуульд хөгжмийн хичээлээр бишгүүр болон пианика хөгжмийг заадаг эсэхээс хамаараад хөгжимдөх чадварын даалгаврыг 138 сурагч гүйцэтгэсэн байна. Эдгээр сурагчийн гүйцэтгэлийг дараах шалгуурын дагуу авсан болно. Үүнд:

- ноотоо таньж, хэмнэлээр хөгжимдсөн,
- ноотоо таньж байгаа боловч хэмнэлээ алдсан
- ноотоо таньж байгаа боловч хэмнэлээр хөгжимдөөгүй,
- ноотоо таньж хөгжимдөөгүй,
- ноотоо таньж байгаа боловч барилтаа мэддэггүй.

Хөтөлбөрийн агуулга нь сонсох, дуулах, хөгжимдөх, бүжиглэх, зохион найруулах үйлд тулгуурлах ба суралцагч урлагийн бүтээлийг мэдрэх, хүлээн авах, түүнийг энгийн болон бишгүүр хөгжмийн зэмсгүүдээр илэрхийлэх чадвар эзэмшихээр томьёологдсон байдаг.

Гүйцэтгэлийн үр дүнгээс харахад сурагчдын 42.1 хувь ноотоо таньж, хэмнэлийн дагуу хөгжимдсөн, 7.2 хувь ноотоо таньж байгаа боловч хэмнэлээ алдсан, 50.7 хувь ноотоо болон хөгжмийн барилтаа мэдэхгүй байсан байна.

Энэ удаагийн хөгжмийн сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн нэг гол зорилго сурагчдын ноот унших чадварыг дээшлүүлэхийн тулд тодорхой нэг хөгтэй хөгжмийн зэмсгээр сургалт, үйл ажиллагаа явуулахад чиглэгдсэн. Гэсэн хэдий ч судалгаанд хамрагдсан зарим сургууль зөвхөн хурууны дугаараар хөгжимдөх үйл ажиллагаа явуулж байгаа нь сурагчдын ноот унших чадварт сөргөөр нөлөөлөх магадлалтай.

Сурагчдын агуулга эзэмшилтийг дараах байдлаар ангилан, үр дүнг хүснэгтэд харуулав.

*Хүснэгт 31. Агуулгын ерөнхий гүйцэтгэл (Хөгжим, 4 дүгээр анги)*

| *Даалгаврын дугаар* | *Агуулга/чадвар* | *Зөв хариулт* | *Стандарт хазайлт* |
|---|---|---|---|
| ЗД:1а | Эгшгүүдийг нэрлэх | 27.6% | .4441 |
| ЗД:1б | Эгшгийн уртыг тоо болон үгэн тэмдэглэгээгээр бичих | 16.1% | .3604 |
| ЗД:Б2 | Хөгжим сонсоод аялгууны шинж төрхийг тодорхойлох | 28.9% | .4542 |
| ЗД:Б3 | Хөгжим сонсоод хурдыг тодорхойлох | 77.9% | .4220 |
| ЗД:Б4 | Ноот уншиж хөгжимдөх | 10.7% | .2985 |

*Хүснэгт 32. Сорилын даалгаврын хамаарал (Хөгжим, 4 дүгээр анги)*

| *Даалгавар* | *ЗД:1а* | *ЗД:1б* | *ЗД:2* | *ЗД:3* | *ЗД:4* |
|---|---|---|---|---|---|
| ЗД:1а | 1 | .394** | 0.026 | .136** | .278** |
| ЗД:1б | .394** | 1 | 0.078 | 0.046 | .193** |
| ЗД:2 | 0.026 | 0.078 | 1 | -.206** | 0.031 |
| ЗД:3 | .136** | 0.046 | -.206** | 1 | .079* |
| ЗД:4 | .278** | .193** | 0.031 | .079* | 1 |

Сорилын гүйцэтгэлийн даалгавар тус бүрийг SPSS программмын хамаарлын хүснэгтээс харвал:

Даалгавар 1а (эшгийг нэрлэх) нь 1б (эгшгийн уртыг тэмдэглэх)-тэй sig 0.394-ын, даалгавар 3 (аялгууны хурдыг тодорхойлох)-тай sig 0.136-ын, даалгавар 4 (хөгжимдөх)-тэй 0.278-ын, даалгавар 4 (хөгжимдөх) нь даалгавар 1а (эшгийг нэрлэх) -тай 0.278-ын, даалгавар 1б (эгшгийн уртыг тэмдэглэх)-тэй 0.193-ын, даалгавар 3 (аялгууны хурдыг тодорхойлох)-тай 0.079-ын хамааралтай байгаа бөгөөд даалгавар 2 нь даалгавар 3-тай -0.206-ын буюу сөрөг хамааралтай байна.

Даалгавар тус бүрийн үр дүнгийн p>0.05-аас бага байгаа нь статистик ач холбогдолтойг харуулж байна.

*Хүснэгт 33. Даалгаврын статистик ач холбогдол, найдварт байдал (Хөгжим, 4 дүгээр анги)*

| *Даалгавар* | *t* | *p<0.05* | *Дундаж үзүүлэлтийн ялгаа* | *Интервалийн ялгаа (95% Confidence Interval of the Difference)* | |
|---|---|---|---|---|---|
| | | *Sig. (2-tailed)* | | *Доод интервал* | *Дээд интервал* |
| ЗД:1а | 15.198 | 0 | 0.2695 | 0.235 | 0.304 |
| ЗД:1б | 10.638 | 0 | 0.1531 | 0.125 | 0.181 |
| ЗД:2 | 16.001 | 0 | 0.2903 | 0.255 | 0.326 |
| ЗД:3 | 45.617 | 0 | 0.7687 | 0.736 | 0.802 |
| ЗД:4 | 8.698 | 0 | 0.1037 | 0.08 | 0.127 |

Бага боловсролын хөгжмийн сорилын даалгаврын нийт гүйцэтгэлийн үр дүнг зураг, хүснэгтээр харуулав.

*Зураг 36. Сорилын нийт гүйцэтгэл (Хөгжим, 4 дүгээр анги)*




Хөгжмийн сорилын даалгаврын нийт гүйцэтгэлийг зургаас харахад зүүн тийш хазайсан байгаа нь тухайн агуулгыг заахгүй орхиод байна уу эсвэл бусад хүчин зүйлс нөлөөлөөд байна уу гэдгийг нарийвчлан шинжлэх хэрэгцээ гарч байна.

Бага боловсролын хөгжмийн сорилын гүйцэтгэлийн үр дүнгээс харахад:

- Хөгжим сонсох чадварын гүйцэтгэл бусад мэдлэг, чадварын даалгаварын гүйцэтгэлтэй харьцуулахад илүү байна. Хөгжмийн онолын нэр томьёо, тэмдэг тэмдэглэгээг нэрлэх, бичих, ноот бичлэг хараад хөгжимдөх чадвар сул байна.
- Энэ нь хөгжмийн сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, сурагчдын идэвх оролцоо, багшийн заах арга зүй, үйл ажиллагаатай холбоотой байх талтай байна.

## Дүрслэх урлаг, технологийн сорилын гүйцэтгэлийн шинжилгээ

Бага боловсролын 4 дүгээр ангийн дүрслэх урлаг, технологийн сорил нь танин мэдэхүйн ойлгох, хэрэглэх, бүтээх түвшний 3 даалгавартай, сорил нийт 5 оноотой. А хэсэгт мэдлэг, ойлголтыг илрүүлэх 1 даалгавар, Б хэсэгт мэдлэгээ хэрэглэх, бүтээх чадварыг илрүүлэх 2 даалгаврыг боловсруулсан байна.

*Хүснэгт 34. Сорилын даалгаврын жин (Дүрслэх урлаг, технологи, 4 дүгээр анги)*

| *Танин мэдэхүйн түвшин* | *Даалгаврын дугаар* | *Онооны хуваарилалт* | *Үнэлгээний жин* |
|---|---|---|---|
| Мэдлэг, ойлголт | А-1 | 1 | 20 хувь |
| Мэдлэгээ хэрэглэх | Б-2 | 2 | 40 хувь |
| Бүтээх | Б-3 | 2 | 40 хувь |
| Нийт | 3 даалгавар | 5 оноо | 100 хувь |

Бага боловсролын дүрслэх урлаг, технологийн сургалтын хөтөлбөрийн агуулга, 4 дүгээр ангийн сорилын даалгаврын холбогдох байдал

Бага боловсролын дүрслэх урлагийн сургалтын хөтөлбөр нь сурагчдад хүрээлэн буй орчноо харж ажиглах, ойлгох, өөрсдийн санааг дүрслэл хэрэглэн бүтээх, турших өөрийгөө илэрхийлэх чадвар эзэмшүүлэхэд чиглэгдэнэ. 4 дүгээр ангийн дүрслэх урлагийн сорилын даалгаврыг боловсруулахдаа судалгаанд хамрагдсан тухайн ангийн судлах агуулгаас гадна өмнөх ангийн агуулгын залгамж холбоог харгалзан авч үзсэн байна. Сургалтын хөтөлбөр болон сорилын даалгавраар илрүүлэх мэдлэг, чадварын холбогдох байдлыг авч үзэв.

*Хүснэгт 35. Агуулга, сорилын даалгаврын холбогдох байдал (Дүрслэх урлаг, технологи, 4 дүгээр анги)*

| Даалгаврын дугаар | Сургалтын хөтөлбөрийн холбогдох агуулга | |
|---|---|---|
| | Агуулгын бүлэг | Мэдлэг, чадвар |
| ЗД:1 | Урлагийн хэл | Зураасны төрлүүдийг таних, нэрлэх |
| ЗД:2 | Гоо сайхны илэрхийлэл | Дулаан өнгийг сонгох, хэрэглэх 2-оос дээш өнгөөр дагнаслан зурах |
| ЗД:3 | | Цаасыг янз бүрийн арга, технологиор хэлбэрт оруулан наах аргаар чимэглэх |

*Зураг 37. Сорилын нийт даалгаврын гүйцэтгэл (Дүрслэх урлаг, технологи, 4 дүгээр анги)*




Даалгавар тус бүрийн сурагчдын гүйцэтгэлээс танин мэдэхүйн ойлгох түвшний даалгаврын сурагчдын гүйцэтгэл бусад даалгаврын гүйцэтгэлээс илүү байна. Харин мэдлэгээ хэрэглэх болон бүтээх түвшний даалгаврын сурагчдын гүйцэтгэлд ялгаа харагдахгүй байна.

Сорилын найдвартай байдал, тохирц

4 дүгээр ангийн Дүрслэх урлаг, технологийн сорилд хамрагдсан сурагчдын даалгаврын гүйцэтгэлийн тархалтыг авч үзье.

*Зураг 38. Сорилын нийт гүйцэтгэл (Дүрслэх урлаг, технологи, 4 дүгээр анги)*




Дүрслэх урлаг, технологийн сорилд сурагчид 5 онооны 3 даалгаврыг гүйцэтгэсэн ба гүйцэтгэлийн арифметик дундаж 47.0 хувьтай байна.

Сорилын даалгаврууд хоорондын хамаарлыг авч үзвэл, 4 дүгээр ангийн дүрслэх урлаг, технологийн сорилын даалгавар 1 нь даалгавар 3-тай ач холбогдол бүхий хамааралтай, даалгавар 2-той ач холбогдол бүхий хүчтэй хамааралтай, даалгавар 2 нь даалгавар 3-тай ач холбогдол бүхий хүчтэй хамааралтай байгааг статистик үзүүлэлт харуулж байна. Энэ нь сорилын даалгаврууд өөр хоорондоо зохицсоныг илэрхийлж байна.

*Мэдлэг, ойлголтыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Даалгавар 1.

*Даалгаврын зорилго:* Зураасны төрлүүдийн таних, нэрлэх мэдлэг, ойлголтыг илрүүлнэ.

Сорилд хамрагдсан сурагчдын 62.5 хувь даалгаврыг зөв гүйцэтгэсэн, 37.4 хувь хариулж чадаагүй байна. Зураасны төрлүүдийг таних, нэршилтэй нь зөв холбох уг даалгаврын гүйцэтгэлийг задалж авч үзье.

*Хүснэгт 36. Сорилын 1 дүгээр даалгаврын гүйцэтгэл (Дүрслэх урлаг, технологи, 4 дүгээр анги)*

| | *Даалгаврын агуулга* | *Даалгавар* | *Зөв гүйцэтгэсэн сурагчдын хувь* | *Буруу гүйцэтгэсэн сурагчдын хувь* | *Огт хариулаагүй* |
|---|---|---|---|---|---|
| ЗД:1 | Зураасны төрлүүдийг таних, нэрлэх | Нуман зураас | 66.9 | 32.3 | 5 |
| | | Шулуун зураас | 96.2 | 3.0 | 5 |
| | | Цагариг зураас | 87.5 | 11.7 | 5 |
| | | Тахир зураас | 69.4 | 29.8 | 5 |
| | | Долгион зураас | 81.9 | 17.7 | 2 |

Сорилд хамрагдсан нийт сурагчийн 62.4 хувь тухайн даалгаврыг ямар ч алдаагүй гүйцэтгэсэн байна. Алдаатай гүйцэтгэсэн сурагчдын 90 гаруй хувь 4 зураасыг, 80 орчим хувь 3 зураасыг, 70 гаруй хувь 2 зураасыг зөв таньж, нэрлэж чадсан байна. Энэ нь сурагчдын зураасны төрлүүдийг ялган таних, нэршлийн талаар мэдлэг ойлголт боломжийн түвшинд байгааг харуулж байна.

*Мэдлэгээ хэрэглэх, бүтээх даалгавар*

4 дүгээр ангийн дүрслэх урлаг, технологийн сорил нь мэдлэгээ хэрэглэх, бүтээх түвшний 2 даалгавартай.

Даалгавар 2.

*Даалгаврын зорилго:* Дулаан өнгийг сонгон 2-оос дээш өнгөөр дагнааслан зурах арга барилыг илрүүлнэ.

*Хүснэгт 37. Сорилын 2 дугаар даалгаврын гүйцэтгэл (Дүрслэх урлаг, технологи, 4 дүгээр анги)*

| | *Даалгаврын агуулга* | *Оноо* | *Гүйцэтгэлийн хувь* | *Дундаж хувь* |
|---|---|---|---|---|
| ЗД:2 | Дулаан өнгийг сонгож 2 дээш өнгөөр дагнааслан зурах | 2 оноо авсан | 19 | 40.8 |
| | | 1 оноо авсан | 43.4 | |
| | | 0 оноо авсан | 37.4 | |

Тухайн даалгаврыг гүйцэтгэсэн сурагчдын 19 хувь цэцгийн дэлбээг дулаан өнгөөр дагнаас үүсгэн жигд будсан бол 43.4 хувь дулаан өнгийг зөв сонгосон боловч дагнаас үүсгэн будаагүй байна. Сурагчдын 37.4 хувь даалгаврын зааврыг ойлгож гүйцэтгээгүй эсвэл даалгаврын агуулгын талаарх ойлголтгүй байж болох юм. Сорил гүйцэтгэсэн нийт сурагчийн 80 гаруй хувь дагнаасын талаар ойлголтгүй, 2-оос дээш өнгийн дагнаас үүсгэн будах арга барилыг хийж туршиж үзээгүй байна.

Даалгавар 3.

*Даалгаврын зорилго:* Цаасыг янз бүрийн арга, технологиор хэлбэрт оруулан наах аргаар чимэглэх арга барилыг илрүүлнэ.

*Хүснэгт 38. Сорилын 3 дугаар даалгаврын гүйцэтгэл (Дүрслэх урлаг, технологи, 4 дүгээр анги)*

| Даалгаврын агуулга | | Оноо | Гүйцэтгэлийн хувь | Дундаж хувь |
|---|---|---|---|---|
| 3Д:3 | Цаасыг янз бүрийн арга, технологиор хэлбэрт оруулан наах аргаар чимэглэх | 2 оноо авсан | 9.5 | 45.6 |
| | | 1 оноо авсан | 72.1 | |
| | | 0 оноо авсан | 18.2 | |

Тухайн даалгаврыг гүйцэтгэсэн сурагчдын 9.5 хувь маш сайн буюу өгсөн зургийг энгийн цаасаар чимэглэхдээ цаасаа технологи арга хэрэглэн орон зайтай зохиомжилсон байна. Харин 18.2 хувь хангалтгүй гүйцэтгэсэн бол 72.1 хувь нь дундаж буюу өгсөн зургийг энгийн цаасаар хавтгай зохиомж үүсгэн чимэглэсэн байна. Сурагчдын гүйцэтгэлийн үр дүнгээс тухайн хичээлийн агуулгаар сурагчид санаагаа дүрслэл ашиглан бүтээх, сэтгэлгээ шаардсан дасгал даалгавар бага гүйцэтгэдэг байх талтай ба сурагчид ихэвчлэн зааврын дагуу, даган дуурайх үйлийг гүйцэтгэдэг байх магадлалтай. Бага боловсролын дүрслэх урлаг, технологийн сургалтын хөтөлбөрийн агуулгад эдгээр нь “Бодит байдлаас хүртэж зурах дүрслэх бүтээх”, “Өөрийн сэтгэгдэл, уран санаагаа дүрслэн урлах бүтээх үйлээр илэрхийлэх” гэж туссан байдаг.

Бага боловсролын дүрслэх урлаг, технологийн сорилын гүйцэтгэлийн үр дүнгээс харахад:

- Сорилын ерөнхий гүйцэтгэл 50 орчим хувьтай байна. Сурагчдын даалгавар тус бүрийн гүйцэтгэлээс мэдлэгээ хэрэглэх, бүтээх түвшний даалгаврын гүйцэтгэл мэдлэг, ойлголт илрүүлэх даалгаврын гүйцэтгэлээс доогуур байна.
- Тухайн үр дүнг сургалтын арга зүйтэй холбон авч үзвэл, хичээл, сургалтын арга зүйд төдийлөн өөрчлөлт гарахгүй байгааг харуулж байна. Учир нь:
  - Сурагчдын мэдлэгээ хэрэглэх, бүтээх түвшний даалгаврыг гүйцэтгэл сул байна.
  - Бүтээх түвшний даалгаврын гүйцэтгэлээс сурагчдын бүтээлч сэтгэлгээ, эрэлхийллийн чадвар сул байна гэж хэлж болохоор байна.

## Биеийн тамирын сорилын гүйцэтгэлийн шинжилгээ

Бага боловсролын биеийн тамирын сорил нь ахуйн хэрэгцээт дасгал, жагсаал зохион байгуулалт, үсрэлт, харайлтын дасгалын гүйцэтгэлийг илрүүлэх зорилготой.

Бага боловсролын 4 дүгээр ангийн биеийн тамирын сорилын даалгавар нь мэдлэг ойлголт, мэдлэгээ хэрэглэх, гүйтгэлийн чанар буюу чадварыг илрүүлэх 3 даалгавартай.

Сорилын даалгаврыг боловсруулахдаа биеийн тамирын сургалтын цөм хөтөлбөрийн үнэлгээний зорилт болон шалгуурт тулгуурлан мэдлэг, ойлголтыг илрүүлэх даалгавар, мэдлэгээ хэрэглэх чадварыг илрүүлэх даалгаврын нийт оноонд эзлэх хувь 25:25:50 байхаар боловсруулсан.

*Хүснэгт 39. Сорилын даалгаврын жин, гүйцэтгэл (Биеийн тамир, 4 дүгээр анги)*

| Агуулга | Даалгаврын эзлэх хувь | Онооны эзлэх хувь | Гүйцэтгэлийн дундаж хувь |
|---|---|---|---|

| | | | |
|---|---|---|---|
| Мэдлэг | 33.3 | 25.0 | 67.8 |
| Ойлголт | 33.3 | 25.0 | 8.5 |
| Мэдлэгээ хэрэглэх чадвар | 33.4 | 50.0 | 45.5 |

Мэдлэг, ойлголтыг илрүүлэх даалгаврыг биеийн тамирын хичээлийн 1 дүгээр улиралд үзсэн агуулгад тулгуурлан, харин биеэр хийж гүйцэтгэх чадварыг илрүүлэх даалгаврыг өмнөх ангид судалсан агуулгатай залгамж холбоотой агуулгад тулгуурлан боловсруулсан.

*Мэдлэг, ойлголтыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрт биеийн тамирын хичээлийн агуулгыг 4 бүлгээр боловсруулсны 1 дүгээр бүлэг буюу ахуйн хэрэгцээт дасгалын бүлэг сэдвээс оруулсан.

Даалгавар 1.

*Даалгаврын зорилго*: Жагсаал зохион байгуулалтыг хэрхэн мэдэж байгааг илрүүлэх.

Сурагчдын 67.8 хувь Б буюу зөв хариултыг сонгосон байна. Сурагчдын 28.4 хувь В буюу буруу хариултыг жагсаалын нэг төрөл учраас сонгосон байх талтай. Харин А буруу хариултыг 2.9 хувь сонгосон нь жагсаал зохион байгуулалтын мэдлэг дутмаг байгааг харуулж байна. Энэхүү даалгаврын хүнд, хөнгөний зэрэг (67.8) тохиромжтой, ялгах чадвар маш сайн байна.

Даалгавар 2.

*Даалгаврын зорилго*: Ахуйн хэрэгцээт дасгалыг хэрхэн мэдэж байгааг илрүүлэх.

Сурагчдын 8.5 хувь зөв хариулсан бол 91.5 хувь буруу хариулсан байна. Энэ даалгаврын агуулга нь биеийн тамирын сургалтын цөм хөтөлбөрийн "ахуйн хэрэгцээт дасгал" гэсэн бүлэг сэдэвт тусгагдсан байдаг. Шинжилгээнээс сурагчдын тухайн бүлэг сэдвийн хүрээнд эзэмшсэн мэдлэг, ойлголт дутмаг байгаа нь харагдаж байна.

*Мэдлэгээ хэрэглэх даалгаврын шинжилгээ*

Даалгавар 3.

*Даалгаврын зорилго*: Байрнаас уртад харайх чадварыг илрүүлэх.

Судалгаанд хамрагдсан 4 дүгээр ангийн нэг бүлгийн сурагчдаас санамсаргүй түүврийн аргаар 10 сурагч сонгож дээрх даалгаврыг гүйцэтгүүлсэн. Энэхүү даалгаврын шалгуурыг монголын хүүхэд, залуучуудын хөгжлийн шалгуур, үзүүлэлт зөвлөмжид тусгасан 9 настай хүүхдүүдийн дундаж түвшинг дээд түвшин болгон авсан.

*Хүснэгт 40. Сорилын 3 дугаар даалгаврын гүйцэтгэл (Биеийн тамир, 4 дүгээр анги)*

| *Шалгуур* | *Хүйс* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|
| 109 см-ээс доош | эр | 9.0 |
| 99 см-ээс доош | эм | |
| 110 см -134 см | эр | 48.1 |
| 100 см -119 см | эм | |
| 135 см-ээс дээш | эр | 42.9 |
| 120 см-ээс дээш | эм | |

Дээрх үр дүнгээс харахад 4 дүгээр ангийн биеийн тамирын сургалтын цөм хөтөлбөрөөр эзэмших сурагчдын бие бялдрын хөгжил бүлэг сэдвээр эзэмшсэн чадвар дутмаг байгаа нь харагдаж байна.

Бага боловсролын биеийн тамирын сорилын даалгаврын нийт гүйцэтгэлийн үр дүнг зургаар харуулав.

*Зураг 39. Сорилын нийт гүйцэтгэл (Биеийн тамир, 4 дүгээр анги)*




Биеийн тамирын сорилын нийт гүйцэтгэлийн арифметик дундаж 30.1 хувь, медиан 25.0 хувь, моод 25.0 хувь, хамгийн өндөр гүйцэтгэл 100 хувь, хамгийн бага гүйцэтгэл 0.0 хувь байна. Гүйцэтгэл ийм байгаа нь тухайн бүлэг сэдвээр эзэмших мэдлэг чадвар, хандлагыг эзэмшүүлэхгүй байгаатай холбоотой байх талтай.

Бага боловсролын биеийн тамирын сорилын гүйцэтгэлийн үр дүнгээс харахад мэдлэг, ойлголтыг авч үзсэн даалгаврын гүйцэтгэлийн дундаж 38.2 хувь, мэдлэгээ хэрэглэх чадварын гүйцэтгэлийн дундаж 45.5 хувьтай байна.

## Бага боловсролын сорилын дүгнэлт

Бага боловсролын сорилд хамрагдсан 4 дүгээр ангийн сурагчдын нийт гүйцэтгэлийн дундаж (арифметик дундаж, моод, медиан) нь тэнцүү (51 хувь), хамгийн өндөр гүйцэтгэл 84.5 хувь, хамгийн бага гүйцэтгэл 10.3 хувь, стандарт хазайлт 15.3 хувь байна.

*Хүснэгт 41. Бүх хичээлийн сорилын даалгаврын гүйцэтгэл (4 дүгээр анги)*

| *Д/д* | *Хичээл/ Судлагдахууны нэр* | *Mean* | *Median* | *Mode* | *Minimum* | *Maximum* | *Std. Deviation* |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Математик | 52 | 50 | 56.3 | 0 | 100 | 21.8 |
| 2 | Монгол хэл | 58.7 | 61.5 | 69.2 | 0 | 100 | 24.4 |
| 3 | Хүн ба байгаль | 49.9 | 50 | 50 | 12.5 | 100 | 19.4 |
| 4 | Хүн ба нийгэм | 66.9 | 71.4 | 71.4 | 0 | 100 | 18.5 |
| 5 | Хөгжим | 32.2 | 20 | 20 | 0 | 100 | 20.8 |
| 6 | Дүрслэх урлаг | 47.1 | 40 | 40 | 0 | 100 | 22.5 |
| 7 | Биеийн тамир | 30.1 | 25 | 25 | 0 | 100 | 21.4 |
| 8 | Нийт гүйцэтгэл | 51.4 | 51.7 | 51.7 | 10.3 | 84.5 | 15.3 |

Сорилын судалгаанд хамрагдсан сурагчдын гүйцэтгэлээс дараах дүгнэлтийг хийх боломжтой байна.

- Хөгжим, биеийн тамирын сорилын гүйцэтгэлийн дунджууд (арифметик дундаж, моод, медиан) 20 хувиас 32.2 хувийн хооронд байгаа нь эдгээр хичээлийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд анхаарч, илүү нарийвчлан судлах шаардлагатайг харуулж байна.
- Хүн ба байгаль, дүрслэх урлаг, технологийн хувьд дунджууд (арифметик дундаж, моод, медиан) 40 хувиас 50 хүртэлх хувийн хооронд байна. Үүн дотор хүн ба байгаль хичээлийн дунджууд ойролцоо (50 хувь) байна.
- Математик, монгол хэл, хүн ба нийгэм хичээлүүдийн хувьд дунджууд (арифметик дундаж, моод, медиан) 50 хувиас 71.4 хувийн хооронд байна.

- Нийтэд нь дүгнэж үзэхэд хөгжим, биеийн тамирын хичээлүүдийн сорилын гүйцэтгэл бусад хичээлийн сорилын гүйцэтгэлээс доогуур хувьтай, бусад хичээлийн гүйцэтгэл дундаж түвшинд байна. Харин нийт хичээлийн хувьд сурагчдын хамгийн өндөр гүйцэтгэл 100 хувьтай, хамгийн бага гүйцэтгэл нь хүн ба байгалийн хичээлээс бусад нь 0 хувьтай байгаа нь сурагчдын мэдлэг, чадварын түвшин харилцан адилгүй, ихээхэн зөрүүтэй байгааг харуулж байна.
- Хичээл тус бүрийн сорилын гүйцэтгэлийн стандарт хазайлт 18 хувиас 22 хувийн хооронд байгаа нь сурагчдын даалгаврын гүйцэтгэл харилцан адилгүй, дунджаас нэлээд зөрүүтэйг харуулж байна.
- Сорилын бүх хичээлийн даалгаврын найдвартай байдал нь сайн, 5 хичээлийн даалгаврууд эерэг хүчтэй, 2 хичээлийн даалгаврууд эерэг хамааралтай байгаа нь даалгаврууд хоорондын зохицол сайн байгааг харуулж байна.

## Бага боловсролын түвшинд суралцагчдын мэдлэг, чадвар, хандлага ба нөлөөлж буй хүчин зүйл

Бага ангийн сурагчдын мэдлэг, ойлголтыг үнэлэх даалгаврын гүйцэтгэлд хийсэн шинжилгээ

Бага ангийн сурагчдын мэдлэг, ойлголтыг хэмжихэд чиглэсэн нийт даалгаврын гүйцэтгэлийн дундаж оноо сонгох даалгаврын хувьд 0.71[6] байхад асуултад хариулах, бүтээх даалгаврын хувьд 0.46 байна. Үүнээс харахад сонгох даалгаврыг сурагчид илүү гүйцэтгэсэн бол асуултад хариулж бичих, бүтээх даалгаврын гүйцэтгэл сул байна. Хүүхдүүдийн гүйцэтгэл жигд бус байгаа нь стандарт хазайлтын үзүүлэлтээс харагдав.

Сонгох даалгаврыг сурагчдын 60 гаруй хувь нь зөв, 30 хувь нь буруу гүйцэтгэжээ.

Бага боловсролын цөм хөтөлбөрт сэтгэн бодох, таамаглал дэвшүүлэх, мэдээлэлтэй ажиллах чадвар судлагдахуунаар эзэмших ерөнхий чадваруудын нэг болохыг тодорхойлсон. Энэхүү чадварыг судалгаанд хамрагдсан сурагчид тодорхой хэмжээнд эзэмшиж байгаа ч анхаарах зүйл байгаа нь шинжилгээнээс харагдав.

Сэтгэн бодох чадварыг хүүхэд бага боловсролоос эхлэн үе шаттай эзэмшихэд сургалтын агуулга, арга зүйг улам сайжруулахад анхаарах зайлшгүй чухал байна.

*Зураг 40. Бага ангийн сурагчдын мэдлэг, ойлголтыг үнэлэх сонгох даалгавруудын гүйцэтгэл (хувиар)*




Асуултад хариулах даалгаврыг судалгаанд хамрагдсан сурагчдын ойролцоогоор 50 хувь нь зөв гүйцэтгэжээ.

Сурагчдын асуултад бие даан хариулах чадвар нь мэдлэг, ойлголтын эзэмшилтийн түвшинг харуулах нэг шалгуур билээ. Цаашид бага ангийн сурагчдын мэдлэг, ойлголтыг батжуулахад дэмжлэг үзүүлэхүйц сургалтын арга зүй хэрэглэх хэрэгцээ шаардлага харагдлаа.

Бүтээх даалгаврыг сурагчдын 10 гаруй хувь нь зөв гүйцэтгэжээ. Энэ нь суралцагчдын мэдлэг өнгөц, сул байгааг харуулж байна.

*Зураг 41. Бага ангийн сурагчдын бүтээх даалгаврын гүйцэтгэл (хувиар)*




Бага ангийн сурагчдын мэдлэг, ойлголтыг үнэлэх даалгавруудын гүйцэтгэл нь хүйс, сургуулийн байршил, өмчийн хэлбэр зэргээс хамааралгүй байна.

[6] Зөв гүйцэтгэсэн даалгавар 1 оноотой, буруу гүйцэтгэл нь 0 оноотой

Харин хөгжмийн даалгавар болох дэвсгэр шугаманд байгаа хөгжмийн эгшгүүдийг нэрлэн бичих даалгавын гүйцэтгэл нь сургуулийн өмчийн хэлбэрээс хамааран статистик ач холбогдолтой ялгаатай байна. (r=.296**; p<0.01)

*Хүснэгт 42. Сургуулийн өмчийн хэлбэрээс хамааран хөгжмийн мэдлэг, ойлголтыг үнэлэх даалгаврын гүйцэтгэл (бага анги)*

| *Сургуулийн өмчийн хэлбэр* | *Хөгжмийн эгшгүүдийг зөв нэрлэж бичсэн* | *Хөгжмийн эгшгүүдийг буруу нэрлэж бичсэн* |
|---|---|---|
| Төрийн өмчийн сургууль | 23% | 77% |
| Хувийн өмчийн сургууль | 65% | 35% |

Харьцуулсан үр дүнгээс харахад, хувийн өмчийн сургуулийн сурагчдын гүйцэтгэл төрийн өмчийн сургуулийнхаас илүү байна.

Бага ангийн сурагчдын мэдлэг, ойлголтыг судлагдахуунаар харьцуулбал, хүн- байгаль, хүн- нийгэм хичээлийн мэдлэг, ойлголт бусад хичээлтэй харьцуулахад илүү үзүүлэлттэй байна.

*Зураг 42. Бага ангийн сурагчдын мэдлэг, ойлголтын даалгаврын гүйцэтгэл (судлагдахуунаар)*




| | монгол хэл | хүн байгаль | хүн нийгэм | хөгжим | дүрслэх урлаг | биеийн тамир | математик |
|---|---|---|---|---|---|---|---|
| нийслэл | 65 | 87 | 75 | 34 | 64 | 41 | 56 |
| аймаг, сум | 64 | 84 | 75 | 25 | 62 | 37 | 55 |

Бага боловсролын цөм хөтөлбөрт туссан харилцаа, байгаль нийгэмтэй зөв харилцах чадварыг эзэмшихэд хүн байгаль - хүн - нийгмийн судлагдахуун бодит үр дүнтэй байна гэж дүгнэв.

Бага ангийн сурагчдын хөгжим, биеийн тамирын хичээл нь цөм хөтөлбөрт тусгаснаар эрүүл ахуй, харилцааны ерөнхий дадал чадвартай болох, цаашилбал, сэтгэлийн хөдөлгөөн, гоо сайхны мэдрэмж, бие бялдрын хөгжилд чухал байр суурь эзэлдэг. Гэтэл судалгаанд хамрагдсан хүүхдүүдын энэхүү мэдлэг, ойлголтыг дэмжих шаардлагатай байгаа нь харагдав.

Дээр шинжилгээнээс харахад дараах дүр зураг харагдаж байна. Бага ангийн сурагчдын сорилын гүйцэтгэлээс харахад, танин мэдэхүйн чадамжийн бүрэлдэхүүн хэсэг болох юмс үзэгдлийн талаарх мэдлэг, ойлголт нь 50-аас дээш хувьтай байна. Гэхдээ даалгаврын хэлбэрээс хамааран гүйцэтгэл харилцан адилгүй байгаа юм. Үүнд:

- Өгөгдсөн хариултаас зөв хариултыг сонгох даалгаврыг нийт сурагчийн 60 гаруй хувь чадсан.

- Асуултад товч хариулж бичих даалгаврыг ойролцоогоор 50 хувь чадсан.
- Бүтээх даалгаврын мэдлэг, ойлголтыг авч үзсэн даалгаврыг 10 гаруй хувь гүйцэтгэсэн, 40 гаруй хувийн гүйцэтгэл дундаж түвшинд байна.

Сурагчид юмс үзэгдлийн талаарх мэдлэг, ойлголтыг цээжлэн тогтоох, бэлэн мэдээлэл авах хэлбэрээр эзэмшдэг дүр зураг харагдав.

Төрийн өмчийн сургуулийн хүүхдүүдийн хөгжмийн судлагдахууны мэдлэг, ойлголт хангалтгүй тул сургалтын үйл ажиллагааг сайжруулах хэрэгцээтэй байна.

Нийт сурагчдын хувьд биеийн тамирын судлагдахууны мэдлэг, ойлголтыг хангалтгүй гэж дүгнэж болохоор байна.

## Бага ангийн сурагчдын мэдлэгээ хэрэглэх чадварыг үнэлэх даалгаврын гүйцэтгэлд хийсэн шинжилгээ

Бага ангийн сурагчдын мэдлэгээ хэрэглэх чадварыг үнэлэх нийт даалгаврын гүйцэтгэлийн дундаж оноо нь 0.45[7] байна. Эдгээрийг даалгаврын төрлөөр авч үзвэл, сонгох даалгаврын дундаж оноо 0.43, асуултад хариулах, бүтээх даалгаврын дундаж оноо 0.46 байна.

Мэдлэгээ хэрэглэх чадварын сонгох даалгаврыг сурагчдын 30 гаруй хувь нь л гүйцэтгэж чаджээ.

*Зураг 43. Бага ангийн сурагчдын мэдлэгээ хэрэглэх чадварын сонгох даалгаврын сурагчдын гүйцэтгэл (хувиар)*




Мэдлэгээ хэрэглэхтэй холбоотой асуултад хариулах даалгаврыг сурагчдын 50 хувь нь, бүтээлч даалгаврыг сурагчдын 20 гаруй хувь нь гүйцэтгэж чаджээ. Энэхүү судалгаанаас бага ангийн сурагчдын мэдлэгээ хэрэглэх чадвар сул байгаа нь харагдав.

[7] Зөв гүйцэтгэл 1 оноо

*Зураг 44. Бага ангийн сурагчдын мэдлэгээ хэрэглэх чадварыг үнэлэх асуултад хариулах даалгаврын сурагчдын гүйцэтгэл (хувиар)*




*Зураг 45. Бага ангийн сурагчдын бүтээх даалгаврын гүйцэтгэл (хувиар)*




Ялангуяа, сэтгэн бодож, бүтээлчээр ажиллах, найруулан бичих, бие даан дүгнэлт гаргах чадвар сул байна. Энэ нь мөн сурагчдын чадвараас хамаарахаас гадна тэдний бүтээлчээр ажиллах хувийн хандлага, анхаарлын тогтворжилт, бие даасан байдал гэх мэт сурах арга барилтай ч холбоотой. Мөн бүтээлч, бие даан суралцах, амьдрах чадвартай иргэн хүнийг төлөвшүүлэх боловсролын зорилгын хэрэгжилтийг дэмжих гол чадвар юм. Цаашид сурагчдын мэдлэгээ бүтээлчээр хэрэглэх чадварыг дэмжихтэй зэрэгцэн анхаарлын чадварыг хөгжүүлэхэд анхаарах нь чухал байна.

Бага ангийн сурагчдын биеийн тамирын хичээлээр хөгжүүлэх чадварыг уртад харайх чадвараар хэмжсэн бөгөөд гүйцэтгэл сул байлаа.

Сурагчдын мэдлэгээ хэрэглэх чадвар нь хүйс, сургуулийн байршил зэргээс хамааралгүй байна.

Харин сургуулийн өмчийн хэлбэрээс шалтгаалан сурагчдын сорилын гүйцэтгэл ялгаатай байлаа. математик ($r=.265^{**}$; $p<0.01$), хүн ба байгаль ($r=.211^{**}$; $p<0.01$), монгол хэл ($r=.300^{**}$; $p<0.01$); хөгжмийн хичээлүүд ( $r=.268^{**}$; $p<0.01$)

*Хүснэгт 43. Бага ангийн сурагчдын мэдлэг хэрэглэх чадварын даалгаврын гүйцэтгэл (сургуулийн өмчийн хэлбэрээр)*

| *Даалгавар* | *Бал худалдан авахдаа үнийг нь тооцон зөв шийдвэр гаргах чадвар (математик)* | | *Мэдээлэлтэй ажиллан дүгнэлт гаргах чадвар (монгол хэл)* | | *Аялгуу сонсоод, хэмнэлийг нь мэдрэх чадвар (хөгжим)* | | *Юмсын зайг баримжаалж, сүүдрийн хэмжээ тодорхойлох (хүн-байгаль)* | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | *Гүйцэтгэлийн хувь* | | | | | | | |
| гүйцэтгэл | Зөв | Буруу | Зөв | Буруу | Зөв | Буруу | Зөв | Буруу |
| Төрийн өмчийн сургууль | 13 | 87 | 31 | 69 | 13 | 87 | 18 | 88 |
| Хувийн өмчийн сургууль | 44 | 56 | 77 | 23 | 44 | 56 | 45 | 55 |

Хүснэгтээс харахад, хувийн сургуулийн сурагчдын чадвар харьцангуй сайн байна. Энд сургалтын материаллаг орчин, хэрэглэгдэхүүн, анги дүүргэлт, багшлах арга зүй гэх мэт олон хүчин нөлөөлснийг үгүйсгэх аргагүй боловч төрийн өмчит сургуулийн бага ангийн сурагчдын тооцоолол хийж шийдвэр гаргах, мэдээлэлтэй ажиллан дүгнэлт хийх логик

чадвар, хөгжмийн хэмнэлийг мэдрэх мэдрэмж, түүнийгээ илэрхийлэх нь маш сул байгаа нь сургалтын чанарыг дээшлүүлэх хэрэгцээ шаардлагыг бий болгож байна.

Мэдлэг хэрэглэх чадварыг судлагдахуунуудаар харьцуулахад 60 хүрэхгүй гүйцэтгэлийн дундаж оноотой байна. Хөдөө орон нутгийн сургуулийн сурагчдын хүн –нийгэм хичээлийн гүйцэтгэлийн дундаж оноо 64-тэй байна.

Хөгжмийн хичээлээр эзэмших ур чадвар судалгаанд хамрагдсан нийт бага ангийн сурагчдын хувьд маш сул түвшинд байгаагийн учир шалтгаанд дүгнэлт хийж, сайжруулахад анхаарах нь зүйтэй байна.

*Зураг 46. Бага ангийн сурагчдын мэдлэг хэрэглэх чадварын даалгаврын гүйцэтгэл (судлагдахуунаар)*



| | монгол хэл | хүн байгаль | хүн нийгэм | хөгжим | дүрслэх урлаг | биеийн тамир | математик |
|---|---|---|---|---|---|---|---|
| нийслэл | 58 | 57 | 41 | 52 | 36 | 47 | 38 |
| аймаг, сум | 52 | 46 | 37 | 64 | 32 | 41 | 47 |

Бага ангийн нийт судлагдахууны хэрэгжилт нь сурагчдад мэдлэгийг хэрэглэх, бүтээлчээр ажиллах чадварыг нь хөгжихөд дэмжлэг үзүүлэх нь сул түвшинд байна.

Сурагчдын мэдлэгийг хэрэглэх чадвар нь мэдлэг ойлголтоосоо сул харагдлаа.

Энэхүү шинжилгээнээс дараах дүр зураг харагдаж *байна.* Бага боловсролын цөм хөтөлбөрийн гол зорилго нь сурагчдад танин мэдэхүй, хэл, нийгэм, амьдрах ухааны чадамж, чадвар, сурах арга барилыг эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх юм. Үүнийг хэмжих гол шалгуур нь юмс үзэгдлийн талаарх бодитой мэдлэгээс гадна түүнийг амьдрал үйл ажиллагаандаа хэрэглэх, өөр нөхцөлд хувирган өөрчлөх дадал чадвар. Энэ тохиолдолд сургалт хувь хүнд үр өгөөжтэй болдог билээ. Мэдлэгээ хэрэглэх чадвар хөгжүүлэхэд анхаарах хэрэгтэй байна. Үүнд:

1. Сэтгэн бодох, бүтээлч сэтгэлгээгээр бие даан мэдээлэлтэй ажиллах чадварыг нь дэмжих, ялангуяа сурагч мэдлэгийг бүтээх чадвар , дадалтай болоход нь дэмжих,
2. Сурагчид сурах үйлдээ сонирхолтой, идэвхтэй, анхааралтай хандах хандлагыг эзэмшихэд нь туслах,
3. Мэдлэгийг гүн бат эзэмшихэд сургалтын идэвхтэй аргыг хэрэглэх нь чухал байна.
4. Сурагчид мэдлэгийг хэрэглэх чадварыг эзэмшихэд сургалтын материаллаг орчин, сургалтын хэрэглэгдэхүүн чухал байдаг. Ялангуяа төрийн өмчит ерөнхий боловсролын сургуульд материаллаг орчин нөхцлийн дутагдалтай байдал нь мэдлэгийг хэрэглэх чадварыг бууруулж байна.
5. Бага ангийн сурагчдын хөгжим, биеийн тамирын хичээлээр эзэмших чадвар, дадлыг нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгцээ шаардлага бий болсон байна.

6. Сурагчдад сурах арга барилыг эзэмшүүлэхэд сургалтын идэвхтэй арга хэрэглэх, мэдлэг бүтээх үйлийг сурагчдаар гүйцэтгүүлэх багшийн ур чадварыг дэмжих олон талын үйл ажиллагаа явуулах хэрэгцээ шаардлага байна.

## Суралцах хэв шинж ба сурагчдын гүйцэтгэл

Судалгаагаар 4 дүгээр ангийн сурагчдын суралцах хэв шинжийг танин мэдэхүйн чадвараар анхаарлын тогтворжилт, шилжилт, ажиллах чадвар, богино хугацааны хараа, сонорын ой, утгын ой тогтоолт, сэтгэхүй, сэтгэхүйн харьцуулах үйлдэлтэй уялдуулан авч үзсэн юм. Танин мэдэхүйн чадваруудыг нэгдүгээрт; анхаарал, ой тогтоолт, сэтгэхүйн үйлийг гүйцэтгэх чадвараа сурагчид өөрсдийгөө хэр үнэлж байгаа, хоёрдугаарт; сурагчдын эзэмшсэн мэдлэг ойлголт, чадварыг хичээлүүдийн даалгаврын гүйцэтгэлтэй уялдуулан шинжлэв.

Сурагчдын сурах арга барилыг танин мэдэхүйн үйлүүдээр авч үзэхдээ тухайн үйл хичээлүүдээр хэр хөгжиж байгаад анхаарал хандуулсан. Судалгаагаар дараах дүр зураг харагдаж байна.

### *Анхаарал*

Сурагчид анхаарлыг хөгжүүлэхтэй холбоотой ямар үйлийг хийх нь тэдэнд таатай байдаг талаар мэдээлэлд тулгуурлан шинжилгээ хийж, харин багшийн хувьд сурагчдын анхаарлын хөгжилтэй холбоотой ямар үйлүүдийг сурагчид сайн гүйцэтгэж чаддаг талаар мэдээлэлд үндэслэн болно.

*Хүснэгт 44. Анхаарлын чадваруудын хариулт багш, сурагчдынхаар (бага анги)*

| *Танин мэдэхүй* | *Багшийн үнэлгээ* | *Сурагчдын өөрийн үнэлгээ* |
|---|---|---|
| Анхаарлын хуваарилалт | 57.5 | 71.9 |
| Анхаарлын тогтворжилт | 60.0 | 93.4 |
| Анхаарлын шилжилт | 47.6 | 81.2 |
| Анхаарлын төвлөрөлт | 47.5 | 85.3 |

Бага ангийн сурагчдын 71.2 хувь нь хичээл дээр зурах, бичих, бодох үйлүүдийг нэгэн зэрэг хийх дуртай юм байна. Харин 1, 2-р ангийн багш нарын 57.5 хувь нь, 3-5-р ангийн багш нарын 38.0 хувь нь хүүхдүүдийг анхаарлаа хуваарилах чадвартай гэжээ.

*Хүснэгт 45. Бага ангийн сурагчдын анхаарлаа төвлөрүүлэх чадварыг хугацаагаар илэрхийлсэн нь (багшийн хариултаар)*

| *Хүүхдүүд хичээл дээр анхаарлаа төвлөрүүлэх хугацаа (ойролцоогоор)* | *1-2 дугаар анги* | *3-5 дугаар анги* |
|---|---|---|
| 3-5 мин | 42.5 | 16.7 |
| 5-10 мин | 40.0 | 47.6 |
| 10-15 мин | 12.5 | 31.0 |
| 15-20 мин | 5.0 | 4.8 |

Судалгаанд хамрагдсан сурагчид өөрсдийгөө хичээл эхлэхээс дуусах хүртэл хугацаанд анхааралтай байж чаддаг гэж үзжээ. (93.4 хувь) Харин багш нарын олонх нь сурагчид анхаарлаа 5-10 мин төвлөрүүлэх чадвартай гэжээ.

*Хүснэгт 46. Бага ангийн сурагчдын анхаарлын шилжилт ба багш нарын дэмжлэг*

| *Хүүхдүүд хичээл дээр дасгал даалгаврыг хурдан, зөв гүйцэтгэхэд:* | *анги* | |
|---|---|---|
| | *1-2 дугаар анги* | *3-5 дугаар анги* |

| | | |
|---|---|---|
| багшийн дэмжлэг шаардлага хэрэгтэй | 47.5% | 47.6% |
| багшийн дэмжлэг шаардлага чухал биш | 52.5% | 52.4% |

Анхаарлын тогтворжилт буюу хичээл дээр дасгал даалгаварыг хурдан зөв хийж чадна гэж нийт сурагчдын 81.4 хувь нь хариулсан бол багш нар энэ үед багш нарын 47.5 хувь нь дэмжлэг шаардлага хэрэгтэй гэж үзжээ.

### *Ой тогтоолт*

Танин мэдэхүйн зориудын үйлдлийн хөгжлийн түвшинг илэрхийлдэг гол үзүүлэлт болох богино хугацааны хараа, сонорын ой тогтоолт, утгын ой тогтоолтыг сурагчдын өөрийн үнэлгээнд тулгуурлан авч үзэв.

*Хүснэгт 47. Бага ангийн сурагчдын сонор, хараа, утгын ой тогтоолтын үзүүлэлт (багш, сурагчийн хариулт)*

| *Ой тогтоолын чадвар* | *Багшийн үнэлгээ* | *Сурагчдын өөрийн үнэлгээ* |
|---|---|---|
| Сонорын ой тогтоолт | 87.5 | 89.7 |
| Харааны ой тогтоолт | 64.7 | 74.7 |
| Утгын ой тогтоолт | 65.0 | 74.4 |

Багш нарын олонх нь сурагчид хичээлийн үед мэдээллийг сонсоод тогтоох чадвар сайн гэж үзсэн бол сурагчид ч мөн өөрсдийгөө сонсожтогтоох дуртай гэж үнэлсэн байна. Хараа, утгын ой тогтоолтын хувьд сурагчдын өөрсдийн үнэлгээ нь бага зэрэг илүү байна.

Ой тогтоолтын бататгах үйлийг бичих буюу унших даалгавартай хослуулан гүйцэтгүүлэх нь утгын ой тогтоолтыг хөгжүүлэх боломж бүрдэх юм.

*Зураг 47. Бага ангийн сурагчдын ой тогтоолтын онцлог (байршлаар)*




Улаанбаатар хотын сурагчид мэдээллийг харж тогтоох нь хөдөөний сурагчдаас илүү харин сонсож тогтоох нь сул гэж өөрсдийгөө дүгнэжээ. Хөдөөний сурагчид сонссон мэдээллээ сайн тогтоодог гэжээ.

Сурагчдад хөгжим бичлэг сонсгохоос (55.9 хувь) илүү үзүүлэн таниулах материал ашиглан заах нь сурагчдын тогтоох чадварыг нэмэгдүүлдэг болохыг сурагчдын 86.1 хувь нь ***би илүү сайн тогтоодог*** гэсэн хариулснаас үзэж болохоор байна.

### *Сэтгэхүй*

Хүүхэд сургуульд суралцаж эхэлснээр хийсвэр сэтгэхүйн хөгжил эрчимждэг боловч тэдний танин мэдэхүй хөгжилд бодит үйлдлийн сэтгэхүй давамгайлсаар байдаг учир сурагчдыг хөгжүүлэх сургах бүхий л үйлд хийсвэр сэтгэхүйг хөгжүүлэхэд сургалтын үйл ажиллагааг чиглүүлэх шаардлагатай болдог.

Бодит үйлийн сэтгэхүй дээр тулгуурлан хийсвэр сэтгэхүй хөгждөг онцлогтой тул бид сурах арга барилыг авч үзэхдээ бодит үйлдлийн сэтгэхүйн талаар мэдээлэл авсан болно. 3 ба 4 дүгээр ангиас эхлэн сурагчдын даалгавар болон хичээлийн гүйцэтгэлийн чадвар сайжирдаг гэж нас зүйн сэтгэл судлаачид үздэг.

*Хүснэгт 48. Бага ангийн сурагчдын сэтгэхүйн үйлдлийн үнэлгээ (багш, сурагчийн хариулт)*

| *Сэтгэхүйн үйлдлүүд* | *Багш* | *Сурагчид* |
|---|---|---|
| бодит үйлдлийн сэтгэхүй | 83.5 | 75.3 |
| бодит дүрслэлийн сэтгэхүй | 98.2 | 84.6 |
| хийсвэр сэтгэхүй | 55.5 | 85.6 |

Сурагчдын 75.3 хувь нь бодит үйлдэл, 84.6 хувь нь дүрслэлийн сэтгэхүйн, 85.6 хувь нь хийсвэр сэтгэхүйн үйлдэл гүйцэтгэх дуртай гэж хариулсан нь тэд хичээлийн явцад багшийн хэрэглэж буй сургалтын аргад тулгуурлан сэтгэхүйн үйлийг хөгжүүлэх дасгалууд гүйцэтгэх сонирхолтойг илтгэнэ.

Сурагчид мэдлэгтээ тулгуурлан 81.7 хувь нь эсээ бичих болон санаагаа үг, өгүүлбэрээр илэрхийлэх, 91.5 хувь нь юмсын цаад учир утгыг олох даалгавар хийх дуртай байдаг байна.

Сурагчдын багшийг даган дууриаж, биеэр хийж сурах нь үр дүнтэй гэж багш нарын 90.0 хувь нь үзсэн бол бодит үйлдлийн сэтгэхүйд тулгуурлан төрөл бүрийн үзүүлэн, зураг ашиглан хичээл заах нь үр дүнтэй гэж 97.5 хувь нь, сэтгэхүйн харьцуулах үйл хийж өөрсдөө сонссон зүйл дээрээ тулгуурлан үйлдэл хийх боломжтой гэж 95.0 хувь нь тус тус үзсэн байна. Багш нарын 64.3 хувь нь хүүхдүүд үгэн мэдээлэлд задлан шинжлэл хийж, нэгтгэж дүгнэж сэтгэх чадвар сул гэсэн байна.

### *Сурах арга барил ба мэдлэг ойлголт, мэдлэгээ хэрэглэх чадвар*

ЕБС-ийн бага боловсролын хөтөлбөрөөр заагдаж буй хичээлүүдийн ойлголт, мэдлэгээ хэрэглэх чадварын нийт хичээлийн гүйцэтгэлийг сурах арга барилыг тодорхойлж буй танин мэдэхүйн чадваруудын гүйцэтгэлтэй уялдуулан авч үзэв.

### *Анхаарал ба хичээлүүдийн сорилын гүйцэтгэл*

Сурагчдын даалгавар тус бүрийн гүйцэтгэлийн оноо болон нийт даалгаврын гүйцэтгэлийг ЕБС-ийн суралцагчийн болон боловсролын чанарын үнэлгээний журмын 3.1-ийн суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц, амжилтыг 4-5 дугаар ангид гүйцэтгэлийн хувиар тооцож дүгнэж авч үзлээ.

*Хүснэгт 49. Бага ангийн сурагчдын анхаарлаа хөгжүүлэх үйлд дуртай эсэх (сорилын гүйцэтгэл)*

| *Анхаарлын чадвар* | *Гүйцэтгэлийн хувь* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | *0-54 хувь* | | *55-69 хувь* | | *70-100 хувь* | |
| | *дуртай* | *дургүй* | *дуртай* | *дургүй* | *дуртай* | *дургүй* |
| Анхаарлын хуваарилалт | 49.5 | 40.2 | 38.3 | 46.9 | 12.2 | 12.8 |
| Анхаарлын тогтворжилт | 46.6 | 48.6 | 41.6 | 31.5 | 20.0 | **11.8** |
| Анхаарлын шилжилт | 45.8 | 52.5 | 42.7 | 30.7 | 16.9 | **11.5** |
| Анхаарлын төвлөрөлт | 45.5 | 55.8 | 41.3 | 37.2 | 13.2 | 7.0 |

Сурагчдын хувьд анхаарлын үйлүүдийг хийх дуртай гэж хариулсан сурагчдын 45.5-49.5 хувь дунджаас доогуур гүйцэтгэлтэй байна. 2013-2017 онд хэрэгжүүлсэн Монголын

хүүхэд, залуусын хөгжлийн цогц судалгаагаар 8-10 насанд анхаарлын шилжилт, тогтворжилт сул байна гэж тогтоосон. Хичээл дээр дасгал даалгаврыг хурдан хугацаанд гүйцэтгэх дуртай гэж хариулсан сурагчдын гүйцэтгэл дунджаар 51.7 байхад, хичээл дээр удаан суух хэцүү гэж хариулсан сурагчдын сорилын гүйцэтгэл дунджаар 47.1 байна.

Сурагчид үйл ажиллагааны нэг төрлөөс нөгөө төрөлд сэтгэцийн үйлээ шилжүүлэх чадвар нь жигд бус гадаад орчны нөлөөнд амархан автагдаж, бодол санаандаа хөтлөгдөж, ямар нэг зүйлд анхаарал сарних нь их байдаг онцлогтой холбоотой байна.

### *Ой тогтоолт ба даалгаврын гүйцэтгэл*

*Хүснэгт 50. Ой тогтоолтыг хөгжүүлэх дасгалд сурагчид дуртай эсэх (сорилын гүйцэтгэл)*

| *Ой тогтоолт* | *Гүйцэтгэлийн хувь* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | *0-54 хувь* | | *55-69 хувь* | | *70-100 хувь* | |
| | *дуртай* | *дургүй* | *дуртай* | *дургүй* | *дуртай* | *дургүй* |
| сонорын ой тогтоолт | 46.8 | 50.9 | 40.7 | 38.6 | 12.5 | 10.5 |
| харааны ой тогтоолт | 47.9 | 44.9 | 38.5 | 47.6 | 13.6 | 7.5 |
| утгын ой тогтоолт | 46.7 | 49.3 | 40.5 | 40.4 | 12.7 | 9.5 |

Сорилын гүйцэтгэл нь хүүхдүүдийн мэдээллийг тогтоох чадвартай нь холбоогүй байна.

### *Сэтгэхүй ба даалгаврын гүйцэтгэл*

*Хүснэгт 51. Бага ангийн сурагчдын сэтгэхүйн төрлүүд хөгжүүлэх дасгалд дуртай эсэх (сорилын гүйцэтгэл)*

| *Ой тогтоолт* | *Гүйцэтгэлийн хувь* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | *0-54 хувь* | | *55-69 хувь* | | *70-100 хувь* | |
| | *дуртай* | *дургүй* | *дуртай* | *дургүй* | *дуртай* | *дургүй* |
| бодит үйлдлийн сэтгэхүй | 46.5 | 48.2 | 41.5 | 38.8 | 12.0 | 13.0 |
| бодит дүрслэлийн сэтгэхүй | 24 .1 | 40.0 | 23.2 | 45.9 | 52.7 | 14.3 |
| хийсвэр сэтгэхүй | 45.5 | 54.3 | 40.2 | 41.9 | **14.3** | 3.8 |

Бодит дүрслэлийн сэтгэхүй буюу төрөл бүрийн зүйлсийг харж учрыг нь олох дуртай гэж хариулсан сурагчдын гүйцэтгэл өндөр байгаа нь сурагчдад бодитоор юмсыг харуулан учрыг олох үйлд чиглүүлэх даалгавар болон хичээлийг зохион байгуулах нь үр дүнтэй байж болох юм.

Хүүхдийн хөгжлийн цогц хөгжлийн судлагаагаар 8-10 насны хүүхдүүд юмсын зарим нэг шинжийг харьцуулан үзсэн ч зарим шинжийг харьцуулж чадаагүй байна. Бодит үйлдлийн сэтгэхүй сул түвшинд буюу юмс үзэгдлийн дотоод зүй тогтлыг нь таньж, даган дууриаж гүйцэтгэх чадвар сул байгаа нь тогтоогдсон. Хийсвэр сэтгэхүй нь мөн адил сул түвшинд буюу юмс үзэгдлийг зүй тогтол, учир шалтгаанд нь харьцуулах чадвар хангалтгүй байна гэж судлагааны үр дүн гарсан. Энэ судалгаагаар багш нар сурагчдын учир шалтгааныг нь олж, дүгнэж ярьж сургах нь чухал байна гэж үзсэн бол сурагчид өөрсдийгөө төрөл бүрийн зүйл харж учир утгыг нь олох дуртай, сонссон зүйлээ харж өөрөө биеэрээ хийж үзэх дуртай гэж бодит дүрслэлийн сэтгэхүйд тулгуурлан үйлдэл хийдэг гэж хариулсан байна. Сэтгэхүйн харьцуулах үйлдэл ба сургалтын явцад хөгждөг гэж үздэг хийсвэр сэтгэхүйн хөгжилд анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

Сурагчдын сурах арга барил болон хичээлүүдийн сорилын гүйцэтгэлд хийсэн шинжилгээнээс дараах дүр зураг харагдав.

Танин мэдэхүйн хөгжил нь хүүхдийн сэтгэн бодох, ухааран ойлгох процесст гарч байгаа өөрчлөлт юм. Энэ нь хүүхэд мэдээллийг хүлээж авах, анализ хийх, харьцуулах, системчлэх, хийсвэрээр сэтгэх, зүй тогтолыг нь олох чадвар эзэмших буюу сурах үйлтэй холбоотой байна.

- Сурагчид өөрсдийнхөө анхаарлын тогтворжилт, шилжилт, төвлөрөлт буюу тодорхой хугацаанд тодорхой зорилготойгоор анхаарлаа төвлөрүүлэх чадвартай гэж үзэж байгаа ч энэ чадварууд сул байгааг сорилын дүн илэрхийлж байна.
- Багш сурагчдыг бие даан сурах арга барилтай болоход чиглүүлэх анхаарлын төвлөрөлт, хуваарилалтыг сайжруулах, сурагч тодорхой хугацаанд нэг зүйлд тогтвортой байх дадалтай болоход нь чиглүүлэх дэмжих.
- Сурагчид юмсыг сонсоод тогтоохоо илүү уншиж тогтоох, уншиж тогтоохоос илүү бичиж тогтоох дуртай гэсэн бол багш нар гэрийн даалгаварт эдгээр үйлүүдийг давтан хийх даалгаврыг сонголттойгоор өгөх шаардлагатай байна.
- Багш нар харааны ой тогтоолт, сонорын ой тогтоолт, утгын ой тогтоолт дээр тулгуурлаж мэдээллийг олон дахин давталттайгаар өгөх, гэрийн даалгавар болон хичээлийн явцад ойлгосон эсэхийг бататган асуудаг байх шаардлагатай байна.
- Багш сурагчид бодит дүрслэлийн болон үйлдлийн сэтгэхүйд тулгуурлан мэдээллийг олгох хандагатай байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байгаа ч сургалтын явцад хийсвэр сэтгэхүй хөгжих боломжтой учир сурагчдын учир шалтгааныг нь олж дүгнэж яриж сургах нь чухал байна.
- Сурагчдад сурах арга барилыг эзэмшүүлэхэд багш нар сурагчдын оношилох судалгаанд суурилан сургалтын идэвхтэй арга хэрэглэх, сурагчдын хийх дуртай үйлийг нь дэмжих, багш нарын чадварыг дэмжих олон талын үйл ажиллагаа явуулах хэрэгцээ шаардлага байна.

## Бага боловсролын түвшинд суралцагчдын гүйцэтгэлд нөлөөлсөн хүчин зүйлс

Бага боловсролын түвшинд хөтөлбөрийн хэрэгжилтийг хичээлүүдийн сорилын гүйцэтгэлээр авч үзэхдээ, гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тогтоон шинжилгээ хийх нь бидний ажлын нэг зорилго юм. Учир нь нөлөөлж буй хүчин зүйлсэд тулгуурлан хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах боломжийг авч үзэх боломжтой.

Хамаарлын шинжилгээгээр сурагчдын гүйцэтгэлд эцэг, эхийн боловсрол ($p<0.01$), өрхийн сарын дундаж орлого ($p<0.01$), хичээлд суугаагүй өдрүүд ($p<0.01$) нөлөөлсөн байна.

*Зураг 48. Эцгийн боловсролын түвшин ба бага ангийн сурагчдын гүйцэтгэл*



Эцгийн боловсролын түвшин ахих тутам сурагчдын сорилын гүйцэтгэл сайжирсан байна.

*Зураг 49. Эхийн боловсролын түвшин ба бага ангийн сурагчдын гүйцэтгэл*




Эхийн боловсролын түвшин ахих тутам сурагчдын сорилын гүйцэтгэл сайжирсан байна.

*Зураг 50. Өрхийн сарын дундаж орлого ба бага ангийн сурагчдын гүйцэтгэл*




Өрхийн орлого нэмэгдэх тутам сурагчдын 70-аас дээш онооны гүйцэтгэлийн эзлэх хувь нэмэгдэж байна.

*Зураг 51. Хичээлийн ирц ба бага ангийн сурагчдын гүйцэтгэл*




Хичээлд бүрэн суусан сурагчдын гүйцэтгэл хичээлд бүрэн бус суусан сурагчдынхаас илүү байна. Тухайлбал, хичээлд бүрэн суусан сурагчдын 75.0 хувь нь 70-аас дээш хувь сорилыг зөв гүйцэтгэсэн бол 1-3 өдөр хичээлд суугаагүй сурагчийн 21.1 хувь нь сорилыг 70-аас дээш хувьтай гүйцэтгэсэн байна.

*Зураг 52. Багшийн ажилласан жил ба бага ангийн сурагчдын гүйцэтгэл*




Сурагчдын сорилын гүйцэтгэлд багш нарын ажилласан жил нөлөөлж байна.

Багшийн ажилласан жил нэмэгдэх тусам сурагчдын сорилын гүйцэтгэл сайжирсан байна.

Бага ангийн сурагчдын хичээлүүдийн сорилын гүйцэтгэлд эцэг эхийн боловсролын түвшин, өрхийн орлогоос гадна сурагчдын хичээлийн ирц нөлөөлж байна.

# ГУРАВДУГААР БҮЛЭГ. СУУРЬ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛ

## Суурь боловсролын сургалтын арга зүй

Суурь боловсролын сургалтын арга зүйг хичээлийн арга зүйн хүрээнд судалсан бөгөөд хичээлийн төлөвлөлт, түүний хэрэгжилт үр дүнд анхаарал хандуулсан болно. Хичээлийн төлөвлөлтийг жилийн, нэгж хичээл, ээлжит хичээлийн хүрээнд баримт бичигт дүн шинжилгээ хийн авч үзэв. Харин хичээлийн төлөвлөлтийн хэрэгжилтийг, хичээлийн зохион байгуулалт, багшлах үйл ажиллагаа, сургалтын явцад суралцагчдын оролцоо, гүйцэтгэж буй үйл, хичээлд сурах бичиг сургалтын хэрэглэгдэхүүний ашиглалт, суралцагчдыг урамшуулах дэмжих үйл ажиллагаа зэргээр авч үзэхдээ ажиглалт, асуулга, ярилцлагыг аргуудыг ашиглан мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийв.

Сургалтын менежерүүдийн дийлэнх нь суурь боловсролын түвшинд хөтөлбөрийн хэрэгжилтэд “сэтгэл дундуур, хангалттай бус” байна. Эдгээр мэргэжилтнүүдийн хувьд үүний шалтгааныг дараах зүйлтэй холбоотой гэж үзэж байна. Үүнд:

- багш нарын ажилласан жил, туршлага зэрэгтэй холбоотой тэдний сургалтын хөтөлбөрийн ойлголт зөрүүтэй байгаа нь доорх байдлаар илэрдэг.
    - багшийн чадвар сул, ялангуяа ахлах ангид шинээр сургалтын хөтөлбөрт орсон сэдвүүдийг зарим багш нар их, дээд сургуульд суралцаж байхдаа ч судлаагүй байдаг,
    - хичээлийн бэлтгэл хангалтгүй, хуучин хандлагаасаа салаагүй, англи хэлний хичээл дээр монголоор ярьсан хэвээрээ, заах аргаа шинэчлээгүй,
    - багш бэлтгэдэг сургуулийн хувьд цөм хөтөлбөрөө өөрсдөө үгүйсгэдэг гэх мэт.
- сургалтын хэрэглэгдэхүүн, орчин:
    - байгалийн ухааны материаллаг бааз, хэрэглэгдэхүүний хүртээмж хангалтгүй,
    - сурах бичгийн боловсруулалтыг сайжруулах, монгол ахуйгаас хол утга санаа бүхий дасгал тусгахгүй байх, тухайлбал; далайн амьтныг нугалах дасгал сурах бичигт тусгасан байна.
- бодлоготой холбоотой:
    - хөтөлбөр, сурах бичиг, үнэлгээний журам ойр ойрхон өөрчлөгддөг,
    - боловсон хүчин хөдөлгөөнтэй, солигддог, тэднийг бэлтгэх ажил хангалтгүй.

Зарим аймгийн БСУГ-ын мэргэжилтнүүдийн олонх нь сургалтын цөм хөтөлбөр хэрэгжүүлж эхэлснээс хойш багш нарын арга зүй, сургалтын технологид ахиц, дэвшил гарсан гэж дүгнэсэн байна.

> Цөм хөтөлбөрийн хэрэгжилтээр багшийн багшлах арга зүйд өөрчлөлт гарсан гэж бодож байна.Сурах арга барилын арга зүйд нэлээд дэвшил гарсан.
>
> *БСУГ-ын мэргэжилтэн*

## Хичээлийн төлөвлөлт

Судалгааны хүрээнд сонгогдсон 8 дугаар ангийн хувьд хичээл (судлагдахуун)-ийн жилийн, нэгж, ээлжит хичээлийн төлөвлөлтийг сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамжтай харьцуулж, тохироцыг илрүүлэхийн тулд:

- Судалгаанд хамрагдсан ерөнхий боловсролын сургуулиудаас сонгогдсон 8 дугаар анги, бүлгийн сонгогдсон хичээл (судлагдахуун)-ийн жилийн, нэгж, ээлжит хичээлийн төлөвлөлтийг авсан.
- Судлагдахуун бүрээр багшийн боловсруулсан төлөвлөлтийг сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамжтай харьцуулж, тодорхой шалгуурын дагуу тохирцыг илрүүлнэ.
- Судлагдахуун бүрээр хийсэн шинжилгээний дүнг нэгтгэн дүгнэв.

Бид судалгаанд хамрагдсан сургуулиудын хичээлийн жилийн болон нэгж, ээлжит хичээлүүдийн хөтөлбөрт шинжилгээг хийв. (Хавсралт 4.2). Суурь боловсролын хичээлийн 13, жилийн 28 төлөвлөлтөд шалгуурын дагуу шинжилгээ хийхэд дараах дүр зураг харагдаж байна.

*Зураг 53. Суурь боловсролын жилийн төлөвлөлтийн бүтцийн үнэлгээний дундаж*




Эндээс үзэхэд багш нар жилийн төлөвлөлт хийхдээ агуулгын хуваарилалтад илүү анхаарч, зорилго, зорилт болон үнэлгээний шалгуур аргачлалаа тусгахдаа сул анхаарсан нь харагдав. Тухайлбал, Үнэлгээний арга, аргачлалын төлөвлөлтийг шинжилгээнд хамрагдсан сургуулиудын тусгасан байдлыг хувьчилсан үнэлгээгээр авч үзэхэд дөнгөж 5.3 хувьтай байх юм.

Суурь боловсролын түвшинд 13 хичээлийн, 27 нэгж хичээлийн төлөвлөлтөд шалгуурын дагуу шинжилгээ хийв.

*Зураг 54. Суурь боловсролын нэгжийн төлөвлөлтийн бүтцийн үнэлгээний дундаж*




Багш нар нэгж хичээлийг төлөвлөхдөө агуулгын хуваарилалтыг ихээхэн анхаарч, харин агуулгын залгамж холбоо, сургалтын хэрэглэгдэхүүний тусгах, үнэлгээний аргачлал, жишиг даалгавар боловсруулахыг орхигдуулж байна. Үүнээс гадна жилийн төлөвлөлттэй

нэгж хичээлийн төлөвлөлт тур бүр уялдахгүй байгаа нь багш нарын хичээл төлөвлөлтийн чадварыг цаг алдалгүй дэмжих хэрэгцээтэйг илтгэнэ.

Суурь боловсролын 12 хичээлийн, 33 ээлжит хичээлийн төлөвлөлтөд дүн шинжилгээ хийсэн бөгөөд жилийн болон нэгж хичээлийн төлөвлөлтийн бүтэцтэй харьцуулахад боловсруулалт илүү сайн байгаа нь харагдав.

*Зураг 55. Суурь боловсролын ээлжит төлөвлөлтийн бүтцийн үнэлгээний дундаж*



| | Зорилго, зорилтыг тусган оруулсан байдал | Агуулгыг хуваарилсан байдал | Хэрэгжүүлэх арга зүйг төлөвлөсөн байдал | Сургалтын хэрэглэгдэхүүн, орчин төлөвлөсөн байдал | Явцын үнэлгээг тусгасан байдал | Нэгжийн төлөвлөлттэй нийцэж байгаа байдал |
|---|---|---|---|---|---|---|
| Үнэлгээ | 56 | 75.2 | 47.3 | 51.1 | 29.5 | 68.1 |

Багш ээлжит хичээлийн агуулгын хуваарилалт (эхлэл, өрнөл, төгсгөл)-ийг сайн төлөвлөсөн боловч, явцын үнэлгээ, хэрэгжүүлэх арга зүй (багшийн стратеги, хичээлд хэрэглсэн арга)-г хангалтгүй төлөвлөж байгаа нь харагдаж байна.

Баримт бичигт үндэслэн мэдээллийн шинжилгээнээс харахад судалгаанд хамрагдсан сургуулиудын багш нарын 18-30 хувь нь төлөвлөлтгүй хичээл зааж байна.

Жилийн, нэгж хичээлийн, ээлжит хичээлийн төлөвлөлтийг харьцуулан авч үзэхэд багш нар эдгээр төлөвлөгөөнүүдийг уялдаатай төлөвлөж тэр бүр чадахгүй байна. Ээлжит хичээлийн төлөвлөлтийг жилийн болон нэгж хичээлийн төлөвлөлттэй харьцуулахад илүү тодорхой төлөвлөж сурсан байгаа юм.

Жилийн болон нэгж, ээлжит хичээлийн төлөвлөлтийг хэрхэн хийдэг талаар багш нараас тодруулахад, сургуулийн нэгдсэн хөтөлбөртэй уялдуулаад мэргэжлийн багш нар хамтран цөм хөтөлбөрийн дагуу боловсруулдаг гэжээ. Түүнчлэн бусад дүүргийн болон аймгийн сургуулиудын мэргэжлийн багш нартай хамтран нэгдсэн төлөвлөгөөг боловсруулах нь нийтлэг байна. Ээлжит хичээлийг төлөвлөхөд тулгардаг бэрхшээлтэй байдаг зүйлсийн талаар судалгаанд хамрагдсан багш нараас асуухад:

Хичээл төлөвлөхөд багш нарт хамгийн их тулгардаг бэрхшээл нь зарцуулах цаг бага, төлөвлөөгүй ажил гардаг, сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэхэд мөнгө, зардал гаргах гэж багш нарын 70-80 хувь нь хариулжээ.

Ээлжит хичээлийн төлөвлөлтийг 1-5 жил ажиллаж байгаа багш нарт заавал гараар бичүүлдэг. Жилийн төлөвлөлт бол цаг, нэгж аль цаг ямар байж цагтаа хэрхэн багтаах, ээлжит 40 минутын үйл ажиллагаа. Тухайн хичээлийг хэрхэн ялгаж төлөвлөх тал дээр анхаарах.

*Нийслэлийн сургуулийн сургалтын менежер*

Сурагчдын мэдлэг, чадварыг үнэлэх үнэлгээний даалгаврыг хичээлийн төлөвлөлтөд тусгадаг талаар багш нараас асуухад үнэлгээний даалгавруудыг багш нар бие даан боловсруулахаас гадна үнэлгээний сангаас даалгаврыг авч ашигладаг гэжээ.

Сурагчдыг үнэлэхэд тулгарч буй бэрхшээлүүдийг багш нар дараах байдлаар хэлжээ. Үүнд:

- үнэлгээ 8 түвшинтэй болчихсон учраас шалгуураа боловсруулахад хүндрэлтэй,
- хүүхэд бүрийн ялгаатай байдлыг харгалзах хэцүү,
- үнэлгээ олон дахин өөрчлөгдөж байгааг эцэг эх ойлгоход бэрхшээлтэй зэрэг болно.

Ээлжит хичээлийг төлөвлөхдөө хичээлийн зорилго, зорилтуудыг сурагчдад ойлгомжтой байдлаар танилцуулах, хичээлийг зохион байгуулах бүтэц, хэлбэрийг тодорхойлох, шинэ мэдлэг бүтээх үйл ажиллагааг төлөвлөх, туршилт, шийдвэрлэх асуудлыг хүүхэд бүрийн идэвхтэй суралцах аргыг хэрэглэн тодорхойлох, үнэлгээ дүгнэлт өгөх зэрэг үйл ажиллагааг тусгадаг.

Багш ээлжит хичээл төлөвлөхдөө туршилт, шийдвэрлэх асуудал дэвшүүлж, суралцах чадварын ялгааг харгалзахгүй байгаа нь ажиглагдаж байна. Туршилт, шийдвэрлэх асуудлыг суралцах чадварын түвшинд ялгаж үзсэнээр сурагчид тодорхой үүрэгтэй, идэвхтэй оролцох, хамтран ажиллах, ангийн түвшинд нэгдсэн шийдэл, үр дүнд хүрэх нь судалгаанаас харагдаж байна.

## Хичээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж буй байдал

Дунд ангид хичээл ордог багш нарын мэргэжлийн зэргийг авч үзэхэд 37.0 хувь нь зэрэггүй, 43.8 хувь нь заах аргач, 18.5 хувь нь тэргүүлэх, 0.7 хувь нь зөвлөх зэрэгтэй бөгөөд ихэнх хувь нь байгалийн ухаан болон монгол хэл, уран зохиолын багш нар байна.

*Зураг 56. Дунд ангийн хичээл зохион байгуулалтын хэлбэр*




Багш нар хичээлийг төлөвлөлтийн дагуу ихэвчлэн анги нийтээр зохион байгуулж байна. Сурагчдын хувьд, анги нийтээр заадаг гэдгийг дурдаад багаар зохион байгуулбал сонирхолтой байдаг гэжээ.

Хичээл бүрийн онцлогийг харгалзан үзэж, түүнд тохирсон аргыг сонгох хэрэгтэй гэж багш нар үзсэн ба ээлжит хичээлийг багаар зохион байгуулах нь сурагчдыг хөгжүүлэхэд давуу талтайг чухалчилж байна.

Ээлжит хичээлийн бүтцийн зохион байгуулалтад гэрийн даалгавар шалгах, хичээлийн зорилго зорилтыг танилцуулах, шинэ мэдлэг бүтээх, үнэлгээ дүгнэлт хийх, гэрийн даалгавар өгөхөд зарцуулж буй хугацааг авч үзэхэд дунджаар:

- Гэрийн даалгавар шалгахад – 8.6 минут
- Ээлжит хичээлийн зорилго, зорилтыг танилцуулахад – 3.3 минут
- Шинэ мэдлэг бүтээх үйл хийлгэхэд – 23.4 минут

- Үнэлгээ, дүгнэлт өгөхөд – 5.8 минут
- Гэрийн даалгавар өгөхөд – 2.0 минут, нийт 43.1 минут зарцуулдаг байна.

Багш гэрийн даалгаврыг хүүхэд бүрээр, хүүхдийг хүүхдээр, анги нийтэд нь шалгахдаа асуух хэлбэрийг түлхүү ашиглаж байгаа нь ажиглалтаар илэрч байна. Харин сурагчдын дэвтрийг хураан авч гэрийн даалгавар шалгах ажил огт хийгдээгүй байна. Сурагчдын гэрийн даалгавар шалгасан хэлбэрүүдийг сурагчдын бусад үйлүүдтэй хамааруулан шинжлэхэд дараах давуу болон сул талууд ажиглагдаж байна.

Хичээлийн зорилго, зорилтыг танилцуулснаар хичээл нь өмнөх болон дараагийн агуулгатай холбогдсон, туршилт, шийдвэрлэх асуудал нь зорилготой уялдсан, зорилгод чиглэсэн эргэцүүлэн бодох асуултаар сурах сэдэл төрүүлсэн, хүүхдийн асуулт, хариултыг анхааралтай сонсож, дэмжсэн, бүх хүүхдэд хариулах боломж олгосон, дасгал даалгаврын гүйцэтгэлээр явцын үнэлгээг хийсэн, төлөвлөсөн зорилтоо бүрэн хэрэгжүүлсэн багш цөөнгүй байна. Сурагчдын хувьд шинжлэх ухааны нэр томьёо ашигласан, уялдаа холбоог илрүүлсэн асуулт асуух, багийн гишүүд идэвхтэй хамтран ажиллах, сурагч өөрийн үнэлгээ хийх үйлүүдийг хийж байна.

Хичээлийн явцад зорилгод чиглэсэн үйлийг дэмжих, учир шалтгаан олох эрэл хайгуул хийх, хичээлд шинжлэх ухааны багаж, хэрэгсэл, бодис ашиглах, зорилгод чиглэсэн үйл ажиллагаанд сурагчдын анхаарлыг хичээлийн туршид хандуулах, самбараас мэдээлэл авах хугацааг сурагчдад хангалттай олгох зэрэг үйлүүд хийж байгаа нь ажиглагдав.

Зорилгод чиглэсэн эргэцүүлэн бодох асуултаар сурах сэдэл төрүүлсэн багшийн эзлэх хувь 60.0 хувь байна. Уг үйлийг хийснээр өөрийн санаа бодол, шүүн тунгааж эргэцүүлснээ бичгээр илэрхийлсэн сурагчдын эзлэх хувь 96.9 хувь байна. Энэ нь хичээл дээр сурагчдыг яриулах нь бага байгааг илэрхийлнэ.

Суралцагч төвтэй сургалтыг зохион байгуулахад тулгамддаг хүндрэл, бэрхшээлүүдийг багш нар дараах байдлаар гарган тавьж байна. Үүнд:

- орчин нөхцлөөс ихээхэн хамаардаг,
- байгалийн ухааны хичээлийн хувьд хүүхдүүд өөрсдөө хийж, турших явах нь сайн байх ч энэ нь сургалтын хэрэглэгдэхүүн хүрэлцээгүй, лаборатори байдаггүй зэрэг нь дутагдалтай байдаг нь хүндрэлтэй,
- сурагчид мэдлэгээ өөрсдөө бүтээдэг тул цаг их ордог, цагийн алдагдал гараад, агуулгаа гүйцэхгүй болдог.
- ялгаатай даалгавар өгч ажиллах шаардлага их байдаг,
- алхамчилж төлөвлөхөөс гадна нэмэлт хэрэглэгдэхүүн их шаардлагатай байна гэх мэт.

> Суралцагч төвтэй сургалтын хувьд багш бол зөвхөн чиглүүлэгч гэж ойлгоод хичээлээ заахдаа дутуу орхигдуулах зүйл гардаг тал ажиглагддаг. Сургалтын хэрэглэгдэхүүн ашиглаж байж л сурагч төвтэй сургалт үр дүнтэй болно гэдэг ч боломж хомс, сургуульд тийм зардал байхгүй.
>
> *Орон нутгийн сургуулийн багш*

Хичээлийн явцад хариултыг мэдэж байсан ч бусдаас түрүүлж хариулах, дуугарах нь хэцүү байдаг эсэх талаар асуухад бүлгийн ярилцлагад оролцсон сурагчдын дийлэнх нь "хэцүү биш байдаг" гэж хариулжээ.

Багшаасаа хэр их асуулт асуудаг вэ, мөн асуултынхаа хариултыг авч чаддаг уу гэж сурагчдаас тодруулахад ихэнх нь "асуудаг" гэсэн ч "хариултыг тэр бүр авч чаддаггүй" гэж цөөн тооны суралцагчид хэлжээ. Хичээлийг хэрхэн, ямар арга барилаар заавал дуртай байх вэ гэсэн асуултад ой тогтоолтын арга ашиглах, ярилцах арга зонхилбол таатай байна гэсэн хариултууд өгсөн. Харин цөөн сурагч бие даан хийлгэх, жишээ гарган тайлбарлавал, баримт нотолгоотой, бодит амьдралтай холбох, мэтгэлцээний хэлбэр ашиглавал, зургаар дүрслэх, сурагч бүртэй ажиллах, дадлага хийлгэвэл хичээл сонирхолтой байна гэжээ.

### *Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн*

Хичээл төлөвлөхдөө сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн ашигладаг талаар багш нараас асуухад тухайн судлагдахууныхаа сурах бичгийг байнга ашигладаг гэсэн хариулт хамгийн өндөр буюу 78.1 хувьтай байна. Түүнээс гадна сургалтын цөм хөтөлбөр, суралцахуйн удирдамж болон тест, даалгаврын санг багш нарын 49.0-52.0 хувь нь байнга ашигладаг дүр зурагтай байна. Сургалтын хэрэглэгдэхүүний хэрэглээний талаар багш нараас асуухад биет үзүүлэн, зураг дүрслэл бүхий үзүүлэн, сорил, туршилтын багаж, хэрэгсэл зэрэг төрөл бүрийн хэрэглэгдэхүүнийг ашигладаг ажээ. Тэр дундаа бие үзүүлэн болон зураг, дүрслэл бүхий үзүүлэн, сорил туршилтын багаж хэрэгслийг нэлээд ашиглаж байна.

Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн дагуу 6-9 дүгээр ангийн 11-17 судлагдахууны 54 нэрийн сурах бичгийг сургалтад хэрэглэж байна. Монгол улсын Засгийн газрын 2009 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар дунд, ахлах ангийн сурагчдын 40 хүртэл хувийг төрөөс үнэгүй хангах тухай гарсан шийдвэрийн дагуу өнөөг хүртэл хагас, бүтэн өнчин, амьдралын баталгаажих түвшнээс доогуур орлоготой айлын, гурав ба түүнээс дээш хүүхэд нь ЕБС-д суралцдаг айлын хүүхдүүдийг сургуулийн номын сангаар сурах бичгээр хангаж байна.

*Зураг 57. Дунд ангийн сурах бичгийн хүртээмж (судлагдахуунаар)*



Нийт сурагчдын сурах бичгийн хүртээмж дунджаар 44.6 хувь байна. Үүнийг нийт хүүхдийн тоотой харьцуулж үзэхэд ойролцоогоор 2 сурагчийн нэг нь сурах бичигтэй гэж тооцож болох юм. Судлагдахуунаар авч үзвэл сурагчдын 56.3 хувь нь математик, 52.6 хувь нь англи хэл, 50-54 хувь нь байгалийн ухаан, харин бусад хичээлийн сурах бичгүүд 50 хувьд хүрэхгүй байна. Харин дүрслэх урлагийн сурах бичиг 25.5 хувь, хөгжмийн сурах бичгийн эзлэх хувь 34.1 байгаа нь хамгийн бага байна. Өөрөөр хэлбэл, ойролцоогоор 3-4 сурагчийн нэг нь дүрслэх урлаг, хөгжмийн сурах бичигтэй байна.

Номын сангаар олгогдож байгаа сурах бичгийг судлагдахуунаар нь авч үзлээ. Монгол хэл, математик, физикийн сурах бичгүүд бусад сурах бичгээсээ 2-3-аар хувиар илүү, дүрслэх урлаг, иргэний боловсрол, мэдээллийн технологийн сурах бичгүүд бусдаасаа 6-15-аај бага хувиар тараагддаг байна. Харин сурах бичгээ худалдаж авсан сурагчдыг аль судлагдахууны сурах бичгийг түлхүү авч байгааг дараах зурагт үзүүлэв.

*Зураг 58. Сурах бичгийн хангалт (судлагдахуунаар)*




Сурагчид математик, англи хэлний сурах бичгийг түлхүү худалдаж авдаг бол хөгжим, дүрслэх урлагийн сурах бичгийг бусад судлагдахууны сурах бичгээс бага хувиар худалдаж авдаг байна. Энэ нь нэг ангийн бүх сурах бичгийг нэг цэгээс авах боломж хомс, тухайн сурагчийн сонирхол зэрэгтэй холбоотой байж болох юм. Номын сангаар түгээж буй судлагдахуун бүрийн сурах бичгүүдийн тоо хэмжээ харилцан адилгүй байгаа нь тухайн сургуульд нийлүүлсэн хангалтын тоо хэмжээтэй шууд хамааралтай.

*Зураг 59. Сурах бичгийн хүртээмж (байршлаар)*




Сурах бичгийн хүртээмжийг байршлаар харуулахдаа сурагчид байгаа номын тооноос хамаарахгүйгээр сурах бичигтэй гэж хамруулж үзсэн. Сурагчид бүх хичээлийн сурах бичиг бий эсэхийг дараагийн шатны боловсруулалтаар гаргах боломжтой.

ЕБС-ийн дунд ангийн сурагчдын 40 хүртэл хувийг төрөөс хангана[8] гэсэн засгийн газрын шийдвэрийн дагуу сургуулийн номын сангаар дамжуулан хагас бүтэн өнчин, амьдралын баталгаажих түвшнээс доогуур орлоготой айлын, 3 ба түүнээс дээш хүүхэд нь ЕБС-д суралцдаг айлын хүүхдийн сурах бичгийг түгээж, хэрэглүүлж байна. Дунд ангийн хүүхдүүдийн 60.0 хувь нь өөрсдийн мөнгөөр зах зээлээс сурах бичгээ худалдаж авах

[8] МУ-ын Засгийн газрын 2009 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны 28 дугаар тэмдэглэлийн 7.1

зохицуулалт өнөөг үйлчилж байна. Иймд сурах бичигтэй сурагчдаас сургуулиас эсвэл худалдаж авсан эсэхийг тодруулав. Сурах бичигтэй нийт сурагчдын 55.9 хувь нь номын сангаас, 44.1 хувь нь худалдаж авсан байна. Үүнийг судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн тоотой харьцуулбал сурагчдын дунджаар 26.0 хувь нь сургуулийн номын сангаас авсан, 18.6 хувь нь худалдаж авсан гэсэн тооцоо гарч байна. Дунд ангийн сурагчдын 40 хүртэл хувийг төрөөс үнэгүй сурах бичгээр хангах шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байгааг харж болно.

Сургуулийн номын сангаар дамжуулан хэрэглүүлж байгаа сурах бичгийн эзлэх хувиас худалдаж авсан сурах бичгийн хувь бага байгаа нь эцэг эхийн худалдан авах хүсэл сонирхол, санхүүгийн боломж, худалдаа борлуулалтын нэгдсэн сүлжээ бий болоогүйтэй холбоотой байж болох юм.

*Зураг 60. Сурах бичгийн хангалт (байршлаар)*




Зургаас харахад сумын сургуулийн сурагчдын сурах бичгийн хангалт худалдаж авснаасаа номын сангаас дамжуулж авсан сурагчдын эзлэх хувь 75.2 хувиар бага байна. Энэ нь суманд сурах бичиг худалдаалах цэг байхгүй, иргэд оршин суугаа газраасаа сурах бичгээ худалдаж авах боломж бүрдээгүйтэй холбоотой байж болох юм.

Сурах бичиггүй байгаагийн шалтгааныг сурагчаас тодруулав. Нийт сурагчдын 8.0 хувь нь сургуулиас өгдөггүй, 59.9 хувь нь худалдаж авах гэхээр олддоггүй гэж хариулсан байна. Энэ нь манай улсад сурах бичгийн худалдаа, борлуулалтын нэгдсэн сүлжээ байхгүйтэй холбоотой байж болох юм. Харин 24.5 хувь нь ээж аав худалдаж авч өгөөгүй, сурах бичиг үнэтэй байдаг гэж хариулсан байна. Үлдсэн 7.6 хувь нь сурах бичгээ гээсэн гэжээ.

Дунд ангийн сурагчид сурах бичгийг хэрхэн хэрэглэдэг талаар судлахад 58.3 хувь нь сурах бичгийг хуулж бичдэг, 44.8 хувь нь эхийг нь уншдаг, 35 хувь нь зургийг нь хардаг, 73.1 хувь нь дасгал даалгаврыг нь хийдэг, 23 хувь нь сорил туршилт хийхдээ ашигладаг гэжээ. Бага ангийнхтай харьцуулахад сурах бигийн зургийг нь хардаг гэсэн хүүхдүүдийн хувь буурсан байна. Энэ нь анги дээшлэх тусам сурах бичгийн зургийн эзлэх хувь буурдагтай холбоотой байж болох юм. Харин дасгал, даалгаврыг нь ажилладаг гэсэн хүүхдийн хувь өссөөн бол сорил туршилт хийхэд ашигладаг гэсэн нь бага ангийнхаас буурсан байна. Сурах бичгийн хувьд дасгал, даалгаврыг нь хийдэг нь 75.3 хувь**, эхийг нь уншдаг нь 69.3 хувь**, хуулж бичдэг нь 66.6 хувь байна. Монгол хэл, уран зохиол, англи хэлний сурах бичгүүдийн хувьд ихэвчлэн эхийг нь уншдаг бол үндэсний бичиг, түүх, нийгэм судлал, иргэний боловсрол сурах бичгүүдийн хувьд хуулж бичдэг нь зонхилж байна.

Сурах бичиг, сургалтын хөтөлбөрийн уялдааны талаар багш нар, “холбоотой, уялдаатай байдаг” гэж олонх нь үзэж байна.Багш нар, сурах бичгийн хангамж, хүртээмж муутай, хангалтгүй, худалдаж авах гэхээр олддоггүй эсвэл үнэтэй байдаг, ялангуяа ахлах ангийн сурах бичиг байхгүй учраас хуучин сурах бичиг ашиглаж байгаа гэв.

Хүүхдүүдийн 1/3-ийг сурах бичгээр хангадаг гэдэг ч бодит байдал дээр хүрэлцээ муу байна. Гадуур худалдаанд өгчихсөн нь хэд дахин үнэтэй зараад байна.Сургууль дээр хүргэж өгөх замыг нь хянах хэрэгтэй.

*Нийслэлийн сургуулийн багш*

Англи хэл болон хөгжмийн хичээлийн сурах бичиг нь CD-тэй байдаг ч ирдэггүй, ирсэн ч хүрэлцээгүй байдаг, худалдаж авах боломж байдаггүй гэсэн байна.

6, 7 дугаар ангийн монгол хэлний сурах бичгийн агуулга хүнд, заах цаг хүрэлцдэггүй, ойлгож байгаа ч заавал нэмэлтээр хэлж өгдөг.

*Нийслэлийн сургуулийн багш*

Сурах бичгийн ашиглалтыг хичээлийн явцад авч үзэхэд дараах дүр зураг харагдаж байна.

*Зураг 61. Хичээл дээр сурах бичигтэй сурагчдын эзлэх хувь, судлагдахуунаар (8 дугаар анги)*




Дунд ангид хичээл дээр сурагчдын дунджаар 50 хувь нь сурах бичигтэй байна. Нийгэм судлал, түүхийн хичээлд сурах бичигтэй сурагчдын хувь цөөн байна.

Сурах бичгийн хангалт, хүртээмж дунд ангийн сурагчдын хувьд анхаарах асуудал бөгөөд хүртээмжээс гадна түүний ашиглалтыг сайжруулах талаар багш нар тодорхой саналууд гаргаж байна. Багш нар сурах бичгийг сайжруулахдаа, сэдэв хоорондын уялдаа холбоог сайжруулах, мөн онолын мэдлэгийг ахиу тусгах шаардлагатай гэж үзэж байна. Түүнчлэн сурах бичгийг дагалдсан бие даалтын дэвтэр эсвэл дасгал, даалгаврын дэвтэр шаардлагатай байгааг дурдсаны дээр ерөнхий боловсролын сургуульд ажилладаг багшийг сурах бичиг боловсруулах багт ажиллуулах, дээд түвшинд бус хүүхдэд хэрэгцээтэй түвшинд боловсруулах хүсэлтийг тавьжээ. Мөн сурах бичгийн хангамж, хүртээмжийг сайжруулах, түрээсийн тогтолцоог оновчтой нэвтрүүлэх, сурах бичгийг борлуулдаг албан ёсны сүлжээ бий болгох нь нэмэгдсэн үнээр бус, үйлдвэрийн үнээр авах боломжтой болох юм гэсэн байна.

## Багшийн ном

Багшийн ном нь сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг болж буй эсэх талаар багш нартай ярилцахад ерөнхийдөө хэрэгтэй бөгөөд дэмжлэг болдог, ялангуяа арга зүйн хувьд хэрэгтэй, жишиг даалгавар, аргачлалыг оруулсан байдаг гэсэн хариултыг өгсөн байна.

Багшийн ном багшид маш хэрэгтэй. Багшийн номоос л шинэ арга зүйгээ олж авдаг.

*Орон нутгийн сургуулийн багш*

Багшийн номтой холбоотой санал байгаа эсэх талаар тодруулахад хүрэлцээ, хангамж хангалтгүй байдаг нь гол бэрхшээл болж байгаа талаар нийслэлийн болон орон нутгийн ерөнхий боловсролын сургуулиудын сургалтын менежерүүд болон багш нар ярьсан байна.

Багшийн номгүй нь бэрхшээлтэй байгаа талаар багш нар асуудал дэвшүүлснээс гадна багшийн номыг байнга ашигладаг ч үг, үсгийн алдаа их байхын зэрэгцээ хариу алдаатай байдаг талаар анхааруулав. Багшийн номтой холбоотой дараах саналуудыг багш нар хэлсэн. Үүнд:

- Багшид зориулсан зөвлөмж болон сургалтын сонирхолтой аргуудыг сайн оруулах,
- Багшийн номыг дахин шинэчлэх шаардлагатай,
- Үнэлгээний шийдлүүдийг тусгах,
- Нэр томьёог цухас дурдсаныг илүү тодорхой, түлхүү оруулах гэх мэт.

> 6-9-р ангид цөм хөтөлбөр хэрэгжиж эхэлж байх үед багшийн номтой байсан. Тэрээр хамгийн ойлгомжтой сайн болсон байсан. Өөр мэргэжлийн багш ч түүнийг хичээлдээ ашиглах боломжтой байсан.
>
> *Нийслэлийн сургуулийн багш*

### *Сурах бичиг, багшийн номоос гадна ашигладаг нэмэлт ном, гарын авлага*

Багш нар өөрсдийн ашигладаг нэмэлт гарын авлага нь цөм хөтөлбөртэй холбогддоггүй, олимпиад, уралдаан тэмцээнд зориулсан байдаг, ийм төрлийн гарын авлага бага байдаг, интернэтээс нэмэлт мэдээлэл авдаг гэжээ. Түүнээс гадна хуучны сурах бичиг ашигладаг талаар багш нар цөөнгүй дурдаж байсан.

Судалгааны явцад багш нарын дурдсан нэмэлт ном, гарын авлагыг ашиглаж буй шалтгааныг тодруулахад, сурах бичигт бие даах ажил, дасгал дутагдалтай, сурагчдын үзсэн зүйлийг бататгах даалгавруудыг нэмэлтээр ашиглах шаардлагатай учраас тэдгээрийг ашигладаг гэв. Багш нарын сургалтад ашигладаг нэмэлт материалуудад бодлого бодох аргачлалтай, туршилт орсон тул чухал талаар байгалийн ухааныхан дурдаж байна. Мөн элсэлтийн ерөнхий шалгалтын номыг дунд, ахлах ангийн багш нар өгсөн байна.

Судалгаанд хамрагдсан хувийн хэвшлийн сургуулиудын багш нар бусад сургуулиудын багш нартай ижил мэдээлэл өгсний дээр өөрсдөө гадаад хэлнээс орчуулж хичээлдээ хэрэглэдэг, интернэт эх сурвалж болон сургуулиас нь гаргасан сургалтын материалыг ашигладаг гэв.

### *Сургалтын хэрэглэгдэхүүн*

Техник хэрэгсэл, хэрэглэгдэхүүний хангамж дутагдалтай байгаа сургалтын менежер болон багш нар асуудал тавьж байна. Тухайлбал, мэргэжил буюу судлагдахуунаас хамаарч тоног төхөөрөмж хомс, үзүүлэн, хэрэглэгдэхүүн хангалтгүй, бичгийн цаас зэргийг багш нар өөрсдөө худалдаж авдаг, тарааж өгөх материалыг өөрсдөө олшруулдаг гэж багш нар хэлсэн бол интернэтэд холбогдсон ч хурд муу, дутагдалтай байдаг. Нэн ялангуяа байгалийн ухааны сургалтын хэрэглэгдэхүүн, орчин хангалтгүй гэж сургалтын менежерүүд онцолж байна.

*Зураг 62. Сургалтад ашигласан бусад төхөөрөмж, үзүүлэн (8 дугаар анги)*




Суурь боловсролын түвшинд лабораторийн үзүүлэн, амьд үзүүлэн ашиглаагүй бөгөөд хэвлэмэл үзүүлэнг судалгаанд хамрагдсан багш нар биет болон цахим, дэлгэцийн тоног төхөөрөмжөөс түлхүү ашигласан нь харагдаж байна.

*Зураг 63. Сургалтад тарааж өгөх материал ашигласан байдал (8 дугаар анги)*




Ажиглалт хийсэн хичээлийн 40 орчим хувьд таракааж өгөх материал ашиглаагүй ба бэлэн эхийг цөөнгүй ашигладаг байна.

Багш нар самбарт гаргацтай, харагдахуйц бичдэг боловч сурагчдад самбараас мэдээлэл авах хангалттай хугацааг тэр бүр олгож чадахгүй байна.

*Үнэлгээ, дүгнэлт*

Багш нарын цөөнгүй нь явцын үнэлгээнд үндэслэн сурагчдыг чиглүүлэх, зөвлөн туслахад өөрчлөлт орсон гэж үзсэн бол олонх нь үнэлгээний даалгавар боловсруулах, явцын үнэлгээний аргыг сонгож, үр дүнтэй хэрэглэх, ээлжит хичээлийн төлөвлөлт явцын үнэлгээний арга, хэрэгслийг тусгахад бага зэрэг өөрчлөлт гарсан гэжээ.

Судалгаанд хамрагдсан багш нарын 69.7 хувь нь сурагчийн өөрийн үнэлгээ, 65.0 хувь сурагчдаар бие биенийг нь үнэлүүлэх аргыг *зарим хичээлд* ашигладаг гэсэн байна. Үнэлгээний аргуудыг бүх хичээлд тодорхой хэмжээгээр ашигладаг гэсний дунд хичээлийн явцад ажиглах, асуулт тавих, тэмдэглэл хөтлөх аргуудыг нэлээд дурдсан байна. Үнэлгээний арга, хэлбэрүүдийг хичээлдээ ашигладаггүй гэж хариулсан багш

нарын хувь бага байгаагаас үзэхэд багш нар үнэлгээний төрөл бүрийн арга, хэлбэрийг хичээлдээ ямар нэг байдлаар хэрэглэдэг байна.

Багш нар явцын болон үр дүнгийн үнэлгээг дараах зорилгоор сургалт, үйл ажиллагаандаа хэрэглэж байгаа ажээ. Үүнд:

- Сурагчдын ахицыг үнэлэх,
- Сурагчдыг идэвхжүүлэх, сонирхлыг сайжруулах,
- Сурагчдыг оношлох,
- Өөрийн боловсруулсан хөтөлбөр, төлөвлөгөөнд анализ хийх гм.

Сурагчдыг үнэлж, дүгнэхэд тулгардаг бэрхшээлийн талаар багш нараас тодруулахад "үнэлгээг 8 түвшинтэй болгосон, шалгуур тодорхойгүй", "үнэлгээний талаарх эцэг эхийн ойлголт хангалтгүй", "ялгаатай даалгавар боловсруулахад хүндрэлтэй байдаг", "журнал хөтлөхөд бэрхшээлтэй" гэсэн нийтлэг хариултыг өгчээ. Түүнчлэн үнэлгээ, үнэлгээний журам ойр ойрхон өөрчлөгдөж байгаа нь хүндрэлтэй байна гэдэгтэй ихэнх багш нар санал нийлжээ.

Судалгаанд хамрагдсан нийслэлийн сургуулийн сургалтын менежерүүд ялгаатай байр суурь илэрхийлсэн байна. Тухайлбал, "Сургалтын менежерийн үүрэг бол хяналт шинжилгээ үнэлгээ бол өдөр тутмын ажил. Хүндрэл бэрхшээл байхгүй."; "Хүүхдийг үнэлэх дээр толгой эргэчихээд байгаа. Одоогийнх боломжийн юм шиг байснаа 8 түвшин болоод ирэхээр бас асуудал байнаа" гэх мэт болно.

Явцын үнэлгээг нэгжийн үнэлгээнд хамааруулахгүй байгаа нь оновчгүй, үнэлгээ 8 шалгууртай болсон нь бэрхшээлтэй байна.

*Орон нутгийн сургуулийн багш*

*Харин сурагчдын хувьд*, үнэлгээнд хэр сэтгэл ханамжтай байдаг талаар тодруулахад сэтгэл ханамжтай гэж 75.0 хувь нь, сэтгэл ханамжгүй гэж 25.0 хувь нь хариулжээ.

Багш шударга үнэлдэг гэж би боддог. Жишээ нь би биологид 60.0 хувь авсан. Аав, ээж маань намайг зэмлээд би хичээгээд дараагийн шалгалтад 90.0 хувь авсан. Тэгээд би үнэхээр 60.0 хувь байснаа ойлгосон.

*Орон нутгийн сургуулийн дунд ангийн сурагч*

Багшийн болон бусад хүүхдийн өгсөн үнэлгээнээс цаашид юун дээр анхаарахаа мэдэж авч чаддаг уу гэсэн асуултад бүгд "тийм" гэсэн хариултыг өгсөн.

Сурагчдын сурлагын амжилтыг бодитой үнэлдэг багш нарын туршлага, арга замын талаар цааш дэлгэрүүлэн ярилцахад гарааны үнэлгээ хийдэг, сайшааж магтвал хүүхэд урамшдаг, улирал бүр хичээл бүрээр хөндлөнгийн үнэлгээ хийлгэдэг гэсэн хариултуудыг судалгаанд хамрагдсан багш нар хэлжээ.

Сургууль, багш нар суралцагчдын үнэлгээний үр дүнд шинжилгээ хийж, сургалтын чанар, үр дүнг сайжруулах талаар ямар үйл ажиллагааг зохион байгуулах хэрэгтэй гэж үзэж байна вэ? гэсэн асуултад багш нар харилцан адилгүй хариулсны дотор харьцуулсан үнэлгээ хийх хэрэгтэй буюу нийслэл, дүүргүүдийн өөр өөр сургуулиудтай харьцуулах, эцэг эхийн анхаарал чухал, сурлагаар хоцорч буй сурагчдын судалгаа гаргаж байгаад улирал, сар бүр ахиулж явдаг гэж нийслэлийн сургуулиудын багш нар хэлсэн бол

нэгдлийн ахлагч нар хичээлд суудаг, ахлах ангийн багш нар зөвлөгөө өгдөг гэх мэтээр хэрэгжүүлж буй аргуудаасаа орон нутгийн багш нар хуваалцсаны зэрэгцээ цаашид сурагчдын ахиц, амжилтыг ахиулахад хугацаа их хэрэгтэй, хөндлөнгийн үнэлгээг бодитой хиймээр байна гэсэн санаануудыг өгчээ.

> Хүүхэд өглөөгүүр хичээлороод, үдээс хойш хөгжүүлэх хичээл орвол тэр хүүхдэд ахиц, амжилт гарах байхаа. Цаг их байвал сурагчид хөгжих боломж бий.
>
> *Орон нутгийн сургуулийн багш*

Сургуулийн зүгээс *багш нарын ажлыг хэрхэн үнэлдэг*, үнэлгээнд юуг чухалчлан авч үздэг болон хэр бодитой байгаа талаар судалгаанд хамрагдсан сургуулийн менежерүүд, багш нартай ярилцав. Багшийн ажлыг үнэлэхдээ БСШУС-ын сайдын 293 тоот тушаалаар батлагдсан үнэлгээний журмыг баримталдаг бөгөөд олон янзын үйл ажиллагаа явуулж, үнэлгээний мэдээллийг цуглуулдаг талаар сургалтын менежерүүд болон багш нар ярьжээ. Тухайлбал, "багшийн ажлын үр дүнгийн тайлан авч үнэлдэг" гэж багш нар бүгд хариулсан байгаа нь багшийн ажлыг үнэлж, дүгнэх журам хэрэгжиж байгааг илэрхийлж гэж судлаачид үзжээ.

Багш нарын ажлын үнэлгээнд хөндлөнгийн үнэлгээ, элсэлтийн ерөнхий шалгалтад сурагчдын үзүүлсэн амжилт, олимпиад, уралдаан тэмцээнд байр эзэлж, амжилт гаргасан байдал зэргийг голчилдогийн зэрэгцээ багшийн өөрийн оролцоог хардаг гэж сургалтын менежерүүд, багш нар үзэж байна.

> Бидний хамгийн гол үнэлгээ нь үр дүн шүү дээ. 40 хувиас хэтрэхгүй гэдэг юм яваад байна. Үндсэн цалин, нэмэгдэл, тэмцээн уралдааны нэмэгдэл гээд энэ бүгд нийлээд 25 хувь л болдог.
>
> *Орон нутгийн сургуулийн багш*

Сургалтын менежерүүд багшийн ажлын үнэлгээнд ЗАН, секц зэрэг нэгжүүд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд эдгээр нэгжээс тухайн багшийн ажлын үнэлгээний гол гол мэдээлэл цуглардаг бололтой. Багш нарын ажлын үнэлгээний шалгуурт ажлын гүйцэтгэл, нэгж хичээлийн төлөвлөлтийн боловруулалт, сайжруулалт, сурагчийн сургалтын чанарт ахиц, амжилт гарсан байдал зэрэг шалгууруудыг түгээмэл нэрлэсэн байна. Хамгийн гол нь багшийн үнэлгээг улирлын үр дүнгийн урамшуулалтай холбож өгдөг гэдгийг сургалтын менежерүүд болон багш нар санал нэгтэй хэлжээ.

Орон нутгийн сургуулийн сургалтын менежерүүд багш нарын ажлыг үнэлэхдээ урамшууллаас гадна хариуцлага хүлээлгэдэг ажээ. Тухайлбал, багш, ажилчдын мөрдөх дэг баталсан сургууль энэ дэгийг зөрчвөл сануулах хуудас өгдөг бөгөөд 3 удаа сануулах хуудас авсан бол захиргааны хариуцлагыг хөдөлмөрийн гэрээнд заасан дагуу оногдуулдаг байна. Түүнчлэн сурлагын амжилт буурсан ангид багш нар давтлага өгдөг, сурагчдын хоцрогдолд анхаарахын зэрэгцээ алданги тооцох хариуцлага хүлээлгэдэг гэжээ.

Багшийн ажлын *үнэлгээ хэр бодитой* байгаа талаар хотын багш нар тодорхой хариулт өгөөгүй бол орон нутгийн багш нар "бодитой бус, ашиг сонирхлын зөрчил байдаг, өөрийн үнэлгээ хийдэг ч бууруулдаг, дардаг" гэх мэтээр хариулсан нь сэтгэл хангалуун бус байгааг илэрхийлж байна. Түүнчлэн зарим бэрхшээлтэй талуудыг дурдсан нь:

- багш нарт ачаалал үүсгэж байна, цаг наргүй, хагас бүтэн сайнгүй ажилладаг,
- бичиг цаасны ажил их хийдэг, бичиг цаасаар ажлаа үнэлүүлдэг,
- эцэг эхээс санал асуулга авдаггүй, зөвхөн сургуулийн удирдлагууд багшийн ажлыг үнэлдэг,
- судалгаа хэрэгтэй байна,
- олон нийтийг хамарсан ажилд оролцдогийг үнэлдэггүй гэх мэтээр шүүмжлэлтэй хандаж байсан ч багш нар ажлаа сайтар төлөвлөдөг нь сайшаалтай, багшийн хийсэн ажлууд, бага дундын залгамж холбоо бүрдүүлэхэд чиглэсэн сайн талтай гэсэн эерэг хариултуудыг өгсөн байна.

> Секцийн ахлагч, эцэг эхийн төлөөлөл орох ёстой ш дээ. Менежер захирал ярьж байгаад удирдлага үнэлж байна. Багш, эцэг эхийн төлөөлөл байхгүй.
>
> *Орон нутгийн сургуулийн багш*

Судалгаанд хамрагдсан нийслэл болон орон нутгийн сургуулиудын сургалтын менежерүүдтэй сурагч, багшийн үнэлгээний чиглэлээр дараах онцлох ажлуудыг аймгууд хэрэгжүүлж буй жишээ байна. Үүнд:

- Аймаг (1)-ийн нэгэн сургууль нь хичээл болгоноор эзэмших чадваруудыг гаргаж ангиуддаа байрлуулдаг, тухайн улирал, жилд ямар хичээлээр ямар ямар чадвар эзэмшихийг багш, эцэг эх, хүүхдүүд өөрсдөө мэдэж байдаг, тэдгээр чадваруудаар нь түвшин тогтоодог сайн туршлага байна. Тухайн сургууль түвшин тогтоосон дүнг хүүхэд, анги тус бүрээр гаргаж, ярилцдаг ажээ.
- Аймаг (3)-ын хувьд сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт үнэлгээг багшийн боловсруулсан жилийн төлөвлөгөөнд үндэслэн жил, нэгжийн хяналтыг хэзээ хийхээ тохирч, багш өөрөө чиглэлээ гаргаж нэгж сэдвийн хүрээнд боловсруулсан жишиг даалгавраар шалгалт авах ажлыг хэвшүүлсэн бөгөөд дахин хөндлөнгийн үнэлгээр баталж шалгадаг, 3-4 судлагдахууны хөтөлбөрийн хэрэгжилтийг сурагчдын чадвараар үнэлээд, бусдыг нь сурагчдын онолын мэдлэгээр шалгадаг гэжээ. Ийм жишээ нийслэлд ч байх бөгөөд хүүхдүүдээс түүврээр шалгалт авч, эцэг эхтэй нь хамтарч ажилладаг, захиалгат шалгалтыг мөн авдаг байна. Багш нар шалгуулах захиалгыг гол төлөв 1, 3 дугаар улиралд өгдөг бөгөөд сэдвийн захиалга ч өгдөг байна.
- Үүнээс гадна графикийн дагуу шалгалт авч, ямар арга зүйгээр заасан нь үр дүнтэй байна, ямар нь үр дүнгүй байгаа талаар багштай ярилцаж, сайжруулах чиглэээр ажиллахын зэрэгцээ сар бүр дааж авсан ажлаар үнэлдэг арга ч байна.

> Графикын дагуу шалгалтаа авч, ямар арга зүйгээр заасан нь үр дүнтэй байна, ямар нь үр дүнгүй байгаа талаар багштай ярилцаж, сайжруулах чиглэлээр ажиллаж байна. 273 хүүхдэд гарааны үнэлгээ хийсэн. Хүүхдийн суурь чадварыг ахиулах зорилгоор унших чадвар сул хүүхдийг цуглуулж тэдэнтэй ажиллаж байна. Сэдвийн шалгалт авч хоцрогдолыг тооцож явдаг.
>
> *Орон нутгийн сургалтын менежер*

Багш нар сургуулийн мэргэжил, арга зүйн нэгж (тэнхим, ЗАН, секц)-ийн үйл ажиллагааг хэрхэн үнэлдэг талаарх, сургалтын менежерүүд хичээлд ажиглалт хийж зөвлөгөө өгдөг,

туршлагатай багш нарын туршлагаас хуваалцдаг, тэнхим, секцээрээ сарын ажил зохион байгуулдаг гэсэн хариултыг хотын сургуулийн багш нар өгсөн бол ямар нэг байдлаар хамтран ажилладаг гэсэн ерөнхий хариултыг орон нутгийн сургуулиудын багш нар өгчээ.

Мөн сургуулиудын хувьд багш нараар өөрсдөөр нь төлөвлөгөө гаргуулж сурлагын амжилт ахиулах ажлыг хийлгэдэг. Тэдний хувьд үнэлгээний даалгавар боловсруулах, шалгууртай холбоотой хүндрэл бэрхшээл гардаг байна.

> Даалгаврын тавил. Дээрээсярихдаа хүүхдийн түвшинд тохирсон байх ёстой гэж ярьдаг. Гэтэл бид нар нэг жил түвшний даалгавраар л шалгалт авч байна. Цөм хөтөлбөрт тухайн хүүхдийн түвшинд тохирсон даалгавар боловсруулж болно гэсэн зүйл байдаггүй. Дээрээс, болон БУСГ"-аас авч байгаа шалгалт яг л ижил түвшнийх байдаг. Үнэлгээний шалгуур тодорхой, түвшинчилж өгөх хэрэгтэй.
>
> *Орон нутгийн сургалтын менежер*

### *Хамтын ажиллагаа, оролцоо*

Сургалтын менежерүүд багш нарт мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, багшийг хөгжүүлэх ажлыг зохион байгуулахад ЗАН, мэргэжлийн секцийн болон судлагдахууны багийн оролцоо, хамтын ажиллагааг чухалчилж байна. Тэнхим, нэгдэл, секцүүд болон судлагдахууны багийн хийсэн ажил, гаргасан мэдээллээс цаашид хийх ажлаа тодорхойлдог ажээ. Мөн өөрсдөө сургалтын төлөвлөгөө, тэдэнд зориулсан сургалт, зөвлөмж зэргээс дэмжин туслах ажлаа олж хардаг байна. Зарим сургууль залуу багш нартаа (1-5 жил) ээлжит хичээл гэж юу юм, сайн хичээл юуг хэлэх, ээлжит хичээлийн элемент, хүүхэд эцэг эхтэй хэрхэн ажиллах талаар тусгайлан сургалт явуулдаг сайн туршлага байна.

Сургалтын менежерүүд нь хичээлд ажиглалт хийж, арга зүйн зөвлөгөө өгөх, ижил мэргэжлийн багш нар болон бусад багш нарын дунд хэлэлцүүлэг зохион байгуулах зэргээр багш нартай хамтарч ажиллахын зэрэгцээ сард 1 удаа багш нарын хурлыг зохион байгуулж, бүх талын мэдээллээр хангаж, зөвлөдөг талаар багш нар тодотгож байна.

Цаашид сургуулийн удирдлагаас ямар дэмжлэг, үйл ажиллагаа шаардлагатай талаар багш нар дараах саналуудыг гаргав. Үүнд:

- Сургалтын хэрэглэгдэхүүн, анги танхимын хүрэлцээ муу байгаагаас хичээлээс гадуурх үйл ажиллагааг амралтын өдрүүдэд зохион байгуулдаг нь ирц муу байх, идэвх сонирхол бага байх зэрэг эрсдэлтэй байгааг тооцох,
- Багш нар хамтран суралцаж хөгжих нөхцөл боломж, өрөө танхим хангалтгүй,
- Сургуулийн өргөтгөл барих асуудлыг нааштайгаар шийдүүлэх,
- Гурван ээлжтэй хүнд байна. Давтлага хийх өрөө байхгүй байна.
- БМДИ, Боловсролын хүрээлэн зэрэг холбогдох байгууллагууд баг бүрдүүлэн жилд дор хаяж нэг удаа багш нартай тулж ажиллан, тулгамдаж буй асуудлыг ярилцах, дээд шатны байгууллагад уламжлах гэх мэт.

> Мэргэжлийн байгууллагаас сургууль бүр дээр ирж санал бодлыг нь сонсох, багшийг хөгжүүлэх сургалт зохион байгуулах хэрэгтэй байна.
>
> *Орон нутгийн сургуулийн багш*

Сургалтын менежерүүд, олонх нь "Өөрийгөө хангалттай гэж хэлж чадахгүй", "Миний хувьд дундаж түвшинд", "Хангалттай гэж хэлэхгүй" гэх мэтээр өөрсдийн мэргэжлийн мэдлэг, чадварт шүүмжлэлтэй хандаж байна. Тэд сургалтын хөтөлбөрт шинээр туссан тодорхой чадвар шаардсан зүйлсийг хийхэд бэлэн биш байна гэж үзсэний дээр багш нараасаа хоцрогдох, хойно орох ч тохиолдол байгааг тэмдэглэсэн байна. Тэдний хувьд мэргэжлийн чиглэлээр сургалтад хамрагдаж, хэлний мэдлэгээ дээшлүүлэх, шинэ цахим программмуудыг сурах, өөрийгөө хөгжүүлэх явдал чухал байгаа ажээ.

Мэргэжилтнүүд мэргэжлийн хувьд хөгжих, багш нартаа мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэгийг хангалттай өгч чадахгүй байгаад дараах нөхцөл байдал нөлөөлдөг гэжээ. Үүнд:

- Захиргааны ажилд маш их цаг зарцуулдаг. Тухайлбал, хэлний зөвлөлийн тайлан бичих, ёс зүйн зөвлөлд ажиллах, төрийн байгууллага болон энэ тэндээс хийж буй эсээ зохион бичлэгийн уралдаануудыг зохион байгуулах гэх мэт. Намын ажлууд хүртэл маш олон зохиогдож ажил дээр ажил нэмдэг.
- Давхар давхар ажил, мөн судлагдахуунуудыг хариуцдаг. Тухайлбал, 2-3 судлагдахуунаас гадна эмч, дотуур байр зэргийг давхар хариуцан ажиллана.
- Цалин бага, багш нараас бага цалин авдаг.

> Бүтцийн нэг бодлоготой байгаасай л гэж боддог. Маш олон сургалт явагддаг. Хөдөөний багш нар бол хотоос ирсэн хүний үгийг л бодит үнэн гэж ойлгодог нь бэрхшээл. Хүн бүр дураараа ярьж, ойлгодог. Ойлголтын түвшинд өөр бус ижил байх ёстой.
>
> *Орон нутгийн сургуулийн сургалтын менежер*

Хичээл, сургалтын явцад олон чиглэл, хэлбэрээр тодорхой давтамжтайгаар эцэг эх, асран хамгаалагчидтай хамтран ажилладаг дүр зурагтай байна. Эдгээрээс багш нарын 34.0 хувь нь хүүхдэд тулгарсан асуудал, бэрхшээлийн талаар 14 хоногт нэг удаа эцэг эх, асран хамгаалагчидтай ярилцдаг, шийдвэрлэдэг; сургуулийн зорилго, хөгжлийн талаар улиралд нэг удаа мэдээлдэг гэж 49.2 хувь нь хариулсан байна. Цаг үеийн мэдээлэл, үйл явцын талаар сард нэг удаа мэдээлдэг гэж багш нарын 38.9 хувь нь, сурагчийн сурлагын ахиц, амжилт, өөрчлөлтийн талаар сард нэг удаа эцэг эхтэй хамтран ажилладаг гэж багш нарын 34.0 хувь хариулсан.

Сурагчдын сурлагын амжилтыг ахиулахад эцэг эх, асран хамгаалагчдын оролцоог багш нараар үнэлүүлэхэд дундаж гэж үнэлсэн дүр зурагтай байна. Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийнхээ сурлагын ахиц, өөрчлөлт болон хүмүүжил, төлөвшлийн талаар багшаас хааяа мэдээлэл авч, асууж ярилцдаг гэж багш нарын олонх нь буюу 60-аас дээш хувь нь хариулсан. Харин сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, хангахад оролцдоггүй гэж багш нарын 60 орчим хувь хариулсан нь энэ тал дээр эцэг эх, асран хамгаалагчдын оролцоонд сэтгэл хангалуун бус байгааг илтгэж байна.

Цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд үзүүлж буй дэмжлэг, хамтын ажиллагааг багшаар үнэлүүлэхэд ерөнхийдөө сайн гэж үнэлжээ. Ялангуяа, секц, заах аргын нэгдлүүд (ЗАН) болон сургалтын захирлыг дэмжлэг сайн үзүүлдэг гэж судалгаанд оролцсон багш нарын 50 гаруй хувь нь хариулсны зэрэгцээ сургалтын менежерийн дэмжлэг маш сайн байдаг гэж тал хувь нь үзжээ.

Багш нарын хувьд аймаг, нийслэлийн боловсролын газар зэрэг шат шатны холбогдох байгууллагууд, эцэг эх, асран хамгаалагчид тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлж, хамтран ажилладаг гэсэн бөгөөд боловсролын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагууд (ТББ)-ын тусламж, дэмжлэг, хамтын ажиллагаанд сэтгэл дундуур байгаа дүр зурагтай байна.

Суралцагч төвтэй сургалтын арга зүйг сургалтын явцад хэр ашигладаг талаар багш нар, хүүхэд хөгжих боломж олгодгоороо давуу талтай, хэрэгжүүлэхийг хичээдэг гэж үзэж байна. Мөн энэ арга зүй нь судлагдахууны онцлогоос хамааран хэрэгжүүлэх боломж нь өөр өөр байгааг дурджээ. Тухайлбал, математикийн хичээлийн хувьд багш төвтэй сургалтын арга зүй тохиромжтой, уламжлалт аргаар заах нь тохиромжтой байдаг талаар хот болон хөдөө орон нутгийн сургуулиудын багш нар дурдсан байна. Давуу тал нь хүүхдүүдийн үйл ажиллагаанд тулгуурладаг учраас бие дааж сурахад тустай гэж ялангуяа гадаад хэл, зураг болон дизайн технологийн багш нар дурджээ.

### *Сургалтыг дэмжих үйл ажиллагаа*

Сургалтыг дэмжих үйл ажиллагаа (СДҮА)-ны цагаар ямар үйл ажиллагааг голчлон явуулдаг, энэ нь сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг болж чадаж буй эсэх, СДҮА-г хэрхэн, яаж зохион байгуулбал үр дүнтэй байх талаар судалгаанд хамрагдсан сургалтын менежерүүд болон багш нараас мэдээлэл авсан болно.

Сургалтыг дэмжих үйл ажиллагааны цаг нь анги удирдсан багшийн мэдэлд байдаг, иймд ангийн ажилтай холбоотой зүйлсийг ярьж, шийдвэрлэхэд ихэвчлэн зарцуулдаг гэж ихэнх багш нар дурдсаны зэрэгцээ 7 хоногийн цаг нь хангалтгүй байгаа гэсэн хариултыг багш нар төдийгүй сургалтын менежерүүд нийтлэг өгчээ.

Судалгаанд хамрагдсан аймгуудын хувьд өөрсдийн хэмжээнд СДҮА-ны хүрээнд цуглуулсан сайн туршлага гэж үзэж болохоор дараах үйл ажиллагааг сургалтын менежерүүд онцолжээ. Тухайлбал:

- Аймаг хувьд СДҮА-гаар “Эко орчин бүрдүүлэх, уламжлалаа дээдлэх” зорилт тавьсан бөгөөд түүнд чиглүүлэн хүүхдийн хүсэл сонирхолд үндэслэн төлөвлөдөг ба тухайлбал, “Усны зөв хэрэглээ” сэдвийг хэрэгжүүлж ус шүүгч авч хэрэглэж байна. Ахлах ангид ажлын аялал хийдэг боловч ихэвчлэн танхимаар орж байгаа нь учир дутагдалтай гэжээ. СДҮА-г төсөлт ажилд тулгуурлан хийхэд оновчтой байдаг бөгөөд амьдрах чадварын хичээл гэж орж байхад харьцангүй үр өгөөжтэй байжээ.
- Аймаг (1)-ийн төвийн сургууль Иргэний боловсролыг хүүхдийг зөв хүн болгох, хичээлээс гадуурх үйл ажиллагааг эх оронч үзлийг төлөвшүүлэхэд илүү чиглүүлж, танхимын болон танхимын бус цагаар хэрэгжүүлэхээр төлөвлөдөг байна.
- Аймаг (4)-ийн хувьд СДҮА-аар сайн үйлсийн аян настай хүнд туслах, сумын хог цэвэрлэх, айлын хүүхдэд туслах гээд олон ажил санаачлан хийдэг. Өв соёлоо хамгаалах хүрээнд сумын нутагт дөрвөд түмний онцлогийг анхаарч мал ахуй, эд хогшил, нутгийн аялгууны үг хэллэгийг заах байдлаар зохион байгуулдаг.

СДҮА-ны цагийг зохих журмын дагуу заах юм бол дэмжлэг болно. Энэ цагаар хүүхдийг хүн болгох, амьдрах ухааны чадвар төлөвшүүлэх, шаардлагатай үед хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зүйлээ төлөвлөж оруулбал сайн л байх.

*Орон нутгийн сургуулийн багш*

Сургалтыг дэмжих үйл ажиллагааг хэрхэн, яаж зохион байгуулах нь үр дүнтэй талаар тодруулахад цагийг нэмэгдүүлж, 7 хоногт дор хаяж 2 цаг болговол үр дүнтэй байна гэсэн саналыг сургалтын менежерүүд болон багш нарын ихэнх нь өгсөнтэй сургалтын менежерүүд ч санал нэг байна.

Мөн СДҮА нь багш нарын цагийг нөхөх хичээл болсонд шүүмжлэлтэй хандсан бөгөөд цаашид бүжиг, үндэсний хөгжмийн дугуйлан хичээллүүлэх хэрэгтэй байгааг нэгэн аймгийн сургалтын менежерүүд анхааруулсан байна.

Хувийн сургуулиудын хувьд сургалтыг дэмжих үйл ажиллагааг мөн адил зохион байгуулдаг бөгөөд энэ нь зарим сургуулийн хувьд төрийн өмчийн сургуулиудаас эрт эхэлсэн түүхтэй байна. Энэ хүрээнд цуглуулсан сайн туршлага гэвэл СДҮА-г ерөнхий боловсролын түвшин бүрээр тусгай хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлдэг байна. Тухайлбал, дунд ангийн хувьд хөдөлмөр сургалтын төвтэй бөгөөд зун бүр сурагчид багш нартайгаа хамтран ажилладаг талаар сургалтын менежерүүд, багш нар ярьжээ. Түүнчлэн СДҮА-ны цаг нь анги удирдсан багш нарын мэдэлд байхын зэрэгцээ төрөл бүрийн үйл ажиллагааг зохион явуулдаг талаар хэлсэн байна. Тухайлбал, ерөнхий боловсролын түвшин бүрээр сургалтыг дэмжих үйл ажиллагааг тогтвортой зохион байгуулдаг туршлага хуримтлуулсан байна.

> Дунд ангиудад тодорхой нэршил бүхий хөтөлбөрүүд бий. Бүр зохицуулчихсан, одоо харин улам сайжруулах л ажил бий.
>
> *Нийслэлийн хувийн сургуулийн багш*

Мөн төсөлт ажлын хүрээнд ч хэрэгжүүлэх ажлуудаа багш, эцэг эх хамтдаа төлөвлөгддөг бөгөөд сургуулийн харьяанд байдаг хөдөлмөр зусланг түшиглэн ахлах ангиуд мал, монгол гэр барих, дунд ангид түүх, газар зүйн хичээлийн чиглэлээр дадлага ажил хийдэг байна.

Сургалтын дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх, зохион байгуулахад ямар нэг бэрхшээл тулгардаг талаар багш нар тодорхой мэдээлэл өгөөгүй бол ярилцлагад хамрагдсан сургалтын менежерүүд зарим бэрхшээлийг дурдсан байна. Тэд “Нөхцөл байдал нөөц бололцоо тооцоогүй зүйлс бидэнд нэлээд саад болж байна” гэж үзсэн бөгөөд үүний жишээг эрүүл мэндийн хичээл шинээр орохдоо бэлтгэлээ хангаагүй, эрсдэлийг тооцоогүй, жишээ нь бэлтгэсэн гэх ганц багш нь шилжсэнээр, анги удирдсан багш нар ангиатайгаа ажиллах цаггүй болсон, “Сайн хичээл үйл ажиллагаа” зогссон зэрэгтэй холбосон байна. Мөн “Дээрээс явуулж буй үйл ажиллагаа цаг үеээ олоогүй муу байна. Доод түвшинд хэрэгжилт маш сайн байгаа шүү” хэмээн сануулжээ.

Хичээлээс гадуурх үйл ажиллагаа, түүнд сурагчдын оролцооны талаар тодруулахад гар бөмбөгийн тэмцээн голдуу зохион байгууллагддаг анги нийтээрээ оролцдог гэсэн хариултыг өгсөн. Дугуйлан секцийн үйл ажиллагаандаа хэр сэтгэл ханамжтай байдаг уу асуултад бүгд эерэг хариулт өгсөн. Харин ямар дугуйлан, секц цаашид хэрэгтэй байгаа талаар асуухад шатар, хөгжмийн дугуйланг ихэвчлэн нэрлэсэн байна.

8 дугаар ангиас сагсан бөмбөгийн шигшээд явж байгаа. Дугуйлан биш шигшээ гэвэл ононо. Хүүхдүүд орох гэхээр “муу” хүүхдүүд гээд оруулдаггүй. Саяхан найрал дууны тэмцээн болж, 2 сар гаруй хичээлээс завсардсан. Түүнээс болоод сурлага муудсан. Тэгээд хичээлээс гадуурх тэмцээнд орохгүй гэхээр багш нь дургүйцэн харьцах хандлага нь ч гэсэн өөрчлөгддөг.

*Хичээлийн төлөвлөлтийг хэрэгжүүлэх байдлыг ээлжит хичээлийн түвшинд судалсан бөгөөд багш нар жилийн болон улирал, нэгж хичээлийн төлөвлөлтийг ээлжит хичээлийнхээс илүүтэй боловсруулдаг. Ээлжит хичээлийг төлөвлөлгүйгээр бусад төлөвлөгөөндөө тулгуурлан хичээлийг зохион байгуулах байдал цөөнгүй ч ээлжит хичээлийн төлөвлөлтийг илүү нарийвчлан боловсруулсан байна. Хичээлийн төлөвлөлтөд агуулгын хуваарилалтыг илүү тусгаж, харин зорилго, зорилт, үнэлгээний даалгаврыг тусгах нь бага байна. Хичээлийн төлөвлөлтийн дагуу ажиллахад цаг үеийн төлөвлөгдөөгүй ажлууд гарч ирдэг мөн хичээлд ашиглах нэмэлт хэрэглэгдэхүүний зардал олдохгүй байх нь бэрхшээл үүсгэж байна.*

*Ихэвчлэн анги нийтээр хичээлийг зохион байгуулсан сурагч төвтэй сургалт явагдаж байна. Мэдлэг бүтээхэд чиглэсэн сурагчдын оролцоонд тулгуурласан аргуудыг ашиглах нь бага боловсролтой харьцуулахад нэмэгдсэн хэдий ч тэдний идэвхтэй харилцаанд түшиглэсэн аргуудыг ашиглах нь сул байна.*

*Суурь боловсролын түвшинд сурах бичгийн хүртээмжийг авч үзэхэд, багшийн журналын тэмдэглэгээний хүрээнд 50 хувьтай байна. Багшийн номд жишиг даалгавар, тэдгээртэй ажиллах аргачлалыг тусгасан нь багш нарт дэмжлэг болж байгаа хэдий ч сургалтын бүтээлч аргуудыг тусгах шаардлагатай байна. Байгалийн ухаан, математик зэрэг судлагдахууны багш нар туршилт, бодлого бодох аргачлалыг тусгасан сургалтын нэмэлт хэрэглэгдэхүүн шаардлагатай байгааг онцолж байна.*

*Хичээлийг зохион байгуулахдаа цахим эх сурвалжаас материал ашиглах нь их байгаа ч сургуулийн сүлжээний хурд муу байгаа нь бэрхшээл үүсгэж байна.*

*Байгалийн ухааны лабратори түүний ашиглалт, мэдээлэл зүйн кабинетын хүртээмжийг сургуулийн зохион байгуулалтад түшиглэн нэмэгдүүлэх хэрэгцээ байна.*

*Багш нар үнэлгээний шинэ журмыг хэрэгжүүлэхтэй холбоотой шалгуур боловсруулж чадахгүй байна. Бага боловсролтой харьцуулахад сурагчдын өөрийн үнэлгээ болон* сурагчид *бие биеэ үнэлэх аргыг илүү ашиглаж байна.*

*Багшийн ажлын үнэлгээнд хичээлийн төлөвлөлт, сурагчийн ахиц амжилтыг шалгуур болгож байна. Гэхдээ багшийн ажлын үр дүнг үнэлэхэд сурагчдын олимпиад, уралдаан тэмцээнд байр эзэлж амжилт гаргасан байдлыг голчилж байна.*

*Сургалтыг дэмжих үйл ажиллагааны цагийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.*

*Хичээлийн төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд зөвхөн тухайн сургуулийн багш нар төдийгүй аймаг, дүүргийн түвшинд багш нар хамтран ажиллах нь нийтлэг байна. Харин төрийн бус байгууллагууд болон бусад оролцогч талуудтай хамтран ажиллах нь сул байна. Багш эцэг эхийн хамтын ажиллагаа сул, сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэхэд тэдний дэмжлэгийг илүү авдаг.*

## Математикийн сорилын гүйцэтгэлийн шинжилгээ

Суурь боловсролын 8 дугаар ангийн математикийн сорилын даалгавар нь мэдлэг ойлголт, мэдлэгээ хэрэглэх, асуудал шийдвэрлэх чадвар, арга барилыг үнэлэх 15 даалгавартай, сорилын нийт оноо 40 байна. А хэсэгт мэдлэг, ойлголтыг илрүүлэх 8 даалгавар, Б хэсэгт хэрэглээ, асуудал шийдвэрлэх чадварыг илрүүлэх 7 даалгаврыг боловсруулсан.

*Хүснэгт 52. Сорилын даалгаврын жин (Математик, 8 дугаар анги(*

| *Даалгаврын түвшин* | *Даалгаврын дугаар* | *Онооны хуваарилалт* | *Үнэлгээний жин* |
|---|---|---|---|
| Мэдлэг, ойлголт | А-1, 2, 3, 4, 5, 6, 7, 8 | 13 | 32.5% |
| Мэдлэгээ хэрэглэх чадвар | Б-1, 2, 3, 4, 5 | 16 | 40% |
| Асуудал шийдвэрлэх чадвар, арга барил | Б-6, 7 | 11 | 27.5% |
| Нийт | 15 даалгавар | 40 оноо | 100% |

*Зураг 64. Сорилын даалгаврын гүйцэтгэл (Математик, 8 дугаар анги)*




Сорилд хамрагдсан сурагчдын 76.7 хувь нь нийт сорилын 10 - 40 хүртэлх хувийг зөв гүйцэтгэсэн байна. Харин гүйцэтгэлийн арифметик дундаж нь 22.8 хувь, медиан нь 20 хувь, хамгийн өндөр гүйцэтгэл 80 хувь, хамгийн бага гүйцэтгэл 0 хувь байна. Сурагчдын гүйцэтгэл хэвийн тархалтын муруйгаас зүүн тийш хазайсан байна.

Нийт 15 даалгаврыг 27 чадвараар задалж, шинжилсэн үр дүнг харууллаа. Даалгавруудын найдвартай байдлын үзүүлэлт (0.878) сайн байна.

*Хүснэгт 53. Даалгаврын найдвартай байдал*

| Reliability Statistics | | |
|---|---|---|
| Cronbach's Alpha | Cronbach's Alpha Based on Standardized Items | N of Items |
| .878 | .904 | 27 |

*Хүснэгт 54. Сорилын даалгаврын хамаарал (Математик, 8 дугаар анги)*

| *Даалгав-рын дугаар* | *Даалгаврын зорилго* | *Correlation mat8_score* | *Mean* | *Maximum* | *Percent* |
|---|---|---|---|---|---|
| Д:1 | Рационал тоог хасах | .354** | 0.400 | 1.0 | 40.0 |
| Д:2 | $a^2 - b^2 = (a - b)(a + b)$ томьёогоор задлах | .308** | 0.559 | 1.0 | 55.9 |
| Д:3 | Өнцгийг тооцоолж олох | .552** | 0.439 | 1.0 | 43.9 |
| Д:4 | Зөв олон өнцөгтийн дотоод өнцгийг олох | .483** | 0.868 | 2.0 | 43.4 |
| Д:5 | Шугаман тэнцэтгэл биш бодох | .312** | 0.387 | 2.0 | 19.4 |
| Д:6 | Процентийг тооцоолж олох | .488** | 1.277 | 2.0 | 63.9 |
| Д:7 | Тоог өгсөн харьцаагаар хуваах | .484** | 1.296 | 2.0 | 64.8 |
| Д:8 | Дугуй диаграмм унших | .385** | 0.905 | 2.0 | 45.3 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| ЗД:1а | Ерөнхий гишүүний томьёо бичих | .335** | 0.031 | 1.0 | 3.1 |
| ЗД:1б | Дараалын гишүүнийг олох | .323** | 0.359 | 2.0 | 18.0 |
| **ЗД:2а** | Параллель шулууныг гурав дахь шулуунаар огтлоход үүсэх өнцгийн чанарыг хэрэглэх | .655** | 0.274 | 2.0 | 13.7 |
| **ЗД:2б** | | .621** | 0.112 | 1.0 | 11.2 |
| **ЗД:3а** | Шулууны тэгшитгэл шилжүүлэх | .374** | 0.032 | 1.0 | 3.2 |
| **ЗД:3б** | Налалтыг олох | -0.006 | 0.013 | 1.0 | 1.3 |
| **ЗД:3в** | Шулуун дээр орших цэгийг олох | .293** | 0.181 | 1.0 | 18.1 |
| **ЗД:4а** | Параллелограммын талбайг олох | .544** | 0.417 | 1.0 | 41.7 |
| **ЗД:4б** | Трапецийн талбайг олох | .663** | 0.229 | 1.0 | 22.9 |
| **ЗД:4в** | Гурвалжны талбайг олох | .599** | 0.137 | 1.0 | 13.7 |
| **ЗД:4г** | Тэгш өнцөгт гурвалжны талбайг олох | .637** | 0.259 | 1.0 | 25.9 |
| **ЗД:5а** | 5-д хуваагдах тооны магадлал олох | .582** | 0.264 | 1.0 | 26.4 |
| **ЗД:5б** | 11-д хуваагдах тооны магадлал олох | .433** | 0.127 | 1.0 | 12.7 |
| **ЗД:5в** | Дээрх 2 тооны алинд ч хуваагдахгүй байх магадлал олох | .451** | 0.105 | 2.0 | 5.3 |
| **ЗД:6а** | Координатын хавтгайд гурвалжин байгуулах | .467** | 1.276 | 2.0 | 63.8 |
| **ЗД:6б** | Гурвалжныг x=1 шулууны хувьд тэгш хэмээр хувиргах | .356** | 0.548 | 2.0 | 27.4 |
| **ЗД:6в** | Гурвалжныг параллель зөөлтөөр хувиргах | .396** | 0.173 | 2.0 | 8.6 |
| **ЗД:6г** | Гурвалжныг эргүүлэлтээр хувиргах | .292** | 0.049 | 2.0 | 2.4 |
| **ЗД:6д** | Асуудал шийдвэрлэх | .332** | 0.250 | 2.0 | 12.5 |

***. Correlation is significant at the 0.01 level (2-tailed). *. Correlation is significant at the 0.05 level (2-tailed).*

Математикийн сорилын 15 даалгавар тус бүрийн хариултыг сорилын нийт оноотой харьцуулахад задгай даалгаврын 3б хариултаас бусад даалгаврын хамаарлын статистик ач холбогдол өндөр байна.

*Мэдлэг, ойлголтыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Суурь боловсролын математикийн сорилын сонгох хариулттай 8 даалгаврын 7 нь хүндрэлийн түвшин тохиромжтой, 6 нь ялгах чадвар маш сайн, харин 5 дугаар даалгавар хэт хүнд, ялгах чадвар дунд байна. Сонгох хариултат даалгаврын хувьд 5 дугаар даалгавраас бусад даалгаврын гүйцэтгэл 40 – 64.8 хүртэл хувьтай байна.

*Хүснэгт 55. Сонгох даалгаврын гүйцэтгэл (Математик, 8 дугаар анги)*

| score 13 оноо | *N* | | *Mean* | *Median* | *Mode* | *Std. Deviation* | *Range* | *Minimum* | *Maximum* |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | *Valid* | *Missing* | | | | | | | |
| | | 0 | 6.1 | 6 | 6 | 3.1 | 13 | 0 | 13 |

Сонгох хариултат даалгаврын нийт оноо 13, үүнээс сурагчдын авсан онооны арифметик дундаж 6.1, медиан 6.0, моод 6.0 буюу дунджууд нь тэнцүү, хамгийн өндөр оноо 13, хамгийн бага оноо 0, далайц 13 байна.

5 дугаар даалгаврын зөв хариулт 19.4 хувь байгаа нь сурагчдын шугаман тэнцэтгэл биш бодох чадвар хангалтгүй, тэнцэтгэл бишийг хялбар хэлбэрт оруулах явцад техник алдаа их гаргаж байгааг харуулж байна.

Буруу хариултыг шинжилж үзэхэд Б хувилбарыг 34.5 хувь хамгийн олон сурагч сонгосон байгаа нь тэнцэтгэл бишийг хялбар хэлбэрт зөв оруулсан боловч, тэнцэтгэл бишийн хоёр талыг сөрөг тоонд хуваахдаа тэнцэтгэл бишийн тэмдгийг өөрчлөөгүйгээс алдаа гарсан байна. Харин В ба Г хариултыг сонгосон сурагчид хаалт задлах, төсөөтэй гишүүдийг эмхэтгэх явцад алдаа гаргасан байна.

*Задгай хариулттай даалгаврын шинжилгээ*

Б хэсгийн 1-ээс 7 хүртэлх задгай хариулттай даалгавруудын гүйцэтгэлийг харахад параллелограммын талбайг олох даалгаврын гүйцэтгэл 41.7 хувь, өгсөн координаттай цэгүүдээр гурвалжин байгуулах даалгаврын гүйцэтгэл 63.8 хувь, бусад даалгавруудын гүйцэтгэл доогуур түвшинд байна.

*Хүснэгт 56. Задгай хариулттай даалгаврын гүйцэтгэл (Математик, 8 дугаар анги)*

| *Mean* | *Std. Deviation* | *Median* | *Minimum* | *Maximum* | *Range* |
|---|---|---|---|---|---|
| **3.0** | 3.4 | 2 | 0 | 20 | 20 |

Б хэсгийн задгай хариулттай даалгаврын нийт оноо 27 бөгөөд сорилд хамрагдсан сурагчдын онооны арифметик дундаж 3.0, медиан 2.0, хамгийн өндөр оноо 20, хамгийн бага оноо 0, далайц 20 байна.

Задгай даалгавруудын хувьд 3б хариултаас бусад даалгаврын хариултууд эерэг хамааралтай, найдвартай байдал сайн байна.

*Хүснэгт 57. Даалгаврын найдвартай байдал (Математик, 8 дугаар анги)*

| Reliability Statistics | |
|---|---|
| Cronbach's Alpha | N of Items |
| .860 | 20 |

Эдгээрээс хамгийн бага гүйцэтгэлтэй даалгаврыг авч үзье.

*3 дугаар даалгаврын шинжилгээ*

3 дугаар даалгаврын хувьд өгсөн шулууны тэгшитгэлийг $y = kx + b$ хэлбэрт оруулах (3.2 хувь) , шулууны налалтыг олох (1.3 хувь) чадвар маш хангалтгүй байсан бөгөөд шулууны тэгшитгэлийг $y = kx + b$ хэлбэрт оруулсан сурагчид налалтыг шууд бичих боломжтой байсан. Иймд “налалт” гэдэг үгийн утгыг сурагчид сайн ойлгоогүйтэй холбоотой болов уу. Энэ нэр томьёог өмнө нь “шулууны өнцгийн коэффициент” гэж нэрлэн багш, сурагчид олон жил хэрэглэж ирсэн бөгөөд 2015 оноос Суурь, БДБ - ын математикийн сургалтын цөм хөтөлбөрт шинээр орж ирсэн англи хэлний “gradient” гэсэн үг юм. Харин энэ даалгаврын хувьд шулуун дээр орших цэгийг олох чадвар18.1 хувьтай байсан байна.

*Сурах арга барил, асуудал шийдвэрлэх чадварыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Математикийн сургалтын цөм хөтөлбөр, суралцахуйн удирдамж, сурах бичигт геометрийн байгуулалт, хувиргалтыг дадлага ажил хийх явцад тодорхой арга, техникийн дагуу гүйцэтгэж, мэдлэг бүтээх арга зүйг тусгасан. Иймд математикийн цөм хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх зорилгоор Б хэсгийн задгай хариулттай 6 дугаар даалгавар (байгуулах, хувиргалт хийх арга техникийг илрүүлэх), 7 дугаар даалгавар (асуудал шийдвэрлэх чадварыг илрүүлэх)-ыг оруулсан болно.

6 дугаар даалгаврын гүйцэтгэл 25.6 хувь, 7 дугаар даалгаврын гүйцэтгэл 12.5 хувь байна. Эдгээр даалгаврын хариултыг шинжилж үзье.

*Сорилын 6 дугаар даалгаврын шинжилгээ*

Сорилын 6 дугаар даалгаврын хувьд координатын хавтгайд өгсөн координаттай цэгүүдийг тэмдэглэж, гурвалжин байгуулах чадвар сайн (63.8 хувь), харин өгсөн гурвалжныг шулууны хувьд тэгш хэмээр хувиргах (27.4 хувь), параллель зөөлт (8.6 хувь), эргүүлэлтээр хувиргах (2.4 хувь) чадвар хангалтгүй байна.

Сорилын 6 дугаар даалгаврын хувьд координатын хавтгайд өгсөн координаттай цэгүүдийг тэмдэглэж, гурвалжин байгуулах чадвар сайн (63.8 хувь), харин өгсөн гурвалжныг шулууны хувьд тэгш хэмээр хувиргах (27.4 хувь), параллель зөөлт (8.6 хувь), эргүүлэлтээр хувиргах (2.4 хувь) чадвар хангалтгүй байна.

*Сорилын 7 дугаар даалгаврын шинжилгээ*

Сорилын 7 дугаар даалгавар нь 8 дугаар ангийн сурах бичгийн даалгавар бөгөөд зурагт өгсөн хоёр квадратаас тогтсон нийлмэл дүрсийн талбайг зарим сурагчид (34.5 хувь) квадратуудын талбайн нийлбэр олох, нийлмэл дүрсийг тэгш өнцөгт болгон гүйцээх аргаар олсон боловч энэ тооцооллыг хийхгүйгээр зураг дээрээс төсөөтэй гурвалжныг олж, төсөөгийн харьцааг зөв бичих нь хамгийн чухал байлаа. Төсөөгийн харьцааг зөв бичсэн (12.5 хувь) сурагчид гурвалжны талбайг олох явцад алдаа гаргасан тул 3 оноо авсан сурагч байхгүй байгаа нь танил бус нөхцөлд мэдлэгээ хэрэглэх буюу асуудал шийдвэрлэх чадвар хангалтгүй байгааг харуулж байна. Мөн сурах бичиг дэх асуудал шийдвэрлэх даалгавруудад багш нар анхаарал хандуулж ажиллах шаардлагатай байна.

Суурь боловсролын математикийн сорилын үр дүнгээс харахад:

- Сорилын судалгаанд хамрагдсан сурагчдын сонгох хариулттай даалгаврын гүйцэтгэл 40–64.8 хүртэл хувьтай байна. Харин сурагчдын шугаман тэнцэтгэл биш бодох даалгаврын гүйцэтгэл хангалтгүй байна.
- Сурагчдын задгай даалгаврын гүйцэтгэл маш хангалтгүй байна. Даалгавар тус бүрээр авах максимум оноог цөөхөн сурагчид авсан байгаа нь сургууль, сурагчдын түвшин харилцан адилгүй байгааг харуулж байна. 1-5 дугаар задгай даалгаврын гүйцэтгэлээс харахад сорилд хамрагдсан ихэнх сурагчдын мэдлэгээ хэрэглэх чадвар муу байна. Харин 3б даалгавар сөрөг хамааралтай гарсан нь сурагчид цөм хөтөлбөрт шинээр орж ирсэн нэр томьёо болох “налалт” гэдэг үгийн утгыг сайн ойлгоогүй, хэрэглэж хэвшээгүйтэй холбоотой байх магадлалтай байна.
- Суурь боловсролын математикийн сургалтын цөм хөтөлбөрт геометрийн агуулгын эзлэх хувь нэмэгдэж, арга зүйн өөрчлөлт орсонтой холбоотойгоор геометрийн байгуулалт, хувиргалт хийх арга, техникийг 6 дугаар даалгавраар (8 оноотой) илрүүлэхийг зорьсон боловч, сорилд хамрагдсан ихэнх сурагчдын координатын хавтгайд дүрс байгуулах чадвар сайн, харин дүрсийг тэгш хэм, параллель зөөлт, эргүүлэлтээр хувиргах чадвар хангалтгүй байлаа. Гэхдээ цөөхөн сурагч энэ даалгаврыг бүрэн гүйцэтгэсэн байна. Харин геометрийн асуудал шийдвэрлэх даалгаврын хувьд (8 дугаар ангийн сурах бичгийн 44 дүгээр нүүр, 75 дугаар бодлого) гүйцэд бодсон сурагч байхгүй байна. Эндээс харахад багш нар сурах бичигт орсон хэрэглэх, асуудал шийдвэрлэх түвшний даалгаврууд дээр онцгой анхаарч, сурагчдаар ажилуулах нь чухал байгааг харуулж байна.

## Мэдээллийн технологийн сорилын гүйцэтгэлийн шинжилгээ

Суурь боловсролын 8 дугаар ангийн мэдээллийн технологи сорилын даалгавар нь мэдлэг, ойлголт, мэдлэгээ хэрэглэх чадварыг үнэлэх 5 даалгавартай. Мөн мэдлэгээ хэрэглэх чадвар, арга барил эзэмшилтийг үнэлэх даалгаврын эзлэх хувь өндөр байх зорилго тавьсан.

*Хүснэгт 58.Сорилын даалгаврын жин (Мэдээллийн технологи, 8 дугаар анги)*

| *Агуулга* | *Даалгаврын эзлэх хувь* | *Онооны эзлэх хувь* | *Гүйцэтгэлийн дундаж* |
|---|---|---|---|
| Мэдлэг, ойлголт | 60 | 30 | 37.3 |
| Мэдлэгээ хэрэглэх чадвар | 40 | 70 | 39.2 |

*Мэдлэг, ойлголтыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Даалгавар 1.

*Даалгаврын зорилго*: Хоёртын тооллын системийг таньж мэдэх, ялгах. Энэхүү даалгавар нь хоёртын тооллын системийг таньж, ялгах зорилготой.

Сургалтын цөм хөтөлбөрт 7 дугаар ангид компьютер бүлэг сэдвийн хүрээнд мэдээллийг дүрслэх хоёртын кодчилол, тоон дүрслэл ба хоёртын кодчиллын хоорондын холбоо хамаарлыг мэдэх, тайлбарлах чадвартай болсон байдаг ба 8 дугаар ангид энэхүү сэдэв өргөжиж мэдээллийг хэмжих нэгж, түүний хэрэглээний ойлголттой болдог.

Судалгаанд оролцсон сурагчдын 43.4 хувь нь зөв хариулт сонгосон бол 56.6 хувь нь буруу хариултыг сонгосон байна. Энэхүү даалгаврын гүйцэтгэлээс харахад цөм хөтөлбөрт тусгагдсан хоёртын кодчилол, тоон дүрслэл, тооллын системийн суурь ойлголт тааруу байгааг илтгэж байна.

Даалгавар 2.

*Даалгаврын зорилго:* Санах ойд мэдээллийг хэмжих нэгж, тэдгээрийг танин мэдэх, даалгавраар санах ойн үүрийг таньж, ялгаж мэдэх зорилготой.

Сургалтын цөм хөтөлбөрт мэдээлэл, загвар, загварчлал бүлэг сэдвийн хүрээнд мэдээллийг хэмжих нэгж, түүний хэрэглээг ойлгох чадвартай болсон байдаг.

Судалгаанд оролцсон сурагчдын 47.3 хувь нь зөв хариулт сонгосон бол 52.7 хувь нь буруу хариултыг сонгосон байна. Энэ нь сургалтын цөм хөтөлбөрт тусгасан мэдээллийг хэмжих нэгж, түүний хэрэглээний талаарх ойлголт хангалтгүй байгааг харуулж байна.

Даалгавар 3.

*Даалгаврын зорилго:* Мэдээллийн хэмжих нэгж хооронд хөрвүүлэх, даалгавраар мэдээллийн хэмжээг нэгж хооронд хөрвүүлэх чадварыг илрүүлэх зорилготой.

Сургалтын цөм хөтөлбөрт 8 дугаар ангид мэдээлэл, загвар, загварчлал бүлэг сэдвийн хүрээнд мэдээллийг хэмжих нэгж, түүний хэрэглээг ойлгох чадвартай болсон байдаг.

Судалгаанд оролцсон сурагчдын 21.2 хувь нь зөв хариулт сонгосон бол 78.8 хувь нь буруу хариултыг сонгосон байна. Энэхүү даалгавраар цөм хөтөлбөрт тусгагдсан мэдээллийг хэмжих нэгж, түүний хэрэглээний талаарх ойлголт хангалтгүй байна.

Нийт сонгох даалгаврын хүнд хөнгөний зэрэг нь 37,3 хувь байгаа нь харьцангуй хөнгөн түвшний даалгавар өгөгдсөн ба харин ялгах чадвар 22,3 хувь сул байна.

Сорилын судалгаанд оролцсон сурагчдын сонгох даалгаврын гүйцэтгэлийг авч үзвэл 3.5 хувь нь 3 даалгаврыг зөв гүйцэтгэсэн, 28.5 хувь нь 1 даалгаврыг алдаж гүйцэтгэсэн байна. Нийт сурагчдын 32 хувь нь сонгох даалгаврыг тодорхой хэмжээнд гүйцэтгэсэн байна. Харин 44.3 хувь нь 2 даалгаварт алдаа гаргасан бол 23.7 хувь нь аль ч даалгаврыг хангалтгүй хэмжээнд гүйцэтгэсэн байна.

*Мэдлэгээ хэрэглэх чадварыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Мэдлэгээ хэрэглэх чадварыг илрүүлэх даалгаврыг богино хариулттай байхаар боловсруулсан.

Даалгавар 4.

*Даалгаврын зорилго*: Цахим орчинд аюулгүй байдлаа хангах ойлголт, даалгавраар цахим орчинд мэдээллээ нууцлах, хамгаалах ойлголт хэр түвшинд байгааг тодруулах зорилготой.

Сургалтын цөм хөтөлбөрт 8 дугаар ангид компьютер бүлэг сэдвийн хүрээнд компьютерийн хэрэглээний соёлыг ойлгох, хэрэгжүүлэх чадвар эзэмшүүлнэ гэж тусгасан.

Цахим орчинд мэдээллээ нууцлах, нууц үгээ бусдад дамжуулахгүй байх, танихгүй хүнтэй найзлахгүй байх гэсэн аргуудаас нийт сурагчдын 73.2 хувь нь 2 зөвлөмж, 16.2 хувь нь 1 зөвлөмжийг бичжээ. Судалгаанаас үзэхэд сургалтын цөм хөтөлбөрийн хүрээнд компьютерийн хэрэглээний соёлыг ойлгох, хэрэгжүүлэх агуулга нь харьцангуй сайн хэрэгжиж, сурагчдын мэдлэг ойлголт маш сайн байгаа нь харагдаж байна. Харин нийт сурагчдын 9.5 хувь нь огт хариулаагүй, 1.1 хувь нь буруу хариулсан байгаа нь нийт сурагчдын 10.6 хувь болж байна. Эдгээр сурагчид цахим орчинд мэдээллээ нууцлах талаар мэдлэг ойлголтгүй байгааг харуулж байна.

Даалгавар 5.

*Даалгаврын зорилго:* Өгсөн өгөгдлөөр зорилгод нийцүүлэн загвар байгуулах, өгөгдлөөр математик загвар байгуулах чадварыг үнэлэх зорилготой.

Сургалтын цөм хөтөлбөрт 8 дугаар ангид мэдээлэл, загвар, загварчлал бүлэг сэдвийн хүрээнд өгсөн байдаг.

Даалгаврыг гүйцэтгэсэн сурагчдын 17.9 хувь нь бүрэн гүйцэтгэлтэй хариулсан бол 5 хувь нь дутуу хариулсан байна. Харин 77.1 хувь нь буруу болон огт хариулаагүй байгаа нь сурагчид математик загвар боловсруулах чадвар хангалттай эзэмшиж чадаагүй байгааг илтгэж байна.

Нийт сурагчдын 83 хувь нь буруу болон огт хариулаагүй байгаа нь дийлэнх сурагчдын математик загвар байгуулах чадвар хангалтгүй байна. Математик загвар байгуулах чадвар нь математикийн хичээлтэй шууд хамааралтай тул сургууль багш нарын хичээл хоорондын агуулгын залгамж холбоо, заах арга зүйг сайжруулахад анхаарах хэрэгтэй.

Дээрх даалгаврын хувьд нийт сурагчдын 39.1 хувь нь зөв, 60.9 хувь нь буруу хариулсан ба огт хариулаагүй байна.

Мэдээллийн технологи хичээлийн сорилыг нийт сурагчдын 81.7 хувь тааруу гүйцэтгэлтэй буюу 50 хувь болон түүнээс доош хувийн гүйцэтгэлтэй хариулсан байгаа тул багшийн заах арга зүйг сайжруулах, тэдэнд арга зүйн дэмжлэг үзүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Суурь боловсролын мэдээллийн технологийн сорилын судалгаанд хамрагдсан сурагчдын даалгаврын нийт гүйцэтгэлийн үр дүнг зураг, хүснэгтээр харуулав.

*Зураг 65. Сорилын даалгаврын гүйцэтгэл (Мэдээллийн технологи, 8 дугаар анги)*




Судалгаанд хамрагдсан сурагчдын гүйцэтгэлийн хувьд арифметик дундаж 38.6 хувь, медиан 30.0 хувь, моод 30.0 хувь, хамгийн өндөр гүйцэтгэл 100 хувь, хамгийн бага гүйцэтгэл 0 хувь байна.

Суурь боловсролын сорилын судалгаанд хамрагдсан сурагчдын мэдлэг ойлголтын түвшний даалгаврын гүйцэтгэлийн дундаж 37.3 хувь, мэдлэгээ хэрэглэх чадварын гүйцэтгэлийн дундаж 39.2 хувь байна.

## Монгол хэлний сорилын гүйцэтгэлийн шинжилгээ

Суурь боловсролын 8 дугаар ангийн монгол хэлний сорилын даалгавар нь мэдлэг ойлголт, чадвар, мэдээлэлтэй ажиллах арга барилыг үнэлэх А, Б хэсгээс бүрдсэн нийт 10 даалгавартай. Тухайн ангийн нэгдүгээр улиралд судалсан агуулгын хүрээнд унших, бичих чадварыг илрүүлэх зорилготой юм.

*Хүснэгт 59. Сорилын даалгаврын жин (Монгол хэл, 8 дугаар анги)*

| | | *Онооны эзлэх хувь* | *Гүйцэтгэлийн дундаж* |
|---|---|---|---|
| Мэдлэг, ойлголт | 30 | 17 | 49.9 |
| Мэдлэгээ хэрэглэх чадвар | 20 | 33 | 42.5 |
| Мэдээлэлтэй ажиллах арга барил | 50 | 50 | 64 |

*Хүснэгт 60. Агуулгын гүйцэтгэл (Монгол хэл, 8 дугаар анги)*

| *Үнэлгээний зорилт* | *Гүйцэтгэлийн дундаж* | | | | | | | | | | *Нийт дундаж* |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Д: 1 | Д: 2 | Д: 3 | Д: 4 | Д: 5 | Д:6 | Д: 7 | Д: 8 | Д: 9 | Д: 10 | |
| Сонсох, унших чадварыг илрүүлэх | 88,5 | 23,1 | 83,8 | 35,5 | 20,7 | | | | | | 50,3 |
| Бичих, хэл зүйн мэдлэг ойлголтыг илрүүлэх даалгавар | | | | | | 22,3 | 13,4 | 42,1 | 42,1 | | 42 |
| Бүтээх, бичих чадварыг илрүүлэх даалгавар | | | | | | | | | | 40,6 | 40,6 |

*Зураг 66.Сорилын сонгох даалгаврын гүйцэтгэл (Монгол хэл, 8 дугаар анги)*




Сонгох даалгавруудын хүнд хөнгөний зэрэг 50.3 хувь буюу дундаж, ялгах чадвар 18.74 хувь, баруун тийш хазайсан байна.

*Унших чадварыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

*Зураг 67. Сорилын задгай хариулттай даалгаврын гүйцэтгэл (Монгол хэл, 8 дугаар анги)*




Сурагчдын задгай хариулттай даалгаврын гүйцэтгэлийг харахад баруун тийш хазайсан, дундаж 56.0 хувь байна.

Сонгох 5 дугаар даалгаварт “сэрүүн салхи сэр сэр үлээгээд” гэсэн өгүүлбэрийг монгол бичгээр зөв бичсэн хариултыг олоорой гэсэн даалгавар байсан бөгөөд Г хариулт буюу зөв хариултыг 20,7 хувь хүүхэд зөв хариулсан нь монгол бичгээр уншиж ойлгох чадвар, мэдээллийн гол ба туслах санааг ялган таних, эхийг уншаад богино, энгийн өгүүлбэрээс тусгай буюу нарийвчилсан мэдээллийг ялган таних чадвар сул байна. А-11.5 хувь, Б-33.0 хувь, В-31.0 хувь тус тус зөрүүлж хариулсан нь монгол бичгээс крилл бичигт, крилл бичгээс монгол бичигт хөрвүүлэн бичих чадвар хангалтгүй монгол бичгийн дүрмийг бүрэн тогтоож аваагүй нь харагдаж байна.

*Бичих чадварыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Даалгавар: 6, 7, 8, 9

*Даалгаврын зорилго*: Зохиолын хэл найруулгыг задлан шинжилж үзэл бодол, мэдрэмж, сэтгэгдэл, үнэлэлт дүгнэлтийг үндэслэлтэй, үр дүнтэй, бүтээлч, оновчтой илэрхийлж бичих

Задгай хариулттай даалгаврын гүйцэтгэлийн нийт дундаж 29,9 хувь байна.

*Хүснэгт 61. Задгай хариулттай даалгаврын гүйцэтгэл (Монгол хэл, 8 дугаар анги)*

| ***д/д*** | *Даалгавар* | | *Оноо* | *Шалгуур* | *Гүйцэтгэлийн хувь* | *Гүйцэтгэлийн дундаж хувь* |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Д: 6 | 1 | 3 | Т-нэр, Тоо-нэр ОЦ-нэр, дуурайх ба дүрслэх үг | 54.4 | 22.3 |
| 2 | | 2 | | | 10.7 | |
| 3 | | 3 | | | 1.8 | |
| 4 | Д: 7 | 1 | 3 | Үйл явдлын орон, цаг, шинжийг тоочин дүрслэх | 13.7 | 13.4 |
| 5 | | 2 | | | 12.8 | |
| 6 | | 3 | | | 13.9 | |
| 7 | Д: 8 | 1 | 2 | Зохиогчийн дүрсэлж бичихдээ хэрэглэсэн өвөрмөц үг хэллэгийг олж тайлбарлах | 53.4 | 42.1 |
| 8 | | 2 | | | 30.9 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 9 | Д: 9 | 1 | 2 | Галигаас монгол бичигт буулгаж буй байдал | 44.1 | 42.1 |
| 10 | | 2 | | | 38.3 | |
| Нийт | | | | | | 29.9 |

1-3 дугаар даалгавар эхээс тайлбарлан бичих, 4 дүгээр даалгавар галигаас монгол бичигт буулгах даалгавар бөгөөд сурагчдын задгай даалгаврыг гүйцэтгэх, эхийн хэв маягыг тодорхойлон бичих, санаа бодлоо цэгцтэй илэрхийлэх чадвар хангалтгүй байна.

*Бүтээх /бичих/ даалгаврын шинжилгээ*

Даалгавар 10.

*Даалгаврын зорилго:* Өөрт төрсөн мэдрэмж, санаа бодол, баримт мэдээ, үйл явдал, туршлагынхаа талаар бичих чадварыг илрүүлэх.

Монгол хэлний 8 дугаар ангийн 10 дугаар даалгавар нь шүлгээс төрсөн мэдрэмж сэтгэгдлээ илэрхийлж эхлэл, гол, төгсгөл хэсэгт хуваан 120-150 үгэнд багтааж эх зохиож бичих даалгавар байв.

| ***д/д*** | *Даалгавар* | *Оноо* | | *Шалгуур* | *Гүйцэтгэлийн хувь* | *Гүйцэтгэлийн дундаж хувь* |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Д: 10а | 1 | 3 | Эхлэл хэсэгт: Шүлэгт хэзээ болж байгаа, ямар ямар үйл явдлын тухай гарч байгаа түүнээс чи юу мэдэрсэн тухай бичнэ. | 9.7 | 33 |
| 2 | | 2 | | | 53.8 | |
| 3 | | 3 | | | 35.1 | |
| 4 | Д:10б | 1 | 3 | | 13.5 | 32.4 |
| 5 | | 2 | | | 62.4 | |
| 6 | | 3 | | | 21.3 | |
| 7 | Д: 10в | 1 | 2 | Гол хэсэгт: зохиогч шүлэгтээ мэдрэмж хэрсэн илэрхийлсэн байна. Үүнээс чамд ямар сэтгэгдэл төрснийг баримтаар нотолж, дүрслэл ашиглаж, сайтар тайлбарлаж бичнэ. | 32,2 | 45.7 |
| 8 | | 2 | | | 59.2 | |
| 9 | Д: 10г | 1 | 2 | | 39.2 | 42.2 |
| 10 | | 2 | | | 45.3 | |
| 11 | Д:10д | 1 | 2 | Төгсгөл хэсэгт: Өөрт төрсөн мэдрэмж, сэтгэгдэлтэйгээ холбон шүлгийн талаар дүгнэлт бичнэ. | 38,2 | 39.2 |
| 12 | | 2 | | | 40.2 | |
| 13 | Д:10е | 1 | 2 | | 42.9 | 36 |
| 14 | | 2 | | | 29.0 | |
| 15 | Д:10ё | 1 | 1 | Шүлгийг уншаад төрсөн мэдрэмж сэтгэгдэлээ илэрхийлж 120-150 үгэнд багтаан бичнэ. | 55.9 | 55.9 |
| | Нийт | | | | | 40.6 |

Сурагчдын 10 дугаар даалгаврын гүйцэтгэлийг харахад 40,6 хувьтай байна. Сурагчдын бүтээх даалгаврын бичвэрийн гүйцэтгэлийг харвал эхлэл хэсэг буюу 1-2 дугаар хэсэгт сурагчид эхийн баримтыг шууд ашиглан бичсэн нь гүйцэтгэл сул гарах үндэс болсон байна..

3-4 дүгээр хэсэгт өөрт төрсөн сэтгэгдлээ сайн тусгаж оруулсан боловч баримт нотолгоо муу, үг сонголт бага. 5-6 дугаар хэсэгт дүрслэх хэрэглүүр, найруулга муу зэрэг алдаанууд ажиглагдаж байна. 7 дугаар хэсэгт үгийн тоо харгалзсан хувь 55,9 байгаа нь нийт сурагчдын эх үгийн тоондоо хүрээгүй болно.

*Хүснэгт 62. Сорилын даалгаврын хамаарал (Монгол хэл, 8 дугаар анги)*

Найдварт байдал=.732

| Descriptive Statistics | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Mean | Стандарт хазайлт | N | Correlation | Гүйцэтгэлийн хувь |
| **Д:1** | 0.885 | 0.3199 | 537 | .254** | 88.5 |
| **Д:2** | 0.231 | 0.4218 | 537 | .144** | 23.1 |
| **Д:3** | 0.838 | 0.3688 | 537 | .269** | 83.8 |
| **Д:4** | 0.335 | 0.4725 | 537 | .178** | 33.5 |
| **Д:5** | 0.207 | 0.4053 | 537 | .190** | 20.7 |
| **Д:6** | 0.812 | 0.6898 | 441 | .382** | 22.3 |
| **Д:7** | 0.809 | 1.1163 | 461 | .413** | 13.4 |
| **Д:8** | 1.153 | 0.6662 | 472 | .333** | 42.1 |
| **Д:9** | 1.208 | 0.7192 | 506 | .353** | 42.1 |
| **ЗД:10а** | 2.226 | 0.6738 | 496 | .665** | 33 |
| **ЗД:10б** | 2.022 | 0.6791 | 497 | .678** | 32.4 |
| **ЗД:10в** | 1.505 | 0.651 | 497 | .622** | 45.7 |
| **ЗД:10г** | 1.298 | 0.7211 | 497 | .679** | 42.2 |
| **ЗД:10д** | 1.187 | 0.7641 | 497 | .646** | 39.2 |
| **ЗД:10е** | 1.008 | 0.7566 | 497 | .678** | 36 |
| **ЗД:10ё** | 0.559 | 0.497 | 497 | .641** | 55.9 |

Суурь боловсролын монгол хэлний сорилын үр дүнгээс харахад:

- Сурагчдын сорилын мэдлэг ойлголт даалгаврын гүйцэтгэл 49,9 хувь, мэдлэгээ хэрэглэх даалгаврын гүйцэтгэл 42,5 хувь, мэдээлэлтэй ажиллах арга барил-64 хувь байна.
- Задгай хариулттай даалгавар дотроо сурагчид мэдлэг ойлголт буюу сонгох хэсгээ оновчтой хийж чадсан боловч тайлбар бичих чадвар буюу мэдлэгээ хэрэглэх даалгаврын гүйцэтгэл хангалтгүй байна.
- Сурагчдын монгол хэлний мэдлэг чадварыг бодит хэрэглээ болгож алдаагүй зөв, цэгцтэй, найруулан бичих чадварт сургах шаардлага байна.
- Монгол хэлний сорилын 1,2,3,4,5, дугаар даалгавар унших чадвар, 6,7,8,9,10 дугаар даалгавар бичих чадварыг үнэлэхэд чиглэгдсэн байсан бөгөөд нийт сурагчдын гүйцэтгэлээс харахад унших чадвар 50,3 хувь, бичих чадвар 41,3 хувь байна.

## Англи хэлний сорилын гүйцэтгэлийн шинжилгээ

Сургалтын цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтууд, үнэлгээний зорилт, шалгуур, жинг баримтлан уг сорилын даалгаврын үнэлгээний зорилтыг 3:6:1 харьцаатайгаар тодорхойлж, тухайн ангийн нэгдүгээр улиралд судалсан агуулгын хүрээнд хэл зүйн хэрэглээ, унших, бичих чадварыг илрүүлэх зорилготой хийгдсэн.

*Хүснэгт 63. Агуулгын гүйцэтгэл (Англи хэл, 8 дугаар анги)*

| *Үнэлгээний зорилт* | *Гүйцэтгэлийн дундаж* | | | | | | | | | | *дундаж* |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | *Д:1* | *Д:2* | *Д:3* | *Д:4* | *Д:5* | *Д:6* | *Д:7* | *Д:8* | *Д:9* | *Д:10* | |
| Сонсох, унших чадварыг илрүүлэх | | | 55.3 | 57.9 | 16.7 | | | | | | 43.3 |
| Хэл зүйн хэрэглээний чадварыг илрүүлэх | 27.6 | 34.2 | | | | 64.6 | 75.8 | 24.2 | 11.5 | | 39.6 |
| Бүтээх, бичих чадварыг илрүүлэх | | | | | | | | | | 16.3 | 16.3 |

*Зураг 68. Сорилын даалгаврын гүйцэтгэл (Англи хэл, 8 дугаар анги)*




Сурагчдын гүйцэтгэлийн арифметик дундаж 41.4 хувь, хамгийн өндөр гүйцэтгэл 52 хувь, хамгийн бага гүйцэтгэл 0.3 хувь, зүүн тийш бага зэргийн хазайсан байна.

*Хүснэгт 64. Даалгаврын хамаарал (Англи хэл, 8 дугаар анги)*

Найдварт байдал=0.722

| | *correlation* | *Mean* | *Стандарт хазайлт* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|---|---|
| Д:1 | .466** | .274 | .4464 | 26.1 |
| Д:2 | .452** | .346 | .4762 | 33.5 |
| Д:3 | .515** | 1.130 | .9926 | 55.3 |
| Д:4 | .533** | 1.159 | .9883 | 57.9 |
| Д:5 | .745** | .510 | .7797 | 25.04 |
| Д:6 | .252** | .648 | .4782 | 64.6 |
| Д:7 | .234** | .756 | .4300 | 75.8 |
| Д:8 | .611** | 1.709 | 1.2353 | 56.9 |
| Д:9 | .749** | .516 | .8450 | 16.5 |
| Д:10 | .705** | 1.240 | 1.1089 | 29.8 |

Даалгаврын найдварт байдлын тохирц сайн, 10 даалгавар хоорондоо шууд, эерэг хамааралтай байна.

*Сонсох, унших чадварыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Даалгавар 3.

*Даалгаврын зорилго:* Хүлээн авч буй мэдээллийн агуулга утга санааг тааварлаж, таамаглах

А буюу зөв хариултыг 55.3 хувь, В хувилбарыг 28.9 хувь, 15.6 хувь аль ч хувилбарыг сонгоогүй байна. Үүнээс харахад А хувилбарыг сонгосон сурагчдын богино эхийн гол санааг ойлгох, туслах санааг ялгах чадвар сайн, В хувилбарыг сонгосон сурагчид эхээс гол ба туслах санааг ялган ойлгох чадвар сул, 15.6 хувь нь эхийн утга санааг тааварлах, ойлгох чадвар хангалтгүй байна.

Даалгавар 4.

*Даалгаврын зорилго:* Эхийг уншиж ойлгох, үйл явдлын уялдаа холбоо, учир шалтгааныг олох

С буюу зөв хариултыг 57.9 хувь, А хувилбарыг 21.4 хувь, В хувилбарыг 13.4 хувь, давхар хариултыг 0.2 хувь нь сонгож, 7.1 хувь аль ч хувилбарыг сонгоогүй байна. Үүнээс харахад С хувилбарыг сонгосон сурагчдын энгийн богино эхээс өгүүлэгчийн хандлага, санааг ойлгох, ялган таних чадвар сайн, А, В хувилбарыг сонгосон сурагчид учир шалтгааны холбоог таних, мэдээллийг боловсруулах чадвар сул байна.

Даалгавар 5.

*Даалгаврын зорилго:* Эхийн гол ба туслах санаа, зохиогч, өгүүлэгчийн хандлага санааг ялгаж таних буюу эхийг уншаад, богино, энгийн асуух өгүүлбэрээс тусгай буюу нарийвчилсан мэдээллийг ойлгож, хариулах чадварыг илрүүлэх.

*Хүснэгт 65. Сорилын 5 дугаар даалгаврын шалгуур, гүйцэтгэл (Англи хэл, 8 дугаар анги)*

| *Шалгуур* | *Оноо* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|
| Тэр 2 хүүхэдтэй гэж энгийн өгүүлбэрээр асуултад хариулсан бол, эсвэл 2 хүүхэдтэй гэсэн үгээр хариулсан | 2 | 16.9 |
| Хариулах өгүүлбэрийн утга санааг хадгалсан боловч хэл зүйн алдаа гаргасан<br>He has 2 children. /зөв бичвэр/<br>He have 2 children. /үйл үгийн хувирал буруу/<br>He has 2 child./ нэр үгийн ганц тоог бичсэн.<br>/have/ has/child/children/ | 1 | 16.2 |
| Өгүүлбэрийн утга санааг илэрхийлж чадаагүй боловч хариулт бичих гэж оролдсон | 0 | 29.6 |
| Огт хариулаагүй | | 37.2 |
| Даалгавар гүйцэтгэлийн нийт дундаж | | 25.04 |

Судалж буй сэдвийн хүрээнд уншиж ойлгох чадвар, мэдээллийн гол ба туслах санааг ялган таних, эхийг уншаад богино, энгийн асуух өгүүлбэрээс тусгай буюу нарийвчилсан мэдээллийг ойлгож, хариулах чадвар хангалтгүй байна. Нөгөө талаар сонгох даалгаврыг гүйцэтгээд, санаа бодлоо илэрхийлж, өгүүлбэрийн бүтцийг ашиглан бичих чадвар маш сул байгаа нь багшийн заах арга, сурагчийн сурах арга барил, сонирхол, идэвхээс шалтгаалж байгааг задгай хариулттай даалгаврын гүйцэтгэлээс харж болно. Эхэд энгийн хэрэглээний үгс орсон, сурагч уншихад эргэлзээтэй, хүнд, танил бус үг хэллэг ороогүй учраас энэ даалгаврыг хөнгөн гэж тооцож болно.

*Хэл зүйн хэрэглээний чадварыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Даалгавар 1, 2.

*Даалгаврын зорилго:* Хэл зүйн мэдлэг, ойлголтыг илрүүлэх /судалсан сэдвийн хүрээнд танил үг, үг хэллэгийг бичвэрт ашиглах/

1 дүгээр даалгаврыг 26.1 хувь зөв, 67.0 хувь буруу, 6.9 хувь нь огт гүйцэтгээгүй, даалгавар 2-ыг 33.5 хувь зөв, 49.7 хувь буруу, 16.8 хувь огт гүйцэтгээгүй байна. 1 дүгээр даалгаварт 67 хувь, 2 дугаар даалгаварт 49.7 хувь буруу хариулсан нь сурагчдын хэл зүйн мэдлэг ойлголт, тухайлбал, тодорхойгүй төлөөний үгийг бичвэрт хэрэглэх чадвар хангалтгүй байгааг харуулж байна. 1 дүгээр даалгаврын хувьд бага оноотой сурагч ихэнх хувийг эзэлж байна.

Даалгавар 6, 7.

*Даалгаврын зорилго:* Хувийн мэдээллийн талаар асуух, хариулах, мэдлэгээ харилцаанд хэрэглэх чадварыг илрүүлэх

Даалгавар 6,7-ын хувьд B хувилбар зөв хариулт байсан бөгөөд сурагчдын гүйцэтгэлийг харахад 6-р даалгавар 64.6, 7-р даалгавар 75.8 хувийг эзэлж байна. Хувийн мэдээллийн талаар асуух хариулах, харилцах чадвар сайн байна.

Даалгавар 8.

*Даалгаврын зорилго*: Бичих зүйлээ төлөвлөх, түлхүүр санааг тэмдэглэж байгаа эсэхийг илрүүлэх /Чөлөөт цагаараа хийх (outdoor activities) үйлүүдээс 3-ыг жагсаан бичих /хөл бөмбөг тоглох, сагсан бөмбөг тоглох, салхинд алхах гэх мэт/ буюу сэргээн санах түвшний даалгавар/

Сурагчдын бичих зүйлээ төлөвлөх, өгүүлбэр бичих, тулгуур үгээ тэмдэглэх чадварын гүйцэтгэл 56.9 хувь байна.

Даалгавар 9.

*Даалгаврын зорилго:* Энгийн, богино өгүүлбэрийн бүтцийг ашиглан асуултад хариулж, өөрийн санаа бодлоо илэрхийлэх чадварыг илрүүлэх

*Хүснэгт 66. Бичих даалгаврын шалгуур, гүйцэтгэл (Англи хэл, 8 дугаар анги)*

| *Шалгуур* | *Оноо* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|
| Хэлзүйн дүрмийн алдаагүй, утга санааг гаргаж, 3 асуултад оновчтой үгээр /юуг, хэзээ, хэнтэй хийх/, өгүүлбэрээр хариулсан | 3 | 4.5 |
| Хэлзүйн дүрмийн алдаагүй, утга санааг гаргаж, 2 асуултад оновчтой үгээр /юуг, хэзээ, хэнтэй хийх/, өгүүлбэрээр хариулсан | 2 | 7.6 |
| Хэлзүйн дүрмийн алдаагүй, утга санааг гаргаж,1 асуултад оновчтой үгээр (юуг, хэзээ, хэнтэй хийх), өгүүлбэрээр хариулсан | 1 | 20.9 |
| Асуултад хариулах гэж оролдсон боловч утга санааг зөв илэрхийлж чадаагүй | 0 | 38.9 |
| **Гүйцэтгэлийн нийт дундаж** | | 16.5 |

Сурагчдын бүтээх хариултат даалгаврыг гүйцэтгэх, энгийн болон нийлмэл өгүүлбэрийн бүтцийг ашиглан, бичих, санаа бодлоо цэгцтэй илэрхийлэх чадварын гүйцэтгэлийн дундаж 16.5 хувь байна байна.

*Бичих даалгаврын шинжилгээ*

Даалгавар 10.

*Даалгаврын зорилго:* Өөрт төрсөн мэдрэмж, санаа бодол, баримт мэдээ, үйл явдал, туршлагынхаа талаар бичих чадварыг илрүүлэх /гэр бүлийн аль нэг гишүүний нэр, нас, эрхэлдэг ажил, сургууль, сонирхлын тухай бичвэр бичих/

*Хүснэгт 67. Бичих даалгаврын шалгуур, гүйцэтгэл (Англи хэл, 8 дугаар анги)*

| *Шалгуур* | *Оноо* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|
| Гэр бүлийн аль нэг гишүүний дээрх мэдээллийг бүгдийг нь хэл зүйн алдаагүй, утга санааг зөв гаргаж бичсэн бол | 4 | 2.0 |
| Гэр бүлийн аль нэг гишүүний дээрх мэдээллээс 3-ыг нь хэл зүйн алдаагүй, утга санааг зөв гаргаж бичсэн бол | 3 | 11.4 |
| | 2 | 25.1 |
| | 1 | 27.0 |
| | 0 | 15.8 |
| **Гүйцэтгэлийн дундаж** | | 29.8 |

Сурагчдын бүтээх даалгаврыг гүйцэтгэх, энгийн болон нийлмэл өгүүлбэрийн бүтцийг ашиглан, бичих, санаа бодлоо цэгцтэй илэрхийлэх чадварын гүйцэтгэлийн дундаж 29.8 хувь байна.

*Зураг 69. Унших, бичих чадварын гүйцэтгэл (Англи хэл, 8 дугаар анги)*




Англи хэлний сорилын унших чадварын гүйцэтгэл 43.3, бичих чадварын гүйцэтгэл 17.3 хувь байна. Эндээс сурагчдын бичих чадвар нь унших чадвараас муу, сурагчдын бичих зүйлээ төлөвлөх, бодол санаагаа бичгээр илэрхийлэх, зохион бичих чадвар сайн биш, ярих, бичих зүйлээ төлөвлөх, бичих, засан сайжруулах суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхэд нэг талаас хэл зүйн мэдлэг ойлголт хангалтгүй, нөгөө талаас гэрийн даалгаврыг ихэвчлэн сурах бичгийн дасгал даалгавраар хязгаарлаж байгаатай холбоотой гэж үзэж байна.

Суурь боловсролын англи хэлний сорилын үр дүнгээс харахад:

- Сонгох, болон задгай хариултат даалгавруудын үр дүнг TESTAN, SPSS программмуудаар тооцоолсон юм. Сонгох даалгаврын гүйцэтгэлийн дундаж 63.4 хувь, задгай даалгаврын гүйцэтгэлийн дундаж 31.3 хувь байгаа бол 5.3 хувь нь зарим даалгаврыг огт гүйцэтгээгүй байна. Задгай даалгавар буюу унших, бичих чадварыг илрүүлэх даалгаврын гүйцэтгэл доогуур байна.
- Сургалтын цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтын дагуу хэл зүйн хэрэглээ (43.3), унших (39.6), бичих чадвар эзэмшилтийг илрүүлэх даалгаврын гүйцэтгэл (16.3) байгаа нь англи хэлний хичээлээр сурагчид тодорхой сэдвийн хүрээнд зөв сонсох, ярих, унших, бичих, харилцах чадвар төлөвшүүлэх цөм хөтөлбөрийн зорилтын хэрэгжилт хангалтгүй байна. Бүтээх хариултат даалгаврын гүйцэтгэл доогуур байгаад сурагчдын сурах арга барил, багшийн хичээл төлөвлөлт, сургалтын хэрэглэгдэхүүн зэрэг зүйлс нөлөөлж байна гэж үзэх талтай.

## Биологийн сорилын гүйцэтгэлийн шинжилгээ

Суурь боловсролын 8 дугаар ангийн биологийн сорилын даалгавар нь мэдлэг, чадвар, шинжлэх ухаанч арга барилыг илрүүлэх 5 даалгавартай. Мөн мэдлэгээ хэрэглэх чадвар, шинжлэх ухаанч арга барил эзэмшилтийг илрүүлэх даалгаврын эзлэх хувь өндөр байх зорилго тавьсан.

*Хүснэгт 68. Сорилын даалгаврын жин (Биологи, 8 дугаар анги)*

| *Агуулга* | *Даалгаврын эзлэх хувь* | *Онооны эзлэх хувь* | *Гүйцэтгэлийн дундаж* |
|---|---|---|---|
| Мэдлэг, ойлголт | 40 | 17 | 37.5 |
| Мэдлэгээ хэрэглэх чадвар | 40 | 33 | 52.7 |
| Шинжлэх ухаанч арга барил | 20 | 50 | 21.8 |

*Мэдлэг, ойлголтыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Даалгавар 1.

Даалгаврын зорилго: Амьд биеийг ангилах ангилал зүйн нэгжийг нэрлэх. Энэ даалгавар нь амьд биеийг ангилах ангилал зүйн том нэгжийг ялган таньж байгаа эсэхийг илрүүлэх зорилготой.

Сургалтын цөм хөтөлбөрт ангилал зүйн том нэгжийн (хүрээ, анги) үндсэн шинжүүд, тэдгээрийг ашиглан ургамал амьтныг таних энгийн түлхүүр зохиох агуулга шинээр тусгаж оруулсан байдаг.

Даалгаврын хүндрэлийн зэрэг маш хүнд, ялгах чадвар маш бага байгааг ТЕСТАН программмын үр дүн харуулав.

Сурагчдын 17.9 хувь нь В буюу зөв хариултыг сонгосон байна. Харин 61.8 хувь нь Г буюу буруу хариултыг сонгосон байгаа нь аймаг ангилал зүйн том нэгж гэдгийг хараад сонгосон байх талтай. Гэтэл бүлэг гэдэг нь амьд биеийн ангилал зүйн нэгж биш гэдгийг олон сурагч мэдэхгүй байгааг харуулж байна. А буруу хариултыг нийт сурагчийн 15.1 хувь сонгосон нь төрөл ба зүйл нь ангилал зүйн том нэгж гэдгийг ойлгоогүй байна гэж төсөөлөгдөж байна. Харин Б буруу хариултыг 4.5 хувь нь сонгосон нь мөн дээрхийн адил зөв ойлголт дутмаг байгааг харуулж байна.

Даалгавар 2.

*Даалгаврын зорилго*: Гэрлийн микроскопоор харсан зургаас ургамлын эсийг ялган таних. Энэхүү даалгаврын зорилго нь өмнөх ангид судалсан агуулга эзэмшилтийг илрүүлэх зорилготой бөгөөд ургамын эсийг амьтны эсээс ялган таних даалгавар байсан.

Амьтан, ургамлын эсийн бүтцийн ялгааг зураг болон гэрлийн микроскоп ашиглан судлах, зурах, тайлбарлан бичих агуулгыг 7 дугаар ангид судалсан. Энэ ангид эсийн хромосомын тухай дэлгэрүүлэн судлах агуулга сургалтын цөм хөтөлбөрт тусгасан.

Энэ даалгаврын хүндрэлийн зэрэг тохиромжтой, ялгах чадвар маш бага байгааг ТЕСТАН программмын үр дүн харуулав.

Сурагчдын 56.2 хувь нь Б буюу зөв хариултыг сонгосон байна. Харин 18.2 хувь нь А буюу бөөм, 9.5 хувь нь В буюу цитоплазм гэсэн хариултыг сонгосон байгаа нь энэ талын агуулгын ойлголт дутмаг байгааг харуулж байна. Мөн 13.2 хувь нь Г буюу эсийн мембран гэсэн хариултыг сонгосон байгаа нь сурагчдад эргэлзээ төрүүлэх магадлалтай байна. Учир нь гэрлийн микроскопоор ургамлын эсийн мембран, амьтны эсийн бүрхүүл харагдана.

Сорилын даалгаврыг боловсруулахдаа мэдлэг ойлголтыг илрүүлэх даалгавар, мэдлэгээ хэрэглэх чадварыг илрүүлэх даалгавар, шинжлэх ухаанч арга барил эзэмшилтийг илрүүлэх даалгаврын нийт оноонд эзлэх хувь 17: 33: 50 байхаар боловсруулсан нь сургалтын цөм хөтөлбөрт тусгасан үнэлгээний зорилт, шалгуур, жинг баримтлан мэдлэгээ хэрэглэх чадвар, сурах арга барилыг илрүүлэх зорилго тавьсан болно.

*Мэдлэгээ хэрэглэх чадварыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Мэдлэгээ хэрэглэх чадварыг илрүүлэх даалгаврыг богино хариулттай байхаар боловсруулсан.

Даалгавар 3.

*Даалгаврын зорилго*: Энэ даалгавар нь эрхтэн тогтолцооны агуулга эзэмшилтийг илрүүлэх буюу хоол боловсруулах эрхтний нэр, үүрэг, онцлогийг харгалзуулан тодорхойлох зорилготой.

Сургалтын цөм хөтөлбөрт хүний эрхтэн тогтолцооны бүтэц, үүргийг анги тус бүрд залгамж холбоотой, танин мэдэхүйн түвшний хувьд гүнзгийрсэн байдлаар тусгасан. 7

дугаар ангид хүний амьсгалын эрхтэн тогтолцооны бүрэлдэхүүн хэсгүүдийг таньж, тэдгээрийн байрлал, үүргийг мэдэх, 8 дугаар ангид хүний хоол боловсруулах замын эрхтнүүдийг таньж, тэдгээрийн байрлал үүргийг мэдэх агуулга туссан байгаа.

Даалгавар 4.

*Даалгаврын зорилго:* Амьтан, ургамлын эсийн бүтцийн ялгааг зураг болон гэрлийн микроскоп ашиглан судлах, зурах, тайлбарлан бичих агуулгыг 7 дугаар ангид судалсан. 8 дугаар ангид эсийн хромосомын тухай мэдэх, митоз хуваагдлыг тайлбарлах байдлаар агуулга өргөсөж байгаа тул тухайн ангид сурагчдын судалсан агуулгын эзэмшилт болон зураг унших, тэмдэглэл хөдлөх чадварыг илрүүлэх зорилготой. Сурах бичигт өгөгдсөн зургийг хөгжүүлэх байдлаар даалгаврыг боловсруулсан.

*Хүснэгт 69. Сорилын 3, 4 дүгээр даалгаврын гүйцэтгэл (Биологи, 8 дугаар анги)*

| *Даалгавар* | *Оноо* | *Хариултын мэдээлэл (гүйцэтгэлийн хувиар)* | | | | *Гүйцэтгэлийн дундаж* |
|---|---|---|---|---|---|---|
| | | *2 оноо авсан* | *1 оноо авсан* | *Буруу хариулсан* | *Огт хариулаагүй* | |
| 3-р даалгавар | 2 | 38.4 | 41.2 | 20.5 | 0 | 58.0 |
| 4-р даалгавар | 2 | 30.2 | 33.9 | 35.9 | 0 | 47.1 |

Богино хариулттай 2 даалгаврын гүйцэтгэл 52.5 хувь байгаа нь багшийн заах арга зүйг сайжруулах, тэдэнд арга зүйн дэмжлэг үзүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

*Шинжлэх ухаанч арга барилыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Даалгавар 5.

*Даалгаврын зорилго*: Сурагчид 6 дугаар ангидаа амьд биеийн үндсэн шинжийг үзэж судалсан. Амьд биеийн 5 аймаг ба ургамал, амьтны аймгийн гол бүлгүүдийг ялган таних агуулгыг 7 дугаар ангид, ангилал зүйн том нэгжийн (хүрээ, анги) үндсэн шинжүүд, тэдгээрийг ашиглан ургамал амьтныг таних энгийн түлхүүр зохиох агуулгыг 8 дугаар ангийн 1 дүгээр улиралд судалсан. Энэ даалгаврын гол зорилго нь амьд биеийн 5 аймгийн онцлог шинжид үндэслэн мөөгийн аймгийг тодорхойлох, түлхүүр бичиг хэрэглэх чадварыг илрүүлэхэд оршино.

*Хүснэгт 70. Сорилын 5 дугаар даалгаврын гүйцэтгэл (Биологи, 8 дугаар анги)*

| *Даалгавар* | *Оноо* | *Хариултын мэдээлэл (гүйцэтгэлийн хувиар)* | | | |
|---|---|---|---|---|---|
| | | *Дээд оноо* | *Доод оноо* | *Буруу хариулсан* | *Огт хариулаагүй* |
| Д:5-I | 4 | 7.4 | 14.9 | 47.7 | 7.6 |
| Д:5-II | 2 | 10.1 | 4.7 | 61.6 | 23.6 |

*Хүснэгт 71. Шинжлэх ухаанч арга барилыг үнэлэх даалгаврын гүйцэтгэл (Биологи, 8 дугаар анги)*

| | *N* | *Minimum* | *Maximum* | *Mean* | *Std. Deviation* |
|---|---|---|---|---|---|
| Д:5_I | 471 | .0 | 4.0 | 1.066 | 1.3722 |
| Д:5_II | 471 | .0 | 2.0 | .268 | .6430 |
| Valid N (listwise) | 471 | | | | |

Сурагчид амьд биеийг ангилах түлхүүр бичгийг хэрэглэх, түлхүүр бичиг зохиох чадвар эзэмшүүлэх агуулга сургалтын цөм хөтөлбөрт шинээр орсон. Энэ даалгаврыг гүйцэтгэсэн сурагчдын гүйцэтгэл хангалтгүй байгаа тул багшийн заах арга зүйг сайжруулах, тэдэнд арга зүйн дэмжлэг үзүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Суурь боловсролын биологийн сорилын 2, 4 буюу 3, 4 дүгээр даалгавар хамааралтай болохыг хүснэгтээр харуулав.

*Хүснэгт 72. Сорилын даалгаврын хамаарал (Биологи, 8 дугаар анги)*

| даалгавар | | 2 | 3 | 4 | 5_I | 5_II |
|---|---|---|---|---|---|---|
| 4 | Pearson Correlation | .136** | .168** | 1 | .065 | .103* |
| | Sig. (2-tailed) | .002 | .000 | | .149 | .037 |

Сурагчдын агуулга эзэмшилтийг дараах байдлаар ангилан судалж, үр дүнг хүснэгтэд харуулав.

*Хүснэгт 73. Агуулгын гүйцэтгэл (Биологи, 8 дугаар анги)*

| Агуулга | Даалгаврын дугаар | Гүйцэтгэлийн дундаж |
|---|---|---|
| Сургалтын цөм хөтөлбөрт шинээр тусгасан агуулга | 5-I<br>5-II | 21.8 |
| Өмнөх ангид судалсан агуулгатай залгамж холбоо бүхий гүнзгийрсэн агуулга | 2<br>3 | 57.1 |
| Сурах бичигт тусгасан даалгаврыг хөгжүүлсэн агуулга | 2<br>4 | 51.6 |

*Зураг 70. Сорилын даалгаврын гүйцэтгэл (Биологи, 8 дугаар анги)*




Суурь боловсролын биологийн сорилын судалгаанд хамрагдсан сурагчдын гүйцэтгэл хэвийн тархалттай байна.

Суурь боловсролын биологийн сорилын үр дүнгээс харахад:

- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдлын судалгааны сорилын даалгаврыг 1 дүгээр улиралд судалсан буюу сургалтын цөм хөтөлбөрт шинээр тусгасан агуулга, сурах бичигт тусгасан даалгаврыг хөгжүүлсэн, мөн өмнөх ангид судалсан агуулгатай залгамж холбоо бүхий гүнзгийрсэн агуулгаар үнэлгээний зорилт, шалгуурт нийцүүлэн боловсруулсан.
- Сурагчдын гүйцэтгэлийн ерөнхий дундаж 37.3 хувь байна.
- 8 дугаар ангийн сурагчдын сургалтын цөм хөтөлбөрт шинээр тусгасан агуулгын эзэмшилт 21.8 хувь байгаа нь багш нарын мэдлэг, заах арга зүйн ур чадвар, хандлага, сургалтын орчин бүрдүүлэлтээс хамааралтай байж болох юм.
- 7 дугаар ангид судалсан агуулгатай залгамж холбоо бүхий гүнзгийрсэн агуулга 57.1 хувь, сурах бичигт тусгасан даалгаврыг хөгжүүлсэн агуулга 51.6 хувийн гүйцэтгэлтэй байна

# Химийн сорилын гүйцэтгэлийн шинжилгээ

Суурь боловсролын 8 дугаар ангийн химийн сорилын даалгавар нь хувилбаргүй, олон сонголтот, богино болон бүтээх хариултат нийт 5 даалгавартай.

*Хүснэгт 74. Сорилын даалгаврын гүйцэтгэл (Хими, 8 дугаар анги)*

| *Үнэлгээний зорилт* | *Даалгаврын Жин (хувиар)* | *Онооны ээлэх хувь* | *Гүйцэтгэл (дундаж хувиар)* | *Төрөл* | *Тоо/Оноо* |
|---|---|---|---|---|---|
| Мэдлэг, ойлголт | 40 | 17 | 62.8 | Олон сонголтот | 2/2 |
| Мэдлэгээ хэрэглэх чадвар | 40 | 33 | 61.7 | Богино хариултат | 2/4 |
| Шинжлэх ухаанч арга барил (туршилтын) | 20 | 50 | 19.7 | Бүтээх хариултат | 1/7 |

*Мэдлэг, ойлголтыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Даалгавар 1.

Сонгох хариулттай 1 дүгээр даалгавар химийн лабораторид түгээмэл хэрэглэдэг цилиндрийг ялган таньж нэрлэх, мэдлэгийг үнэлэх зорилготой даалгавар байлаа.

*Зураг 71. Сорилын даалгаврын гүйцэтгэл (Хими, 8 дугаар анги)*




Энэхүү даалгавар хөнгөн )68.3(, ялгах чадвар сул )0.370( болсон байна.

Сурагчийн 68.3 хувь нь зөв хариултыг сонгосон байна. Харин 21.0 хувь нь А буруу хариултыг сонгосон байгаа нь хуруу шил, цлиндрийн хэлбэр төстэй байгаатай холбоотой байж болох юм. Б хариултын хувьд нийт сурагчийн 0.9 хувь буюу маш бага 5 сурагч сонгосон нь “аяга” гэсэн )ажилладаггүй үүрэггүй хариулт( үг орсоноос хамааралтай байна. Харин Г буруу хариултыг 9.3 хувь нь сонгосон нь буруу хариултын хэвийн гүйцэтгэл боловч Г хариулт сонгосон тэдгээр сурагчдын бусад даалгавруудын гүйцэтгэлийн дундаж 23.4 хувь байгаа нь ДэБ-ийн сурагчид олон алдсан байх магадлалтай. Энэ нь Г хариултад “пипетка” гэсэн гадаад нэр хэрэглэсэнтэй холбоотой хэмээн үзэв.

Даалгавар 2.

Сонгох хариултат 2 дугаар даалгавар химийн хатуу, шингэн, хийн 3 төлөвт явагдах диффузийн хурдыг харьцуулсан зөв эрэмбийг өгөгдлөөс сонгох зорилготой даалгавар юм.

*Зураг 72. Сорилын 2 дугаар даалгаврын гүйцэтгэл (Хими, 8 дугаар анги)*




Энэхүү даалгавар хөнгөн (57.4), ялгах чадвар сул (0.723) даалгавар болсон байна. Стандарт хазайлт 0.1 байгаа нь боломжийн гэсэн үг.

Сонгох хариултат 2 дугаар даалгаврыг нийт сурагчдын 57.4 хувь нь зөв хариулсан байна.

Даалгаврын Б хариултыг сурагчийн 32.4 хувь сонгосон нь диффузийн хөдөлгөөний хурд хий, шингэн, хатуу гэсэн төлөвийн эрэмбээр өөрчлөгддөгийг мэдэж байгаа боловч их, багын (<, >) тэмдгийг уншиж ойлгох чадвар дутмаг байгаатай холбоотой. Даалгаврын Б, Г хариултын дундаж хувь нь зөв хариултын дундажтай ойролцоо, давхар хариултыг бөглөсөн 1 сурагчийн дундаж 25.0 хувь байгаа нь диффузийн үзэгдлийн талаар зарим сургуулийн сурагчдын мэдлэг эргэлзээтэй буюу сэдвийг бага судалсан байх магадлал өндөр байна. Мөн диффузийн үзэгдэл нь ЕБС-ийн суурь боловсрлын химийн сургалтын хөтөлбөрт анх удаа орсон шинэ сэдэв тул багш нарын багшлах арга туршлага дутсан талтай байх магадлалтай.

*Мэдлэгээ хэрэглэх чадварыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Даалгавар 3.

Химийн диффузийн үзэгдлийг жижиг хэсгийн онолоор тайлбарлах, загварчлах мэдлэг чадварыг илрүүлэх зорилготой даалгавар юм.

Сурагчдын 43.6 хувь нь огт хариулаагүй, 0-2 хүртэл оноо авсан буюу гүйцэтгэлийн дундаж 56.4 хувь байгааг шинжилгээний үр дүн харуулж байна.

Сорилд хамрагдсан сурагчдын 29.4 хувь нь 2, 51.5 хувь нь 1, 19.5 хувь нь 0 оноог тус тус авсан байна. Гүйцэтгэл тааруухан гарсан шалтгаан нь диффузийн үзэгдэл сэдэв нь манай орны химийн сургалтын хөтөлбөрт анх удаа тусгасан сэдэв байхаас гадна түүнийг тайлбарладаг жижиг хэсгийн онол ч мөн шинэ агуулга болно. Диффузийн үзэгдлийг жижиг хэсгийн онолоор загварчлан харуулдаг арга зүй нь ч манай багш нарт бас шинэлэг юм. Иймд багш нарын туршлага дутсан байх талтай.

Даалгавар 4.

Энэхүү даалгавар нь химийн хэмжилт, түүн дотроо термометртэй ажиллах, термометрийн заалтыг зөв унших чадварыг илрүүлэх зорилготой даалгавар юм.

Даалгаврын шинжилгээнээс үзэхэд хүчинтэй гүйцэтгэлийн 85.3 хувь нь 2 гэсэн дээд оноог авсан нь энэ удаагийн хамгийн сайн гүйцэтгэлтэй болсон даалгавар юм. Алдсан сурагчдын гүйцэтгэлд анализ хийхэд даалгаврын өгөгдлийг уншиж ойлгох чадвар дутмагаас болж зураг дахь термометрийн “а” ба “б” гэсэн дугаарыг дугуйлсан байна.

*Шинжлэх ухаанч арга барилыг илрүүлэх, бүтээх хариултат даалгаврын шинжилгээ*

Даалгавар 5.

*Даалгаврын зорилго:* Химийн сорил туршилтын мэдлэг, чадвараар дамжуулан шинжлэх ухаанч арга барилд хэрхэн суралцаж байгааг илрүүлэх юм.

Энэ даалгаврыг сорил туршилтыг биечлэн гүйцэтгэсэн сурагчид л амжилттай хариулах боломжтой. Даалгавар 5 нь Блумын таксономийн когнитив үйлийн ялган таних, ойлгох, хэрэглэх, задлан шинжлэх түвшний асуулттай бөгөөд нийт 7 оноотой.

Нэгдсэн үр дүнгээс харахад даалгаврын бүх асуултын хүчинтэй гүйцэтгэл ба огт хариулаагүй сурагчдын тоо ойролцоо тоотой гарсныг дараах хүснэгтээр харууллаа.

*Хүснэгт 75. Сорилын 5 дугаар даалгаврын гүйцэтгэл (Хими, 8 дугаар анги)*

| | 5А | 5Б | 5В | 5Г | 5Д |
|---|---|---|---|---|---|
| Хүчинтэй | 285 | 276 | 240 | 252 | 218 |
| Хоосон | 252 | 261 | 297 | 285 | 319 |
| Нийлбэр | 160 | 127 | 104 | 50 | 89 |

2014 оноос хэрэгжиж эхэлсэн суурь боловсролын цөм хөтөлбөрт анх удаа туршилтын мэдлэг, чадварыг үнэлэх болсон билээ. Энэ үр дүн нь нэг талаас бид өмнө нь зөвхөн онолын мэдлэг, чадварыг олон жил үнэлж ирсэн, нөгөө талаас ЕБС-ийн үнэлгээнд олон жил олон сонголтот хариулттай даалгавраар үнэлж ирсэн практиктай холбоотой байж болох юм. Хэдийгээр сурах бичигт тусгаж өгсөн туршилт боловч даалгаварт задлан шинжлэх түвшний асуулт орсон тул зарим асуулт хүндэдсэн байх талтай. Учир нь манай сургалтын өмнөх уламжлал, практикт доод түвшний асуулт, үйл ажиллагаа зонхилж ирсэн байдаг.

Бүтээх хариулттай 5 дугаар даалгаврын гүйцэтгэлийг асуулт тус бүрээр шинжлэн авч үзье. 5а нь урвалд орж буй бодисын нэгийг илүүдэл авдаг шалтгааныг тайлбарлах Блумын таксономийн задлан шинжлэх түвшнийх байсан. Бүрэн дүүрэн хариулсан нэг ч сурагч байхгүй гэсэн үг. Энэ нь химийн сорил туршилтыг хийх, түүнийг тайлбарлах арга туршлага сул байгаатай холбоотой.

5а асуултын буруу хариултуудыг авч үзвэл хий ялгарахыг болиулахын тулд, натри ууршдаг, натрийн карбонат ууршдаг тул, натри хлороос илүү идэвхтэй, саармагжуулах, шатаасан гэж гэх мэтчилэн хариулсан байна. Энэ хариултууд нь 6 дугаар ангиас эхлэн химийн хичээлийн агуулгад туссан боловч химийн хэлд төдийлөн тайлагдаагүй байгааг илэрхийлж байна.

5б асуулт нь урвалд ороогүй үлдсэн илүүдэл карбонатыг урвалын орчноос хэрхэн салгах аргыг нэрлүүлэх байлаа. Гүйцэтгэлээс харахад сурагчдын бараг тал хувь нь огт хариулаагүй байна. Нийт сурагчдын 23.6 хувь асуултад зөв хариулсан. Энэ байдал нь химийн хичээлээр сорил туршилт бараг хийдэггүй, ялангуяа шинжлэх ухаанч арга барилыг төлөвшүүлэхийн тулд сурагчдаар бодуулах, сэтгүүлэх үйл ажиллагааг бага хийлгэдэг байх магадлал өндөр байна. Хэрвээ энэ туршилтыг сурагчид хийсэн бол илүүдэл үлдсэн натрийн карбонат нь тунаж үлдэх тул түүнийг шүүж авах боломжтой гэдгийг ямар ч сурагч ойлгон тайлбарлах боломжтой юм.

5в асуулт нь уусмалаас натрийн хлоридын талстыг гарган авах аргыг тайлбарлах ойлгох түвшний асуулт байлаа. Сурагчдын 55.3 хувь нь огт хариулаагүй бол 44.7 хувь ямар нэг байдлаар хариулж, амжилт нь 19.4 хувьтай байна. Хэрвээ сурагчид энэ туршилтыг гүйцэтгэсэн бол бүтээгдэхүүн болох натрийн хлоридыг уусмалаас уршуулах аргаар гарган авна гэдгийг ихэнх нь мэдэх учиртай. Сорилд хамрагдсан сурагчид энэ туршилтыг гүйцэтгэж байгаагүй, гүйцэтгэсэн гэж үзэхэд учир шалтгааныг нь тайлбарлаагүй гэдэг нь харагдаж байна.

5г асуулт нь туршилтаар явагдсан урвалыг үгэн тэгшитгэлээр илэрхийлэх, мэдлэгээ хэрэглэх чадварыг сорьсон юм. Сурагчдын 53.1 хувь нь огт хариулаагүй, 46.9 хувь нь хүчинтэй хариулт өгчээ. Ойлгох, мэдлэгээ хэрэглэх түвшний энэ асуултын амжилт нь 9.3 хувь байгаа нь сорилын хамгийн амжилтгүй гүйцэтгэсэн асуулт болж байна. Химийн сургалтын цөм хөтөлбөрт сурагчдын танин мэдэх онцлогтой холбоотойгоор 7-8 дугаар ангид химийн урвалыг үгэн тэгшитгэлээр илэрхийлэхээр суралцахуйн зорилтыг тусгасан. Энэ зорилтын биелэлт хангалтгүй байгаа нь багш нар хөтөлбөрөө баримтлахгүй байх, хуучин туршлагаараа химийн тэгшитгэлийг бичүүлж байгаатай холбоотой. Үүнийг ихэнх сурагчийн буруу хариултад байгаа химийн тэгшитгэл бичих оролдлого харуулж байна.

5д асуулт нь хүчлийг илүүдэл авдаггүй шалтгааныг тайлбарлах Блумын таксономийн задлан шинжлэх түвшний асуулт байлаа. Энэ асуултад сурагчдын 59.4 хувь нь огт хариулаагүй, 40.6 хувь нь ямар нэг байдлаар хариулснаас 16.6 хувь амжилттай хариулжээ. Энэ мөн л химийн хичээлээр сорил туршилтыг хийдэггүй, хийсэн ч мөн чанарыг химийн үүднээс тайлбарладаггүйтэй холбоотой гэсэн дүгнэлт гарч байна. Мөн когнитив үйлийн дээд түвшний чадвар эзэмшүүлэх үйлийг сурагчдаар хийлгэдэггүйтэй холбоотой байж болох юм.

*Хүснэгт 76. Сорилын даалгаврын нэгтгэл (Хими, 8 дугаар анги)*

| *Даалгаврын дугаар, Үнэлгээний зорилт* | *Агуулга* | *Зөв хариулт (%)* | *Хэлбэр* |
|---|---|---|---|
| 1. Мэдлэг ойлголт | Туршилтын багаж, сав суулга нэрлэх | 68.3 | ОСХ |
| 2. Мэдлэг ойлголт | Янз бүрийн төлөв дэх диффузийн хурд | 57.4 | ОСХ |
| 3. Мэдлэгээ хэрэглэх | Диффузийн үзэгдлийг загвараар харуулах | 45.5 | БоХ |
| 4. Мэдлэгээ хэрэглэх | Термометрийн хэмжилтийн заалтыг унших | 77.9 | БоХ |
| 5. Туршилтын мэдлэг, чадвар (ШУАБ) | 5А. Туршилтад бодисын илүүдэл авсан шалтгаан тайлбарлах | 29.8 | БүХ |
| | 5Б. Туршилтын үед холимгоос бодис салгах арга нэрлэх | 23.6 | |
| | 5В. Туршилтын эцсийн бүт-ийг ялган авах арга | 19.4 | |
| | 5Г. Туршитаар явагдсан урвалыг үгэн тэгшитгэлээр илэхийлэх | 9.3 | |
| | 5Д. Хүчил илүүдэл авдаг шалтгааныг тайлбарлах | 16.6 | |
| **Дундаж** | | 38.6 | |

*Зураг 73. Сорилын даалгаврын гүйцэтгэл (Хими, 8 дугаар анги)*

8 дугаар ангийн сурагчдын нийт даалгаврын дундаж 38.6 хувь байна. Сорилын сонгох хариултат болон богино хариултат даалгавраас туршилтын мэдлэг, чадварыг илрүүлэх даалгаврын гүйцэтгэл доогуур байна.




Химийн сорилын даалгаврын гүйцэтгэлийг тархалтын муруйгаас харвал судалгаанд хамрагдсан сурагчдын гүйцэтгэл хэвийн тархалттай байна.

Суурь боловсролын химийн сорилын үр дүнгээс харахад:

- 8 дугаар ангийн хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгаанд хамрагдсан сурагчдын сорилын гүйцэтгэлийн онооны дундаж 38.6 хувь байна. Энэ нь тодорхой зорилго тавьж бэлтгэсэн сурагчид өгдөг ЭЕШ-ийн сүүлийн жилүүдийн дундаж амжилт (ойролцоогоор 30 хувь)-аас дээгүүр үзүүлэлтэй байгаа юм.
- Туршилтын чадвар (шинжлэх ухаанч арга барил) эзэмшилтийг шалгах үнэлгээний зорилтын хүрээнд боловсруулсан туршилтын мэдлэг, чадвар илрүүлэх даалгаврын гүйцэтгэл 19.7 хувь байгаа нь мэдлэг, ойлголт, мэдлэгээ хэрэглэх даалгаврын гүйцэтгэлийн 62.3 хувиас 3 дахин бага хувьтай байна. Энэ нь химийн хичээлээр сорил туршилтыг сурагчид хийж, шинжлэх ухаанч арга барилыг төлөвшүүлэх цөм хөтөлбөрийн зорилтыг биелүүлж байгаа байдал нь эргэлзээтэй болов. Энэ даалгаварт тусгасан натрийн хлорид гаргах туршилт нь 8 дугаар ангийн сурах бичиг (тал 21-25)-ийн “Бодис гарган авах техник” нэгдүгээр бүлгийн 1.2. “Давс гарган авах техник” сэдэвт их хэмжээтэй хлорид гарган авах, уусмалаас хлорид гарган авах гэсэн хоёр аргыг сайтар тусгаж өгсөн байна. Мөн даалгаварт орсон үгэн тэгшитгэл бичих, яагаад карбонатыг илүүдлээр нэмсэн бэ? Яагаад илүүдэл карбонатыг шүүж байна вэ? гэсэн асуултууд ч туршилтын дараа тайлбарлахаар сурах бичигт орсон байна.
- Сургалтын цөм хөтөлбөрт анх удаа тусгасан диффузийн үзэгдэл зэрэг сэдэвт асуудлыг жижиг хэсгийн онолын үндэслэлтэй тайлбарлах, загварчлах мэдлэг, чадвар дутмаг байна. Энэ баримт нь цөм хөтөлбөрийн үзэл санааны дагуу агуулга арга зүйн хувьд гүнзгий сургалтыг биш, баримтын мэдлэгт суурилсан сургалтыг явуулсан хэвээр байна гэж үзэхээр байна.

## Физикийн сорилын гүйцэтгэлийн шинжилгээ

Суурь боловсролын 8 дугаар ангийн физикийн сорилын даалгавар нь мэдлэг, чадвар, шинжлэх ухаанч арга барилыг үнэлэх 5 даалгавартай.

*Хүснэгт 77. Сорилын даалгаврын жин (Физик, 8 дугаар анги)*

| *Агуулга* | *Даалгаврын эзлэх хувь* | *Онооны эзлэх хувь* |
|---|---|---|
| Мэдлэг, ойлголт | 40 | 16.7 |
| Мэдлэгээ хэрэглэх чадвар | 40 | 33.3 |
| Шинжлэх ухаанч арга барил | 20 | 50 |

Сорилын даалгавар боловсруулахдаа мэдлэг ойлголтыг илрүүлэх даалгавар, мэдлэгээ хэрэглэх чадварыг илрүүлэх даалгавар, шинжлэх ухаанч арга барил эзэмшилтийг илрүүлэх даалгаврын нийт оноонд эзлэх хувь 17: 33: 50 байхаар боловсруулсан нь сургалтын цөм хөтөлбөрт тусгасан үнэлгээний зорилт, шалгуур, жинг баримтлан мэдлэгээ хэрэглэх чадвар, сурах арга барилыг илрүүлэхэд зорилго оршино.

Мэдлэг, ойлголтыг илрүүлэх даалгаврын шинжилгээ

Даалгавар 1.

Даалгаврын зорилго: Хүч, даралт, талбайн хоорондын хамаарлыг гаргах. Энэ даалгавар нь хүч, даралт, талбайн хоорондын хамаарлын ойлголтыг илрүүлэх зорилготой.

Биеийн хөдөлгөөнд хүчний үзүүлэх нөлөө, биед үзүүлэх гравитацийн нөлөө зэргийг туршилтаар судлан шинжилж, хүчний шинж чанарыг тодорхойлон, дүрслэн үзүүлэхийг 6 дугаар ангид судалсан. Хатуу биетийн даралтыг хүчний үйлчлэлээр үүсдэг болохыг туршилтаар илрүүлэх, хүч ба талбайг даралттай холбон тайлбарлахыг 8 дугаар ангийн 1 дүгээр улиралд судалсан.

Даалгаврын хүндрэлийн зэрэг тохиромжтой, ялгах чадвар маш сайн байна.

Сурагчдын 49.7 хувь нь Б буюу зөв хариултыг сонгосон байна. А буруу хариултыг нийт сурагчийн 24 хувь сонгосон нь даралт болон талбай хоёрын хоорондын хамаарлыг ойлгоогүй байна. Харин В буруу хариултыг 12.8 хувь нь сонгосон нь мөн дээрхийн адил зөв ойлголт дутмаг байгааг харуулж байна. Мөн Г буруу хариултыг 12.1 хувь сонгосон нь дарах хүч болон даралтын хоорондын хамаарлыг ойлгоогүй байна.

Даалгавар 2.

Даалгаврын зорилго: Шингэний жингийн даралтыг тодорхойлох.

Энэ даалгавар нь шингэний даралт шингэний баганы өндөртэй шууд пропорционал учир ёроол дахь даралт савны хэлбэр ба ёроолын талбайгаас хамаарахгүй гэдгийг ойлгож байгаа эсэхийг илрүүлэх зорилготой.

Даалгаврын хүндрэлийн зэрэг хүнд, ялгах чадвар муу байна.

Сурагчдын 22.9 хувь нь Г буюу зөв хариултыг сонгосон байна. Харин 47.3 хувь нь Б буюу буруу хариултыг сонгосон байна. Энэ нь шингэний зүгээс савны ёроолд учруулах даралтыг биш, савнуудын ёроолын талбайг харьцуулж, савны доод талын тулгуууртаа учруулах даралтыг гэж ойлгон сонгосон байж болох юм. Эдгээр сонголтыг хийсэн сурагчид нь талбайгаас, даралт хэрхэн хамаарахыг ойлгосон боловч шингэний жингийн даралтын талаарх ойлголт дутмаг байгааг харуулж байна. А буруу хариултыг нийт сурагчийн 26.3 хувь сонгосон нь шингэний жингийн даралт өндрөөс хамаарах талаарх ойлголт бага байна. Харин В буруу хариултыг 3.9 хувь нь сонгосон нь мөн дээрхийн адил зөв ойлголт дутмаг байгааг харуулж байна.

Мэдлэгээ хэрэглэх чадварын даалгаврын шинжилгээ

Даалгавар 3

Даалгаврын зорилго: Хатуу биеийн даралтыг тодорхойлох.

Хатуу биеийн даралтыг тодорхойлох, даралтын томьёо нэгжийг хэрэглэж чадаж байгаа эсэхийг илрүүлэх зорилготой.

Сурагчдын 28.9 хувь нь бүрэн хариулж 2 оноогоо авсан. Харин 0.4 хувь дутуу бодолт хийсэн учир 1 оноо авсан. Харин 70.6 хувь нь буруу хариулсан. Даалгаврыг ихэнх сурагчид хийсэн боловч буруу гүйцэтгэсэн нь энэ талын мэдлэг дутмаг байгаа нь харагдаж байна. Мөн хатуу биеийн даралтын томьёогоо мэдэхгүй байгаа нь харагдаж байна. Даалгаврын тавилын хувьд сонгох хэлбэрээр өгөгдсөн учир материал дээр бодолт хийхгүйгээр шууд сонголт хийсэн нь ихэнх сурагчдын хувьд оноо 0 болсон байх магадлал ажиглагдаж байна.

Даалгавар 4

*Даалгаврын зорилго:* Хэмжилтийн үр дүнг ашиглах. Графикаар өгөгдсөн хэмжилтийн үр дүнг ажиглаж дүгнэлт хийж чадаж байгаа эсэхийг илрүүлэх зорилготой.

Сурагчдын 44.3 хувь нь 4а даалгаварт зөв хариулсан байна. Харин 55.7 хувь нь буруу, алдаатай хариулсан байна. Сурагчид хэдэн удаа хэмжилт хийснийг бус, хэмжилт үргэлжилсэн хугацааг графикаас ажиглаж тэмдэглэсэн байна. Сурагчдын 80.4 хувь нь 4б даалгаварт зөв хариулсан байна. 19.4 хувь нь буруу, алдаатай хариулсан байна. Алдаатай гүйцэтгэсэн сурагчид графикын босоо тэнхлэгийн утгыг шууд харж тэмдэглэсэн байна. Энэ даалгаврын гүйцэтгэлээс харахад сурагчдыг график унших чадварыг хөгжүүлэх шаардлага харагдаж байна.

*Шинжлэх ухаанч арга барилыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Даалгавар 5

*Даалгаврын зорилго:* Агаарын даралтыг тодорхойлох.

Өдөр тутмын амьдрал ахуй дээрх үзэгдлийг мэдлэгээ ашиглаж тайлбарлаж чадаж байгаа эсэхийг илрүүлэх зорилготой. Энэ даалгавар 12 жилийн үндэсний хөтөлбөр болон сургалтын цөм хөтөлбөрт тусгагдсан.

*Хүснэгт 78. Шинжлэх ухаанч арга барилыг үнэлэх даалгаврын гүйцэтгэл (Физик, 8 дугаар анги*

| | *Minimum* | *Maximum* | *Mean* | *Std. Deviation* |
|---|---|---|---|---|
| Д:5а | 0.0 | 1.0 | .213 | .4099 |
| Д:5б | 0.0 | 1.0 | .508 | .5004 |
| Д:5в | 0.0 | 2.0 | .182 | .4289 |
| Д:5г | 0.0 | 2.0 | .476 | .5178 |

Сурагчдын 19.4 хувь нь 5-I, 46.9 хувь нь 5-II, 9.1 хувь нь 5-III, 23.8 хувь нь 5-IV даалгаварт зөв хариулсан байна. Эндээс харахад яагаад ийм болдгийг зурж, тайлбарлана уу гэсэн даалгаварт гүйцэтгэлийн хувь нь хамгийн бага байна. Хэдийгээр сурагчид тодорхой хэмжээгээр хариулсан боловч ихэнх нь буруу хариулсан байгаагаас харахад энэ талын мэдлэг дутмаг байж болох юм. Сурагчдын аливаа зүйлийг зурах, тайлбарлах чадвар дутагдалтай байгаа нь харагдаж байна. Мөн олж авсан мэдлэгээ хэрэглэх чадвар тааруу байна.

*Зураг 74. Сорилын даалгаврын гүйцэтгэл (Физик, 8 дугаар анги)*




Судалгаанд хамрагдсан сурагчдын гүйцэтгэлийн хувьд арифметик дундаж 30.8 хувь, медиан 25.0 хувь, моод 25.0 хувь, хамгийн өндөр гүйцэтгэл 75 хувь, хамгийн бага гүйцэтгэл 0 хувь байна.

Сурагчдын гүйцэтгэл хэвийн тархалттай байна.

Суурь боловсролын физикийн сорилын үр дүнгээс харахад:

- Суурь боловсролын 8 дугаар ангийн физикийн сорилын гүйцэтгэлийн тархалтыг графикаас харвал судалгаанд хамрагдсан сурагчдын гүйцэтгэл баруун гар тал руугаа бага зэргийн шилжилттэй гарсан байна.
- Даалгаврын гүйцэтгэлийн хувиас харахад арифметик дундаж 30.8 хувь, медиан 25.0 хувь, моод 25.0 хувь, стандарт хазайлт 16.5 хувь, хамгийн өндөр гүйцэтгэл нь 84.6 хувь байна. Эндээс сорилын гүйцэтгэл дундаж түвшинд байна гэсэн дүгнэлт гаргах боломжтой байна.

## Газар зүйн сорилын гүйцэтгэлийн шинжилгээ

Суурь боловсролын 8 дугаар ангийн газарзүйн сорилын даалгавар нь мэдлэг, чадвар, шинжлэх ухаанч арга барилыг илрүүлэх 5 даалгавартай.Мөн мэдлэгээ хэрэглэх чадвар, шинжлэх ухаанч арга барил эзэмшилтийг илрүүлэх даалгаврын эзлэх хувь өндөр байх зорилго тавьсан.

*Хүснэгт 79 Сорилын даалгаврын жин (Газарзүй, 8 дугаар анги)*

| *Агуулга* | *Даалгаврын эзлэх хувь* | *Онооны эзлэх хувь* | *Гүйцэтгэлийн дундаж хувь* |
|---|---|---|---|
| Мэдлэг, ойлголт | 40 | 15 | 52 |
| Мэдлэгээ хэрэглэх чадвар | 40 | 31 | 35 |
| Шинжлэх ухаанч арга барил | 20 | 54 | 37 |

*Мэдлэг, ойлголтыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Даалгавар 1.

*Даалгаврын зорилго:* Монгол орны газарзүйн байрлалын онцлогийг нэрлэх. Энэ даалгавар нь Монгол орны газарзүйн байрлалын онцлогийг бусад шинжүүдээс ялган таньж байгаа эсэхийг илрүүлэх зорилготой.

Сургалтын цөм хөтөлбөрт гео орон зайн дүрслэл бүлэгт газар орны үнэмлэхүй болон харьцангуй байрлалыг ялган тодорхойлж, газарзүйн хэлээр илэрхийлэх, сонирхсон газар нутгийнхаа байрлалын давуу, давуу бус байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, ашигтай байрлалыг сонгох чадвар эзэмшинэ гэж тусгасан байдаг.

*Хүснэгт 80. Сорилын 1 дүгээр даалгаврын гүйцэтгэл (Газарзүй, 8 дугаар анги)*

| *Хариултын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэлийн хувь* | *Зөв хариулт* |
|---|---|---|---|
| 1 | А. З.У85$^{0}$-д оршдог | 31.2 | |
| 2 | Б Далайд гарцгүй | 47.6 | + |
| 3 | В Казахстан улстай хиллэдэг | 4.2 | |
| 4 | Г Дундаж өндөр нь 950 м | 14.8 | |
| 5 | Огт хариулаагүй | 1.8 | |
| 6 | Хариулт хүчингүй | 0.1 | |

Даалгаврын хүндрэлийн зэрэг дундаж, ялгах чадвар дундаж байна.

Даалгавар 2.

*Хүснэгт 81. Сорилын 2 дугаар даалгаврын гүйцэтгэл (Газарзүй, 8 дугаар анги)*

| *Хариултын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэлийн хувь* | *Зөв хариулт* |
|---|---|---|---|
| 1 | А Цагийн бүсийн ялгаа үүссэн | 41.4 | + |
| 2 | Б. Гадаргын усны хуваарилалтад нөлөөлсөн | 13.1 | |
| 3 | В. Газрын гадарга баруунаас зүүн тийш намссан | 17.2 | |
| 4 | Г Хүн ам Улаанбаатарт нягтран суурьшсан | 24.8 | |
| 5 | Огт хариулаагүй | 0 | |
| 6 | Хүчингүй хариулт | 3.4 | |

Даалгаврын хүндрэлийн зэрэг тохиромжтой, ялгах чадвар сайн байна.

*Мэдлэгээ хэрэглэх даалгаврын шинжилгээ*

Мэдлэгээ хэрэглэх чадварыг илрүүлэх даалгаврыг богино хариулттай байхаар боловсруулсан.

Даалгавар 3.

*Даалгаврын зорилго:* Сургалтын цөм хөтөлбөрт газарзүйн зурагт юмсын дүрслэгдсэн байдлыг ажиглан масштаб, агуулгыг нь харьцуулах ангилах, анализ хийж чаддаг болно. Байр зүйн зургаас байгалийн (гадарга, гол мөрөн, нуур, ургамалжилт г.м) болон нийгмийн (суурин,үйлдвэр, зам, худаг г.м) юмс үзэгдлийг ялган унших ашиглах чадвартай болно гэж тусгасан. Энэ даалгавар нь газарзүйн зургийн агуулга эзэмшилтийг илрүүлэх буюу байр зүйн зургаас байгалийн юмс үзэгдлийг хэрхэн дүрсэлсэн, юмс үзэгдлийг ялган таних, унших, ашиглах чадварыг тодорхойлох зорилготой.

Даалгавар 4.

*Даалгаврын зорилго:* Сургалтын цөм хөтөлбөрт нар ба дэлхийн харилцан байрлалаас шалтгаалж, өдрийн үргэлжлэх хугацаа өөрчлөгдөн дэлхийн гадарга дээр гэрэл, дулааны хуваарилалтын ялгаатай байдал үүсдэг шалтгааныг туршилтаар нотолж, шинжлэх ухаанч арга барилд суралцана. Нарны өндөр ба өдрийн үргэлжлэх хугацааны хамаарлыг графикаар дүрслэх, дүгнэлт хийх аргад суралцана. Энэ даалгаврыг сурах бичигт өгөгдсөн хүснэгтийг хөгжүүлэх байдлаар боловсруулсан.

3, 4 дүгээр даалгаврын хариултын шинжилгээ

*Хүснэгт 82. Сорилын 3, 4 дүгээр даалгаврын гүйцэтгэл (Газарзүй, 8 дугаар анги)*

| *Даалгавар* | *Оноо* | *Хариултын мэдээлэл (гүйцэтгэлийн хувиар)* | | | | *Гүйцэтгэлийн дундаж* |
|---|---|---|---|---|---|---|
| | | *2 оноо авсан* | *1 оноо авсан* | *Буруу хариулсан* | *Огт хариулаагүй* | |
| Д:3 | 2 | 9 | 180 | 336 | 12 | 18.4 |
| Д:4 | 2 | 90 | 373 | 54 | 20 | 51.5 |

Богино хариулттай 2 даалгаврын гүйцэтгэл 35 хувь байгаа нь багшийн заах арга зүйг сайжруулах, тэдэнд арга зүйн дэмжлэг үзүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

*Шинжлэх ухаанч арга барилыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Даалгавар 5.

*Даалгаврын зорилго*: Хүн амын тоо өсөлт нягтшлыг өөрийн орны жишээн дээр судалж, нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлон тайлбарлана. Энэ даалгаврын гол зорилго нь хүснэгтэд өгөгдсөн Өмнөговь аймгийн хүн амын тоон мэдээллийг ашиглан шугаман график байгуулах, байгуулсан графикаас хүн амын өсөлт хамгийн их байсан хугацаа, өссөн шалтгааны тайлбарлах, нягтшил тооцох гэх мэт анализ дүгнэлт хийх, график байгуулах бүтээлч чадварыг илрүүлэхэд оршино.

*Хүснэгт 83. Сорилын 5 дугаар даалгаврын гүйцэтгэл (Газарзүй, 8 дугаар анги)*

| *Даалгавар* | *Оноо* | *Хариултын мэдээлэл (гүйцэтгэлийн хувиар)* | | | |
|---|---|---|---|---|---|
| | | *2 оноо* | *1 оноо* | *Буруу хариулсан* | *Огт хариулаагүй* |
| Д:5а | 2 | 15.6 | 19.2 | 60.9 | 4.3 |
| Д:5б | 2 | 4.5 | 0.2 | 71.5 | 23.8 |
| Д:5в | 2 | 31.5 | 23.8 | 28.3 | 16.4 |
| Д:5г | 1 | | 34.3 | 23.1 | 42.6 |

Сорилын даалгавар боловсруулахдаа мэдлэг ойлголтыг илрүүлэх даалгавар, мэдлэгээ хэрэглэх чадварыг илрүүлэх даалгавар, шинжлэх ухаанч арга барил эзэмшилтийг илрүүлэх даалгаврын нийт оноонд эзлэх хувь 17:33:50 байхаар боловсруулсан нь сургалтын цөм хөтөлбөрт тусгасан үнэлгээний зорилт, шалгуур, жинг баримтлан мэдлэгээ хэрэглэх чадвар, сурах арга барилыг илрүүлэх зорилго тавьсан болно.

Даалгавар 1. Сурагчдын 47.6 хувь Б буюу зөв хариултыг сонгосон байна. Харин 31.2 хувь нь А, 14.8 хувь нь Г, 4.2 хувь нь В хариултыг тус тус сонгосон байгаа нь Монгол орны газарзүйн байрлалд хамааралгүй үзүүлэлтийг газарзүйн байрлалын онцлогтой харьцуулан ойлгохдоо алдаа гаргасан байна.

Даалгавар 2. Сурагчдын 41.4 хувь нь А буюу зөв хариултыг сонгосон байна. Харин 24.8 хувь нь Г буюу буруу хариултыг сонгосон байгаа нь асуултыг хариулттай харьцуулан ойлгохдоо алдаа гаргаж зөвхөн “Хүн ам Улаанбаатарт нягтран суурьшсан” гэдгийг үнэн гэж хараад сонгосон байх талтай. Гэтэл Монгол орон өргөрөгийн дагуу сунаж тогтсон нь хүн ам Улаанбаатарт нягтран суурьшсантай холбоогүй гэдгийг олон суралцагч мэдэхгүй байгааг харуулж байна. Б буруу хариултыг нийт суралцагчийн 13.1 хувь сонгосон нь гадаргын усны хуваарилалт нь өргөрөг, уртрагаас хамааралгүй гэдгийг ойлгоогүй байна. Харин В буруу хариултыг 17.2 хувь нь сонгосон нь мөн дээрхийн адил зөв ойлголт дутмаг байгааг харуулж байна.

Даалгавар 3. Сурагчдын гүйцэтгэлээс харахад 0 оноо авсан 336 буюу 62.6 хувь, 1 оноо авсан сурагч 180 буюу 34.3 хувь, 2 оноо авсан сурагч 9 буюу 1.7 хувь, дундаж гүйцэтгэлийн хувь 18.4 хувьтай үнэлэгдсэн нь сурагчдын хувьд газрын зургийн хаяалбар шугам түүний шатлал, зүг чиг, таних тэмдэг уншиж ойлгох чадвар дутмаг, багш нарын хувьд энэ агуулгыг заах арга зүйг сайжруулах, тэдэнд арга зүйн дэмжлэг үзүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Даалгавар 4. Сорилд хамрагдсан сурагчдаас1 оноо авсан 373 буюу нийт сурагчдын 69.4 хувь байна. 2 оноо авсан сурагч 90 буюу 16.7 хувь байна. Энэ нь сурагчид хүснэгтэд өгөгдсөн тоон үзүүлэлтээс өдөр хамгийн урт болон богино үргэлжлэх хотуудыг зөв ялгасан боловч яагаад гэсэн асуултад хариулах, учир шалтгааныг тайлбарлахдаа хангалтгүй байна.

Даалгавар 5. Тухайн даалгавруудаас 5б даалгаврын гүйцэтгэл хамгийн муу буюу нийт сурагчдын 4.7 хувь нь оноо авсан байна. Энэ нь цөм хөтөлбөрт тухайн агуулга шинээр орсон бөгөөд багш нар энэ агуулгыг хангалтгүй заасан байгаа нь харагдаж байна.

Мөн 5г даалгаврыг хамгийн олон хүүхэд буюу нийт сурагчдын 42.3 хувь нь огт хариулаагүй байгаа нь анхаарал татаж байна. Сурагчдын агуулга эзэмшилтийг дараах байдлаар ангилан судалж, үр дүнг хүснэгтэд харуулав.

*Хүснэгт 84. Сорилын агуулгын гүйцэтгэл (Газарзүй, 8 дугаар анги)*

| *Агуулга* | *Даалгаврын дугаар* | *Гүйцэтгэлийн дундаж хувь* |
|---|---|---|
| Сургалтын цөм хөтөлбөрт шинээр тусгасан агуулга | 1, 2 | 52 |
| Өмнөх ангид судалсан агуулгатай залгамж холбоо бүхий гүнзгийрсэн агуулга | 3, 5 | 37 |
| Сурах бичигт тусгасан даалгаврыг хөгжүүлсэн агуулга | 4 | 36.1 |

*Хүснэгт 85. Сорилын даалгаврын хамаарал (Газарзүй, 8 дугаар анги)*

| | Д:1 | Д:2 | Д:3 | Д:4 | Д:5а | Д:5б | Д:5в | Д:5г | gscore |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Д:1 | 1 | .167 | .139** | -.015 | .171** | .046 | .015 | .095 | .381** |
| Д:2 | .167 | 1 | .103* | .174** | .179** | .111* | .097* | .036 | .463** |
| Д:3 | .139 | .103* | 1 | .021 | .186** | .102* | .101* | .125* | .424** |
| Д:4 | -.015 | .174* | .021 | 1 | .119** | .126* | .058 | .087 | .375** |
| Д:5а | .171 | .179* | .186** | .119** | 1 | .157** | .110* | .134* | .609** |
| Д:5б | .046 | .111* | .102* | .126* | .157** | 1 | .040 | .051 | .408** |
| Д:5в | .015 | .097* | .101* | .058 | .110* | .040 | 1 | .174** | .532** |
| Д:5г | .095 | .036 | .125* | .087 | .134* | .051 | .174** | 1 | .432** |
| gscore | .381 | .463** | .424** | .375 | .609 | .408** | .532** | .432** | 1 |

Даалгавар хоорондын хамаарлыг авч үзэхэд 1, 4 дүгээр даалгаврын хамаарал сөрөг утгатай, бусад даалгаврын хамаарал хоорондоо эерэг утгатай байна.

*Хүснэгт 86. Сорилын даалгаврын гүйцэтгэл (Газарзүй, 8 дугаар анги)*




Судалгаанд хамрагдсан сурагчдын гүйцэтгэлийн хувьд арифметик дундаж 32.7 хувь, медиан 30.1 хувь, моод 38.6 хувь, хамгийн өндөр гүйцэтгэл 84.6 хувь, хамгийн бага гүйцэтгэл 0 хувь, хэвийн тархалттай байна.

Суурь боловсролын газарзүйн сорилын үр дүнгээс харахад:

- Сорилын дундаж гүйцэтгэл 32.7 хувьтай байна. Сорилын даалгаврын стандарт тархалтаас харахад хэвийн байна.
- Сорилын гүйцэтгэлийг ойлголтын түвшнээр авч үзэхэд мэдлэг ойлголтын түвшний даалгаврын гүйцэтгэл харьцангуй өндөр 52,4 хувь байгаа боловч багш нарын хувьд мэдлэгээ хэрэглэх, шинжлэх ухаанч арга барилын даалгавар боловсруулах, энэ чиглэлийн даалгаврыг сурагчдаар гүйцэтгүүлэх тал дээр анхаарах шаардлагатай нь харагдаж байна.

## Монголын түүхийн сорилын гүйцэтгэлийн шинжилгээ

Суурь боловсролын 8 дугаар ангийн монголын түүхийн сорил нь сургалтын цөм хөтөлбөрт заасан мэдлэг, ойлголт болон мэдлэгээ хэрэглэх чадварыг илрүүлэх 4 даалгавраас бүрдэнэ.

*Хүснэгт 87. Сорилын даалгаврын жин (Монголын түүх, 8 дугаар анги)*

| *Агуулга* | *Даалгаврын эзлэх хувь* | *Онооны эзлэх хувь* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|---|
| Мэдлэг, ойлголт | 50,0 | 33.3 | 34.5 |
| Мэдлэгээ хэрэглэх чадвар | 50,0 | 96.7 | 48.3 |
| Шинжлэх ухаанч арга барил | - | - | - |

Мэдлэг, ойлголтыг илрүүлэх даалгаврын шинжилгээ

Даалгавар 1

Даалгаврын зорилго*:* Монголын түүхийн гарамгай зүтгэлтэн хүмүүсийн төрсөн он цаг, газар нутгийг зөв танин мэдэж, ойлгох

Даалгаврын зэрэг хөнгөн, ялгах чадвар дундаж болох нь шинжилгээний үр дүнгээс харагдаж байна.

Энэхүү даалгавар нь хамгийн тохиромжтой (82.1 хувь), ялгах чадвар дундаж (28.3) болсон байна. Сурагчдын 82.1 хувь нь зөв хариултыг, 17.9 хувь нь буруу хариултыг сонгожээ. Үүний 1.3 хувь нь А буруу хариултыг сонгосон байна. В буруу хариултыг 4.7 хувь сонгосон нь Чингис хааны төрсөн он болон төрсөн газрыг ялгаагүй, өөрөөр хэлбэл, түүхэн он цаг, орон зайн хамаарлыг дутмаг ойлгосноос болжээ. Г буруу хариултыг 11.4 хувь нь сонгосон нь Чингис хааны төрсөн он цагийг тодорхой мэдээгүйтэй холбоотой гэж үзэж байна.

Даалгавар 2

*Даалгаврын зорилго:* Монголын Их Юань улс мөхсөний дараа хөрш Хятадад ямар улс байгуулагдсаныг зөв мэдэх, сонгох.

Хүндрэлийн зэрэг тохиромжтой, ялгах чадвар дундаж болох нь шинжилгээний үр дүнгээс харагдаж байна.

Энэхүү даалгавар нь маш хөнгөн (64.4 хувь), ялгах чадвар дундаж (21.4), стандарт хазайлт 0.1 даалгавар болсон байна. Сурагчдын 64.4 хувь нь зөв хариулт, 35.6 хувь нь буруу хариултыг сонгожээ. А зөв хариултыг 64.4 хувь сонгосон нь Хятадын Мин улсын

оршин тогтнож байсан хугацааг сурагчдын 60-аас дээш хувь нь ойлгожээ. Б буруу хариултыг нь 4.1 хувь, В буруу хариултыг 1.9 хувь сонгосон байна. Г буруу хариултыг 29.4 хувь сонгосон нь Манж чин улсын оршин тогтносон хугацааг Мин улсынхтай андуурсан гэж үзэхээр байна.

Даалгавар 3

*Даалгаврын зорилго*: Монголын түүхийн тухайн үеийн богино хугацаанд Монголын төрийг олон хаан барьж, хаадууд хаан ширээний төлөө тэмцэлдэж байсан үеийг зөв таних, тодорхойлох чадвартай байх

Хүндрэлийн зэрэг тохиромжтой, ялгах чадвар дундаж болох нь харагдаж байна.

Энэхүү даалгавар нь маш хөнгөн (65.4), ялгах чадвар дундаж (25.5), стандарт хазайлт 0.1 даалгавар болсон байна. Сурагчдын 65.4 хувь нь зөв хариултыг, 36.6 хувь нь буруу хариултыг сонгожээ. В зөв хариултыг 65,4 хувь сонгосон нь тэдний энэ талын мэдлэгийн хэрэглээний байдлыг илрүүлж байна. Сорилд хамрагдсан сурагчдын 3.5 хувь нь А буруу хариултыг сонгосон. Б буруу хариултыг 25,9 хувь нь сонгосон. Мөн Г буруу хариултыг 4.8 хувь нь сонгосон. Сурагчдын буруу хариултуудыг шинжилбэл, түүхэн хүмүүс, түүхэн үйл явдлын он цагийн эхлэх, дуусах хугацаа болон түүхэн гарамгай зүтгэлтэн хүмүүсийн түүхэн үүргийг тодорхойлох чадварыг бүрэн эзэмшээгүйтэй холбоотой байна.

Даалгавар 4

*Даалгаврын зорилго*: 15-17-р зууны Монголын бүтэц, бүрэлдэхүүнийг зөв ойлгох, нэрлэх, тайлбарлаж чаддаг байх

Хүндрэлийн зэрэг хүнд, ялгах чадвар дундаж байгаа хагадаж байна.

Энэхүү даалгавар нь маш дундаж (28.9 ), ялгах чадвар дундаж (26.2) байна. Сурагчдын 28.9 хувь нь зөв хариултыг, 71.1 хувь нь буруу хариултыг сонгожээ. Б зөв хариултыг 28,9 хувь, өөрөөр хэлбэл, сорилд хамрагдсан сурагчдын 30 хүрэхгүй хувь гүйцэтгэсэн нь анхаарал татаж байна. Сорилд хамрагдсан сурагчдын 9.7 хувь А буруу хариултыг, В буруу хариултыг 31.3 хувь, Г буруу хариултыг 28.1 хувь сонгосон нь 15-17-р зууны үед Монголчууд улс төрийн зөрчлийн улмаас эхлээд, түүхэн газар нутаг, байршлын хувьд Зүүн Монгол ба Баруун Монгол хэмээх хоёр хэсэгт хуваагдсаныг тодорхой ойлгоогүйтэй холбоотой байна.

*Задгай даалгаврын шинжилгээ*

*Хүснэгт 88. Даалгавар хоорондын хамаарлын шинжилгээ (Монголын түүх, 8 дугаар анги)*

| | *5.1а* | *5.1б* | *5.1в* |
|---|---|---|---|
| 5.1a sig.(2 tailed) | | 0.026 | 0.76 |
| 5.1 б.(2 tailed) | 0.026 | | 0.695 |
| 5.1 в.(2 tailed) | 0.071 | 0.0695 | |

Сурагчийн 54.4 хувь нь Б даалгаврыг зөв гүйцэтгэж, 39.6 хувь нь буруу гүйцэтгэсэн бөгөөд эндээс сурагчид тайлбарлах арга барилыг нийтлэг эзэмшсэн байна гэж үзэж болно. А, В даалгаврын гүйцэтгэл 12.1-34.5 хувь буюу ангийн дундаж гүйцэтгэлээс доогуур байгаа нь учир шалтгааныг тайлбарлах, ялгааг гаргах үйлийг гүйцэтгэх арга барил дутагдалтай байгааг илэрхийлж байна. Даалгаврын хамаарлын шинжилгээний дүнгээс үзэхэд 5.1а даалгавар нь 5в, 5б даалгавартай; 5б даалгавар нь 5а, 5в даалгавартай; 5в даалгавар нь 5б, 5а даалгавартай тус тус хамааралтай найдварын зэрэг 0.261 байна.

*Хүснэгт 89. Даалгавар хоорондын хамаарлын шинжилгээ (Монголын түүх, 8 дугаар анги)*

| | *5.2а* | *5.2б* | *5.2.в* | *5.2г* |
|---|---|---|---|---|
| 5.2а .(2 tailed) | | 0.001 | 0.279 | 0289 |
| 5.2 б.(2 tailed) | 0.001 | | 0.042 | 0.231 |
| 5.2 в.(2 tailed) | 0.279 | 0.042 | | 0.012 |
| 5.2 .(2 tailed) | 0.289 | 0.231 | 0.012 | |

Сурагчийн 31.7 хувь нь А даалгаврыг зөв гүйцэтгэж, 39.6 хувь нь буруу гүйцэтгэсэн. Сурагчид үндэслэл гаргаж тайлбарлах арга барилыг нийтлэг эзэмшсэн байна. Б, В, Г даалгаврын гүйцэтгэл 11,4-17,8 хувийн ангийн дундаж гүйцэтгэлээс доогуур гүйцэтгэж байгаа нь тодорхойлох, баримтаар нотлох, шалтгааныг тайлбарлах үйлийг гүйцэтгэх арга барил дутагдалтай байгааг илэрхийлж байна. Даалгаврын хамаарлын шинжилгээний дүнгээс үзэхэд 5.2 а даалгавар нь 5в, 5б, 5г даалгавартай; 5б даалгавар нь 5г, 5в даалгавартай; 5в даалгавар нь 5б, 5г даалгавартай, 5,2 г даалгавар нь 5а, 5б, 5г даалгавартай тус тус хамааралтай.

*Зураг 75. Сорилын даалгаврын гүйцэтгэл (Монголын түүх, 8 дугаар анги)*




Судалгаанд хамрагдсан сурагчдын гүйцэтгэлийн хувьд арифметик дундаж 34.6 хувь, хамгийн өндөр гүйцэтгэл 100 хувь, хамгийн бага гүйцэтгэл 0 хувь, хэвийн тархалттай байна.

*Суурь боловсролын монголын түүхийн сорилын үр дүнгээс харахад:*

- Тухайн сорилын 1 дүгээр даалгавар хамгийн тохиромжтой (82.1), ялгах чадвар дундаж (28.3) болсон ба сурагчдын гүйцэтгэл 82.1 хувь байна. Гэхдээ Чингис хааны төрсөн он болон төрсөн газрыг ялгаагүй, өөрөөр хэлбэл, сурагч түүхэн он цаг, орон зайн хамаарлыг дутмаг ойлгосон нь харагдаж байна.
- 1, 2 дугаар даалгаврыг сурагчдын 64.4- 65.4 хувь зөв гүйцэтгэсэн бөгөөд буруу хариултын шинжилгээ нь сурагчдын Монголын түүхийн он цагийн мэдлэг дунд зэрэг, мөн түүхэн хүмүүс, түүхэн үйл явдлын эхлэх, дуусах хугацаа болон түүхэн гарамгай зүтгэлтэн хүмүүсийн түүхэн үүргийг тодорхойлох чадварыг бүрэн эзэмшээгүйг харуулж байна.
- 4 дүгээр даалгаврын гүйцэтгэлийг шинжилбэл,15-17-р зууны үед Монголчууд улс төрийн зөрчлийн улмаас эхлээд, түүхэн газар нутаг, байршлын хувьд Зүүн Монгол ба Баруун Монгол гэсэн хоёр хэсэгт хуваагдсаныг тодорхой ойлгоогүй баримт нь тэдний түүхэн он цаг, орон зай, тэдгээрийн холбоо хамаарлын мэдлэг, ойлголт хангалтгүй байгааг илтгэж байна.
- Задгай даалгаврын гүйцэтгэл нь түүхэн үйл явдал, үзэгдлийг тодорхойлох, баримтаар нотлох, шалтгаан, үр дагаврыг тайлбарлах арга барил дутагдалтай байгааг илэрхийлж байна.

- Монголын түүх хичээлийн сонгох болон задгай даалгаврын гүйцэтгэлд нөлөөлж буй голлох хүчин зүйлийн тоон шинжилгээнээс харахад, түүнд сурагчийн сурах барил, багшийн заах арга зүй шууд болон дам хамаарал, нөлөөлөлтэй байгааг харуулав.

## Нийгмийн ухааны сорилын гүйцэтгэлийн шинжилгээ

Суурь боловсролын 8 дугаар ангийн нийгмийн ухааны сорил нь сургалтын цөм хөтөлбөрт заасан мэдлэг, ойлголт, мэдлэгээ хэрэглэх чадвар, шинжлэн судлах арга барилыг илрүүлэх 4 даалгавраас бүрдэнэ.

*Хүснэгт 90. Сорилын даалгаврын жин (Нийгмийн ухаан, 8 дугаар анги)*

| *Агуулга* | *Даалгаврын эзлэх хувь* | *Онооны эзлэх хувь* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|---|
| Мэдлэг, ойлголт | 50.0 | 33.3 | 34.0 |
| Мэдлэгээ хэрэглэх чадвар | 25.0 | 33.3 | 75.8 |
| Шинжлэх судлах арга барил | 25.0 | 33.3 | 10.4 |

*Сонгох хариултат даалгаврын шинжилгээ*

Даалгавар 1*.*

*Даалгаврын зорилго*: Орон нутгийн амьдралд гол нөлөө үзүүлэгч бүлгийн тодорхойлолтыг зөв нэрлэх, бүлгийг тодорхойлж буй үндсэн шинжийг сурагчид зөв танин мэдсэн байх.

Хүнд, хөнгөний зэрэг тохиромжтой, ялгах чадвар сайн байна.

Нийт сорилд оролцсон сурагчдын 38.9 хувь нь бүлэг хэмээх ойлголтыг тодорхойлж буй тодорхойлолтын үндсэн шинжийг мэдэхийн зэрэгцээ түүний гүйцэтгэх чиг үүрэг, зорилгыг ойлгосон байна. Бүлгийн жишээг зөв нэрлэсэн. Бусад хариултыг сонгосон сурагчдын хувьд тухайн ойлголтын тодорхойлолтын үндсэн шинжийг танин мэдээгүй, бусад ойлголтын зарим шинжүүрээс ялгаж, салгах, таних чадвар сул байна.

Даалгавар 2*.*

*Даалгаврын зорилго*: Орон нутагт тулгамдаж буй асуудлыг ялган таньж, тэдгээрийг хувь хүний хэрэгцээний шатлалын онолыг үндэслэн шийдвэрлэх

Хүнд, хөнгөний зэрэг хүнд, ялгах чадвар муу байна*.*

Нийт сорилд оролцсон сурагчдын 22.5 хувь нь хувь хүний хэрэгцээний шатлалын эрэмбийг зөв нэрлэсэн байна. Мөн бусад 3 хувилбарыг 20.0 гаруй хувьтай ижил тэнцүү сонгосон нь гэр бүл, хайр сэтгэл, найз нөхөд, ажлыг чухалчилж сонголтоо хийжээ.

Даалгавар 3*.*

*Даалгаврын зорилго*: Нийгмийн ухааны шинжлэн судлах арга барилын эхний алхам болох таамаглал дэвшүүлэх алхамыг ялгах

Хүнд, хөнгөний зэрэг хэт хүнд, ялгах чадвар маш сул болох нь шинжилгээний үр дүнгээс харагдаж байна.

Сорилд оролцсон сурагчдын 10.4 хувь нь нийгмийн ухааны хичээлд шинжлэн судлах арга барилын эхний алхам болох таамаглалыг зөв нэрлэсэн. Таамаглал, мэдээллийн ялгааг таних чадвар сул. Хүн амын тооллогын дүнгээр Монгол улсад хүний дундаж наслалт 67

байна гэсэн хувилбарыг сурагчдын 32.2 хувь нь нэрлэсэн байна. Бусад хувилбарууд нь мэдээллийн агуулгын шинжээр боловсруулсан. Цөөнгүй тооны сурагч таамаглал гэж хичээл дээр судлаагүй гэж бичсэн байна. Уг арга барилаар хичээл зохион байгуулалт тохирох сэдвүүдээр хэрэгжихгүй байгаа тал ажиглагдаж байна.

Даалгавар 4*.*

*Даалгаврын зорилго*: Бүлгүүдийн хооронд зөрчилдөөн үүсэх нөхцөлийг танин мэдэж, зөрчилдөөний шийдвэрлэх арга зам, хандлагыг зөв тодорхойлох

Хүнд, хөнгөний зэрэг хөнгөн, ялгах чадвар сайн болох нь шинижлгээний үр дүнгээс харагдаж байна.
Нийт сорилд оролцсон сурагчдын 75.8 хувь нь зөрчилдөөнийг шийдвэрлэх арга зам, хандлагыг зөв тодорхойлсон байна. 10.4 хувийг сонгосон сурагчдын хувьд зөв хариулттай 2, 3 дахь өгөгдлийг сольж түлхүүрийг хийсэн нь сурагчдыг төөрөгдүүлэхэд хүргэсэн гэж үзэхээр байна. Мөн сурагч даалгаврыг ажиллах явцад анхаарал суларсан зөвхөн 1, 2 хариултыг уншиж хариулсан нь алдаа гаргасан байна.

*Задгай хариулттай даалгаврын шинжилгээ*

Даалгавар 5*.*

*Даалгаврын зорилго*: Харьяалагдах байгууллага бүлгийн зорилго болон гүйцэтгэх үүрэг, байр сууриа зөв илэрхийлэх

Сорилд оролцсон сурагчдын 1.9 хувь нь байгууллага, бүлгийн зорилго болон гүйцэтгэх үүрэг, байр сууриа бүрэн илэрхийлж байгаа бол 32.1 хувь нь байгууллага, бүлэгт гүйцэтгэх гүйцэтгэх үүрэг, байр сууриа илэрхийлэх нь сул байна. Тухайлбал, сурагчдын зөвлөлийн бүлгийн зорилго, гүйцэтгэх үүргийг үнэн зөв илэрхийлэн бичихдээ тааруу байна. Энэ нь тухайн судалгаанд хамрагдсан сургуулиудад сурагчдын зөвлөл 8 дугаар ангийн сурагчдын хүрээнд зохион байгуулах үйл ажиллагаа дутмаг байгаатай холбоотой.

Даалгавар 6**.**

*Даалгаврын зорилго:* Орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулах, идэвхтэй оролцох шинэлэг санаа, хувилбарууд дэвшүүлэх, мөн бусдыг уриалах, оролцуулах.

*Зураг 76. Сорилын даалгаврын гүйцэтгэл (Нийгмийн ухаан, 8 дугаар анги)*




Судалгаанд хамрагдсан сурагчдын гүйцэтгэлийн хувьд арифметик дундаж 38.6 хувь, хамгийн өндөр гүйцэтгэл 100 хувь, хамгийн бага гүйцэтгэл 0 хувь, хэвийн тархалттай байна.

Суурь боловсролын нийгмийн ухааны сорилын үр дүнгээс харахад:

- Тухай хичээлийн сорилд оролцсон сурагчид (1 дүгээр даалгаврын хувьд) бүлэг хэмээх ойлголтын тодорхойлолт, чиг үүрэг, зорилгыг дутуу ойлгосон, тухайлбал, уг ойлголтын үндсэн шинжийг бүрэн танин мэдээгүй, бусад ойлголтоос ялгах, хэрэглэх чадвар хангалтгүй байгааг харуулж байна.
- 2 дугаар даалгаврын гүйцэтгэлийн хувьд сурагчид хэрэгцээний шатлалаас гэр бүл, хайр сэтгэл, найз нөхөд, ажил хөдөлмөрийг чухалчилж сонголтоо хийсэн ба харин хэрэгцээний шатлалыг бүрэн ойлгоогүй нь харагдаж байна.
- 3 дугаар даалгаврын гүйцэтгэлийн шинжилгээ нь нийгмийн ухааны хичээлд шинжлэн судлах арга барил хэрэгжихгүй байгааг баримтаар (даалгавар гүйцэтгэгчдийн зөвхөн 10.4 хувь нь шинжлэн судлах арга барилын эхний алхам болох таамаглалыг нэрлэсэн) харуулж байна.
- 4 дүгээр даалгаврын хувьд сурагчдын гүйцэтгэл 75.8 хувь байгаа нь тэд зөрчилдөөнийг шийдвэрлэх арга зам, хандлагын чадварыг дундаж төвшинд эзэмшсэнийг илтгэж байна.
- Задгай хариулттай даалгаврын шинжилгээ нь сурагчид тухайн асуудлаар өөрийн байр сууриа илэрхийлэх болон орон нутагтаа тулгамдаж буй асуудлыг олох, шийдвэрлэх арга замын чадварыг сул эзэмшсэнийг харуулж байна.
- Нийгмийн ухаан хичээлийн сонгох болон задгай даалгаврын гүйцэтгэлд нөлөөлж буй голлох хүчин зүйлийн тоон шинжилгээнээс харахад, түүнд сурагчийн сурах барил шууд болон дам хамаарал, нөлөөлөлтэй байгааг илрүүлэв.

## Хөгжмийн сорилын гүйцэтгэлийн шинжилгээ

Суурь боловсролын 8 дугаар ангийн хөгжмийн сорилын даалгавар нь мэдлэг, чадвар, бүтээлч эрэлхийллийн арга барилыг үнэлэх 5 даалгавартай. Мөн сорилын даалгаварт мэдлэгээ хэрэглэх чадвар, бүтээлч эрэлхийллийн арга барил эзэмшилтийг үнэлэх даалгаврын эзлэх хувь өндөр байх зорилготой бөгөөд тухайн агуулгад онооны эзлэх хувийг дараах хүснэгтээс харж болно.

*Хүснэгт 91. Сорилын даалгаврын жин (Хөгжим, 8 дугаар анги)*

| *Агуулга* | *Даалгаврын эзлэх хувь* | *Онооны эзлэх хувь* | *Гүйцэтгэлийн дундаж* |
|---|---|---|---|
| Мэдлэг, ойлголт | 40.0 | 23.0 | 68.5 |
| Мэдлэгээ хэрэглэх чадвар | 30.0 | 38.4 | 34.8 |
| Бүтээлч эрэлхийллийн арга барил | 30.0 | 38.4 | 45.8 |

Сорилын даалгавар боловсруулахдаа мэдлэг ойлголтыг илрүүлэх даалгавар нь нийт даалгаврын оноонд 23:38:38 хувь эзлэхээр боловсруулсан нь сургалтын цөм хөтөлбөрт тусгасан үнэлгээний зорилт, шалгуурыг баримтлан мэдлэгээ хэрэглэх, бүтээлчээр гүйцэтгэх чадварыг илрүүлэх зорилготой нийцэж байгаа юм.

*Мэдлэг үнэлэх даалгаврын шинжилгээ*

Даалгавар 1.

Даалгаврын зорилго: Сонгодог дуулаачийн төрөл тус бүрийн онцлог, илэрхийлэх арга хэрэглүүрийн талаарх ойлголтыг илрүүлэх

Сургалтын цөм хөтөлбөрт сонгодог дуурь, дуулаачийн хөгжмийн төрөл, хэлбэрийн онцлогийг мэдэрч, сонирхон судлах, илэрхийллийн аргуудыг таньж мэдэх агуулга тусгаж оруулсан байдаг.

Энэ даалгаврын хүндрэлийн зэрэг 60.9 буюу оновчтой, ялгах чадвар нь маш сайн байна.

*Зураг 77. Сорилын 1.1, 1.2- дугаар даалгаврын гүйцэтгэл (Хөгжим, 8 дугаар анги)*




Даалгаврын шинжилгээнээс үзэхэд сорилд хамрагдсан нийт сурагчдын 87.9 хувь нь 1-р даалгаврын "в" хариулт, 60.9 хувь нь 2-р даалгаврын "в" хариултыг зөв сонгосон байна. Харин 10.3 хувь нь эхний даалгаврын, 38.0 хувь нь дараагийн даалгаврын буруу хариултыг сонгосон байгаа нь дуулаачийн хөгжмийн төрлийг ялган таньж чадахгүй байгааг харуулж байна. Харин 3.0 хувь нь огт хариулт сонгоогүй хоосон орхисон байгаа нь дээрх агуулгын талаар ойлгоогүй байна гэж үзэж болохоор байна.

*Сонсох чадварыг үнэлэх даалгаврын шинжилгээ*

Даалгавар 2.

Даалгаврын зорилго: Дууны ноот бичлэг дэх тэмдэг тэмдэглэгээг таньж, хурд, өнгө аясыг тодорхойлох

Сургалтын цөм хөтөлбөрт дуулаачийн хөгжмийн бүтээлээс үзэж, сонсон төрөл, хэлбэр, илэрхийллийн аргууд, тэдгээрийн онцлогийг мэдэрч, ойлгон хэрэглэх агуулгыг тусгаж оруулсан байдаг.

Энэ даалгаврын хүндрэлийн зэрэг 79.7 буюу хялбархан, ялгах чадвар багатай байна.

*Зураг 78. Сорилын 2.1, 2.2 дугаар даалгаврын гүйцэтгэл (Хөгжим, 8 дугаар анги)*




Сурагчдын ноот бичлэгийг уншиж, тэмдэг тэмдэглэгээг таньж, аялгууны хурд, өнгө аясыг мэдэрч дуулах чадварыг илрүүлэх зорилгоор авсан.

Даалгавар 1, 2-ийн гүйцэтгэлээс харахад сурагчдын аялгууны хурд (48 хувь), өнгө аяс (79.7 хувь)-ыг тодорхойлох чадвар зохих түвшинд байгаа харагдаж байгаа боловч 4.4 хувь нь огт хариулаагүй байна. Энэ нь сэргээн санах, цээжлэх, бататгах зэрэг үйлүүд хангалтгүй хийгдэж байна гэж үзэж болохоор байна.

Даалгавар 1-ийн тухайд сурагчдын 38.2 хувь нь “в” хариултыг сонгосон байгаа нь хариултын хувилбар хоорондоо ойролцоо утгыг илэрхийлсэн, сурагчдад эргэлзээтэй байдлыг бий болгосон байх талтай байна.

Даалгавар 3*.*

*Даалгаврын зорилго:* Хөгжмийн зохиолчдын бүтээлийг (Ж.Верди “Аида” дуурийн Ялгуусан марш) сонсоод айзам хэмжээ, хурд, аялгууны шинж төрхийг тодорхойлох

Сургалтын цөм хөтөлбөрт дуурь, бүжгэн жүжгийн хөгжмийн бүтээлийг сонирхон судлах, сонгодог хөгжмийн зохиолчдын арга барил, бүтээлийн дүрслэл, илэрхийллийн арга хэрэглүүрийн талаар сонсож мэдэх агуулга тусгагдсан байдаг.

Энэ даалгаврын хүндрэлийн зэрэг 28.3 буюу хүнд, ялгах чадвар нь сөрөг байна*.*

Аялгууны шинж төрхийг тодорхойлох даалгаврын тухайд 51.8 хувь нь “а” хариултыг, 28.3 хувь нь “в” хариултыг сонгосон байгаа нь “а” болон “в” хариулт төстэй, сурагчдыг эргэлзэхэд хүргэсэн ойролцоо утга бүхий үг хэллэг байгаатай холбоотой байж болох юм гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

*Зураг 79. Сорилын 3.1, 3.2 дугаар даалгаврын гүйцэтгэлийн харьцуулалт (Хөгжим, 8 дугаар анги)*




Ж.Верди “Аида” дуурийн Ялгуусан маршийг сонсоод гүйцэтгэсэн даалгаврын үр дүнг харахад сэдэв аялгууг тоглосон хөгжмийн зэмсэгжилтийг тодорхойлох чадвар өндөр, харин зохиолын айзам хэмжээг тодорхойлох чадвар доогуур түвшинд байгаа харагдаж байна.

Дээрх даалгавруудын гүйцэтгэлийг ерөнхийд нь авч үзэхэд бага боловсролын түвшинд үзсэн хөгжмийн онолын суурь, мэдлэг ойлголтыг суурь боловсролд сонсох, дуулах, хөгжимдөх үйлийн явцад үргэлжлүүлэн ойлгуулж, бататгаж, дадал болгох асуудал учир дутагдалтай байгааг харуулж байна.

*Задгай даалгаврын шинжилгээ*

*Даалгаврын зорилго*: Хөгжмийн онолын нэр томьёо, тэмдэг тэмдэглэгээг ялган таньж, хэрэглэж буй байдлыг илрүүлэх

*Зураг 80. Задгай хариулттай даалгаврын гүйцэтгэл (Хөгжим, 8 дугаар анги)*




Задгай хариулттай даалгавар 1-д хөгжмийн хэрэглүүрүүдийн онцлог шинж, үүрэг зориулалтыг дуулах, хөгжимдөх үйл ажиллагаатай холбон ойлгох байдлыг илрүүлэх зорилгоор боловсруулсан бөгөөд гүйцэтгэлээс харахад зөв хариулсан 60.1 хувьтай байгаа нь сурагчид тодорхой ойлголттой байгааг харуулж байна. Харин сурагчдын 39.9 хувь буруу хариулсан байна.

Сурагчид хэмнэлийг гүйцээж зохиох, өөрийн хувилбарыг боловсруулах, хэмнэлээр дамжуулж өөрийн болон бусад улс орны хөгжмийн онцлог тус бүрийг мэдэх боломжтой бөгөөд энэ удаад задгай даалгавар 2-т хэмжээнд хэмнэлийг гүйцээж бичихээр өгсөн болно. 

Задгай хариулттай даалгавар 2-ын гүйцэтгэлээс харахад сурагчдын 2.6 хувь нь хэмнэлийг зөв гүйцээж бичсэн бол 97.4 хувь нь буруу бичсэн байна. Энэ нь байнгын дадал хэвшил болж чадахгүй, суурь боловсролд ихэвчлэн сурах бичгээс хөгжмийн зохиолчдын намтар, уран бүтээлийн талаар хуулж бичих үйлийг хийлгээд, дуулах, хөгжимдөх, зохион найруулах үйлийг бага хийлгэж байгаатай холбоотой байж болох юм.

Задгай хариулттай даалгавар 3-ын тухайд Ц.Намсрайжав "Халуун элгэн нутаг" дууны ноот бичлэгт байгаа тэмдэг, тэмдэглэгээг нэрлэж бичихээр боловсруулсан бөгөөд сурагчдын гүйцэтгэлийг харахад 8.2 хувь нь зөв нэрлэж бичсэн байхад 91.8 хувь нь нэрлэж чадаагүй байна. Сурагчдын буруу хариултыг үзэхэд тухайн агуулгыг хичээл, үйл ажиллагаанд тогтмол хэрэглээ болгоход анхаарч ажиллахгүй, ноот бичвэртэй бага ажиллуулж байгааг харуулж байна.

Сургалтын цөм хөтөлбөрөөр сурагчдын урлагийн бүтээлийг мэдэрч, бүтээлч сэтгэлгээгээр илэрхийлж, гүйцэтгэх чадварыг хөгжүүлэх болон урлаг, соёлын талаарх ойлголтыг гүнзгийрүүлж, гоо сайхны мэдрэмжтэй хүн болгон төлөвшүүлэх зорилго тавьсан билээ. Энэхүү зорилгыг хангахад чиглэсэн агуулга эзэмшилтийг дараах байдлаар ангилан, үр дүнг хүснэгтэд харуулав.

*Хүснэгт 92. Агуулгын гүйцэтгэл (Хөгжим, 8 дугаар анги)*

Сурагчдын даалгаврын гүйцэтгэлийг агуулга тус бүрт харгалзах байдлаар нь шинжилж үзэхэд дараах байдалтай байна.

| | *Даалгаврын дугаар* | | *Гүйцэтгэлийн хувь* | *Стандарт хазайлт* |
|---|---|---|---|---|
| Сургалтын цөм хөтөлбөрт тусгасан агуулга | A1 | | 59,7 | .4900 |
| | A4 | | 3,0 | .3190 |
| | Б | 1 | 8,7 | .5490 |
| | | 2 | 48,8 | .5001 |
| | | 3 | 78,8 | .4026 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Сурах бичигт тусгасан даалгаврыг хөгжүүлсэн агуулга | А2 | | 87,0 | .3265 |
| | А3 | | 59,0 | .9769 |
| | Б | 4 | 24,2 | .4242 |
| | | 5 | 29,1 | .4509 |
| | | 6 | 84,3 | .3489 |

*Хүснэгт 93. Даалгаврын хамаарал (Хөгжим, 8 дугаар анги)*

| | *ЗД:1* | *Д:1* | *Д:2* | *ЗД: 2* | *ЗД: 3* | *Д:3* | *Д:4* | *Д:5* | *Д:6* | *Д:7* |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| ЗД: 1 | 1 | .001 | .174** | .085* | .202** | -.062 | -.042 | -.007 | .022 | .062 |
| Д: 1 | .001 | 1 | .182** | .025 | -.056 | .014 | .026 | .030 | -.084 | .029 |
| Д:2 | .174** | .182** | 1 | .059 | .128** | -.054 | .032 | .029 | -.056 | .058 |
| ЗД: 2 | .085* | .025 | .059 | 1 | .249** | .006 | -.005 | .075 | .027 | .066 |
| ЗД: 3 | .202** | -.056 | .128** | .249** | 1 | -.043 | .049 | -.021 | -.052 | -.015 |
| Д: 3 | -.062 | .014 | -.054 | .006 | -.043 | 1 | .124** | -.040 | .008 | .038 |
| Д: 4 | -.042 | .026 | .032 | -.005 | .049 | .124** | 1 | .061 | .040 | .008 |
| Д: 5 | -.007 | .030 | .029 | .075 | -.021 | -.040 | .061 | 1 | .023 | .061 |
| Д:6 | .022 | -.084 | -.056 | .027 | -.052 | .008 | .040 | .023 | 1 | .065 |
| Д:7 | .062 | .029 | .058 | .066 | -.015 | .038 | .008 | .061 | .065 | 1 |

Даалгавар хоорондын хамаарлыг SPSS программмын correlation-р авч үзэхэд задгай даалгавар 1, 2, 3 болон даалгавар 1, 2, 3, 4 хоорондоо хамааралтай нь батлагдаж байна. Тухайлбал; задгай хариулттай даалгавар 1 )хөгжмийн нэр томьёог харгалзуулах( нь даалгавар 2 )дуулаачийн урлагийн төрлийг харгалзуулах(-той sig 0,174, задгай хариулттай даалгавар 2)хэмнэлийг гүйцээх(-той sig 0,085-ын, задгай хариулттай даалгавар 3 )тэмдэг тэмдэглэгээг нэрлэх(-тай sig 0,202-ын, даалгавар 1 )дуулаачийн хөгжмийн төрлийг сонгох( нь даалгавар 2 )дуулаачийн урлагийн төрлийг харгалзуулах(-той sig 0,182-ын,даалгавар 2 )дуулаачийн урлагийн төрлийг харгалзуулах( нь задгай хариулттай даалгавар 1 )хөгжмийн нэр томьёог харгалзуулах( -тэй sig 0,174-ын, даалгавар 1)дуулаачийн хөгжмийн төрлийг сонгох( -тэй sig 0,182"ын, задгай хариулттай даалгавар 3 )тэмдэг тэмдэглэгээг нэрлэх(- тай sig 0,128-ын,задгай хариулттай даалгавар 2 )хэмнэлийг гүйцээх( нь задгай даалгавар 1-тэй sig 0,085-ын, задгай хариулттай даалгавар 3-тай sig 0,249-ын, задгай хариулттай даалгавар 3 )тэмдэг тэмдэглэгээг нэрлэх( нь задгай 1 )хөгжмийн нэр томьёог харгалзуулах( -тэй sig 0,202-ын, даалгавар 2 )дуулаачийн урлагийн төрлийг харгалзуулах( -той sig 0,128-ын, задгай хариулттай даалгавар 2)хэмнэлийг гүйцээх(-той sig 0,249-ын, даалгавар 3)дууны хурдыг тодорхойлох( нь даалгавар 4 )дууны өнгө аясыг тодорхойлох(-тэй sig 0,124-ын хамааралтай байна.

*Хүснэгт 94. Даалгаврын статистик ач холбогдол, найдварт байдал (Хөгжим, 8 дугаар анги)*

| | *95 хувийн магадлал* | | | | |
|---|---|---|---|---|---|
| | t | P<0.05 | Дундаж үзүүлэлтийн ялгаа | Интервалийн ялгаа (95хувь Confidence Interval of the Difference) | |
| | | Sig. (2-tailed) | | Доод интервал | Дээд интервал |
| ЗД:1 | 28.443 | .000 | 60.15 | 56.00 | 64.30 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Д:1 | 62.387 | .000 | 87.90 | 85.10 | 90.70 |
| Д:2 | 28.890 | .000 | 60.80 | 56.75 | 65.00 |
| ЗД:2 | 3.788 | .000 | 52.10 | 25.00 | 79.00 |
| ЗД:3 | 6.916 | .000 | 16.39 | 11.70 | 21.00 |
| Д:3 | 22.263 | .000 | 48.04 | 43.80 | 52.30 |
| Д:4 | 45.877 | .000 | 79.70 | 76.30 | 83.10 |
| Д:5 | 12.819 | .000 | 23.46 | 19.90 | 27.10 |
| Д:6 | 14.547 | .000 | 28.31 | 24.50 | 32.10 |
| Д:7 | 57.020 | .000 | 85.85 | 82.90 | 88.80 |

Даалгавар тус бүрийн үр дүнгийн p<0,05-аас бага байгаа нь статистик ач холбогдолтойг харуулж байна.

*Зураг 81. Сорилын даалгаврын гүйцэтгэл (Хөгжим, 8 дугаар анги)*




Судалгаанд хамрагдсан сурагчдын гүйцэтгэлийн хувьд арифметик дундаж 42.8 хувь, хэвийн тархалттай байна.

Суурь боловсролын хөгжмийн сорилын үр дүнгээс харахад:

- Сурагчдын гүйцэтгэлийг даалгавар тус бүрээр авч үзэхэд задгай даалгавар 2, 3-ыг буюу айзам хэмд тохируулан хэмнэлийг гүйцээж бичих, ноот бичлэгээс тэмдэг тэмдэглэгээг ялган таних чадвар сул байна. Үүнээс гадна 5, 6 даалгавар буюу айзам хэмжээ, аялгууны шинж төрхийг тодорхойлох даалгаврыг мөн л бага хувьтай гүйцэтгэсэн байна. Энэхүү бууралт нь даалгаврын агуулгыг бага боловсролд үзсэн хэдий ч суурь боловсролд үргэлжлүүлэн үзэх ёстой бөгөөд давтан хийж бататгах, сонсох, дуулах, хөгжимдөх үйл ажиллагаа бага хийж байгаатай тодорхой хэмжээгээр холбоотой байж болох юм.
- Сорилын даалгаварт орсон хөгжмийн онолын нэр томьёо, тэмдэг тэмдэглэгээг нэрлэх, бичих, дуу болон хөгжим сонсох чадварыг гүйцэтгэл хангалтгүй байна. Энэ нь хөгжмийн сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, сурагчдын идэвх оролцоо, багшийн заах арга зүй, үйл ажиллагаатай холбоотойг харуулж байна.

## Дүрслэх урлагийн сорилын гүйцэтгэлийн шинжилгээ

Суурь боловсролын 8 дугаар ангийн дүрслэх урлагийн сорил нь танин мэдэхүйн ойлгох, хэрэглэх, бүтээх түвшний 5 даалгавартай, сорил нийт 12 оноотой. А хэсэгт мэдлэг, ойлголтыг илрүүлэх 2 даалгавар, Б хэсэгт мэдлэгээ хэрэглээ, бүтээлч эрэлхийллийн арга барилын чадварыг илрүүлэх 3 даалгаврыг боловсруулсан байна.

*Хүснэгт 95. Сорилын даалгаврын жин (Дүрслэх урлаг, 8 дугаар анги)*

| *Танин мэдэхүйн түвшин* | *Даалгаврын дугаар* | *Онооны хуваарилалт* | *Үнэлгээний жин* |
|---|---|---|---|
| Мэдлэг, ойлголт | А-2, | 2 | 17 хувь |

| | | | |
|---|---|---|---|
| Мэдлэгээ хэрэглэх | Б-2 | 4 | 33 хувь |
| Бүтээх | Б-1 | 6 | 50 хувь |
| **Нийт** | 5 даалгавар | 5 оноо | 100 хувь |

Суурь боловсролын дүрслэх урлагийн сургалтын хөтөлбөрийн агуулга нь суралцагчийн хүрээлэн буй орчноо харж ажиглах, ойлгох, утга өгөх, өөрсдийн санаагаа дүрслэл ашиглан бүтээх, турших, мэдрэмж, туршлагаа солилцох ,санаа хөгжүүлэх, урлагийн үнэ цэнийг олж харах, өөрсдийн амьдрал дахь дүрслэх урлагийн холбоо хамаарлыг ухааран ойлгох чадвар, хандлагыг хөгжүүлэхэд чиглэгддэг. 8 дугаар ангийн дүрслэх урлагийн сорилын даалгаврыг боловсруулахдаа судалгаанд хамрагдсан тухайн ангийн судлах агуулгаас гадна өмнөх ангийн агуулгын залгамж холбоог уялдуулан авч үзсэн. Сургалтын хөтөлбөр болон сорилын даалгавраар илрүүлэх мэдлэг, чадварын холбогдох байдлыг авч үзвэл:

*Хүснэгт 96 Сургалтын хөтөлбөрийн агуулга, сорилын даалгаврын холбогдох байдал (Дүрслэх урлаг, 8 дугаар анги)*

| *Танин мэдэхүйн түвшин* | *Даалгаврын дугаар* | *Сургалтын хөтөлбөрийн холбогдох агуулга* | |
|---|---|---|---|
| | | *Агуулгын бүлэг* | *Мэдлэг, чадвар* |
| Мэдлэг | Даалгавар 1. | Урлагийн хэл | Ахромат ба хромат өнгүүдийг таних, нэрлэх |
| | Даалгавар 2. | | Уран зургийн зохиомжийн арга, шийдлүүдийг нэрлэх |
| Мэдлэгээ хэрэглэх | Даалгавар 3. | Урлан бүтээхүй | Таталбар болон зураасан зургийн онцлогыг тайлбарлах |
| | Даалгавар 4. | | Монголын зураачдын уран зураг унших, тайлбарлах |
| Бүтээх | Даалгавар 5. | | Геометрийн биетүүдийг зохиомж үүсгэн орон зайтай дүрслэх |

*Зураг 82. Сорилын даалгаврын гүйцэтгэл (Дүрслэх урлаг, 8 дугаар анги)*




Даалгавар тус бүрийн сурагчдын гүйцэтгэлээс даалгавар 4-ийн гүйцэтгэл 48.5 хувь буюу бусад даалгаврын гүйцэтгэлээс илүү харагдаж байгаа ч сорилын бүх даалгаврын сурагчдын гүйцэтгэл 50 хувиас доош, сорилын дундаж гүйцэтгэл 30 гаруй хувьтай байгаа нь хангалттай үзүүлэлт биш юм. Танин мэдэхүйн ойлгох, мэдлэгээ хэрэглэх, бүтээх түвшний даалгаврын сурагчдын гүйцэтгэлийг харьцуулан авч үзэхэд ялгаа ажиглагдсангүй.

Дүрслэх урлагийн сорилд хамрагдсан сурагчдын даалгаврын гүйцэтгэлийг авч үзье.

*Зураг 83. Сорилын даалгаврын гүйцэтгэл (Дүрслэх урлаг, 8 дугаар анги)*




Дүрслэх урлагийн сорилд сурагчид 10 онооны 5 даалгаврыг гүйцэтгэсэн ба гүйцэтгэлийн дундаж 34.5 хувьтайгаар шалгагдсан байна.

Сорилын 5-н даалгавар хоорондын хамаарлыг авч үзвэл:

Бүтээх түвшний 5 дугаар даалгавар нь 2 дугаар даалгавартай ач холбогдол бүхий хамааралтай байгаа бол 3, 4 дэх даалгавартай чухал ач холбогдол бүхий хүчтэй хамааралтай байна. Мөн 3 болон 4 дүгээр даалгаврууд нь хоорондоо чухал ач холбогдол бүхий хүчтэй хамааралтай байгааг статистик үзүүлэлт харуулж байна. Энэхүү статистик үзүүлэлт нь сорилы хамаарал бүхий даалгаврууд нь хоорондоо хэр зохицсоныг харуулж байгаа ба тухайн сорилын найдвартай байдлын нэг үзүүлэлт болж байгаа юм.

*Мэдлэг, ойлголтыг үнэлэх даалгаврын шинжилгээ*

Сорилын сонгох 2 даалгавар нь мэдлэг ойлголтыг илрүүлэхэд чиглэнэ.

Даалгаврын зорилго: Зохиомжийн хэрэгсэл, зарчмуудын талаарх мэдлэг ойлголтыг илрүүлнэ.

Даалгавар 1. Хромат өнгүүдийг таних, нэрлэх

Сорилд хамрагдсан сурагчид бүгд тухайн даалгаврыг хариулсан байна. Үүний 24.6 хувь нь зөв гүйцэтгэсэн бол 75.4 хувь нь буруу хариулсан байна. Тухайн даалгавар нь А, Б, В гэсэн гурван сонгох хувилбартай бөгөөд буруу хариулсан сурагчдын гүйцэтгэлийн авч үзэхэд Б хувилбарыг сурагчдын 59.2 хувь нь сонгосон байна.

Энэ нь тухайн хариултын хувилбарыг сурагчид таамаглан сонгосон байх магадлалтай юм. Учир нь зөв хариулттай бусад сонголт нь төсөөтэй байхад Б сонголтын агуулга эрс ялгаатай байна. Иймд сонголттой даалгаврын хариултын хувилбарыг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна. Мөн сурагчдын ахромат ба хромат өнгийн талаарх мэдлэг, ойлголт тааруухан байгааг харуулж байна.

Тестаны үр дүнгээс тухайн даалгаврын хүнд хөнгөний зэрэг нь 24.6, ялгах чадвар 5.5 ).272( байгаа нь тухайн даалгавар нь хүндрэлийн зэрэг хувьд хүнд, ялгах чадвар маш бага байгааг харуулж байна. Энэ нь тухайн даалгаврын агуулга )тавил, хариултын хувилбарууд(-ыг нарийвчлан тодруулах шаардлага буйг харуулж байна. Тухайн даалгавар тухайн сорилын даалгаврууд хоорондын хамаарал sig .055 байгаа нь тухайн даалгавар тухайн сорилын бусад даалгавартай хамааралгүй байгаа харуулж байна. Гэхдээ энэхүү хамаарлын үр дүн нь судалгаанд хамрагдсан бүх хичээлийн сорилын даалгавруудын хамаарлыг авч үзсэн гэдгийг анхаарах хэрэгтэй юм.

Даалгавар 2. Уран зургийн зохиомжийн арга, шийдлүүдийг нэрлэх

Сорилд хамрагдсан сурагчид бүгд тухайн даалгаврыг хариулсан байна. Үүний 44.4 хувь нь зөв гүйцэтгэсэн бол 55.6 хувь нь буруу хариулсан байна. Тухайн даалгавар нь А, Б, В гэсэн гурван сонгох хувилбартай бөгөөд буруу хариулсан сурагчдын гүйцэтгэлийн авч үзэхэд Б хувилбарыг сурагчдын 44.3 хувь, В хувилбарыг 19.4 хувь нь сонгосон байна. Сонгох даалгаврын сурагчдын хариултыг хувиар авч үзье.

Тестаны үр дүнгээс тухайн даалгаврын хүнд хөнгөний зэрэг нь 44.3, ялгах чадвар 17.9 ).002( байгаа нь тухайн даалгавар нь хүндрэлийн зэрэг хувьд дундаж, ялгах чадвар бага байгааг харуулж байна. Тухайн даалгавар тухайн сорилын даалгаврууд хоорондын хамаарал sig.139 байгаа нь тухайн даалгавар тухайн сорилын бусад даалгавартай зохицлийн хувьд сул гэдгийг харуулж байна. Гэхдээ энэ нь судалгаанд хамрагдсан бүх хичээлийн сорилын даалгавруудын хамаарлыг авч үзсэн үр дүн юм. Иймд тухайн хичээлийн сорилын 5 даалгаврын харилцан хамаарал, ач холбогдлыг дээр авч үзсэн болно.

*Богино хариултат даалгаврын шинжилгээ*

Уг сорил нь богино хариулттай 2 даалгавартай бөгөөд тухайн даалгаврууд нь уран зургийн төрлүүдийг нэрлэх, уран бүтээлийн ажиглах, ойлгох, утга өгөх түүнийгээ илэрхийлж буй байдлыг илрүүлэхэд чиглэнэ. Богино хариулттай даалгавар тус бүр 2 оноотой. Гүйцэтгэлийн үр дүнг даалгавар тус бүрээр авч үзье.

Даалгавар 3. Таталбар болон зураасан зургийн онцлогыг тайлбарлах

Даалгаврын сурагчдын гүйцэтгэлийг дараах хүснэгтээр харуулав. Тухайн даалгаврын нийт сурагчдын гүйцэтгэл 21.6 хувь байна.

Задгай даалгавар гүйцэтгэсэн сурагчдын 21 хувь нь таталбар болон зураасан зургийн онцлогыг бүрэн тайлбарлаж чадсан бол 1.3 хувь нь ойролцоо утгаар тайлбарласан, 77.7 хувь нь тайлбарлаж чадаагүй байна. Судалгаанд хамрагдсан нийт сурагчдын 80 орчим хувь нь уран зургийн төрөл, онцлогыгн талаарх мэдлэг, ойлголт хангалтгүй байгааг харуулж байна.

Даалгавар 4. Монголын зураачдын уран зураг унших, тайлбарлах

Даалгаврын сурагчдын гүйцэтгэлийг дараах хүснэгтээр харуулав. Даалгавар 4- ийн гүйцэтгэл 48.5 хувьтай байна.

Задгай даалгавар гүйцэтгэсэн сурагчдын 15.3 хувь нь даалгаварт өгөгдсөн тухайн уран бүтээлийн зохиомжийн төрлийн тодорхойлж, утга санааг зургийн агуулгатай нийцүүлэн гаргаж чадсан бол 72.4 хувь нь уран бүтээлийн зохиомжийн төрөл, утга санааг өөрийнхөөрөө гаргах гэж оролдсон байна. Харин 12.3 хувь нь тайлбарлаж чадаагүй байна.

Тухайн даалгаврын сурагчдын гүйцэтгэл 48.5 хувьтай байгаа ч даалгаврыг оновчтой гүйцэтгэн 2 оноо авсан сурагчдын хувь бага байна. Харин уран бүтээлийн зохиомжийн төрөл, утга санааг өөрийнхөөрөө гаргах гэж оролдсон сурагчдын гүйцэтгэлийн хувь өндөр байгаа нь тухайн хичээлийн сургалтын хөтөлбөрт уран бүтээлийн ажиглах, утга

өгөх, өөрийн санаагаа илэрхийлэх чадварыг тусгаж өгсөнтэй холбоотой байх магадлалтай.

*Бүтээх түвшний даалгаврын шинжилгээ*

Уг сорил нь бүтээх түвшний 1 даалгавартай бөгөөд тухайн даалгавар нь зохиомжийн болон орон зайн дүрслэлийн талаарх ойлголт, дүрслэл ашиглан бүтээх, илэрхийлэх чадварыг илрүүлэхэд чиглэсэн. Тухайн даалгавар 6 оноотой.

Даалгавар 5. Геометрийн биетүүдийг зохиомж үүсгэн орон зайтай дүрслэх

Тухайн даалгаврын сурагчдын гүйцэтгэлийг дараах хүснэгтээр харуулав. Сурагчдын тухайн даалгаврын гүйцэтгэл 34.0 хувьтай байна.

Тухайн даалгавар гүйцэтгэсэн сурагчдын 11.1 хувь нь геометрийн биетүүдийг зохиомж үүсгэн орон зайтай дүрслэн зурж чадсан бол 20.8 хувь нь геометрийн биетүүдийг зохиомж үүсгэсэн хэдий ч орон зай үүсгэн дүрсэлж чадаагүй, 55.2 хувь нь геометрийн биетүүдийг зохиомж үүсгэн дүрслэх гэж оролдсон байна. Харин 13 хувь нь тухайн даалгаврыг гүйцэтгэж чадаагүй байна.

Суурь боловсролын дүрслэх урлагийн сорилын үр дүнгээс харахад:

- Дүрслэх урлагийн сорилын даалгавруудын хүндрэлийн зэрэг дундаж, 1 дүгээр даалгавраас бусад даалгавар хоорондоо ач холбогдол бүхий хүчтэй хамааралтай болохыг статистик үзүүлэлт харуулж байна.
- Сорилын ерөнхий гүйцэтгэл 34 хувьтай байна. Танин мэдэхүйн ойлгох, хэрэглэх, бүтээх түвшний даалгавруудын гүйцэтгэлийн дундаж ойролцоо байна.

# Дизайн технологийн сорилын гүйцэтгэлийн шинжилгээ

Суурь боловсролын 8 дугаар ангийн дизайн технологийн сорил нь танин мэдэхүйн ойлгох, хэрэглэх, бүтээх түвшний 5 даалгавартай, сорил нийт 12 оноотой. А хэсэгт мэдлэг, ойлголтыг илрүүлэх 2 даалгавар, Б хэсэгт мэдлэгээ хэрэглээ, бүтээлч эрэлхийллийн арга барилын чадварыг илрүүлэх 3 даалгаврыг боловсруулсан байна.

*Хүснэгт 97. Сорилын даалгаврын жин (Дүрслэх урлаг, 8 дугаар анги)*

| *Танин мэдэхүйн түвшин* | *Даалгаврын дугаар* | *Онооны хуваарилалт* | *Үнэлгээний жин* |
|---|---|---|---|
| Мэдлэг, ойлголт | А-2, | 2 | 17 хувь |
| Мэдлэгээ хэрэглэх | Б-2 | 4 | 33 хувь |
| Бүтээх | Б-1 | 6 | 50 хувь |
| **Нийт** | 5 даалгавар | 5 оноо | 100 хувь |

Суурь боловсролын дизайн технологи сургалтын хөтөлбөрийн агуулга нь сурагчдын эзэмшсэн өмнөх мэдлэг, чадварт нь тулгуурлан бүтээлч эрэлхийллийн арга барилаар дамжуулан санаагаа олох, хөгжүүлж бүтээх, үнэлэх үйлийг дэмжихэд чиглэгддэг. Сорилын даалгаврыг боловсруулахдаа бүтээлч эрэлхийллийн арга барилын чадварууд суурь боловсролын дизайн технологийн сургалтын хөтөлбөрийн 8 дугаар ангийн дизайн, зурагзүй бүлгийн агуулга, өмнөх ангийн холбогдох агуулгын залгамж холбоонд авч үзсэн байна. Сургалтын хөтөлбөр болон сорилын даалгавраар илрүүлэх мэдлэг, чадварын холбогдох байдлыг авч үзэв.

*Хүснэгт 98 Сургалтын хөтөлбөр ба сорилын холбогдох байдал (Дизайн технологи, 8 дугаар анги)*

| *Танин мэдэхүйн түвшин* | *Даалгаврын дугаар* | *Сургалтын хөтөлбөрийн холбогдох агуулга* | |
|---|---|---|---|
| | | *Агуулгын бүлэг* | *Мэдлэг, чадвар* |
| Мэдлэг | Даалгавар 1. | Дизайн | Эдлэлд тавигдах шаардлагуудыг нэрлэх |
| | Даалгавар 2. | | Дизайны талаарх ойлголтоо илэрхийлэх |
| Мэдлэгээ хэрэглэх | Даалгавар 3. | Урлан бүтээхүй | График дизайны төрлүүдийн нэрлэх, тайлбарлах |
| | Даалгавар 4. | | Сав баглаа боодлын дизайны хэрэглээг тайлбарлах |
| Бүтээлч эрэлхийллийн арга барил | Даалгавар 5. | Дизайн График бүтээл | График бүтээл (сав баглаа боодол) хийх төсөлт ажлын санаа боловсруулах |

*Зураг 84. Сорилын даалгаврын гүйцэтгэл (Дизайн технологи, 8 дугаар анги)*




Даалгавар тус бүрийн сурагчдын гүйцэтгэлээс танин мэдэхүйн ойлгох түвшний 2 даалгаврын сурагчдын гүйцэтгэл мэдлэгээ хэрэглэх болон бүтээх түвшний бусад даалгаврын гүйцэтгэлтэй харьцуулбал доогуур үзүүлэлттэй байна. Харин мэдлэгээ хэрэглэх түвшний задгай хариулттай 2 даалгаврын сурагчдын гүйцэтгэл нь ойлгох болон бүтээх түвшний даалгавруудын гүйцэтгэлийн хувь илүү байна.

*Зураг 85. Сорилын даалгаврын гүйцэтгэл (Дизайн технологи, 8 дугаар анги)*




Дизайн технологийн сорилд сурагчид 10 онооны 5 даалгаврыг гүйцэтгэсэн ба гүйцэтгэлийн дундаж 39.6 хувьтайгаар шалгагдсан байна. Сорилд хамрагдсан сурагчдын дунд хамгийн бага болон хамгийн өндөр оноог авсан сурагч байхгүй байна.

Сорилын даалгавар хоорондын хамаарлын статистик ач холбогдлыг авч үзвэл: Сорилын даалгавар 1 нь даалгавар 2- той статистик ач холбогдол бүхий хамааралтай байгаа бол даалгавар 2 нь даалгавар 1 болон 3-тай, даалгавар 3 нь даалгавар 2, 4, 5 –тай даалгавар 4 нь даалгавар 3, 5 дугаар даалгавартай, даалгавар 5 нь даалгавар 3, 4 дүгээр даалгавартай статистик ач холбогдол бүхий хамааралтай гэдгийг уг үзүүлэлт харуулж байна. Энэ үзүүлэлт нь сорилы хамаарал бүхий даалгаврууд нь өөр хоорондоо хэр зохицсоныг харуулж байгаа ба тухайн сорилын найдвартай байдлын нэг үзүүлэлт болох юм.

*Мэдлэг, ойлголтыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

*Даалгаврын зорилго:* Дизайн, зохион бүтээлтийн талаарх мэдлэг ойлголтыг илрүүлнэ.

Даалгавар 1. Эдлэлд тавигдах шаардлагуудыг нэрлэх

Сорилд хамрагдсан сурагчид бүгд тухайн даалгаврыг хариулсан байна. Үүний 11.2 хувь нь зөв гүйцэтгэсэн бол 88.6 хувь нь буруу хариулсан байна. Тухайн даалгавар нь А, Б, В гэсэн гурван сонгох хувилбартай бөгөөд буруу хариулсан сурагчдын гүйцэтгэлийн авч үзэхэд А хувилбарыг сурагчдын 77.3 хувь нь сонгосон байна.

Сурагчдын сонгох даалгаврын хариултыг авч үзье.

Тестаны үр дүнгээс тухайн даалгаврын хүнд хөнгөний зэрэг нь 11.4, ялгах чадвар 9.5 (.025) байгаа нь тухайн даалгавар нь хүндрэлийн зэргийн хувьд хүнд, ялгах чадвар маш бага байгааг харуулж байна. Уг сонголттой даалгаврын хариултын хувилбарын агуулгыг сайжруулах шаардлага байгааг харуулж байна. Тухайн даалгавар тухайн сорилын даалгаврууд хоорондын хамаарал sig.097 байгаа нь тухайн даалгавар тухайн сорилын бусад даалгавартай хамааралгүй харуулж байна. Гэхдээ энэ нь судлагдахуун тус бүрийн сорилын даалгаваруудтай тухай даалгаврын харилцан хамаарлын авч үзсэн үр дүн гэдгийг анхаарах хэрэгтэй юм.

Даалгавар *2*. Дизайны талаарх ойлголтоо илэрхийлэх

Сорилд хамрагдсан сурагчид бүгд тухайн даалгаврыг хариулсан байна. Үүний 27 хувь нь зөв гүйцэтгэсэн бол 73 хувь нь буруу хариулсан байна. Тухайн даалгавар нь А, Б, В гэсэн гурван сонгох хувилбартай бөгөөд буруу хариулсан сурагчдын гүйцэтгэлийн авч үзэхэд А хувилбарыг сурагчдын 49.9 хувь, Б хувилбарыг 20.7 хувь нь сонгосон байна.

Сурагчдын сонгох даалгаврын хариултыг хувиар авч үзье.

Тестаны үр дүнгээс тухайн даалгаврын хүнд хөнгөний зэрэг нь 27.0, ялгах чадвар 20.0 (.000) байгаа нь тухайн даалгавар нь хүндрэлийн зэргийн хувьд хүнд, ялгах чадвар дундаж байгааг харуулж байна. Тухайн даалгавар тухайн сорилын даалгаврууд хоорондын хамаарал sig.140 байна.

*Богино хариулттай даалгаврын шинжилгээ*

Уг сорил нь богино хариулттай 2 даалгавартай бөгөөд тухайн даалгаврууд нь сурагчдын график дизайны төрөл, хэрэглээ, зохион бүтээлтийн талаарх мэдлэг ойлголт,бүтээлч эрэлхийллийн арга барилын чадварыг илрүүлэхэд чиглэнэ. Гүйцэтгэлийн үр дүнг даалгавар тус бүрээр авч үзье.

*Даалгавар 3*. График дизайны төрлүүдийн нэрлэх, тайлбарлах

Даалгаврын сурагчдын гүйцэтгэлийг дараах хүснэгтээр харуулав. Тухайн даалгаврын нийт сурагчдын гүйцэтгэл 21.6 хувь байна.

Задгай даалгавар гүйцэтгэсэн сурагчдын 18 хувь нь график дизайны 3-4-ийг төрлийг нэрлэж тайлбарласан, 44.8 хувь график дизайны 1-2-ийг төрлийг нэрлэж тайлбарласан, бол 37.2 хувь нь тайлбарлаж чадаагүй байна.

Даалгавар 4. Сав баглаа боодлын дизайны хэрэглээг тайлбарлах

Даалгаврын сурагчдын гүйцэтгэлийг дараах хүснэгтээр харуулав. Даалгавар 4-ийн гүйцэтгэл 48.5 хувьтай байна.

Задгай даалгавар гүйцэтгэсэн сурагчдын 15.3 хувь нь зөв (график дизайны 3-4-ийг төрлийг нэрлэж тайлбарласан), 72.4 хувь дундаж гүйцэтгэлтэй (график дизайны 1-2-ийг төрлийг нэрлэж тайлбарласан) бол 12.3 хувь нь хангалтгүй буюу график дизайны төрлийг нэрлэж, тайлбарлаж чадаагүй байна. Гүйцэтгэлийн хамгийн их хувийг дундаж гүйцэтгэлтэй сурагчид эзэлж байгаа ба эдгээр нь график дизайны төрлүүдээс 1-2 ийг зөв нэрлэсэн байна.

*Бүтээх түвшний даалгаврын шинжилгээ*

Уг сорил нь бүтээх түвшний 1 даалгавартай бөгөөд тухайн даалгавар нь сурагчид санаагаа олох, хөгжүүлж бүтээх, үнэлэх үйлийг төлөвлөн бүтээлч эрэлхийллийн арга барилд хэрхэн суралцаж буйг илрүүлэхэд чиглэсэн.

Сурагчдын тухайн даалгаврын гүйцэтгэл 31.3 хувьтай байна. Тухайн даалгавар гүйцэтгэсэн сурагчдын 5.6 хувь нь хангалтай, 29.1 хувь нь дундаж, 45.8 хувь нь сул, 21.7 хувь нь хангалтгүй гүйцэтгэсэн гэж харж болохоор байна. Хангалттай гүйцэтгэсэн сурагчид нь төсөлт ажлын нэр, зорилго, үе шат , үе шат тус бүрийнхээ технологи үйл ажиллагааг тайлбарласан бол, дундаж гүйцэтгэлтэй сурагчид нь төсөлт ажлын нэр, зорилгыг тодорхойлсон боловч үе шат болон технологи үйл ажиллагааг дутуу талбарласан байна. Харин сул гүйцэтгэлтэй сурагчдын гүйцэтгэлийг авч үзэхэд төсөлт ажлын нэр, зорилгын аль нэгийг тодорхойлох гэж оролдсон, 1-2 үе шат, технологи үйл ажиллагааг дурдсан байна.

Суурь боловсролын дизайн технологийн сорилын үр дүнгээс харахад:

- Сорилын ерөнхий гүйцэтгэл 40 орчим хувьтай байна. Сорилын даалгавар тус бүрийн сурагчдын гүйцэтгэлээс танин мэдэхүйн ойлгох түвшний 2 даалгаврын сурагчдын гүйцэтгэл мэдлэгээ хэрэглэх болон бүтээх түвшний даалгавруудын гүйцэтгэлээс доогуур үзүүлэлттэй байна.
- Харин мэдлэгээ хэрэглэх түвшний задгай хариулттай 2 даалгаврын сурагчдын гүйцэтгэл нь ойлгох болон бүтээх түвшний даалгавруудын гүйцэтгэлээс илүү байна.

# Биеийн тамирын сорилын гүйцэтгэлийн шинжилгээ

Суурь боловсролын 8 дугаар ангийн биеийн тамирын сорилын даалгавар нь мэдлэг ойлголт, мэдлэгээ хэрэглэх, гүйцэтгэлийн чадварыг илрүүлэх 5 даалгавартай. Энэхүү даалгаврыг биеийн тамирын хичээлийн 1 дүгээр улиралд үзсэн агуулгын ерөнхий мэдлэг ойлголт, биеэр хийж гүйцэтгэх чадвар болон өмнөх ангийн агуулгатай залгамж холбоотойгоор боловсруулсан.

Сорилын даалгавар боловсруулахдаа биеийн тамирын сургалтын цөм хөтөлбөрийн үнэлгээний зорилт болон шалгуурт тулгуурлан мэдлэг, ойлголтыг илрүүлэх даалгавар, мэдлэгээ хэрэглэх чадварыг илрүүлэх даалгаврын нийт оноонд эзлэх хувь 15.5:30.7:53.8 байхаар боловсруулсан.

Биеийн тамирын сургалын цөм хөтөлбөрийн бие бялдрын хөгжил, үндэсний спорт, хөнгөн атлетик, гимнастик, сагсан бөмбөгийн бүлэг сэдвээр эзэмшсэн мэдлэг, ойлголт, гүйцэтгэл болон чадварыг илрүүлэх зорилготой даалгаврууд боловсруулсан.

*Хүснэгт 99. Сорилын даалгаврын жин (Биеийн тамир, 8 дугаар анги)*

| *Агуулга* | *Даалгаврын эзлэх хувь* | *Онооны эзлэх хувь* | *Гүйцэтгэлийн дундаж* |
|---|---|---|---|
| Мэдлэг | 33.3 | 15.5 | 44.1 |
| Ойлголт | 33.3 | 30.7 | 30.0 |
| Мэдлэгээ хэрэглэх чадвар | 33.4 | 53.8 | 40.0 |

*Мэдлэгийг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Суурь боловсролын биеийн тамирын сургалтын цөм хөтөлбөрийн агуулгыг 7 бүлэг сэдвээр боловсруулсны 1 дүгээр улиралд үзсэн агуулга болон өмнөх ангийн агуулгатай залгамж холбоотойгоор дараах даалгаваруудыг боловсруулсан.

Даалгавар 1.

*Даалгаврын зорилго*: Бие бялдраа хөгжүүлэх арга барил, мэдлэгийг илрүүлэх.

Даалгаврын гүйцэтгэлийн үр дүнгээс харахад 54.2 хувь нь А хувилбар буюу зөв хариултыг сонгосон байна. Харин 23.1 хувь нь Б хувилбар буюу буруу хариултыг сонгосон байгаа нь сурагчдын бие бялдраа хөгжүүлэх мэдлэг дутмаг байх талтай байна. Энэхүү даалгаврын хүнд хөнгөний зэрэг нь (54.2) тохиромжтой, ялгах чадвар нь (42.1) маш сайн байна.

Даалгавар 2.

*Даалгаврын зорилго*: Үндэсний спортын талаарх мэдлэгийг илрүүлэх

*Хүснэгт 100. Сорилын 2 дугаар даалгаврын гүйцэтгэл (Биеийн тамир, 8 дугаар анги)*

| *Хариултын хувилбар* | *Гүйцэтгэлийн хувь* | *Зөв хариулт* |
|---|---|---|
| А | 65.0 | |
| Б | 34.1 | √ |
| Огт хариулаагүй | 0.9 | |

*Ойлголтыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Даалгавар 3.

*Даалгаврын зорилго:* Хөнгөн атлетикийн гүйлтийн талаарх ойлголтыг илрүүлэх

*Хүснэгт 101. Сорилын 3 дугаар даалгаврын гүйцэтгэл (Биеийн тамир, 8 дугаар анги)*

| *Хариултын хувилбар* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|
| 2 оноо авсан | 42.3 |
| 1 оноо авсан | 0.4 |
| Буруу хариулсан | 52.1 |
| Огт хариулаагүй | 5.2 |

Даалгаврын гүйцэтгэлээс харахад 42.3 хувь нь 2 оноо авсан байна. Харин 52.1 хувь нь буруу хариулсан байгаа нь хөнгөн атлетикийн агуулгын хүрээний ойлголт болон сурах арга барил бага байгаа нь харагдаж байна.

Даалгавар 4.

*Даалгаврын зорилго*: Бие бялдраа хөгжүүлэх арга барил, ойлголтыг илрүүлэх

Даалгаврын гүйцэтгэлийн үр дүнгээс харахад 17.7 хувь нь 2 оноо авсан байна. Харин 5.8 хувь нь огт хариулаагүй байгаа нь бие бялдраа хөгжүүлэх сурах арга барил, ойлголт дутмаг харагдаж байна.

*Сурах арга барил, чадварыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Даалгавар 5.

*Даалгаврын зорилго*: Сагсан бөмбөгийн мэдлэг, ойлголт, сурах арга барилаа хэрэглэх чадварыг илрүүлэх

Сорилыг санамсаргүй түүврийн аргаар нэг ангиас 10 сурагчийг сонгож даалгаврыг гүйцэтгүүлсэн.

*Хүснэгт 102. Сорилын 5 дугаар даалгаврын гүйцэтгэл (Биеийн тамир, 8 дугаар анги)*

| *Шалгуур* | | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|
| Баруун гараар залсан эсэх | Гүйцэтгэж чадсан | 88.9 |
| | Гүйцэтгэж чадаагүй | 11.1 |
| Хананд оновчтой дамжуулсан эсэх | 1 удаа дамжуулсан | 9.2 |
| | 2 удаа дамжуулсан | 30.0 |
| | 3 удаа дамжуулсан | 60.4 |
| | Дамжуулалт хийж чадаагүй | 0.5 |
| Зүүн гараар залсан эсэх | Гүйцэтгэж чадсан | 71.0 |
| | Гүйцэтгэж чадаагүй | 29.0 |
| Хугацаандаа амжиж гүйцэтгэсэн эсэх | Гүйцэтгэж чадсан | 10.1 |
| | Гүйцэтгэж чадаагүй | 89.9 |

Дээрх үр дүнгээс харахад сурагчдын 88.9 хувь нь сагсан бөмбөгийг баруун гараар залах нь сайн байна. Харин 29.0 хувь нь зүүн гараар залах болон 89.9 хувь нь хугацаандаа амжиж гүйцэтгэх чадварууд нь сул харагдаж байна.

*Зураг 86. Сорилын даалгаврын гүйцэтгэл (Биеийн тамир, 8 дугаар анги)*




Суурь боловсролын биеийн тамирын сорилын үр дүнгээс харахад: Судалгаанд хамрагдсан 8 дугаар ангийн сурагчдын биеийн тамирын хичээлийн мэдлэг, ойлголтын гүйцэтгэлийн дундаж 37.05 хувь, мэдлэгээ хэрэглэх чадварын гүйцэтгэлийн дундаж 45.1 хувьтай байна.

## <u>Суурь боловсролын сорилын дүгнэлт</u>

Суурь боловсролын сорилын судалгаанд хамрагдсан сурагчдын ерөнхий гүйцэтгэлийн дундаж нь 36.2 хувьтай, хамгийн өндөр гүйцэтгэл 67.1 хувь, хамгийн бага гүйцэтгэл 10.1 хувь, стандарт хазайлт 9.9 хувь байна. Хичээл тус бүрээр гаргасан статистик үзүүлэлтүүдийг хүснэгтээр харууллаа.

*Хүснэгт 103. Суурь боловсролын сорилын гүйцэтгэл (8 дугаар анги)*

| *Хичээлийн нэр* | *Mean* | *Median* | *Mode* | *Minimum* | *Maximum* | *Std. Deviation* |
|---|---|---|---|---|---|---|
| Математик | 22.8 | 20.0 | 17.5 | 0.0 | 80.0 | 14.0 |
| Мэдээллийн технологи | 38.7 | 30.0 | 30.0 | 0.0 | 100.0 | 21.2 |
| Монгол хэл | 50.3 | 53.3 | 60.0 | 0.0 | 86.7 | 19.1 |
| Англи хэл | 40.8 | 40.0 | 40.0 | 0.0 | 100.0 | 21.7 |
| Биологи | 34.4 | 33.3 | 33.3 | 0.0 | 83.3 | 17.7 |
| Хими | 39.9 | 36.4 | 36.4 | 0.0 | 100.0 | 18.3 |
| Физик | 30.8 | 25.0 | 25.0 | 0.0 | 75.0 | 16.5 |
| Газар зүй | 32.7 | 30.8 | 38.5 | 0.0 | 84.6 | 16.8 |
| Түүх | 34.7 | 33.3 | 40.0 | 0.0 | 86.7 | 16.0 |
| Нийгмийн ухаан | 38.7 | 40.0 | 33.3[a] | 0.0 | 80.0 | 17.1 |
| Хөгжим | 42.8 | 46.2 | 46.2 | 0.0 | 92.3 | 14.2 |
| Дүрслэх урлаг | 33.7 | 33.3 | 25.0 | 0.0 | 91.7 | 18.0 |
| Дизайн технологи | 38.5 | 41.7 | 33.3 | 0.0 | 83.3 | 17.9 |
| Биеийн тамир | 34.9 | 30.8 | 23.1 | 0.0 | 92.3 | 22.6 |
| Ерөнхий гүйцэтгэл | 36.2 | 36.0 | 32.0 | 10.1 | 67.1 | 9.9 |

Сорилын судалгаанд хамрагдсан сурагчдын гүйцэтгэлийн дунджуудыг 30 хувиас доош, 30-аас дээш хувьтай гэсэн хоёр түвшинд ангилж үзэхэд дараах дүгнэлтүүдийг хийх боломжтой байна.

- Математик, Физикийн хичээлийн сорилын гүйцэтгэлийн дунджууд 30 хүртэлх хувьтай, Мэдээллийн технологи, Биологи, Хими, Газарзүй, Монголын түүх, Нийгмийн ухаан, Дүрслэх урлаг, Дизайн технологи, Биеийн тамирын сорилын гүйцэтгэлийн дунджууд 30-40 хувь, харин Монгол хэл, Англи хэл, Хөгжмийн сорилын гүйцэтгэлийн дунджууд 40-60 хүртэлх хувьтай байна. Харин нийт хичээлийн хувьд хамгийн өндөр гүйцэтгэл нь 75-100 хувьтай, хамгийн бага гүйцэтгэл нь 0 хувьтай байгаа нь сурагчдын мэдлэг, чадварын түвшин харилцан адилгүй, ихээхэн зөрүүтэй байгааг харуулж байна.

- Сорилын гүйцэтгэлийн тархалтын хувьд стандарт хазайлт нь 15 хувиас бага хазайлттай 2 хичээл (математик, хөгжим), 15-аас 19 хүртэлх хувийн хазайлттай 9 хичээл, 20- иос дээш хувийн хазайлттай 3 хичээл (мэдээллийн технологи, англи хэл, биеийн тамир) байна.

- Сорилд хамрагдсан 8 дугаар ангийн сурагчдын сорилын ерөнхий гүйцэтгэлийг 14 хичээл тус бүрийн гүйцэтгэлтэй харьцуулахад найдвартай байдал сайн байна. (Cronbach's Alpha .826)

- 8 дугаар ангийн сорилын судалгаанд хамрагдсан сурагчдын ерөнхий гүйцэтгэлийг хичээл тус бүрийн гүйцэтгэлийн хувьтай харьцуулахад Математик, Мэдээллийн технологи, Монгол хэл, Англи хэл,Физик, Газар зүй,Нийгмийн ухааны сорилын гүйцэтгэлтэй эерэг хүчтэй (Pearson Correlation > 0.5 , Sig. (2-tailed) 0.0) хамааралтай, бусад хичээлийн хувьд (0.07< Pearson Correlation < 0.5, Sig. (2-tailed) 0.0) эерэг хамааралтай байна.

- Сорилын даалгаврын талаар дунд ангийн сурагчдаас тодруулахад “амархан байсан” гэсэн хариултыг зарим сурагч өгсөн бөгөөд математик, дүрслэх урлаг технологи,

хөгжим зэрэг хичээлүүдийн сорилын даалгаварт судлаагүй, өмнө үзсэн агуулга байсан гэж зарим сурагч ярилцлагадаа дурджээ.

Хөгжмийн ноот нөхөж гүйцээх даалгавар 2-3 жилийн өмнө үзсэн хичээл байсан.

*Орон нутгийн сургуулийн сурагч*

## Суурь боловсролын түвшинд суралцагчдын мэдлэг, чадвар, хандлага ба нөлөөлж буй хүчин зүйл

### *Дунд ангийн сурагчдын мэдлэг, ойлголтыг үнэлэх даалгаврын гүйцэтгэлд хийсэн шинжилгээ*

Суурь боловсролын түвшинд суралцагчдын мэдлэг, ойлголтыг үнэлэх нийт даалгаврын гүйцэтгэл нь 44 хувьтай байна. Эдгээрийг судлагдахуун тус бүрээр нь харьцуулахад, химийн судлагдахууны мэдлэгийн түвшин сайн байлаа.

Түүх, газар зүй, монгол хэл, математик, хөгжмийн судлагдахууны мэдлэгийн түвшин 50 хувийн үзүүлэлттэй , бусад судлагдахуун болох биологи, физик, мэдээллийн технологи, биеийн тамир, дүрслэх урлаг, англи хэлний судлагдахуунаар эзэмшвэл зохих мэдлэгийн түвшин хангалтгүй үнэлэгдлээ. Дизайн технологийн мэдлэг маш сул түвшинтэй байна.

*Зураг 87. Дунд ангийн сурагчдын мэдлэг ойлголтын үнэлгээний үзүүлэлтийн хувь (судлагдахуунаар)*




| | монгол хэл | хөгжим | дүрслэх урлаг | дизайн технологи | математик | англи хэл | газар зүй | биеийн тамир | түүх | нийгэм судлал | мэдээллийн технологи | физик | хими | биологи |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Series1 | 51 | 47 | 35 | 20 | 46 | 40 | 54 | 42 | 54 | 45 | 37 | 35 | 64 | 37 |

Суурь боловсролын сургалтын хөтөлбөр нь суралцагчдад шинжлэх ухааны суурь мэдлэг ойлголтыг эзэмшихэд боломж олгох зорилгыг агуулдаг. Суралцагчдын шинжлэх ухааны мэдлэг ойлголтын эзэмшилт хангалтгүй түвшинтэй байна. Судлагдахуун тус бүрээр нь харьцуулахад, химийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт нь мэдлэг олгоход илүү дэмжлэг болж байгаа дүр зураг харагдлаа.

Сурагчдын мэдлэг ойлголтын эзэмшилт нь сургуулийн байршлаас хамаараад ялгаатай биш байна. Харин хөгжим, англи хэлний даалгаврын гүйцэтгэлийн хувь ба сургуулийн өмчийн хэлбэрийн хооронд статистик ач холбогдолтой ялгаа ажиглагдлаа. (r=.225**; .367** ; p<0.01)

*Зураг 88. Дунд ангийн сурагчдын хөгжим, англи хэлний мэдлэгийн үнэлгээний үзүүлэлтийн хувь (сургуулийн өмчийн хэлбэрээр)*




Хувийн өмчийн сургуулийн сурагчдын хөгжмийн судлагдахуунаар эзэмших хөгжмийн эгшиг, ноот тэмдэглээ, хөгжмийн төрлийн талаарх мэдлэг, англи хэлний судлагдахуунаар эзэмших дүрмийн мэдлэг, үгийн нөөц, эхийг уншаад утга санааг нэгтгэн дүгнэх нь төрийн өмчийн сургуулийн сурагчдаас сайн байна.

Эндээс:

- Сурагчдын судлагдахуунаар эзэмшиж байгаа мэдлэг ойлголтын эзэмшилтийг сайжруулахад чиглэсэн судалгаа шинжилгээ, арга зүйн үйл ажиллагааг чиглүүлэх.
- Юуны өмнө дизайн технологи, мэдээллийн технологи, биологи, физикийн судлагдахууны суурь мэдлэгийгсайжруулахад анхаарах.
- Төрийн өмчийн сургуулидуын хөгжим, англи хэлний судлагдахууны агуулга, арга зүй, сургалтын материаллаг орчин, цагийн төлөвлөлтөд шинжилгээ хийж түүнийг сайжруулах алхмуудыг хийх шаардлагатай байна.

## *Дунд ангийн сурагчдын мэдлэгээ хэрэглэх чадварыг үнэлэх даалгаврын гүйцэтгэлд хийсэн шинжилгээ*

Сурагчдын мэдлэгээ хэрэглэх чадварыг үнэлэх даалгаврын гүйцэтгэл нь 43 хувьтай байлаа. Мэдлэгээ хэрэглэх чадварт судлагдахууны үүргийн авч үзэхэд, мэдээллийн технологи, англи хэл, дилзайн технологийн судлагдахуун зонхилж байна (60 гаран хувь эзлэсэн) байна. Харин хими, биологи, монгол хэлний хичээлүүдээр сурагчдын 50 гаран хувь мэдлэгээ хэрэглэх чадвартай байна.

Суралцагчдын физик, хөгжим, дүрслэх урлагийн судлагдахуунаар эзэмших чадвар нь хангалтгүй байна. Математик , түүх, биеийн тамирын судлагдахууны чадвар сул түвшинд байгаа нь цаашид анхааран судлах, сайжруулах хэрэгцээ шаардлагыг бий болгож байна. Ялангуяа матемтикийн чадвар маш сул түвшинд харагдлаа.

*Зураг 89. Дунд ангийн сурагчдын мэдлэгээ хэрэглэх чадварын үзүүлэлтийн хувь (судлагдахуунаар)*



Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн зорилгын хүрээнд сурагчдын суралцах чадварын хөгжлийг дэмжихийг тусгасан бөгөөд энэ нь таамаглал дэвшүүлэн шинжлэн судлах, бүтэц, дараалалтайгаар мэдээлэлтэй ажиллаж сурах, сэтгэхүйн задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, үнэлэн сайжруулах чадварын эзэмшилтээр хэрэгжинэ гэж тодорхойлогдсон. Сурагчдын сорилын гүйцэтгэлд хийсэн шинжилгээнээс тухайн чадвар хангалтгүй гэж дүгнэхүйц үр дүн ажиглагдлаа.

Сургуулийн байршлаас сурагчдын чадварын үзүүлэлт хамаарах нь бага байна. Харин дүрслэх урлагийн хичээлээр мэдлэг ашиглах чадвар нь сургуулийн хот, хөдөөгийн байдлаас хамаарч байгаа нь бага зэргийн ялгаатай байна. (r=.290**; p<0.01) Аймгийн сурагчдын гүйцэтгэл 38.0 хувьтай, хотын сурагчдынх 30.0 хувьтай байна.

Англи хэлний чадвар нь сургуулийн өмчийн хэлбэрээс хамаарч байгаа тал харагдлаа. (r=.222**; p<0.01)

*Хүснэгт 104. Дунд ангийн сурагчдын англи хэлний чадварын үзүүлэлт (сургуулийн өмчийн хэлбэрээр)*

| *Сургуулийн өмчийн хэлбэр* | *Англи хэл* |
|---|---|
| | *Өгүүлбэрийг уншаад ойлгох, асуултад хариулах чадвар* |
| Төрийн өмчийн сургууль | 62 |
| Хувийн өмчийн сургууль | 83 |

Англи хэлний чадвар нь сургуулийн өмчийн хэлбэрээс хамаарч байгаа тал харагдлаа.

Хувийн сургуулийн сурагчдын англи хэлний хэрэглээний чадвар нь харьцангуй илүү байгаа нь сургалтын хөтөлбөрийн онцлог, багшийн заах арга зүй, анги,хүүхдийн тоо сурагчдын сэдэл, сонирхлоос шалтгаалж байх боломжтой ч төрийн өмчийн сургуульд англи хэлний сургалтын агуулга, арга зүйг дээшлүүлэх шаардлагатай байна.

Сурагчдад юмс үзэгдэлд шинжлэх ухаанч арга барилын төлөвшил нь харьцангуй сул байна. (M=28 хувь) Судлагдахуун тус бүрээр нь авч үзвэл, дизайн технологийн судлагдахууны үзүүлэлт харьцангуй илүү байна (62 хувь). Монгол хэлний үзүүлэлт 42.0, хөгжмийн судлагдахууны үзүүлэлт 46.0 хувьтай байна. Бусад судлагдахууны үзүүлэлт маш сул түвшинд байна. Дизайн технологийн судлагдахуун нь сурагчдад бүтээлч чадвар эзэмшүүлэхэд илүү дэмжлэг болж байна.

Суурь боловсролын түвшинд сурагчдын мэдлэг, чадвар, шинжлэх ухаанч арга барилын эзэмшилт нь хангалтгүй байна.

*Зураг 90. Дунд ангийн сурагчдын мэдлэг, чадварын эзэмшилтийн харьцуулалт*




Эндээс дараах дүр зураг харагдаж байна.

- Судлагдахуунаар эзэмшиж байгаа чадвар хангалтгүй байна.
- Судлагдахуун тус бүрээр харахад, англи хэл, мэдээллийн технологи, дизайн технологиийн судлагдахуун нь сурагчдын чадвар эзэмшилтэд илүү дэмжлэг болж чадаж байна. Харин эдгээр судлагдахуун нь үндсэн мэдлэг, ойлголтыг эзэмшүүлэх нь хангалтгүй байв.
- Математик, хөгжим, газар зүй, биеийн тамир, түүхийн судлагдахууны мэдлэгийг чадвар болгох агуулга, арга зүй дутмаг байна гэж дүгнэхүйц байна. Өөрөөр хэлбэл, эдгээр судлагдахууны мэдлэгийн үзүүлэлт нь чадварын үзүүлэлтээс харьцангуй дээгүүр байна. Энэ нь сурагчдын мэдээлэлтэй ажиллах, таамаглал дэвшүүлэх, сэтгэхүйн задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, асуудалд шүүмжлэлтэй хандах сэтгэлгээний чадварыг бууруулах үр дагавартай тул анхаарах нь зүйтэй юм. Сурагчдын мэдлэг бүтээх чадвар сул байгаа нь мэдлэг өнгөц байгааг харуулж байна.

## Суралцах хэв шинж ба сурагчдын гүйцэтгэл

Бид судалгаандаа суурь боловсролын түвшинд суралцаж буй 8 дугаар ангийн сурагчдын сураглцах хэв шинжийг барилыг танин мэдэхүйн чадвараар анхаарлын тогтворжилт, шилжилт, ажиллах чадвар, богино хугацааны хараа, сонорын ой, утгын ой тогтоолт, сэтгэхүй, сэтгэхүйн харьцуулах үйлдэлтэй уялдуулан авч үзсэн юм. Танин мэдэхүйн чадваруудыг нэгдүгээрт; анхаарал, ой тогтоолт, сэтгэхүйн үйлийг гүйцэтгэх чадвараа сурагчид өөрийгөө хэр үнэлж байгаа, хоёрдугаарт; сурагчдын эзэмшсэн мэдлэг ойлголт, чадварыг хичээлүүдийн даалгаврын гүйцэтгэлтэй уялдуулан шинжлэв.

Бид сурагчдын сурах арга барилыг танин мэдэхүйн үйлүүдээр авч үзэхдээ тухайн үйл хичээлүүдээр хэр хөгжиж байгаад анхаарлаа хандуулсан болно. Судалгаагаар дараах дүр зураг харагдаж байна.

### *Анхаарал*

Сурагчид анхаарлыг хөгжүүлэхтэй холбоотой ямар үйлийг хийх нь тэдэнд таатай байдаг талаар мэдээлэлд тулгуурлан шинжилгээ хийж, харин багшийн хувьд сурагчдын анхаарлын хөгжилтэй холбоотой ямар үйлүүдийг сурагчид сайн гүйцэтгэж чаддаг талаар мэдээлэлд үндэслэн болно.

*Хүснэгт 105. Анхаарлын чадваруудын хариулт багш, сурагчид 9 (дунд анги)*

| Танин мэдэхүй | Багшийн үнэлгээ | Сурагчдын өөрийн үнэлгээ |
|---|---|---|
| Анхаарал | 65.3 | 71.4 |

*Хүснэгт 106. Сурагчдын анхаарлаа төвлөрүүлэх чадварыг хугацаагаар илэрхийлсэн нь (багшийн хариулт)*

| *Хүүхдүүд хичээл дээр анхаарлаа төвлөрүүлэх хугацаа* (ойролцоогоор) | *Дунд анги* |
|---|---|
| 5-10 мин | **38.8** |
| 10-15 мин | 36.7 |
| 15-20 мин | 12.2 |

Багш нарын үзэж байгаагаар дунд ангийн сурагчдын анхаарал төвлөрөх хугацаа ойролцоогоор 5-15 мин байна гэжээ.

*Хүснэгт 107. Анхаарлын шилжилт ба багш нарын дэмжлэг*

| *Хүүхдүүд хичээл дээр дасгал даалгаврыг хурдан, зөв гүйцэтгэхэд:* | *Суурь боловсрол* |
|---|---|
| багшийн дэмжлэг шаардлага хэрэгтэй | 55.1 |

Сурагчид хичээлийн явцад дасгал, даалгаврыг хурдан зөв гүйцэтгэхэд багшийн шаардлага чухал гэж багш нарын 55.1 хувь нь үзжээ.

### *Ой тогтоолт*

Танин мэдэхүйн зориудын үйлдлийн хөгжлийн түвшинг илэрхийлдэг гол үзүүлэлт болох богино хугацааны хараа, сонорын ой тогтоолт, утгын ой тогтоолтыг сурагчдын өөрийн үнэлгээнд тулгуурлан авч үзэв.

*Хүснэгт 108. Дунд ангийн сурагчдын сонор, хараа, утгын ой тогтоолтын үзүүлэлт (багш, сурагчийн хариулт)*

| *Ой тогтоолын чадвар* | *Багшийн үнэлгээ* | *Сурагчдын үнэлгээ* |
|---|---|---|
| Сонорын ой тогтоолт сайн | 91.1 | 74.6 |
| Харааны ой тогтоолт сайн | 64.4 | 70.9 |
| Утгын ой тогтоолт сайн | 71.1 | 64.9 |

Сурагчид сонсоод болон утгачлан мэдээллийг тогтоох нь сайн гэж багш нар үзсэн байхад сурагчид өөрсдийгөө үүнээс доогуур үнэлжээ.

*Зураг 91. Сурагчдын ой тогтоолтын талаарх өөрийн үнэлгээ*




Хөдөө орон нутгийн сурагчид өөрсдийгөө мэдээллийг сонсоод тогтоох нь сайн гэж үнэлэх нь нийслэлтэй харьцуулахад илүү байна.

### *Сэтгэхүй*

Ерөнхий боловсролын сургуулийн дунд ангид сурч байх үе нь хүүхдийн хийсвэр сэтгэхүйн хөгжлийн эрчимтэй үе байдаг.

*Хүснэгт 109. Дунд ангийн сурагчдын сэтгэхүй хөгжүүлэх үйлийн үнэлгээ (багш, сурагчийн хариулт)*

| *Сэтгэхүйн үйлдлүүд* | *Багшийн үнэлгээ* | *Сурагчдын өөрсдийн үнэлгээ* |
|---|---|---|
| бодит үйлдлийн сэтгэхүй | 97.8 | 92.3 |
| бодит дүрслэлийн сэтгэхүй | 95.6 | 81.5 |
| хийсвэр сэтгэхүй | **71.1** | 84.0 |

Сурагчид хичээлийн үед мэдээллийг харж, түүнтэй бодит үйлдэл хийх замаар сэтгэх үйлийг хийх нь сайн байна. Сурагчдын хийсвэрлэн сэтгэх үйл сайн гэж багш нарын 71 хувь нь үзжээ.

### *Суралцах хэв шинж ба мэдлэг ойлголт, мэдлэгээ хэрэглэх чадвар*

ЕБС-ийн суурь боловсролын хөтөлбөрөөр заагдаж буй хичээлүүдийн ойлголт, мэдлэгээ хэрэглэх чадварыг нийт хичээлийн гүйцэтгэлээр суралцах хэв шинжийг тодорхойлж буй танин мэдэхүйн чадваруудтай уялдуулан авч үзэв.

### *Анхаарал ба хичээлүүдийн сорилын гүйцэтгэл*

Сурагчдын даалгавар тус бүрийн гүйцэтгэлийн оноо болон нийт даалгаврын гүйцэтгэлийг ЕБС-ийн суралцагчийн болон боловсролын чанарын үнэлгээний журмын 3.1-ийн суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц, амжилтын үнэлгээгээр авч үзлээ.

*Хүснэгт 110. Дунд ангийн сурагчдын анхаарал хөгжүүлэх үйлд дуртай эсэх ба сорилын гүйцэтгэл*

| *Анхаарлын чадвар* | *Эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц, амжилтын түвшин* | | | |
|---|---|---|---|---|
| | *Дунджаас доогуур* | | *Хангалттай* | |
| | *дуртай* | *дургүй* | *дуртай* | *дургүй* |
| Анхаарлын хувиарлалт | 71.3 | 28.7 | 75.0 | 25.0 |
| Анхаарлын тогтворжилт | 78.4 | 21.6 | 75.0 | 25.0 |
| Анхаарлын шилжилт | 73.0 | 27.0 | 73.7 | 26.3 |
| Анхаарлын төвлөрөлт | 71.9 | 28.1 | 65.0 | 35.0 |

Дунд ангийн сурагчдын анхаарлын төвлөрөл сорилын гүйцэтгэлтэй хамааралгүй байна.

### *Ой тогтоолт ба даалгаврын гүйцэтгэл*

*Хүснэгт 111. Дунд ангийн сурагчдын ой тогтоолтын талаарх өөрийн үнэлгээ ба сорилын гүйцэтгэл*

| *Ой тогтоолт* | *Эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц, амжилтын түвшин* | | | |
|---|---|---|---|---|
| | *Дунджаас доогуур* | | *Хангалттай* | |
| | *сайн* | *сайн биш* | *сайн* | *сайн биш* |
| Сонсоод мэдээллийг тогтоох | 75.3 | 24.7 | 60.0 | 40.0 |
| Хараад мэдээллийг тогтоох | 70.5 | 29.5 | 80.0 | 20.0 |
| Утгачлан мэдээллийг тогтоох | 75.5 | 24.5 | 65.0 | 35.0 |

Сорилын гүйцэтгэлд дунджаас доогуур үнэлгээ авсан сурагчдын 71 хувь өөрсдийгөө хараад мэдээллийг тогтоох чадвар сайн гэж үнэлсэн бол хангалттай үнэлгээ авсан сурагчдын 80 хувь нь өөрсдийгөө тухайн чадвар сайн гэж өөрсдийгөө үнэлжээ. Харааны ой тогтоолт сайтай сурагчдын сорилын гүйцэтгэл сайн байна.

### *Сэтгэхүй ба даалгаврын гүйцэтгэл*

*Хүснэгт 112. Дунд ангийн сурагчдын сэтгэхүйн төрлүүд хөгжүүлэх дасгалд дуртай эсэх, сорилын гүйцэтгэл*

| *Сэтгэхүй* | *Эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц, амжилтын түвшин* | | | |
|---|---|---|---|---|
| | *Дунджаас доогуур* | | *Хангалттай* | |
| | *дуртай* | *дургүй* | *дуртай* | *дургүй* |
| бодит үйлдлийн сэтгэхүй | 66.7 | 33.3 | 75.0 | 25.0 |
| бодит дүрслэлийн сэтгэхүй | 81.4 | 18.6 | 85.0 | 15.0 |
| хийсвэр сэтгэхүй | 51.7 | 48.3 | 55.0 | 45.0 |

Хичээл дээр сэтгэн бодох үйл хийх дуртай гэж үзсэн сурагчдын сорилын гүйцэтгэлийн оноо нь илүү байна.

Хүүхдийн цогц хөгжлийн судалгаагаар 11-14 насны хүүхдүүд юмсын зарим нэг шинжийг харьцуулан үзсэн ч зарим шинжийг харьцуулж чадаагүй байна. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн нас нэмэгдэх тутам хийсвэр сэтгэхүйн гүйцэтгэлийн дундаж болон дунджаас дээгүүр шатанд хамаарах хүүхдийн хувь өссөн байна. Харин тэдний нас нэмэгдэх тутам хийсвэр бодит үйлдийн сэтгэхүйн гүйцэтгэлийн дундаж болон дунджаас дээгүүр шатанд хамаарах хүүхдийн хувь өсөж байгаа нь тогтоогдсон байна.

Сурагчид учир шалтгааныг нь олж дүгнэж ярьж сургах нь чухал байна гэж багш нар үзсэн бол сурагчид өөрсдийгөө төрөл бүрийн зүйл харж учир утгыг нь олох дуртай, сонссон зүйлээ харж өөрөө биеэрээ хийж үзэх дуртай гэж бодит дүрслэлийн сэтгэхүйд тулгуурлан үйлдэл хийдэг гэж хариулсан байна. Сэтгэхүйн харьцуулах үйлдэл ба сургалтын явцад хөгждөг гэж үздэг хийсвэр сэтгэхүйн хөгжилд анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

## Суурь боловсролын түвшинд суралцагчдын мэдлэг, чадвар, хандлагад нөлөөлж байгаа хүчин зүйлсийн шинжилгээ

Суурь боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд сургуулийн байршил , өмчийн хэлбэрээс гадна нийгмийн хүчин зүйл, материаллаг орчин нөлөөлж байгаа эсэхийг илрүүлэх үүднээс шинжилгээ хийлээ. Нийт судлагдахууны хөтөлбөрийн хэрэгжилтэд нөлөөлж байгаа тодорхой хүчин зүйл ажиглагдсангүй.

Судлагдахуун тус бүрийн даалгаврын гүйцэтгэлд нөлөөлж байгаа зарим хүчин зүйл харагдлаа. Тухайлбал, англи хэлний сорилын гүйцэтгэлийн түвшин нь гэрийн даалгавраа хийхэд хэрэглэж байгаа материалын төрөл зүйлээс хамаарч байгаа тал байна. ($r= .2.0^{**}$; $p<0.01$)

Сурагчид интернэтийн мэдээлэл, сайт, нэмэлт гарын авлага хэрэглэх нь зөвхөн багшийн өгсөн материал, сурах бичиг хэрэглэдэг сурагчдын гүйцэтгэлээс ялгаатай байна.

*Зураг 92. Дунд ангийн сурагчдын англи хэлний даалгаврын гүйцэтгэлийн хувь ба ашиглаж буй материал*




Хичээлээр сурагчид нэмэлт гарын авлага, ялангуяа интернэтээс мэдээллийг ашиглах нь сургалтын үр дүнг дээшлүүлэх нөлөө үзүүлжээ. Цаашид англи хэлний сурах бичиг, заах арга зүй, агуулгад нарийвчилсан шинжилгээ хийснээр дунд ангийн англи хэлний сургалтыг дээшлүүлэх арга замыг тоддорхойлох боломжтой байна.

Мөн сорилын гүйцэтгэлийн түвшинд өрхийн өрхийн орлого нөлөөлж байна. ($r=.300^{**}$; $p<0.01$) Тухайлбал, англи хэл, математикийн судлагдахуунаар эзэмших мэдлэг, чадварын түвшинд, мэдээллийн технологиор эзэмших чадварт илүү нөлөөлжээ.

Өрхийн орлого нь нэмэгдэхэд сурагчдын гүйцэтгэлийн түвшин сайжирдаг нь статистик магадлал сайтай байна.

*Зураг 93. Дунд ангийн сурагчдын мэдлэг, чадварт өрхийн орлогын нөлөөлөл*




Өрхийн сарын орлого 700.000 хүртэл байгаа сурагчдын гүйцэтгэл 30 гаруй хувьтай байхад, 1 сая 500 мянга хүртэлх өрхийн орлоготой сурагчдынх 40 гаруй хувьтай, 2 сая ба түүнээс дээш өрхийн орлоготой байгаа тохиолдолд 60 гаруй хувьтай байна.

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн чанар нь хүмүүсийн амьжиргааны түвшинтэй холбоотой байгаа тул нийгмийн бодлогын түвшинд анхаарч үзэх хэрэгцээ харагдлаа.

Багшийн ажилласан жил сурагчдын сорилын гүйцэтгэлд нөлөөлсөн байна ($p>0.01$).

*Зураг 94. Багшийн ажилласан жил ба сурагчдын сорилын гүйцэтгэл (8 дугаар анги)*




1-5 жил ажилласан багш нараар хичээл заалгадаг сурагчдын гүйцэтгэл дурдсан хугацаанаас олон жил ажилласан багш нараар хичээл заалгадаг багш нарынхтай харьцуулахад илүү байна.

Эндээс сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд сургалтын орчин, багшийн ажилласан жил, багшлах арга зүй нөлөөлөхөөс гадна нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал, сургалтын хэрэглэгдэхүүн, материалын төрөл зүйл нөлөөлдөг байна.

# ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛ

## Бүрэн дунд боловсролын сургалтын арга зүй

Бүрэн дунд боловсролын сургалтын арга зүйг хичээлийн арга зүйн хүрээнд судалсан бөгөөд хичээлийн төлөвлөлт, түүний хэрэгжилт үр дүнд анхаарлаа хандуулсан болно. Хичээлийн төлөвлөлтийг жилийн, нэгж хичээл, ээлжит хичээлийн хүрээнд баримт бичигт дүн шинжилгээ хийн авч үзэв. Харин хичээлийн төлөвлөлтийн хэрэгжилтийг, хичээлийн зохион байгуулалт, багшлах үйл ажиллагаа, сургалтын явцад суралцагчдын оролцоо, гүйцэтгэж буй үйл, хичээлд сурах бичиг сургалтын хэрэглэгдэхүүний ашиглалт, суралцагчдыг урамшуулах дэмжих үйл ажиллагаа зэргээр авч үзэхдээ ажиглалт, асуулга, ярилцлагыг аргуудыг ашиглан мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийв.

<u>Хичээлийн төлөвлөлт</u>

Судалгааны хүрээнд сонгогдсон 11 дүгээр ангийн хувьд хичээл (судлагдахуун)-ийн жилийн, нэгж, ээлжит хичээлийн төлөвлөлтийг сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамжтай харьцуулж, тохироцыг илрүүлэхийн тулд:

- Судалгаанд хамрагдсан ерөнхий боловсролын сургуулиудаас сонгогдсон 11 дүгээр анги, бүлгийн сонгогдсон хичээл (судлагдахуун)-ийн жилийн, нэгж, ээлжит хичээлийн төлөвлөлтийг авч шинжилгээ хийв.
- Судлагдахуун бүрээр багшийн боловсруулсан төлөвлөлтийг сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамжтай харьцуулж, тодорхой шалгуурын дагуу тохироцыг илрүүлнэ.
- Судлагдахуун бүрээр хийсэн шинжилгээний дүнг нэгтгэн дүгнэв.

Төлөвлөлтүүдэд ихэвчлэн агуулга, үүн дотор бүлэг сэдэв буюу нэгж хичээлийн сэдэв, цагийн хуваарилалтыг голчлон тусгаж (97.2 хувь), харин зорилго, зорилтыг бага (5.7-17.4 хувь) тусган, үнэлгээг бараг тусгаагүй (80 хувь) байна.

Төлөвлөлтүүдийн 5.7 - 17.4 хувьд тусгасан зорилго, зорилт нь сургалтын хөтөлбөртэй тодорхой хэмжээгээр уялдаж байна. Жилийн төлөвлөлт дэх бүлэг сэдэв, нэгж хичээл, ээлжит хичээлийн агуулга, цагийн хуваарилалт нь сургалтын төлөвлөгөө, сургалтын цөм хөтөлбөр, суралцахуйн удирдамжид баримжаалан гаргасан байдал ажиглагдаж байна.

Үзүүлэлт бүрийн үр дүнг нэгтгээд багш нарын жилийн төлөвлөлтийн сургалтын хөтөлбөртэй тохирох байдлыг ерөнхийд нь авч үзвэл төлөвлөлтүүдийн 14.3 хувь сайн, 54.3 хувь дунд, 31.4 хувь хангалтгүй байна.

Багшийн нэгж хичээлийн төлөвлөлтөд зорилго, зорилт, агуулгын залгамж холбоо, тухайн нэгжийн агуулга, орчин хэрэглэгдэхүүн, үнэлгээг жилийнхтэй харьцуулахад тодорхой хэмжээгээр туссан байна.

Төлөвлөлтүүд дэх зорилго, зорилтын 48.2 - 51.7 хувь, агуулгын 86.2 хувь, орчин, хэрэглэгдэхүүний 37.9 хувь сургалтын хөтөлбөрийн зорилго, агуулга, арга зүйтэй нийцэж байна. Нэгжийн төлөвлөлтүүдийн 13.8 хувьд үнэлгээг маш сайн, 3.4 хувьд сайн, 20.7

хувьд дунд, 6.9 хувьд хангалтгүй байгаа нь төлөвлөлтийн бусад бүрэлдэхүүн хэсгүүдтэй харьцуулахад бага хувийг эзэлж байна.

Багш нарын нэгж хичээлийн төлөвлөлтүүдийн 55.2 хувь жилийн төлөвлөлттэй нийцэж байгаа бол үлдсэн хувь нь жилийн төлөвлөлттэй сайн уялдаагүй байна. Ерөнхийд нь дүгнэвэл, шинжилгээнд хамруулсан нэгж хичээлийн төлөвлөлтүүдийн 24.1 хувь сургалтын хөтөлбөртэй маш сайн, 31 хувь сайн, 41.4 хувь дунд зэрэг нийцсэн, 3.5 хувийнх нь тохироц хангалтгүй байна.

Ээлжит хичээлийн төлөвлөлтүүдийн 73.5 хувьд агуулгыг, 67.6 хувьд зорилгыг сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж, сурах бичигтэй уялдуулан тусгажээ. Харин 29.4 хувьд арга зүйг, 26.4 хувьд хэрэглэгдэхүүнийг, 26.5 хувьд явцын үнэлгээний арга, хэрэгслийг тусгах байдал бусад бүрэлдэхүүн хэсэгтэй харьцуулахад бага байна. Түүнчлэн ээлжит хичээлийн явцад хэрэглэх арга стратегийг ерөнхийд нь томьёолж бичсэн ч аль үе шатанд хэрхэн хэрэглэх нь төлөвлөлтүүдээс тодорхой харагдахгүй байв.

*Зураг 95. Ээлжит хичээлийн төлөвлөлтийн шинжилгээний дүн (хувиар, 11 дүгээр анги)*




| | Зорилго | Зорилт | Агуулга | Хэрэгжүүлэх арга зүй | Орчин, хэрэглэгдэхүүн | Явцын үнэлгээ | Нэгж хичээлийн төлөвлөлттэй нийцэх байдал |
|---|---|---|---|---|---|---|---|
| Маш сайн | 52.9 | 26.5 | 50.0 | 23.5 | 17.6 | 26.5 | 52.94 |
| Сайн | 14.7 | 14.7 | 23.5 | 5.9 | 8.8 | 0.0 | 2.94 |
| Дунд | 8.8 | 11.8 | 14.7 | 20.6 | 5.9 | 11.8 | 5.88 |
| Хангалтгүй | 11.8 | 5.9 | 2.9 | 41.2 | 29.4 | 2.9 | 2.94 |
| Тусгаагүй | 11.8 | 41.2 | 8.8 | 8.8 | 38.2 | 58.8 | 35.29 |

Багш нарын ээлжит хичээлийн төлөвлөлтүүдийн 55.8 хувь нэгж хичээлийн төлөвлөлттэй уялдсан, 35.3 хувь нь уялдаагүй байна. Ерөнхийд нь авч үзэхэд ээлжит хичээлийн төлөвлөлтүүдийн 50 хувь нь сургалтын хөтөлбөртэй уялдах нь сайн, 38.2 хувь дунд зэрэг, 11.8 хувь нь хангалтгүй байна.

Ахлах ангийн багш нар ээлжит хичээлийн төлөвлөгөөнд даалгаврын боловсруулалтыг дараагийн хичээлийн агуулгатай холбох нь сул байв.

Бүрэн дунд боловсролын түвшинд төлөвлөлтийг сайжруулахад дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй нь харагдав. Үүнд:

- Жил, бүлэг/нэгж, ээлжит хичээлийн төлөвлөлтийн зорилго, зорилтоо цөм хөтөлбөрийн үзэл баримтлал, зорилго, зорилт, суралцахуйн удирдамжид нийцүүлэн оновчтой, зөв тодорхойлох
- Жилийн төлөвлөлтөд үнэлгээний графикийг тусгах
- Бүлэг/нэгжийн төлөвлөлтөд үнэлэх арга, аргачлал, үнэлгээний даалгавар боловсруулах, ээлжит хичээлийн төлөвлөлтөд явцын үнэлгээний арга, хэлбэрийг тодорхой тусгах
- Бүлэг/нэгж, ээлжит хичээлийн төлөвлөлтөд сургалтын арга, хэрэглэгдэхүүн, материаллаг орчныг төлөвлөх, жишиг даалгавар, шаардлагатай ажлын хуудсыг боловсруулах
- Ээлжит хичээлийн төлөвлөлтөд хичээлийн үе шат бүрд хийх алхмууд буюу багш, сурагчийн хийх үйлийн дарааллыг тодорхой төлөвлөх
- Жил, бүлэг/нэгж, ээлжит хичээлийн төлөвлөлт хоорондын уялдааг сайжруулах, төлөвлөлтийн дагуу хичээлээ заах

## Хичээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж буй байдал

Ахлах ангид хичээл заадаг багш нарын 30.4 хувь нь мэргэжлийн зэрэггүй, 47.4 хувь нь заах аргач, 21.1 хувь нь тэргүүлэх, 1.1 хувь нь зөвлөх зэрэгтэй бөгөөд ихэнх хувь нь байгалийн ухаан болон монгол хэл, гоо зүй (биеийн тамир, технологи)-н багш нар байна.

Хичээл төлөвлөхдөө багш нар сурах бичгийг илүүтэй ашигладаг нь харагдлаа. (79.3 хувь) Түүнээс гадна сургалтын цөм хөтөлбөр, суралцахуйн удирдамж болон тест, даалгаврын санг багш нарын 53.0-55.6 хувь нь байнга ашигладаг дүр зурагтай байна. Сургалтын хэрэглэгдэхүүний хувьд багш нар биет үзүүлэн, зураг дүрслэл бүхий үзүүлэн, сорил, туршилтын багаж, хэрэгсэл зэрэг төрөл бүрийн хэрэглэгдэхүүнийг ашигладаг байна. Тэр дундаа биет үзүүлэн болон зураг, дүрслэл бүхий үзүүлэн, сорил туршилтын багаж хэрэгслийг хамгийн их ашигладаг байна. Багш нарын сургалтын хэрэглэгдэхүүний ашиглах байдал сайн байна.

Ээлжит хичээлийг төлөвлөхөд тулгардаг бэрхшээлтэй байдаг зүйлсийн талаар судалгаанд хамрагдсан багш нараас асуухад:

*Хүснэгт 113. Хичээл төлөвлөхөд багш нарт тулгардаг бэрхшээл (ахлах ангийн багш)*

| *бэрхшээлүүд* | *хэцүү* |
|---|---|
| хичээлийн зорилгыг цөм хөтөлбөртэй уялдуулах | 25.6 |
| сурагчдын өмнөх мэдлэг, чадвар, хандлагыг харгалзах | 38.1 |
| сурагчдын ялгаатай байдалд тохируулах | 59.3 |
| нэгж хичээлийн үнэлгээний даалгавар боловсруулах | 27.0 |
| явцын үнэлгээний арга, хэрэгслийг тусгах | 23.3 |
| дадлага, туршилтыг тусгах | 27.0 |
| асуултыг танин мэдэхүйн түвшнийг харгалзан боловсруулах | 33.0 |
| явцын үнэлгээнд тулгуурлан төлөвлөлтийг сайжруулах | 20.0 |
| гэрийн даалгаврын гүйцэтгэлд тулгуурлах | 24.8 |
| цаг бага, төлөвлөөгүй ажил гарах | 68.1 |
| сургалтын хэрэглэгдэхүүнд зардал гарах | 82.2 |

Дурдсан бэрхшээлүүдээс сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэхэд мөнгө, зардал гаргах нь хамгийн их бэрхшээлтэй байдаг гэж судалгаанд хамрагдсан ахлах ангийн багш нар

үзжээ. (82.8 хувь) Үүнээс гадна, хичээл төлөвлөхөд зарцуулах цаг бага, төлөвлөөгүй ажил гарах, сурагчдын ялгаатай байдалд тохируулан төлөвлөх нь амаргүй байдгийг нэлээдгүй дурдсан байна.

*Ээлжит хичээлийн бүтцэд хийсэн шинжилгээ*

Энэхүү судалгаанд хичээлийн бүтэцтэй холбоотой хийгддэг үйлүүдийг түүнд зарцуулсан хугацаатай хамааруулан шинжиллээ.

*Зураг 96. Ээлжит хичээлийг зохион байгуулах бүтэц, зарцуулсан дундаж хугацаа (минутаар, 11 дүгээр анги)*




Ээлжит хичээлийн зохион байгуулалтын хугацааны бүтцийг хувиар тооцвол, гэрийн даалгавар шалгахад нийт хичээлийн 17.0 хувь, зорило зорилтыг танилцуулахад 8.1 хувь, шинэ мэдлэг бүтээх үйл ажиллагаанд 51.8 хувь, үнэлгээ дүгнэлт өгөхөд 14.5 хувь, гэрийн даалгавар өгөхөд 8.3 хувь тус тус эзэлж байна.

Багш, сурагчдын гэрийн даалгаврыг хүүхэд бүрээр шалгахдаа анги нийтэд нь асууж өнгөрдөг байдал нь нийтлэг байна.

Ахлах ангийн багш нар хичээл дээр зорилго, зорилтыг шинжлэх ухааны нэр томъёог ашиглан танилцуулах үйлийг хийдэг нь харагдлаа.

Шинэ мэдлэг бүтээх үе шатанд багш сурагчдаас эргэцүүлэн бодох үйлийг шаардсан асуултуудыг нэлээдгүй асуудаг байна.

Ээлжит хичээлийн үнэлгээ дүгнэлт өгөх хэсэгт сурагчид өөрийн санаа бодол, шүүн тунгааж эргэцүүлснээ оюуны зураглалаар илэрхийлэх үйлийг хийх нь бага, суурь боловсролын түвшинтэй харьцуулахад сайн байв.

*Ээлжит хичээл зохион байгуулалтын хэлбэр*

Хичээлийг багаар болон хосоор зохин байгуулахад сургалтын хэрэглэгдэхүүний ашиглалт, сурагчид учир шалтгааныг олох эрэл хайгуул хийх, багш сурагчдын асуулт, хариултыг анхааралтай сонсож, дэмжих, сурагчид бие биеэ үнэлэх, оюуны зураглал хамтран хийх гэх мэт идэвхтэй үйлүүд илүү ажиглагдаж байна.

Ээлжит хичээлээр багш, эргэцүүлэн бодох олон янзын санаа гаргахад сурагчдыг чиглүүлэх үйл хийснээр зорилгодоо чиглэсэн эргэцүүлэн бодох асуултаар сурах сэдэл төрүүлэх, суралцах чадварын ялгааг харгалзан үзэх, шинжлэх ухааны багаж, хэрэгсэл, бодис ашиглах, учир шалтгааныг олох эрэл хайгуул хийлгэх, сурагчид санал, бодлоо хуваалцах, бие даан дүгнэлт гаргаж, мэдлэг бүтээх боломж олгох, явцын үнэлгээг дасгал

даалгаварын гүйцэтгэлээр хийх, асуудлыг хамтран хэлэлцэж, шийдвэрт хүрэх, багш сурагчид ангийн түвшинд нэгдсэн шийдэлд хүрэх үйлүүд илүү хийгдсэн байна.

Бүрэн дунд боловсролын 11 дүгээр ангийн 13 судлагдахууны 38 хичээлийн ажиглалтын мэдээллийг шинжилж үзэхэд 50.0 хувь нь ямар нэг хэлбэрээр сурагчдыг эргэцүүлэн бодох олон янзын санаа гаргахад чиглүүлсэн байна.

Багшийн сурагчдаар хийлгэсэн туршилт, шийдвэрлэх асуудал дэвшүүлсэн үйл нь ээлжит хичээлийн зорилго, зорилттой уялдаж, хүүхдийн олж авсан өмнөх мэдлэг туршлагад тулгуурласан боловч тухайн туршилт, шийдвэрлэх асуудал нь сурагчдын суралцах чадварын ялгааг харгалзан үзэхгүй байгаа нь судалгаанаас харагдлаа.

*Зураг 97. Туршилт шийдвэрлэх асуудлыг оновчтой тодорхойлсон байдал (11 дүгээр анги)*




*Зураг 98. Зорилгод чиглэсэн сэдэлжүүлэх үйлийн эзлэх хувь (11 дүгээр анги)*




Судалгаанд хамрагдсан багш нар зорилгод чиглэсэн үйлээр сурагчдыг сэдэлжүүлэх үйлийг түлхүү ашигладаг байна. Эдгээр үйлийг багш хийснээр ахлах ангийн сурагчид өөрийн санаа бодол, шүүн тунгааж эргэцүүлснээ бичгээр болон схем диаграммаар илэрхийлэх, уялдаа холбоог илрүүлэх асуулт асуух, бие биедээ тайлбарлаж ярих, багаар болон хосоор ажиллах, ангийн түвшинд нэгдсэн шийдэлд хүрэх үйлүүд илүү ажиглагдлаа.

Сурагчдын дэвтрийн бичиглэлийн эмх цэгц, дэс дараалал жигд бус байна.

Хичээлийн идэвх, оролцооны талаар ахлах ангийн сурагчдаас тодруулахад тэдний олонх нь математик, биеийн тамир, нийгэм судлал, физик, англи хэл, монгол хэлний хичээлд идэвхитэй оролцдог талаараа дурджээ. Үүний шалтгааныг тодруулж асуухад дуртай, сонирхолтой, мэргэжилтэй холбоотой гэсэн тайлбаруудыг олонх нь өгчээ.

Залуу багш нарын хичээл гоё хичээл байдаг, яагаад гэвэл сурагчидтайгаа нээлттэй байдаг, Хөгшин багш нарын хичээл болохоор хүндлээд байдаг ч гэхүү, дуугүй байдаг, тэд хуучны аргаар дэвтэр номоо хардаг.

*Нийслэлийн сургуулийн ахлах ангийн сурагч*

Багш нар хичээлээ ихэвчлэн ямар зохион байгуулалттай явуулдаг талаар лавлахад анги нийтээр заадаг гэж сурагчдын олонх хариулсан бол хичээлийн зохион байгуулалтын ямар хэлбэр таалагддаг тухай асуултад “багаар” гэж дийлэнх нь хариулсан.

### *Ахлах ангид сонгон судалж буй хичээлийн зохион байгуулалт*

Ахлах ангид сонгон судалж байгаа хичээлийн зохион байгуулалт, бэрхшээл, цаашид авах арга хэмжээний талаар судалгаанд хамрагдсан сургуулиудын сургалтын менежер болон багш нараас мэдээлэл авахад дараах дүрзураг харагдав. Сурагчид монгол хэл, математик, англи хэл, нийгэм гэсэн хичээлүүдийг ихэвчлэн сонгодог бөгөөд энэ нь сурагчдын мэргэжил сонголт, монгол хэлний болон ЭЕШ зэрэгтэй холбоотой байна гэжээ. Газар зүй, орос хэл, түүх зэрэг хичээлийг цөөн сурагч сонгодог байх бөгөөд зарим сургууль дээр байгалийн ухааны хичээлүүдийг сурагчид цөөн сонгож байгаа нь анхаарал татаж байна.

Математик, нийгэм, англи хэл, өнөөгийн нийгэмд чинь хэлтэй бол хөлтэй гэдэг шиг математик мэдэхгүй бол хүн цаашаа явахгүй.

*Нийслэлийн сургуулийн ахлах ангийн сурагч*

ЕБС-д ахлах ангийн сурагчдын хичээл сонголтыг намар голдуу хийлгэдэг бөгөөд нэг сургууль сургуулийнхаа дотоод журамд зохих зүйл заалт оруулсан тухайгаа тодотгов. Энэ үйл ажиллагаа 14-21 хоног үргэлжилдэг ажээ. Хичээл сонголтод эцэг, эхчүүдийн оролцоо их ба сургалтын менежерүүдийн мэдэгдэж байгаагаар мэргэжлээ сонгосон хүүхдүүдийн хувьд хичээл сонголт асуудалгүй байдаг ажээ.

Намар сурагчдыг хичээлдээ ирэхэд нь гадна талбайд зогсоож байгаад сургалтын хөтөлбөрийг талаар танилцуулж, анги удирдсан багш нар болон мэргэжлийн багш нарын энэ анги удирдах, тухайн хичээлийн орох талаар нь танилцуулдаг. 10а анги байгалийн ухаан, 10б нийгэм, монгол хэл сонгосон анги гэж хэлээд заа хүүхдүүд өөрсдийн хүслээр ямар ямар ангид орох вэ? гэж дахин сонголт хийлгэдэг байгаа.

*Орон нутгийн сургуулийн сургалтын менежер*

Сургалтын менежерүүдийн өгсөн мэдээллээс үзэхэд сурагчдын сонгосон хичээлийг дараах байдлаар зохион байгуулдаг байна. Үүнд:

- байгалийн ухаан, нийгмийн ухааны ангиар хуваарилах,
- сонгосон хичээлээр бүлэг үүсгэж, сүүлийн цагууд дээр оруулах,
- 10-12-р ангийн нийлмэл сонгон үүсгэх, энэ нь ялангуяа түүх, газар зүй, орос хэл, биологи, хими зэрэг хичээлүүд цөөнх болж босоогоор нь сонгох зэрэг байна.

Сургалтын менежерүүд болон багш нар нь ахлах ангид хичээл сонголтод дараах бэрхшээлүүд тулгарч байна гэв. Үүнд:

- сурагчдын сонголт хийх чадвар, сонголтоо өөрчлөх байдал,
- зарим судлагдахуунд анги буюу бүлэг үүсгэх боломжгүй, хүүхдийн тоо цөөн учраас зарим хүүхэд хүчээр сонгодог,
- анги танхим хүрэлцээгүй,

- зарим хичээлийн хувьд цөөн хүүхэд сонгосон тохиолдолд тэр хичээлийг нь орох боломжгүй,
- хичээл сонголтыг хөдөө орон нутагт зохион байгуулахад багшийн хүрэлцээ муу, хүүхдийн тоо цөөн учраас маш их хүндрэлтэй байна,
- хүүхдүүд биенээ даган дууриах байдлаар сонгож байна гэжээ.

Энэ жил манайх 12 дугаар ангийн ганц бүлэгтэй. Шууд математик 6 цаг үзнэ гэж хувааж болохгүй. Ийм учраас Математик, Нийгэм, Монгол хэл 4 цаг бусад хичээлийг улирлаар ороод явж байгаа. Ирэх жилээс хичээлээ төрөлжүүлээд явахаар сургалт явуулж байна. Багш хүүхэд 2оо дасгаад бэлдээд л байна даа.

*Орон нутгийн сургуулийн сургалтын менежер*

Хүүхдийн тоо заалгүйгээр өгөх ёстой цагийг нь өгч байвал их зүгээр байна. Хөдөө орон нутаг, сумдад л ийм асуудал гарна.

*Орон нутгийн сургуулийн багш*

Сонгох гэсэн хичээл бүрийг оруулах нь өрөөсгөл байна. Харин заавал судлах хичээл бүрийг оруулах нь тохиромжтой. Сонгон судлах хичээлийг тушаал дээр тавьсан цаг нь газар дээрээ ирээд хэрэгжихгүй байна.

*Нийслэлийн сургуулийн багш*

Сургууль өөрийн хөтөлбөртэй болох бие даасан байдлыг илүү их хангах зайлшгүй хэрэгцээ шаардлага байгааг нэг сургалтын менежер хөндсөн байна. Хичээл сонгодог болоод 3-4 жил болж байгаа боловч хүүхдүүд сонголт хийх арга барилдаа суралцаагүй, сонголтоо өөрчилж байгааг менежерүүд тэмдэглэж байна. Энэ нь хичээлийн хуваарьт хүндрэл учруулдаг байна.

Сонголт хийх нь зөв. Хүүхдүүд сонголт хийж сураагүй байна. Хүүхдүүд сонголтондоо хариуцлагагүй хандах тохиолдол байна.

*Орон нутгийн сургуулийн сургалтын менежер*

Дээр тэмдэглэсэн зарим бэрхшээлийг “ойр хавийн сургуулиуд хамтран” шийдэх боломжтой гэж нэг менежер мэдэгдсэн бөгөөд үүний тулд эрх зүйн болон эдийн засгийн зохицуулалт шаардлагатай ажээ.

Тулгарч буй хүндрэл бэрхшээлүүдийг хэрхэн шийдвэрлэж байгаа, мөн хичээл сонгон судлахтай холбоотой цаашид ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай талаар бүлгийн ярилцлагад хамрагдсан багш нараас тодруулж асуухад сургуулиуд өөрсдийн хүчин чадал, нөөц бололцоонд тулгуурлан харилцан адилгүй үйл ажиллагаа явуулж, арга хэмжээ авч байгаа нь харагдав. Эдгээрт, дунд анги төгсөх жил буюу 9 дүгээр ангид нь мэргэжил сонгох талаар сургалт явуулдаг, мэргэжил сурталчлах ажил зохион байгуулдаг, эцэг эх, багш нар зөвлөн тусалдаг гэх мэт үйл ажиллагааг багш нар дурдсан байна.

Сурагчдын хичээл сонголтын хувьд манай аймгийн бренд болж байгаа зүйл байна. Эцэг эхтэй холбогдож 8 ангиас эхлээд мэргэжил сонголтын тухай ярилцаад 10 ангид ороод хувилбарт ангид ордог. Багш болох хүн ямар хичээл сонгохыг ярилцаад шийддэг. Хүүхдийн судалгаа хийгээд хамгийн олонх хүүхдийн бүлэг үүсгээд ямар хичээл байхыг судлаад тодорхойлж өгдөг.

*Орон нутгийн сургуулийн сургалтын менежер*

Хувийн сургуулийн хувьд ахлах ангийн сурагчдын хичээл сонголтод харьцангуй асуудал бага байдаг бөгөөд энэ нь тухайн сургуулиудын сургалтын бодлого, анги танхим, багшлах боловсон хүчний мэдлэг чадвар зээргтэй холбоотой байна. Тухайлбал, судалгаанд оролцсон хувийн сургуулийн менежерүүдийн нэг нь сурагчид 10 дугаар ангиасаа судлах сургалтын хөтөлбөрөө сонгодог бөгөөд эдгээр хөтөлбөрүүд нь үндэсний сургалтын хөтөлбөр болон олон улсын жишигт нийцүүлэн боловсруулсан сургуулийнх нь хөтөлбөр байдаг, сурагчдыг ямар хөтөлбөр сонгосноор нь байгалийн, нийгмийн ухааны ангиар хичээллүүлдэг талаар ярьсан бол нөгөө сургуулийн сургалтын менежер ахлах ангидаа сурагчид “10-р ангид стандарт хичээлүүдээ үзээд, 11 дүгээр ангидаа үдээс өмнө заавал судлахаа 2 хоёр цагаар, үдээс хойш сонгон судлахаа сонгон маягаар явж байна. 12-р ангидаа яг үүнийгээ давтаад явж байгаа. Ингэхээр ЭЕШ, бага дунд ангид авсан мэдлэг маш сайн баталгаажддаг” гэжээ.

### *Сургалтыг дэмжих үйл ажиллагаа*

Сургуулиуд ахлах ангиудад мэргэжлийн чиг баримжаа олгох талаар илүү анхаардаг ажээ.

> Тухайн ангиудад хичээл заадаг багш нарын баг байгуулж, сурагчдаас судалгаа аваад, сурагчдад хэрэгцээ шаардлагатай сэдвийг сонгодог бас төлөвлөдөг. Ахлах ангийн сурагчдын хувьд мэргэжил сонголттой холбоотойгоор эцэг эхтэй хамтран байгууллагаар явах гэх мэт. Жишээлбэл: нийгмийн хичээлтэй холбоотойгоор хууль, шүүх гэх мэт явж, дадлага хийдэг. Жилийн төлөвлөгөөг хийж дууссаны дараа эцэг эхэд нь мэдэгддэг.
>
> *Нийслэлийн хувийн сургуулийн багш*

### *Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн*

ЕБС-ийн 10-12 дугаар ангид 14-15 судлагдахууны 38 нэрийн сурах бичгийг сургалтад хэрэглэж байна. Гэхдээ судалгааны мэдээлэл цуглуулах үед 11 дүгээр ангийн мэдээллийн технологи, дизайн технологи, нийгэм судлалын сурах бичгүүд хэвлэлтээс гараагүй байсан тул асуулгад оруулаагүй. Мөн орос хэл, бизнес судлалын сурах бичгийг сонгон судлах хөтөлбөрийн хүрээнд судлах тул сурах бичгийн хангалтын хувь, хэмжээний тооцоонд оруулаагүй болно.

*Зураг 99. Ахлах ангийн сурах бичгийн хүртээмж (судлагдахуунаар)*




Нийт сурагчдын 48.3 нь ямар нэг хэмжээгээр сурах бичигтэй байна.

Сурах бичгийн хангалтыг байршлаар авч үзвэл худалдаж авсан хүүхдийн эзлэх хувь суманд нийслэл, аймгийн хувиас бага байгаа нь өмнө дурдсан худалдаа борлуулалтын нэгдсэн сүлжээ, зохицуулалт байхгүйтэй шууд холбоотой юм.

*Зураг 100. Ахлах ангийн сурах бичгийн хангалт (байршлаар)*




Ахлах ангийн сурагчид сурах бичгийг хэрхэн хэрэглэдэг талаар судлахад 37.6 хувь нь сурах бичгийг хуулж бичдэг, 32.8 хувь нь эхийг нь уншдаг, 20.6 хувь нь зургийг нь хардаг, 52.5 хувь нь дасгал даалгаврыг нь хийдэг, 16.7 хувь нь сорил туршилт хийхдээ ашигладаг гэжээ. Бага, дунд ангийнхтай харьцуулахад сурах бичгийн зургийг нь хардаг гэсэн хүүхдүүдийн хувь буурсан байна. Энэ нь анги дээшлэх тусам сурах бичгийн зургийн эзлэх хувь буурдагтай холбоотой байж болох юм. Харин дасгал, даалгаврыг нь ажилладаг гэсэн хүүхдийн хувь дунд ангийн сурагчдаас бага болсон байна. Сорил туршилт хийхэд ашигладаг гэж хариулсан сурагчдын хувь дунд ангиас буурсан байна. Бүх судлагдахууны сурах бичгийн хувьд дасгал, даалгаврыг нь хийдэг гэх хүүхдийн эзлэх хувь бусад үйлийг хийдэг гэх хүүхдийн эзлэх хувиас өндөр байна. Дараах зурагт хамгийн их санал авсан үйлийг судлагдахуун бүрээр харуулав.

Монгол хэл, уран зохиол, англи хэлний сурах бичгийн хувьд эхийг нь уншдаг гэх хариулт, үндэсний бичиг, түүхийн сурах бичгийн хувьд хуулж бичдэг гэх хариулт дийлэнх хувийг эзэлж байна.

Математик, физик, хими, биологи, газарзүйн сурах бичгийн эхийг нь уншдаг гэх хариулт нэг ч сурагчаас ирээгүй нь байгалийн ухааны судлагдахууны онцлогтой холбоотой байж болох юм. Харин биологийн сурах бичигт зургийг нь хардаг гэх хариулт багагүй хувийг эзэлж байна. Байгалийн ухааны сурах бичгүүдийг хуулж бичдэг гэх хариулт өгсөн хүүхдийн эзлэх хувь сорил, туршилт хийдэг гэх хариулт өгсөн сурагчдын эзлэх хувиас бага байгаа нь анхаарах асуудлын нэг болж байна.

Сурах бичиггүй нийт сурагчдын 2.2 хувь нь аав, ээж худалдаж авч өгөөгүй, 83.4 хувь нь худалдаж авах гэхээр олддоггүй, өндөр үнэтэй тул худалдаж аваагүй гэжээ. Харин 4.9 хувь нь сурах бичгээ гээсэн, 9.4 хувь нь сургуулиас өгөөгүй гэснээс үзвэл ахлах ангийн сурагчдын 90 орчим хувь нь сургуулиас өгөхгүй, өөрөө сурах бичгээ худалдаж авах ёстой гэдгийг мэдэж байна гэж үзэж болох юм. Сурах бичгийн хангалтыг нэмэгдүүлэхийн тулд сурах бичгээ үйлдвэрийн үнээр, оршин суугаа газраа, нэг цэгээс бүгдийг нь худалдаж авах худалдаа борлуулалтын талаар ямар нэгэн зохицуулалтыг хийх хэрэгтэй нь харагдлаа.

Судалгаанд хамрагдсан нийт эцэг эх, асран хамгаалагчийн 96.1 хувь нь “Манай хүүхэд хичээлийнхээ сурах бичгээр бүрэн хангагдсан”, 3.2 хувь нь “Үгүй”, 0.7 хувь нь “Мэдэхгүй” байна. Сурах бичгийн хангалтын тоо, хэмжээтэй харьцуулахад хүүхдийнхээ сурах бичиггүй байгааг ихэнх ээж, аав нар мэддэггүй гэж үзэж болохоор байна. Эцэг эх, асран

хамгаалагчийн 96.8 хувь нь хүүхдийнхээ сурах бичгийг сургуулиас өгсөн гэжээ . Харин 3.2 хувь нь сурах бичгийг үйлдвэрийн үнээр болон нэмэгдсэн үнэ (дам)-ээр худалдаж авсан байна.

Сурах бичгийн хангалтыг нэмэгдүүлэх талаар эцэг эх, асран хамгаалагчийн 86.7 хувь нь төрөөс үнэгүй өгөх, 1.5 хувь нь өөрсдөө худалдаж авах, 10.9 хувь нь түрээсээр авч хэрэглэдэг байхыг онцолжээ.

Сургалтын хөтөлбөр, сурах бичиг нь хоорондоо уялдаатай гэж багш нарын олонх нь үзсэн байна.

> Тогтвортой хөгжлийн хүрээнд химийн сурах бичиг цөм хөтөлбөрийн хоорондын уялдаа холбоог судалж байсан. 90 хувь уялдаатай байсан.
>
> *Нийслэлийн хувийн сургуулийн багш*

### *Сурах бичгийн хангамж, хүртээмж*

Багш нар сурах бичгийн *хангамж, хүртээмж* хангалтгүй, худалдаж авах гэхээр олддоггүй эсвэл үнэтэй байдаг, ялангуяа ахлах ангийн сурах бичиг байхгүй учраас хуучин сурах бичиг ашиглаж байгаа нь харагдлаа.

> Сурах бичгийн хүртээмж муутай, одоо болтол ирээгүй. Сүүлийн 3 жилийн хугацаанд нийгмийн ухааны сурах бичиггүй байна. Суралцахуйн удирдамжаа ашиглан, сэдвийн дагуу өөрсдөө мэдээллээ интернэтээс эрж хайж ашигладаг.
>
> *Орон нутгийн сургуулийн багш*

### *Сурах бичгийн агуулга, арга зүй*

Сурах бичгийн агуулга, арга зүйн талаар багш нар судлагдахууны онцлогоос хамааран харилцан адилгүй хариултыг өгсөн байгаа ч нийтлэг дараах зүйлс байна. Үүнд:

- нэгж, сэдэв хоорондын залгамж холбоо, уялдаа муу,
- дасгал, даалгавар нэг хэвийн,
- байгалийн ухааны хичээлийн хувьд бодитоор харах, гүйцэтгэх тухай аргачлал байгаа ч хэрэглэгдэхүүн хангалтгүй байна,
- заавал судлах болон сонгон судлах хичээлийн агуулга өөр,
- сурах бичгийн агуулга хүнд гэх мэт хариултыг өгсөн байна.

> Зарим ангийн математикийн сурах бичгийн хувьд хэт онолын өндөр түвшний агуулгатай, жишээ нь: 10 дугаар ангийн сурах бичгийн агуулгыг их, дээд сургуулийн агуулгаар бичсэн.
>
> *Орон нутгийн сургуулийн багш*

> Зарим ангийн унших текст их хүнд. 12 дугаар ангийн сурах бичигт улсын шалгалт болон элсэлтийн ерөнхий шалгалттай холбоотой ороогүй.
>
> *Нийслэлийн сургуулийн гадаад хэлний багш*

Багш нар сурах бичигт сурагчдын мэдлэг, чадварыг бататгах дасгал, даалгавар хангалтгүй байгаа талаар дурджээ. Ахлах ангид ордог зарим судлагдахууны сурах бичиг

харьцангуй гайгүй байгааг тэд тодотгов. Тухайлбал, монгол хэлний сурах бичгийн хувьд бататгах даалгавар сайтай, биологийн сурах бичиг дажгүй гэх мэт.

Багш ээлжит хичээлийн төлөвлөлтдөө шийдвэрлэх асуудалтай холбоотой сургалтын хэрэглэгдэхүүн (сурах бичиг, гарын авлага ба бусад)-ийг тухайн хичээлийн зорилго, суралцахуйн зорилтууд, хэрэгжүүлэх аргатай уяж тусгах ёстой байдаг. Ээлжит хичээл бүрээр хөтөлбөрийн зорилго, суралцахуйн алхмуудыг хэрэгжүүлэхэд тухайн судлагдахууны сурах бичиг чухал үүрэгтэй, ач холбогдолтой.

Ангийн нийт сурагчдын дунджаар 56 хувь нь хичээл дээр сурах бичигтэй байсан байна . Ахлах ангийн сурагчдын хувьд орж байгаа хичээлийн сурах бичгийн хүрэлцээ, хангамж дутагдалтай байгаа үед ээлжит хичээлийн идэвх, оролцоо сулрах тал илүү ажи гла гдаж байв.

Судалгаанд хамрагдсан багш нарын 50 хувь нь хичээлийн төгсгөлд гэрийн даалгаврыг сурах бичгээс, 11 хувь нь нэмэлт гарын авлага, материалаас, үлдсэн хувь нь гэрийн даалгавар өгөөгүй байна.

Багш гэрийн даалгаврыг сурах бичгээс өгсөн тохиолдолд сурагчид учир шалтгаан, зүй тогтлыг тодруулсан асуулт асуудаггүй, бие биедээ тайлбарлаж ярих үйл хийдэггүй байдал ажиглагдав. Багш гэрийн даалгаврыг гарын авлага бусад туслах материалаас өгсөн тохиолдолд өөрийн санаа бодол, шүүн тунгааж эргэцүүлснээ оюуны зураглалаар илэрхийлэх, сурагч сурагчаа үнэлэх үйл илүү хийгдэж байлаа.

*Сурах бичгийг сайжруулахад цаашид юу анхаарах вэ?*

Сурах бичгийг сайжруулахад цаашид юунд анхаарах талаар багш нартай ярилцахад эн тэргүүнд хангамж, хүртээмжийг сайжруулах шаардлагатай гэсэн байна. Мөн агуулга, арга зүйн хувьд анхаарах, сурах бичгийг дагалдсан бие даалтын дэвтэр эсвэл дасгал, даалгаврын дэвтэр хэрэгтэй байгааг дурдсаны дээр ерөнхий боловсролын сургуулийн туршлагатай багш нарыг сурах бичиг боловсруулах багт оруулж ажиллуулах зэрэг саналуудыг мөн адил өгчээ.

> Сурах бичгийг хэрэглээнд оруулахаас өмнө заавал турших үзсэн байх шаардлагатай байна.
>
> *Нийслэлийн сургуулийн багш*

Ахлан ангид нэмэлт гарын авлага, интернетийн эх сурвалжаас мэдээлэл авахаас гадна хуучны сурах бичгийг багш нар цөөнгүй ашиглаж байна.

Бүрэн дунд боловсролын түвшинд сургалтын хэрэглэгдэхүүний ашиглалт ямар байгааг авч үзвэл сурагчдын нас хөгжлийн онцлогт тохирсон гарын доорх материал, хэрэглэгдэхүүнийг хими, нийгэм судлал, мэдээллийн технологиос бусад хичээлүүдэд ашигласан цөөн тохиолдол байна.

*Зураг 101. Гарын доорх материал хэрэглэгдэхүүн, шинжлэх ухааны багаж хэрэгсэл ашигласан байдал (11 дүгээр анги)*




Ахлах ангийн сурагчдад нас хөгжлийн онцлогт тохирсон гарын доорх материал хэрэглэгдэхүүн ашиглаж хичээл сургалтыг явуулахад өөрийн санаа бодол, шүүн тунгааж эргэцүүлснээ бичгээр илэрхийлэх, оюун дүгнэлт дүгнэлж хийж танилцуулах үйлүүд, сурагчдын дэвтрийн бичиглэл эмх цэгц, дэс дараалал сайжирсан байна.

Багш сургалтад үзүүлэн, тараах материал ашигласан байдлаар судалгааны үр дүнг харвал цахим болон дэлгэцийн тоног төхөөрөмж ашигласан 42 хувь, хэвлэмэл үзүүлэн 26.3 хувь, бэлэн эх дээр ажиллах зорилготой тараах материал 44.7 хувь, сэтгэн бодох тарааж өгөх материал 30 орчим хувьтай ашиглажээ.

*Зураг 102. Самбар ашиглалт (11 дүгээр анги)*




11 дүгээр ангид хичээл заасан багш нарын самбар ашиглалтыг авч үзэхэд гаргацтай, харагдахуйц байснаас гадна, тэдний 55 гаруй хувь нь сурагчдад самбараас мэдээлэл авах хангалттай хугацаа олгожээ.

## Үнэлгээ, дүгнэлт

Судалгаагаар сурагчдыг үнэлэхэд гардаг өөрчлөлтийн талаар багш нараас тодруулахад ямар нэг хэмжээгээр өөрчлөлт орсон гэж багш нарын дийлэнх хувь нь үзжээ. Тэр дундаа явцын үнэлгээнд үндэслэн сурагчдыг чиглүүлэх, зөвлөн туслахад өөрчлөлт орсон гэж багш нарын 42.6 хувь нь үзсэн бол тэдний 50-иас дээш хувь нь үнэлгээний даалгавар боловруулах, явцын үнэлгээний аргыг сонгож, үр дүнтэй хэрэглэх, ээлжит хичээлийн

төлөвлөлт явцын үнэлгээний арга, хэрэгслийг тусгахад бага зэрэг өөрчлөлт гарсан гэжээ. Харин багш нарын 6-11 хувь нь үнэлгээнд өөрчлөлт гараагүй гэсэн байна.

Судалгаанд хамрагдсан багш нарын 70.4 хувь нь сурагчийн өөрийн үнэлгээ, 67.4 хувь сурагчдаар бие биенийг нь үнэлүүлэх аргыг *зарим хичээлд* хамгийн их ашигладаг гэсэн байна. Үнэлгээний аргуудыг бүх хичээлд тодорхой хэмжээгээр ашигладаг гэсний дунд хичээлийн явцад ажиглах, асуулт тавих аргуудыг нэлээд дурджээ. Үнэлгээний арга, хэлбэрүүдийг хичээлдээ ашигладаггүй гэж хариулсан багш нарын хувь бага байгаагаас үзэхэд багш нар үнэлгээний төрөл бүрийн арга, хэлбэрийг хичээлдээ ямар нэг байдлаар хэрэглэдэг байна.

Судалгаанд хамрагдсан ахлах ангийн сурагчид багшийн үнэлгээнд олонх нь сэтгэл ханамжтай байна. Харин үнэлгээний шударга байдлын хувьд 60 гаруй хувь нь шударга, бусад нь шударга бус гэж үзэж байна. Багшийн болон бусад хүүхдийн өгсөн үнэлгээнээс цаашид юун дээр анхаарахаа мэдэж авч чаддаг уу гэсэн асуултад бүх сурагч "тийм" гэсэн хариултыг өгсөн. Явцын үнэлгээг ахлах ангид багш нар ихэвчлэн даалгавар ашиглан хийж байгаа бөгөөд энд үед сурагчдын идэвхтэй харилцах байдал сулрах хандлагатай байна. Харин хэрэглэгдэхүүн ашиглаж сурагчдын үнэлэх үйл ажиллагаа ажиглалт хийсэн хичээлийн 23.7 хувьд нь байна.

Газар зүй, мэдээллийн технологи, монгол хэл, химийн хичээлүүдээр багш нарын 15.8 хувь нь самбар ашиглан хичээлээ дүгнэсэн байна.

Ээлжит хичээлээр төлөвлөсөн зорилгоо хэрэгжүүлсэн эсэхэд судлаачдын өгсөн үнэлгээг авч үзвэл, бүрэн хэрэгжүүлсэн 50, дутуу хэрэгжүүлсэн 40, хэрэгжүүлээгүй 10 хувь тус тус байгаа нь бүрэн дунд боловсролын багш нар хичээлийн төлөвлөлт, хэрэгжүүлэлт, үр дүнд анхаарч сайжруулах шаардлагатайг харуулж байна.

*Хамтын ажиллагаа, оролцоо*

Хичээл, сургалтын явцад олон чиглэл, хэлбэрээр тодорхой давтамжтайгаар эцэг эх, асран хамгаалагчдтай хамтран ажилладаг дүр зурагтай байна. Багш нарын 37.0 хувь нь хүүхдэд тулгарсан асуудал, бэрхшээлийн талаар 14 хоногт нэг удаа эцэг эх, асран хамгаалагчидтай ярилцдаг, шийдвэрлэдэг; сургуулийн зорилго, хөгжлийн талаар улиралд нэг удаа мэдээлдэг гэж 53.3 хувь нь хариулсан байна. Цаг үеийн мэдээлэл, үйл явцын талаар сард нэг удаа мэдээлдэг гэж багш нарын 31.9 хувь нь, сурагчийн сурлагын ахиц, амжилт, өөрчлөлтийн талаар улиралд нэг удаа эцэг эхтэй хамтран ажилладаг гэж багш нарын 56.3 хувь хариулсан.

Сурагчдын сурлагын амжилтыг ахиулахад эцэг эх, асран хамгаалагчдын оролцоог багш нараар үнэлүүлэхэд дундаж гэж үнэлсэн дүр зурагтай байна. Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийнхээ сурлагын ахиц, өөрчлөлт болон хүмүүжил, төлөвшлийн талаар багшаас хааяа мэдээлэл авч, асууж ярилцдаг гэж багш нарын олонх нь буюу 60-аас дээш хувь нь хариулсан. Харин сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, хангахад оролцдоггүй гэж багш нарын 53.0 орчим хувь хариулсан нь энэ тал дээр эцэг эх, асран хамгаалагчдын оролцоонд сэтгэл хангалуун бус байгааг илтгэж байна.

Цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд үзүүлж буй дэмжлэг, хамтын ажиллагааг багшаар үнэлүүлэхэд ерөнхийдөө сайн гэж үнэлжээ. Ялангуяа, секц, заах аргын нэгдлүүд (ЗАН) -ийн дэмжлэг, хамтын ажиллагааг сайн үзүүлдэг гэж судалгаанд оролцсон багш нарын 50 орчим хувь нь хариулжээ. Мөн сургуулийн захирал болон сургалтын менежерүүдийн

дэмжлэгт сэтгэл хангалуун байгаа нь судалгаанд хамрагдсан ахлах ангийн багш нарын хариултаас харагдаж байна.

Аймаг, нийслэлийн боловсролын газар зэрэг шат шатны холбогдох байгууллагууд, эцэг эх, асран хамгаалагчид тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлж, хамтран ажилладаг гэсэн бөгөөд боловсролын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагууд (ТББ)-ын тусламж, дэмжлэг, хамтын ажиллагааг дунд болон сайн гэж үнэлсэн багш нарын хувь өндөр байна.

*Хичээлийн төлөвлөлт ахлах ангийн түвшинд ихэвчлэн агуулга, үүнд дотор бүлэг сэдэв буюу нэгж хичээлийн сэдэв, цагийн хуваарилалтыг голчлон тусгаж, харин зорилго зорилт мөн үнэлгээний жишиг даалгаварыг тэр бүр тусгахгүй байна. Бага, дунды түвшинд төлөвлөлтөд гарч байсан дүр зураг ахлах ангийн түвшинд мөн ижил дүр зурагтай, өөрөөр хэлбэр жилийн болон нэгжийн төлөвлөлтийг боловсруулсан хэдий ч ээлжит хичээлийг төлөвлөөгүй тохиолдол цөөнгүй байсан. Нэгж хичээлийн төлөвлөлтийг жилийн төлөвлөлттэй харьцуулахад зорилго, зорилт, агуулгын залгамж холбоо, агуулга, орчин хэрэглэгдэхүүн, үнэлгээг илүү тодорхой тусгасан байна. Хичээлийг төлөвлөхдөө ахлах ангийн багш нарын 80 хувь нь тухайн судалгдахууны сурах бичгийг ашиглаж байна. Хичээлийг төлөвлөхөд багш нар сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэхэд санхүүгийн дэмжлэг дутдаг байдал нь бэрхшээл үүсгэж байна.*

*Бага болон дунд ангитай харьцуулахад ахлах ангийн сургалтад үзүүлэн, таниулах матиериал болон туршилтын багаж хэрэгслийг илүү ашиглаж байна. Ээлжит хичээл дээр сурагчдаар эргэцүүлэн бодох үйлийг бага болон дунд ангитай харьцуулахад илүү хийлгэж байна.*

*Хичээлийг багаар болон хосоор зохион байгуулахад сургалтын хэрэглэгдэхүүний ашиглалт, сурагчид учир шалтгааныг олох эрэл хайгуул хийх, багш сурагчдын асуулт, хариултыг анхааралтай сонсож, дэмжих , сурагчид бие биеэ үнэлэх, оюуны зураглал хамтран хийх гэх мэт идэвхтэй үйлүүдийг анги нийтээр зохион байгуулсан хичээлтэй харьцуулахад илүү хийлгэж байна.*

*Ээлжит хичээлээр сурагчдын ялгаатай байдлыг харгалзан даалгавар дасгал ажиллуулах нь сул байна.*

*Ахлах ангийн сурагчид монгол хэл, математик, англи хэл, нийгмийн хичээлийг ихэвчлэн сонгохдоо мэргэжил сонголт, ЭЕШ-тай холбоотой байхаас гадна эцэг эхчүүдийн оролцоо голлох үүрэгтэй байна. Газар зүй, орос хэл, түүх зэрэг хичээлийг цөөн сурагч сонгож байна. Хичээл сонгоход сурагчид бэлэн биш байх, цөөн хүүхэд сонгосон тохиолдолд тухайн сурагч сонгосон хичээлээ судлах боломжгүй болох, анги танхимын хүрэлцээгүй байдал нь хичээлийн нэг өдрийн ачааллад хүндрэл үүсэх, багш болон хүүхдийн тоо цөөн сургуульд сонголтийг хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй байна.*

*Бага, дунд ангитай харьцуулахад сурах бичигтэй сурагчдын тоо цөөн байна. Ойролцоогоор 50 хувь нь сурах бичигтэй бөгөөд сурах бичгийг худалдан авах нь сумын сургуулийн сурагчдынх аймаг, нийслэлтэй харьцуулахад цөөн буюу 29.9 хувь байна.*

*Сурах бичгийг ашиглан дасгал даалгавар ажиллах, сорил туршилт хийх нь бага болон дунд ангитай харьцуулахад буурсан нь анхаарал татав. Англи хэлний хичээлээр бусад хичээлтэй харьцуулахад дасгал даалгавар дээр илүү ажилладаг, үндэсний бичиг болон*

*түүхийн хичээлээр хуулж бичүүлэх үйл бусад хичээлтэй харьцуулахад илүү хийлгэдэг, байгалийн ухааны хичээлүүдээр сорил туршилт хийлгэх нь 20 гаран хувьтай байна. Биологийн хичээлийн хувьд сурах бичгийн зургийг сурагчид ашиглах нь бусад хичээлтэй харьцуулахад илүү байна.*

*Ахлах ангийн багш нарын олонх нь сургалтын хөтөлбөртэй сурах бичиг уялдсан гэж үзэж байна.*

*Ахлах ангид бага, дунд ангитай харьцуулахад сурагчийн өөрийн үнэлгээ болон харилцан биенийг нь үнэлүүлэх үйл илүү хийгдэж байна. Сурагчдын 60 хувь нь үнэлгээг шудрага гэж үзсэн.*

*Ахлах ангийн түвшинд багш эцэг эхчүүдийн хамтын ажиллагаа дунд ангитай харьцуулахад нэмэгдсэн байна. Аймаг нийслэлийн боловсролын газар болон шат шатны холбогдох байгууллагууд төрийн бус байгууллагууд хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэн сургууль, багштай хамтран ажиллаж байна. Энэ нь бага болон дунд ангитай харьцуулахад илүү байна.*

## Математикийн сорилын гүйцэтгэлийн шинжилгээ

Бүрэн дунд боловсролын 11 дүгээр ангийн математикийн сорилын даалгавар нь мэдлэг ойлголт, мэдлэгээ хэрэглэх, асуудал шийдвэрлэх чадвар, шинжлэх ухаанч арга барилыг үнэлэх 10 даалгавартай, сорилын нийт оноо 30 байна. А хэсэгт мэдлэг, ойлголтыг илрүүлэх 5 даалгавар, Б хэсэгт хэрэглээ, асуудал шийдвэрлэх чадварыг илрүүлэх 5 даалгаврыг боловсруулсан байна.

Сорилын судалгааг хичээлийн жилийн 2 дугаар улиралд хийсэн тул:

- БДБ – ын математикийн цөм хөтөлбөрийн 10-11 дүгээр ангийн агуулгын хүрээнд давтагдан өргөсөж, гүнзгийрсэн суралцахуйн зорилтуудыг үнэлэх;
- 11 дүгээр ангийн 1 дүгээр улиралд судалсан болон 10 дугаар ангид судалсан агуулгыг хамруулах;
- Математикийн цөм хөтөлбөрийн зорилготой уялдсан шинжлэх ухаанч арга барил, асуудал шийдвэрлэх чадварыг илрүүлэхэд чиглэсэн болно.

*Хүснэгт 114. Сорилын даалгаврын жин (Математик, 11 дүгээр анги)*

| *Даалгаврын түвшин* | *Даалгаврын дугаар* | *Онооны хуваарилалт* | *Үнэлгээний жин* |
|---|---|---|---|
| Мэдлэг, ойлголт | А-1, 2, 3, 4, 5 | 6 | 20 хувь |
| Мэдлэгээ хэрэглэх чадвар | Б-1, 2, 5 | 16 | 53.3 хувь |
| Шинжлэх ухаанч арга барил, асуудал шийдвэрлэх чадвар | Б-3, 4 | 8 | 26.7 хувь |
| Нийт | 10 даалгавар | 30 оноо | 100 хувь |

*Зураг 103. Сорилын даалгаврын гүйцэтгэл (Математик, 11 дүгээр анги)*




Бүрэн дунд боловсролын математикийн сорилын гүйцэтгэл нь хэвийн тархалтаас бага зэрэг зүүн тийш хазайсан байна.

Сорилд хамрагдсан сурагчдын 74.7 хувь нь нийт сорилын 10-аас 40 хүртэлх хувийг зөв гүйцэтгэсэн байна. Харин гүйцэтгэлийн арифметик дундаж 23.5 хувь, медиан 20 хувь, моод 13.3 хувь, хамгийн өндөр гүйцэтгэл 90 хувь, хамгийн бага гүйцэтгэл 0 хувь байна.

*Хүснэгт 115. Гүйцэтгэлийн статистик үзүүлэлтүүд (Математик, 11 дүгээр анги)*

| Mean | Median | Mode | Minimum | Maximum |
|---|---|---|---|---|
| **23.5** | 20.0 | 13.3 | 0.0 | 90.0 |

Даалгавруудын найдвартай байдал сайн байна.

*Хүснэгт 116. Даалгавруудын найдвартай байдал (Математик, 11 дүгээр анги)*

| Reliability Statistics | |
|---|---|
| Cronbach's Alpha | N of Items |
| .829 | 22 |

Математикийн сорилын нийт 10 даалгавар тус бүрийн хариултыг сорилын нийт оноотой харьцуулахад эерэг хамааралтай байна.

*Хүснэгт 117. Сорилын даалгаврын хамаарал (Математик, 11 дүгээр анги)*

| № | Даалгаврын зорилго | Mean | Maximum | Correlation | Percent |
|---|---|---|---|---|---|
| Д:1 | Шугаман тэгшитгэлийн систем бодох | 0.604 | 1.0 | .479** | 60.4 |
| Д:2 | Дарааллын гишүүнийг олох | 0.900 | 1.0 | .219** | 90.0 |
| Д:3 | Тойрогт багтсан өнцгийн хэмжээг олох | 0.522 | 1.0 | .450** | 52.2 |
| Д:4 | Тригонометр функцийн утгыг олох | 0.262 | 1.0 | .355** | 26.2 |
| Д:5 | Рационал тэгшитгэл бодох | 0.948 | 2.0 | .565** | 47.4 |
| ЗД:1а | $f(x) \geq 0$ тэнцэтгэл биш бодох | 0.067 | 1.0 | .570** | 6.7 |
| ЗД:1б | $f(x) < 0$ тэнцэтгэл биш бодох | 0.078 | 1.0 | .618** | 7.8 |
| ЗД:1в | $Ox$ –тэнхлэгийг огтлох цэгийн координатыг олох | 0.558 | 2.0 | .711** | 27.9 |
| ЗД:1г | $Oy$ –тэнхлэгийг огтлох цэгийн координатыг олох | 0.390 | 1.0 | .628** | 39.0 |
| ЗД:1д | $f(x)$ функцийн томьёог бичих | 0.084 | 2.0 | .616** | 4.2 |
| ЗД:1е | Өгсөн цэг дээрх функцийн утгыг олох | 0.052 | 1.0 | .570** | 5.2 |
| ЗД:2а | Хэрчмийн дундаж цэгийн коодинатыг олох | 0.392 | 1.0 | .576** | 39.2 |
| ЗД:2б | Хэрчмийн уртыг олох | 0.115 | 1.0 | .484** | 11.5 |
| ЗД:2в | Шулууны тэгшитгэл бичих | 0.056 | 2.0 | .523** | 2.8 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| ЗД:2г | Өгсөн шулуунтай параллель шулууны тэгшитгэл бичих | 0.043 | 2.0 | .492** | 2.2 |
| ЗД:3 | Асуудал шийдвэрлэх | 0.180 | 2.0 | .555** | 9.0 |
| ЗД:4а | Давтамжийн хүснэгт нөхөх | 0.747 | 1.0 | .376** | 74.7 |
| ЗД:4б | Моод бүлгийг олох | 0.292 | 1.0 | .372** | 29.2 |
| ЗД:4в | Давтамжийн хүснэгт ашиглан арифметик дундаж олох | 0.022 | 2.0 | .202** | 1.1 |
| ЗД:4г | Медианы орших завсрыг олох | 0.260 | 1.0 | .375** | 26.0 |
| ЗД:5а | Тэгш хэмээр хувиргах | 0.372 | 1.0 | .520** | 37.2 |
| ЗД:5б | Параллель зөөлтөөр хувиргах | 0.104 | 1.0 | .551** | 10.4 |

*Мэдлэг, ойлголтыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Бүрэн дунд боловсролын математикийн сорилын А хэсгийн сонгох хариулттай 5 даалгаврын 4 дүгээр даалгавраас бусад даалгаврын гүйцэтгэл 47.4 – 90 хүртэл хувьтай байна.

*Хүснэгт 118. Сонгох хариултат 4 дүгээр даалгаврын гүйцэтгэл (Математик, 11 дүгээр анги)*

| № | Даалгаврын зорилго | Хариултын хувь | | | | | | Хүнд, хөнгөний зэрэг | Ялгах чадвар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | А | Б | В | Г | Хүчингүй | Хоосон | | |
| Д:4 | Тригонометр функцийн утгыг олох | 6.9 | 26.2 | 14.3 | 9.5 | 0 | 43.1 | Хүнд | Маш сул |

Хүснэгтээс харахад 4 дүгээр даалгаврын тухайд зөв хариултын хувь (26.2) дунджаас доогуур, хариулаагүй хоосон орхисон сурагчдын эзлэх хувь (43.1) өндөр, буруу хариултын нийт хувь (30.7), хүнд түвшинтэй, ялгах чадвар маш сул байна. Агуулгыг үзэхэд энэ нь 10, 11 дүгээр ангид давтагдаж орсон тригонометрийн чадвар байгаа нь анхаарал татаж байна. Иймд энэ даалгаврыг багшийн заах арга зүй, бусад хүчин зүйлтэй холбож нарийвчлан судлах шаардлагатай.

Буруу хариултыг шинжилж үзэхэд А хариултыг сонгосон сурагчид функцийн утгыг зөв олсон боловч, өгсөн өнцөг дэх тригонометр функцийн тэмдгийг олоход алдсан байна. Харин В ба Г хариултыг сонгосон сурагчдын хувьд энэ талын мэдлэг ойлголт байхгүй тул тааж хариулсан байх магадлалтай байна.

*Задгай хариултат даалгаврын шинжилгээ*

Б хэсгийн задгай хариулттай 1-ээс 5 хүртэлх даалгавруудын гүйцэтгэлийг харахад функцийн график ашиглан $Oy$ –тэнхлэгийг огтлох цэгийн координатыг олох (39.0 хувь), хэрчмийн дундаж цэгийн коодинатыг олох (39.2 хувь), давтамжийн хүснэгт нөхөх (74.7 хувь), тэгш хэмээр хувиргах (37.2 хувь) даалгаврын гүйцэтгэл дундаж, бусад даалгавруудын гүйцэтгэл дунджаас доош түвшинд байна

*Хүснэгт 119. Задгай хариултат даалгаврын статистик үзүүлэлт (Математик, 11 дүгээр анги)*

| Mean | Std. Deviation | Minimum | Maximum | Median |
|---|---|---|---|---|
| 3.8 | 3.7 | 0.0 | 21.0 | 3.0 |

Б хэсгийн задгай хариулттай даалгаврын нийт оноо 24 бөгөөд сорилд хамрагдсан сурагчдын онооны арифметик дундаж 3.8, медиан 3.0, хамгийн өндөр оноо 21, хамгийн бага оноо 0, стандарт хазайлт нь 3.7 байна.

*Сурах арга барил, асуудал шийдвэрлэх чадварыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Математикийн цөм хөтөлбөрт геометрийн агуулгын эзлэх хувь нэмэгдэж, статистикийн агуулга шинэчлэгдэж, олон улсын жишигт ойртсон. Иймд математикийн цөм хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх зорилгоор Б хэсгийн задгай хариултат 3 дугаар даалгавар (асуудал шийдвэрлэх чадварыг илрүүлэх), 4 дүгээр даалгавар (статистикийн арга, техникийг илрүүлэх)-ыг оруулсан болно. Эдгээр даалгаврын хариултыг шинжилж үзье.

*3 дугаар даалгаврын шинжилгээ*

Энэ нь 11 дүгээр ангийн сурах бичигт тусгасан даалгавар бөгөөд сорилд хамрагдсан сурагчдын гүйцэтгэл 9.0 хувьтай байгаа нь дунджаас доош түвшинд байна. Пифагорын теорем ашиглан $x$ −ийн утгыг зөв олсон сурагчид 12.8 хувь байсан боловч $y$ −ийн утгыг олохдоо Пифагорын теорем, төсөөгийн харьцаа бичээд, тооцоолол хийх явцад алдаа гаргасан байна. Иймд энэ бодлогыг гүйцэд бодсон буюу 3 оноо авсан сурагч байхгүй байна.

*4 дүгээр даалгаврын шинжилгээ*

Энэ нь өмнөх ангиудад үзэж судалсан статистикийн суурь мэдлэг, чадвараа хэрэглэн гүйцэтгэх даалгавар бөгөөд хүснэгтийг нөхөх загвар байсан тул сурагчид шууд дууриаж хийх боломжтой байсан, иймд 4а – хариултын хувь (74.7 хувь) өндөр гарсан байна. Харин моод бүлгийг олох (29.2 хувь), давтамжийн хүснэгт ашиглан арифметик дунджийг олох (1.1 хувь), медианы орших завсрыг олох (26.0 хувь) чадварууд маш хангалтгүй байна. Эндээс ахлах ангид статистикийн агуулга заагдахгүй орхигдоод байна уу, эсвэл бусад хүчин зүйл нөлөөлөөд байна уу гэдгийг нарийвчлан шинжлэх хэрэгцээ гарч байна.

Бүрэн дунд боловсролын математикийн сорилын судалгааны үр дүнгээс харахад:

- Сорилын судалгаанд хамрагдсан сурагчдын сонгох хариултат даалгаврын гүйцэтгэл 47.4 – 90 хүртэл хувьтай байна. Харин тригонометр функцийн утгыг олох 4 дүгээр даалгаврын гүйцэтгэл хангалтгүй байна.
- Сурагчдын задгай хариултат даалгавруудын гүйцэтгэл маш хангалтгүй байна. Даалгавар тус бүрээр авах максимум оноог цөөхөн сурагчид авсан байгаа нь сургууль, сурагчдын түвшин харилцан адилгүй байгааг харуулж байна. Задгай хариултат 1, 2, 5 дугаар даалгаврын гүйцэтгэлээс харахад сорилд хамрагдсан ихэнх сурагчдын мэдлэгээ хэрэглэх чадвар хангалтгүй байгааг харуулж байна.
- Бүрэн дунд боловсролын математикийн цөм хөтөлбөрт статистик болон геометрийн агуулгын эзлэх хувь нэмэгдэж, арга зүйн өөрчлөлт орсонтой холбоотойгоор статистикийн арга, техникийг 4 дүгээр даалгавраар (5 оноотой) илрүүлэхийг зорьсон боловч сорилд хамрагдсан сурагчдын статистикийн тооцоолол хийх арга, техник хангалтггүй, давтамжийн хүснэгт ашиглан арифметик дундаж олох чадвар маш сул байлаа. Мөн геометрийн асуудал шийдвэрлэх чадварыг 3 дугаар даалгавраар (математик XI, сурах бичгийн 10 дугаар нүүр, 38 дугаар бодлого) илрүүлэхийг зорьсон боловч сурагчдын танил бус нөхцөлд мэдлэгээ хэрэглэх буюу асуудал шийдвэрлэх чадвар хангалтгүй байна.

# Мэдээллийн технологийн сорилын гүйцэтгэлийн шинжилгээ

Бүрэн дунд боловсролын мэдээллийн технологи хичээлийн сургалтын цөм хөтөлбөрийн зорилго нь сурагч мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ), компьютерийн шинжлэх ухааны хөгжил, түүний хэрэглээг шинжлэх ухаанчаар судлах арга барилтай, мэдээллийн нийгмийн үнэт зүйлсийг эрхэмлэн хэрэгжүүлдэг, хариуцлагатай, бүтээлч, бие дааж шийдвэр гаргах чадвартай иргэн болж төлөвшинө гэсэн байдаг.

Бүрэн дунд боловсролын 11 дүгээр ангийн мэдээллийн технологийн сорилын даалгавар нь мэдлэг, ойлголт, мэдлэгээ хэрэглэх чадварыг үнэлэх 5 даалгавартай.

*Хүснэгт 120. Сорилын даалгаврын жин (Мэдээллийн технологи, 11 дүгээр анги)*

| *Агуулга* | *Даалгаврын эзлэх хувь* | *Онооны эзлэх хувь* | *Гүйцэтгэлийн дундаж* |
|---|---|---|---|
| Мэдлэг, ойлголт | 80 | 40 | 27.7 |
| Мэдлэгээ хэрэглэх чадвар | 20 | 60 | 22.4 |

*Мэдлэг, ойлголтыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Даалгавар 1.

*Даалгаврын зорилго:* Үйлдлийн дараалал, алгоритмыг таньж мэдэх

Сургалтын цөм хөтөлбөрт мэдээлэл харилцаа холбооны технологи бүлэг сэдвийн хүрээнд оролт, гаралт, мэдээллийг боловсруулах төхөөрөмж болон программмчлалын ойлголттой болохоор байдаг. Энэхүү даалгавраар компьютер нь тодорхой зааварчилгааны дагуу ажилладаг болохыг ойлгож мэдсэнийг илрүүлэх зорилготой.

*Хүснэгт 121. Сорилын 1 дүгээр даалгаврын гүйцэтгэл (Мэдээллийн технологи, 11 дүгээр анги)*

| *Хариултын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэлийн хувь* | *Зөв хариулт* |
|---|---|---|---|
| 1 | А. функц | 30.5 | |
| 2 | Б. заавар | 35.7 | + |
| 3 | В. түлхүүр үг | 3.9 | |
| 4 | Г. зарчим | 29 | |
| 5 | Огт хариулаагүй | 0 | |
| 6 | Хариулт хүчингүй | 0.9 | |

Судалгаанд оролцсон сурагчдын 35.7 хувь нь зөв хариулт сонгосон бол 64.3 хувь нь буруу хариултыг сонгосон байна. Энэхүү компьютерийн ерөнхий ажиллах зарчмын талаар дийлэнх сурагчид ойлголтын зөрөөтэй байгааг харуулж байна.

Даалгавар 2.

*Даалгаврын зорилго:* Санах ойг таньж мэдэх мэдээлэл харилцаа холбооны технологи бүлэг сэдвийн хүрээнд мэдээллийг хэмжих нэгж болон санах ой, санах ойд мэдээлэл хэрхэн байршдаг талаар 7 дугаар ангиас залгамж холбоотойгоор мэдлэг, ойлголт өгдөг ба энэхүү даалгавраар санах ойг хэрхэн ангилдаг талаарх ойлголтыг илрүүлэх зорилготой.

*Хүснэгт 122. Сорилын 2 дугаар даалгаврын гүйцэтгэл (Мэдээллийн технологи, 11 дүгээр анги)*

| *Хариултын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэлийн хувь* | *Зөв хариулт* |
|---|---|---|---|
| 1 | А.4 | 9.1 | |
| 2 | Б. 3 | 34.8 | |
| 3 | В. 5 | 3.9 | |
| 4 | Г. 2 | 49.8 | + |
| 5 | Огт хариулаагүй | 0 | |
| 6 | Хариулт хүчингүй | 2.4 | |

Судалгаанд оролцсон сурагчдын 49.8 хувь нь зөв хариулт сонгосон бол 50.2 хувь нь буруу хариултыг сонгосон байна. Энэ нь сурагчид сургалтын цөм хөтөлбөрт тусгагдсан мэдээлэл харилцаа холбооны технологи бүлэг сэдвийн хүрээн дэх мэдлэг ойлголт тааруу байгааг харуулж байна.

Даалгавар 3.

*Даалгаврын зорилго:* Сургалтын цөм хөтөлбөрт 6 дугаар ангиас компьютерийн үндсэн иж бүрдлийг таних, нэрлэх, үүрэг зориулалтыг мэдэх агуулга залгамж холбоотойгоор туссан байдаг ба энэхүү даалгавраар комьпютерийн оролтын төхөөрөмжүүдийг таньж мэдэх суурь мэдлэгийн түвшинг тодорхойлох зорилготой.

*Хүснэгт 123. Сорилын 3 дугаар даалгаврын гүйцэтгэл (Мэдээллийн технологи, 11 дүгээр анги)*

| *Хариултын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэлийн хувь* | *Зөв хариулт* |
|---|---|---|---|
| 1 | А. холболт | 61.3 | |
| 2 | Б. хадгалалт | 15.4 | |
| 3 | В. оролт | 18.8 | + |
| 4 | Г. гаралт | 3.2 | |
| 5 | Огт хариулаагүй | 0.2 | |
| 6 | Хариулт хүчингүй | 1.1 | |

Судалгаанд оролцсон сурагчдын 18.8 хувь нь зөв хариулт сонгосон бол дийлэнх нь буюу 81.2 хувь нь буруу хариултыг сонгосон нь сурагчид оролт, гаралтын төхөөрөмжүүдээ төдийлөн ялгаж чадахгүй байгааг харуулж байна.

Даалгавар 4.

*Даалгаврын зорилго:* Мэдээлэл хадгалах, зөөх төхөөрөмжүүдийг таньж мэдэх

Сургалтын цөм хөтөлбөрт 7 дугаар ангиас залгамж холбоотойгоор компьютерийн үндсэн иж бүрдлийг таних, нэрлэх, үүрэг зориулалтыг мэдэх агуулга багтдаг ба энэхүү даалгавар нь сургалтын цөм хөтөлбөрт тусгагдсан мэдээлэл харилцаа холбооны технологи бүлэг сэдвийн суурь мэдлэгийн түвшинг тодорхойлох зорилготой.

Сорилд хамрагдсан сурагчдын 93.5 хувь нь буруу хариулсан нь даалгаврын тавил хоёрдмол утгатай, сурагчдыг төөрөгдөлд оруулсан байх магадлалтай байна. Өөрөөр хэлбэл: Даалгавар нь CD – R болон CD – RW тэмдэглэгээ юуг илэрхийлдэг болохыг тайлбарлаад, дискний хэмжээг бичих гэсэн хоёрдмол утгыг агуулсан байна.

*Мэдлэгээ хэрэглэх чадварыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Мэдлэгээ хэрэглэх чадварыг илрүүлэх даалгаврыг богино хариултат байхаар боловсруулсан.

Даалгавар 5.

*Даалгаврын зорилго:* Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хэрэглээний түвшинг илрүүлэх

Сургалтын цөм хөтөлбөрт 6 дугаар ангиас залгамж холбоотойгоор нийт судалсан агуулга нь сурагчдын мэдээлэл, харилцаа холбооны технологийн чадвартай уялдаж байдаг ба мэдлэг хэрэглэх чадварыг илрүүлэх энэхүү даалгаврууд нь сургалтын цөм хөтөлбөрт тусгагдсан мэдээлэл, харилцаа холбооны технологи бүлэг сэдвийн суурь мэдлэгийн түвшинг тодорхойлох зорилготой.

А. Эдгээр программ хангамжууд нь компьютерийн системийн бүрдлүүд болох процессор, шуурхай санах ой, оролт-гаралтын төхөөрөмж, сүлжээний болон бусад хэрэгслүүдийг удирдан зохицуулдаг. Хэрэглээний программм хангамжтай харьцуулахад практик тодорхой ажил үйлдлийг хийхэд бус харин бусад программуудыг ажиллахад техник хангамжийн боломж, нөөцүүдийг удирдан зохицуулах үйлчилгээ үзүүлдэг. Мөн компьютерийн ажиллагааг шалгах, оношлох, дискийг хуулах, форматлах, файл сэргээх, файлын нөөц хадгалах, вирусээс хамгаалах, өгөгдлийг шахах зэрэг олон тооны үйлчилгээний программууд багтдаг. гэсэн мэдээллийг уншиж, дээрх мэдээлэлд ямар программм хангамжийн талаар авч үзсэн болохыг тайлбарлах даалгаврыг нийт сурагчдын 10.2 хувь хариулсан байгаа нь системийн программ хангамжийн талаар мэдлэгээ хэрэглэх чадвар сул байгааг харуулж байна.

Б. Уг программ хангамжийн бүрдэл болсон үйлдлийн системүүдээс нэрлэx даалгаварт 3.9 хувь нь үйдлийн системээс нэрлэж чадаж байгаа бол дийлэнх буюу нийт сурагчдын 96.1 хувь нь ямар нэг үйлдлийн системийг нэрлэж чадаагүй байна.

В. Үйлчилгээний программ хангамж, түүний үүргийг зөв харгалзуулах даалгаврын хувьд нийт сурагчдын 56.1 хувь нь 3 сонголтыг зөв сонгосон бол 33.5 хувь нь зөвхөн 1 асуултыг зөв харгалзуулсан байна. Харин нийт сурагчдын 10.4 хувь бүх сонголтыг буруу хариулсан байна.

Г. Файл шахах үйлдлийн үр дүнд дүн шинжилгээ хийх даалгаварт 19.3 хувь нь файлыг шахсанаар хэмжээ нь багасч байгааг анзаарсан бол дийлэнх сурагчдын буюу 80.7 хувь нь файлыг шахахад хэмжээ багасаж байгааг хариулж чадаагүй байна.

Бүрэн дунд боловсролын мэдээллийн технологийн сорилд оролцсон нийт сурагчдын мэдлэгээ хэрэглэх чадварыг илрүүлэх даалгаврын гүйцэтгэл 39.2 хувь байгаа нь мэдээлэл, харилцаа холбооны технологийн хэрэглээний түвшин сул байгааг харуулж байна.

*Зураг 104. Сорилын даалгаврын гүйцэтгэл (Мэдээллийн технологи, 11 дүгээр анги)*




Бүрэн дунд боловсролын мэдээллийн технологийн сорилын судалгаанд хамрагдсан сурагчдын даалгаврын нийт гүйцэтгэлийг тархалтын муруйгаас харвал хэвийн тархалттай байна.

Бүрэн дунд боловсролын мэдээллийн технологийн сорилын гүйцэтгэлийн үр дүнгээс харахад:

- Бүрэн дунд боловсролын түвшинд судалгаанд хамрагдсан сурагчдын хувьд мэдлэг ойлголтын даалгаврын гүйцэтгэлийн дундаж 27.7 хувь, мэдлэгээ хэрэглэх чадварын гүйцэтгэлийн дундаж 22.4 хувь байна. Энэ нь багшийн заах арга зүйг сайжруулах, тэдэнд арга зүйн дэмжлэг үзүүлэх шаардлагатай байгааг харуулж байна

# Монгол хэлний сорилын гүйцэтгэлийн шинжилгээ

Бүрэн дунд боловсролын 11 дугаар ангийн монгол хэлний сорилын даалгавар нь мэдлэг, ойлголт, чадвар, мэдээлэлтэй ажиллах арга барилыг үнэлэх А, Б хэсгээс бүрдсэн нийт 10 даалгавартай. Тухайн ангийн сурагчдын нэгдүгээр улиралд судалсан агуулгын хүрээнд унших, бичих, бүтээх чадварыг илрүүлэх зорилготой юм.

Мөн мэдлэгээ хэрэглэх чадвар, мэдээлэлтэй ажиллах арга барил эзэмшилтийг үнэлэх даалгаврын эзлэх хувь өндөр байх зорилго тавьсан.

*Хүснэгт 124. Сорилын даалгаврын жин (Монгол хэл, 11 дүгээр анги)*

| *Агуулга* | *Даалгаврын эзлэх хувь* | *Онооны эзлэх хувь* | *Гүйцэтгэлийн дундаж* |
|---|---|---|---|
| Мэдлэг, ойлголт | 30 | 17 | 43.2 |
| Мэдлэгээ хэрэглэх чадвар | 20 | 33 | 40.3 |
| Мэдээлэлтэй ажиллах арга барил | 50 | 50 | 69.3 |

*Зураг 105. Сорилын даалгаврын гүйцэтгэл (Монгол хэл, 11 дүгээр анги)*




Бүрэн дунд боловсролын монгол хэлний сорилын гүйцэтгэл нь хэвийн тархалтаас баруун тийш хазайсан байна.

*Хүснэгт 125. Сонсох, унших, бичих чадварын даалгаврын гүйцэтгэл (Монгол хэл, 11 дүгээр анги)*

| *Үнэлгээний зорилт* | *Гүйцэтгэлийн дундаж* | | | | | | | | | *Нийт дундаж* |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | *Д:1* | *Д:2* | *Д:3* | *Д:4* | *Д:5* | *Д:6* | *Д:7* | *Д:8* | *Д:9* | |
| Сонсох, унших чадварыг илрүүлэх | 30.1 | 70.8 | 22.9 | 49.1 | 43.5 | | | | | 43.3 |
| Бичих, хэл зүйн мэдлэг ойлголтыг илрүүлэх даалгавар | | | | | | 41.7 | 62.5 | 33.5 | 23.4 | 40.3 |
| Зохиогчийн үзэл бодол, дүгнэлт, баталгаа нотолгоонд дүн шинжилгээ хийх, харьцуулах | Д:10а | Д:10б | Д:10в | Д:10г | Д:10д | Д:10е | Д:10ё | | | |
| Бүтээх, бичих чадварыг илрүүлэх даалгавар | 77.9 | 68.4 | 68.2 | 62.0 | 63.9 | 67.9 | 67.2 | | | 68 |

*Хүснэгт 126. Сорилын даалгаврын статистик үзүүлэлт буюу гүйцэтгэл*

Найдвартай байдал=.801

| *462* | *Mean* | *Std. Deviation* | *Correlate* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|---|---|
| Д:1 | 0.301 | 0.4591 | 0.017 | 30.1 |
| Д:2 | 0.708 | 0.4553 | .113* | 70.8 |
| Д:3 | 0.229 | 0.4209 | 0,067 | 22.9 |
| Д:4 | 0.491 | 0.5005 | .131** | 49.1 |
| Д:5 | 0.435 | 0.4963 | 0,06 | 43.5 |
| Д:6 | 1.251 | 1.0589 | .546** | 41.7 |
| Д:7 | 1.251 | 0.7665 | .495** | 62.5 |
| Д:8 | 1.006 | 0.9780 | .469** | 33.5 |
| Д:9 | 0.470 | 0.6734 | .340** | 23.4 |
| Д:10а | 2.338 | 0.9560 | .754** | 77.9 |
| Д:10б | 2.054 | 0.9654 | .786** | 68.4 |
| Д:10в | 1.366 | 0.7322 | .685** | 68.2 |
| Д:10г | 1.240 | 0.7428 | .738** | 62 |
| Д:10д | 1.279 | 0.7751 | .741** | 63.9 |
| Д:10е | 1.344 | 0.7990 | .774** | 67.9 |
| Д:10ё | 0.773 | 0.4195 | .746** | 67.2 |

*Сонсох, унших чадварыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Даалгаврын зорилго: Эхийн агуулгын бүтэц, цогцолборын дараалал, уялдаа холбоог үндэслэл ба нотолгоо, шалтгаан ба үр дагавар, харьцуулах ба эсрэгцүүлэх зэргээр холбосон арга хэрэглүүрийг харьцуулан судалж, дүгнэх

- Монгол хэлний сонгох 1, 2, 3, 4, 5 даалгавар 43.3 хувийн гүйцэтгэлтэй, 2 дугаар даалгавар болох үгийн утгыг зөв олох даалгаврыг нийт сурагчдын 70.8 хувь

гүйцэтгэсэн байна. Харин 3 дугаар даалгавар болох өгүүлбэр зүйн сонгох хариулттай даалгаврыг 22,9 хувь гүйцэтгэсэн нь өгүүлбэрийн гишүүдээр зурах, өгүүлбэрийн бүтэц дээр ажиллах чадвар тааруу байгааг харуулж байна.

*Бичих, хэл зүйн мэдлэг ойлголтыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Даалгаврын зорилго: Эхийн агуулгын бүтэц, цогцолборын дараалал, уялдаа холбоог үндэслэл ба нотолгоо, шалтгаан үр дагавар, харьцуулах ба эсрэгцүүлэх зэргээр найруулж бичих

- IX ангийн монгол хэлний бичих, хэл зүй мэдлэг ойлголтыг илрүүлэх 6, 7, 8, 9 даалгаварын гүйцэтгэл 40.3 хувь байгаагаас 9 даалгавар болох холбоо үгийг монгол бичгээр бичих даалгаврыг сурагчид 23.4 хувь гүйцэтгэсэн нь монгол бичгийн дүрэм, үг нүдлэн тогтоох чадвар хангалтгүй байгааг харуулж байна.
- Бичих, хэл зүйн даалгаврын нийтлэг алдаа нь сурагчид эхээ бүрэн гүйцэд ойлгож уншаагүй, эхийн зарим далд утга санааг буруу ойлгосноос оновчгүй тайлбар бичсэн алдаанууд ажиглагдаж байна.

*Зохиогчийн үзэл бодол, дүгнэлт, баталгаа нотолгоонд дүн шинжилгээ хийх даалгаврын шинжилгээ*

Даалгаврын зорилго: Эхийн найруулгын төрөл, бүтэц, хэв маягийн онцлогт тохируулан өгүүлбэр, үг, бүтээврийг сонгон найруулах

- Монгол хэлний 10 даалгавар болох эхийн үзэл бодол, дүгнэлт, баримт нотолгоонд дүн шинжилгээ хийж аян замын тэмдэглэл бичих даалгаврыг сурагчид 68 хувь гүйцэтгэсэн нь IX ангийн сурагчдын найруулан бичих чадвар сайн өөрийн үзэл бодлоо баримт нотолгоотой тайлбарлан бичих чадварыг эзэмшсэн боловч зөв бичих дүрэм, үг сонголтын алдаа ихээр гаргасан байна.

Бүрэн дунд боловсролын монгол хэлний сорилын гүйцэтгэлийн үр дүнгээс харахад:

- 11 дүгээр ангийн сорилын унших чадварын гүйцэтгэл 43.3 хувь бичих чадварын гүйцэтгэл 54.1 хувь, байгаа нь ойролцоо гүйцэтгэлтэй байна. Энэ нь сурагчдын мэдээлэлтэй ажиллах, мэдээлэлд боловсруулалт хийх арга барил дутмаг, үр дүнг бусдад танилцуулах чадварыг дэмжиж хөгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.
- Сурагчдын эхийн агуулгыг уншиж ойлгох, утга агуулгыг задлан шинжлэх чадвар сул байна. Сурагчид хэлэх санаагаа тодорхой, бүрэн гүйцэд, дэлгэрэнгүй тайлбар хийж чадаагүй байна.
- Цаашид сургууль, багш нар ээлжит хичээлийн төлөвлөлтөд эхийн бүтэц, хэв маяг дээр ажиллах дасгал даалгаврыг түлхүү тусган хэрэгжүүлэхэд анхаарах хэрэгтэй байна. Мөн сурагчдын бие даах судлах эхийн сонголтод дэмжлэг үзүүлэх шаардлага байгааг судалгааны үр дүн харуулж байна.

## Англи хэлний сорилын гүйцэтгэлийн шинжилгээ

Сургалтын цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтууд, үнэлгээний зорилт, шалгуур, жинг баримтлан уг сорилын даалгаврын үнэлгээний зорилтыг 2:5:3 харьцаатайгаар

тодорхойлж, тухайн ангийн нэгдүгээр улиралд судалсан агуулгын хүрээнд хэл зүйн хэрэглээ, унших, бичих чадварыг илрүүлэх зорилго тавьсан.

*Хүснэгт 127. Сорилын даалгаврын гүйцэтгэл (Англи хэл, 11 дүгээр анги)*

| *Үнэлгээний зорилт* | *Гүйцэтгэлийн хувь* | | | | | | | | | | *Гүйцэт-гэлийн дундаж* |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | *Д:1* | *Д:2* | *Д:3* | *Д:4* | *Д:5* | *Д:6* | *Д:7* | *Д:8* | *Д:9* | *Д:10* | |
| Хэл зүйн мэдлэг ойлголтыг илрүүлэх | 15.2 | 29.8 | | | | | | | | | 22.5 |
| Унших, ярих чадварыг илрүүлэх | | | 21.2 | 63.7 | 29.8 | 69.9 | 59.8 | | | | 48.9 |
| Бүтээх, бичих чадварыг илрүүлэх | | | | | | | | 55.9 | 29.1 | 39.9 | 41.7 |

*Зураг 106. Сорилын даалгаврын гүйцэтгэл (Англи хэл, 11 дүгээр анги)*




Бүрэн дунд боловсролын англи хэлний сорилын гүйцэтгэлийг тархалтын муруйгаас харвал баруун, зүүн тийш хазайсан байна.

Даалгаврын статистик үзүүлэлт болон гүйцэтгэлийн шинжилгээг хүснэгтээр харуулав.

*Хүснэгт 128. Сорилын даалгаврын статистик үзүүлэлт буюу гүйцэтгэл (Англи хэл, 11 дүгээр анги)*

| | *Хамаарал* | *Дундаж* | *Стандарт хазайлт* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|---|---|
| Д:1 | .494** | .152 | .3598 | 15.2 |
| Д:2 | .313** | .298 | .4579 | 29.8 |
| Д:3 | .211** | .425 | .8191 | 21.2 |
| Д:4 | .591** | 1.274 | .9627 | 63.7 |
| Д:5 | .533** | .596 | .9157 | 29.8 |
| Д:6 | .494** | .700 | .4589 | 69.9 |
| Д:7 | .346** | .598 | .4908 | 59.8 |
| Д:8 | .724** | 1.679 | 1.2678 | 55.9 |
| Д:9 | .800** | 1.164 | 1.5719 | 29.1 |
| Д:10 | .826** | 1.199 | 1.1596 | 39.9 |

Даалгаврын найдварт байдлын тохирц сайн. 10 даалгавар хоорондоо шууд, эерэг хамааралтай, 3 дугаар даалгавар их сул, 1, 2, 6, 7 дугаар даалгавар сул, 4, 5, 8, 9, 10 дугаар даалгавар хамаарал сайн байна.

*Хэл зүйн мэдлэг, ойлголтыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

*Хүснэгт 129. Хэл зүйн мэдлэг, ойлголтыг илрүүлэх даалгаврын гүйцэтгэл (Англи хэл, 11 дүгээр анги)*

| *Даалгавар* | *Даалгаврын зорилго* | *оноо* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|---|
| 1 | Судалж буй сэдвийн хүрээнд хэлзүйн дүрмийг үгийн сан, үгзүй, өгүүлбэрзүйн түвшинд зөв хэрэглэх чадвартай болох | 1 | 15.2 |
| | | 0 | 61.3 |
| | | Огт хариулаагүй | 27.7 |
| 2 | | 1 | 29.8 |
| | | 0 | 50.8 |
| | | Огт хариулаагүй | 27.7 |
| | Гүйцэтгэлийн дундаж хувь | | 22.5 |

Хэл зүйн мэдлэг ойлголтыг илрүүлэх зорилготой эдгээр даалгавруудын гүйцэтгэлийн дундаж 22.5 хувь, онооны тархалтын статистик үзүүлэлтээр стандарт хазайлт 0.35, хэм байгаагаас харахад ихэнх сурагчдын хэл зүйн мэдлэг ойлголт тааруу, тэр дундаа энгийн өгүүлбэрийг холбоос хэрэглэн нийлмэл өгүүлбэр болгох үг зүй, өгүүлбэр зүйн мэдлэг ойлголт хангалтгүй байна. Энэ нь сурагчдын унших (уншиж ойлгох) чадвар сул байгаатай холбоотой.

*Унших, ярих чадварыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Унших, ярих чадварыг 3, 4, 5, 6, 7 дугаар даалгаваруудаар илрүүлэхээр боловсруулсан.

*Даалгаврын зорилго*

- Унших даалгаврын зорилго (3, 4, 5 дугаар даалгавар): Судалж буй сэдвийн хүрээнд өгүүлбэр, харилцан яриа, эхийн гол, дагалдах, далд санааг ойлгох
- Ярих чадварыг илрүүлэх даалгавар (6, 7 дугаар даалгавар): Судалж буй сэдвийн хүрээнд өгүүлбэр, харилцан яриа, эхийн түвшинд албан ба албан бус найруулгын үг хэллэг ашиглан өөрийн үзэл бодлыг илэрхийлэх

Сорилын даалгавруудын хүнд хөнгөний зэрэг дундаж, ялгах чадвар дундаж байна. 3 дугаар даалгаврын зөв хариултын гүйцэтгэл 21.2 хувь, 5 дугаар даалгаврын зөв хариултын гүйцэтгэл 29.8 хувь гэсэн үзүүлэлттэй гарчээ. Эдгээр гүйцэтгэлийн хувь багатай даалгаврыг шинжилж үзвэл:

3 дугаар даалгаврын гүйцэтгэлийн хувь бага байгаа нь сурагчдын зорилготой уншихад анхаарлаа төвлөрүүлэх чадвар, эхийн гол ба дагалдах санааг ойлгох, ялган таних, хэрэгцээт мэдээллийг боловсруулах чадвар хангалтгүй байгааг харуулж байна. Нөгөө талаар даалгаврын A, B хариултад хоёуланд нь шинэ бүтээл (invention) гэсэн үг орсноос эхийн гол утга санааг ойлгоход хүндрэл үүссэн байж болзошгүй.

5 дугаар даалгаврын гүйцэтгэлийн хувь бага байгаа нь сурагчид эхийн дагалдах санааг ойлгох, эхийн доторх гол ба гол бус мэдээллийг ялгах чадвар сул байгааг нотолж байна.

Харин 6,7 дугаар даалгаврын гүйцэтгэлээс харахад харилцан яриа, эхийн түвшинд албан ба албан бус найруулгын үг хэллэг ашиглан өөрийн үзэл бодлыг илэрхийлэн ярих чадвар сайн (64.8 хувь) байна.

*Бичих чадварыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Даалгаврын зорилго: Судалж буй сэдвийн хүрээнд бичвэрийн зарим төрлөөр тодорхой тогтсон загвар ашиглан бодит ба бодит бус үйл явдлын талаар өөрийн санааг төлөвлөн бичиж сурах

*Хүснэгт 130. Сорилын 8 дугаар даалгаврын гүйцэтгэл (Англи хэл, 11 дүгээр анги)*

| *шалгуур* | *оноо* | *гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|
| Өөрт байгаа зуны хувцас, өвлийн хувцас, хүүхдийн хувцас гэсэн категориудад хувцасны нэрсийг жагсаан бичих | 3 | 28.2 |
| Хоёр ангилалд нь хувцасны нэрсийг жагсаан бичих | 2 | 14.5 |
| Нэг ангилалд нь нэрсийг жагсаан бичих | 1 | 7.7 |
| Бичих гэж оролдсон боловч хувцасны нэрсээс өөр зүйл бичих | 0 | 21.9 |
| Огт бичээгүй | | 27.7 |
| Гүйцэтгэлийн нийт дундаж | | 55.9 |

*Хүснэгт 131. Сорилын 9 дүгээр даалгаврын гүйцэтгэл (Англи хэл, 11 дүгээр анги)*

| шалгуур | оноо | гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|
| Өөрийн төсөөллөөр сайн дурын байгууллагад ажиллах бол хэл зүйн алдаагүй, утга санааг зөв илэрхийлэн (юу хийх, юу сурах, хэнтэй хамтарч ажиллах, хаана ажиллахаа) оновчтой үг хэллэгээр, эсвэл өгүүлбэрээр бичих | 4 | 12.9 |
| Өөрийн төсөөллөөр сайн дурын байгууллагад ажиллах бол хэл зүйн алдаагүй, утга санааг зөв илэрхийлэн /юу хийх, юу сурах, хэнтэй хамтарч ажиллах, хаана ажиллахаас 3-ыг нь оновчтой үг хэллэгээр, эсвэл өгүүлбэрээр бичих | 3 | 3.7 |
| Өөрийн төсөөллөөр сайн дурын байгууллагад ажиллах бол хэл зүйн алдаагүй, утга санааг зөв илэрхийлэн /юу хийх, юу сурах, хэнтэй хамтарч ажиллах, хаана ажиллахаас 2-ыг нь оновчтой үг хэллэгээр, эсвэл өгүүлбэрээр бичих | 2 | 7.8 |
| Өөрийн төсөөллөөр сайн дурын байгууллагад ажиллах бол хэл зүйн алдаагүй, утга санааг зөв илэрхийлэн /юу хийх, юу сурах, хэнтэй хамтарч ажиллах, хаана ажиллахаас 1-ийг нь оновчтой үг хэллэгээр, эсвэл өгүүлбэрээр бичих | 1 | 6.0 |
| Бичих гэж оролдсон боловч санаа бодлоо илэрхийлж чадаагүй, хэл зүйн алдаатай бол | 0 | 41.9 |
| Огт бичээгүй | | 27.7 |
| Гүйцэтгэлийн нийт дундаж | | 29.1 |

*Хүснэгт 132. Сорилын 10 дугаар даалгаврын гүйцэтгэл (Англи хэл, 11 дүгээр анги)*

| *шалгуур* | *оноо* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|
| Бишрэн хүндэтгэдэг хэн нэгэн хүний тухай 3 асуултад хариулан, хэлзүйн алдаагүй, санаагаа зөв илэрхийлэн бичих | 3 | 16.5 |
| Бишрэн хүндэтгэдэг хэн нэгэн хүний тухай 2 асуултад хариулан, хэлзүйн алдаагүй, санаагаа зөв илэрхийлэн бичих | 2 | 7.5 |
| Бишрэн хүндэтгэдэг хэн нэгэн хүний тухай 1 асуултад хариулан, хэлзүйн алдаагүй, санаагаа зөв илэрхийлэн бичих | 1 | 22.0 |
| Бичих гэж оролдсон боловч хэл зүйн алдаатай, санаагаа зөв илэрхийлж чадаагүй бол | 0 | 26.2 |
| Огт бичээгүй | | 27.7 |
| Гүйцэтгэлийн нийт дундаж | | 39.9 |

8, 9, 10 дугаар даалгавруудын гүйцэтгэлийн дунджаас харахад бичвэрийн зарим төрлөөр тодорхой тогтсон загвар ашиглан бодит ба бодит бус үйл явдлын талаар өөрийн санааг төлөвлөн бичих чадвар дундаж түвшинд байна. Энэ нь сурагчдын хэл зүйн мэдлэг ойлголт, үгийн нөөц хангалтгүй байгаатай холбоотой.

*Зураг 107. Унших, бичих чадварын гүйцэтгэлийн харьцуулалт (Англи хэл, 11 дүгээр анги)*




11 дүгээр ангийн сорилын унших чадварын гүйцэтгэл 38.2 хувь байгаа нь эхийн гол ба дагалдах санааг ялгах, өгүүлэгчийн санаа, хандлагыг ойлгох чадвар сул байгааг, бичих чадварын гүйцэтгэл 34.5 хувь байгаа нь бичих зүйлээ төлөвлөх, бодол санаагаа бичгээр илэрхийлэх, зохион бичих арга барил сайн биш, нэг талаас хэл зүйн мэдлэг ойлголт хангалтгүй, нөгөө талаас хичээл болон гэрийн даалгавар ихэвчлэн сурах бичгийн дасгал даалгавраар хязгаарлагддагтай холбоотой байна гэж үзэж байна. Сурах бичгийн дасгал даалгавраас зөвхөн нөхөх, гүйцээх, тохируулах гэх мэт цөөн тооны даалгаврыг ихэвчлэн гүйцэтгээд, ярих, унших, зохион бичих даалгаврыг гүйцэтгэхгүй байх хандлага ажиглагдаж байна. Үүнийг сурагч бие даан сурах арга барилыг сайн эзэмшээгүй, сурах үйлдээ бүтээлчээр ханддаггүйтэй холбон ойлгож болох юм. Тиймээс багш үүнд хичээл төлөвлөлт, арга зүйгээ чиглүүлэх шаардлагатай байна.

Бүрэн дунд боловсролын англи хэлний сорилын гүйцэтгэлийн үр дүнгээс харахад:

- Хэл зүйн мэдлэг ойлголт 22.5 хувь, унших чадвар 48.9 хувь, бичих чадвар 41.7 хувь байна. Энэ нь Европын холбооны олон хэлний суурь хөтөлбөрийн хэлний хүрээг баримжаалан бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн агуулга, гадаад хэлний мэдлэг, чадварын түвшинг )B1( тодорхойлж, суралцахуйн удирдамж, сурах бичгийн агуулга шинэчлэгдсэнтэй холбоотой. Тухайлбал, өгүүлбэр зүйн бүтэц, хэрэглээ, нийлмэл өгүүлбэрийн түвшинд хэл зүйн мэдлэгийг судлахаар цөм хөтөлбөрт тусган оруулсан. Мөн унших эхүүдэд шинэ, хүндэвтэр үг хэллэгүүд цөөнгүй орсон нь бий. Тиймээс ихэнх сурагчийн хэлний түвшин анхан шатны түвшнээс хэтрэхгүй байгаагаас шинэчилсэн агуулга, хэл зүйн /өгүүлбэр зүйн/ ойлголтыг судлах, сорилын даалгаврыг гүйцэтгэхэд хүндрэл гарсан нь ажиглагдаж байна.

## Биологийн сорилын гүйцэтгэлийн шинжилгээ

Суурь боловсролын 11 дүгээр ангийн биологийн сорилын даалгавар нь мэдлэг, чадвар, дадлага, туршилт гүйцэтгэх чадварыг илрүүлэх 5 даалгавартай.

*Хүснэгт 133. Сорилын даалгаврын жин (Биологи, 11 дүгээр анги)*

| *Агуулга* | *Даалгаврын эзлэх хувь* | *Онооны эзлэх хувь* | *Гүйцэтгэлийн дундаж* |
|---|---|---|---|
| Ойлгосон мэдлэгийг илрүүлэх | 20 | 25.0 | 48.3 |
| Мэдээлэл боловсруулах, асуудал шийдвэрлэх чадварыг илрүүлэх | 20 | 33.3 | 31.3 |
| Дадлага, туршилт гүйцэтгэх ур чадварыг илрүүлэх | 10 | 41.7 | 29.6 |

*Мэдлэг, ойлголтыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Даалгавар 1.

*Даалгаврын зорилго:* Амьд биед хэрэгцээтэй нүүрс усны химийн томьёог ялган таних. Энэ даалгавар нь амьд биед хэрэгцээтэй нүүрс, усны химийн томьёог ялган таньж чадаж буй эсэхийг илрүүлэх зорилготой.

11 дүгээр ангийн сургалтын цөм хөтөлбөрийн биологийн молекулууд бүлгийн агуулгаар мономер, полимер, макромолекул гэсэн нэр томьёонуудыг моносахарид, дисахарид, полисахаридын жишээгээр тайлбарлах суралцахуйн зорилтыг судална.

Даалгаврын хүндрэлийн зэрэг тохиромжтой, ялгах чадвар сайн байгааг Testan программ хэрэглэн даалгаварт хийсэн шинжилгээний үр дүн харуулж байна.

*Хүснэгт 134. Сорилын 1 дүгээр даалгаврын гүйцэтгэл (Биологи, 11 дүгээр анги)*

| *Хариултын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэлийн хувь* | *Зөв хариулт* |
|---|---|---|---|
| 1 | А. | 21.2 | |
| 2 | Б. | 10.4 | |
| 3 | В. | 65.4 | + |
| 4 | Г. | 1.7 | |
| 5 | Огт хариулаагүй | 0.6 | |
| 6 | Хариулт хүчингүй | 0.6 | |

Сурагчдын 65.4 хувь нь В буюу зөв хариултыг сонгосон байна. Харин 21.2 хувь нь А, 10.4 хувь нь Б буюу буруу хариултыг сонгосон байгаа нь сурагчдын химийн томьёог нүдлэх, молекул бүтцийг талаарх ойлголт дутмаг байгааг харуулж байна.

Даалгавар 2.

*Даалгаврын зорилго:* Амьд бие дэх триглицеридын биологийн үүргийг нэрлэх.

Энэ даалгавар нь амьд бие дэх тосны молекул болох триглицеридийн биологийн үүргийг мэдэж байгаа эсэхийг илрүүлэх зорилготой.11 дүгээр ангийн сургалтын цөм хөтөлбөрийн биологийн молекулууд бүлгийн агуулгаар триглицеридийн молекул бүтцийн тайлбарлаж, түүний амьд биед гүйцэтгэх үүргийг ойлгох гэсэн суралцахуйн зорилтыг судална.

Даалгаврын хүндрэлийн зэрэг хүнд, ялгах чадвар сул байгааг Testan программ хэрэглэн даалгаварт хийсэн шинжилгээний үр дүн харуулж байна.

*Хүснэгт 135. Сорилын 2 дугаар даалгаврын гүйцэтгэл (Биологи, 11 дүгээр анги)*

| *Хариултын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэлийн хувь* | *Зөв хариулт* |
|---|---|---|---|
| 1 | А. | 13.9 | |
| 2 | Б. | 32.9 | |
| 3 | В. | 34.4 | + |
| 4 | Г. | 15.2 | |
| 5 | Огт хариулаагүй | 0.2 | |
| 6 | Хариулт хүчингүй | 3.2 | |

Сурагчдын 34.4 хувь нь В буюу зөв хариултыг сонгосон байна. Харин 32.9 хувь нь Б, 13.9 хувь нь А буюу буруу хариултыг сонгосон байгаа нь амьд бие дэх биологийн молекулуудын гүйцэтгэх үүргийн талаарх ойлголт дутмаг байгааг харуулж байна. Харин 15.2 хувь нь Г буруу хариултыг сонгосон байгаа нь хариултын хувилбар сурагчдад эргэлзээ төрүүлсэн байх магадлалтай.

*Мэдээлэл боловсруулах, асуудал шийдвэрлэх чадварыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Даалгавар 3.

*Даалгаврын зорилго:* Уургийг бүтцийг ялган таних, хоёрдогч, гуравдагч, дөрөвдөгч уургийн бүтэц хэрхэн үүсэж байгааг тайлбарлах.

Энэ даалгавар нь уургийг бүтцийг ялган таних, хоёрдогч, гуравдагч, дөрөвдөгч уургийн бүтэц хэрхэн үүсэж байгааг тайлбарлах чадварыг илрүүлэх зорилготой. 11 дүгээр ангийн сургалтын цөм хөтөлбөрийн биологийн молекулууд бүлгийн агуулгаар амин хүчлийн бүтцийг тодорхойлж буй пептид холбооны үүсэл болон задрал, уургийн анхдагч, хоѐрдогч, гуравдагч, дөрөвдөгч бүтцийг тайлбарлаж, биологийн үүргийг ойлгох гэсэн суралцахуйн зорилтыг судална.

*Хүснэгт 136. Сорилын 3 дугаар даалгаврын гүйцэтгэл (Биологи, 11 дүгээр анги)*

| *Шалгуур* | *Оноо* | *Хариултын мэдээлэл (хүүхдийн эзлэх хувь)* | | *Гүйцэтгэлийн дундаж* |
|---|---|---|---|---|
| | | *2 оноо авсан* | *1 оноо авсан* | |
| Уургийн анхдагч бүцийг нэрлэсэн байх | 2 | 11.3 | 32.7 | 27.6 |
| Химийн холбоог нэрлэсэн байх | | | | |

Сурагчдын гүйцэтгэлийн дундаж 27.6 хувь байгаа нь биологийн хичээлээр олгох химийн суурь мэдлэг ойлголт хангалтгүй байгааг харуулж байна. Сургууль, багш нар хичээл хоорондын агуулгын залгамж холбоон дээр анхаарч, мэргэжлийн багш нарт дэмжлэг үзүүлэх, багш нарын хамтын ажиллагааг сайжруулах нь сурагчдын мэдлэг, чадварын гүйцэтгэлд нөлөөлөх болно.

Даалгавар 4.

*Даалгаврын зорилго:* Энзимийн үйл ажиллагааны онцлог шинжийг түлхүүр-цоожийн зарчмаар тайлбарлах.

Энэ даалгавраар энзимийн үйл ажиллагааны онцлог шинжийг түлхүүр-цоожийн зарчмаар тайлбарлах, зургаар илэрхийлэх чадварыг илрүүлэх зорилго тавьсан.

Үндэсний 12 жилийн сургалтын хөтөлбөрт ферментийн тухай хичээлийн агуулгад багтаан судалдаг байсан бол сургалтын цөм хөтөлбөрт "энзим" нэртэй шинэ бүлэг болон туссан бөгөөд нэр томьёо өөрчлөгдөж, агуулга өргөссөн. Энзим нь бодисын солилцооны урвалуудыг хурдасгадаг уураг болох, энзимийн үйл ажиллагааны онцлог шинжийг түлхүүр-цоожийн зарчмаар тайлбарлах агуулга шинээр нэмэгдсэн.

*Хүснэгт 137.* Сорилын 4 дүгээр даалгаврын гүйцэтгэл *(Биологи, 11 дүгээр анги)*

| *Шалгуур* | *Оноо* | *Хариултын мэдээлэл /хүүхдийн эзлэх хувь/* | | *Гүйцэтгэлийн дундаж* |
|---|---|---|---|---|
| | | *2 оноо авсан* | *1 оноо авсан* | |
| Идэвхтэй төв нь субстраттайгаа тохирсон хэлбэрээр зурсан байх | 2 | 31.8 | 6.5 | 35.1 |
| Зурсан зурагт тайлбар бичсэн байх | | | | |

Энзимийн идэвхтэй төв нь субстратын молекулын хэлбэртэй тохирч холбогдох түлхүүр – цоожийн зарчмыг зурж илэрхийлсэн сурагчдын эзлэх хувь 31.8 хувь байна.

Биологийн хичээлээр эзэмшсэн мэдлэг, чадвараа ашиглан шинжлэх ухааны ойлголтыг зураг, хүснэгт, диаграмм, графикаар илэрхийлэх чадварыг хөгжүүлэхийн тулд багш нарын даалгаврын чанарт буюу даалгавар боловсруулах чадварыг сайжруулахад мэргэжлийн сургалтуудыг чиглүүлэх шаардлагатай байна.

*Дадлага, туршилт гүйцэтгэх ур чадварыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Даалгавар 5.

*Даалгаврын зорилго:* Энэ даалгавар нь энзим хэрэглэснээр урвалд зарцуулагдах энерги багасч, урвалын хурд өөрчлөгдөхийг туршилтын үр дүнгээс харж, дүгнэлт бичих чадварыг илрүүлэх зорилготой.

Сургалтын цөм хөтөлбөрт энзимийн оролцоотойгоор субстратаас шинэ бодис үүсэх процессыг ажиглан урвалын хурдыг тодорхойлох агуулга шинээр туссан. Бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрт туршилт хийх чадварыг сурагч хэрхэн эзэмшсэн болохыг илрүүлэх үнэлгээний зорилт, шалгуурыг тусгасан. Энэ даалгавар нь энзимийн талаарх сурагчдын үндсэн мэдлэг, ойлголт, үзэгдэл, мөн чанарыг тайлбарлах чадвар, лабораторид хийсэн туршилтын графикаар харуулсан үр дүнгээс дүгнэлт гаргах гэсэн бүтэцтэй, 5 алхамтай даалгавар байсан. Сурагчдын гүйцэтгэлийн үр дүнг хүснэгтээр харууллаа.

*Хүснэгт 138. Сорилын 5 дугаар даалгаврын гүйцэтгэл (Биологи, 11 дүгээр анги)*

| *Даалгаврын шалгуур* | *Оноо* | *Хариултын мэдээлэл (хүүхдийн эзлэх хувь)* | | *Гүйцэтгэлийн дундаж* |
|---|---|---|---|---|
| | | *2 оноо авсан* | *1 оноо авсан* | |
| Энзим нь уургийн гаралтай болохыг санах байдал | 1 | | 45.0 | 45.0 |
| Уургийн молекулын бүтцэд өөрчлөлт гарах үзэгдлийг тайлбарлах байдал | 1 | | 7.1 | 7.14 |
| Субстратын концентрациас урвалын хурд өөрчлөгдсөн туршилтын үр дүнг хараад субстратын концентрацид юу нөлөөлсөн болохыг тайлбарлах байдал | 1 | | 77.9 | 77.9 |
| Урвалын хурд нь энзимийн концентраци тогтмол байгаа үед субстратын концентрациас хамаардаг болохыг дүгнэх байдал | 2 | 5.0 | 14.1 | 12.1 |
| Урвалын хурдыг дахин нэмэгдүүлэх нөхцлийг тооцоолох байдал | 1 | | 3.7 | 3.67 |

Сурагчдын туршилтын үр дүнгээс дүгнэлт гаргах, туршилтыг дахин шинэ нөхцөлд төлөвлөн хөгжүүлэх чадвар хангалтгүй байна.

Бүрэн дунд боловсролын биологийн сорилын даалгаврын хамаарлыг хавсралтаас харна уу.

Бүрэн дунд боловсролын биологийн хичээлийн агуулга эзэмшилтийг дараах байдлаар ангилан судалж, үр дүнг хүснэгтэд харуулав.

*Хүснэгт 139. Агуулгын шинжилгээний дүн (Биологи, 11 дүгээр анги)*

| *Агуулга* | *Даалгаврын дугаар* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|
| Сурах бичигт тусгасан даалгаврыг хөгжүүлсэн агуулга | 3<br>4 | 27.6<br>35.1 |
| Сургалтын цөм хөтөлбөрт шинээр тусгасан буюу дадлага туршилт гүйцэтгэх ур чадварыг илрүүлэх даалгавар | 5 | 29.6 |

Бүрэн дунд боловсролын биологийн сорилын судалгаанд хамрагдсан сурагчдын даалгаварын нийт гүйцэтгэлийн үр дүнг зургаар харуулав.

*Зураг 108. Сорилын даалгаврын гүйцэтгэл (Биологи, 11 дүгээр анги)*




Бүрэн дунд боловсролын биологийн сорилын гүйцэтгэлийг тархалтын муруйгаас харвал бага зэрэг зүүн тийш хазайсан байна.

Бүрэн дунд боловсролын биологийн сорилын гүйцэтгэлийн үр дүнгээс харахад:

- 11 дүгээр ангийн сурагчдын биологийн сорилын гүйцэтгэлийн дундаж 31.93 хувь байна.
- Сурагчдын мэдлэг ойлголт 48,3 хувь, мэдээлэл боловсруулах, асуудал шийдвэрлэх чадварын гүйцэтгэл 31.3 хувь, дадлага, туршилт гүйцэтгэх ур чадварын гүйцэтгэл 29.6 хувь байгаа нь багш нарын мэдлэг ур чадвар, хандлага, сургалтын орчин бүрдүүлэхээс хамааралтай байж болох юм.
- Энэ удаагийн 11 дүгээр ангийн биологийн сорилоор химийн хичээлийн агуулгатай залгамж холбоо бүхий даалгаврыг түлхүү тусгасан бөгөөд сурагчдын гүйцэтгэл хангалтгүй байгаа тул сургууль багш нар, мэргэжлийн багш нарын хамтын ажиллагаанд анхаарах, сургуулийн хөтөлбөрт хичээл хоорондын агуулгын залгамж холбоог хөгжүүлж тусгах шаардлага байгааг харуулж байна.
- Мэдээлэл боловсруулах, асуудал шийдвэрлэх чадварын гүйцэтгэл хангалтгүй байгаа нь багш нарын хичээлийн явцад тавьж байгаа асуулт, дасгал, даалгавар, үнэлгээний даалгаврын чанарт анхаарал хандуулах шаардлагатай байгааг харуулж байна.
- Дадлага туршилтын үр дүнг илрүүлэх даалгаврын гүйцэтгэл доогуур үзүүлэлттэй байгаа нь судалгаанд хамрагдсан сургуулиуд лабораторийн орчинд сургалтыг явуулахгүй, сорил туршилтыг сурагчид биеэр хийж гүйцэтгэх орчин нөхцөлийг бүрдүүлэхгүй байгаатай холбоотой байх талтай.
- Судалгаанд хамрагдсан сурагчдын гүйцэтгэлийн амжилт сул байгаа нь сургалтын цөм хөтөлбөрийн агуулгад нийцүүлэн блюпринт боловсруулж, сургалтын цөм хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлсэн нь нөлөөлж байж болзошгүй. Учир нь манай сургууль,

сургалтын практикт зөвхөн ЭЕШ өгөхөөр сонгосон хичээлийг түлхүү анхаарч байгаа нь тухайн хичээлийн сорилын гүйцэтгэлд нөлөөлсөн байх талтай.

## Химийн сорилын гүйцэтгэлийн шинжилгээ

Бүрэн дунд боловсролын 11 дүгээр ангийн химийн сорилын даалгавар нь хувилбаргүй бөгөөд олон сонголтот хариултат болон бүтээх хариултат нийт 5 даалгавартай. Даалгаврыг бүрэн гүйцэтгэсэн сурагч нийт 13 оноо авна.

*Хүснэгт 140. Сорилын даалгаврын жин (Хими, 11 дүгээр анги)*

| *Үнэлгээний зорилт* | *Даалгаврын жин (хувиар)* | *Онооны эзлэх хувь* | *Гүйцэтгэл (дундаж, хувиар)* | *Төрөл* |
|---|---|---|---|---|
| Мэдлэг, ойлголт | 40 | 17 | 30.7 | Олон сонголтот |
| Мэдлэгээ хэрэглэх чадвар | 40 | 33 | 27.0 | Олон сонголтот |
| Шинжлэх ухаанч арга барил (туршилтын) | 20 | 50 | 24.9 | Бүтээх хариултат |

*Хүснэгт 141. Даалгаврын илрүүлэх мэдлэг, чадвар ба когнитив үйлийн түвшин (Хими, 11 дүгээр анги)*

| *д/д* | *Илрүүлэх мэдлэг, чадвар* | *Сэргээн санах* | *Ойлгох* | *Хэрэглэх* | *Задлан шинжлэх* |
|---|---|---|---|---|---|
| 1 | Ухагдахууныг таних | 1 | | | |
| 2 | Молийн тооцоо хийх | | | 1 | |
| 3 | Мэдээлэл ашиглах | | | 1 | |
| 4 | Мэдлэгээ хэрэглэх | | | 1 | |
| 5 | Туршилтын мэдлэг, чадвар илрүүлэх | | 1 | 2 | 1 |

### *Мэдлэг, ойлголтыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Даалгавар 1.

Сонгох хариултат 1 дүгээр даалгавар нь моль ухагдахууны тодорхойлолтыг сонгох, Блумын таксономийн когнитив үйлийн ойлгох түвшний даалгавар байлаа.

*Хүснэгт 142. Сорилын 1 дүгээр даалгаврын гүйцэтгэл (Хими, 11 дүгээр анги)*

| | А | Б | В* | Г | ДХ | Хо |
|---|---|---|---|---|---|---|
| Нийт тоо | 51 | 78 | 57 | 274 | 1 | 1 |
| Нийт (хувь) | 11.0 | 16.9 | 12.3 | 59.3 | 0.2 | 0.2 |

Тестан программын анализаас харахад хүндрэлийн зэрэг хэт хүнд, ялгах чадвар сул даалгавар болсон байна.

Сорилд хамрагдсан сурагчдын 12.3 хувь нь зөв хариулсан бол Г буруу хариултыг нийт 59.3 хувь нь сонгосон байна. Энэ нь $6{,}02*10^{23}$ ширхэг жижиг хэсэг гэсэн утгыг л ойлгож байгаатай холбоотой бөгөөд энэ буруу хариултын ялгах чадвар маш сул болсон нь нөлөөлсөн байх магадлалтай.

Даалгавар 2.

Сонгох хариултат 2 дугаар даалгавар тодорхой концентрацтай, тодорхой эзлэхүүнтэй уусмалын ууссан бодисын молийн тоог тооцоолох чадварыг илрүүлэх зорилготой, Блумын таксономийн когнитив үйлийн мэдлэгээ хэрэглэх түвшний даалгавар юм.

*Зураг 109. Сорилын 2 дугаар даалгаврын хариулт (Хими, 11 дүгээр анги)*




ДХ-Давхар хариулт сонгосон

Хо-Хариулаагүй

*Хүснэгт 143. Сорилын 2 дугаар даалгаврын гүйцэтгэл (Хими, 11 дүгээр анги)*

| | А | Б* | В | Г | ДХ | Хо |
|---|---|---|---|---|---|---|
| Нийт тоо | 195 | 85 | 74 | 92 | 4 | 12 |
| Нийт (хувь) | 42.2 | 18.4 | 16.0 | 19.9 | .9 | 2.6 |

Даалгаврын хүндрэлийн зэрэг хүнд, ялгах чадвар маш сул байна. Сорил гүйцэтгэсэн сурагчдын 42.2 хувь нь уусмалын концентрацийг 2-т хуваасан буруу хариуг сонгосон байна. Уусмалын концентрацийг 2-оор үржүүлсэн буруу хариуг сонгож байгаа сурагчид тодорхой эзлэхүүнтэй уусмалын уусcан бодисын молийн тоог тооцоолох чадварыг сайн эзэмшээгүй, мэдлэгээ хэрэглэх чадвар сул байгааг харуулж байна.

Даалгавар 3.

Сонгох хариултат 3 дугаар даалгавар байгаль дахь изотопын эзлэх хувиар элементийн харьцангуй атом массыг тооцоолох чадварыг илрүүлэх зорилготой, Блумын таксономийн когнетив үйлийн мэдлэгээ хэрэглэх түвшний даалгавар юм.

*Зураг 110. Сорилын 3 дугаар даалгаврын хариулт (Хими, 11 дүгээр анги)*




*Хүснэгт 144. Сорилын 3 дугаар даалгаврын гүйцэтгэл (Хими, 11 дүгээр анги)*

| | А | Б | В* | Г | ДХ | Хо |
|---|---|---|---|---|---|---|
| Нийт тоо | 58 | 184 | 171 | 35 | 4 | 10 |
| Нийт (хувь) | 12.5 | 39.8 | 37.0 | 7.4 | 0.9 | 2.2 |

Даалгаврын хүндрэлийн зэрэг хэвийн боловч ялгах чадвар сул даалгавар болох нь шинжилгээний үр дүнгээс гарсан байна.

Сурагчдын 37 хувь нь зөв хариултыг сонгосон байна. Харин 39.8 хувь нь Б буруу хариултыг тооцоолж сонгосон нь байгаль дахь изотопын эзлэх хувиар элементийн харьцангуй атом массыг тооцоолох агуулга 11 дүгээр ангийн хөтөлбөрт анх удаа

тусгасан агуулгатай холбоотой байж болох юм. Мөн зураг дээр байгаль дээрх изотопын эзлэх хувь зэрэг мэдээллийг нэмж өгч даалгаврыг сайжруулах, эсвэл 70 ба 30 гэсэн хувийг график дээр тавьсан бол гүйцэтгэлд эерэг нөлөөлөх боломжтой байж магадгүй юм.

Даалгавар 4.

Сонгох хариултат 4 дүгээр даалгавар байгаль дахь изотопын эзлэх хувиар элементийн харьцангуй атом массыг тооцоолох чадварыг илрүүлэх зорилготой, Блумын таксономийн когнетив үйлийн мэдлэгээ хэрэглэх түвшний даалгавар юм.

*Зураг 111. Сорилын 4 дүгээр даалгаврын хариулт (Хими, 11 дүгээр анги)*




*Хүснэгт 145. Сорилын 4 дүгээр даалгаврын гүйцэтгэл (Хими, 11 дүгээр анги)*

| | А | Б | В | Г* | ДХ | Хо |
|---|---|---|---|---|---|---|
| Нийт тоо | 81 | 228 | 66 | 79 | 0 | 8 |
| Нийт (хувь) | 17.5 | 49.4 | 14.3 | 17.1 | 0 | 1.7 |

Энэ даалгавар нь 6 дугаар ангиас эхлэн бүх ангийн цөм хөтөлбөрийн агуулгад тусгаж өгсөн сэдэв агуулга, олон ангид давтан үзсэн зэргээрээ судлагдахуун талаас хамгийн хөнгөн суурь боловсролын түвшний агуулгыг хамарсан юм. Даалгаврын хүндрэлийн зэрэг хэт хүнд, ялгах чадвар сул даалгавар гэсэн үр дүн гарсан байна.

Даалгаврын хүнсний сод, саван суурилаг шинжтэй учир фенолфталейн улаан ягаан болно гэсэн зөв хариултыг нийт сорилд хамрагдсан сурагчдын 17.1 хувь сонгосон сонирхолтой үр дүн гарсан байна. Харин шалгуулагчийн тал (49.4хувь) нь Б буруу хариултыг буюу хүчиллэг бодисууд фенолфталеинд ягаан өнгө үзүүлнэ (өнгө үзүүлдэггүй юм) гэсэн хариуг сонгосон манай багш нар туршилтын хичээлийг бага ордог эсвэл туршилт хийдэггүй гэсэн дүгнэлтэд хүрч байна.

*Туршилтын чадвар үнэлэх даалгаврын шинжилгээ*

*Даалгавар 5.*

Даалгавар 5 нь цаасан хромаографийн туршилтын техникийн болон үр дүнг тайлах чадварыг үнэлэх зорилготой, Блумын таксономийн когнетив үйлийн ойлгох, хэрэглэх, задлан шинжлэх, үнэлэх түвшний асуулттай, бүтээх хариултат даалгавар байлаа.

11 дүгээр ангийн химийн сургалтын цөм хөтөлбөрт 1дугаар улиралд туршилтын ажил бүхий агуулга байхгүй тул 10 дугаар ангид судалсан “Бодисын цэвэршлийн зэргийг үнэлэх арга” бүлгийн “Хроматографийн арга” сэдвийн суралцахуйн а, б зорилтуудын үр дүнгээр 5 дугаар даалгаврыг боловсруулж оруулсан болно.

Бүтээх хариултат 5 дугаар даалгаврын гүйцэтгэлийг асуулт тус бүрээр авч үзье.

5.1 асуулт нь хроматограммаас илэрсэн бодисыг таних чадварыг илрүүлэх асуулт байлаа.

*Хүснэгт 146. Сорилын 5 дугаар даалгаврын асуулт 5.1-ийн гүйцэтгэлийн шинжилгээний үр дүн (Хими, 11 дүгээр анги)*

| | Оноо | Онооны давтамж | Хувь | Хүчинтэй хувь | Нэгтгэсэн хувь |
|---|---|---|---|---|---|
| Хүчинтэй | .0 | 185 | 30.9 | 42.7 | 42.7 |
| | 1.0 | 66 | 11.0 | 15.2 | 58.0 |
| | 2.0 | 182 | 30.4 | 42.0 | 100.0 |

Энэ асуултад сурагчдын 41.4 хувь нь амжилттай хариулснаас 30.4 хувь нь дээж бүрд гарсан толбоны тоо, байршил 2-ыг харьцуулах ёстой гэдгээ мэдэж тооцоолсон тул авбал зохих 2 оноогоо бүрэн авсан байна. Хүчинтэй хариултын 30.9 хувь нь тэг оноотой байна.

5.2 асуулт нь хроматограммаас илэрсэн тухайн бодис хэдэн холимгоос тогтсон болохыг ялган таних туршилтын чадварыг илрүүлэх асуулт байлаа.

*Хүснэгт 147. Сорилын 5 дугаар даалгаврын асуулт 5.2-ын гүйцэтгэлийн шинжилгээний үр дүн (Хими, 11 дүгээр анги)*

| | Оноо | Онооны давтамж | Хувь | Хүчинтэй хувь | Нэгтгэсэн хувь |
|---|---|---|---|---|---|
| | -41.0 | 1 | 0.2 | 0.2 | 0.2 |
| Хүчинтэй | .0 | 169 | 28.2 | 39.0 | 39.3 |
| | 1.0 | 263 | 43.9 | 60.7 | 100.0 |

Асуултад нийт сурагчдын 43.9 хувь зөв хариулсан бол 28.2 хувь нь буруу хариулсан байгаа нь хүлээн зөвшөөрч болохуйц амжилт юм.

5.3 асуулт нь энэ туршилтын үед баримтлах тусгай техникийг хэрэглэдэг шалтгааныг тайлбарлуулах зорилготой асуулт юм.

*Хүснэгт 148. Сорилын 5 дугаар даалгаврын асуулт 5.3-ын гүйцэтгэлийн шинжилгээний үр дүн (Хими, 11 дүгээр анги)*

| | Оноо | Онооны давтамж | Хувь | Хүчинтэй хувь | Нэгтгэсэн хувь |
|---|---|---|---|---|---|
| | 0.0 | 360 | 60.1 | 83.1 | 83.1 |
| Хүчинтэй | 1.0 | 73 | 12.2 | 16.9 | 100.0 |

Хэрвээ туршилтыг биечлэн гүйцэтгэсэн сурагч бүр хариулж болох энэ асуултад нийт сурагчдын дөнгөж 12.2 хувь нь хариулсан нь маш чамлалттай үр дүн юм. Энэ нь туршилтыг хичээлээр хийдэг боловч үр дүн, хэрэглэж буй тусгай техникийн учир шалтгааныг тайлбарлуулах тал дээр дутагдалтай гэдгийг харуулж байна.

5.4 асуулт нь туршилтын техникт баримтлах тусгай шаардлагын учир шалтгааныг тайлбарлах, Блумын таксономийн задлан шинжлэх түвшний асуулт юм.

*Хүснэгт 149. Сорилын 5 дугаар даалгаврын асуулт 5.4-ийн гүйцэтгэлийн шинжилгээний үр дүн (Хими, 11 дүгээр анги)*

| | Оноо | Онооны давтамж | Хувь | Хүчинтэй хувь | Нэгтгэсэн хувь |
|---|---|---|---|---|---|
| Хүчинтэй | 0.0 | 400 | 66.8 | 92.4 | 92.4 |
| | 1.0 | 12 | 2.0 | 2.8 | 95.2 |
| | 2.0 | 21 | 3.5 | 4.8 | 100.0 |

5.4 асуултын гүйцэтгэлийн үр дүн хамгийн доогуур буюу 5.3 хувь, үүнээс 3.5 хувь нь асуултад зөв хариулж авбал зохих оноогоо бүрэн авчээ. Энэ нь 4 дүгээр асуултын тайлбартай адил тайлбар өгч болохоор байна.

5.5 асуулт мөн л тусгай техникийн шалтгааныг мэддэг эсэхийг тандах зорилготой асуулт юм. (эхлэх шугамыг яагаад заавал харандаагаар зурдаг вэ?)

*Шинжилгээний үр дүн, асуудал*

*Хүснэгт 150. Сорилын 5 дугаар даалгаврын асуулт 5.5-ын гүйцэтгэлийн шинжилгээний үр дүн (Химы, 11 дүгээр анги)*

| | Оноо | Онооны давтамж | Хувь | Хүчинтэй хувь | Нэгтгэсэн хувь |
|---|---|---|---|---|---|
| | 0.0 | 304 | 50.8 | 70.2 | 70.2 |
| Хүчинтэй | 1.0 | 129 | 21.5 | 29.8 | 100.0 |

Гүйцэтгэлийн шинжилгээний үр дүнгээс харахад нийт сурагчдын 21.5 хувь нь асуултад зөв хариулсан байхад 50.8 хувь нь амжилтгүй хариулсан байна.

Туршилтын мэдлэг, чадварын үнэлгээний зорилтын 5 дугаар даалгаврын 5 дугаар асуултын дундаж амжилт 24.9 хувь байгаа нь мэдлэг, ойлголт, мэдлэгээ хэрэглэх үнэлгээний зорилтын даалгаврын дундаж амжилтаас 3.7 хувиар илүү байна. (бага зэрэг) Энэ нь БДБ-ын цөм хөтөлбөрт анх удаа орсон агуулга боловч 2016 оны химийн багш нарын зуны сургалтаар цаасан хроматогафын аргын туршилтыг багш нар биечлэн дадлага хийсэн тул сурагчид хийсэн байх магадлалтай. Гэхдээ асуулт бүрийн анализаас харахад энэ үр дүн бас л чамлахаар үр дүн юм.

*Хүснэгт 151. Нийт даалгаврын гүйцэтгэл (Химы, 11 дүгээр анги)*

| Даалгавар №, Үнэлгээний зорилт | Агуулга | Зөв хариулт (хувь) |
|---|---|---|
| 1. Мэдлэг ойлголт | Моль ухагдахууны ойлголтыг тандах | 12.3 |
| 2. Мэдлэг ойлголт | Уусмалд уусcан бодисын агуулагдах молийг тооцоолох | 18.4 |
| 3. Мэдлэгээ хэрэглэх | Өгсөн мэдээллийг ашиглан тухайн элементийн харьцангуй атом массыг тооцоолох | 37.0 |
| 4. Мэдлэгээ хэрэглэх | Суурилаг, хүчиллэг уусмалд индикаторын үзүүлэх өнгийг мэдэх, таних | 17.1 |
| 5. Туршилтын мэдлэг, чадвар | 5.1. Хроматграммд илэрсэн толбоны байрлалаар нь бодисын тоог ялган таних | 41.4 |
| | 5.2. Будагч бодисын толбоор хэдэн холимог бодис байсныг ялгах | 43.9 |
| | 5.3. уусмалаас дахин дахин дусаадаг учрыг тайлбарлах. | 12.2 |
| | 5.4. Эхлэх шугамыг уусгагчийн түвшнээс дээр байрлуулдагийг тайлбарлах | 5.5 |
| | 5.5. Эхлэх шугамыг харандаагаар тэмдэглэдэг учрыг тайлбарлах | 21.5 |

11 дүгээр ангийн сурагчдын нийт даалгаврын дундаж амжилт 27.7 хувь байгаа нь 8 дугаар ангийн сурагчдын дундаж амжилтаас 10 гаруй хувьд доогуур гарсан байна. Амжилт доогуур байгаа энэ байдал нь манай орны ЕБС-ийн 11-12 дугаар ангид анх удаа ахисан түвшний химийн хичээл ордог болсон, ахисан түвшний химийн хичээлийг заадаг багш нарыг бэлтгээгүй, мөн энэ ангийн химийн хичээлийн агуулгад математик хэл зонхилж байгаатай холбоотой байж болох юм.

Сорилын мэдлэг ойлголт, мэдлэгийн хэрэглээ үнэлгээний зорилтын даалгаврын гүйцэтгэл )21.2 хувь(, туршилтын мэдлэг, чадварыг илрүүлэх даалгаврын гүйцэтгэл )24.9 хувь) байгаа нь ойролцоо буюу 3.7 хувийн зөрүүтэй байна.

11 дүгээр ангийн химийн нийт даалгаврын гүйцэтгэлийн статистик үзүүлэлт, гистограммыг дараах зурагт үзүүллээ.

*Зураг 112. Сорилын даалгаврын гүйцэтгэл (Химі, 11 дүгээр анги)*




Химийн сорилын нийт гүйцэтгэлийн хувьд арифметик дундаж нь 27.7 хувь, медиан нь 23.0 хувь, моод нь 23.1 хувь, хамгийн өндөр гүйцэтгэл нь 84.6 хувь, стандарт хазайлт нь 16.5 хувьтай байна.

Бүрэн дунд боловсролын химийн сорилын гүйцэтгэлийн үр дүнгээс харахад:

- Бүрэн дунд боловсролын 11 дүгээр ангийн цөм хөтөлбөрийн хэрэгжилтийг тандах судалгаанд хамрагдсан сурагчдын сорилын гүйцэтгэлийн онооны дундаж 27.7 хувь байна.
- Цөм хөтөлбөрийн туршилтын чадвар эзэмшилтийг шалгах үнэлгээний зорилтын хүрээнд боловсруулсан туршилтын мэдлэг, чадвар илрүүлэх даалгаврын гүйцэтгэл 21.2 хувь мэдлэг, ойлголт, мэдлэгийн хэрэглээ үнэлгээний зорилтын даалгаврын гүйцэтгэл 24.9 хувь байгаа нь сурагчдын сурлагын амжилт доогуур үзүүлэлттэй байгааг харуулж байна.
- Сургалтын хөтөлбөрт анх удаа тусгасан цаасан хроматографийн арга, техник, байгаль дахь изотопын эзлэх хувиар элементийн харьцангуй атом массыг тооцоолох зэрэг сэдвүүдийн даалгаврын амжилт сул байна. Ялангуяа байгаль дахь изотопын эзлэх хувиар элементийн харьцангуй атом массыг тооцоолох чадварыг илрүүлэх даалгаврын амжилт хамгийн сул үзүүлэлттэй буюу 17.1 хувь байна.
- Энэ удаагийн химийн сорилын даалгаварт баримтын (цээжилсэн мэдлэг) мэдлэг үнэлэх асуулт оруулаагүй, хөтөлбөрийн үнэлгээний зорилт, шалгуур, жинг баримтласан блупринтыг анх удаа хэрэгжүүлж, ойлгосон мэдлэг (ухагдахууны), мэдлэгээ хэрэглэх, туршилтын чадварыг үнэлэх тул даалгавраар сорил тавьсан нь шалгуулагчдын хувьд бэрхшээл учруулсан байж болно.
- БДБ-ын 11 дүгээр ангийн сурагчдын гүйцэтгэлийн амжилт сул байгаад заавал судлах хөтөлбөрийн агуулгаар үнэлсэн нь нөлөөлсөн байх талтай. Учир нь манай сургууль, сургалтын практикт зөвхөн ЭЕШ өгөхөөр сонгосон хичээлийг түлхүү анхаарч судлах бусад хичээлийг орхигдуулах, мөн ЭЕШ-д зөвхөн олон сонголтот даалгавар (тест) цээжлэн бэлтгэдэг буруу хандлага ихэд дэлгэрсэн байдаг.

## Физикийн сорилын гүйцэтгэлийн шинжилгээ

Ахлах боловсролын 11 дүгээр ангийн физикийн сорилын даалгавар нь мэдлэг, чадвар, шинжлэх ухаанч арга барилыг үнэлэх 5 даалгавартай. Тус судалгааг хичээлийн жилийн 2 дугаар улиралд хийсэн тул:

- 1 дүгээр улиралд үзэж судалсан буюу сургалтын цөм хөтөлбөрт шинээр тусгасан агуулга
- өмнөх ангид судалсан агуулгатай залгамж холбоо бүхий гүнзгийрсэн агуулга

- сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх зорилгоор сурах бичигт тусгасан даалгаврыг хөгжүүлэх байдлаар боловсруулсан болно.

Мөн мэдлэгээ хэрэглэх чадвар, шинжлэх ухаанч арга барил эзэмшилтийг үнэлэх даалгаврын эзлэх хувь өндөр байх зорилго тавьсан.

*Хүснэгт 152. Сорилын даалгаврын жин (Физик, 11 дүгээр анги)*

| *Агуулга* | *Даалгаврын эзлэх хувь* | *Онооны эзлэх хувь* | *Гүйцэтгэлийн дундаж хувь* |
|---|---|---|---|
| Мэдлэг, ойлголт | 40 | 17 | 42.1 |
| Мэдлэгээ хэрэглэх чадвар | 40 | 33 | 14.3 |
| Шинжлэх ухаанч арга барил | 20 | 50 | 4.52 |

Сорилын даалгавар боловсруулахдаа мэдлэг ойлголтыг илрүүлэх даалгавар, мэдлэгээ хэрэглэх чадварыг илрүүлэх даалгавар, шинжлэх ухаанч арга барил эзэмшилтийг илрүүлэх даалгаврын нийт оноонд эзлэх хувь 17: 33: 50 байхаар боловсруулсан нь сургалтын цөм хөтөлбөрт тусгасан үнэлгээний зорилт, шалгуур, жинг баримтлан мэдлэгээ хэрэглэх чадвар, сурах арга барилыг илрүүлэх зорилго тавьсан болно.

*Мэдлэг, ойлголтыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Даалгавар 1.

*Даалгаврын зорилго:* Хөдөлгөөний тоо хэмжээг масс ба хурдны үржвэр гэж тодорхойлох

Даалгаврын хүндрэлийн зэрэг маш хүнд, ялгах чадвар маш сул болохыг тестан программын шинжилгээний үр дүн харуулж байна.

*Хүснэгт 153. Сорилын 1 дүгээр даалгаврын гүйцэтгэл (Физик, 11 дүгээр анги)*

| *Хариултын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэлийн хувь* | *Зөв хариулт* |
|---|---|---|---|
| 1 | А. Хөдөлгөөний тоо хэмжээ нь биеийн масс ба хурдатгалын үржвэртэй тэнцүү | 32.3 | |
| 2 | Б. Хөдөлгөөний тоо хэмжээ нь биеийн масс ба хурдны үржвэртэй тэнцүү | 26.8 | + |
| 3 | В. Хөдөлгөөний тоо хэмжээ нь биеийн масс ба хурдны өөрчлөлтийн үржвэртэй тэнцүү | 16.7 | |
| 4 | Г. Хөдөлгөөний тоо хэмжээ нь биед үйлчилсэн хүч ба хугацааны үржвэртэй тэнцүү | 23.4 | |
| 5 | Огт хариулаагүй | 0 | |
| 6 | Хариулт хүчингүй | 0.9 | |

Сурагчдын 26.8 хувь нь Б буюу зөв хариултыг сонгосон байна. 32.3 хувь нь А буруу хариултыг, 16.7 хувь нь В буруу хариултыг, 23.4 хувь нь Г буруу хариултыг сонгосон байна. Нийт сурагчид даалгаврыг гүйцэтгэсэн боловч зөв гүйцэтгэлийн хувь бага байгаа нь даалгаврын ялгах чадвар болон сурагчдын энэ талын мэдлэг, ойлголт дутмаг байгаатай холбоотой байж болох юм.

Даалгавар 2.

*Даалгаврын зорилго:* Энергийн хэлбэрийн болон харилцан хувирлын жишээг тайлбарлах

Даалгаврын хүндрэлийн зэрэг тохиромжтой, ялгах чадвар маш сул болохыг тестан программын шинжилгээний үр дүн харуулж байна.

*Хүснэгт 154. Сорилын 2 дугаар даалгаврын гүйцэтгэл (Физик, 11 дүгээр анги)*

| *Хариултын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэл хувь* | *Зөв хариулт* |
|---|---|---|---|
| 1 | А. Кинетик энергитэй, потенциал энерги тэг | 19.7 | |
| 2 | Б. Кинетик энерги тэг, потенциал энерги тэг | 4.1 | |
| 3 | В. Кинетик энерги тэг, потенциал энергитэй | 18.0 | |
| 4 | Г. Кинетик ба потенциал энергитэй | 57.4 | + |
| 5 | Огт хариулаагүй | 0 | |
| 6 | Хариулт хүчингүй | 0.9 | |

Сурагчдын 57.4 хувь нь Г буюу зөв хариултыг сонгосон байна. Харин 19.7 хувь нь А буруу хариултыг сонгосон байна. А буруу хариултыг сонгосон сурагчдын хувьд хурдтай хөдөлж байгаа учраас кинетик энергитэй гэж үзээд, харин газрын гадаргуутай харьцангуй өндөрт өргөгдсөн байгаа гэдгийг анзааралгүй орхигдуулсан байх талтай. 18.0 хувь нь В буруу хариултыг сонгосон байна. В буруу хариултыг сонгосон сурагчдын хувьд нисэж байгаа шувуу газраас харьцангуй өндөрт өргөгдсөн учир потенциал энергитэй, харин хурдтай хөдөлж байгаа гэдгийг анзааралгүй орхисон байх талтай.

*Мэдлэгээ хэрэглэх чадварыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Мэдлэгээ хэрэглэх чадварыг илрүүлэх даалгаврыг богино хариулттай байхаар боловсруулсан.

Даалгавар 3.

*Даалгаврын зорилго:* Энэ даалгавар нь чадлыг нэгж хугацаанд хийсэн ажил ба хүч болон хурдны үржвэр байдлаар тодорхойлж чадаж байгаа эсэхийг илрүүлэх зорилготой.

*Хүснэгт 155. Сорилын 3 дугаар даалгаврын гүйцэтгэл (Физик, 11 дүгээр анги)*

| *Даалгавар* | *Оноо* | *Хариултын мэдээлэл /гүйцэтгэлийн хувиар/* | | | |
|---|---|---|---|---|---|
| | | *Дээд оноо* | *Доод оноо* | *Буруу хариулсан* | *Огт хариулаагүй* |
| Д:3а | 1 | 27.9 | | 72.1 | 0 |
| Д:3б | 1 | 8.2 | | 91.8 | 0 |

3а даалгаварт чадлыг олох томьёог бичиж чадаагүй сурагчид 72.1 хувь, зөв нэрлэсэн сурагчид 27.9 хувийг тус тус эзэлж байна. 3б даалгаварт машины хөдөлгүүрийн чадлыг зөв тооцоолсон сурагчид 8.2 хувь, тооцоолж чадаагүй сурагчид 91.8 хувь байна. Нийт сурагчдын 72.1 хувь нь чадлыг олох томьёогоо мэдэхгүй байна. Сурагчдын 19.7 хувь нь томьёогоо мэдэж байгаа боловч хэрэглэж чадахгүй байгааг харуулж байна. Энэ нь багшийн заах арга зүйг сайжруулах, тэдэнд арга зүйн дэмжлэг үзүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Даалгавар 4.

*Даалгаврын зорилго:* Хүчийг байгуулагч болгон задлах

10 дугаар ангидаа вектор болон скаляр хэмжигдэхүүний ялгаа, вектор дээр хийх үйлдэл болон механик хүчнүүд, тэдгээрийг задлах талаар судалсан. 11 дүгээр ангидаа харилцан үйлчлэл ба хүч гэсэн агуулгын хүрээнд хүчийг задлах талаар гүнзгийрүүлэн судалсан.

*Хүснэгт 156. Сорилын 4 дүгээр даалгаврын гүйцэтгэл (Физик, 11 дүгээр анги)*

| *Даалгавар* | *Оноо* | *Хариултын мэдээлэл (гүйцэтгэлийн хувиар)* | | | |
|---|---|---|---|---|---|
| | | *Дээд оноо* | *Доод оноо* | *Буруу хариулсан* | *Огт хариулаагүй* |
| Д:4 | 2 | 5.0 | 4.5 | 90.5 | 0 |

Энэ даалгаварт сурагчдын 5.0 хувь нь зөв, 4.5 хувь нь дутуу, 90.5 хувь нь буруу буюу алдаатай хариултыг өгсөн байна. Вектор дээр хийх үйлдэл болон хүчийг байгуулагч болгон задлах талаарх ойлголт бага байгаа учраас сурагчдын гүйцэтгэл хангалтгүй байна.

*Шинжлэх ухаанч арга барилыг илрүүлэх даалгавар*

Даалгавар 5.

*Даалгаврын зорилго:* Төвд тэмүүлэх хурдатгал хурдны чиглэл өөрчлөгдсөнийг тооцоолох, илэрхийлэх

*Хүснэгт 157. Сорилын 5 дугаар даалгаврын гүйцэтгэл (Физик, 11 дүгээр анги)*

| *Даалгавар* | *Оноо* | *Хариултын мэдээлэл (гүйцэтгэлийн хувиар)* | | | |
|---|---|---|---|---|---|
| | | *Дээд оноо* | *Доод оноо* | *Буруу хариулсан* | *Огт хариулаагүй* |
| Д:5а | 2 | 0.9 | 5.4 | 93.7 | 0 |
| Д:5б | 2 | 2.4 | 0.6 | 97.0 | 0 |
| Д:5в | 2 | 4.8 | 3.5 | 91.8 | 0 |

*Хүснэгт 158. Шинжлэх ухаанч арга барилыг илрүүлэх даалгаврын статистик үзүүлэлт (Физик, 11 дүгээр анги)*

| | *Minimum* | *Maximum* | *Mean* | *Std. Deviation* |
|---|---|---|---|---|
| Д:5а | .0 | 2.0 | .071 | .2895 |
| Д:5б | .0 | 2.0 | .054 | .3147 |
| Д:5в | .0 | 2.0 | .130 | .4568 |

5а буюу тухайн цэгт нормал хурдатгалын чиглэлийг зурах даалгаврыг сурагчдын 0.9 хувь нь зөв, 5.4 хувь нь дутуу, 93.7 хувь нь буруу хариулсан байна. Сурагчид нормал хурдатгал болон хурдны чиглэлийг зурж чадахгүй байгаа нь нормал хурдатгалын чиглэлийг мэдэхгүй байгаатай холбоотой байх талтай.

5б буюу нормал хурдатгалыг тооцоолох даалгаврыг сурагчдын 2.4 хувь нь зөв, 0.6 хувь дутуу, 97.0 хувь нь буруу хариулсан байна. Эндээс үзэхэд сурагчид нормал худатгалыг тооцоолох томьёогоо мэдэхгүй, тооцоололд хэрэглэж чадахгүй байгаа нь харагдаж байна.

5в даалгаврыг 4.8 хувь нь зөв, 3.5 хувь нь дутуу, 91.8 хувь нь буруу буюу алдаатай хариулсан байна. Нормал хурдатгалын хэмжээ нь чөлөөт уналтын хурдатгалаас их буюу тэнцүү үед ус асгарахгүй гэдэг нөхцлийг мэдэхгүй байна. Тойргоор эргэх хөдөлгөөний агуулга нь 12 жилийн үндэсний хөтөлбөрөөр 12 дугаар ангидаа судалдаг байсан. Сургалтын цөм хөтөлбөрийн дагуу 11 дүгээр ангид судалж байгаа шинэ агуулга юм. Энэ даалгаврыг гүйцэтгэсэн сурагчдын гүйцэтгэл хангалтгүй байгаа тул багшийн заах арга

зүйг сайжруулах, тэдэнд арга зүйн дэмжлэг үзүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Сурагчдын агуулга эзэмшилтийг дараах байдлаар ангилан судалж, үр дүнг хүснэгтээр харуулав.

*Хүснэгт 159. Агуулгын гүйцэтгэл (Физик, 11 дүгээр анги)*

| *Агуулга* | *Даалгаврын дугаар* | *Гүйцэтгэлийн дундаж хувь* |
|---|---|---|
| Сургалтын цөм хөтөлбөрт шинээр тусгасан агуулга | 5а 5б 5в | 4.52 |
| Өмнөх ангид судалсан агуулгатай залгамж холбоо бүхий гүнзгийрсэн агуулга | 4 | 7.25 |
| Сурах бичигт тусгасан даалгаврыг хөгжүүлсэн агуулга | 1, 2, 3 | 28.3 |

Бүрэн дунд боловсролын физикийн сорилын 3а, 3б даалгавар , 3б, 4, 5а даалгаврууд хоорондоо хамааралтай болох нь хамаарлын шинжилгээний үр дүнгээс харагдаж байна.

*Хүснэгт 160. Сорилын даалгаврын хамаарал (Физик, 11 дүгээр анги)*

| | Д:1 | Д:2 | Д:3а | Д:3б | Д:4 | Д:5а | Д:5б | Д:5в |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Д:3а | .037 | .088 | 1 | .341** | .146** | .097* | .046 | .098* |
| Д:3б | .121** | .178** | .341** | 1 | .475** | .335** | .074 | .139** |
| Д:4 | .134** | .144** | .146** | .475** | 1 | .526** | .064 | .204** |
| Д:5а | .171** | .107* | .097* | .335** | .526** | 1 | .148** | .274** |

Судалгаанд хамрагдсан сурагчдын физикийн сорилын даалгаварын нийт гүйцэтгэлийн үр дүнг зураг, хүснэгтээр харуулав.

*Зураг 113. Сорилын даалгаврын гүйцэтгэл (Физик, 11 дүгээр анги)*




Бүрэн дунд боловсролын физикийн сорилын гүйцэтгэлийн тархалтыг тархалтын муруйгаас харвал судалгаанд хамрагдсан сурагчдын гүйцэтгэл зүүн тийшээ шилжилттэй гарсан байна. 11 дүгээр ангийн даалгаврын гүйцэтгэлийн хувиас харахад дундаж гүйцэтгэл 12.3 хувь стандарт хазайлт 12.3 хувь, өндөр гүйцэтгэл нь 84.6 хувь байна.

Бүрэн дунд боловсролын физикийн сорилын гүйцэтгэлийн үр дүнгээс харахад:

- 11 дүгээр ангийн физикийн сорилын мэдлэг ойлголтын түвшний даалгаврын дундаж гүйцэтгэл 42.1 хувь байна. Сурагчдын зөв гүйцэтгэлийн хувь бага байгаа нь даалгаврын ялгах чадвар болон сурагчдын энэ талын мэдлэг, ойлголт дутмаг байгаатай холбоотой байж болох юм.
- Мэдлэгээ хэрэглэх түвшний даалгаврын гүйцэтгэл 14.3 хувь байна. Сурагчид томъёо ашиглан тооцоолол хийх, асуудал шийдвэрлэх хангалтгүй байгаа тул багшийн заах арга зүйг сайжруулах, тэдэнд арга зүйн дэмжлэг үзүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

- Шинжлэх ухаанч арга барилын даалгаврын гүйцэтгэл 4.52 хувь байна. Энэ даалгаврын агуулга нь 12 жилийн үндэсний хөтөлбөрөөр 12 дугаар ангидаа судалдаг байсан. Сургалтын цөм хөтөлбөрийн дагуу 11 дүгээр ангид судалж байгаа шинэ агуулга юм. Тиймээс сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх, шинээр туссан агуулгыг эзэмшүүлэхэд анхаарал хандуулах хэрэгтэй байна.

# Газарзүйн сорилын гүйцэтгэлийн шинжилгээ

Бүрэн дунд боловсролын 11 дүгээр ангийн газарзүйн сорилын даалгавар нь мэдлэг, чадвар, шинжлэх ухаанч арга барилыг илрүүлэх 5 даалгавартай.

*Хүснэгт 161. Сорилын даалгаврын жин (Газарзүй, 11 дүгээр анги)*

| *Агуулга* | *Даалгаврын эзлэх хувь* | *Онооны эзлэх хувь* | *Гүйцэтгэлийн дундаж хувь* |
|---|---|---|---|
| Мэдлэг, ойлголт | 5 | 15 | 48 |
| Мэдлэгээ хэрэглэх чадвар | 30 | 31 | 45.5 |
| Шинжлэх ухаанч арга барил | 20 | 54 | 48.7 |

Мэдлэг ойлголтыг илрүүлэх даалгаврын шинжилгээ

Даалгавар 1.

Даалгаврын зорилго: Байгаль, нийгмийн юмс, үзэгдлийн цаг хугацааны өөрчлөлтийг илэрхийлэхэд график, диаграммыг ашиглах ба энэхүү даалгаврын зорилго нь график диаграммын төрлүүдийг ялгах, ач холбогдол, үүргийг мэдэж байгаа эсэхийг илрүүлэх зорилготой.

Даалгаврын хүндрэлийн зэрэг хүнд, ялгах чадвар сайн болохыг тестан программын шинжилгээний үр дүн харуулж байна.

*Хүснэгт 162. Сорилын 1 дүгээр даалгаврын гүйцэтгэл (Газарзүй, 11 дүгээр анги)*

| *Хариултын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэлийн хувь* | *Зөв хариулт* |
|---|---|---|---|
| 1 | А. Бүхэл зүйлийн 3 бүрэлдэхүүний харьцааг харуулах | 35.7 | |
| 2 | Б Хувьсах хэмжигдэхүүнүүдийн хамаарлыг илэрхийлэх | 21 | + |
| 3 | В Юмс үзэгдлийн тодорхой хугацаан дахь өөрчлөлтийг үзүүлэх | 9.7 | |
| 4 | Г Юмс үзэгдлийн орон зайн тархалтыг тодорхойлох | 31.6 | |
| 5 | Огт хариулаагүй | 0.2 | |
| 6 | Хариулт хүчингүй | 1.7 | |

Сурагчдын 21 хувь Б буюу зөв хариултыг сонгосон байна. Харин 35.7 хувь нь А, 31.7 хувь нь Г, 9.7 хувь нь В хариултыг тус тус сонгосон байгаа нь график унших мэдлэг чадвар, графикийн төрлийг ялган таних чадвар хангалтгүй байгааг харуулж байна.

Даалгавар 2

*Даалгаврын зорилго:* Газарзүйн сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилтод дэлхийн улс орнуудын хөгжлийн ялгааг харьцуулж, жишээгээр тайлбарлах гэж тусгасан тул энэ даалгавар нь Сири улсын хүний хөгжлийн индексийн өөрчлөлтөөс дүгнэлт хийж учир шалтгааныг зөв таньж байгаа эсэхийг илрүүлэх зорилготой.

Даалгаврын хүндрэлийн зэрэг хөнгөн, ялгах чадвар сайн болохыг тестан программын шинжилгээний үр дүн харуулж байна

*Хүснэгт 163. Сорилын 2 дугаар даалгаврын гүйцэтгэл (Газарзүй, 11 дүгээр анги)*

| *Хариултын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэлийн хувь* | *Зөв хариулт* |
|---|---|---|---|
| 1 | А Соёлын өөрчлөлт явагдсан | 10.6 | |
| 2 | Б Хүн амын боловсролын түвшин дээшилсэн | 9.3 | |
| 3 | В Улс төрийн тогтворгүй байдал үүссэн | 75.1 | + |
| 4 | Г Эмнэлгийн хүртээмж сайжирсан | 3.9 | |
| 5 | Огт хариулаагүй | 0.2 | |
| 6 | Хариулт хүчингүй | 0.9 | |

Сурагчдын 71.5 хувь нь В буюу зөв хариултыг сонгосон байна. Энэ нь даалгаврын хүндрэлийн зэрэг хөнгөн байгаатай холбоотой байж болох юм.

*Мэдлэгээ хэрэглэх даалгаврын шинжилгээ*

Мэдлэгээ хэрэглэх чадварыг илрүүлэх даалгаврыг богино хариулттай байхаар боловсруулсан.

Даалгавар 3.

*Даалгаврын зорилго:* График ашиглан дэлхийн улс орнуудын хөгжлийн ялгааг харьцуулж, ДНБ болон бичиг үсэг тайлагдсан байдлыг жишээгээр тайлбарлах чадварыг тодорхойлох зорилготой.

*Хүснэгт 164. Сорилын 3, 4 дүгээр даалгаврын гүйцэтгэл (Газарзүй, 11 дүгээр анги)*

| *Даалгавар* | *Оноо* | *Гүйцэтгэл* | | | |
|---|---|---|---|---|---|
| | | *1 оноо авсан* | *Буруу хариулсан* | *Огт хариулаагүй* | *Гүйцэтгэлийн хувь* |
| Д:3а | 1 | 87.7 | | 12.3 | 87.7 |
| Д:3б | 1 | 69.0 | | 31.0 | 69.0 |
| Д:4а | 1 | 18.6 | | 81.4 | 18.6 |
| Д:4б | 1 | 6.7 | | 93.3 | 6.7 |

4 дүгээр даалгаварт дундаж гүйцэтгэлийн хувь 12,6 хувьтай үнэлэгдсэн нь сурагчдын хувьд XXI-ийн нэг үзүүлэлт болох боловсролын түвшинг дээшлүүлэхэд авч болох арга хэмжээг оновчтой тодорхойлж чадахгүй байгааг харуулж байна.

*Шинжлэх ухаанч арга барилыг илрүүлэх даалгавар*

Даалгавар 5.

*Даалгаврын зорилго:* Хүн амын төрөлт, нас баралтын жишээн дээр судалж нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлон тайлбарлах агуулга сургалтын цөм хөтөлбөрт туссан. Энэ даалгаврын гол зорилго нь хүснэгтэд өгөгдсөн тоон мэдээллийг ашиглан цэгэн график байгуулах, байгуулсан графикаас хүн амын төрөлт, нас баралтын тоог хөгжлийн түвшинтэй холбон ангилах, хөгжингүй болон хөгжиж буй орноор жишээлэн тайлбарлах гэх мэт нэгтгэн дүгнэх чадварыг илрүүлэхэд оршино.

*Хүснэгт 165.* Сорилын 5 дугаар даалгаврын гүйцэтгэл (Газарзүй, 11 дүгээр анги)

| *Даалгавар* | *Оноо* | *Хариултын мэдээлэл /гүйцэтгэлийн хувиар/* | | | | *Гүйцэтгэлийн дундаж* |
|---|---|---|---|---|---|---|
| | | *2 оноо* | *1 оноо* | *Буруу хариулсан* | *Огт хариулаагүй* | |
| Д:5а | 2 | 78.6 | 13.6 | | 7.8 | 84.9 |
| Д:5б | 2 | 42.6 | 16.9 | | 40.5 | 50.8 |
| Д:5в | 2 | 8.7 | 43.5 | | 47.8 | 29.9 |
| Д:5г | 1 | | 30.3 | | 69.7 | 29.5 |

5а даалгаврын гүйцэтгэл 84.9 хувьтай байгаа нь сурагчдын цэгэн график байгуулах чадвар боломжийн түвшинд байгааг харуулж байна.

5б даалгаврын гүйцэтгэл 50.8 хувь, 5в даалгаврын гүйцэтгэл 29.9 хувь, 5г даалгавар 29.5 хувь байна. Эндээс үзэхэд сурагчдын графикаар илэрхийлсэн үр дүнг уншиж байгаа ч, улс орнуудын төрөлт нас баралтын тоон үзүүлэлт хөгжлийн ялгаатай хэрхэн хамааралтай болохыг учирлан тайлбарлах чадвар хангалтгүй байна.

*Зураг 114. Сорилын даалгаврын гүйцэтгэл (Газарзүй, 11 дүгээр анги)*




Сорилын гүйцэтгэлийн статистик үзүүлэлтээс харахад дундаж гүйцэтгэл 49.4 хувь, сурагчдын гүйцэтгэл хэвийн тархалттай байна.

*Хүснэгт 166. Сорилын даалгаврын хамаарал (Газарзүй, 11 дүгээр анги)*

| | *Д:1* | *Д:2* | *Д:3а* | *Д:3б* | *Д:4а* | *Д:4б* | *Д:5а* | *Д:5б* | *Д:5в* | *Д:5г* |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Д:1 | 1 | .137** | .032 | .082 | -.104* | -.073 | -.028 | .066 | -.034 | -.032 |
| Д:2 | .137** | 1 | .033 | .091 | -.039 | .010 | .066 | .046 | .022 | .069 |
| Д:3а | .032 | .033 | 1 | .509** | .060 | .073 | .156** | .218** | .167** | .084 |
| Д:3б | .082 | .091 | .509** | 1 | .061 | .083 | .157** | .221** | .176** | .102* |
| Д:4а | -.104* | -.039 | .060 | .061 | 1 | .087 | .041 | .078 | .188** | .188** |
| Д:4б | -.073 | .010 | .073 | .083 | .087 | 1 | .090 | .065 | .171** | .082 |
| Д:5а | -.028 | .066 | .156** | .157** | .041 | .090 | 1 | .180** | .235** | .153** |
| Д:5б | .066 | .046 | .218** | .221** | .078 | .065 | .180** | 1 | .328** | .217** |
| Д:5в | -.034 | .022 | .167** | .176** | .188** | .171** | .235** | .328** | 1 | .335** |
| Д:5г | -.032 | .069 | .084 | .102* | .188** | .082 | .153** | .217** | .335** | 1 |

Даалгавар хоорондын хамаарлыг харахад 1 дүгээр даалгавар 4, 5 дугаар даалгавартай, 2 дугаар даалгавар 4 дүгээр даалгавар хоорондын хамаарал сөрөг утгатай, бусад даалгаврын хамаарал хоорондоо эерэг утгатай байна.

Бүрэн дунд боловсролын газар зүйн сорилын гүйцэтгэлийн үр дүнгээс харахад:

- 11 дүгээр ангийн газар зүйн сорилын мэдлэг ойлголтын түвшний даалгаврын дундаж гүйцэтгэл 48.0 хувь байна. Энэ нь сурагчдын графикын онцлогийг ялган таних чадвар болон цөм хөтөлбөрт туссан шинэ агуулгын мэдлэг хангалтгүй байгааг харуулж байна.
- Мэдлэгээ хэрэглэх түвшний даалгаврын гүйцэтгэл 45.5 хувь байгаа нь сурагчдын график диаграммаас мэдээлэл унших чадвар боломжийн түвшинд байгаа ч асуудалд дүгнэлт хийж оновчтой тодорхойлолт гаргах чадвар (мэдлэгээ хэрэглэх чадвар) дутмаг байгааг харуулж байна.
- Шинжлэх ухаанч арга барилын даалгаврын гүйцэтгэл 48.7 хувь байна. Гэхдээ даалгаврыг дотор нь задалж үзвэл харилцан адилгүй гүйцэтгэлтэй буюу хүснэгтээс мэдээлэл уншиж, график байгуулах чадвар боломжийн байгаа ч, мэдээлэлд дүгнэлт хийж оновчтой тайлбарлах чадвар харьцангуй сул гүйцэтгэлтэй байна.

## Монголын түүхийн сорилын гүйцэтгэлийн шинжилгээ

Бүрэн дунд боловсролын 11 дүгээр ангийн Монголын түүхийн сорил нь сургалтын цөм хөтөлбөрт заасан мэдлэг, ойлголт, мэдлэгээ хэрэглэх чадварыг илрүүлэх 4 даалгавраас бүрдэнэ.

*Хүснэгт 167. Сорилын даалгаврын жин (Монголын түүх, 11 дүгээр анги)*

| *Агуулга* | *Даалгаврын эзлэх хувь* | *Онооны эзлэх хувь* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|---|
| Мэдлэг, ойлголт | 50.0 | 33.3 | 15 |
| Мэдлэгээ хэрэглэх чадвар | 50.0 | 96.7 | 27.3 |
| Шинжлэх ухаанч арга барил | - | - | - |

Даалгавар 1

*Даалгаврын зорилго:* Неолитийн үед Монгол нутагт оршин суугчид үйлдвэрлэх аж ахуйд шилжсэн болон түүнийг нотлох дурсгалт газрыг зөв мэдэх, тэдгээрийн хамаарлыг ойлгох

Шинжилгээний үр дүнгээс харахад даалгаврын хүндрэлийн зэрэг хүнд, ялгах чадвар дундаж байна.

*Хүснэгт 168.Сорилын 1 дүгээр даалгаврын гүйцэтгэл (Монголын түүх, 11 дүгээр анги)*

| *Хариултын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэлийн хувь* | *Зөв хариулт* |
|---|---|---|---|
| 1 | А | 41.8 | |
| 2 | Б | 15.3 | |
| 3 | В | 32.7 | + |
| 4 | Г | 8.2 | |
| 5 | Огт хариулаагүй | - | |
| 6 | Хүчингүй хариулт | 4.1 | |

Сурагчийн 32.7 хувь нь зөв хариултыг, 67.3 хувь нь буруу хариултыг сонгожээ. В зөв хариултыг сурагчдын 32.7 хувь гүйцэтгэсэн нь сорилын хүндрэлийн зэрэгтэй хамааралтай бөгөөд анхаарал татаж байна. Сорилд хамрагдсан сурагчдын 41.8 хувь нь А буруу хариултыг, 15.3 хувь нь Б буруу хариултыг, 8.2 хувь нь Г буруу хариултыг сонгосон нь неолитийн үеийн олдвор бүхий Тамсагбулгийн суурин нь Монгол нутаг дахь хүмүүс үйлдвэрлэх аж ахуйд шилжсэнийг гэрчилдэгийг ухаарч ойлгоогүйтэй холбоотой байна.

Даалгавар 2

*Даалгаврын зорилго*: Хүннү, Хань улсын хооронд байгуулсан түүхэн гэрээний он цагийг зөв танин мэдэх, тайлбарлах.

Даалгаврын хүндрэлийн зэрэг хүнд, ялгах чадвар дундаж болох нь шинжилгээний үр дүнгээс харагдаж байна.

*Хүснэгт 169. Сорилын 2 дугаар даалгаврын гүйцэтгэл (Монголын түүх, 11 дүгээр анги)*

| *Хариултын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэлийн хувь* | *Зөв хариулт* |
|---|---|---|---|
| 1 | А | 27 | + |
| 2 | Б | 61.7 | |
| 3 | В | 6.6 | |
| 4 | Г | 4.1 | |
| 5 | Огт хариулаагүй | 4.1 | |
| 6 | Хүчингүй хариулт | 0.5 | |

Сурагчийн 27 хувь нь зөв хариултыг, 73 хувь нь буруу хариултыг сонгожээ. А зөв хариултыг нийт сурагчдын 27 хувь сонгосон нь гүйцэтгэлийн хувьд хангалтгүй байна. Б буруу хариултыг нийт сурагчдын 61.7 хувь сонгосон нь нь Хүннү Хань улсын хооронд байгуулсан ”Энх ургийн гэрээ”-ний түүхэн хугацаа-он цаг болон гэрээний утга, агуулгын талаар сорилд хамрагдсан эдгээр сурагч тодорхой мэдлэг, ойлголт эзэмшээгүй болон даалгаврын зэрэг хүнд буйтай холбоотой байх талтай. В буруу хариултыг 6.6 хувь, Г буруу хариултыг 4.1 хувь сонгосон нь мөн л дээрх шалтгаантай холбоотой юм.

Даалгавар 3

*Даалгаврын зорилго:* Монгол аймаг, улсуудыг нэгтгэн Их Монгол улсыг байгуулахын төлөөх үйл хэрэгт Тэмүүжин Мэргидүүдийн хооронд хийсэн тэмцлийн үйл явц, баримтын шалтгаан, үр дагаврыг тайлбарлах чадварыг илрүүлэх

Даалгаврын хүндрэлийн зэрэг хүнд, ялгах чадвар дундаж болох нь шинжилгээний үр дүнгээс харагдаж байна.

*Хүснэгт 170. Сорилын 3 дугаар даалгаврын гүйцэтгэл (Монголын түүх, 11 дүгээр анги)*

| *Хариултын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэл хувь* | *Зөв хариулт* |
|---|---|---|---|
| 1 | А | 38.3 | |
| 2 | Б | 24 | + |
| 3 | В | 10.2 | |
| 4 | Г | 23.5 | |
| 5 | Огт хариулаагүй | - | |
| 6 | Хүчингүй хариулт | 4.1 | |

Сурагчийн 1.3 хувь нь зөв хариултыг, 98.7 хувь нь буруу хариултыг сонгосон нь хангалтгүй бөгөөд анхаарал татаж байна. Сорилд хамрагдсан сурагчдын 38.3 хувь нь А буруу хариултыг, 10.2 хувь В буруу хариултыг, 23.5 хувь Г буруу хариултыг сонгосон байна. Эдгээрийн шалтгаан нь сурагчид Монгол аймаг, улсуудыг нэгтгэн Их Монгол улсыг байгуулахын төлөөх үйл хэрэгт Тэмүүжин Мэргидүүдийн хооронд хийсэн тэмцлийн явц, баримтыг тайлбарлах чадвар эзэмшээгүйтэй холбоотой байна. Мөн сурагчдын гүйцэтгэлд сорилын хүндрэлийн зэрэг нөлөөлсөн байх талтай.

Даалгавар 4

*Даалгаврын зорилго*: Их Монгол улсын нийслэл Хар хорум дахь мөнгөн мод зэрэг түүх, соёлын дурсгалуудыг сурагчид зөв ойлгож, ялган тайлбарлах, таниулах чадварыг илрүүлэх.

Шинжилгээний үр дүнгээс харахад даалгаврын хүндрэлийн зэрэг хүнд, ялгах чадвар муу байна.

*Хүснэгт 171. Сорилын 4 дүгээр даалгаврын гүйцэтгэл (Монголын түүх, 11 дүгээр анги)*

| *Хариултын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэлийн хувь* | *Зөв хариулт* |
|---|---|---|---|
| 1 | А | 30.6 | + |
| 2 | Б | 9.7 | |
| 3 | В | 49.5 | |
| 4 | Г | 7.1 | |
| 5 | Огт хариулаагүй | 5 | |
| 6 | Хүчингүй хариулт | 2.6 | |

Сурагчийн 30.6 хувь нь зөв хариултыг, 69.4 хувь нь буруу хариултыг сонгожээ. Сорилд хамрагдсан сурагчдыын 49.5 хувь В буруу хариултыг сонгосон нь сорилын ялгах чадвар муутай холбоотой бөгөөд мөн Их Монгол улсын нийслэл Хар хорум дахь мөнгөн мод зэрэг түүх, соёлын дурсгалуудыг сурагчид ойлгож, ялган тайлбарлах, таниулах чадвар эзэмшээгүйтэй холбоотой. Б буруу хариултыг 9.7 хувь, Г буруу хариултыг 7.1 хувь сонгосон нь дээрх шалтгаантай холбогдоно.

*Задгай даалгаврын шинжилгээ*

*Хүснэгт 172. Сорилын 5 дугаар даалгаврын гүйцэтгэл (Монголын түүх, 11 дүгээр анги)*

| *Даалгаврын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|
| Д:5 | А | 9.1 |
| | Б | 60.4 |
| | В | 6.3 |
| | Г | 15.2 |
| | Дундаж | 22.7 |

*Хүснэгт 173. Даалгаврын хамаарал (Монголын түүх, 11 дүгээр анги)*

| | Д:5а | Д:5б | Д:5в | Д:5г |
|---|---|---|---|---|
| Д:5а sig.(2 tailed) | | 0.28 | 0.000 | 0.000 |
| Д:5б.(2 tailed) | 0.28 | | 0.330 | 0.004 |
| Д:5в.(2 tailed) | 0.000 | 0.33 | 0.33 | 0.004 |
| Д:5г.(2 tailed) | 0.000 | 0.004 | | |

*Шинжилгээний үр дүн, асуудал*

Сурагчийн 60.4 хувь нь 5б даалгаврыг зөв гүйцэтгэж , 39.6 хувь нь буруу гүйцэтгэсэн байна. Эдгээр сурагчид зураг ажиглах арга барилыг нийтлэг эзэмшсэн байна. 5а, в, г даалгаврын гүйцэтгэл 6.3-15.2 хувь буюу дундаж гүйцэтгэлээс доогуур байгаа нь зургийг дүрслэх, тайлбарлах, ялгааг гаргах үйлийг гүйцэтгэх арга барил дутагдалтай байгааг илэрхийлж байна. Даалгаврын хамаарлын шинжилгээний дүнгээс үзэхэд 5а даалгавар нь 5в, 5г даалгавартай; 5б даалгавар нь 5в, 5г даалгавартай; 5в даалгавар нь 5б, 5в,5г

даалгавартай; 5г даалгавар нь 5б даалгавартай тус хамааралтай байна. 5а, 5б даалгаврууд хоорондоо хамааралгүй байна.

*Хүснэгт 174. Сорилын 6а дугаар даалгаврын гүйцэтгэл (Монголын түүх, 11 дүгээр анги)*

| *Даалгаврын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэлийн хувь* | *Зөв хариулт* |
|---|---|---|---|
| Д:6 | А | 72.9 | + |
| | Б | 21.9 | |
| | В | 24.7 | |
| | Дундаж | 39.8 | |

*Хүснэгт 175. Сорилын даалгаврын хамаарал (Монголын түүх, 11 дүгээр анги)*

| | Д:6а | Д:6б | Д:6в |
|---|---|---|---|
| Д:6а sig.(2 tailed) | | 0.006 | 0.034 |
| Д:6б.(2 tailed) | 0.006 | - | 0.000 |
| Д:6в.(2 tailed) | 0.034 | 0.000 | |

Сурагчийн 72.4 хувь нь А даалгаврыг зөв гүйцэтгэж, 27.4 хувь нь буруу гүйцэтгэсэн байна. Сурагчид эх унших баримтаар нотлох арга барилыг нийтлэг эзэмшсэн байна. Б, Г даалгаврын гүйцэтгэл 21.4-24.7 хувь байгаа нь шалттгаан, үр дагавар, сургамж тодорхойлох даалгавар бага хийсэнтэй холбоотой. Даалгаврын хамаарлын шинжилгээний дүнгээс үзэхэд 6а даалгавар нь 6в, 6б даалгавартай; 6б даалгавар нь 6а, 6в даалгавартай; 6в даалгавар нь 6а, 6б даалгавартай тус тус хамааралтай байна.

*Зураг 115. Сорилын даалгаврын гүйцэтгэл (Монголын түүх, 11 дүгээр анги)*




Сорилын гүйцэтгэлийн статистик үзүүлэлтээс харахад дундаж гүйцэтгэл 33.3 хувь, сурагчдын гүйцэтгэлийн тархалт зүүн тийш хазайсан үр дүн харагдаж байна.

Бүрэн дунд боловсролын Монголын түүхийн сорилын гүйцэтгэлийн үр дүнгээс харахад:

- Тухайн сорилын 1 дүгээр даалгаврын гүйцэтгэл 32.7 хувь байгаа нь сурагчид неолитийн үеийн олдвор бүхий Тамсагбулгийн суурин нь Монгол нутаг дахь хүмүүс үйлдвэрлэх аж ахуйд шилжсэнийг гэрчилдэгийг бүрэн ойлгоогүйг харуулж байна. Энд тус сорилын зэрэг хүнд буй ч нөлөөлсөн байж болно.
- 2 дугаар даалгаврын зөв гүйцэтгэл 36 хувь буй нь сорилд хамрагдсан сурагчид Монголчуудын анхны төрт улс Хүннү ба Хятадын Хань улсын хооронд байгуулсан ”Энх ургийн гэрээ”-ний түүхэн он цаг, гэрээний утга, агуулгын тухай тодорхой мэдлэг, ойлголт эзэмшээгүйг харуулж байна.
- 3 дугаар даалгаврыг сурагчдын 98.7 хувь буруу гүйцэтгэсэн нь маш хангалтгүй үнэлгээ бөгөөд шалтгаан нь сурагчид Монгол аймаг, улсуудыг нэгтгэн Их Монгол улсыг

байгуулахын төлөөх үйл хэрэгт Тэмүүжин Мэргидүүдийн хооронд хийсэн тэмцлийн явц, баримтыг тайлбарлах чадварыг эзэмшээгүйг илэрхийлж байна.

- 4 дүгээр даалгаврын зөв гүйцэтгэл 30.6 хувь гарсан нь хангалтгүй ба үүний шалтгаан нь Их Монгол улсын нийслэл Хар хорум дахь мөнгөн мод зэрэг түүх, соёлын үнэт дурсгалуудыг сурагчид дутмаг ойлгосон, түүнийг тайлбарлах, таниулах чадвар олж аваагүйг харуулж байна.
- Задгай даалгавруудын шинжилгээ нь сурагчид түүхэн зураг, дүрслэлийг ажиглах, эх уншиж, ойлгосноо баримтаар нотлох зэрэг арга барилыг нийтлэг эзэмшсэн нь сайн талтай ч харин зургийг дүрслэх, тайлбарлах, ялгааг гаргах, задлан шинжлэх, мөн шалтгаан, үр дагавар, сургамжийг тодорхойлох, үнэлэх арга барил дутагдалтай байгааг харуулж байна.
- Тухайн ангийн Монголын түүх хичээлийн сонгох болон задгай даалгаврын гүйцэтгэлд нөлөөлж буй голлох хүчин зүйлийн тоон шинжилгээнээс харахад, түүнд сурагчийн сурах барил, багшийн заах арга зүй шууд болон дам хамаарал, нөлөөлөлтэй байгааг харуулав.

## Нийгмийн ухааны сорилын гүйцэтгэлийн шинжилгээ

Бүрэн дунд боловсролын 11 дүгээр ангийн нийгмийн ухааны сорил нь сургалтын цөм хөтөлбөрт заасан мэдлэг, ойлголт, мэдлэгээ хэрэглэх чадварыг илрүүлэх 4 даалгавраас бүрдэнэ.

*Хүснэгт 176. Сорилын даалгаврын жин (Нийгмийн ухаан, 11 дүгээр анги)*

| *Агуулга* | *Даалгаврын эзлэх хувь* | *Онооны эзлэх хувь* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|---|
| Мэдлэг, ойлголт | 50.0 | 33.3 | 15.3 |
| Мэдлэгээ хэрэглэх чадвар | 50.0 | 96.7 | 37.7 |
| Шинжлэх ухаанч арга барил | - | - | |

Даалгавар 1

*Даалгаврын зорилго:* Сурагч хоёр дахь нийгэмшилт болон нийгэмшилтийн хүчин зүйлийг ялгах, ойлгох

Шинжилгээний үр дүнгээс харахад даалгаврын хүндрэлийн зэрэг маш хүнд, ялгах чадвар сул байна.

*Хүснэгт 177. Сорилын 1 дүгээр даалгаврын гүйцэтгэл (Нийгмийн ухаан, 11 дүгээр анги)*

| *Хариултын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэлийн хувь* | *Зөв хариулт* |
|---|---|---|---|
| 1 | А | 21 | + |
| 2 | Б | 57.7 | |
| 3 | В | 30.1 | |
| 4 | Г | 1 | |
| 5 | Огт хариулаагүй | 5 | |
| 6 | Хүчингүй хариулт | - | |

Сурагчийн 10.7 хувь нь зөв хариултыг, 89.3 хувь нь буруу хариултыг сонгосон нь нэн хангалтгүй бөгөөд сорилын зэрэг маш хүнд буйтай холбоотой байж болно. Б буруу хариултыг 57.7 хувь сонгосон нь хоёр дахь нийгэмшилтийг сурагчид тодорхой

ойлгоогүйтэй холбоотой байна. В буруу хариултыг 30.1 хувь сонгосон нь тэд хоёр дахь нийгэмшилт болон нийгэмшилтийн хүчин зүйлийг ялган ойлгоогүйтэй холбогдоно. Г буруу хариултыг 1 хувь сонгосон сурагчид энэ талын ойлголт сул байж болох талтай.

Даалгавар 2

Даалгаврын зорилго: Эрх зүй бүлгээр судалдаг захиргааны шийтгэл, түүний хэлбэрийн тухай ойлгох, тодорхойлох

Шинжилгээний үр дүнгээс харахад даалгаврын хүндрэлийн зэрэг маш хүнд, ялгах

*Хүснэгт 178. Сорилын 2 дугаар даалгаврын гүйцэтгэл (Нийгмийн ухаан, 11 дүгээр анги)*

| *Хариултын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэлийн хувь* | *Зөв хариулт* |
|---|---|---|---|
| 1 | А | 31.6 | |
| 2 | Б | 9.7 | + |
| 3 | В | 34.7 | |
| 4 | Г | 24 | |
| 5 | Огт хариулаагүй | - | |
| 6 | Хүчингүй хариулт | - | |

Сурагчийн зөвхөн 9.7 хувь нь зөв хариултыг, 90.3 хувь нь буруу хариултыг сонгосон нь нэн хангалтгүй бөгөөд бас сорилын зэрэг маш хүндтэй холбоотой. 31.6 хувь нь А буруу хариултыг, 34.7 хувь нь В буруу хариултыг, 24 хувь нь Г буруу хариултыг сонгосон нь эрх зүй бүлгээр судалдаг захиргааны шийтгэл, түүний хэлбэрийн тухай ойлголтыг эдгээр сурагчид танин мэдэж, эзэмшээгүйтэй холбоотой байна.

Даалгавар 3

*Даалгаврын зорилго:* Сурагч нийгмийн хэв маягийн тухай ойлголтоо хэрэглэн, тэдгээрийг ялгах, ангилах, нэрлэх, тодорхойлох чадвартай байх

Шинжилгээний үр дүнгээс харахад даалгаврын хүндрэлийн зэрэг хөнгөн, ялгах чадвар дундаж байна.

*Хүснэгт 179. Сорилын 3 дугаар даалгаврын гүйцэтгэл (Нийгмийн ухаан, 11 дүгээр анги)*

| *Хариултын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэлийн хувь* | *Зөв хариулт* |
|---|---|---|---|
| 1 | А | 4.1 | |
| 2 | Б | 5,6 | |
| 3 | В | 14.3 | |
| 4 | Г | 75.5 | + |
| 5 | Огт хариулаагүй | - | |
| 6 | Хүчингүй хариулт | 5 | |

Сурагчийн 75.5 хувь нь зөв хариултыг, 24.5 хувь нь буруу хариултыг сонгосон нь боломжийн гүйцэтгэл юм. 4.1 хувь нь А буруу хариултыг, 5.6 хувь Б буруу хариултыг, 14.3 хувь В буруу хариултыг сонгосон нь тэд нийгмийн хэв маягийн тухай ойлголтоо хэрэглэн, тэдгээрийг ялгах, ангилах, нэрлэх чадварыг эзэмшээгүйтэй холбоотой.

Даалгавар 4

*Даалгаврын зорилго:* ОУХ-ны “ улс” оролцогч болон улсуудын хөгжлийн түвшингийн тухай ойлголтыг шалгуур ашиглан тайлбарлах чадвар

Даалгаврын хүндрэлийн зэрэг маш хүнд, ялгах чадвар маш сул болох нь шинжилгээний дүнгээс харагдаж байна.

*Хүснэгт 180. Сорилын 4 дүгээр даалгаврын гүйцэтгэл (Нийгмийн ухаан, 11 дүгээр анги)*

| *Хариултын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэлийн хувь* | *Зөв хариулт* |
|---|---|---|---|
| 1 | А | 100 | |
| 2 | Б | | |
| 3 | В | | + |
| 4 | Г | | |
| 5 | Огт хариулаагүй | | |
| 6 | Хүчингүй хариулт | | |

Сорилд хамрагдсан сурагчид бүгд зөв хариулт (В)-ыг сонгоогүй байна. Харин 100 хувь буруу хариултыг сонгосон нь анхаарал татаж байна. Сорилд хамрагдсан сурагчид 100 хувь А буруу хариултыг сонгосон нь ОУХ-ны "улс" оролцогч болон улсуудын хөгжлийн түвшингийн тухай ойлголтыг шалгуур ашиглан тайлбарлах чадварыг огт эзэмшээгүйг илрүүлж байна.

*Задгай даалгаврын шинжилгээ*

*Хүснэгт 181. Сорилын 5 дугаар даалгаврын гүйцэтгэл (Нийгмийн ухаан, 11 дүгээр анги)*

| *Даалгаврын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|
| Д:5 | А | 38.5 |
| | Б | 35.5 |
| | В | 83.6 |
| | Дундаж | 52.5 |

*Хүснэгт 182. Сорилын даалгаврын хамаарал (Нийгмийн ухаан, 11 дүгээр анги)*

| | Д:5а | Д:5б | Д:5в |
|---|---|---|---|
| Д:5а sig.(2 tailed) | | 0.002 | 0.067 |
| Д:5б.(2 tailed) | 0.002 | | 0.068 |
| Д:5в.(2 tailed) | 0.067 | 0.068 | |

Сурагчийн 83.6 хувь нь 5в даалгаврыг зөв гүйцэтгэж, 39.6 хувь нь буруу гүйцэтгэсэн байна. Сурагчид хүснэгт дэх өгөгдлийг ажиглах нэрлэх, тоон утга олох арга барилыг нийтлэг эзэмшсэн байна. 5а, 5б даалгаврын гүйцэтгэл 35.5-38.5 хувь байгаа нь дундаж гүйцэтгэлээс доогуур байна. Эдгээр сурагчид шалтгаан тайлбарлах, ялгааг гаргах үйлийг гүйцэтгэх арга барил дутагдалтай байгааг илэрхийлж байна. Даалгаврын хамаарлын шинжилгээний дүнгээс үзэхэд 5а даалгавар нь 5в, 5б даалгавартай; 5б даалгавар нь 5а, 5в даалгавартай; 5в даалгавар нь 5а, 5а даалгавартай тус тус хамааралтай байна.

*Хүснэгт 183. Сорилын 6 дугаар даалгаврын гүйцэтгэл (Нийгмийн ухаан, 11 дүгээр анги)*

| *Даалгаврын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|
| Д:6 | А | 69.5 |
| | Б | 57.5 |
| | В | 5 |
| | Дундаж | 44 |

*Хүснэгт 184. Сорилын даалгаврын хамаарал (Нийгмийн ухаан, 11 дүгээр анги)*

| | Д:6а | Д:6б | Д:6в |
|---|---|---|---|
| Д:6а sig.(2 tailed) | | 0.000 | 0.147 |
| Д:6б.(2 tailed) | 0.000 | | 0.048 |
| Д:6в.(2 tailed) | 0.147 | 0.088 | |

Сурагчийн 69.5 хувь нь 6а даалгаврыг зөв гүйцэтгэж, 30.5 хувь нь буруу гүйцэтгэсэн байна. Сурагчид эх уншиж, шинж чанарыг бичих арга барилыг нийтлэг эзэмшсэн байна. 6б, 6в даалгаврын гүйцэтгэл 5-57.5 хувь байгаа нь дундаж гүйцэтгэлээс доогуур байна. Эдгээр сурагчид үндэслэл гаргах, хамаарлыг нотлох үйлийг гүйцэтгэх арга барил дутагдалтай байгааг илэрхийлж байна. Даалгаврын хамаарлын шинжилгээний дүнгээс үзэхэд 6а даалгавар нь 6в, 6б даалгавартай; 6б даалгавар нь 6а, 6в даалгавартай; 6в даалгавар нь 6а, 6б даалгавартай тус тус хамааралтай байна.

*Зураг 116. Сорилын даалгаврын гүйцэтгэл (Нийгмийн ухаан, 11 дүгээр анги)*




Сорилын гүйцэтгэлийн статистик үзүүлэлтээс харахад дундаж гүйцэтгэл 35.2 хувь, сурагчдын гүйцэтгэл хэвийн тархалттай үр дүн харагдаж байна.

Бүрэн дунд боловсролын нийгэм судлалын сорилын гүйцэтгэлийн үр дүнгээс харахад:

- Тухайн сорилын 1 ба 2 дугаар даалгаврын зөв гүйцэтгэл зөвхөн 10.7-9.7 хувь байгаа нь маш хангалтгүй бөгөөд сорилд хамрагдсан сурагчид хоёр дахь нийгэмшилт болон хоёр дахь нийгэмшилт, нийгэмшилтийн хүчин зүйлийг ялгаа хийгээд захиргааны шийтгэл, түүний хэлбэрийн тухай ойлголтыг үндсэндээ танин мэдээгүй, ойлгоогүй байгааг харуулж байна.
- 3 дугаар даалгаврыг сурагчдын 75.5 хувь зөв гүйцэтгэсэн нь харьцангуй дундаж үзүүлэлт ба харин тэд нийгмийн хэв маягийн тухай ойлголтоо хэрэглэн, тэдгээрийг ялгах, ангилах, нэрлэх чадвар эзэмших талаар дутагдалтай байгааг илрүүлж байна.
- 4 дүгээр даалгаврыг сорилд оролцсон бүх сурагч буруу гүйцэтгэсэн нь маш хангалтгүй үзүүлэлт бөгөөд шалтгаан нь тэд ОУХ-ны “улс” оролцогч болон улсуудын хөгжлийн түвшингийн тухай мэдлэг, ойлголтыг шалгуур ашиглан тайлбарлах чадварыг огт эзэмшээгүй байгааг харуулж байна. Энэ нь мөн тус ангийн сургалтын цөм хөтөлбөрийн дагуу зохиогдсон сурах бичиг одоогоор хэвлэгдээгүй буйтай холбоотой байж болно.
- Задгай даалгавруудын шинжилгээ нь сурагчид хүснэгт ажиглах, нэрлэх, тоон утга олох болон эх уншиж, түүний шинж чанарыг тодорхойлон бичих зэрэг арга барилыг нийтлэг эзэмшсэн нь сайн талтай ч харин юмс үзэгдлийн учир шалтгааныг тайлбарлах, ялгааг гаргах, үндэслэл дэвшүүлэх, хамаарлыг нотлох, батлах зэрэг арга барил дутагдалтай байгааг илтгэж байна.
- Тухайн ангийн нийгмийн ухаан хичээлийн сонгох болон задгай даалгаврын гүйцэтгэлд нөлөөлж буй голлох хүчин зүйлийн тоон шинжилгээнээс харахад, түүнд сурагчийн

сурах барил, багшийн заах арга зүй шууд болон дам хамаарал, нөлөөлөлтэй байгааг харуулав.

## Дизайн, зураг зүй, технологийн сорилын гүйцэтгэлийн шинжилгээ

Бүрэн дунд боловсролын 11 дүгээр ангийн дизайн, зурагзүй, технологийн сорил нь танин мэдэхүйн ойлгох, хэрэглэх, бүтээх түвшний 10 даалгавартай, сорилын нийт оноо 25 байна. А хэсэгт мэдлэг, ойлголтыг илрүүлэх 4 даалгавар, Б хэсэгт мэдлэгээ хэрэглээ, бүтээлч эрэлхийллийн арга барилын чадварыг илрүүлэх 6 даалгаврыг боловсруулсан байна.

*Хүснэгт 185. Сорилын даалгаврын жин (Дизайн, технологи, 11 дүгээр анги)*

| *Танин мэдэхүйн түвшин* | *Даалгаврын дугаар* | *Онооны хуваарилалт* | *Үнэлгээний жин* |
|---|---|---|---|
| Мэдлэг, ойлголт | А-1,2,3,4 | 4 | 16 хувь |
| Мэдлэгээ хэрэглэх | Б-5,6,7,8 | 8 | 32 хувь |
| Бүтээх | Б-9,10 | 13 | 52 хувь |
| Нийт | 5 даалгавар | 5 оноо | 100 хувь |

Бүрэн дунд боловсролын дизайн зураг зүй, технологийн сургалтын хөтөлбөрийн агуулга, сорилын даалгавартай холбогдох байдал

Бүрэн дунд боловсролын Дизайн зураг зүй, технологийн сургалтын хөтөлбөрийн агуулга нь сурагчдад зурагзүй, дизайн, техник технологи, инженерчлэлийн шинжлэх ухааны үндэс, зохион бүтээх арга эзэмшүүлэхэд чиглэдэг. Сорилын даалгаврыг боловсруулахдаа бүрэн дунд боловсролын дизайн технологийн сургалтын хөтөлбөрийн 11 дүгээр ангийн Дизайн, зурагзүй бүлгийн агуулга болон өмнөх ангид судалсан агуулгатай залгамж холбоо бүхий агуулгыг сонгож авч үзсэн. Сургалтын хөтөлбөр болон сорилын даалгавраар илрүүлэх мэдлэг, чадварын холбогдох байдлыг авч үзэв.

*Хүснэгт 186. Сургалтын хөтөлбөр ба сорилын холбогдох байдал (Нийгмийн ухаан, 11 дүгээр анги, эрэгтэй сурагч)*

<table>
<tr><th rowspan="2">Танин мэдэхүйн түвшин</th><th rowspan="2">Даалгаврын дугаар</th><th colspan="2">Сургалтын хөтөлбөрийн холбогдох агуулга</th></tr>
<tr><th>Агуулгын бүлэг</th><th>Мэдлэг, чадвар</th></tr>
<tr><td rowspan="4">Мэдлэг</td><td>Д:1</td><td rowspan="3">Зураг зүй</td><td>Форматын хэмжээг тодорхойлох</td></tr>
<tr><td>Д:2</td><td>Масштабын тухай ойлголтоо илэрхийлэх</td></tr>
<tr><td>Д:3</td><td>Эд ангиудыг зурахад хэрэглэгдэх зураасны төрлүүдийг таних, нэрлэх</td></tr>
<tr><td>Д:4</td><td rowspan="3">Боловсруулах технологи</td><td>Хагас боловсруулсан модон материалыг нэрлэх</td></tr>
<tr><td rowspan="4">Мэдлэгээ хэрэглэх</td><td>Д:5</td><td>Салдаг ба салдагүй холболтын төрлүүдийг ангилах, нэрлэх</td></tr>
<tr><td>Д:6</td><td>Металлын шинж чанарыг мэдэх, тодорхойлох</td></tr>
<tr><td>Д:7</td><td rowspan="2">Зураг зүй</td><td>Нэгдсэн проекцын дүрслэлийг ойлгох, унших</td></tr>
<tr><td>Д:8</td><td>Аксонометр проекцын тэнхлэгүүдийг нэрлэх, хэрэглээг тайлбарлах</td></tr>
</table>

| | | | |
|---|---|---|---|
| Бүтээх | Д:9 | Техник | Техникийн хөдөлгөөн дамжуулах механизмийн хэрэглээг зургаар илэрхийлэх |
| | Д:10 | Төсөлт ажил | Төсөлт ажлын санаа боловсруулах, тайлбарлах |

*Хүснэгт 187. Сургалтын хөтөлбөр ба сорилын холбогдох байдал (Нийгмийн ухаан, 11 дүгээр анги, эмэгтэй сурагч)*

| *Танин мэдэхүйн түвшин* | *Даалгаврын дугаар* | *Сургалтын хөтөлбөрийн холбогдох агуулга* | |
|---|---|---|---|
| | | *Агуулгын бүлэг* | *Мэдлэг, чадвар* |
| Мэдлэг | Д:1 | Зураг зүй | Форматын хэмжээг тодорхойлох |
| | Д:2 | | Масштабын тухай ойлголтоо илэрхийлэх |
| | Д:3 | | Эд ангиудыг зурахад хэрэглэгдэх зураасны төрлүүдийг таних, нэрлэх |
| | Д:4 | Боловсруулах технологи | Нэхмэлийн утасны төрөл ангилалыг таних, нэрлэх |
| Мэдлэгээ хэрэглэх | Д:5 | | Үндэсний хувцас хийхэд биеэс авах хэмжээг нэрлэх, тодорхойлох |
| | Д:6 | | Дээл эсгэх аргуудыг нэрлэх, тодорхойлох |
| | Д:7 | Зураг зүй | Аксонометр проекцын дүрслэлийг ойлгох, унших |
| | Д:8 | | Аксонометр проекцын тэнхлэгүүдийг нэрлэх, хэрэглээг тайлбарлах |
| Бүтээх | Д:9 | Техник | Мөртэй хувцас үндсэн эсгүүрийг загварчлах зургаар илэрхийлэх |
| | Д:10 | Төсөлт ажил | Төсөлт ажлын санаа боловсруулах, тайлбарлах |

*Зураг 117. Сорилын даалгаврын гүйцэтгэл (Дизайн, зураг зүй, технологи, 11 дүгээр анги)*




Сурагчдын гүйцэтгэлээс 7 дугаар даалгаврын гүйцэтгэл бусад даалгаврын гүйцэтгэлээс өндөр байна. Бусад даалгавруудын гүйцэтгэл 9.5-45.3 хувь байгаа нь хангалтгүй байна. Танин мэдэхүйн ойлгох, мэдлэгээ хэрэглэх, бүтээх түвшний даалгаврын сурагчдын гүйцэтгэлийг харьцуулан авч үзэхэд танин мэдэхүйн ойлгох түвшний 4 даалгаврын дундаж 32.8 хувь байна. Гэхдээ даалгавар 3-ийн гүйцэтгэл анхаарал татаж байна. Мэдлэгээ хэрэглэх түвшний даалгаврын дундаж 45.1 хувь байна. Тухайн үзүүлэлт нь ойлгох, бүтээх түвшний даалгаврын дунджаас бага зэргийн илүү байна. Бүтээх түвшний 2 даалгаврын гүйцэтгэлийн дундаж 20.8 хувь байна. Энэ нь ойлгох, мэдлэгээ хэрэглэх түвшний даалгаврын гүйцэтгэлээс бага харагдаж байна.

*Сорилын найдвартай байдал, тохирц*

11 дүгээр ангийн дизайн, зураг зүй, технологийн сорилд хамрагдсан сурагчдын даалгаврын гүйцэтгэлийн хэвийн тархалтыг авч үзье.

*Зураг 118. Сорилын даалгаврын гүйцэтгэл (Дизайн, зураг зүй, технологи, 11 дүгээр анги)*




11 дүгээр ангийн дизайн, зурагзүй, технологийн эрэгтэй, эмэгтэй сурагчдаас авсан сорил нь тус бүр 10 даалгавар, сорил тус бүрийн даалгавруудын нийт оноо 25 оноотой болно. Сурагчдын сорилын даалгаврын гүйцэтгэлийн дундаж 34.0 хувьтайгаар шалгагдсан байна.

*Сорилын даалгавар тус бүрийн шинжилгээ*

11 дүгээр ангийн дизайн, зурагзүй, технологийн сорилын нийт 10 даалгавар тэдгээрийн хоорондын хамаарлыг авч үзвэл:

Мэдлэг ойлголтын түвшний даалгавар (1, 2, 3, 4): Даалгавар1 нь даалгавар 3, 5, 10 дугаар даалгавартай ач холбогдол бүхий хамааралтай, даалгавар 8, 9-тэй сул хамааралтай байна. Даалгавар 2 нь 3, 6, 10 дугаар даалгавартай, даалгавар 3 нь 1, 2, 6, 7, 8, 9, 10 даалгавартай ач холбогдол бүхий хамааралтай байна. Даалгавар 4 нь 10 дах даалгавартай сул хамааралтай байгааг статистик үзүүлэлт харуулж байна.

Мэдлэгээ хэрэглэх түвший даалгавар (5, 6, 7, 8): Даалгавар 5 нь 1, 4, 9, 10 дах даалгавартай хамааралтай, даалгавар 6 нь даалгавар 2, 3 10 тай ач холбогдол бүхий хамааралтай, 8 дах даалгавартай сул хамааралтай байна. Даалгавар 7 нь 9 дах даалгавартай, Даалгавар 8 нь даалгавар 3 тай ач холбогдол бүхий хамааралтай бол даалгавар 1, 6, 10-тай сул хамааралтай байна.

Бүтээх түвшний даалгавар (8, 9): Даалгавар 9 нь 5, 7, 10 дугаар даалгавартай ач холбогдол бүхий хамааралтай, 1 дэх даалгавартай сул хамааралтай байна. Даалгавар 10 нь даалгавар 7 бусад сорилын даалгаваруудтай чухал ач холбогдол бүхий хамааралтай байна. Мөн даалгавар 4-тэй сул хамааралтайг статистик үзүүлэлт харуулж байна.

Сорилын сонгох даалгаварт шинжилгээ хийн даалгавруудын зорилго хангагдсан эсэхийн даалгавар тус бүрээр авч үзье.

*Даалгавар 1*. Форматын хэмжээг тодорхойлох

*Даалгаврын зорилго*: Зураг зүйн дүрэм, стандартын талаарх мэдлэг, ойлголтыг илрүүлнэ.

Сорилд хамрагдсан эрэгтэй сурагчид 100 хувь даалгаврыг гүйцэтгэсэн байна. Үүний 26.5 хувь нь зөв, 73.5 хувь нь буруу хариулсан байна. Тухайн даалгавар нь А, Б, В, Г гэсэн дөрвөн сонгох хувилбартай бөгөөд буруу хариулсан сурагчдын гүйцэтгэлийн авч үзэхэд А хувилбарыг хамгийн их буюу сурагчдын 32.1 хувь нь сонгосон байна. Сурагчдын сонгох даалгаврын хариултыг хувиар авч үзье.

*Хүснэгт 188. Сорилын 1 дүгээр даалгаврын эрэгтэй сурагчдын гүйцэтгэл (Дизайн технологи, 11 дүгээр анги)*

| *Хариултын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэл хувь* |
|---|---|---|
| 1 | А | 32.1 |
| 2 | Б | 8.2 |
| 3 | В | 29.1 |
| 4**+** | Г+ | 26.5+ |
| 6 | Хариулт хүчингүй | 4.1 |

Тестан программын үр дүнгээс тухайн даалгаврын хүнд хөнгөний зэрэг нь 26.5, ялгах чадвар 28.5 (p = .002) байгаа нь тухайн даалгавар нь хүндрэлийн зэргийн хувьд хүнд, ялгах чадвар дундаж байгааг харуулж байна.

Сорилд хамрагдсан эмэгтэй сурагчдын 98 хувь нь тухайн даалгаврыг гүйцэтгэсэн байна. Үүний 54.2 хувь нь зөв, 45.8 хувь нь буруу хариулсан байна. Тухайн даалгавар нь А, Б, В, Г гэсэн дөрвөн сонгох хувилбартай бөгөөд сурагчдын гүйцэтгэлийн хувийг авч үзэв.

*Хүснэгт 189. Сорилын 1 дүгээр даалгаврын эмэгтэй сурагчдын гүйцэтгэл (Дизайн технологи, 11 дүгээр анги)*

| *Хариултын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэл хувь* |
|---|---|---|
| 1+ | А+ | 54.2+ |
| 2 | Б | 6.4 |
| 3 | В | 16.5 |
| 4 | Г | 18.4 |
| 5 | Хоосон орхисон | 4.1 |
| 6 | Хариулт хүчингүй | 0.3 |

Тестан программын үр дүнгээс тухайн даалгаврын хүнд хөнгөний зэрэг нь 54.0, ялгах чадвар 22.2 байгаа нь тухайн даалгавар нь хүндрэлийн зэргийн хувьд дундаж, ялгах чадвар дундаж байгааг харуулж байна.

Даалгавар 2. Масштабын тухай ойлголтоо илэрхийлэх

*Даалгаврын зорилго:* Зураг зүйн дүрэм, стандартын талаарх мэдлэг, ойлголтыг илрүүлнэ.

Сорилд хамрагдсан эрэгтэй сурагчид 100 хувь даалгаврыг гүйцэтгэсэн байна. Үүний 47.5 хувь нь зөв, 52.5 хувь нь буруу хариулсан байна. Тухайн даалгавар нь А, Б, В, Г гэсэн дөрвөн сонгох хувилбартай бөгөөд сурагчдын гүйцэтгэлийн хувийг авч үзэв.

*Хүснэгт 190. Сорилын 2 дугаар даалгаврын эрэгтэй сурагчдын гүйцэтгэл (Дизайн технологи, 11 дүгээр анги)*

| *Хариултын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэл хувь* |
|---|---|---|
| 1 | А | 9.7 |
| 2 | Б | 33.2 |
| 3+ | В+ | 47.5+ |
| 4 | Г | 5.6 |
| 6 | Хариулт хүчингүй | 4.1 |

Тестан программын үр дүнгээс тухайн даалгаврын хүнд хөнгөний зэрэг нь 47.4, ялгах чадвар 34.0 (p = .000) байгаа нь тухайн даалгавар нь хүндрэлийн зэргийн хувьд дундаж, ялгах чадвар сайн байгааг харуулж байна.

Сорилд хамрагдсан эмэгтэй сурагчид 100 хувь даалгаврыг гүйцэтгэсэн байна. Үүний 6.4 хувь нь зөв, 93.6 хувь нь буруу хариулсан байна. Тухайн даалгавар нь А, Б, В, Г гэсэн дөрвөн сонгох хувилбартай бөгөөд сурагчдын гүйцэтгэлийн хувийг авч үзэв.

*Хүснэгт 191. Сорилын 2 дугаар даалгаврын эмэгтэй сурагчдын гүйцэтгэл (Дизайн технологи, 11 дүгээр анги)*

| *Хариултын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэл хувь* |
|---|---|---|
| 1 | А | 54.1 |
| 2+ | Б+ | 6.4+ |
| 3 | В | 16.5 |
| 4 | Г | 18.4 |
| 5 | Хоосон орхисон | .4 |
| 6 | Хариулт хүчингүй | 4.1 |

Тестан программын үр дүнгээс тухайн даалгаврын хүнд хөнгөний зэрэг нь 6.4, ялгах чадвар 9.7 байгаа нь тухайн даалгавар нь хүндрэлийн зэргийн хувьд хүнд, ялгах чадвар маш бага байгааг харуулж байна.

*Даалгавар 3.*

*Даалгаврын зорилго:* Эд ангиудыг зурахад хэрэглэгдэх зураасны төрлүүдийг таних, нэрлэх

Сорилд хамрагдсан эрэгтэй сурагчид 100 хувь даалгаврыг гүйцэтгэсэн байна. Үүний 9.2 хувь нь зөв, 90.8 хувь нь буруу хариулсан байна. Тухайн даалгавар нь А, Б, В, Г гэсэн дөрвөн сонгох хувилбартай бөгөөд сурагчдын гүйцэтгэлийн хувийг авч үзэв.

*Хүснэгт 192. Сорилын 3 дугаар даалгаврын эрэгтэй сурагчдын гүйцэтгэл (Дизайн технологи, 11 дүгээр анги)*

| *Хариултын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэл хувь* |
|---|---|---|
| 1 | А | 5.6 |
| 2 | Б | 56.1 |
| 3 | В | 27.0 |
| 4 | Г+ | 9.2+ |
| 6 | Хариулт хүчингүй | 1.5 |

Тестан программын үр дүнгээс тухайн даалгаврын хүнд хөнгөний зэрэг нь 9.2, ялгах чадвар 20.8 (p = .000) байгаа нь тухайн даалгавар нь хүндрэлийн зэргийн хувьд хүнд, ялгах чадвар дундаж байгааг харуулж байна.

Сорилд хамрагдсан эмэгтэй сурагчид 100 хувь даалгаврыг гүйцэтгэсэн байна. Үүний 8.3 хувь нь зөв, 91.7 хувь нь буруу хариулсан байна. Тухайн даалгавар нь А, Б, В, Г гэсэн дөрвөн сонгох хувилбартай бөгөөд сурагчдын гүйцэтгэлийн хувийг авч үзэв.

*Хүснэгт 193. Сорилын 3 дугаар даалгаврын эмэгтэй сурагчдын гүйцэтгэл (Дизайн технологи, 11 дүгээр анги)*

| *Хариултын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэл хувь* |
|---|---|---|
| 1 | А | 54.1 |
| 2+ | Б+ | 8.3+ |
| 3 | В | 16.5 |
| 4 | Г | 18.4 |
| 5 | Хоосон орхисон | .4 |
| 6 | Хариулт хүчингүй | 4.1 |

Тестан программын үр дүнгээс тухайн даалгаврын хүнд хөнгөний зэрэг нь 8.3, ялгах чадвар .0 байгаа нь тухайн даалгавар нь хүндрэлийн зэргийн хувьд хүнд, ялгах чадвар маш бага байгааг харуулж байна.

*Даалгавар 4.* Хагас боловсруулсан модон материалыг нэрлэх

*Даалгаврын зорилго:* Материалын шинж чанарын талаар ойлголтыг илрүүлнэ.

Сорилд хамрагдсан эрэгтэй сурагчид 100 хувь даалгаврыг гүйцэтгэсэн байна. Үүний 56.1 хувь нь зөв, 43.8 хувь нь буруу хариулсан байна. Тухайн даалгавар нь А, Б, В гэсэн гурван сонгох хувилбартай бөгөөд сурагчдын гүйцэтгэлийн хувийг авч үзэв.

*Хүснэгт 194. Сорилын 4 дүгээр даалгаврын эрэгтэй сурагчдын гүйцэтгэл (Дизайн технологи, 11 дүгээр анги)*

| *Хариултын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэл хувь* |
|---|---|---|
| 1 | А | 20.9 |
| 2 | Б | 18.4 |
| 3+ | В+ | 56.1+ |
| 5 | Огт хариулаагүй | 0 |
| 6 | Хариулт хүчингүй | 1.5 |

Тестан программын үр дүнгээс тухайн даалгаврын хүнд хөнгөний зэрэг нь 56.1, ялгах чадвар 24.5 (p = .011) байгаа нь тухайн даалгавар нь хүндрэлийн зэргийн хувьд дундаж, ялгах чадвар дундаж байгааг харуулж байна.

*Даалгавар 4*. Нэхмэлийн утасны төрөл ангилалыг таних, нэрлэх

Сорилд хамрагдсан эмэгтэй сурагчид 100 хувь даалгаврыг гүйцэтгэсэн байна. Үүний 2.3 хувь нь зөв, 97.7 хувь нь буруу хариулсан байна. Тухайн даалгавар нь А, Б, В, Г гэсэн дөрвөн сонгох хувилбартай бөгөөд сурагчдын гүйцэтгэлийн хувийг авч үзэв.

*Хүснэгт 195. Сорилын 4 дүгээр даалгаврын эмэгтэй сурагчдын гүйцэтгэл (Дизайн технологи, 11 дүгээр анги)*

| *Хариултын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэл хувь* |
|---|---|---|
| 1+ | А+ | 2.3+ |
| 2 | Б | 66.5 |
| 3 | В | 21.1 |
| 4 | Г | 9.4 |
| 5 | Хоосон орхисон | .4 |
| 6 | Хариулт хүчингүй | .4 |

Тестан программын үр дүнгээс тухайн даалгаврын хүнд хөнгөний зэрэг нь 2.3, ялгах чадвар 1.3 байгаа нь тухайн даалгавар нь хүндрэлийн зэргийн хувьд хүнд, ялгах чадвар маш бага байгааг харуулж байна.

*Даалгавар 7*. Нэгдсэн проекцын дүрслэлийг ойлгох, унших

*Даалгаврын зорилго:* Нэгдсэн болон аксонометр дүрслэлийн талаарх мэдлэг, ойлголтыг илрүүлнэ.

Сорилд хамрагдсан эрэгтэй сурагчид 100 хувь даалгаврыг гүйцэтгэсэн байна. Үүний 84.7 нь зөв, 15.3 хувь нь буруу хариулсан байна. Тухайн даалгавар нь А, Б, В, Г гэсэн дөрвөн сонгох хувилбартай бөгөөд сурагчдын гүйцэтгэлийн хувийг авч үзэв.

*Хүснэгт 196. Сорилын 7 дугаар даалгаврын эрэгтэй сурагчдын гүйцэтгэл (Дизайн технологи, 11 дүгээр анги)*

| *Хариултын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэл хувь* |
|---|---|---|
| 1+ | А+ | 84.7+ |
| 2 | Б | 2.6 |
| 3 | В | 9.2 |
| 4 | Г | 2.6 |
| 6 | Хариулт хүчингүй | 1.0 |

Тестан программын үр дүнгээс тухайн даалгаврын хүнд хөнгөний зэрэг нь 84.7, ялгах чадвар 15.1 (p = .030) байгаа нь тухайн даалгавар нь хүндрэлийн зэргийн хувьд хөнгөн, ялгах чадвар багатай байгааг харуулж байна.

Сорилд хамрагдсан эмэгтэй сурагч сурагчид 100 хувь даалгаврыг гүйцэтгэсэн байна. Үүний 68.0 хувь нь зөв, 32.0 хувь нь

буруу хариулсан байна. Тухайн даалгавар нь А, Б, В, Г гэсэн дөрвөн сонгох хувилбартай бөгөөд сурагчдын гүйцэтгэлийн хувийг авч үзэв.

*Хүснэгт 197. Сорилын 7 дугаар даалгаврын эмэгтэй сурагчдын гүйцэтгэл (Дизайн технологи, 11 дүгээр анги)*

| *Хариултын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэл хувь* |
|---|---|---|
| 1 | А | 16.5 |
| 2 | Б | 7.1 |
| 3 | В | 7.1 |
| 4+ | Г+ | 68.0+ |
| 6 | Хариулт хүчингүй | 1.2 |

Тестан программын үр дүнгээс тухайн даалгаврын хүнд хөнгөний зэрэг нь 68.0, ялгах чадвар 37.5 байгаа нь тухайн даалгавар нь хүндрэлийн зэргийн хувьд дундаж, ялгах чадвар сайн гэдгийг харуулж байна.

*Даалгавар 8.* Нэгдсэн проекцын дүрслэлийг ойлгох, унших

Сорилд хамрагдсан эрэгтэй сурагчид 100 хувь даалгаврыг гүйцэтгэсэн байна. Үүний 46.4 хувь (91 сурагч) нь зөв гүйцэтгэсэн бол 53.6 хувь (105 сурагч) нь буруу хариулсан байна. Тухайн даалгавар нь А, Б, В, Г гэсэн дөрвөн сонгох хувилбартай бөгөөд сурагчдын гүйцэтгэлийн хувийг авч үзэв.

*Хүснэгт 198. Сорилын 8 дугаар даалгаврын эрэгтэй сурагчдын гүйцэтгэл (Дизайн технологи, 11 дүгээр анги)*

| *Хариултын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэл хувь* |
|---|---|---|
| 1+ | А+ | 46.4+ |
| 2 | Б | 35.7 |
| 3 | В | 10.2 |
| 4 | Г | 6.6 |
| 6 | Хариулт хүчингүй | 1.0 |

Тестан программын үр дүнгээс тухайн даалгаврын хүнд хөнгөний зэрэг нь 46.4, ялгах чадвар 15.1 (p = .120) байгаа нь тухайн даалгавар нь хүндрэлийн зэргийн хувьд дундаж, ялгах чадвар багатай байгааг харуулж байна

Сорилд хамрагдсан эмэгтэй сурагчид 100 хувь даалгаврыг гүйцэтгэсэн байна. Үүний 7.1 хувь (19 сурагч) нь зөв гүйцэтгэсэн бол 92.8.0 хувь (247 сурагч) нь буруу хариулсан байна. Тухайн даалгавар нь А, Б, В, Г гэсэн дөрвөн сонгох хувилбартай бөгөөд сурагчдын гүйцэтгэлийн хувийг авч үзэв.

*Хүснэгт 199. Сорилын 8 дугаар даалгаврын эмэгтэй сурагчдын гүйцэтгэл (Дизайн технологи, 11 дүгээр анги)*

| *Хариултын дугаар* | *Хариулт* | *Гүйцэтгэл хувь* |
|---|---|---|
| 1 | А | 16.5 |
| 2+ | Б+ | 7.1+ |
| 3 | В | 7.1 |
| 4 | Г | 68.0 |
| 6 | Хариулт хүчингүй | 1.2 |

Тестан программын үр дүнгээс тухайн даалгаврын хүнд хөнгөний зэрэг нь 7.1, ялгах чадвар 5.6 байгаа нь тухайн даалгавар нь хүндрэлийн зэргийн хувьд хүнд, ялгах чадвар маш бага гэдгийг харуулж байна.

*Задгай хариултат даалгаврын шинжилгээ*

Уг сорил нь богино хариултат 2 даалгавартай бөгөөд тухайн даалгаврууд нь салдаг ба салдаггүй холболтын төрлүүдийг ангилах, нэрлэх, металлын шинж чанарыг тодорхойлох мэдлэг, чадварыг илрүүлэхэд чиглэнэ. Задгай даалгавар тус бүр 2 оноотой. Гүйцэтгэлийн үр дүнг даалгавар тус бүрээр авч үзье.

Задгай даалгавар 5.

Даалгаврын сурагчдын гүйцэтгэлийг дараах хүснэгтээр харуулав.

*Хүснэгт 200. Сорилын задгай 5 дугаар даалгаврын эрэгтэй сурагчдын гүйцэтгэл (Дизайн технологи, 11 дүгээр анги)*

| | *Даалгаврын агуулга* | *Оноо* | *Гүйцэтгэлийн хувь* | *Дундаж хувь* |
|---|---|---|---|---|
| Д:5 | Салдаг ба салдаггүй холболтын төрлүүдийг ангилах, нэрлэх | 2 оноо авсан | 22.8 | 44.8 |
| | | 1 оноо авсан | 64.6 | |
| | | 0 оноо авсан | 22.8 | |

Даалгавар гүйцэтгэсэн сурагчдын 22.8 хувь нь хангалтай, 64 хувь дундаж гүйцэтгэсэн бол 22.8 хувь гүйцэтгэж чадаагүй буюу буруу хийсэн байна. Тухайн даалгаврыг гүйцэтгэсэн сурагчдын гүйцэтгэлийн задалж авч үзье. Нийт эрэгтэй сурагчдын 12.5 хувь нь салдаг ба салдаггүй холболтыг ялган нэрлэсэн, салдаг ба салдаггүй холболтын төрлүүдээс тус бүр 3-ийг нэрлэсэн 41.3 хувь, тус бүр 2-ыг нэрлэсэн 23.9 хувь, тус бүр 1-ийг нэрлэсэн 9.7 хувь байгаа бол буруу хийсэн 10.5 хувь, огт нэрлээгүй 1.6 хувийг эзэлж байна. Сурагчдын 80 гаруй хувь нь тухайн даалгаврыг ямар нэг хэмжээгээр хийсэн байна гэсэн дүр зураг харагдаж байна.

*Хүснэгт 201. Сорилын задгай 5 дугаар даалгаврын эмэгтэй сурагчдын гүйцэтгэл (Дизайн технологи, 11 дүгээр анги)*

| | *Даалгаврын агуулга* | *Оноо* | *Гүйцэтгэлийн хувь* | *Дундаж хувь* |
|---|---|---|---|---|
| *Д:5* | Үндэсний хувцас хийхэд биеэс авах хэмжээг нэрлэх, тодорхойлох | 2 оноо авсан | 87.1 | 84.*3* |
| | | 1 оноо авсан | 1.2 | |
| | | 0 оноо авсан | 15.6 | |

Даалгавар гүйцэтгэсэн эмэгтэй сурагчдын 87.1 хувь нь хангалтай гүйцэтгэсэн, 1.2 хувь нь дундаж гүйцэтгэлтэй, 15.6 хувь нь буруу гүйцэтгэсэн байна. Тухайн даалгаврын задалж авч үзэхэд сурагчдын ихэнх буюу 80 гаруй хувь үндэсний хувцас хийхэд биеэс авах хэмжээнүүдийг нэрлэхдээ алдаагүй зөв гүйцэтгэсэн бол дундаж гүйцэтгэлтэй сурагчид нь үндэсний хувцас хийхэд биеэс авах хэмжээнээс 3-ийг нэрлэсэн байна.

Даалгавар 6

Сурагчдын гүйцэтгэлийг дараах хүснэгтээр харуулав.

*Хүснэгт 202. Сорилын задгай 6 дугаар даалгаврын эрэгтэй сурагчдын гүйцэтгэл (Дизайн технологи, 11 дүгээр анги)*

| | *Даалгаврын агуулга* | *Оноо* | *Гүйцэтгэлийн хувь* | *Дундаж хувь* |
|---|---|---|---|---|
| Д:6 | Металлын шинж чанарыг мэдэх, тодорхойлох | 2 оноо авсан | 20.5 | 48.0 |
| | | 1 оноо авсан | 62.5 | |
| | | 0 оноо авсан | 20.0 | |

Даалгавар гүйцэтгэсэн эрэгтэй сурагчдын 20.5 хувь нь хангалтай, 62.5 хувь нь дундаж гүйцэтгэлтэй, 20 хувь нь хангалгүй гүйцэтгэсэн байна. Тухайн даалгаврыг сурагчдын гүйцэтгэлийн задалж авч үзье. Нийт эрэгтэй сурагчдын 20 хувь нь металлын зэврэлт, шалгаан, хамгаалах аргуудыг маш сайн тодорхойлсон бол 51 хувь нь металлын зэврэлт ба түүний шалгааныг, 9 хувь нь металлыг зэврэлтээс хамгаалах аргыг тайлбарласан байна. Хангалтгүй гүйцэтгэсэн сурагчдын 13 хувь буруу хийсэн, 7 хувь нь даалгаврыг гүйцэтгээгүй байна.

*Хүснэгт 203. Сорилын 6 дугаар даалгаврын эмэгтэй сурагчдын гүйцэтгэл (Дизайн технологи, 11 дүгээр анги)*

| | *Даалгаврын агуулга* | *Оноо* | *Гүйцэтгэлийн хувь* | *Дундаж хувь* |
|---|---|---|---|---|
| Д:6 | Дээл эсгэх аргуудыг нэрлэх, тодорхойлох | 2 оноо авсан | 16.1 | 22.5 |
| | | 1 оноо авсан | 12.8 | |
| | | 0 оноо авсан | 71.1 | |

Даалгавар гүйцэтгэсэн эмэгтэй сурагчдын 16.1 хувь нь хангалтай, 12.8 хувь нь дундаж гүйцэтгэлтэй, 71.1 хувь нь хангалгүй гүйцэтгэсэн байна. Тухайн даалгаврыг сурагчдын гүйцэтгэлийн задалж авч үзье. Нийт эмэгтэй сурагчдын 16.1 хувь нь Дээл эсгэх 2 аргыг зөв нэрлэж тодорхойлсон, 9.6 хувь нь ухаж эсгэх аргыг, 3.2 хувь нь зөрүүлдэж эсгэх аргыг нэрлэсэн байна. Хангалтгүй гүйцэтгэсэн сурагчдын 57 хувь буруу хийсэн, 13.6 хувь нь даалгаврыг гүйцэтгээгүй байна.

Сорилын (эмэгтэй) 4, 5 дугаар даалгаврын агуулга нь залгамж холбоотой боловч сурагчдын гүйцэтгэлийн үр дүнгийн хамаарал бага харагдаж байна. Иймээс тухайн 2 даалгаврын гүйцэтгэлийн хамаарлыг статистик үзүүлэлтийг авч үзэх хэрэгтэй байна.

## *Бүтээх даалгавар*

Сурагчдын даалгаврын гүйцэтгэлийг дараах хүснэгтээр харуулав.

*Даалгавар 9.*

*Даалгаврын зорилго:* Техникийн хөдөлгөөн дамжуулах механизмийн хэрэглээг зургаар илэрхийлэх

*Хүснэгт 204. Сорилын 9 дүгээр даалгаврын эрэгтэй сурагчдын гүйцэтгэл (Дизайн технологи, 11 дүгээр анги)*

| | *Даалгаврын агуулга* | *Оноо* | *Гүйцэтгэлийн хувь* | *Дундаж хувь* |
|---|---|---|---|---|
| Д:9 | Техникийн хөдөлгөөн дамжуулах механизмийн хэрэглээг зургаар илэрхийлэх | 5-6 оноо авсан | 1.6 | 2.2 |
| | | 3-4 оноо авсан | 0 | |
| | | 1-2 оноо авсан | 2.2 | |
| | | 0 оноо авсан | 96.2 | |

Даалгавар гүйцэтгэсэн эрэгтэй сурагчдын 1.6 хувь нь хангалтай, 2.2 хувь нь дундаж гүйцэтгэлтэй, 96.2 хувь нь хангалгүй гүйцэтгэсэн байна.

Тухайн даалгаврын сурагчдын гүйцэтгэл буюу хөдөлгөөн дамжуулах аргыг өгөгдсөн нөхцлийн дагуу хийсэн эсэхийг нь задалж авч үзье.

*Хүснэгт 205. Сорилын 9 дүгээр даалгаврын эрэгтэй сурагчдын гүйцэтгэл (Дизайн технологи, 11 дүгээр анги)*

| *Даалгаврын өгөгдөл* | *Зөв гүйцэтгэсэн хувь* | *Буруу гүйцэтгэсэн хувь* | *Даалгаврыг хийгээгүй хувь* |
|---|---|---|---|
| А. Эргэлтийн тоо нь ижил байхаар | 3.8 | 52.1 | 44.1 |
| Б. Эргэлтийн тоог 2 дахин ихэсгэх | 1.6 | 54.3 | 44.1 |
| В. Эргэлтийн тоог 2 дахин багасгах | 1.6 | 54.3 | 44.1 |

Сорилд хамрагдсан эрэгтэй сурагчдын гүйцэтгэлийн үр дүн сурагчдын техникийн хөдөлгөөн дамжуулах механизм болон түүний хэрэглээний талаарх ойлголт хангалтгүй

байгааг харуулж байна. Мөн тухайн даалгавар нь тухайн сорилд хамрагдсан сурагчдын хувьд хүнд даалгавар байжээ гэж харж болохоор байна.

Даалгавар 9. Мөрний хувцасны үндсэн эсгүүрийг загварчлах, зургаар илэрхийлэх

*Хүснэгт 206. Сорилын 9 дүгээр даалгаврын эмэгтэй сурагчдын гүйцэтгэл (Дизайн технологи, 11 дүгээр анги)*

| | *Даалгаврын агуулга* | *Оноо* | *Гүйцэтгэлийн хувь* | *Дундаж хувь* |
|---|---|---|---|---|
| Д:9 | Мөрний хувцасны үндсэн эсгүүрийг загварчлах зургаар илэрхийлэх | 5-6 оноо авсан | 2.8 | 16.0 |
| | | 3-4 оноо авсан | 11.2 | |
| | | 1-2 оноо авсан | 18.9 | |
| | | 0 оноо авсан | 67.0 | |

Даалгавар гүйцэтгэсэн эмэгтэй сурагчдын 2.8 хувь нь хангалтай, 30 хувь нь дундаж гүйцэтгэлтэй, 67.2 хувь нь хангалгүй гүйцэтгэсэн байна

Тухайн даалгаврын сурагчдын гүйцэтгэл буюу мөрний хувцасны үндсэн эсгүүрийг загварчилгааг хэрхэн хийсэн гүйцэтгэлийг задалж авч үзье.

Хүснэгт 207. *Сорилын 9 дүгээр даалгаврын эмэгтэй сурагчдын гүйцэтгэл (Дизайн технологи, 11 дүгээр анги)*

| *Даалгаврын өгөгдөл* | *Зөв гүйцэтгэсэн хувь* | *Буруу гүйцэтгэсэн хувь* | *Даалгаврыг хийгээгүй хувь* |
|---|---|---|---|
| А. Загварчилгаа 1. | 7.6 | 77.5 | 14.8 |
| Б. Загварчилгаа 2. | 13.6 | 71.2 | 14.8 |
| В. Загварчилгаа 3. | 31.7 | 53.8 | 14.8 |

Мөрний хувцасны загварчилгаа,түүний хэрэглээний талаарх ойлголт сурагчдад хангалтгүй байгааг харуулж байна.

*Даалгавар 10*.

Сурагчдын даалгаврын гүйцэтгэлийг дараах хүснэгтээр харуулав.

*Хүснэгт 208. Сорилын 10 дугаар даалгаврын эрэгтэй, эмэгтэй сурагчдын гүйцэтгэл (Дизайн технологи, 11 дүгээр анги)*

| *д/д* | *Даалгаврын агуулга* | *Оноо* | *Гүйцэтгэлийн хувь* | *Дундаж хувь* |
|---|---|---|---|---|
| 1 | Төсөлт ажлын санаа боловсруулах, тайлбарлах (Техникийн бүтээл) | 7 оноо авсан | 0.5 | 22.3 |
| | | 5-6 оноо авсан | 2.2 | |
| | | 3-4 оноо авсан | 21.1 | |
| | | 1-2 оноо авсан | 47.2 | |
| | | 0 оноо авсан | 28.8 | |
| 2 | | 7 оноо авсан | 0.4 | 37.7 |
| | Төсөлт ажлын санаа боловсруулах, тайлбарлах | 5-6 оноо авсан | 10 | |

| | | |
|---|---|---|
| (Оёмол эдлэл) | 3-4 оноо авсан | 42.1 |
| | 1-2 оноо авсан | 40.5 |
| | 0 оноо авсан | 6.8 |

Даалгавар гүйцэтгэсэн эрэгтэй сурагчдын 0.5 хувь нь хангалтай сайн, 2.2 хувь нь хангалтай, 68 хувь нь дундаж гүйцэтгэлтэй, 28.8 хувь нь хангалгүй гүйцэтгэсэн байна

*Хүснэгт 209. Төсөлт ажлын санаа боловсруулах даалгаврын сурагчдын гүйцэтгэлийн үр дүн*

| | |
|---|---|
| 1. Төсөлт ажлын нэр | Сорилд хамрагдсан нийт сурагчдын 60.5 хувь нь төсөлт ажлын нэрээ оновчтой тодорхойлж чадсан байна. Харин 29.3 хувь нь төсөлт ажлын нэрийг даалгаврын өгөгдөлд нийцүүлэн тодорхойлж чадаагүй бол 10.1 хувь нь огт тодорхойлоогүй байна. |
| 2. Төсөл ажлын зорилго | Сорилд хамрагдсан нийт сурагчдын 23.3 хувь нь төсөлт ажлын зорилгыг оновчтой томьёолж чадсан байна. Харин 66 хувь нь төсөлт ажлын зорилгоо томьёолж чадаагүй, 10.6 хувь огт томьёолоогүй байна. |
| 3. Төсөлт ажлын үе шат | Сорилд хамрагдсан нийт сурагчдын 89.1 хувь нь тухайн даалгаврыг гүйцэтгэсэн байна. Сорилд хамрагдсан сурагчдын 6.4 хувь нь төслийн бүх нэрлэж, оновчтой тайлбарласан, 15 хувь нь 3-4 үе шатыг нэрлэн тайлбарласан, 19 хувь нь 1-2 үе шат нэрлэж тайлбарласан байна. Харин 49.2 хувь нь төслийн үе шат даалгаварын өгөгдөлд холбогдолгүй тайлбарыг бичсэн байна. |
| 4. Төсөлт ажлын технологи ажилбар | Сорилд хамрагдсан сурагчдын 11.5 хувь нь төслийн үе шатад хийх технологи ажилбарыг маш сайн тайлбарласан , 37.2 хувь нь технологи ажилбарыг товч тайлбарласан байна. Харин 41.6 хувь нь төслийн технологи ажилбар болон даалгаврын өгөгдөлд холбогдолгүй тайлбарыг бичсэн, дутуу орхисон болон өөрийн санаагаа илэрхийлж чадаагүй бол 9.9 хувь нь огт хийгээгүй гэсэн үр дүн харагдаж байна. |

# Биеийн тамирын сорилын гүйцэтгэлийн шинжилгээ

Бүрэн дунд боловсролын 11 дүгээр ангийн биеийн тамирын сорилын даалгавар нь мэдлэг ойлголт, мэдлэгээ хэрэглэх, гүйтгэлийн чанар буюу чадварыг илрүүлэх 10 даалгавартай. Биеийн тамирын сургалтын цөм хөтөлбөрийн бие бялдрын хөгжил, чийрэгжилт, хөнгөн атлетик, хөл бөмбөг, сагсан бөмбөг, волейбол, монголын ба олон улсын спортын хөгжлийн бүлэг сэдвээр эзэмшсэн мэдлэг, ойлголт, гүйцэтгэл болон чадварыг илрүүлэх зорилгоор сорилын даалгаврыг боловсруулсан.

*Хүснэгт 210. Сорилын даалгаврын жин (Биеийн тамир, 11 дүгээр анги)*

| *Агуулга* | *Даалгаврын эзлэх хувь* | *Онооны эзлэх хувь* | *Гүйцэтгэлийн дундаж* |
|---|---|---|---|
| Мэдлэг | 35 | 16.0 | 35.06 |
| Ойлголт | 35 | 32.0 | 48.9 |
| Мэдлэгээ хэрэглэх чадвар | 30 | 52.0 | 29.9 |

*Мэдлэгийг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Даалгавар 1.

Даалгаврын зорилго*:* Хөнгөн атлетикийн холын зайн гүйлтэд гүйхэд амьсгалаа хэрхэн зөв авах мэдлэгийг илрүүлэх

*Хүснэгт 211. Сорилын 1 дүгээр даалгаврын гүйцэтгэл (Биеийн тамир, 11 дүгээр анги)*

| *Хариултын хувилбар* | *Гүйцэтгэлийн хувь* | *Зөв хариулт* |
|---|---|---|
| А | 54.2 | + |
| Б | 23.1 | |
| В | 9.1 | |
| Г | 12.3 | |
| Хүчингүй хариулт | 0 | |
| Огт хариулаагүй | 1.3 | |

Даалгаврын гүйцэтгэлийн үр дүнгээс харахад 54.2 хувь нь А хувилбар буюу зөв хариултыг сонгосон байна. Харин 45.8 хувь нь буруу хариултыг сонгосон байгаа нь сурагчид хөнгөн атлетикийн гүйлтийн үед амьсгал авах, гаргах мэдлэг, ойлголтыг төгс эзэмшээгүй байгааг харуулж байна. Мөн нөгөө талаас даалгаврын хүндрэлийн зэрэг хүнд, ялгах чадвар сул байгаа нь нөлөөлсөн байх талтай.

Даалгавар 2.

*Даалгаврын зорилго:* Бие бялдраа хөгжүүлэх, уян хатны түвшинг илрүүлэх дасгалыг нэрлэх

*Хүснэгт 212. Сорилын 2 дугаар даалгаврын гүйцэтгэл (Биеийн тамир, 11 дүгээр анги)*

| *Хариултын хувилбар* | *Гүйцэтгэлийн хувь* | *Зөв хариулт* |
|---|---|---|
| А | 44.6 | + |
| Б | 8.9 | |
| В | 10.8 | |
| Г | 33.1 | |
| Хүчингүй хариулт | 1.5 | |
| Огт хариулаагүй | 1.1 | |

Сурагчдын даалгаврын гүйцэтгэлийн үр дүнгээс харахад 44.6 хувь нь А хувилбар буюу зөв хариултыг сонгосон байна. Харин 45.4 хувь нь буруу хариултыг сонгосон байгаа нь сурагчид бие бялдраа хөгжүүлэх, уян хатан байдлаа үнэлэх суурь мэдлэг ойлголт дутмаг байгааг харуулж байна. Энэ даалгаврын хүндрэлийн зэрэг нь тохиромжтой, ялгах чадвар нь сул даалгавар болохыг тестан программын шинжилгээний үр дүн харуулж байна.

Даалгавар 3.

*Даалгаврын зорилго*: Хөл бөмбөгийн тэмцээний үед чөлөөт цохилт хийх тохиолдлыг нэрлэх

*Хүснэгт 213. Сорилын 3 дугаар даалгаврын гүйцэтгэл (Биеийн тамир, 11 дүгээр анги)*

| *Хариултын хувилбар* | *Гүйцэтгэлийн хувь* | *Зөв хариулт* |
|---|---|---|
| А | 3.2 | |
| Б | 72.9 | + |
| В | 17.7 | |
| Г | 3.9 | |
| Хүчингүй хариулт | 0.9 | |
| Огт хариулаагүй | 1.3 | |

Даалгаврын гүйцэтгэлийн үр дүнгээс харахад 72.9 хувь нь Б хувилбар буюу зөв хариултыг сонгосон байгаа нь хөл бөмбөгийн чөлөөт цохилтын талаарх мэдлэг хангалттай байна. Энэхүү даалгаврын хүндрэлийн зэрэг нь хөнгөн, ялгах чадвар нь дундаж даалгавар болохыг тестан программын шинжилгээний үр дүн харуулж байна.

Даалгавар 4.

*Даалгаврын зорилго:* Хөнгөн атлетикийн гүйлтээс уртад харайх аргыг нэрлэх

*Хүснэгт 214. Сорилын 4 дүгээр даалгаврын гүйцэтгэл (Биеийн тамир, 11 дүгээр анги)*

| *Хариултын хувилбар* | *Гүйцэтгэлийн хувь* | *Зөв хариулт* |
|---|---|---|
| А | 18.2 | + |
| Б | 6.3 | |
| В | 72.1 | |
| Г | 2.4 | |
| Хүчингүй хариулт | 0.0 | |
| Огт хариулаагүй | 1.1 | |

Даалгаврын гүйцэтгэлийн үр дүнгээс харахад 18.2 хувь нь А хувилбар буюу зөв хариултыг сонгосон байна. Харин 72.1 хувь нь В хувилбар буюу буруу хариултыг сонгосон байгаа нь тухайн төрлийн техникийн талаарх мэдлэг дутмаг нөгөө талаас даалгаврын хүндрэлийн зэрэг хүнд, ялгах чадвар сул байгаа нь нөлөөлсөн байх талтай. байна.

*Ойлголтыг илрүүлэх даалгаврын шинжилгээ*

Даалгавар 5.

*Даалгаврын зорилго:* Сагсан бөмбөгийн шүүгчийн заалтыг унших, ойлгох

*Хүснэгт 215. Сорилын 5 дугаар даалгаврын гүйцэтгэл (Биеийн тамир, 11 дүгээр анги)*

| *Хариултын хувилбар* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|
| 2 оноо авсан | 1.3 |
| 1 оноо авсан | 63.9 |
| Буруу хариулсан | 31.1 |
| Огт хариулаагүй | 3.7 |

*Шинжилгээний үр дүн, асуудал*

Даалгаврын гүйцэтгэлийн үр дүнгээс харахад 63.9 хувь зургийг хараад шүүгчийн 1 заалтыг, 1.3 хувь нь зургийг хараад шүүгчийн 2 заалтыг ойлгож, бичсэн байна. Харин буруу хариулсан болон огт хариулаагүй сурагчид 34.8 хувь байгаа нь сагсан бөмбөгийн шүүлтийн талаар ойлголт бага байна.

Даалгавар 6.
*Даалгаврын зорилго:* Сагсан бөмбөгийн дамжуулалтын талаарх ойлголтыг илрүүлэх

*Хүснэгт 216. Сорилын 6 дугаар даалгаврын гүйцэтгэл (Биеийн тамир, 11 дүгээр анги)*

| *Хариултын хувилбар* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|
| 2 оноо авсан | 15.5 |
| 1 оноо авсан | 11.4 |
| Буруу хариулсан | 69.4 |
| Огт хариулаагүй | 3.7 |

Даалгаврын гүйцэтгэлийн үр дүнгээс харахад 15.5 хувь нь 2 оноо, 11.4 хувь нь 1 оноо авсан байна. Харин 69.4 хувь нь буруу хариулсан байгаагаас харахад сагсан бөмбөгийн дамжуулалтын талаар ойлголт сул байна.

Даалгавар 7.

*Даалгаврын зорилго:* Волейболын дүрмийн талаарх ойлголтыг илрүүлэх

*Хүснэгт 217. Сорилын 7 дугаар даалгаврын гүйцэтгэл (Биеийн тамир, 11 дүгээр анги)*

| *Хариултын хувилбар* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|
| 2 оноо авсан | 62.1 |
| 1 оноо авсан | 9.0 |
| Буруу хариулсан | 23.0 |
| Огт хариулаагүй | 5.9 |

Даалгаврын гүйцэтгэлийн үр дүнгээс харахад 62.1 хувь нь 2 оноо, 9.0 хувь нь 1 оноо авсан байгаа нь сурагчдын волейболын дүрмийн талаарх ойлголт боломжийн байна.

Даалгавар 8.

Даалгаврын зорилго: Монголын ба олон улсын спортын хөгжлийн талаарх ойлголтыг илрүүлэх

*Хүснэгт 218. Сорилын 8 дугаар даалгаврын гүйцэтгэл (Биеийн тамир, 11 дүгээр анги)*

| *Хариултын хувилбар* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|
| 2 оноо авсан | 54.9 |
| 1 оноо авсан | 40.3 |
| Буруу хариулсан | 1.8 |
| Огт хариулаагүй | 3.1 |

Даалгаврын гүйцэтгэлийн үр дүнгээс харахад 54.9 хувь нь 2 оноо, 40.3 хувь нь 1 онооны хариулт гүйцэтгэсэн байгаа нь сургалтын цөм хөтөлбөрт тусгасан монголын ба олон улсын спортын хөгжлийн талаарх ойлголт дундаж гүйцэтгэлтэй болохыг харуулж байна.

*Мэдлэг, ойлголтоо хэрэглэх түвшний даалгаврын шинжилгээ:*

Даалгавар 9.

*Даалгаврын зорилго*: Волейболын давуулалтын чадварыг илрүүлэх

*Хүснэгт 219. Сорилын 9 дүгээр даалгаврын гүйцэтгэл (Биеийн тамир, 11 дүгээр анги)*

| *Шалгуур* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|
| 1 давуулалт гүйцэтгэсэн | 16.8 |
| 2 давуулалт гүйцэтгэсэн | 37.5 |
| 3 давуулалт гүйцэтгэсэн | 33.7 |
| давуулж чадаагүй | 12.0 |

Даалгаврын гүйцэтгэлийн үр дүнгээс харахад сорилд хамрагдсан сурагчдын 12.0 хувь давуулалт гүйцэтгэж чадаагүй байгаа нь “волейбол” бүлэг сэдвээр эзэмшсэн чадвар гүйцэтгэл сул байна. Гүйцэтгэлийн дундаж 29.3 хувь байна.

Даалгавар 10.

*Даалгаврын зорилго:* Байрнаас уртад харайх чадварыг илрүүлэх.

Судлагаанд хамрагдсан 11 дүгээр ангийн сурагчдаас санамсаргүй түүврийн аргаар сонгож дээрх даалгаврыг гүйцэтгүүлсэн. Энэ даалгаврын шалгуурыг монголын хүүхэд залуучуудын шалгуур үзүүлэлтийн 16 настай хүүхдүүдийн дунджаас дээгүүр түвшинг дээд хязгаар болгон авсан.

*Хүснэгт 220. Сорилын 10 дугаар даалгаврын гүйцэтгэл (Биеийн тамир, 11 дүгээр анги)*

| *Шалгуур* | *Хүйс* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|
| Гүйцэтгэж чадаагүй | эр | 1.0 |
| | эм | |
| 160-169 см | эр | 4.3 |
| 120-129 см | эм | |
| 170-179 см | эр | 5.3 |
| 130-139 см | эм | |
| 180-189 см | эр | 11.5 |
| 140-149 см | эм | |
| 190-199 см | эр | 19.2 |
| 150-159 см | эм | |
| 200-209 см | эр | 16.8 |
| 160-169 см | эм | |
| 210-219 см | эр | 41.8 |
| 170-180 см | эм | |

Даалгаврын гүйцэтгэлийн үр дүнгээс харахад ихэнх буюу 41.8 хувь нь дундаж хувьтай гүйцэтгэсэн байна. Харин 19.2 хувь нь дундажаас доогуур хувьтай гүйцэтгэсэн байгаа нь бие бялдрын хөгжил, чийрэгжилт бүлэг сэдвээр эзэмшсэн чадвар бага байгааг харуулж байна.

Бүрэн дунд боловсролын биеийн тамирын сорилын даалгаврын гүйцэтгэлийн үр дүнг зургаар харуулав.

*Хүснэгт 221. Сорилын нийт гүйцэтгэл (Биеийн тамир, 11 дүгээр анги)*




Биеийн тамирын сорилын гүйцэтгэл хэвийн тархалтаас баруун, зүүн тийш шилжсэн байгаа нь анхаарал татаж байна.

Бүрэн дунд боловсролын биеийн тамирын сорилын гүйцэтгэлийн үр дүнгээс харахад:

- Судалгаанд хамрагдсан 11 дүгээр ангийн сурагчдын биеийн тамирын сорилын гүйцэтгэл 37.0 хувь байна.
- Сурагчдын биеийн тамирын сургалтын хөтөлбөрт тусгасан бие бялдрын хөгжил, чийрэгжилт, хөнгөн атлетик, хөл бөмбөг, сагсан бөмбөг, волейбол, монголын ба олон улсын спортын хөгжлийн бүлэг сэдвээрх мэдлэг, ойлголтыг эзэмшсэн байдал 42.0 хувь байна.
- Сурагчдын мэдлэгээ хэрэглэх чадварын гүйцэтгэлийн дундаж 29.9 хувь байгаа нь спорт заалын хүрэлцээ, сургалтын орчин хэрэглэгдэхүүний хангалт, ашиглалттай холбоотой байх талтай.

### *Бүрэн дунд боловсролын сорилын дүгнэлт*

*Хүснэгт 222. Бүх хичээлийн даалгаврын найдвартай байдал (11 дүгээр анги)*

Reliability Statistics

| Cronbach's Alpha | N of Items |
|---|---|
| .732 | 13 |

Сорилд хамрагдсан 11 дүгээр ангийн ерөнхий гүйцэтгэлийг 12 хичээл тус бүрийн гүйцэтгэлтэй харьцуулахад найдвартай байдал боломжийн (acceptable) түвшинд байна.

*Хүснэгт 223. Бүх хичээлийн даалгавруудын гүйцэтгэлийн хамаарал (11 дүгээр анги)*

Correlations

| | | |
|---|---|---|
| mat11_percent | Pearson Correlation | .632** |
| | Sig. (2-tailed) | 0.000 |
| med11_percent | Pearson Correlation | .260** |
| | Sig. (2-tailed) | 0.000 |
| mon11_percent | Pearson Correlation | .659** |
| | Sig. (2-tailed) | 0.000 |
| eng11_percent | Pearson Correlation | .666** |
| | Sig. (2-tailed) | 0.000 |
| bio11_percent | Pearson Correlation | .518** |
| | Sig. (2-tailed) | 0.000 |
| fiz11_percent | Pearson Correlation | .387** |
| | Sig. (2-tailed) | 0.000 |
| gaz11_percent | Pearson Correlation | .556** |
| | Sig. (2-tailed) | 0.000 |
| tuu11_percent | Pearson Correlation | .348** |
| | Sig. (2-tailed) | 0.000 |
| nii11_percent | Pearson Correlation | .372** |
| | Sig. (2-tailed) | 0.000 |
| diz11_percent | Pearson Correlation | .401** |
| | Sig. (2-tailed) | 0.000 |
| niit11_percent | Pearson Correlation | 1 |
| | Sig. (2-tailed) | |

**. Correlation is significant at the 0.01 level (2-tailed).

*. Correlation is significant at the 0.05 level (2-tailed).

Дээрх хүснэгтээс харахад бүх хичээлүүдийн сорилын даалгаврын гүйцэтгэл эерэг хамааралтай байна.

*Хүснэгт 224. Бүх хичээлийн даалгаврын гүйцэтгэл (11 дүгээр анги)*

| *д/д* | *Хичээл/ судлагдахууны нэр* | *Mean* | *Median* | *Mode* | *Minimum* | *Maximum* | *Std. Deviation* |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Математик | 23.5 | 20.0 | 13.3 | 0.0 | 90.0 | 16.0 |
| 2 | Мэдээлэл зүй | 34.6 | 40.0 | 40.0 | 0.0 | 80.0 | 16.8 |
| 3 | Монгол хэл | 55.1 | 60.0 | 60.0 | 0.0 | 90.0 | 19.5 |
| 4 | Англи хэл | 40.2 | 40.0 | 10.0 | 0.0 | 100.0 | 25.5 |
| 5 | Биологи | 29.1 | 29.4 | 32.1 | 7.9 | 50.9 | 7.1 |
| 6 | Хими | 27.7 | 23.1 | 23.1 | 0.0 | 84.6 | 16.6 |
| 7 | Физик | 12.3 | 7.7 | 7.7 | 0.0 | 84.6 | 12.3 |
| 8 | Газар зүй | 49.4 | 53.8 | 53.8 | 0.0 | 92.3 | 17.9 |
| 9 | Монголын түүх | 33.3 | 33.3 | 20.0 | 0.0 | 80.0 | 16.7 |
| 10 | Нийгмийн ухаан | 35.2 | 38.5 | 38.5 | 0.0 | 76.9 | 14.7 |
| 11 | Дизайн технологи | 34.3 | 32.0 | 28.0 | 0.0 | 100.0 | 14.6 |
| 12 | Биеийн тамир | 37.0 | 28.0 | 20.0 | 0.0 | 84.0 | 22.2 |

- Бүрэн дунд боловсролын 11 дүгээр ангийн сурагчдын гүйцэтгэл 34.25 хувь, нийт хичээлийн хувьд хамгийн өндөр гүйцэтгэл нь 50.9-100 хувьтай, хамгийн бага гүйцэтгэл нь 0-7.7 хувьтай байгаа нь сурагчдын мэдлэг, чадварын түвшин харилцан адилгүй, ихээхэн зөрүүтэй байгааг харуулж байна.
- Математик, байгалийн ухааны хичээлүүдийн сорилын гүйцэтгэл 30 хувь хүртэлх гүйцэтгэлтэй, Мэдээлэл зүй, Монголын түүх, Нийгмийн ухаан, Дизайн технологи, Биеийн тамирын сорилын гүйцэтгэл 30-40 хувь, харин Монгол хэл, Англи хэл, Газар зүйн сорилын гүйцэтгэл 40-өөс 55 хүртэлх хувьтай байна.
- Сорилын гүйцэтгэлийн тархалтын хувьд стандарт хазайлт нь 15 хувиас бага хазайлттай 4 хичээл, 15-18 хүртэлх хувийн хазайлттай 4 хичээл, 19-25.5 хүртэлх хувийн хазайлттай 4 хичээл байна.
- 11 дүгээр ангийн сорилын ерөнхий гүйцэтгэлийг хичээл тус бүрийн гүйцэтгэлийн хувьтай харьцуулахад Математик, Монгол хэл, Англи хэл, Биологи, Газар зүйн сорилын гүйцэтгэлтэй эерэг хүчтэй )Pearson Correlation > 0.5 , Sig. )2-tailed 0.0( хамааралтай, бусад хичээлийн хувьд )0.07< Pearson Correlation < 0.5, Sig. )2-tailed 0.0( эерэг хамааралтай байна. Эндээс бүх хичээлийн сорилын даалгаврууд хоорондоо сайн зохицсон байна гэсэн дүгнэлтийг гаргах боломжтой.

# Бүрэн дунд боловсролын түвшинд суралцагчдын мэдлэг, чадвар, хандлага ба нөлөөлж буй хүчин зүйлс

## Ахлах ангийн сурагчдын мэдлэг, ойлголтыг үнэлэх даалгаврын гүйцэтгэлд хийсэн шинжилгээ

Ахлах ангийн сурагчдын мэдлэг, ойлголтыг үнэлэх нийт даалгаврын гүйцэтггэл нь 37.0 хувьтай байна.

Эдгээрийг судлагдахуун тус бүрээр авч үзэхэд, математикийн мэдлэг, ойлголт нь 50 гаруй, биологи, газар зүй, түүхийн ойлголт мэдлэг нь 40 гаруй хувьтай, харин хими, нийгэм, мэдээллийн технологийн мэдлэг, ойлголт харьцангуй сул байна.

*Зураг 119. Ахлах ангийн сурагчдын мэдлэгийн түвшин, судлагдахуунаар*



| | дизайн зураг | математик | газар зүй | биеийн тамир | түүх | нийгэм | физик | хими | биологи | мэдээллийн технологи | англи хэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Series1 | 33 | 53 | 48 | 35 | 48 | 26 | 42 | 15 | 49 | 28 | 34 |

Бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрөөр эзэмших танин мэдэхүйн чадамж нь шинжлэх ухааны үндэс, түүний гүнзгийрлийг эзэмшихэд чиглэдэг.

Судалгаанд хамрагдсан ахлах ангийн сурагчдын бодлогыг өгөгдсөн аргаар бодох математикийн мэдлэг ойлголт нь бусдаасаа илүү байна.

Биологи, түүх, газар зүйн судлагдахууны талаарх шинжлэх ухааны мэдлэг тодорхой түвшинд эзэмшсэн боловч хангалтгүй гэж дүгнэж болохуйц харагдлаа.

Дизайн зураг зүй, биеийн тамир, нийгэм, мэдээллийн технологи, англи хэлний судлагдахууны шинжлэх ухааны үндсэн суурь мэдлэг нь маш сул түвшинд дүгнэгджээ.

Ахлах ангийн сурагчдын англи хэлний хичээлийн мэдлэгийн эзэмшилтэд хот, хөдөөгийн ялгаатай байдал ажиглагдлаа. ($r = -.407^{**}$; $p < 0.01$)

*Зураг 120. Ахлах ангийн сурагчдын англи хэлний мэдлэгийн гүйцэтгэлийн хувь, хот, хөдөөгөөр*




Улаанбаатар хотын сурагчдын англи хэлний мэдлэг ойлголтыг үнэлэх даалгаврын гүйцэтгэлийн түвшин 50 хувьтай байхад, хөдөөний сургуулийн сурагчдынх 30 хүрэхгүй хувьтай байгаа тул англи хэлний сургалтын чанар хөдөөд хангалтгүй түвшинд байгааг илэрхийлж байна.

Сургуулийн өмчийн хэлбэр ба математикийн судлагдахууны мэдлэг, ойлголтын үнэлгээний хооронд статистик ач холбогдолтой ялгаатай байна ($r=.334^{**}$ ; $p<0.01$).

Хувийн өмчийн сургуулийн сурагчдын мэдлэг, ойлголтыг үнэлэхэд чиглэсэн даалгавруудын гүйцэтгэлийн түвшин бараг 80 хувьтай байхад төрийн өмчийн сургуулийнх дунджаар 50 хувьтай буюу харьцангуй сул үзүүлэлттэй байна.

*Зураг 121. Ахлах ангийн сурагчдын математикийн мэдлэгийн гүйцэтгэлийн хувь, сургуулийн өмчийн хэлбэрээр*




Хувийн өмчийн сургуулийн матемтикийн хичээлийн чанар төрийн өмчийн сургуулиас харьцангуй сайн байна. Үүнд анги дүүргэлт, багшийн ур чадвар, судлагдахууны нэмэлт агуулга, гүнзгийрэл нөлөөлсөн байх бүрэн боломжтой. Нөгөөтэйгүүр бусад шинжлэх ухааны суурь нь, сэтгэхүйн хөгжлийн үндэс нь математик тул төрийн өмчийн сургуулийн сургалтын чанарыг дээшлүүлэхийг бодлогоор дэмжих зайлгүй хэрэгцээ шаардлага тулгарчээ.

Энэхүү шинжилгээнээс дараах дүр зураг харагдаж байна. Ахлах ангийн сурагчдын шинжлэх ухааны үндэсийн талаарх ойлголт мэдлэг сул байна.

- Математикийн судлагдахууны шинжлэх ухааны мэдлэг нь бусад судлагдахуунтай харьцуулахад илүү. Ялангуяа, хувийн өмчийн сургуулийн сурагчдын тухайн мэдлэг төрийн өмчийн сургуулийн сурагчдын гүйцэтгэлтэй харьцуулахал сайн байна.
- Хөдөө орон нутгийн сурагчдын англи хэлний холбоос хэрэглэж өгүүлбэр бүтээх, эхийг ойлгож нэгтгэн дүгнэж асуултад хариулах чадвар хангалтгүй байгаа нь дүрмийн мэдлэг, үгийн нөөц хангалтгүй байгааг илэрхийлж байна.
- Сурагчдын нийгэм, мэдээллийн технологийн мэдлэгийг илүү системтэй гүн бат олгоход сургалтын агуулга, арга зүйн дэмжлэг чухал болох нь харагдлаа.
- Сурагчдын химийн судлагдахууны ухагдахууны талаарх ойлголт маш сул байгаа нь энэ талын сургалтыг сайжруулах хэрэгцээ шаардлагыг бий болгож байна.

## Ахлах ангийн сурагчдын чадварыг үнэлэх даалгаврын гүйцэтгэлд хийсэн шинжилгээ

Ахлах ангийн сурагчдын чадварыг үнэлэх даалгаврын гүйцэтгэлийн нийт дундаж хувь нь 34 байна. Сурагчдын ур чадварыг мэдээлэл боловсруулах, туршилт хийх ур чадвар гэж 2 хэсэгт хуваан үзсэн.

Сурагчдын мэдээлэл боловсруулах, асуудлыг шийдвэрлэх чадвар нь 36.0 хувьтай байна. Иймд сурагчдын судлагдахуунаар эзэмших чадвар хангалтгүй гэж дүгнэж болохуйц дүр зураг харагдлаа.

Сурагчдын мэдээлэл боловсруулах, асуудал шийдвэрлэх ур чадварын эзэмшилтэд судлагдахуун тус бүрийн үзүүлж байгаа дэмжлэгийг харах үүднээс харьцуулбал,

математик 55.0 хувьтай бусад хичээлтэй харьцуулахад илүү үүрэгтэй гэж дүгнэхээр байна.

Судлагдахууны мэдлэгээ ашиглан мэдээлэлтэй ажиллах, асуудлыг оновчтой шийдвэрлэх чадварын түвшин нь түүх, биеийн тамирын судлагдахууны хувьд 40 гаруй хувьтай, англи хэл газар зүй, дизайн зураг зүй, физик, мэдээллийн технологийн чадвар нь 30 гаруй хувьтай байна.

Хими, нийгмийн судлагдахууны мэдлэгтэй холбоотой мэдээлэл боловсруулах, асуудлыг шийдвэрлэх чадвар нь бусад хичээлтэй харьцуулахад сурагчдын гүйцэтгэл сул байлаа.

*Зураг 122. Ахлах ангийн сурагчдын мэдээлэл боловсруулах, асуудал шийдвэрлэх чадварын гүйцэтгэлийн хувь, судлагдахуунаар*




Бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрийн гол зорилго болох суралцагчдад судалгааны арга, бие даан бүтээлчээр суралцах чадварыг эзэмшүүлэхэд дэмжлэг болохуйц, түүний хэрэгжилтийн үйл явцыг үнэлэх боломжтой шалгуур болох мэдээллийг боловсруулан, асуудлыг шийдвэрлэх ур чадварыг төлөвшүүлэхэд судалгаа шинжилгээ хийх, сургалтын хөтөлбөрийн төлөвлөлт, агуулга, арга зүйг сайжруулах бодит хэрэгцээ шаардлага үүссэн байна.

Англи, хэл, түүхийн судлагдахуунаар эзэмших мэдээлэлтэй ажиллах, шийдвэр гаргах чадвар нь сургуулийн байршлаар ялгаатай түвшинтэй байна ($r= .304^{**}$; $-.297^{**}$; $p<0.01$).

*Хүснэгт 225. Ахлах ангийн сурагчдын англи хэл, түүхийн судлагдахуунаар мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах чадварын үзүүлэлтийн хувь, сургуулийн байршлаар*

| *Судлагдахуун* | *Англи хэл* | *Түүх* |
|---|---|---|
| Даалгавар<br>Сургуулийн байршил | Харилцан яриаг ойлгож оновчтой хариултыг олох, товч мэдээллийг ойлгон оновчтой шийдвэр гаргах чадвар (%) | Хадны зургийг таньж ойлгон, таамаглал дэвшүүлэн, оновчтой шийдвэр гаргах чадвар (%) |
| Нийслэл | 72 | 3 |
| Аймаг | 58 | 5 |
| Сум | 30 | 29 |

Англи хэлний хичээлээр мэдээлэлтэй ажиллан, шийдвэр гаргах чадвар нь хотын сургуулийн сурагчдынх харьцангуй сайн харин сумын сургуулийн сурагчдынх хангалтгүй түвшинд байна.

Түүхийн мэдээлэлтэй ажиллах ялангуяа хадны сүг зургийг таньж ойлгох чадвар нийслэл, аймгийн сургуулийн сурагчдад маш сул байна. Сумын сургуулийн хүүхдүүдэд харьцангуй илүү үзүүлэлттэй байгаа ч түүхийн судлагдахууны энэ талын мэдлэг, чадварын сул

байдалд бодит дүгнэлт хийж, сайжруулалтыг хийх арга замуудыг хэрэгжүүлэх нь сурагчдын нийгмийн үнэт зүйлийн эзэмшилт, хувь хүний хөгжилд дэмжлэг болно.

Сургуулийн өмчийн хэлбэрээс математик, физик, биологийн судлагдахуунаар эзэмших мэдээлэлтэй ажиллах, шийдвэр гаргах чадварын эзэмшилт хамааралтай байна ($r=.368^{**}$; $r=.321^{**}$; $r=.353^{**}$; $p<0.01$).

*Хүснэгт 226. Ахлах ангийн сурагчдын мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах чадварын үзүүлэлтийн хувь, сургуулийн байршлаар*

| *Судлагдахуун* | *Математик* | *Физик* | *Биологи* |
|---|---|---|---|
| Даалгавар / Сургуулийн өмчийн хэлбэр | Өгөгдсөн утгыг ойлгож даалгаврыг зөв гүйцэтгэх бүтээлч чадвар (%) | Мэдлэгийг ахуй амьдралын тодорхой нөхцөлд хэрэглэх бүтээлч чадвар (%) | Ургийн бүтэц, түүний химийн холбоог таних чадвар (%) |
| Төрийн өмчийн сургууль | 33 | 10 | 26 |
| Хувийн өмчийн сургууль | 74 | 30 | 58 |

Төрийн өмчийн сургуулийн суралцагчдын дээрх 3 судлагдахууны мэдээлэлтэй бүтээлчээр ажиллах, оюун дүгнэлт гаргах чадвар нь хувийн өмчийн сургуулийн суралцагчдын гүйцэтгэлтэй харьцуулахад харьцангуй сул байна. Энэ нь сургалтын хөтөлбөрийн агуулгын гүнзгийрэл, багшийн ур чадвар, хүүхдийн тооноос хамаарахаас гадна сургалтын материаллаг орчин, хэрэглэгдэхүүний ялгаатай байдлаас шалтгаалах бүрэн боломжтой юм.

Суралцагчдын туршилт хийх ур чадвар нь 32.0 хувьтай буюу сул түвшинд байна. Эдгээрийг судлагдахуун тус бүрээр нь харахад, дизайн, зураг зүй технологийн судлагдахуун нь сурагчдад бүтээлч чадварыг эзэмшихэд нь харьцангуй илүү дэмжлэг үзүүлж байгаа дүр зураг шинжилгээний үр дүнгээс харагдлаа.

*Зураг 123. Ахлах ангийн сурагчдын бүтээлчээр ажиллах, туршилт хийх чадварын үзүүлэлт, судлагдахуунаар*




Биеийн тамирын судлагдахуунаар суралцагчдын дасгал хөдөлгөөн хийх, спорт тоглоомын техник эзэмшилт дундаж түвшинд байна.

Англи хэлний судлагдахуунаар санаагаа дэс дараатай илэрхийлэх, физикийн судлагдахууныг ахуй амьдралын хүрээнд ойлгох, математикийн мэдлэгийг тодорхой нөхцөлд бүтээлчээр хувиргах, түүхийн судлагдахуунаар түүхэн үйл явдлыг ойлгож дүгнэлт хийх, компьютертай ажиллах чадвар хангалтгүй түвшинд байна. Харин хими, газар зүйн мэдлэг, чадварыг амьдрал үйл ажиллагааны нөхцөлд хэрэглэх чадвар маш сул түвшинд байна. Англи хэлний судлагдахууны тухайн чадвар нь Улаанбаатар хотын сургуулийн сурагчдад харьцангуй илүү, сумын сурагчдад сул түвшинд байна ($r=-.375^{**}$ $p<0.01$).

Математик, физик, биологи, англи хэлний судлагдахуунаар эзэмших бүтээлчээр үйлдэх ур чадвар ба сургуулийн өмчийн хэлбэрийн хооронд статистик ач холбогдолтой ялгаа харагдлаа. ($r= .465^{**}$; $.256^{**}$; $.328^{**}$ $p<0.01$)

*Хүснэгт 227. Ахлах ангийн сурагчдын бүтээлч, туршилт хийх чадварын үзүүлэлтийн хувь сургуулийн өмчийн хэлбэрээр*

| *Судлагдахуун* | *Математик* | *Физик* | *Биологи* | *Англи хэл* |
|---|---|---|---|---|
| Даалгавар<br><br>Сургуулийн өмчийн хэлбэр | Мэдлэгээ янз бүрийн нөхцөлд бүтээлчээр хувирган хэрэглэх (%) | Мэдлэгээ ахуй амьдралтай холбон ойлгож хэрэглэх | Мэдлэгийг хэрэглэн бодисыг таних, зургийг ойлгон өөрчлөлтийг танин дүгнэлт гаргах чадвар (%) | Санаагаа дэс дараатай илэрхийлэх (%) |
| Төрийн өмчийн сургууль | 11 | 5 | 24 | 30 |
| Хувийн өмчийн сургууль | 35 | 17 | 41 | 58 |

Хувийн өмчийн сургуулийн сурагчдын англи хэл, биологи, математикийн бүтээлч чадвар нь төрийн өмчйин сургуулийн сурагчдаас харьцангуй илүү байна.

Бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрөөр суралцагчдын бүтээлчээр ажиллах чадвар харьцангуй сул байна.

*Зураг 124. Ахлах ангийн сурагчдын мэдлэг, чадварын үзүүлэлтийн хувь*




Зургаас харахад, бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй түвшинд байна.

Сурагчдын чадварыг үнэлэх шинижилгээний үр дүнгээс дараах дүр зураг харагдаж байна. Ахлах ангийн сурагчдын мэдлэг, мэдээлэлтэй ажиллах, мэдлэгээ хэрэглэх чадвар хангалтгүй түвшинтэй байна. Ялангуяа, бүтээлчээр ажиллах, туршилт хийх ур чадвар сул түвшинд байна.

- Сурагчдын мэдлэгээ амьдрал үйл ажиллагаанд хэрэглэх чадварыг үнэлсэн үзүүлэлт нь сургуулийн байршил, өмчийн хэлбэрээс хамаарч байгаа тул хүчин зүйлүүдэд

бодитоор үнэлгээ хийж, ялгаатай байлдлыг багасгах, юуны өмнө сургалтын материаллаг орчин, багшлах хүчний чанарт анхаарч ажиллах

- Хөдөө орон нутаг, сумын сургуулийн сургалтын чанарыг дээшлүүлэх, ялангуяа англи хэлний сургалтын чанарыг нэмэгдүүлэхэд анхаарал хандуулах шаардлагатай байна.

## Суралцах хэв шинж ба сурагчдын гүйцэтгэл

Бид сурагчдын сурадлцах хэв шинжийг танин мэдэхүйн үйлүүдээр авч үзэхдээ тухайн үйлийг сурагчид хичээл дээр гүйцэтгэх хэр дуртай байгааг тодруулан анхаарлаа хандуулсан болно. Судалгаагаар дараах дүр зураг харагдаж байна.

### *Анхаарал*

*Хүснэгт 228. Анхаарлын чадваруудын хариулт багш, сурагчдынхаар (ахлах анги)*

| Танин мэдэхүй | Багшийн үнэлгээ | Сурагчдын өөрийн үнэлгээ |
|---|---|---|
| Анхаарал | 65.3 | 71.4 |

Ахлах ангийн сурагчдын 54.5 хувь нь хичээл дээр анхаарлын шилжилт шаардсан үйл хийх дуртай гэсэн бол 65.1 хувь нь анхаарлаа төвлөрүүлэн хичээлийг эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд үйлдэл хийх дуртай гэсэн байна.Анхаарлын шилжилт, сэтгэхүйн хурд шаардсан ажлыг 61.1 хувь нь хийх дуртай гэсэн бол хичээл дээр анхаарлаа тогтвортой төвлөрүүлэн суух дуртай гэж 68 хувь нь хариулсан байна.

Байршлаар нь авч үзэхэд нийслэлийн сурагчдын 62.3 хувь нь анхаарлын хуваарилалт шаардсан үйл хийх дуртай гэсэн бол орон нутгийн сурагчдын 50.8 хувь нь дуртай гэж хариулжээ. Унтах цагаар нь авч үзэхэд 20-21 цагт болон 21-22 цагт унтдаг сурагчдын 58.8 хувь нь анхаарлын шилжилт, хуваарилалт шаардсан ажил хийх дуртай гэж хариулжээ.

Зориудаар анхаарлаа нэгээс нөгөөд шилжүүлэх үйлийг хийх дуртай гэж нийслэлийн сурагчдын 64.5 хувь, орон нутгийн сурагчдын 59.5 хувь нь хийх дуртай гэжээ

*Хүснэгт 229. Сурагчдын анхаарлаа төвлөрүүлэх чадварыг хугацаагаар илэрхийлсэн нь (багшийн хариулт)*

| *Хүүхдүүд хичээл дээр анхаарлаа төвлөрүүлэх хугацаа (ойролцоогоор)* | *ахлах анги* |
|---|---|
| 3-5 минут | 13.3% |
| 5-10 мин | 33.8% |
| 10-15 мин | 39.7% |
| 15-20 мин | 13.2% |

Сурагчид хичээлийг эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд анхааралтай байх дуртай гэж нийслэлийн сурагчдын 61.0 хувь, орон нутгийн сурагчдын 71.0 хувь нь үзсэн . Багш нарын үзэж байгаагаар ахлах ангийн 39.7хувь нь сурагчдын анхаарал төвлөрөх хугацаа ойролцоогоор 10-15 мин байна гэжээ.

*Хүснэгт 230. Анхаарлын тогтворжилт ба багш нарын дэмжлэг*

| *Хүүхдүүд хичээл дээр дасгал даалгаврыг хурдан, зөв гүйцэтгэхэд*: | *Ахлах анги* |
|---|---|
| багшийн дэмжлэг шаардлага хэрэгтэй | 353. |

Сургалтын явцад ахлах ангийн сурагчдын 64.7 хувь нь дасгал даалгаврыг хурдан зөв гүйцэтгэхэд багшийн дэмжлэг хэрэгтэй гэж үзсэн бол багш нарын 35.3 хувь нь үзсэн байна.

### *Ой тогтоолт*

Танин мэдэхүйн зориудын үйлдлийн хөгжлийн түвшинг илэрхийлдэг гол үзүүлэлт болох богино хугацааны хараа, сонорын ой тогтоолт, утгын ой тогтоолтыг сурагчдын өөрийн үнэлгээнд тулгуурлан авч үзэв.

*Хүснэгт 231. Ахлах ангийн сурагчдын сонор, хараа, утгын ой тогтоолтын үзүүлэлт (багш, сурагчийн хариулт)*

| *Ой тогтоолтын чадвар* | *Багшийн үнэлгээ* | *Сурагчдын өөрийн үнэлгээ* |
|---|---|---|
| Сонорын ой тогтоолт | 61.2 | 66.9 |
| Харааны ой тогтоолт | 85.3 | 75.3 |
| Утгын ой тогтоолт | 50.0 | 44.1 |

Сурагчдын сонсоод мэдээллийг тогтоох нь сайн гэж багш нарын 61 хувь нь үзсэн бол сурагчдын 67 хувь нь тухайн чадвар сайн гэж өөрсдийгөө дүгнэжээ. Энд сурагчдын өөрийн үнэлгээ нь илүү байна.

Сурагчдын хараад тогтоох мэдээллийг тогтоох чадвар нь сайн гэж багш нарын 85 хувь нь үзсэн байхад сурагчдын 75 хувь нь өөрсдийгөө тухайн чадвар сайн гэж үнэлжээ. Энд багшийн үнэлгээ нь харьцангуй дээгүүр байна.

Сурагчдын мэдээллийг утгачлан тогтоох чадвар нь сайн гэж багш нарын 50 хувь үзсэн байхад сурагчдын 44 хувь өөрсдийгөө тухайн чадвар сайтай гэж үнэлжээ.

Ахлах ангийн сурагчды н хараад мэдээллийг тогтоох чадвар нь сайн гэж багш сурагчдын аль аль нь үнэлсэн бол утгаар мэдээллийг тогтоох нь сул болохыг багш сурагчдын аль аль нь үнэлжээ.

*Зураг 125. Ахлах ангийн сурагчдын ой тогтоолтын онцлог, байршлаар*




Улаанбаатар хотын сурагчид мэдээллийг илүү харж, уншиж тогтоодог гэж өөрсдийгөө үнэлжээ. Гэтэл бичиж тогтоох дургүй гэж ихэнх нь үзсэн байна.

Хотын сурагчидтай харьцуулахад хөдөө орон нутгийн сурагчид мэдээллийг харж, сонсож, бичиж тогтоох дуртай гэж хариулсан байна. Ялангуяа, хотын сурагчидтай харьцуулахад хөдөө орон нутгийн сурагчид мэдээллийг бичиж тогтоох дуртай байна.

### *Сэтгэхүй*

Ахлах ангийн сурагчдын хувьд ЕБС-ийн хөтөлбөрөөр орж буй хичээлүүд нь хийсвэр сэтгэхүй хөгжил дээр тулгуурладаг.

*Хүснэгт 232. Бүрэн дунд боловсролын түвшинд суралцаж буй сурагчдын сэтгэхүйн үйлдэл, багш, сурагчийн хариулт*

| *Сэтгэхүйн үйлдлүүд* | *Багшийн үнэлгээ* | *Сурагчдын өөрийн үнэлгээ* |
|---|---|---|
| бодит үйлдлийн сэтгэхүй | 92.6 | 64.7 |
| бодит дүрслэлийн сэтгэхүй | 98.5 | 75.8 |
| хийсвэр сэтгэхүй | **63.2** | 77.0 |

Ахлах ангийн сурагчид хичээлийн явцад дүрслэн харж, үйлдэж сэтгэх нь илүү сайн гэж ихэнх багш нар үзжээ. Харин сурагчдын өөрийн үнэлгээ нь багш нарын үнэлгээнээс доогуур байна. Хичээлийн үед сурагчдын хийсвэр сэтгэхүйн үйлдэлд тулгуурлан сургалтыг явуулах нь багш нарын 40 хувьд нь бэрхшээлтэй бол сурагчдын 70 гаруй хувь нь өөрсдийн хийсвэр сэтгэхүйн чадварыг сайн гэж үнэлжээ.

Ахлах ангийн сурагчдын 57.3 хувь нь эссээ бичих санаагаа үг өгүүлбэрээр илэрхийлэх дуртай гэсэн бол, өгүүлбэртэй бодлого бодох дуртай гэж 37.7 хувь нь, 77.1 хувь нь юмсын цаад учир утгыг олох сэтгэн бодох даалгавар хийх дуртай гэжээ.

## *Сурах арга барил ба мэдлэг ойлголт, мэдлэгээ хэрэглэх чадвар*

ЕБС-ийн суурь боловсролын хөтөлбөрөөр заагдаж буй хичээлүүдийн ойлголт, мэдлэгээ хэрэглэх чадварын нийт хичээлийн гүйцэтгэлийг суралцах хэв шинжийг тодорхойлж буй танин мэдэхүйн чадваруудын гүйцэтгэлтэй уялдуулан авч үзэв.

## *Анхаарал ба хичээлүүдийн сорилын гүйцэтгэл*

Сурагчдын даалгавар тус бүрийн гүйцэтгэлийн оноо болон нийт даалгаврын гүйцэтгэлийг ЕБС-ийн суралцагчийн болон боловсролын чанарын үнэлгээний журмыг баримтлан тооцож үзэв.

*Хүснэгт 233. Анхаарлаа хөгжүүлэх үйлийн сурагчийн үнэлгээ ба сорилын гүйцэтгэл*

| *Анхаарлын чадвар* | *Эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц, амжилтын түвшин* | | | |
|---|---|---|---|---|
| | *Дунджаас доогуур* | | *Хангалттай* | |
| | дуртай | дургүй | дуртай | дургүй |
| Анхаарлын хуваарилалт | 54.9 | 45.1 | 50.0 | 50.0 |
| Анхаарлын тогтворжилт | 64.7 | 35.3 | 72.2 | 27.8 |
| Анхаарлын шилжилт | 60.8 | 39.2 | 72.2 | 27.8 |

Нэгэн зэрэг хэд хэдэн үйлийг зэрэг хийх чадвар нь сорилын гүйцэтгэлийн дундаж оноонд нөлөөлөөгүй байна. Гэтэл анхаарлаа төвлөрүүлэн ажиллах, нэг зүйлээс нөгөө зүйлд анхаарлаа шилжүүлэх чадвар нь сорилын гүйцэтгэлд эерэгээр нөлөөлжээ.

## *Ой тогтоолт ба даалгаврын гүйцэтгэл*

*Хүснэгт 234. Ахлах ангийн сурагчдын ой тогтоолт хөгжүүлэх үйлд дуртай эсэх ба сорилын гүйцэтгэл*

| *Ой тогтоолт* | *Эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц, амжилтын түвшин* | | | |
|---|---|---|---|---|
| | *Дунджаас доогуур* | | *Хангалттай* | |
| | *дуртай* | *дургүй* | *дуртай* | *дургүй* |
| Сонорын ой тогтоолт | 67.2 | 32.8 | 55.6 | 44.4 |
| Харааны ой тогтоолт | 75.0 | 25.0 | 88.9 | 11.1 |
| Утгын ой тогтоолт | 59.7 | 40.3 | 55.6 | 44.4 |

Сурагчдын хараад мэдээллийг тогтоох чадвар нь сорилын гүйцэтгэлд эерэгээр нөлөөлсөн нь дээрх хүснэгтээс харагдаж байна.

Хүүхдийн цогц хөгжлийн судалгаагаар хүүхэд, залуучуудын богино хугацааны харааны ой дунджаас доогуур (M=2.5), сонорын ой тогтоолт дундаж түвшинд (M=3.1), утгын ой тогтоолт дундаж түвшинд (M=2.8) байгааг тогтоосон. Сурагчдын үзүүлсэн үр дүн ч үүнийг илэрхийлэн харуулж байна.

### *Сэтгэхүй ба даалгаврын гүйцэтгэл*

*Хүснэгт 235. Ахлах ангийн сурагчдын сэтгэхүйн хөгжүүлэх үйлд дуртай эсэх ба сорилын гүйцэтгэл*

| *сэтгэхүй* | *Эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц, амжилтын түвшин* | | | |
|---|---|---|---|---|
| | *Дунджаас доогуур* | | *Хангалттай* | |
| | *дуртай* | *дургүй* | *дуртай* | *дургүй* |
| бодит үйлдлийн сэтгэхүй | 63.5 | 36.5 | 83.3 | 16.7 |
| бодит дүрслэлийн сэтгэхүй | 75.4 | 24.6 | 83.3 | 16.7 |
| хийсвэр сэтгэхүй | 78.1 | 21.9 | 66.7 | 33.3 |

Бодит сэтгэхүйн хөгжил нь хүүхдийн сорилын гүйцэтгэлд эерэгээр нөлөөлсөн байна. Бодит сэтгэхүйн хөгжил сайтай сурагчдын сорилын гүйцэтгэл нь сайн байна.

Хүүхдийн цогц хөгжлийн судалгаагаар 15-18 насны хүүхэд, залуучуудын хийсвэр сэтгэхүйн хөгжил дундаас доогуур (M=2.74), сэтгэхүйн харьцуулах үйлдлийн хөгжил сул (M=1.7) үзүүлэлттэй гарчээ. Сэтгэхүйн харьцуулах үйлдэл нь стандарт хазайлттай байгаа тул маш сул түвшний эзлэх хувь багагүй байгааг харуулж байсан (SD=1.7).

Энэ судлагаагаар багш нар сурагчдын учир шалтгааныг нь олж дүгнэж ярьж сургах нь чухал байна гэж үзсэн бол сурагчид өөрсдийгөө төрөл бүрийн зүйл харж учир утгыг нь олох дуртай гэж хариулсан байна. Сэтгэхүйн харьцуулах үйлдэл сургалтын явцад хөгждөг гэж сэтгэл судлалын шинжлэх ухаанд үздэг учир хийсвэр сэтгэхүйн хөгжилд анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

### *Сурагчдын сурах арга барил болон хичээлүүдийн сорилын гүйцэтгэлд хийсэн шинжилгээнээс дараах дүр зураг харадав.*

Танин мэдэхүйн хөгжил нь сурагчдын сурах арга барилд гарч байгаа өөрчлөлт юм. Энэ нь хүүхэд мэдээллийг хүлээж авах, анализ хийх, харьцуулах, системчлэх, хийсвэрээр сэтгэх, зүй тогтолыг нь олох чадвар эзэмших буюу сурах үйлтэй холбоотой байна.

- Бүрэн дунд боловсролын түвшинд суралцаж буй сурагчид анхаарлын төвлөрөлт, хуваарилалт шаардсан болон сэтгэхүйн хурд шаардсан үйлдүүдийг хийх дуртай гэж хариулжээ. Анхаарлын чадваруудыг шаардсан үйлдэл хийх дуртай эсэхэд сурагчдын хүйс болон сургуулийн байршил төдийлөн хамааралтай биш байна.
- Багш нар сурагчдад дасгал даалгавараа хурдан зөв гүйцэтгэхэд дэмжлэг болон шаардлага чухал байдаг гэж үзсэн байна.
- Ахлах ангийн сурагчдыг багш нар мэдээллийг уншаад цээжлэх боломжтой ч сонссон зүйлээ уншсанаасаа илүү сайн тогтоодог гэж үзсэн байна. Сурачид өөрсдөө багшийн ярьж байгаа зүйлийг сонсож тогтоодог ч мэдээллийг харж тогтоох, утгачлан тогтоох дуртай гэж хариулжээ.

- Ахлах ангийн сурагчид багшийн хэрэглэж буй сургалтын аргад тулгуурлан сэтгэхүйн үйлийг гүйцэтгэх боломжтой гэж багш нар үзсэн бол сурагчид учир шалтгааныг олсон даалгавар хийх дуртай гэж хариулсан байна.
- Хүүхдийн цогц хөгжлийн судалгааны үр дүнгээс хархад сурагчдын анхаарал, ой тогтоолт, сэтгэхүйн үйлүүд сул үзүүлэлттэй байсан. Энэ судалгааны үр дүнгээс хархад сурагчдын сорилын даалгаврын гүйцэтгэл нийт сурагчдаар авч үзэхэд мөн дунджаас доогуур түвшинд байна.

## Бүрэн дунд боловсролын түвшинд суралцаж буй суралцагчдын гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийн шинжилгээ

Бүрэн дунд боловсролын түвшинд суралцаж буй суралцагчдын сорилын гүйцэтгэл болон түүнд нөлөөлж буй хүчин зүйлд шинжилгээ хийв.

Сорилын гүйцэтгэлд ахлах ангийн сурагчдын унтах цаг (r=.204**; p<0.00) ба англи хэл (r=.227**; p<0.00) , дизайн технологийн (r=.210**; p<0.00) хичээлүүдэд гэрийн даалгавраа хийхдээ ашигладаг сурах бичиг, гарын авлага гэх мэт нэмэлт материал ашиглаж байгаа нь нөлөөлсөн байна.

*Зураг 126. Ахлах ангийн сурагчдын англи хэлний хичээл ба гэрийн даалгавар хийдээ ашиглаж буй материал*




Сургалтын явцад англи хэлний хичээлд сурах бичгээс гадна нэмэлт материалууд ашиглах гэрийн даалгавраа хийхдээ ашиглах нь хэл сурах явцад эерэг нөлөө үзүүлдэг байна.

*Зураг 127. Ахлах ангийн сурагчдын дизайн технологийн хичээл ба гэрийн даалгавар хийхдээ ашиглаж буй материал*




Дизайн технологийн хичээлд сурах бичгээс гадна багш нарын өөрсдийн зохиосон гарын авлаг материалыг ашиглан ашиглах даалгавар өгдөг байна.

Ахлах ангийн сурагчид орой унтах тусам даалгаврын (r=.204**; p<0.00) гүйцэтгэл сайн байгаа нь нөлөөлөх хүчин зүйл болж байна.

*Зураг 128. Орой унтах цаг ба даалгаврын гүйцэтгэл*




Сурагчид анги ахих тусам сурагчдын унтах цаг 24 цагаас хойш болж байгаа ба орой унтах тусам сурагчдын сорилын гүйцэтгэл өндөр байна.

Ахлах ангийн сурагчдын гүйцэтгэлд багшийн ажилласан жил нөлөөлсөн байна (p >0.01)

*Зураг 129. Багшийн ажилласан жил ба сурагчдын сорилын гүйцэтгэл (ахлах анги)*




16-аас дээд жил ажилласан багш нараар хичээл заалгадаг сурагчдын сорилын гүйцэтгэл түүнээс цөөн жил ажилласан багш нараар хичээл заалгадаг сурагчдын гүйцэтгэлээс илүү байна.

Суралцагчдын гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийн шинжилгээнээс дараах дүр зураг харагдав.

Сорилын гүйцэтгэлийн хүчин зүйлийн шинжилгээг байршил, хүйс, нас, ам бүлийн тоо, цэцэрлэгт явсан эсэх, амьдралын нөхцөл, өглөөний цайгаа уудаг уу, гэрийн даалгавар хийхдээ хэдэн цаг зарцуулдаг, эцэг эхийн боловсрол,ажил эрхлэлт өрхийн орлого зэрэг нь сорилын гүйцэтгэлтэй ач холбогдол бүхий ялгаатай эсэхээр хүчин зүйлсийн шинжилгээ хийв. Эдгээрээс зөвхөн доорх хүчин зүйлс сурагчдын гүйцэтгэлд нөлөөлсөн байна.

- Англи хэл болон дизайн технолгийн хичээлийн гэрийн даалгавар хийхдээ ашиглаж буй материал нь сорилын гүйцэтгэлтэй ач холбогдол бүхий ялгаатай байна.
- Сурагчдын унтах цаг ба сорилын гүйцэтгэлд ач холбогдол бүхий ялгаатай байна.

# ТАВДУГААР БҮЛЭГ: СУРГАЛТЫН ОРЧНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ

ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг илрүүлэх судалгааны хүрээнд сургалтын материаллаг орчин, хэрэглэгдэхүүний нөхцөл ямар байгааг авч үзэх улмаар сургуулиудад хүүхдэд ээлтэй, эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангасан эсэх тэдний сурах, хөгжих үйлийг дэмжсэн таатай орчин бүрдсэн эсэхийг авч үзэв.

## Хүүхдэд ээлтэй эрүүл ахуйн орчин

Эдэлбэр газар

Судалгаанд нийслэлийн хоёр дүүргийн 6, дөрвөн аймгийн 10, дөрвөн сумын 5, нийт 21 сургуулийг хамруулав.

Нийт сургуулийн 76.2 хувь нь гаднаа цэцэрлэгжүүлэлтийн талбайтай, 71.4 хувь нь гэрэлтүүлэгтэй, 64.2 хувь нь цардмал зам болон явган хүний замтай, 81.0 хувь нь сууж амрах зориулалт бүхий сандалтай, 66.7 хувь нь сүүдрэвчтэй байна.

*Зураг 130. Гадаад орчны тохижилт*




Сургуулийн гадаад орчин, эдэлбэр газрын тохижилтод аймгийн сургуулиуд цэцэрлэгжүүлэлтээрээ, нийслэлийн сургуулиуд цардмал зам болон явган хүний замаараа, сумын сургуулиуд сууж амрах сандал, сүүдрэвч зэрэг тохижилтоороо бусад байршил дахь сургуулиудаасаа илүү байгаа нь ажиглагдлаа. Сургуулийн гадна орчин сургуулийн байршлаар нь авч үзвэл аймаг, сумын сургууль нь нийслэлийн сургуулиас илүү тохижилттой байна. “Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм[9]”-ийн 6.2-д сургууль нь өөрийн эдэлбэр газрыг биеийн тамир, хичээл туршлагын болон тоглоомын талбай байгуулах зэрэгт ашиглахыг заасан байдаг. Иймд сургуулийн гаднах эдэлбэр газрын ашиглалтыг судалж, сургуулийн гадна биеийн тамирын болон тоглоомын талбай бий эсэхийг ажиглав. Нийт сургуулийн 57.1 хувь нь тоглоомын, 71.4 хувь нь сагсан бөмбөгийн, 38.1 хувь нь хөл бөмбөгийн талбайтай бөгөөд 52.4 хувь нь гүйлтийн зам, гулсуур, турник, савлуур зэрэг биеийн тамирын хэрэгсэл бүхий талбайтай байна.

[9] БСШУ-ы сайдын 2010 оны 471 дүгээр тушаалаар батлагдсан.

*Зураг 131. Гадаад орчин дахь биеийн тамирын талбайн хүртээмж*




Аймгийн сургуулийн 90.0 хувь нь гаднаа сагсан бөмбөгийн талбайтай бол сумын сургуулийн 20.0 хувь нь хөл бөмбөгийн талбайтай байна. Дээрх 4 төрлийн талбайгаас нийтлэг байгаа нь сагсан бөмбөгийн талбай бөгөөд хамгийн бага хувьтай нь хөл бөмбөгийн талбай байна.

### *Гэрэлтүүлэг*

Сургуулиуд нь коридортоо өдрийн гэрэл эсвэл лед гэрэлтэй бөгөөд, улайсдаг шар гэрэлтэй сургууль байхгүй байна. Лед гэрэлтэй сургуулийн эзлэх хувь нийслэлд 50 хувь, аймагт 20 хувь байна. Харин сумын төвийн аль ч сургууль лед гэрэл хэрэглэдэггүй байна. Сурагчдад гэрэл, цахилгаан хэмнэхийг сануулсан гэрлээ унтраана уу гэх мэт санамжийг нийт сургуулийн 19.0 хувь нь ханандаа байрлуулсан. Харин 81.0 хувь нь гэрэл цахилгааны зохистой хэрэглээтэй байна гэж ажиглалтаар гарчээ. Энэ нь заавал санамж байх эсэхээс үл хамаарч, гэрэл цахилгааны хэмнэлттэй хэрэглээтэй байгааг харуулж байна.

## Эрүүл ахуйн байгууламж

*Зураг 132. Нэг багшид ногдох хүүхдийн тоо, байршлаар*




Судалгаанд хамрагдсан сургуулиудын нэг багшид ногдох хүүхдийн тоог Зурагт харуулав. Нийслэлийн нэг багшид ногдох хүүхдийн тоо бага ангид 5-13, дунд, ахлах ангид 2-4 хүүхдээр илүү байна. Судалгааны хүрээнд нийт сургуулийн дөрөвдүгээр анги хичээлд ажиглалтад хамрагдсан ангийн хүүхдийн тоо нийслэлд 34.3, аймагт 31.6, суманд 25.2 байна. Нийслэлийн төрийн өмчийн сургуулийн дөрөвдүгээр ангийн сурагчийн дундаж тоо 40.5 байхад төрийн бус өмчийн сургуулийнх 22 байна. "Сургалт-хүмүүжлийн байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм10"-ийн 4.3-д нэг анги дахь хүүхдийн тооны дээд хэмжээг 30-35 байхаар заасан. Гэтэл нийслэлийн төрийн өмчийн нийт сургуулийн 87.5 хувийнх нь дөрөвдүгээр ангийн хүүхдийн тоо дээрх шаардлагаас 5-6-аар хүүхдээр илүү байна. Энэ

[10] МХЕГ-ын даргын 2017 оны А/179 дүгээр тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан

нь нийслэлийн төрийн өмчийн сургуулийн бага ангийн багш аймаг, сумын сургуулийн бага ангийн багшаас илүү ачаалалтай байгааг харуулж байгаа юм.

Сургуулиудын 90.0 орчим хувь нь сурагчдын бүтээлийг коридорын хананд байрлуулжээ. Сургуулийн коридорт мэдээллийг гэрлэн самбар, зурагт, узель, биет самбар зэргийн алийг байрлуулсан болон ашиглаж буй эсэхийг нь ажиглав. Нийт сургуулиудын 52.4 хувь нь коридортоо гэрлэн самбар, 33.3 хувь нь зурагт, 47.6 хувь нь узель, 76.2 хувь нь самбар байрлуулсан байна. Харин узелийг аймаг, сумын сургуулиас хотын сургуулиуд 50.0 хувиар илүү хэрэглэж байгаа нь ажиглагдлаа. Сургуулиудын 40.0 орчим хувь нь коридортоо хувцасны өлгүүр байрлуулсан бөгөөд аймаг, сумын сургуулиас илүү нийслэлийн сургуулиуд хүүхдүүдийн хувцасыг коридортоо нэгдсэн журмаар өлгөдөг байна. Хувийн хэвшлийн бүх сургууль хувцасны өлгүүрийг коридортоо байрлуулсан байсан. Энэ нь анги, танхимын багахан зайг өлгүүр эзлэхгүй, илүү тав тухтай байхад тустай байж болох талтай юм.

БСШУ-ны сайд, ЭМС-ын сайд, Сангийн сайдын 2015 оны А/253/251/173 тоот хамтарсан тушаалаар "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлага"-ыг баталсан. Уг шаардлагын 1.1.4-д хүүхэд өдөрт 1 литрээс доошгүй ундны цэвэр ус уух боломжоор хангагдсан байх ёстой гэжээ. Судалгаанд хамрагдсан нийслэлийн бүх сургууль дээрх шаардлагад нийцсэн, сургуулийн коридортоо шүүлтүүр бүхий ус цэвэршүүлэгч, ус халаагч байрлуулсан байна. Харин аймаг, сумын хоёр сургууль тутмын нэг нь коридортоо цэвэр усны эх үүсвэргүй байгаа нь дээрх шаардлагыг хангахгүй байна. Сумын сургуулийн 20.0 хувь нь дээрх шаардлагад нийцсэн, цэвэр усны эх үүсвэр коридортоо байрлуулсан байна.

Суралцагчдад бүх түвшний боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих, төлөвших үйл явцыг удирдан зохион байгуулах нь сургуулийн үндсэн зорилт тул БСШУ-ны сайдын 2010 оны 471 дүгээр тушаалын хавсралтаар "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм"-ийг баталсан байдаг. Түүний 6.2-д сургууль нь хичээлийн танхим, төрөлжсөн кабинет, лаборатори, номын сан, уншлагын танхим, багш, хүүхэд хөгжлийн төв, биеийн тамирын заал, талбайн өрөө, тасалгаатай байхыг заасан байдаг. .

Хүснэгтэд судалгаанд хамрагдсан сургуулиудад нийгмийн үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн дараах өрөө, тасалгаа бий эсэхийг ажиглаж, судлав.

*Зураг 133. Сургуулийн нийгмийн үйлчилгээ үзүүлэх материаллаг нөхцөл (хувиар илэрхийлсэн)*




Нийслэлийн сургуулиуд бүгд биеийн тамирын заал, урлаг танхим, номын сан, багш нарын өрөөтэй, зарим аймаг, сумын сургуульд биеийн тамирын заал, урлагийн танхим, хүүхэд хөгжлийн өрөө байхгүй байна. Нөгөөтэйгүүр, БНбД II-66-

88[11]-д ерөнхий боловсролын сургуульд зайлшгүй байх шаардлагатай өрөө тасалгаанд номын сан, биеийн тамирын заал, урлаг соёлын танхимыг оруулсан байдаг. Гэвч судалгаанд хамрагдсан аймаг, сумын сургуулийн 20.0 орчим хувьд нь дээрх зориулалтын өрөө, тасалгаа байхгүйгээр сургалт, хүмүүжлийн ажил явуулж байгаа нь зайлшгүй анхаарах асуудлын нэг байна. Хөдөө, орон нутгийн хувийн өмчийн сургуульд номын сан, биеийн тамирын заал, талбай байхгүйгээр хичээл, сургалтын үйл ажиллагаа зохион байгуулж байгаа нь хүүхдийн танин мэдэхүй болон бие бялдрын хөгжилд сөргөөр нөлөөлөхийг анхаарч, сургалт-хүмүүжлийн ажил эрхлэх тусгай зөвшөөрлийг дахин авч үзэх шаардлага байна.

*Багшийн хөгжлийн материаллаг нөхцөл*

Сургууль төвтэй мэргэжил дээшлүүлэх тогтолцоо бүрдүүлэх, багш ажлын байрандаа мэргэжил боловсролоо дээшлүүлэх, ээлжит хичээлээ хамтран бэлтгэх орчин нөхцөл бүрдүүлэх үүднээс БСШУ-ны сайдын 2008 оны 114 тоот тушаалаар "Багшийн хөгжлийн танхим" ажиллуулах зөвлөмж, шаардлагагыг баталсан. Нийт сургуулийн 70 орчим хувьд дээрх зориулалт бүхий багш хөгжлийн өрөөг тохижуулж, үйл ажиллагаа явуулж байна. Харин түүний материаллаг тавилга, тоног төхөөрөмжийн хүртээмж, хэвийн ажиллах боломж, үйлчилгээ, ашиглалт ямар байгааг цаашид судлах шаардлагатай гэж үзэж байна.

*Цайны газрын үйлчилгээ*

БНбД II-66-88-д 280 хүртэл сурагчтай сургууль цайны газартай байна гэж заасан. Судалгаанд хамрагдсан сургуулиудын 23.0 хувь нь цайны газаргүй байна. Цайны газрын хооллох танхимын суудлын тоо дунджаар 42, төрийн өмчийн сургуулийнх 20 байна. Хооллох танхимын талбайн хэмжээ дунджаар 93.2 кв.м, төрийн өмчийн сургуулийнх 66.2 кв.м байна. Хооллох танхимын нэг суудалд ногдох талбайг 0.65 кв.м байхаар заасан байдаг. Тэгвэл судалгаанд хамрагдсан сургуулийн хооллох танхимын суудлын тоог нэг суудалд ногдох талбайгаар нь үржүүлэхэд бүх сургууль дээрх заалтыг хангаж байгаа төдийгүй, дунджаар 65.9 кв.м-ээр их байна. Гэхдээ нэг удаа хооллох хүүхдийн тоог сургуулийн нийт хүүхдийн тоотой харьцуулахад нэг суудалд ойролцоогоор 92 хүүхэд ногдож байгаа нь хүүхдүүд цайны газраар ширээнд сууж үйлчлүүлэх боломж хомс байгаа нь харагдаж байна. Сургуулийн цайны газрууд ихэвчлэн ширхэгийн хоол гэж нэрлэгдэх ороомог, пирошки, мантуун буузаар үйлчилдэг тул хүүхдүүд ширээнд суухгүйгээр идэх боломжтой байдаг байна. Ер нь сургуулиуд хооллох танхимынхаа суудлын тоог нэмэх боломжтой гэсэн үг.

Цайны газрын хоолны амт чанарын талаарх сурагчийн өгсөн хариултыг шинжилж үзэхэд нийт сурагчдын дунджаар 70.0 хувь нь “”сайн байдаг” гэж хариулсан бол эцэг эхийн 30.0 хувь нь үргэлж, 36.0 хувь нь ихэнхдээ амт чанартай хоолоор үйлчилдэг гэж хариулснаас үзэхэд эцэг эх, сурагчдын хариулт ойролцоо байна. Харин цайны газрын үйлчилгээ, ариун цэвэр, аятухтай байдлын талаар тодруулахад нийт сурагч, эцэг эхийн дунджаар 66.0 хувь нь цайны газрууд нь хоол, хүнс эрүүл аюулгүй байдлыг “үргэлж”, “ихэнхдээ” хангадаг гэж хариулсан байна. Эндээс үзэхэд дунджаар 60.0 хувь нь сургуулийн цайны

[11] “Сургалт-хүмүүжлийн барилгын зураг төсөл зохиох нэгдсэн норм” /БНбД II-66-88/

газрын хоол амт чанар сайтай, эрүүл аюулгүй байдлыг хангасан цэвэрхэн байна гэж үзэж болохоор байна.

*Ариун цэврийн байгууламж*

Аймаг, нийслэлийн бүх сургууль төвийн нэгдсэн системд холбогдсон татуурган жорлонтой, харин ажиглатад хамрагдсан сумын сургуулийн 40.0 хувь нь татуурган жорлонтой, 60.0 хувь нь гаднаа модон жорлонтой байна. Нийт жорлонгийн 86.0 хувь нь эрэгтэй эмэгтэй гэж ялгасан таних тэмдэгтэй, 71.0 хувь нь зургаан настай суралцагчдад зориулсан ариун цэврийн өрөө эсвэл суултуууртай, 5.0 орчим хувь нь зургаан настай суралцагчдад зориулсан зориулалтын бус ч суултуурын нүх нь бага, өөрөөр хэлбэл бага насны хүүхэд хэрэглэхэд тохиромжтойгоор хийсэн байна. Нийт сургуулийн 20.0 орчим хувь нь зургаан настай суралцагчдад зориулсан ариун цэврийн өрөө, суултуур ашигладаггүй байна. "Бага ангийн 6 настай сурагчдад зориулсан ариун цэврийн өрөөг сургуулийн ариун цэврийн өрөөний хажуу хэсэгт хаалт, хашлагаар тусгаарлах болон тусад нь байлгах, суултуур, тосгуурын тоог багадаа 10-15 хүүхэд тутамд нэг ногдож байхаар тогтоох, суултуур тосгуурыг стандартын дагуу сонгох, байршуулах хэмжээг БНбД-II-66-88, ТН-II-2.2-1985 нормалийн дагуу тогтооно"[12] гэж заасан байдаг бөгөөд цаашид энэ шаардлага, нормын дагуу байгаа эсэхийг нарийвчлан судлах шаардлагатай. Сургуулиудын ариун цэврийн өрөөний 14.0 орчим хувь нь хөгжлийн бэрхшээлтэй сурагч үйлчлүүлэх боломжтой байна. Ариун цэврийн өрөөний хаалганы өргөн 1.4 м-ээс багагүй байж хөгжлийн бэрхшээлтэй суралцагч үйлчлүүлэх боломжтой болохыг заасан байдаг[13]. Үүнийг цаашид нарийвчлан судлах зайлшгүй шаардлага байна. "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлага[14]"-ын 2.1.1-д 30 эмэгтэй хүүхдэд 1 суултуур, 40 эрэгтэй хүүхдэд 1 суултуур+1 шээлтүүр, 3.1.1-д 40 сурагчид нэг гар угаах угаагуур ногдож байхыг шаардсан байдаг. Аймгийн төвийн нэг сургууль нь сургалтын зориулалтын бус байрт ашигладаг бөгөөд, тухайн сургуулийн угаалтуур, суултуурын тоо хэт бага (800-аад хүүхдэд 1 ширхэг угаалтуур, 4 ширхэг суултуур ногдож байна) байгааг анхаарах хэрэгтэй.

*Хүснэгт 236. Ариун цэврийн өрөөний тоног төхөөрөмжийн хүрэлцээ*

| Үзүүлэлт | | Нийслэл | Аймаг | Сум |
|---|---|---|---|---|
| Арuитгах татуургын сүлжээнд холбогдсон | Нэг угаалтуурт ногдох хүүхдийн тоо | 51.3 | 83.9 | 67.3 |
| | Нэг суултуурт ногдох хүүхдийн тоо | 53.0 | 56.3 | 55.2 |
| Аруитгах татуургын сүлжээнд холбогдоогүй | Нэг гишгүүрт ногдох хүүхдийн тоо | | | 24.0 |
| | Нэг гар угаалтуурт ногдох хүүхдийн тоо | | | 79.5 |

Судалгаанд хамрагдсан сургуулиудын нэг угаалтуурт дунджаар 67-68, нэг суултуурт 54-55 хүүхэд ногдож байна. Энэ нь сургуулийн ариун цэврийн байгууламжийн хүрэлцээ эрүүл ахуйн нормоос бага байгааг харуулж байна. Сумын нэг сургууль нь дотуур байртайгаа хамт гаднаа модон жорлон хэрэглэдэг байна. "Сургалт-хүмүүжлийн байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм"-ийн 2.34-д

[12] Монгол улсын барилгын дүрэм- Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлтийн дүрэм
[13] Монгол улсын барилгын дүрэм- Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлтийн дүрмийн 7.4.5.3
[14] БСШУ-ы сайд, ЭМС-ын сайд, Сангийн сайдын хамтарсан А/253/251/173 тоот тушаалаар батлагдсан.

сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан ариун цэврийн өрөө, гар угаагуур 1-ээс багагүй байна гэж заажээ. Гэтэл нийт сургуулийн 14.3 хувьд л дээрх шаардлагыг хангасан ариун цэврийн өрөө, гар угаалтуур байна. Нийт сургуулийн 85.7 хувийнх нь крант усны алдагдалгүй, эвдэрхий биш, цоргоороо ус алдахгүй байх гэх мэт усны хэмнэлтийг дэмжсэн байна. Харин усаа хэмнэе зэрэг санамжийг нийт сургуулийн 20 орчим хувьд л байрлуулсан байна.

Судалгаанд хамрагдсан сургуулийн 28.6 хувь нь хогийг ангилан хаядаг байна.

Асуулгаар нийт сурагчдын дунджаар 50.0 хувь нь ариун цэврийн өрөө үргэлж цэвэрхэн байдаг гэж хариулсан бол эцэг эхийн дунджаар 36.0 хувь нь үргэлж, 40.0 хувь нь ихэвчлэн ариун цэврийн өрөө цэвэр байдаг гэж хариулсан байна. Сургуулийн ариун цэврийн өрөө цэвэр байдаг эсэхийг мэдэхгүй гэх эцэг эхийн хариулт багахан хувийг эзэлж байна. Сургуулийн ариун цэврийн өрөө цэвэрхэн байдаг гэж дунджаар 40 орчим хувь нь үзэж байна. Эндээс ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг сургууль бүр анхаарах хэрэгтэй.

## Хүүхдэд ээлтэй аюулгүй орчин

Авто зам, цахилгаан хүчдэл

Нийт сургуулийн 71.4 хувь нь гал унтраах багаж хэрэгсэлтэй, харин 52.4 хувь нь галын аюулгүйн гарц, тэмдэглэгээтэй байна. 81.0 хувь нь цахилгааны утасны ил, задгай холболтгүй, 47.6 хувь нь цахилгаан хүчдэлийн аюулгүй байдлын тэмдэг, тэмдэглэгээтэй байна.

ЕБС-ийн эдэлбэр газар, орчны аюулгүй байдал нь сурагчдын сурах болон эрүүл орчинд амьдрах нөхцөл болно. Иймд сургуулийн ойр 500 метр дотор “авто зам, задгай зогсоол, архи согтууруулах ундаа, тамхиар үйлчлэх цэг, бар караоке, ил ухсан нүх шуудуу, аюулгүйн гарц, тэмдэг тэмдэглэгээ бий эсэх” талаар ажиглалт хийлээ. Нийт сургуулийн 54.8 хувийнх нь ойр орчмоос 500 метр дотор авто машины граж, задгай талбайгүй, 76.2 хувь нь баар, караоке байхгүй, 42.9 хувь нь согтууруулах ундаа, тамхиар үйлчлэх худалдааны цэггүй, 90.5 хувь нь ил ухсан нүх шуудуугүй байна.

*Зураг 134. Сургуулийн ойр орчмын аюулгүй байдал*



Зурагт хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэхэд сөргөөр нөлөөлөх барилга, байгууламж, объект, үйлчилгээ бий эсэхийг үзүүлэв. Авто машины граж, задгай талбай нийслэлийн сургуулийн ойр орчимд багагүй хувь, аймаг сургуулийн ойр орчимд согтууруулах ундаа, тамхиар үйлчлэх цэг багагүй хувь эзэлж байна.

*Зураг 135. Сурагчдын аюулгүй байдлыг хангасан байдал*




Сургуулийн ойр орчимд сурагчдад аюул, ослын тэмдэг тэмдэглэгээ байрлуулсан эсэхийг ажиглахад дээрх зурагт үзүүлсэн үр дүнгүүд гарчээ. Авто машин, явган хүний гарц, хурд сааруулагч, замын тэмдэг, тэмдэглэгээг нийслэл, аймгийн сургуулиудын 55.0 орчим хувьд нь байна. Харин цахилгаан, хүчдэлийн аюулыг анхааруулсан тэмдэг тэмдэглэгээ сургуулиудын ойр орчимд 18.0 хувьд нь байна. Иймд хүүхдийн аюулгүй, эрүүл сурах орчин нөхцөлд сургуулийн удирдлага, бусад хамаарах байгууллагууд сул анхаарч байгааг анхаарах хэрэгтэй.

# Хүүхдийн сурах үйлийг дэмжсэн орчин

## Номын сангийн үйлчилгээ

Сургуулиудын 85.0 хувь нь ном хадгалах фондын өрөөтэй, 95.0 хувь нь уншлагын танхимтай байна. Огт номын сангүй нэг сургууль байна. 2 сургууль нь уншлагын танхимтай боловч ном хадгалах фондын өрөөгүй байна. Бүх сургууль өдрийн гэрлээр гэрэлтүүлдэг байна. Улайсдаг шар гэрэл хэрэглэж буй сумын төвийн нэг л сургууль байна. Номын сангийн өрөөний агаарын хэмийг хэмжиж, дундаж температурыг дараах диаграммаар харуулав. БНбД 31-03-03[15]-ын 4.29-д номын сангийн агаарын тооцоот температур 18$^{0}$С байхаар заасан байна. Диаграммаас харахад нийслэл, аймгийн төвийн сургуулийн номын сангийн өрөөний агаарын хэм нормт хэмжээнд, харин сумын төвийнх нормт хэмжээнд хүрэхгүй байна.

Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, сургалтын материаллаг орчинг авч үзэхэд, 21 сургуулийн 1 нь номын сангүй байна.

[15] Олон нийт иргэний барилга БНбД 31-03-03 нь олон нийтийн барилгын зураг төсөл зохиоход дагаж мөрдөх норм, дүрэм

*Зураг 136. Номын санч, ажилласан жилээр*




Төрөөс бага ангийн сурагчдыг сурах бичгээр 100.0 хувь хангах шийдвэр хэрхэн хэрэгжиж буйг тодорхойлох үүднээс авсан асуулгад сургуулиудын бага ангийн сурагчдын сурах бичгийн хангалт энэ хичээлийн жилд 87.0 хувь, 13.0 хувь нь сурах бичгээр хангагдаагүй байна. Үүний шалтгааны талаар номын санчдын өгсөн хариултыг харахад:

- Сурах бичгүүд хүүхдийн тоонд хүрэхгүй дутагдалтай ирдэг,
- Ялангуяа 5 дугаар ангийн математик, монгол хэлний хичээлийн сурах бичгүүд дутсан,
- Иргэний боловсрол хичээлийн сурах бичиг нь энэ жилээс шинээр хэвлэж түгээсэн тул 2-5 дугаар ангиудад сурах бичгийн хангалт 70.0 хувьд ч хүрээгүй дутсан гэжээ.

Мөн шинээр хэвлэгдэн гарч буй сурах бичгийн 56.5 хувь нь захиалсан тоогоороо ирээгүй байна. Энэ нь хичээлийн жилийн хугацаанд хуваарилсан сурах бичгээ хүлээн авдаг ч нэмэлт захиалга нь хүлээлт ихтэй, аймаг дүүргийн газраас хуваарилсан тоо багассан ялангуяа дунд, ахлах ангийн сурах бичгүүдийг захиалсан тоонд хүрэхгүй 30.0 хувийг хүлээн авсан байна.

Судалгаанд оролцсон сургуулиудын номын сангаар олгодог дунд болон ахлах ангийн сурагчдын сурах бичгийн хангалтыг авч үзвэл:

*Хүснэгт 237. Дунд, ахлах ангийн номын сангаар олгодог сурах бичгийн хангалт*

| | *1-10 хувь* | *10-20 хувь* | *20-30 хувь* | *30-40 хувь* |
|---|---|---|---|---|
| Дунд анги | - | 13.0 % | 30.4 % | 56.5 % |
| Ахлах анги | - | 21.8 % | 26.1 % | 52.1 % |

Дээрх хүснэгтээс үзвэл төрөөс зорилтод бүлэгт номын сангаар олгож буй сурах бичгийн хангалт орон нутгийн сургуулиудын дунд, ахлах сургуулийн 10-20.0 хувь, 20-30.0 хувь байна. Үндсэндээ зорилтод бүлэгт олгогддог сурах бичгийн хангалт дунд ангийн сурагчдын 56.5 хувь, ахлах ангийн сурагчдын 52.1 хувийг эзэлж байна. Дээрх үүсэж буй нөхцөл байдалд дараах хүчин зүйл нөлөөлж байна гэж номын санчид үзжээ. Захиалсан тоогоороо сурах бичиг ирдэггүй, сурах бичиг нэг, хоёр жилээр өнжиж нөхөн хангалтаар хэвлэгдэн хуваарилагдаж ирдэг. Зарим сурах бичиг хэвлэгдэж ирээгүй байгаа зэргийг дурдсан байна.

*Хүснэгт 238. Сургуулийн зорилтод бүлгийн сурагчдад олгосон сурах бичгийн хувь*

| | *1-25 хувь* | *25-50 хувь* | *50-75 хувь* | *75-100 хувь* | *100 хувь* |
|---|---|---|---|---|---|
| Дунд анги | 17.4 % | 8.7 % | 21.7 % | 30.5 % | 21.7% |
| Ахлах анги | 13.0 % | 34.9 % | - | 39.1 % | 13.0 % |

Зорилтод бүлэгт сургуулийн номын сангаар олгодог сурах бичиг дунд ангид 21.7 хувь, ахлах ангид 13.0 хувь л бүрэн хангагдсан байна. Сурах бичгийн хэвлэлтийн шатад хугацаа алдсанаас сурах бичиг олгогдохгүй, нөхөн хангалтаар ирдэг сурах бичиг нь дутагдалтай ирдэг, захиалсан тооноос цөөн тоогоог хэвлэх, сургуулийн сурагчдын тоо нэмэгдэх зжраг нь сурах бичгийн хангалтад нөлөөлсөн гэж үзэж байна. 8, 9 дүгээр ангийн сурах бичиг зорилтод бүлэгт хүрэхгүй байх тохиолдол гарч байна. Мөн 12 дугаар ангийн сурах бичиг сурагчдын гарт хүргэгдээгүй зэрэг нь тодорхой нөлөө үзүүлж байна. Зорилтод бүлгийн дунд ангийн сурагчдын 52.2 хувь, ахлах ангийн сурагчдын 73.9 хувь нь 100.0 хүртэлх хувиар хангагддсан.

Аймаг, дүүргийн соёлын газраас хуваарилж буй сурах бичгийг номын санчид хүлээн авахад дараах хүндрэл бэрхшээл тулгарч байна. Үүнд:

- Сурах бичгээ номын сан руу зөөх унаагүй, захиалсан тоондоо хүрдэггүй – (41.7 хувь)
- Цөөн тоогоор ирдэг учир дахин дахин очиж авах шаардлага гардаг – (58.3 хувь)
- Зарим сурах бичиг сургалтад хэрэглэх боломжгүй болдог норох, гэмтэх г.м- (8.7 хувь)
- Сурах бичиг дутагдалтай ирдэг – (4.5 хувь) зэрэг нь сурах бичгийн хангамж хүртээмжид нөлөөлдөг байна.

Сургуулиудын анги удирдсан багш нар нь ангийнхаа зорилтод бүлгийн хүүхдийн тоогоор нь сурах бичгээ хуваарилдаг уу гэдэгт 95.5 хувь нь тийм, 4.5 хувь нь үгүй гэжээ. Зорилтод бүлгийн сурах бичиг дутагдалтай ирдэг тул ангийн багш нар нь өөрсдөө зохицуулалт хийж хуваарилдаг ба номын санчид эдгээрт 100.0 хувь хяналт тавьж чаддаг гэж үзсэн байна.

Сурах бичгийн хангамж хүртээмжид нөлөөлөх бас нэгэн хүчин зүйл нь сурагчдын тоо нэмэгдэх, хөдөө орон нутагт сумаас аймгийн төв рүү шилжилт их байдаг, ахлах, дунд ангийнхан сурах бичгээ худалдан авах цэг, номын худалдаа тодорхой биш байдаг нь сурах бичиг хүрэлцэхгүй байх шалтгаан болжээ.

Номын санчдаас сурах бичгийн эдэлгээ (насжилт) анги бүрт хэрхэн байгааг гаргаж үзлээ.

*Хүснэгт 239. Сурах бичгийг ашиглах боломжит жил, хугацаа*

| | *1 жил* | *2 жил* | *3 жил* | *4 жил* | *5-аас дээш* |
|---|---|---|---|---|---|
| Бага анги | 4.5% | 36.4% | 40.9% | 18.2% | - |
| Дунд анги | - | 4.5% | 40.9% | 40.9% | 13.7% |
| Ахлах анги | - | 4.5% | 18.2% | 36.4% | 40.9% |

Сурах бичиг ашиглах боломжит хугацааг номын санчид бага ангид ялангуяа I-II ангид 1-2 жил л хэрэглэх (6, 7 настай хүүхэд сурах бичгээ гамтай хэрэглэх туршлагагүй), III-V ангид 2-3 жил, харин дунд болон ахлах ангид сурах бичгийг 4-5 жил ашиглах боломжтой гэсэн байна. Номын сангийн сурах бичгийг дамжуулан дахин хэрэглэхэд дараах бэрхшээлүүд гардаг байна. Үүнд:

- Сурах бичгийн наалт 52.2 хувь нь ихэнхдээ салдаг.
- Сурах бичгийн хуудас 61 хувь нь ихэнхдээ салдаг.

- Сурах бичиг дээр 52.2 хувь нь ихэнхдээ зурж, бичдэг.
- Сурах бичгийн 56.5 хувь нь ихэнхдээ эрүүл ахуйн шаардлага хангадаггүй гэсэн хариулт өгчээ.

Дахин ашиглахад хүндрэлтэй, хуучирсан ном хэвлэлийг төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийг үндэслэн акталдаг байна. Гэвч актлах хугацаа болоогүй, сурах бичиг хадгалах өрөө, тасалгаагүй тул номын санчид үндсэн номын сангийн үйлчилгээгээ явуулахад хүндрэл тулгардаг.

Сурах бичгийн хангалт хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр авах арга хэмжээнд 43.0 хувь нь бүх сурах бичгийг төрөөс 100.0 хувь хангах, 39.0 хувь нь сурах бичгийн түрээсийн тогтолцоог сэргээх, 13.0 хувь нь бүх эцэг эх сурах бичгээ худалдан авдаг байх, 4.0 хувь нь бага ангид зорилтод бүлгийн сурагчдыг сурах бичгээр хангах 1.0 хувь нь дунд, ахлах ангийн зорилтод бүлгийн 40.0 хувьд худалдаж авах гэсэн хариултыг өгчээ.

Номын сангийн дотоод орчныг сайжруулах чиглэлээр номын санчид 78.3 хувь нь сургуулийн удирдлагатай, 30.4 хувь нь багш нартай, 39.1 хувь нь сурагчидтай илүү хамтран ажилладаг байна.

Судалгаанд хамрагдсан сургуулиудын сурах бичгийн хангамж хүртээмж нь нийтлэг байдлаар дутагдалтай байгаа төдийгүй цаашид сурах бичгийн хангамж хүртээмжийн менежментийг сайжруулах, сурах бичгийн ашиглалт болон хэрэглээ хэрхэн байгаа талаар судалгааг үргэлжлүүлэх, сурах бичгийн хэвлэлийн дараах материаллаг чанарын хяналт шинжилгээг тасралтгүй хийж байх, сурах бичгийг түрээлэн ашиглах түрээсийн тогтолцоо эргэлтийн санг сэргээх зэрэг шаардлага гарч байна.

*Зураг 137. Номын сангийн дундаж температур*




Судалгаанд хамрагдсан сургуулийн номын сангийн уншлагын танхимын суудлын тоо дунджаар 26 байна. Харин ажиглалт хийж буй цаг хугацаанд уншлагын танхимаар үйлжлүүлж буй сурагчдын тоо суудлын тооноос дунджаар 10 дахин бага буюу 2.6 байна. Нийт сургуулийн 60.0 хувь нь ажиглалт хийх үед уншлагын танхим хоосон буюу хүүхэдгүй байсан байна. Харин 40.0 хувьд нь дунджаар 6-7 сурагч номын сангаар үйлчлүүлж байсан байна.

*Зураг 138. Номын сангийн суудлын тоо, дундаж*




Дээрх зургаар сургуулиудын номын сангийн суудлын тоо байршлаар нь харуулав. Нийслэлийн сургуулиудын номын сангийн суудлын тоо аймаг, сумынхтай ойролцоо байна. Ажиглалт хийж байх тухайн цагт үйлчлүүлж буй хүүхдийн тоо нийслэлийнхээс илүү байсан нь ажиглагдсан. Харин хувийн өмчийн сургуулийн номын сангийн суудлын тоо төрийн өмчийн сургуулийнхаас 5 дахин илүү байна. Өөрөөр хэлбэл төрийн өмчийн сургууль суралцаж буй хүүхдийн номын сангаар үйлчлүүлэх боломж хувийн өмчийн сургуулийн хүүхдийнхээс 5 дахин бага байгаа нь ажиглагдлаа. Ажиглалт хийж байх үед бүх уншлагын танхимын 70.0 орчим хувь нь ямар нэгэн байдлаар хүүхдүүдэд үйлчилгээ үзүүлээгүй байсан байна.

Номын сангаас хүссэн үедээ хэрэгтэй номоо авч ашиглах боломжтой эсэхийг тодруулахад нийт сурагчдын дунджаар 55 хувь нь “боломжтой” гэж хариулсан бол эцэг эхийн 29 хувь нь үргэлж, 27 хувь нь манай хүүхэд ихэнхдээ номын сангаар үйлчлүүлдэг гэж хариулсан байна. Эндээс үзэхэд эцэг эх, сурагчийн хариулт ойролцоо байна. Дээрх хариултыг ажиглалтын судалгаагаар номын сангаар үйлчлүүлж байсан хүүхэд дунджаар 5 байна гэсэн үр дүнтэй харьцуулахад их зөрүүтэй байгаа нь харагдаж байна.

## Кабинетын нөхцөл байдал

Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд, сургалтын орчин кабинет чухал нөлөөтэй юм. ЕБС-ийн кабинетын нэг сурагчид ноогдох талбайн хэмжээ, сурагчийн ширээ хоорондын зай, ашиглаж буй үзүүлэн, техник хэрэгслийн хэрэглээний талаар мэдээлэл цуглуулахад 21 сургуулийн математик, монгол хэл, гадаад хэл, газар зүй, түүх, нийгэм судлал, бага анги, дүрслэх урлагийн хичээлийн 108 кабинетын ажиглалтын үр дүнг танилцуулж байна.

*Зураг 139. Кабинетын урт, өргөний хэмжээ (хувиар)*




Нийслэлийн төрийн өмчийн сургуулийн нэг сурагчид 1.4 $м^2$ талбай ногдох бол аймгийн төрийн өмчийн сургуулийн нэг сурагчид 1.8 $м^2$ талбай ноогдох бол, сумын төвийн сургуулийн нэг сурагчид 2.2 $м^2$ талбай ногдох бол хувийн хэвшлийн сургуулийн нэг

сурагчид 1.6 $м^2$ талбай ноогдож байгаа боловч ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн танхимд 1 хүүхдэд 2.0 $м^2$ талбай ногдохоор төлөвлөдөг. Энэхүү шаардлагаас үзвэл нийслэл, аймгийн төв, хувийн хэвшлийн сургуулийн сурагч ногдсон талбайнаас бага зайд оногдох байдал ажиглагдаж байна. Танхимын зай талбай нь аль ч хичээлийн кабинет байхаас хамааралгүй байна. Сургалт-хүмүүжлийн байгууллагын анги, танхим, бүлгийн үндсэн өрөөнүүдийн агаарын хэм 16-200С байх шаардлагыг 36.0 хувь хангаж байгаа бол 63.0 хувь нь 200С-тай байна. Сургуулийн анги танхимд даардаг эсэхийг тодруулахад асуулгад нийслэл, аймаг, сумын нийт сурагчийн дунджаар 73 хувь нь даардаггүй гэж хариулсан бол нийт эцэг эхийн 71 хувь нь үргэлж, 24 хувь нь ихэнхдээ сургуулийн анги танхимыг дулаан байдаг гэж үзжээ. Иймд байршлаас үл хамааран анги танхим дулаан байна гэж хэлж болохоор байна.

*Зураг 140. Ангийн эгнээ хоорондын зай (хувиар)*




Сурагчийн ширээ, сандлын эгнээ хоорондын 70-75 см зайтай байх шаардлагыг 22.2 хувь нь хангаж байна. “Сургалт-хүмүүжлийн байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм” Кабинетэд 40-70 см хүртэл зайтай 58.3 хувь нь байрлаж байна. Мөн ширээ, сандалын зай гадна хананаас 60-70 см байх шаардлагыг 16.7 хувь хангаж байгаа бол эсрэг талын хананаас 50-60 см байх шаардлагыг 24.1 хувь нь хангаж байна.

*Зураг 141. Самбараас сурагчийн эхний ширээ хүртэл зай (хувиар)*




Кабинетэд самбараас эхний ширээ хүртэл 2-2.7 м зайтай байх шаардлагыг 29.6 хувь нь хангаж байна. “Сургалт-хүмүүжлийн байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм” 0.9-2.0 м хүртэл зайтай 63.0 хувь байгаа нь уг шаардлагыг хангахад цаашид анхаарах хэрэгтэй. Мөн самбарын доод ирмэг шалнаас дээш бага ангид 70-80 см байх шаардлагыг 39.0 хувь нь хангаж байгаа бол, дунд, ахлах ангид 80-90 см байх шаардлагыг 55.6 хувь нь хангаж байна. Кабинетэд байрлах самбарын 92.0 хувь хүрэн, 8.0 хувь хар ногоон байна. Самбарыг хар ногоон буюу хүрэн өнгөөр будна гэсэн шаардлагад бүрэн нийцэж байна.

*Зураг 142. Кабинет дахь үзүүлэн (хувиар)*




Кабинетэд үзүүлэнг ашиглахдаа хичээл/судлагдахууны онцлогоос хамааруулж байна. Биет үзүүлэнг түлхүү математик, дүрслэх урлаг, дизайн технологийн хичээлд 80.0 хувиас дээш ашиглаж байгаа бол Түүх, нийгэм судлал, газар зүйн хичээлд зурагт үзүүлэнг 100.0 хувь ашиглаж байна. Хэвлэмэл үзүүлэнг хичээл/судлагдахуун бүрд адил тэнцүү хэрэглэж байгаа нь ажиглагдлаа. Зурагт үзүүлэнг нийслэлийн сургуульд 100.0 хувь ашиглаж байгаа боловч бусад үзүүлэн нь тухайн сургуулиудын байршлаас хамаарахгүй байна. Кабинетэд унших судлах ном нийт кабинетын 97.2 хувьд нь байдаг бол унших материал 75.0 хувьд нь байна. Сурагчид тухайн хичээлийн хүрээнд уншиж судлах ном, материал хангалтта хэмжээнд бэлтгэсэн байна.

*Зураг 143. Кабинетэд ашиглаж буй техник хэрэгсэл*




Судалгааны явцад хэмжилт хийсэн нийт кабинетын 56.5 хувьд нь зурагт, ухаалаг самбар, проекторын аль нэгийг суурилуулсан. Хөдөө орон нутагт кабинетэд ашиглаж байгаа нийт ухаалаг самбарын 87.5 хувь, проекторын 70.0 хувь, зурагтын 64.0 хувийг ашиглаж байна. Кабинетэд ашиглаж байгаа нийт компьютер, хэвлэгч, хувилагч машин нь аймаг, сумын сургуульд 100.0 хувь ногдож байна.

## Лабораторийн нөхцөл байдал

### *Байгалийн ухааны лаборатори*

Судалгааны материалд дүн шинжилгээ хийхдээ байгалийн ухааны лаборатори тус бүрийн аюулгүй байдал, сургалтад хэрэглэх үзүүлэн, цахим техник хэрэгслийн хангамжийн нөхцөл байдал ямар байгааг тодруулах шилжилгээ хийв. Шинжилгээнд байгалийн ухааны нийт 49 лаборатори хамрагдсанаас 32.0 хувь нь химийн, 39.0 хувь нь физикийн, 29.0 хувь нь биологийнх байна. Үүнээс, Улаанбаатар хотын сургуулиуд 100 хувь лабораторитай, харин аймгийн төвийн сургуулиудын 20.0 хувь нь, сумын сургуулиудын 53.0 хувь нь байгалийн ухааны лабораторигүй байна. Үүнд: Аймгийн

лабораторигүй сургуулиудын 33.0 хувь нь химийн, 17.0 хувь нь физикийн, 50.0 хувь нь биологийн лабораторигүй байна. Сумын сургуулиудын 38.0 хувь нь химийн, 13 хувь нь физикийн, 50.0 хувь нь биологийн лабораторигүй байна.

Ердийн сургуулийн 68.0 хувь нь, цогцолбор сургууль 100.0 хувь байгалийн ухааны лабораторитай байна. Харин гадаад хэлний гүнзгийрүүлсэн сургалттай сургууль 100.0 байгалийн ухааны лабораторигүй байна. Лабораторигүй ердийн сургуулийн 36.0 хувь нь химийн, 9.0 хувь нь физикийн, 55.0 хувь нь биологийн лабораторигүй байна.

Судалгаанд хамрагдсан сургуулиудын 86.0 хувь нь төрийн өмчийн 14.0 хувь нь төрийн бус өмчийн сургуулиуд байна. Үүнээс, төрийн өмчийн сургуулиудын 26 хувь нь, төрийн бус өмчийн сургуулиудын 50.0 хувь нь байгалийн ухааны лабораторигүй байна. Лабораторигүй, төрийн өмчийн сургуулиудын 36.0 хувь нь химийн, 9.0 хувь нь физикийн, 55 хувь нь биологийн лабораторигүй байна. Төрийн бус өмчийн сургуулийн хувьд 33 хувь нь хими, физик, биологийн лабораторигүй байна.

Байгалийн ухааны лабораторуудад хийсэн дүн шилжилгээнээс дараах дүр зураг харагдаж байна. Судалгаанд хамрагдсан сургуулиудын 22 хувь нь байгалийн ухааны лабораторигүй байна. Судалгаанд хамрагдсан лабораториудыг байршил, сургуулийн хэв шинж, өмчийн хэлбэрээр авч үзэхэд биологийн лабораторигүй сургууль 50-55 хувийг, химийн лабораторигүй сургууль 33-38 хувийг, физикийн лабораторигүй сургууль 9-17 хувийг эзэлж байна.

Судалгаанд хамрагдсан хими, физик, биологийн 49 лабораторт нийт талбайн дунджийг тооцож үзэхэд 53 м$^2$ байна. Үүнээс нийслэлийн сургуулийн хими, физик, биологийн лабораторийн талбайн дундаж нь 56 м$^2$, аймгийн сургуулийнх 52 м$^2$, сумын сургуулийнх 50 м$^2$ байна. Лаборатори тус бүрээр нь авч үзэхэд химийн лабораторийн талбайн дундаж 54 хувь, физик, биологийн лабораторийн талбайн дундаж 53.0 хувьтай байгаа нь ерөнхийдөө ижил байна.

*Зураг 144. Хими, физик, биологийн лабораторийн талбай (м$^2$-аар)*




Ердийн сургуулийн лабораторийн талбайн дундаж 53 м$^2$, цогцолбор сургууль 52 м$^2$ , төрийн өмчийн сургууль 54 м$^2$, төрийн бус өмчийн сургууль 53 м$^2$ байна. Гэхдээ төрийн бус өмчийн сургуулиудын лабораторийн талбай харьцангуй ялгаатай байлаа. Зарим төрийн бус өмчийн сургуулийн талбайн дундаж 75 м$^2$ байсан бол зарим сургууль нь 33 м$^2$ байна. Нэг хүүхдэд ногдож буй талбайн хэмжээг авч үзвэл ажиглалтын судалгааны үед хими, физик, биологийн 22 хичээлд оролцож байсан хүүхдийн тооны дундаж (26 хүүхэд), болон 49 лабораторийн талбайн дундаж (53 м$^2$)-ийг ашиглан шинжилгээг гүйцэтгэхдээ “Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн танхимд 1 хүүхдэд 2.0 м$^2$ талбай ногдохоор

төлөвлөнө.”[16], “Нэг сурагчид ноогдох талбай 2-3 м$^2$ байна”[17] гэсэн үлгэрчилсэн дүрэм, судалгааны материалуудыг баримталлаа. Эндээс үзэхэд нийслэл хотод нэг хүүхдэд 1,96м$^2$, аймагт 1,8 м$^2$ , суманд 2.7 м$^2$ талбай ногдож байгаагаас үзэхэд сумын сургуулийн лабораториуд стандарт хэмжээнд байна гэж үзэж байна. Ердийн сургуулийн лабораторид 1 хүүхдэд 2 м$^2$ , цогцолбор сургуульд 1.6 м$^2$ , төрийн өмчийн сургуульд 1.96 м$^2$ , төрийн бус өмчийн сургуульд 2.7 м$^2$ талбай ногдож байгаагаас үзэхэд цогцолбор болон төрийн өмчийн сургуулиуд нэг хүүхдэд ногдох талбайн хэмжээгээр стандарт хэмжээнд байж чадахгүй байна.

Эндээс харахад, сумын болон төрийн бус өмчийн сургуулиудын лабораторийн нэг хүүхдэд ногдох талбай 2,7 м$^2$ стандарт хэмжээнд байна. Хот болон аймаг, цогцолбор, төрийн өмчийн сургуулийн лабораторийн нэг хүүхдэд ногдох талбай стандарт 1.6 м$^2$ - 1,96м$^2$ хэмжээнд хүрэхгүй байна.

Лабораторийн агаарын температурт шинжилгээ хийхдээ “ЕБС-ийн анги танхимын дулаан 18-20$^0$С байна[18], “Сургалт-хүмүүжлийн байгууллагын анги танхим, бүлгийн үндсэн өрөөнүүдийн агаарын дундаж хэм 16-20$^0$С, ...бусад нь 16-24$^0$С” байна”[19], “Биологийн кабинетын экологийн хүчин зүйлийн үзүүлэлтэд ангийн температурын стандарт хэмжээ нь 18±4 байна” гэж заасан үлгэрчилсэн дүрэм, баримт бичгүүдээс 18±4 гэсэн агаарын температурын үзүүлэлтийг баримтлан шинжилгээг гүйцэтгэлээ.

Хими, биологи, физикийн 49 лабораторийн агаарын температурын дундаж 21$^0$С, лаборатори тус бүрийн дундаж мөн 21$^0$С градус байна. Нийслэлийн сургуулиудын лабораторийн дундаж температур 22 градус, аймгийнх 21 градус, сумынх 20 градус байгаа нь температурын хувьд стандартын хэмжээнд байна гэж үзэж болохоор байна. Ердийн сургуулийн дундаж температур стандарт хэмжээнээс давсан (23$^0$С), цогцолбор сургуулийн лабораторийн дундаж температур (21$^0$С) стандарт хэмжээнд байна. Төрийн болон төрийн бус өмчийн сургуулийн лабораторийн агаарын температур стандарт хэмжээнд 21$^0$С - 22$^0$С байна. Харин 16 хими, 19 физикийн лабораторийн хувьд 4 лаборатори тутмын нэг нь (23$^0$С - 30$^0$С), 14 биологийн лабораторийн 9 нь дунджаас дээш (23$^0$С - 24$^0$С) температуртай байна.

Байгалийн ухааны лабораториудын самбарын өнгө 79-94 хувь нь ногоон өнгөтэй байна. Хананы өнгөний хувьд цайвар шар, цайвар ногоон өнгө 25-43 хувь, шалны өнгөний хувьд 14-32 нь улбар шар, шар, бор өнгө эзэлж байгаа нь хамгийн өндөр хувь эзэлж байна. Байгалийн ухааны лаборатори (хими, физик, биологи)-ийн самбарын урт 2м-2.4м, 3-3.6м-ийн урттай, өндөр нь 1.2м байгаа нь хамгийн өндөр хувь эзэлж байна.

Нийслэлийн сургуулиудын байгалийн ухааны лабораториудын 28.0 хувь нь цахим үзүүлэнтэй байгаа нь аймаг сумын лабораториудтай харьцуулахад бараг 3 дахин бага байна. Цогцолбор сургуулиудын 33.0 хувь нь, ердийн сургуулиудын 60.0 хувь нь, төрийн

[17] Физикийн сургалтын орчны загвар

[18] “Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн хөтөлбөр” сургалтын модуль, 2017

[19] Сургалт хүмүүжлийн байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм, МХЕГ-ын даргын 2017 оны 11-р сарын 01-ний өдрийн А/179 дүгээр тушаал

бус өмчийн сургуулиудын 17.0 хувь нь, төрийн өмчийн сургуулиудын 63.0 хувь нь цахим үзүүлэнтэй байна. Байгалийн ухааны лабораториудыг судлагдахуун тус бүрээр авч үзэхэд хими, физик, биологийн лабораториудад цахим үзүүлэн бусад үзүүлэнгүүдтэй харьцуулахад бага байна. Үүнд: физикийн лабораториудын 47.0 хувь нь, химийн 37.5 хувь нь, биологийн 43.0 хувь нь цахим үзүүлэнгүй байна.

*Зураг 145. Байгалийн ухааны лабораторийн үзүүлэн (байршлаар)*




Улаанбаатар хотын сургуулиудын 67.0 хувь нь биет үзүүлэнтэй байгаа нь аймаг сумын биет үзүүлэнтэй лабораториудтай харьцуулахад 14-17.0 хувь бага байна. Зурагт болон хэвлэмэл үзүүлэнтэй лабораторийг байршил, сургуулийн хэв шинж, өмчийн хэлбэрээр үзэхэд 80-100 хувь хангагдсан байна. Төрийн өмчийн сургуулиудыг бодвол төрийн бус өмчийн сургуулиуд биет болон зурагт, хэвлэмэл үзүүлэн 100.0 хувь хангасан байна.

Эндээс үзэхэд, байгалийн ухааны лабораториудад цахим үзүүлэн бусад үзүүлэнтэй харьцуулахад 2-3 дахин бага байна. Мөн нийслэлийн сургуулиудын байгалийн ухааны лабораториуд аймаг, сумын сургуулиудын лабораторийг бодвол биет үзүүлэн (20-30 хувь) бага байна. 80-100 хувь нь зурагт болон хэвлэмэл үзүүлэнтэй лаборатори байгаа нь байршил, сургуулийн хэв шинж, өмчийн хэлбэр харгалзахгүй нийтлэг байна.

Лабораториудад компьютераас бусад цахим техник хэрэгсэл 10-30-тай, үлдсэн 70-90 хувь нь цахим техник хэрэгсэлгүй байна.

*Зураг 146. Лаборатори дахь цахим техник хэрэгсэл*




Ухаалаг самбар хот, сумын сургуульд огт байхгүй байна. нийслэл, аймгийн байгалийн ухааны лабораториудад сумын байгалийн ухааны лабораторийг бодвол цахим техник хэрэгсэл бага байна. Ухаалаг самбартай лаборатори 7-13 хувь, үлдсэн 87-93 хувь нь ухаалаг самбаргүй байна. Ердийн сургуулийн хувьд зурагт, компьютер, проектор нь цогцолбор сургуулийн байгалийн ухааны лабораториудтай харьцуулахад 22-23 хувиар илүү байна. Төрийн бус өмчийн сургуулиудад судалгаанд дурдсан бүх цахим техник хэрэгслээр 50-83 хувь нь хангагдсан байгаа нь төрийн өмчийн сургуулиудаас илүү

хангалттай байна. Төрийн өмчийн сургуулийн байгалийн ухааны лаборатори нь зурагт, хэвлэгч хувилагч машинаар 30.0 хүртэл хувь хангагдаж, бусад цахим техник хэрэгсэл нь 10-20 хувь л хангагдсан байна. Эндээс дүгнэж үзэхэд байгалийн ухааны лабораториудад 60.0 хувь нь зурагт, 87.0 хувь нь ухаалаг самбар, 14-44.0 хувь нь компьютер, 70.0 хувь нь проектор, 57-90 хувь нь зөөврийн самбар, 30-70 хувь нь хэвлэгч хувилагч машин тус тус байхгүй байна.

Эндээс үзэхэд дараах дүр зураг харагдаж байна. Цахим техник хэрэгсэлтэй лабораториуд 10-30 хувийг эзэлж байна. Хот болон аймгийн сургуулиуд цахим техник хэрэгслээр сумдын сургуулиудаас бага байна. Байгалийн ухааны лабораторигүй сумдын сургуулиуд аймаг болон хотын сургуулиас их байна. Компьютераас бусад цахим техник хэрэгсэл 50-аас доош хувийг эзэлж байна.

### *Туршилт судалгааны багаж төхөөрөмж*

Судалгаанд хамрагдсан байгалийн ухааны лабораториудад туршилт судалгааны багаж төхөөрөмжтэй нь 61-79 хувийг эзэлж байна. Нийслэлд 40.0 хувь нь, аймагт 20.0 хувь нь, сумдад 30.0 хувь нь туршилт судалгааны багаж төхөөрөмжгүй байна. Аймгийн байгалийн ухааны лабораториуд хот болон сумын байгалийн ухааны лабораториудтай харьцуулахад туршилт судалгааны багаж төхөөрөмжөөр 8-18 хувиар илүү хангагдсан байна. Цогцолбор сургуулийн байгалийн ухааны лабораториудад 83.0 хувь нь, ердийн сургуулиудын 70.0 хувь нь, төрийн бус өмчийн сургуулиудын 83.0 хувь нь, төрийн өмчийн сургуулиудын 70.0 хувь нь туршилт судалгааны шаардлага хангасан багаж төхөөрөмжтэй байна.

Харин шаардлага хангасан туршилт судалгааны багаж төхөөрөмжтэй хэрнээ 40-70 хувь нь багаж төхөөрөмжөө ашиглах зааварчилгаагүй байгаа нь нийтлэг байна. Мөн 20-30 хувь нь туршилт судалгааны багаж төхөөрөмжийн осол аюулгүйн шаардлага хангаагүй байгаа нь бүх сургуулиудад нийтлэг байна.

Эндээс харахад дараах дүр зураг харагдаж байна. Байршил, сургуулийн хэв шинж, өмчийн хэлбэр харгалзахгүй 20-40 хувь нь туршилт судалгааны багаж төхөөрөмжгүй байна. Ялангуяа, Улаанбаатар хотын сургуулиудын лабораториудад аймаг, сумын сургуулиудаас бага байна. Туршилт судалгааны багаж төхөөрөмжтэй хэрнээ туршилт судалгааны төхөөрөмжийг ашиглах зааварчилгаагүй байгаа нь сургуулиудад байршил, сургуулийн хэв шинж, өмчийн хэлбэр харгалзахгүй нийтлэг байна.

### *Лабораторийн аюулгүй байдал*

Улаанбаатар хотын байгалийн ухааны лабораториудын 11.0 хувь нь, аймгийн 14.0 хувь нь, сумын 42.0 хувь нь эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх сантай байна. Ердийн болон төрийн өмчийн сургуулиудын 28.0 хувь нь, цогцолбор болон төрийн бус өмчийн сургуулиудын 17 хувь нь тус бүр эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх сантай байна. Эндээс үзэхэд 90.0 хувь нь Улаанбаатар хот болон аймагт, 60.0 хувь нь сумдын лабораториудад эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх сангүй байгаа нь ер нийтлэг харагдаж байна.

Улаанбаатар хотын байгалийн ухааны лабораториудын 60.0 хувь нь, аймаг болон сумдад, ердийн болон төрийн өмчийн сургуулиудын тус бүр 70.0 хувь нь, цогцолбор сургуулийн 50.0 хувь нь, төрийн бус өмчийн сургуулиудын 30.0 хувь нь цэвэр усны

угаалтуургүй байна. Эндээс үзэхэд "Лаборатори усаар хангагдсан байна, лаборатори унь ус түгээгүүрээр тоноглогдсон байна" гэсэн Сургалт хүмүүжлийн байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэмд заасантай зөрчилдөж байна. Улаанбаатар хотын сургуулиудад 67.0 хувь нь, аймаг, сумын сургуулиудад 71.0 хувь нь, ердийн сургуулиудад 44.0 хувь нь, цогцолбор сургуулиудад 17.0 хувь нь, төрийн өмчийн сургуулиудад 35.0 хувь нь, төрийн бус өмчийн сургуулиудад 83.0 хувь нь осол аюулгүй ажиллах дүрэм, зааваргүй байна.

*Зураг 147. Байгалийн ухааны лабораторийн аюулгүй байдал*




Нийслэлд 2 сургууль тутмын 1 нь цахилгааны залгуур, холболтын аюулгүй байдал хангалтгүй байна. Харин төрийн бус өмчийн сургуулиудын хувьд цахилгааны залгуур, холболт далдлан битүүмжлэгдсэн байдлаа 100.0 хувь хангасан байна. Төрийн өмчийн сургуулиуд 67.0 хувь нь, ердийн болон цогцолбор сургуулиудын 70-86 хувь нь цахилгааны аюулгүй байдлаа хангасан байна.

Судалгаанд хамрагдсан сургуулиудын 90.0 хувь нь мэдээллийн технологийн лабораторитай, 10 хувь нь лабораторигүй ба үүнээс, 5 хувь нь аймгийн гүнзгийрүүлсэн сургалттай төрийн бус өмчит сургууль, 5 хувь нь ердийн, төрийн өмчит сумын сургууль байна. Судалгаанд хамрагдсан мэдээллийн технологийн 19 лабораторийн талбайн дунджийг тооцож үзэхэд 47 м$^2$ байна. Үүнээс, нийслэлийн сургуулийн мэдээллийн технологийн лабораторийн талбайн дундаж нь 42 м$^2$, аймгийн сургуулийнх 51 м$^2$, сумын сургуулийнх 44 м$^2$ , ердийн сургуулийнх 46 м$^2$, цогцолбор сургуулийнх 48 м$^2$ , төрийн өмчийн сургуулийнх 48 м$^{2,}$ төрийн бус өмчийн сургуулийнх 38 м$^2$ байна.

*Зураг 148. Мэдээллийн технологийн лабораторийн талбай (м$^2$-аар)*




Эндээс нэг хүүхдэд ногдох талбайн дунджийг нийслэл, аймаг, сумаар гаргахдаа ажиглалтын судалгааны үед мэдээллийн технологийн 7 хичээлд оролцож байсан хүүхдийн тооны дунджийг нийслэл, аймаг, сумаар гарган тооцож үзэхэд *нийслэлд 1.68 м$^2$ , аймагт 2.2 м$^2$, сумдад 2 м$^2$ талбай тус тус ногдож байгаа нь стандарт хэмжээнээс 2 дахин бага байна.* "Компьютерийн кабинетад 1 хүүхдэд 4-5 м$^2$

талбай ноогдоно”[20] ”гэсэн үлгэрчилсэн дүрмийн 3.21-д заасныг баримтлан үзэхэд нэг хүүхдэд ногдох талбай стандарт хэмжээнд хүрэхгүй байгааг харуулж байна.

Агаарын температурт шинжилгээ хийхдээ “Сургалт-хүмүүжлийн байгууллагын анги танхим, бүлгийн үндсэн өрөөнүүдийн агаарын дундаж хэм 16-20$^{0}$С, ...бусад нь 16-24$^{0}$С” байна”[21], гэсэн агаарын температурын үзүүлэлтийг баримтлан шинжилгээг гүйцэтгэлээ.

*Зураг 149. Мэдээллийн технологийн лабораторийн агаарын хэм*




Мэдээллийн технологийн 19 лабораторийн агаарын температурын дунджийг гаргаж үзэхэд 20$^{0}$С градус байна. Нийслэлийн сургуулиудын лабораторийн дундаж температур 22$^{0}$С, аймгийнх 22$^{0}$С байгаа нь температурын хувьд стандартын хэмжээнд харин сумын сургуулийнх 15$^{0}$С байгаа нь стандарт хэмжээнээс доогуур байна. Ердийн сургуулийн дундаж температур 20$^{0}$С, цогцолбор сургуулийнх 23$^{0}$С, төрийн сургуулийнх 20$^{0}$С, төрийн бус сургуулийнх 22$^{0}$С байгаа нь 16-24$^{0}$С байх стандарт хэмжээнд нийцэж байна. Эндээс үзэхэд *сумын сургуулийн мэдээллийн технологийн агаарын дундаж хэм стандарт хэмжээнээс доогуур 15$^{0}$С байна.*

Мэдээллийн технологийн лабораторийн самбарын өнгөний 79.0 хувь нь ногоон, 16.0 хувь нь цагаан байна. Нэг лаборатори самбаргүй байна. Хананы өнгөний хувьд цайвар шар, цайвар ногоон байгаа нь хамгийн өндөр буюу тус бүр 28.0 хувь байна. Энэ нь “цайвар шар, цайвар ногоон өнгө байна”[22] гэсэн заалттай нийцэж байна. Шалны өнгөний хувьд 33.0 хувь нь шаргал, 22.0 хувь нь шар өнгө эзэлж байгаа нь хамгийн өндөр байна. Самбарын урт дунджаар 1.9 м, өндөр нь 1м байгаа нь хамгийн өндөр хувь эзэлж байна.

*Үзүүлэн, таниулах материал*

Аймгийн сургуулиудын мэдээллийн технологийн лабораториудад үзүүлэнгийн бүх төрөл нийслэл, сумын сургуулиудын мэдээллийн технологийн лабораториудаас судалгаанд дурдсан үзүүлэнгийн бүх төрлүүдээр илүү байна. Харин *нийслэл, сумын сургуулиудад 17-25 хувь нь биет үзүүлэнтэй байна.* Ердийн сургуулиудын лабораториудын 82-88 хувь нь зурагт, цахим, хэвлэмэл үзүүлэнтэй байна. Цогцолбор сургуулиудын хувьд үзүүлэнгийн бүх төрөл 50 хувьтай байна. Төрийн бус өмчийн сургуулиуд 100 хувь зурагт болон хэвлэмэл үзүүлэнтэй, харин 50 хувь нь биет болон цахим үзүүлэнтэй байна. Төрийн өмчийн сургуулиудын 80-аас дээш хувь нь зурагт, цахим, хэвлэмэл үзүүлэнтэй байна. Байршил, сургуулийн хэв шинж, өмчийн аль ч хэлбэрээр авч үзсэн биет үзүүлэн хамгийн бага буюу 50-аас доош хувьтай, цахим үзүүлэн 50-79 хувьтай байна.

[20] Сургалт хүмүүжлийн байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм, МХЕГ-ын даргын 2017 оны 11-р сарын 01-ний өдрийн А/179 дүгээр тушаал
[21] Сургалт хүмүүжлийн байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм, МХЕГ-ын даргын 2017 оны 11-р сарын 01-ний өдрийн А/179 дүгээр тушаал
[22] Сургалт хүмүүжлийн байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм, МХЕГ-ын даргын 2017 оны 11-р сарын 01-ний өдрийн А/179 дүгээр тушаал

*Зураг 150. Үзүүлэн*




Мэдээллийн технологийн лабораториудад ухаалаг самбар, зөөврийн самбар, зурагт 50 болон түүнээс доош хувьтай байна. Аймгийн сургуулиудын хувьд проектор 100 хувь хангагдсан байна.

*Зураг 151. Цахим техник хэрэгсэл*




Цогцолбор сургуулиудын 50 хувь нь зурагт, ухаалаг самбар, проектор, зөөврийн самбартай, 100 хувь хэвлэгч хувилагч машинтай байна. Ердийн сургуулиудын 30-35 хувь нь зурагт, ухаалаг самбар, зөөврийн самбартай, 47 хувь нь хэвлэгч хувилагч машинтай, 71 хувь нь проектортой байна. Төрийн бус өмчийн сургуулиудад зурагт, ухаалаг самбар, зөөврийн самбар огт байхгүй, 50 хувь нь проектор, хэвлэгч хувилагч машинтай байна. Төрийн өмчийн сургуулиудын хувьд 35-40 хувь нь зурагт, ухаалаг самбар, зөөврийн самбартай, 53-71 хувь нь хэвлэгч хувилагч машин, проектортой байна. *Эндээс үзэхэд байршил, сургуулийн хэв шинж, өмчийн аль ч хэлбэрээр авч үзсэн мэдээллийн технологийн лабораториудад зурагт, ухаалаг болон зөөврийн самбар 50-аас доош хувьтай байна.*

*Зураг 152. Туршилтын багаж төхөөрөмж*




Нийслэл болон сумын мэдээллийн технологийн лабораториуд шаардлага хангасан компьютераар 100 хувь, аймгийн сургуулиуд 89 хувь хангагдсан хэдий ч төхөөрөмжтэй ажиллах зааварчилгаа нь байршил, сургуулийн хэв шинжээр авч үзэхэд 70-аас доош хувьтай, ялангуяа сумын сургуулиуд 25 хувьтай байна. Энэ нь "Компьютерийн танхимд осол, аюулгүй ажиллах, үйлчлүүлэх дүрэм заавар, санамжийг ойлгомжтой хэлбэрээр бичиж, багш сурагч бүрт танилцуулсан байна."[23] гэсэн заалт хангалтгүй хэрэгжиж байна гэж үзэж болохоор байна. *Цэвэр усны угаалтуур аль ч хэлбэрийн сургуулиудад огт байхгүй, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх сантай лаборатори 6-25 хувьтай байгаа нь аюулгүй ажиллах шаардлага хангагдаагүй байна гэж үзэж болохоор байна.*

*Зураг 153. Аюулгүй байдал*




Мөн "эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх сан ... байрлуулсан байна", "Танхимд байрлуулсан компьютер, сургалын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн холболтын утас нь далдлан битүүлмжлэгдсэн байна"[24] гэсэн заалтуудыг сургуулийн аюулгүй байдлын үүднээс сайтар хангах шаардлагатай байна. Төрийн бус өмчийн сургуулиудын хувьд цахилгааны залгуур, холболтын аюулгүй байдлыг 100 хувь хангасан байгаа нь төрийн бус өмчийн байгалийн ухааны лабораториудад мөн адил байсан.

[23] ЕБС-ийн компьютерийн танхимд тавих үлгэрчилсэн шаардлага, БСШУ-ны сайдын 2006 оны 413-р тушаал

[24] Сургалт хүмүүжлийн байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм, МХЕГ-ын даргын 2017 оны 11-р сарын 01-ний өдрийн А/179 дүгээр тушаал

Сургалтын хэрэглэгдэхүүний талаар сурагч, багш нараас хэрэглэдэг байдал, хүртээмжтэй эсэхийг асуулгаар тодруулав. Лабораторийн хэрэглэгдэхүүн, техник, урвалж бодис, биет загвар, бодит үзүүлэн, сургалтын хэвлэмэл ном, гарын авлага болон биеийн тамирын хэрэглэл, хөгжмийн зэмсэг, дүрслэх урлаг, технологийн багаж хэрэгсэл нь хүртээмжтэй, үргэлж хэрэглэдэг, хичээл төлөвлөхдөө байнга ашигладаг гэж хариулсан багшийн хувийг хооронд нь харьцуулж үзэхэд жигд бөгөөд 4-8 хувийн хооронд хэлбэлзэж байгаа учраас тохирч байна гэж үзлээ.

*Зураг 154. Сургалтын хэрэглэгдэхүүний хэрэглээ, хүртээмж (багшийн хариулт)*




*Хүснэгт 240. Сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмж, хэрэглээ*

| | *Лабораторийн урвалж бодис, техник* | *Биет, бодит загвар, үзүүлэн* | *Хэвлэмэл ном, тест, даалгаврын сан* |
|---|---|---|---|
| хичээлд төлөвлөдөг | 17% | 33% | 51% |
| үргэлж хэрэглэдэг | 10% | 37% | 56% |
| хүртээмжтэй | 16% | 42% | 48% |

Сургалтын хэрэглэгдэхүүн хүртээмжтэй, үргэлж хэрэглэдэг, хичээл төлөвлөхдөө байнга ашигладаг гэсэн 3 асуулгын хувийг байгалийн ухаан, дизайн технологийн лабораторийн хэвлэмэл үзүүлэн (дунджаар 67 хувь), цахим үзүүлэн (дунджаар 60 хувь)-тэй гэсэн ажиглалтын судалгааны дундаж хувьтай харьцуулахад дээрх 3 асуулгын хувь 10-20-оор бага хувьтай байна. Энэ нь ажиглалтын судалгаанд зөвхөн анги танхимд байгаа нүдэнд үзэгдэх үзүүлэнг тооцож, сэдэв бүрийн нарийн шаардлагатай үзүүлэнг тооцоогүйтэй холбоотой гэж үзэж байна.

Телевизор, проектор, ухаалаг самбар зэрэг дэлгэцийн тоног төхөөрөмж хүртээмжтэй гэж багш нарын 32.0 хувь нь хариулсан дээрх хариултыг лабораторийн орчны ажиглалтын (компьютероос бусад) цахим техник хэрэгсэлтэй гэж хариулсан үр дүнгийн дундаж 28.0

хувьтай харьцуулахад ойролцоо байна. Эндээс үзэхэд компьютероос бусад цахим техник хэрэгслийн хүртээмжгүй байдал 70.0 хувьтай байна (зөвхөн байгалийн ухааны лабораториудад) гэдэг нь батлагдаж байна. Эндээс үзэхэд лабораторийн хэрэглэгдэхүүн, техник, урвалж бодис, биеийн тамирын хэрэглэл, хөгжмийн зэмсэг, дүрслэх урлаг, дизайн технологийн хичээлийн багаж хэрэгслийн хүртээмжгүй байдал 80.0-90.0 хувь байна гэж хариулсан байна. Гэтэл ажиглалтын явц дахь дизайн технологийн лабораториуд дунджаар 14 хувь (компьютероос бусад) нь цахим техник хэрэгсэлтэй байна гэсэн үр дүнтэй нийцэж байна. Өөрөөр хэлбэл, 86.0 хувь нь сургалтын хэрэглэгдэхүүн хүртээмжгүй гэж хариулсан багш нарын хариулттай тохирч байна. Гэтэл нийт сурагчдын дунджаар 70.0-90.0 хувь нь хэрэглэгдэхүүн, материаллаг хэрэгсэлтэй хичээлийг илүү сайн ойлгодог, дуртай гэж хариулснаас үзэхэд сургалтын багаж хэрэгсэл, биет, бодит материал дээр ажиллах хэрэглэгдэхүүний хүртээмжийг зайлшгүй нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

Судалгаанд хамрагдсан дунд, ахлах ангийн сурагчдын дунджаар 57.0 хувь нь хими, физик, биологийн хичээлд лабораторийн хэрэглэгдэхүүн, урвалж бодис, биет үзүүлэн хэрэглэдэг гэж хариулсан бол 54.0 хувь нь гадаад хэлний хичээлд CD, хөгжим ашигладаг, 93.0 хувь нь мэдээллийн технологийн хичээлд компьютер хэрэглэдэг, 96.0 хувь нь биеийн тамирын хичээлд бөмбөг, дээс, олс ... зэрэг хэрэглэгдэхүүн хэрэглэдэг, 31.0 хувь нь хөгжмийн хичээлд бишгүүр, CD, даралтат хөгжим, бөмбөр ... хэрэглэдэг, 61.0 хувь нь дүрслэх урлаг, дизайн технологийн хичээлд оёдлын машин, мужааны багаж хэрэгсэл ашигладаг гэж тус тус хариулсан сурагчдын асуулгыг багшийн асуулгатай харьцуулж үзэхэд сургалтын техник хэрэгсэл, материал хэрэглэл хичээлд хэрэглэдэг гэж үзсэн багш хариултын эзлэх хувь 2-3 дахин бага байна. Энэ нь багшаас сэдэв бүрд шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүнийг нарийн төлөвлөж тооцдогтой холбоотой гэж үзэж болохоор байна.

## Дотуур байрны нөхцөл байдал

Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд хүүхдийн эрүүл аюулгүй, эсэн мэнд амьдрах, хамгаалагдах, тэдний хөгжих, оролцох эрхийг хангасан орчин бүрдсэн эсэхийг тодруулав.

*Зураг 155. Дотуур байранд амьдарсан хугацаа, жилээр*




Судалгаанд хамрагдсан дотуур байранд амьдардаг хүүхдүүдийн тухайн байранд амьдарсан жилийг авч үзэхэд, олонх нь 1-3 жил амьдарч байгаа ажээ. 7-оос дээш жил амьдарсан хүүхэд 12.0 хувь байна.

### *Дотуур байрны орчин нөхцөл*

Судалгаанд 40-180 сурагчтай дотуур байр хамрагдсан. Хүүхдүүдтэй дотуур байрын орчин нөхцөлийн талаар ярилцахад нэг өрөөнд дунджаар 5-6 сурагч амьдардаг байна. Харин хамгийн олондоо 8-уулаа, багадаа 3 сурагч амьдардаг бөгөөд судалгаанд хамрагдсан өрөөний 68.7 хувьд нь хүүхдийн тоотой тэнцүү тоогоор ортой, 25.0 хувь нь хүүхдийнхээ тооноос цөөн тооны ортой байна. Өөрөөр хэлбэл судалгаанд хамрагдсан 4 өрөө тутмын нэг нь амьдарч байгаа хүүхдийн тооноос 1-2-оор бага тооны ортой гэжээ. Энэ нь бага ангийн дүүтэйгээ хамт нэг ор хэрэглэж байгаатай холбоотой байна. Суалгаанд хамрагдсан өрөөний 50.0 хувь нь дотроо ус буцалгагчтай, 30.0 орчим хувь нь зурагттай байна. Харин өрөөндөө зурагтгүй ч нийтээр үзэх боломжтой өрөө бүх дотуур байранд байдаг байна.

Өрөө бүрд нэг ширээ, 3-4 ширхэг сандал байна. Өрөөндөө гэрийн даалгавар хийх боломж, нөхцөлийн талаар өрөөндөө гэрийн даалгавар хийх, хичээл давтах боломж хомс байдаг, ширээ сандал хүрэлцдэггүй, хүүхэд хөгжлийн өрөө эсвэл номын санд хийх боломжтой гэж хариулж байна.

Ихэнх сурагчид нэг өрөөнд амьдрах хүүхдийн тоог олон гэж үзжээ. Улмаар нэг өрөөнд хэдүүлээ амьдрах хүсэлтэй талаар тодруулахад ихэнх сурагч 4 байх нь зохимжтой гэж хариулсан байна. Өрөөндөө ижил насны, эсвэл нэг ангийн сурагчид хамт байхаас илүүтэй холимог буюу ах дүү нартайгаа хамт байхыг судалгаанд хамрагдсан бүх сурагчид дэмжсэн байна. Бага ангийн сурагчид төрсөн ах, эгч, хамаатан, садан төрлийн хүүхдүүдтэй нэг өрөөнд амьдрах бөгөөд тэд үе тэнгийн хүүхдүүдтэй нэг өрөөнд хамтдаа байхаас өөрийн ах, эгч, хамаатан, садан төрлийн хүүхдүүдтэй хамтдаа байх сонирхолтой байдаг нь ярилцлагаас харагдав. Өрөөндөө бага, дунд, ахлах ангийн сурагчид холимогоор амьдардаг тул гэрийн даалгавар хийх, хичээл давтахад ах эгч нар нь багачууддаа тусалдаг, ер нь бие биенээсээ асууж, ярилцдаг байна.

> Манай дотуур байрны ах Намжил 8 дугаар ангид сурдаг. Тэр байрны дарга, их ухаантай ах биднийг гэрийн даалгавраа хийхэд тусалдаг.
>
> *4 дүгээр ангийн сурагч*

Хүүхдүүдийн амьдрах өрөөний талбайн хэмжээг хэмжихэд дунджаар 20.36 кв.м байна. Энэ хэмжээг хүүхдийн тоонд харьцуулж, нэг хүүхдэд ногдох талбайн хэмжээг тооцоолоход 3.87 кв.м байна. Энэ нь БСШУ, ЭМ-ийн сайдын хамтарсан 2008 оны 84/43 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага”-ын 1.1-д заасан дотуур байрны нэг хүүхдэд ногдох талбайн хэмжээ 5 кв.м-ээс багагүй байна гэсэн шаардлагад нийцэхгүй байна. Өөрөөр хэлбэл, судалгаанд хамрагдсан нийт өрөөний 88.0 орчим хувь нь дээрх шаардлагыг хангахгүй байна гэж үзэж болно. Дотуур байр бүр мөрдөх дүрэм, журамтай бөгөөд коридортоо мэдээллийн самбар ажиллуулдаг байна.

Судалгаанд хамрагдсан дотуур байрын өрөөний температурыг хэмжихэд дунджаар $22^{0}$C байсан бөгөөд нийт өрөөний 30.0 орчим хувь нь +20-оос бага хэмтэй байна. Хүүхдүүдтэй хийсэн бүлгийн ярилцлагаас харахад нийт сурагчийн 65.0 хувь нь өөрийн амьдардаг өрөө нь дулаахан байдаг гэж хариулсан байхад үлдсэн хувь нь өвөлдөө хүйтэн байдгийг

дурджээ. Мөн өглөө, оройдоо сэрүүн, цонхны хагархайгаар дулаан алддаг талаар тэд ярьсан байна. Дээрх шаардлагын 1.10-д өрөө, тасалгааг $20^0$С-оос доошгүй хэм байхыг заасан байдаг. Тэгвэл судалгаанд хамрагдсан байрын 30 орчим хувь нь дээрх шаардлагад нийцэхгүй байна.

Өглөө эрт хүүхдүүдийг байрын багш, эсвэл жижүүр хүүхдүүд сэрээдэг бөгөөд нэг л сургуулийн дотуур байр хөгжмийн аяар сэрээдэг байна. Тасгийн жижүүр хүүхдүүд тухайн өдрийнхөө бүхий л үйл ажиллагааг хариуцаж хийдэг байна. Жишээ нь: Хоол цай зөөх, аяга таваг хураах, гал тогооны ажилд туслах, бага ангийн сурагчдын гэрийн даалгаврыг хийлгэх гэх мэт.

Орой бага ангийн сурагчид 21 цагт, дунд ахлах ангийнхан 22-23 цагт унтдаг бөгөөд бага ангийн сурагчид хоногт дунджаар 10 цаг унтаж амардаг ажээ. Өрөөний гэрлийг дотуур байрын багш, хүүхдүүд өөрсдөө унтраадаг.

Судалгаанд хамрагдсан дотуур байрын 33.0 хувь нь угаалгын өрөөндөө халуун устай бөгөөд 17 орчим хувь нь төвийн нэгдсэн системд холбогдсон татуургатай жорлонтой байгаа нь ажиглагдлаа. Өөрөөр хэлбэл, судалгаанд хамрагдсан сурагчдын 80.0 орчим хувь нь байрын гаднах модон жорлон хэрэглэдэг гэжээ. Нийт сурагчдын 30.0 орчим хувь нь дотуур байртаа зориулсан модон жорлон биш, сургуулийн гаднах жорлонг хэрэглэдэг, олон хүүхэд ордог тул цэвэрхэн биш, бохир байдаг гэж хариулжээ. Гаднах бие засах газар байртай ойрхон бөгөөд гаднаа гэрэлтэй байдаг боловч хоёр сурагч тутмын нэг нь бие засахаар гарахдаа айдаг тул бөөнөөрөө явдаг гэж хариулжээ. Ялангуяа өвлийн улиралд бие засах газар явах хэцүү байдгийг дурдсан байна. Байрын гадна байрлах бие засах газрын 2 суултуур тутмын нэг нь эрэгтэй, эмэгтэй гэсэн таних тэмдэггүй, 3 суултуур тутмын хоёр нь бага насны хүүхдэд тохиромжгүй бөгөөд бүх жорлонг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хэрэглэх боломжгүй нь ажиглагдсан байна. Сурагчид жорлон хаалгагүй, цоожгүй байх, хогийн савгүй, хогийн савтай байлаа ч тэр нь таггүй байх нь нийтлэг байгааг дурдав. Нийт дотуур байрын 30.0 орчим хувь нь халуун усанд орох боломжтой. Өөрөөр хэлбэл, дотуур байрт амьдарч байгаа 3 сурагчийн нэг нь л халуун усанд орох боломжоор хангагдсан байна. Сурагчидтай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс харвал:

> Халуун усанд орох газар байхгүй. Таньдаг айлд юмуу өөр халуун усны газар очиж ордог. Заримдаа тэр нь ажилладаггүй. Тэгээд тэр нь байлаа ч гэсэн долоо хоног бүр очоод усанд оръё гэхээр 3500-4000 төгрөгийн үнэтэй байдаг. Бидэнд энэ нь үнэтэй байдаг. Тийм болохоор жаахан бэрхшээлтэй байна.
>
> *11 дүгээр ангийн сурагч*

БСШУ, ЭМ-ийн сайдын хамтарсан 2008 оны 84/43 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан "Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага"-ын 1.6 дэх зөөврийн усан хангамжтай нөхцөлд ч нам даралтын зуухаар халаах эрүүл ахуйн шаардлага хангасан халуун, хүйтэн усан сантай байна гэсэн шаардлагыг ихэнх байр хангахгүй байна.

Мөн хувцасаа угаах боломж, хатаах талбай бий эсэхийг тодруулахад нийт байрын 50.0 хувь нь угаалгын машинтай, хувцас хатаах талбайтай байна. Харин бусад сурагчдын

зарим нь хувиасаа угаалгын машин авчирсан байдаг ба ер нь ихэнхдээ худгаас ус зөөж, гараараа угаадаг болохыг хүүхдүүдтэй хийсэн ярилцлагаар тодруулав.

Нийт дотуур байрын 80 орчим хувь нь гал унтраах багаж хэрэгсэлтэй ч галын аюулгүй гарц, тэмдэг тэмдэглэгээ хийгээгүй байх үзэгдэл нийтлэг байгаа нь ажиглагдсан байна. Мөн гурван байр тутмын хоёр нь ил, задгай цахилгааны утас, холболтгүй боловч, цахилгаан, хүчдэлийн аюулгүй байдлыг анхааруулсан тэмдэг, тэмдэглэгээ дутмаг байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн орох гарах хаалга, шаттай байр 20.0 хүрэхгүй хувийг эзэлж байна. Сурагчид байрын ойролцоо машин зам, ухсан нүх байхгүй, хүүхдүүд гэмтэж бэртсэн тохиолдол гараагүй гэж хэлсэн. Хүүхдийн амьдрах орчны аюулгүй байдлыг машин зам, нүх төдийгөөр хязгаарлахгүйгээр гал, цахилгааны аюулгүй байдлыг хангах тэмдэг, тэмдэглэгээ хийх, түүнийг таниулах хэрэгтэй байна. “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага”-д энэ төрлийн шаардлага, үзүүлэлтийг тусгах хэрэгтэй байна. Уг шаардлагад хүүхдийн аюулгүй байдлыг хэрхэн хангаж ажиллах талаар дурдаагүй байна.

Ажиглалтаар дотуур байрын хооллох танхимын суудлын тоо дунджаар 36, талбайн хэмжээ дунджаар 46-47 кв.м байна. Тухайн байрт амьдарч байгаа хүүхдийн тооноос хамаарч 1-2 ээлжээр хооллох зохион байгуулалтыг хийдэг байна. Сурагчид өдөрт 3 удаа хооллох бөгөөд долоо хоног бүрийн хоолны хуваарь мөрддөг. Ихэнх сурагчид хоолондоо цаддаг, янз бүрийн амттай хоолоор үйлчилдэг гэж хариулсан байна. Мөн өдөр 1 ба 2 дугаар хоол иддэг тул цаддаг, харин оройн хоолондоо цаддаггүй, нэмүүлж идэх боломжгүй, ямар ч хоол байсан өөр сонголтгүй тул идэхээс өөр аргагүй байх тохиодол гардгийг дурдсан байна.

Дотуур байрын гадна орчинд сандал, явган хүний зам цаашлаад хүүхдийн тоглоомын талбай бий эсэхийг ажиглахад дараах үр дүн гарч байна.

*Зураг 156. Дотуур байрны гадаад орчин*




Өнөөдрийн байдлаар дотуур байрын гадаад орчинд тавих ерөнхий шаардлага байхгүй. Үүнийг судалж, хүүхэд гадаа, агаарт тоглох, биеийн тамираар хичээллэх боломжийг хангасан, гадаад орчинд зайлшгүй шаардлагатай зүйлсийг тодруулах, зохицуулах хэрэгтэй байна.

*Хүүхэд хөгжих орчин нөхцөл*

Дотуур байрын сурагчдын чөлөөт цагаа өнгөрөөх, нийгмийн үйлчилгээ авах өрөө тасалгааны хүртээмжийг ажиглалт болон ярилцлагын аргаар судлав. Ихэнх сурагчид хичээлээ давтах, гэрийн даалгавраа өрөөндөө хийх боломж бага тул номын сан болон хүүхэд хөгжлийн өрөөнд хийдэг гэж хариулсан байна.

Бүх дотуур байр хүүхэд хөгжлийн өрөөтэй бөгөөд түүнийг хүүхдүүд сургалт хийх, хичээл давтах, ном унших, шатар даам тоглох зэргээр хэрэглэдэг байна. Нийт байрын 50.0 хувь нь номын сангүй, хүүхэд хөгжлийн өрөөг хичээл давтах, ном уншихад хэрэглэдэг байна. Зарим дотуур байрт амьдрах ухааны өрөө, зан үйлийн өрөө, зурагт үзэх өрөө, тоглоомын өрөө, эцэг эхтэй уулзах өрөө гэх мэтээр тохижуулсан нэмэлт өрөө байгаа боловч эдгээр нь бүх байрт нийтлэг биш байна. Дотуур байрууд хүүхэд хөгжлийн өрөөндөө номын булан байгуулсан байна. Сурагчидтай ном, сурах бичиг, нэмэлт гарын авлагаар хэр зэрэг хангагдсан талаар ярилцахад зарим нь сургуулийн номын сангаас сурах бичиг авсан, харин дотуур байрт номын булан байдаг боловч ихэнхдээ гадаад ном байдаг, жаахан хүүхдүүдэд зориулсан үлгэрийн ном багахан байдаг гэж хариулсан байна. Дунд, ахлах ангийн бүх сурагчид сонирхолтой ном, зохиол байдаггүй гэж хариулсан байна. Сурагчид чөлөөт цагаа шатар, даам, шагай тоглох, зураг зурах, зурагт үзэх, хичээлээ хийх зэргээр өнгөрөөдөг бөгөөд, дулааны цагт амралтын өдрөөр ойрхон гэртэй хүүхдүүд нь харьдаг гэж хариулж байна.

> Чөлөөт цагаараа шагай тоглодог. Бас хичээлээ хийдэг. Хагас, бүтэн сайнд тоглодог. Гадаа дулаан болохоор амралтын өдрөөр хүүхдүүд гэртээ харьдаг. Хүйтний улиралд явдаггүй. Ихэнхдээ гэр нь 100 км орчим хол байдаг хүүхдүүд гэр лүүгээ явж чаддаггүй. Аав ээж нар хааяа эргэж ирдэг.
>
> *8 дугаар ангийн сурагч*

Сурагчид долоо хоногт цагийн хуваарийн дагуу сургуулийн зааланд тоглох, байрны шинэ жил тэмдэглэх, урлагийн үзлэгт оролцох, байрны сагсан бөмбөг, гар бөмбөг, дууны тэмцээн, хүмүүжлийн ажил, их цэвэрлэгээний өдөр, эрүүл ахуйн сургалт, АХА, тататунга зэрэг үйл ажиллагааг зохион байгуулдаг гэж нэрлэсэн.

> Эрүүл мэндийн зөөвлөл, ёс зүйн зөвлөл, соёл хүмүүжлийн зөвлөлүүд ажилладаг. Байрны шинэ жил, урлагийн үзлэг, байрны волейбол, сагсны тэмцээн зохион байгуулна. Соёл, амралтын ажил тогтмол явуулдаг. 14 хоног тутамд нэг ажил заавал явуулдаг.
>
> *11 дүгээр ангийн сурагч*

Дотуур байранд амьдрах аятухай, таатай байдал, багшийн харилцааны талаар ярилцахад бүх сурагч эерэг сэтгэгдэлтэй байна. Дотуур байрт амьдрахад таатай зүйл:

- бусадтай харилцах чадвар дээшилдэг,
- тайван байдаг,
- хичээл хийхэд гадуур дотуур гэрийн ажил хийхгүй амар байдаг,
- сургуультай ойрхон тул багш нараас хичээлээ асуух, давтлага авахад амар байдаг,
- олуулаа байх гоё.

таагүй зүйл:

- жаахан хүүхдүүд уйлах нь хэцүү,
- гэрээ санах гэв.

Ямар нэгэн хэцүү, бэрхшээлтэй зүйл тохиолдвол хэнд хандах, хэнтэй хуваалцах талаар ярилцахад ихэнх сурагчид байрын багш эсвэл найзтайгаа хуваалцана, цөөн тооны сурагчид эцэг эхдээ, байрын жижиүүрт хандана гэж хариулжээ.

Дотуур байрт хүүхдүүд эд зүйлсээ алдах, алдсан тохиодолд ямар арга хэмжээ авдаг талаар хүүхдүүдтэй ярилцав. Ихэнх хүүхэд мөнгө, гар утас, цэнэглэгч зэргээ алга болгох тохиолдол гардаг, байрын багшид хэлээд, камер шүүлгэдэг, заримдаа эд зүйлсээ буцааж олдог, ихэнхдээ хэн авсныг тодорхойлж чаддаггүй, байрын багш гаргаж өг л гэдэг, тэгээд л чимээгүй болдог гэж хариулжээ. Муу зуршилтай, бусдыг дээрэлхдэг хүүхэд байхгүй гэж ихэнх сурагч үзжээ. Хүүхдүүд “байрны багш бидэнтэй гэрээ хийдэг, гэрээгээ зөрчвөл байрнаас гаргадаг, хэл амаар доромжилдог, хүнийг хүндэлдэггүй, хараал хэлдэг, тамхи татдаг хүүхдүүд мэр сэр бий, багш битгий хэрэлд гээд д өнгөрдөг” гэж нийтлэг хариулсан.

Дотуур байраа ямар байгаасай гэж хүсэж байна вэ? гэсэн асуултад сурагчид дараах нийтлэг хариултуудыг өгсөн байна. Үүнд:

- Хүүхдийг хөгжүүлэх олон янзын тоглоомтой байх,
- Зурагтын сувгийг олон болгох,
- Номын сантай болох,
- Интернэттэй болох,
- Байр дотроо халуун, хүйтэн устай, жорлонтой болох,
- Соёлын танхимтай байх
- Хөгжим, техник хэрэгсэлтэй байх
- Усанд орох газартай болох
- Гаднаа жаахан хүүхэд тоглох тоглоомын талбайтай байх
- Том өрөөтэй болох
- Номын сан нь ном ихтэй байх
- Зурагттай болох гэжээ.

Дотуур байрын орчин нөхцөл сайжруулах талаар сурагчдаас ямар санал санаачилга гардаг болон түүнийг хэрхэн хэрэгжүүлсэн талаар сонирхсон асуултад ер нь бол өрөө, тасалгааны талаар, хоолны амт чанар, байрны санал ширээ, хүүхдүүдийн хоорондын харьцаа, тулгамдаж байгаа асуудлын талаар байрны багш, сургуулийн нийгмийн ажилтан асуулга, санал авдаг. Өрөөнд засвар хийсэн, хүсэлт тавьсаны дагуу 6 сувагтай зурагттай болсон.

# ДҮГНЭЛТ

*Хичээлийн төлөвлөлт*

- Судалгаанд хамрагдсан сургуулиудын багш нарын хичээлийн төлөвлөлтийг сургалтын цөм хөтөлбөрт уялдуулан шинжилж үзэхэд бага боловсролын түвшинд 3.2-57.7 хувь, суурь боловсролын түвшинд 57.5 хувь, бүрэн дунд боловсролын түвшинд 20.6-31 хувь байгаа нь багш нар хичээлийн бэлтгэлээ хангалттай түвшинд хийхгүй байгааг харуулж байна.
- Багш нар сурагчдын ялгаатай байдалд тохируулан хичээл төлөвлөж тэр бүр чадахгүй байна. Ялангуяа, анги ахих тутам сурагчдын ялгаатай байдлыг төлөвлөлтөд тусгахад бэрхшээлтэй байна. Сургалтын хэрэглэгдэхүүнд зардал, мөнгө гаргах шаардлагатай болдог тул төлөвлөлтөд тэдгээрийг ашиглах талаар тодорхой тусгаж чадахгүй байна.

*Хөтөлбөрийн хэрэгжилт*

- Сурагчдын мэдлэг, ойлголтыг боловсролын түвшин бүрд хичээл тус бүрээр авч үзэхэд, бага ангид 56.0 хувьтай, дунд ангид 46.0 хувьтай, ахлах ангид 37.0 хувь байна.
- Сурагчдын мэдлэгээ хэрэглэх чадвар хангалтгүй байна. Тэрээр бага ангид 37.5 хувьтай, дунд ангид 43.0 хувьтай, ахлах ангид 36.0 хувь байна. Дунд ангийн сурагчдын мэдээлэлтэй ажиллах, асуудлыг шийдвэрлэх, бүтээлч чадвар, сурах арга барилын эзэмшилт, сэтгэхүйн задлан шинжлэх, харьцуулах, нэгтгэн дүгнэх, таамаглал дэвшүүлэх чадвар сул байна. Мөн ахлах ангийн сурагчдын мэдээлэлтэй ажиллан асуудал шийдвэрлэх, бие даан бүтээлч үйл гүйцэтгэх чадвар мөн сул байна.
- Сурагчдын мэдлэгээ хэрэглэх чадвар хичээлүүдээр ялгаатай байна. Бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд хөтөлбөрийн хэрэгжилт сул, жигд бус буюу сурагчдын эзэмшиж буй мэдлэг, чадвар нь өнгөц байгаа нь хөтөлбөрөөр эзэмшиж буй боловсролын чанар, үр дүнд анхаарах цаг болсныг харууллаа.
- Шинжлэх ухаанч арга барил эзэмшсэн байдал нь дунд ангид 28.0 харин ахлах ангид 32.0 хувь байна.
- Даалгаврын хүнд хөнгөнийг авч үзэхэд, бага ангид 49.0 хувь нь дунд болон ахлах ангид 37.0 хувь нь тохиромжтой, харин хүнд хэт хүнд даалгавар 38 хувь, дунд ангид 58.0, ахлах ангид 57.0 хувь байна. хөнгөн буюу хэт хөнгөн даалгавар багад 8.0 хувь, дунд ангид 5.0 хувь, ахлах ангид 5.0 хувь байна.
- Мэргэжлийн зэргийн хувьд анги ахих буюу түвшин нэмэгдэх тусам багшийн мэргэжлийн зэрэг ахиж байна.
- Судалгаанд хамрагдсан бага, дунд, ахлах ангид хичээл заадаг багш нарын хувьд анги ахих тусам тест, даалгаврын санг хичээл төлөвлөхдөө ашиглах нь бага зэрэг өссөн үзүүлэлтэй ч ерөнхийдөө сул.
- Сурагчийн сурлагын ахиц, амжилт болон хүүхдийн онцлог, ялгаатай байдлын талаар улиралд нэг удаа эцэг эх, асран хамгаалагчдад мэдээлж, хамтран ажиллах нь дунд, ахлах ангиудад хичээл заадаг багш нарын хувьд бага зэрэг нэмэгдэж байгаа дүр зурагтай байна.

- Сурагчийн сурлагын амжилтыг ахиулахад эцэг эхчүүд сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх, хангахад туслах нь дунд болон ахлах ангид багасч байгаагийн зэрэгцээ хүүхдийнхээ хүмүүжил, төлөвшлийн талаар асуух нь цөөрдөг дүр зураг ажиглагдав.
- Багш, эцэг эхчүүдийн хамтын ажиллагааг бодит үйл ажиллагаанд авч дүгнэхэд бэрхшээлтэй. Багштай ихэвчлэн хүүхдийн сурлагын ахиц өөрчлөлтийн талаар ярилцдаг, харин хүүхдийн хөгжил, хүмүүжил, сонирхолын талаар тэр бүр мэдээлэл авдаггүй, авах талаар ч санаачилга бага гаргаж буй байдал ажиглагдав.

*Сурах бичгийн хангалт, хүртээмж, ашиглалт*

- Сурах бичгийн хангалт бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд харилцан адилгүй, бага боловсролын түвшинд хангалт сайн бусад түвшинд буурсан байна. Хүүхэд нийслэл, аймаг, сумын сургуульд сурч байгаагаас хамаарч сурах бичгийн хүртээмж ялгаатай байна. Сумын сургуулийн хүүхдүүдийн сурах бичгийн хүртээмж дөнгөж 29.0 хувь байна. Эцэг эхчүүд сурах бичгийг аль болох төрөөс хангуулах сонирхолтой байгаа нь бага, суурь, бүрэн дунд аль аль түвшинд ажиглагдав.
- Сурах бичгийн ашиглалтын хугацаа нь боловсролын түвшнээс хамааран ялгаатай байх шаардлагатайг номын санчид чухалчлан, бага боловсролд 1-2 жил байх, харин ахлах ангид 5-аас дээш жил байж болох талаар асуудал дэвшүүлж байна.
- Багш нарт багшийн ном нь арга зүйн талаасаа дорвитой дэмжлэг болдог ба сургалтад сурах бичгийг голлон ашигладаг ба нэмэлт гарын авлага, сургалтын материалыг бага болон ахлах ангид дунд ангитай харьцуулахад илүү ашиглаж байна. Багшийн номын хүртээмжийг нэмэгдүүлэх хэрэгцээ байгааг багш нар чухалчилсан байна.

*Хөтөлбөрийн хэрэгжилтэд нөлөөлж буй хүчин зүйлс*

- Хөтөлбөрийн хэрэгжилтэд хөтөлбөрт хамрагдаж буй бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд сурагчдын эцэг эхийн боловсролын түвшин, эцэг эхийн ажил эрхлэлт, өрхийн сарын дундаж орлого, сургуулийн өмчийн хэлбэр, сургуулийн байршил (нийслэл, аймаг, сум) нөлөөлсөн бөгөөд бага боловсролын түвшинд хичээл таслалт, суурь болон бүрэн дунд боловсролын түвшинд гэрийн даалгавар хийхдээ ашигладаг нэмэлт хэрэглэгдэхүүн, орой унтдаг цаг зэрэг хүчин зүйлс хичээлээс хамаарч нөлөөлсөн байна.

*Сургалтын гадаад, дотоод орчин*

- Сургуулийн орчны хувьд, сумын сургууль нь орчны тохижилтыг өөрийн нөхцөл бололцоондоо тулгуурлан сайн хийж байна. Тухайлбал, сумын сургуулийн гадаад гэрэлтүүлэг аймаг, нийслэлийн сургуулиас илүү сайн байна.
- Сургуулийн анги дүүргэлт буюу нэг багшид ногдох хүүхдийн ачааллын хувьд, сумын сургуулийн ачаалал нийслэл, аймгийнхаас бага үзүүлэлттэй, нийслэлийн төрийн өмчийн сургуулийн бага ангийн багш аймаг, сумын сургуулийн бага ангийн багшаас илүү ачааллтай ажиллаж байна.
- Сургуулиуд номын сан, цайны газруудтай ч сурагчид номын санд суух нь бага, цайны газраар үйлчлүүлэх нөхцөл нь харилцан адилгүй байна.

*Дотуур байрны нөхцөл*

- Дотуур байрны хувьд нэг хүүхдэд ногдох талбай бага, нэг өрөөнд дунджаар 5-6 хүүхэд амьдарч байна.

# САНАЛ

*Бодлогын түвшинд*

- Сургалтын бодлогын тогтвортой байдлыг хадгалах,
- Сурагчдын гүйцэтгэлд эцэг эхийн ажил эрхлэлт, өрхийн орлого нөлөөлж байгаатай учир нийгэм эдийн засгийн хөгжил тогтворгүй байгаа цаг үед боловсролын амжилтыг сайжруулах цаг үеийн чанартай бодлогуудыг боловсруулан хэрэгжүүлэх,
- Сургалтын хөтөлбөрийн менежментийн цоклийн дагуу хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгааг тогтмол хийж, үр дүнд үндэслэн сайжруулах,
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг сургуулийн төлөвлөлт, орон нутгийн хөгжлийн онцлогт үндэслэн ялгаатай дэмжих бодлоготой болох,
- Хөтөлбөрийн хөгжлийн тогтворгүй цаг үед нэгж дээр БСУГ, сургууль, багштай мэргэжлийн байгууллагууд хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх,
- Багшийн номын хүртээмжийг цаг алдалгүй нэмэгдүүлэх,
- Сургалтын хэрэглэгдэхүүн, лабораторийн тоног төхөөрөмжийг хэрэгцээнд үндэслэн зохистой нийлүүлэх,

*Мэргэжлийн байгууллагуудын түвшинд*

- Багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтуудад:
  - хичээлийн төлөвлөлтийн арга зүй,
  - сургалтын хөтөлбөрт шинээр туссан агуулга,
  - мэдлэгээ хэрэглэх, сорил туршилтын аргууд,
  - сургалтын хэрэглэгдэхүүнийг ашиглах аргачлалыг тусгах,
- Сургалтын цөм хөтөлбөрт тусгасан үнэлгээний зорилт, шалгуурт үндэслэн явцын болон үр дүнгийн үнэлгээг бодитой хийх, даалгаврын чанарыг сайжруулах, багш нарт үнэлгээний арга зүйн сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах,
- Үндэсний хэмжээнд хийгдсэн судалгааны үр дүнг нэгжүүдэд хүргэж, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад анхаарч, сайжруулах асуудлаар зөвлөн туслаж, хамтран ажиллах,

*Орон нутгийн түвшинд*

- Хөгжим, Биеийн тамир, дизайн технологийн хичээлийн хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх,
- Сургууль, эцэг эх, олон нийтийн хамтын ажиллагааг сайжруулах,
- БСУГ-ын мэргэжлийн удирдлага, арга зүйн чадавхийг дэмжих, Үндэсний мэргэжлийн байгууллагуудтай судалгаа, арга зүйн чиглэлээр байнга хамтран ажиллах,
- Сургууль, багш нарыг хичээлийн чанарыг сайжруулах, сургалтын хэрэглэгдэхүүн, кабинет, лабораторийн үр дүнтэй ашиглалтын чиглэлээр дэмжих,

*Сургуулийн түвшинд*

- Эцэг эх, олон нийтийн оролцоог хөтөлбөрийн хэрэгжилтэд чиглүүлэх,
- Багш нарын хичээлийн бэлтгэл, төлөвлөлт хангалтгүй байгаа тул цаашид сургуулийн хөтөлбөрийн хөгжлийг дэмжих, сургуулийн менежмент, багшийн хичээлийн бэлтгэлийг чанаржуулах,
- Сургалтын орчин, хэрэглэгдэхүүний хангалтад анхаарах, байгалийн ухаан, мэдээллийн технологийн хичээлийг лабораторид, дизайн технологи, хөгжим, биеийн тамирын хичээлийг зориулалтын кабинет, спорт зааланд хичээллэх боломж, нөхцлийг бүрдүүлэх.

# АШИГЛАСАН МАТЕРИАЛ


Монгол-Кембрижийн санаачилга, Б. (2014). *Багшийн үнэлгээний гарын авлага*: *Танилцуулга*. Улаанбаатар.

БСШУЯ, Боловсролын хүрээлэн.(2014). *Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр*. Улаанбаатар. Колорфул ХХК.

БСШУЯ.(2015). *Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр*. Улаанбаатар. Колорфул ХХК.

БСШУЯ.(2016). *Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр*. Улаанбаатар. Колорфул ХХК.

Cambridge international examinations, G. o. (2015). *Бага, дунд, ахлах ангид явцын үнэлгээ хийх гарын авлага*. Улаанбаатар.

Боловсролын шинэчлэл, М.-К. б. (2015). *Үндэсний хөтөлбөр, үнэлгээний загвар*: *Товч тайлан ба санал зөвлөмжүүд*. Улаанбаатар.

Монгол-Кембрижийн боловсрол санаачилга. (2015). *Шалгуурт суурилсан үнэлгээний хүрээнд багш нарт өгөх зөвлөмж*. Улаанбаатар.

БҮТ. (2017). *Боловсролын үнэлгээ арга зүйн зөвлөмж*. Улаанбаатар.

БШУЯ, Боловсролын хүрээлэн.(2014). *Бага боловсролын сургалтын шинэчилсэн хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгааны тайлан*. Улаанбаатар.

